



Улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь

Гарын авлага

Улс төрийн намд
эмэгтэйчүүдийн оролцоог
дэмжих нь
гарын авлага







ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албанаас эрхлэн хэвлүүлэв (АИХЭА)
Миодовагийн гудамж 10
00–251 Варшав
Польш улс www.osce.org/odihr
© OSCE/ODIHR 2014

Бүх эрх хамгаалагдсан. ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны эх сурвалж хэмээн мэдэгдсэн тохиолдолд боловсролын болон арилжааны бус зорилгоор чөлөөтэй ашиглаж болно.

ISBN 978-92-9234-888-5
Хэвлэлийн дизайныг Homework
Хавтасны зургийг AP/Jae C. Hong
Хэвлэсэн Sungraf, Польш улс

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр орчуулж хэвлүүлэв. 2016 он

Агуулга

	
Өмнөх үг	7
	
Талархал	9
	
Нэгдүгээр бүлэг: Оршил	12
1.1 ЕАБХАБ-ын бүс нутаг дах эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, сонгуульт албан тушаалд ажиллаж буй байдал	12
1.2 Улс төрийн нам ардчиллыг “тээн хэрэгжүүлэгч” болох нь	15
1.3 Гарын авлагын зорилго	17
1.4 “Эмэгтэйчүүд улс төрийн намд” төсөл, гарын авлагын арга зүй	18
1.5 Гарын авлагыг хэнд зориулсан тухай, гарын авлагын бүтэц	21
	
Хоёрдугаар бүлэг: Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг улс төрийн албан тушаалд дэвшүүлэх асуудлыг яагаад дэмжин сурталчлах хэрэгтэй вэ?	
Хоёрдугаар бүлгийн оршил	26
2.1 Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж ирсэн учир шалтгаан	28
2.2 Улс төрийн намын удирдлагад тусах ашигтай тал	30
2.2.1. Олон нийтийн дунд улс төрийн намын дүр төрх, нэр хүнд сайжирна	31
2.2.2. Намын мөрийн хөтөлбөр, бодлогыг боловсронгуй болгоно	32
2.2.3. Улс төрийн намын сонгуулийн сурталчилгаа хийх арга замыг сайжруулна	34
2.2.4. Намын гишүүнчлэл буурахаас сэргийлнэ	37





2.3. Улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдэд тусах ашигтай тал	38
2.3.1. Сонгуульт албан тушаалд өрсөлдөх сонирхолтой эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлнэ	39
2.4. Нийгэмд тусах ашигтай тал	40
2.4.1. Улс төрийн тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ	41
2.4.2. Бодлогод нөлөөлнө	41
2.4.3. Нийгэм-эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна	42
2.4.4. Нийгэмд жендэрийн тэгш байдлын талаарх ойлголтыг дээшлүүлнэ	43
Хоёрдугаар бүлгийн дүгнэлт	44

Гуравдугаар бүлэг: Улс төрийн намууд, намын удирдлага

Гуравдугаар бүлгийн оршил	48
3.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?	51
3.1.1. Намын тогтолцоо, үйл явц, практикт жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх нь	52
3.1.2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг сайн дурын үндсэн дээр авч хэрэгжүүлэх нь	64
3.1.3. Санхүүгийн нөөц болон сонгуулийн сурталчилгааны санхүүжилт олгоход жендэрийн тэгш байдлыг хангах нь	81
3.1.4. Жендэрийн асуудлыг намын сонгуулийн сурталчилгааны ажлын нэг хэсэг болгох нь	84
3.1.5. Жендэрийн мэдрэмжтэй засаглалыг дэмжих нь	87
Гуравдугаар бүлгийн дүгнэлт	93

Дөрөвдүгээр бүлэг: Улс төрийн нам дах эмэгтэйчүүд

Дөрөвдүгээр бүлгийн оршил	96
4.1. Ямар арга зам үр дүнтэй байна вэ?	99
4.1.1. Карьераа амжилттай хөгжүүлж, улс төрийн албан тушаал ахих	99
4.1.2. Эмэгтэйчүүд өөр хоорондоо хамтран ажиллах, хамтын сонирхлыг хөндсөн асуудлаар нэгдэж ажиллах	130
4.1.3. Улс төрийн намын бодлого, журам, практикт жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх	137
Дөрөвдүгээр бүлгийн дүгнэлт	144

	
Тавдугаар бүлэг: Иргэний нийгмийн байгууллага, бусад оролцогчид	
Тавдугаар бүлгийн оршил	148
5.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?	149
5.1.1. Эмэгтэйчүүд улс төрд орох, улс төрийн карьераа ахиулахыг дэмжих	151
5.1.2. Улс төрийн намуудтай ажиллах	162
5.1.3. Олон нийтийн эерэг хандлагыг бүрдүүлж төлөвшүүлэх	169
5.1.4. Хэвлэл мэдээлэлтэй ажиллах	172
5.1.5. Судалгааны байгууллагатай ажиллах	176
5.1.6. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллагатай ажиллах	181
5.1.7. Үйл явдлын тэргүүнд явах нь	183
Тавдугаар бүлгийн дүгнэлт	185
	
Дүгнэлт	187
	
Хавсралт	193
	
Ном зүй	217

Өмнөх үг

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, улс төр, олон нийтийн амьдралын бүхий л салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог бий болгох нь ЕАБХАБ-ын гишүүн улс орон бүрийн баримталбал зохих суурь зарчим юм. 2009 оны 12 дугаар сард болсон ЕАБХАБ-ын Сайд нарын Афины зөвлөлөөс баталсан улс төр, нийтийн салбар дах эмэгтэйчүүдийн оролцооны талаарх баримт бичигт “шийдвэр гаргах бүх түвшний сонгуульд албан тушаалд жендэрийн илүү тэнцвэрт байдлыг бий болгох үүднээс улс төрийн намд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог дэмжихийг улс төрийн бүхий л оролцогчдод уриалахыг” гишүүн улс орнууддаа даалгасан байдаг. Энэхүү баримт бичиг нь 2004 онд ЕАБХАБ-ын гишүүн орнуудын баталсан Жендэрийн тэгш байдлыг дэмжих Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан зорилтуудыг бататган сэргээсэн. ЕАБХАБ-ын гишүүн бүх улс орны баталсан Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “ардчиллын үйл явцад эмэгтэйчүүдийн тэгш оролцоог бий болгох үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх чиглэлээрх сайн туршлагыг хөгжүүлэхэд гишүүн улс орнуудад дэмжлэг үзүүлэх бүрэн эрхийг ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албанд (АИХЭА) тусгайлан олгосон болно.

ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудын хүрээнд парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь өнөөдөр 25% орчим байгаа нь 2000 онд 15% байсантай харьцуулахад өссөн дүн юм. Гэхдээ энэ нь сүүлийн арав орчим жилд цөөн хэдэн гишүүн улс оронд гарсан дорвитой өсөлтийн үр дүн бөгөөд нийт бүс нутгийн хэмжээнд ахиц дэвшил харилцан адилгүй хэвээр байна.

Тухайн улс оронд эмэгтэйчүүд сонгуульд албан тушаалд хэр зэрэг төлөөлөлтэй байх вэ гэдэгт нийтийн болон хувийн салбар дах эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдал, тэгш бололцоог хангахад гарсан ерөнхий ахиц дэвшил, улс төрийн болон сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын дотоод шийдвэр гаргах тогтолцоо, ил тод байдлын түвшин зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байдаг. Эдгээр хүчин зүйлийн дунд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг чухал бөгөөд тэднийг эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог “тээн хэрэгжүүлэгч” гэж үзэх нь бий. Намын дотоод дүрэм журам, практикт жендэрээс үүдэлтэйгээр шүүд ба шүүд бусаар ялгаварлан гадуурхах, нэр дэвшигчийг сонгож тодруулахад жендэрийн мэдрэмж дутах, нэр дэвшигчдэд намаас санхүүжилт олгохдоо тэгш бус хандах зэрэг нь улс төрийн намын хүрээнд эмэгтэйчүүдэд, ялангуяа эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг олон талт бэрхшээлийн нэг хэсэг юм.

Улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих тухай энэхүү гарын авлага нь намын дотоод шийдвэр гаргах үйл явцад жендэрийн асуудлыг тусгахад намын эрэгтэй, эмэгтэй удирдлагын аль алинд нь тус дөхөм болох зорилготой. Түүнчлэн эмэгтэй улс төрчдөд карьераа ахиулахад шаардлагатай чадавх бий болгоход хувь нэмэр оруулна.

Эмэгтэйчүүд улс төрийн карьераа ахиулахад намын дотоод шинэчлэл чухал үүрэгтэй гэдэг нь энэхүү гарын авлагыг боловсруулах явцад олж тогтоосон гол үр дүн юм.

Намын дотоод ардчилал, ил тод байдал хангалтгүй байх, нэр дэвшигчийг сонгож тодруулахад жендэрийн мэдрэмж дутагдах, намын шийдвэр гаргах үйл явц төвлөрсөн байх нь эмэгтэйчүүд улс төрийн нам дотор ахиж дэвших, сонгуульт албан тушаалд нэр дэвших бололцоог хааж байдаг. Ийм учраас ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь улс төрийн амьдралд бодитой оролцох тэгш бололцоог бүрдүүлэх үүднээс намын дотоод тогтолцоо, үйл явц, бодлого, үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг улс төрийн намууд сайн дурын үндсэн дээр авч хэрэгжүүлж болох тухай чухал санааг энэхүү гарын авлагаар дамжуулан танилцуулахыг зорив. Гарын авлагыг боловсруулах, хянан тохиолдуулах, хэвлэх ажил бараг бүхэлдээ АИХЭА-ны захирлаар миний өмнө ажиллаж байсан элчин сайд Янез Ленарчичийн үед түүний заавар зөвлөгөөгөөр хийгдсэн тул хэвлэлийг нийтэд танилцуулах завшаан тохиолдсоныг ашиглан түүнд талархал илэрхийлье.

Уншиж танилцах, сургалтанд ашиглах зорилгоор боловсруулсан энэхүү гарын авлага нь ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудын тусын тулд ардчилсан засаглалын үйл явцад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог дэмждэг намын дотоод дүрэм журам, практикийг бий болгоход намын удирдах албан тушаалтнуудыг идэвхжүүлж чадна гэдэгт би итгэж байна.

Микаел Георг Линк (Michael Georg Link)

ЕАБХАБ-ын АИХЭА-ны захирал

Талархал

Улс төрийн албан тушаалд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар мэргэшсэн шинжээчид болох Харвардын их сургуулийн профессор Пиппа Норрис, Ратжерсийн их сургуулийн профессор Мона Лена Крук нарын хийсэн судалгаа, боловсруулсан тайлангийн төсөлд тулгуурлан энэхүү гарын авлагыг ЕАБХАБ-ын Ардчилсан институц, хүний эрхийн албанаас эрхлэн гаргав.

ЕАБХАБ-д хамаарах бүс нутгийн улс орнуудын парламент, улс төрийн намуудын төлөөлөл, жендэр, улс төрийн намын асуудлаар мэргэшсэн шинжээчид, эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудаас гаргаж өгсөн мэдээлэл тус гарын авлагыг бэлтгэж гаргахад чухал үүрэгтэй байлаа. Ялангуяа АИХЭА-ны “Эмэгтэйчүүд улс төрийн намд” төслийн хүрээнд байгуулагдсан мэргэшсэн шинжээчид, зөвлөлдөх бүлгүүдийн гишүүдэд талархал илэрхийлж байна. Гарын авлага нь тус төслийн нэг хэсэг байсан юм. Эдгээр шинжээч нь эмэгтэйчүүд улс төрийн карьер ахихад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, намын дотоод бүтцэд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж байгаа сайн туршлагын талаар үнэтэй мэдээлэл өгч, гарын авлагын төслийг хянан тохиолдуулахад оролцсон. Тэдний оролцоо, санал бодлын үр дүнд энэхүү гарын авлага бүтээгдсэн болно.

АИХЭА-ны албаны зүгээс ялангуяа Michelle Bekkering, Lolita Cigane, Ivan Doherty, Lenita Freidenvall, Maria Rauch Kallat, Sonja Lokar, Joni Lovenduski, Petra Meier, Karolina Ó Beacháin Stefanczak, Susan Scarrow, Melanie Sully, Erika Veberyte, Kristina Wilfore нарт мэргэжлийн шинжээчийн хувьд оролцсонд талархаж байна. Түүнчлэн төслийн хүрээнд сонгон авсан таван улс орны хамтрагч байгууллагын төлөөлөгчид болох Эмэгтэйчүүдийн мянганы сүлжээний Jeta Katro (Албани), Эмэгтэйчүүдийн мэдээллийн төвийн Elena Rusetskaia (Гүрж), Феминист лигийн Yevgenya Kozyreva (Казахстан), Нийгмийн технологийн агентлагийн Zulfia Kochorbaeva (Киргизстан), Хөгжлийн төлөөх түншлэлийн Daniela Terzi-Barbarosie, Alexei Buzu нарт туйлаас талархаж байгаагаа илэрхийлье.

ЕАБХАБ-ын Албани дах төлөөлөл, Астана болон Бишкек дэх ЕАБХАБ-ын төвүүд, ЕАБХАБ-ын Молдав дах төлөөлөгчийн газар зэрэг ЕАБХАБ-ын харьяа байгууллага, төлөөлөгчийн газрын ажилтнуудад тус гарын авлагатай холбоотой санал бодлоо хуваалцаж, гарын авлагын тодорхой бүлгийг хэлэлцүүлэх дугуй ширээний ярилцлага-сургалт семинар зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэнд талархаж буйгаа илэрхийлж байна. Тажикистан дах ЕАБХАБ-ын газар гарын авлагын агуулга, бүтцийн талаар үнэтэй санал гаргасан бөгөөд дугуй ширээний ярилцлага-сургалт семинарыг Сонгуулийн тогтолцооны талаарх олон улсын сан (IFES), Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI), Ардчиллын үндэсний хүрээлэн (NDI), Олон намт ардчиллын Нидерландын хүрээлэн (NIMD), НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөтөлбөр, НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан болно.

Гарын авлагыг бүтээхэд дэмжлэг туслалцаа үзүүлсэн ЕАБХАБ-ын даргын Жендэрийн асуудал хариуцсан Тусгай төлөөлөгч June Zeitlin, ЕАБХАБ-ын Жендэрийн хэлтсийн ахлах зөвлөх Miroslava Beham нарт тусгайлан талархал илэрхийлж байна.

ОРШИЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

1. Оршил

- 1.1. ЕАБХАБ-ын бүс нутаг дах эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, сонгуульт албан тушаалд ажиллаж буй байдал**
- 1.2. Улс төрийн нам ардчиллыг “тээн хэрэгжүүлэгч” болох нь**
- 1.3. Гарын авлагын зорилго**
- 1.4. “Эмэгтэйчүүд улс төрийн намд” төсөл, гарын авлагын арга зүй**
- 1.5. Гарын авлагыг хэнд зориулсан тухай, гарын авлагын бүтэц**

21 дүгээр зуун ирээд байгаа ч улс төрд жендэрийн тэгш байдлыг тогтоох зорилгыг биелүүлж чадах эсэх нь бүрхэг хэвээр байна. Өнөөдөр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил тоогоор, магадгүй илүү олноороо сонгуульд санал өгч оролцож байна¹. Гэвч намын гишүүнчлэл, сонгуулийн сурталчилгааны ажилд оролцох, хууль тогтоох байгууллагын төлөөлөгчөөр сонгогдохоор нэр дэвших, орон нутгийн хурал, бүс нутгийн, улс орны болон Европын парламентын гишүүн, даргаар сонгогдох, шүүх болон төрийн бусад өндөр албан тушаал, засгийн газрын гишүүн, ерөнхий сайдаар томилогдох, төрийн тэргүүнээр сонгогдох тал дээр эрэгтэйчүүдээс хол хоцорч явна.

Хэдийгээр орчин цагийн бүхий л ардчилсан нийгэмд эмэгтэйчүүдийн иргэний харьяалалтай байх, сонгуульд санал өгөх зэрэг тэгш эрхийг үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг ч дээрх нөхцөл байдал өөрчлөгдөхгүй байна². Сонгогчдын олонх нь эмэгтэйчүүд байгаа ч сонгуульд албан тушаалд очих нь цөөн хэвээр байгаа онол, практикийн энэхүү зөрүүтэй байдал нь нийгмийн шударга ёсны суурь асуудлыг хөндөж байгаа юм. Тэгш бололцоо тэнцвэртэй хангагдахгүй байгаа нь яваандаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв байдалд нөлөөлж, хойч үеийнхэнд маань ч сөрөг нөлөө үзүүлнэ.

1.1. ЕАБХАБ-ын бүс нутаг дах эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, сонгуульд албан тушаалд ажиллаж буй байдал

Эмэгтэйчүүд төрийн албан тушаалд сонгогдох нь ЕАБХАБ-ын бүс нутагт алгуур дээшилж байна. Нэг танхимтай парламент болон хоёр танхимтай парламентын доод танхимд гишүүнээр сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо 1996 онд 13.8 хувь³ байсан бол 2000 онд 16.5 хувь⁴ болжээ. Өнөөдөр ЕАБХАБ-ын бүс нутгийн улс орнуудын парламентын доод танхимын нийт гишүүдийн 24.8 хувь нь эмэгтэй байгаа нь ойролцоогоор дөрвөн гишүүн тутмын нэг нь эмэгтэй гэсэн үг⁵.

1 Ronald Inglehart and Pippa Norris, *Rising Tide: Gender Equality and Cultural Change* (New York: Cambridge University Press, 2003); Hilde Coffé and Catherine Bolzendahl, "Same game, different rules? Gender differences in political participation", *Sex Roles*, Vol. 62, No. 5–6, 2010, pp. 318–333


2 Ann Towns, *Women and States: Norms and Hierarchies in International Society* (New York: Cambridge University Press, 2010).

3 *Women in National Parliaments: Situation as of 1 January 1997*, Inter-Parliamentary Union, <www.ipu.org/wmn-e/arc/world010197.htm>

4 *Women in National Parliaments: Situation as of 15 December 2000*, Inter-Parliamentary Union, <www.ipu.org/wmn-e/arc/world010197.htm>

5 *Women in National Parliaments: Situation as of 1 May 2014*, Inter-Parliamentary Union, www.ipu.org/wmn-e/classif.htm. The Figure excludes the Holy See

Зураг 1.1: Парламентын доод танхим дах эмэгтэйчүүдийн төлөөлөл, 2014 оны 5 дугаар сарын байдлаар



Парламентын доод танхим дах эмэгтэйчүүдийн төлөөллийн хувь хэмжээ, 2014 оны 5 дугаар сарын байдлаар

Эх сурвалж: Inter-Parliamentary Union, <www.ipu.org>

Түүнчлэн сүүлийн хорин жилд ЕАБХАБ-ын гишүүн хэд хэдэн улсад эмэгтэйчүүд Засгийн газрыг тэргүүлж ажиллажээ. Тухайлбал, Канад, Хорват, Дани, Финлянд, Герман, Исланд, Польш, Словак, Украин, Их Британи эмэгтэй Ерөнхий сайдтай байв. Зарим гишүүн улс оронд эмэгтэйчүүд парламентын спикерээр ажиллаж байна (тоо баримтыг Хүснэгт 1.2-оос үзнэ үү). 1996 онд Финляндын парламентын спикер, түүний нэг, хоёрдугаар орлогчийн албан тушаалыг эмэгтэйчүүд хашиж байсан нь түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал болсон байдаг⁶.

Хүснэгт 1.2. Эмэгтэйчүүд парламентын спикерээр ажилласан ЕАБХАБ-ын бүс нутгийн улс орнууд

Улс орон	Парламент (танхимтай бол нэр нь)	Спикерийн нэр
Албани	Parliament of Albania	Jozefina Topalli
Австри	Nationalrat	Barbara Prammer
Бельги	Senate	Sabine de Bethune
Чех	Poslanecká Sněmovna	Miroslava Němcová
Эстони	Riigikogu	Ene Ergma
Итали	Chamber of Deputies	Laura Boldrini
Латви	Saeima	Solvita Ābolviņa
Нидерланд	Tweede Kamer der Staten Generaal	Gerdi Verbeet
Польш	Sejm	Ewa Kopacz
Португал	Assembleia da República	Maria da Assunção Esteves
ОХУ	Soviet Federatsii	Valentina Matviyenko
Сан Марино	Consiglio Grande e Generale	Denise Bronzetti
Швейцар	Federal Assembly	Maya Graf
Туркменистан	Mejlis	Akja Nurberdiyewa
Их Британи	House of Lords	Baroness Frances D'Souza
Узбекистан	Legislative Chamber	Diloram G. Tashmukhamedova

Эх сурвалж: “Улс орнуудын парламентын эмэгтэй спикерүүд. 2013 оны 9 сарын 1”, <<http://www.ipu.org/wmn-e/speakers.htm>>.

Финлянд, Латви, Литва, Исланд, Киргизстан улс эмэгтэй Ерөнхийлөгчтэй байв⁷. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд Ирланд хоёр удаа эмэгтэй Ерөнхийлөгчтэй байсан: 1990-1997 онд Мэри Робинсон, 1997 оноос 2011 оны 11 дүгээр сар хүртэл Мэри МакАлиз нар тус улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан байна. 2003 онд Финляндын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын албан тушаалын аль алинд эмэгтэй хүн ажиллах болсон нь дахин бүх нийтийн анхаарлыг татав⁸. 2010 онд Роза Отунбаева Ерөнхийлөгч болсноор Киргизстан Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн гишүүн улс орнууд дунд эмэгтэй төрийн тэргүүнтэй хамгийн анхны улс болов⁹.

6 “Women members of Finland’s parliament,” Parliament of Finland, <www.eduskunta.fi/efakta/opus/tiedotus/naisede.htm>.

7 In addition, in 2012, a woman was elected President of Kosovo. All references to Kosovo refer to Kosovo under UNSCR 1244; all references to Kosovo institutions refer to the Provisional Institutions of Self-Government

8 “Finland–Government”, Encyclopedia of the Nations, 2013, <www.nationsencyclopedia.com/Europe/Finland-GOVERNMENT.html>.

9 “Президент Киргизии – Роза Отунбаева”, LiveJournal, <<http://as03.livejournal.com/29569.html>>.

Хүснэгт 1.3. ЕАБХАБ-ын бүс нутагт сүүлийн үед сонгогдсон, томилогдсон төр, Засгийн газрын тэргүүнүүд

Улс орон	Албан тушаал	Нэр
Хорват	Ерөнхий сайд	Jadranka Kosor
Дани	Ерөнхий сайд	Helle Thorning-Schmidt
Финлянд	Ерөнхийлөгч	Tarja Halonen
Герман	Канцлер	Angela Merkel
Исланд	Ерөнхий сайд	Jóhanna Sigurðardóttir
Ирланд	Ерөнхийлөгч	Mary McAleese
Киргизстан	Ерөнхийлөгч	Rosa Otunbayeva
Латви	Ерөнхийлөгч	Vaira Vīķe-Freiberga
Литва	Ерөнхийлөгч	Dalia Grybauskaitė
Мальта	Ерөнхийлөгч	Marie Louise Coleiro Preca
Словак	Ерөнхий сайд	Iveta Radičová
Словени	Ерөнхий сайд	Alenka Bratušek
Украин	Ерөнхий сайд	Yulia Tymoshenko

Эх сурвалж: Rulers.org, <<http://www.rulers.org/ruld.html>>

Ийнхүү тэмдэглэхүйц ахиц гарсан ч ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудын нөхцөл байдал өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Арав хүрэхгүй улс оронд л шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо 1995 оны Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөрт заасан 30 хувьд хүрсэн байна¹⁰. Парламентад нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд бараг тэнцүү суудалтай Андорра, Финлянд, Швед зэрэг цөөн хэдэн улс орны хууль тогтоох байгууллагад л жендэрийн зөрүү арилаад байна. Үүний зэрэгцээ ЕАБХАБ-ын гишүүн олон улсад эмэгтэйчүүдийн төлөөлөл 15 хувьд ч хүрэхгүй хэвээр байна¹¹. Дээрх жишээнүүд боломж байгаа гэдгийг харуулж байгаа ч эмэгтэйчүүд парламентын спикер, төр, засгийн газрын тэргүүн, сайд зэрэг төрийн шийдвэр гаргах дээд түвшинд сонгогдох нь харьцангуй ховор байгаа нь бодит үнэн юм. Улс төрд жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатайг эдгээр тоо баримт харуулж байна. Эмэгтэйчүүдийг улс төрийн хувьд бүрэн эрх мэдэлжүүлэх цаг аль хэдийн болжээ.

1.2. Улс төрийн нам ардчиллыг “тээн хэрэгжүүлэгч” болох нь

Тухайн улс орны хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь улсын болон хувийн салбар дах эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдал, тэгш бололцоог хангахад гарсан ерөнхий ахиц дэвшил, улс төрийн болон сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын дотоод шийдвэр гаргах тогтолцоо, ил тод байдлын түвшин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Эдгээр хүчин зүйлийн дунд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг чухал тул улс төрийн нам бол ардчилал, түүн дотроо эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог “тээн хэрэгжүүлэгч” гэж үзэх нь бий.

10 “The United Nations Fourth World Conference on Women. Beijing, China, – September 1995. Action for Equality, Development and Peace. Platform for Action”, United Nations (UN), <<http://www.un.org/womenwatch/daw/beijing/platform/>>.

11 “Women in National Parliaments: Situation as of 1 May 2014”, Inter-Parliamentary Union, <<http://www.ipu.org/wmn-e/classif.htm>>.

Улс төрийн нам нь эрэгтэй, эмэгтэй ялгаагүй бүхий л иргэдийн санаа бодол, байр суурийг төлөөлж, төрийн бодлогод тусгуулах суваг болж байдгаараа ардчиллын үйл явцад онцгой үүрэгтэй тул ардчиллыг сахиулагч гэж үздэг. Түүнчлэн улс төрийн намаар л дамжин иргэд (эрэгтэй, эмэгтэй хүмүүс) улс төрийн шийдвэр гаргах түвшинд төлөөлөгчөөр сонгогддог. ЕАБХАБ-ын хүрээнд иргэдийн эвлэлдэн нэгдэх эвлэлдэн нэгдсэн байгууллагынхаа үйл ажиллагаанд оролцох эрхийг баталгаажуулан хамгаалж байдаг бөгөөд иргэдийн эвлэлдэн нэгдсэн байгууллага гэдэг утгаараа улс төрийн нам ч чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, цуглах, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг бүхий л эрхийг иргэдтэй нэгэн адил эдэлнэ¹². Улс төр, сонгуульд намуудын гүйцэтгэх онцгой үүрэгтэй холбоотойгоор мэргэшсэн шинжээч, төрийн албан тушаалтан, тэр ч байтугай намын гишүүд өөрсдөө “төлөөллийг хангасан, шударга ёсонд нийцсэн, үр дүнтэй ардчилсан засаглалыг бий болгох үүднээс шаардлагатай” зохицуулалтыг улс төрийн намд хийх хэрэгтэй гэж үзэх хандлага өсөн нэмэгдэж байна¹³.

Ийм ч учраас улс төрийн намын үйл ажиллагааг зохицуулах, ардчиллын үйл явцад гүйцэтгэх үүргийг нь тодорхойлох зорилгоор ЕАБХАБ-ын гишүүн улс орнууд тодорхой хууль тогтоомж баталсан байдаг. Улс төрийн нам ямар үйл явц, хөрөнгө нөөц ашиглах эрхтэйг тэдгээр хууль тогтоомжид тодорхойлон зааж болно. Хамгийн гол нь, тэдгээр хуульд сонгуульд өрсөлдөх боломж, ямар журмын дагуу уг боломжоо хэрэгжүүлэхийг зааж өгдөг. Мөн хуулиар намын үйл ажиллагааны болон сонгуулийн сурталчилгааны ажилд зориулан улсын төсвөөс санхүүжилт авах, өмч хөрөнгө олж авах, сонгуулийн үеэр олон нийтийн нэвтрүүлгийн цаг хуваарилуулж авах зэрэг эрхийг улс төрийн намд олгож болно¹⁴.

Улс төрийн намын үйл ажиллагаа, түүнийг хуулиар зохицуулсан байдал нь эмэгтэйчүүдийн улс төрийн ахиц дэвшилд их нөлөөтэй. Улс төрийн намын тухай хууль эмэгтэйчүүдийг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхсан байх боломжтой. Тухайлбал, эмэгтэйчүүд улс төр, нийгэм, эдийн засгийн эрх мэдлийн хувьд эрэгтэйчүүдтэй эн зэрэгцэж чадахгүй байгаа нөхцөлд нэр дэвших зардлыг өндрөөр тогтоох зэрэг нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотой хуульд заасан шаардлагыг эмэгтэйчүүд биелүүлэх боломжгүй юм. Түүнчлэн өндөр түвшний боловсрол эсвэл төрийн албанд ажилласан доод хугацааг шалгуур болгох нь сонгуульд өрсөлдөх эрхийг шаардлагагүйгээр хязгаарлаж, эмэгтэй нэр дэвшигчдийг илүү мохоож байдаг.

Шигтгээ 1.4: Улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог “тээн сахиулагч” болох нь

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны асуудлаар саяхан гаргасан тогтоолдоо НҮБ-ын Ерөнхий ассамблей гишүүн улс орнууддаа ийнхүү сонордуулжээ: “Эмэгтэйчүүдийн оролцоог шууд болон шууд бусаар хязгаарлаж ялгаварлан гадуурхаж байгаа бүхий л саад тотгорыг арилгах, асуудалд жендэрийн мэдрэмжтэй хандах болон намын дотоод шийдвэр гаргах бүх шатанд эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн оролцох чадварыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэхийг улс төрийн намууддаа шийдвэртэйгээр уриалан дэмжих” шаардлагатай байна.

Эх сурвалж: НҮБ-ын Ерөнхий ассамблейн эмэгтэйчүүд, тэдний улс төрийн оролцооны асуудлаарх 66/130 тоот тогтоол, 2012

Шигтгээ 1.5. Улс төрийн намын тодорхойлолт

ЕАБХАБ/АИХЭА, Европын зөвлөлийн Венецийн комиссоос гаргасан Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамжинд **улс төрийн нам** бол “Чөлөөт, ардчилсан сонгуульд нэр дэвшүүлэх гэх мэт арга замаар төрийн хэргийг удирдахад оролцох зорилго бүхий, иргэдийн чөлөөтэй эвлэл юм.

12 See OSCE/ODIHR and the Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010, para. 4: “Political parties must be protected as an integral expression of the individual’s right to freely form as- sociations”.

13 Ibid, para. 6.

14 As the focus of this document is on internal party regulation, the handbook does not explore in detail what meas- ures the state can introduce in order to require political parties to increase gender equality and women’s political advancement. In this regard, readers are encouraged to consult the OSCE/ODIHR-Venice Commission Guidelines on Political Party Regulation, published in 2010, available at: <www.osce.org/odihr/77812>.

Үүний зэрэгцээ намын дотоод дүрэм журам нь эмэгтэйчүүдийг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхсан байвал эмэгтэйчүүдийн оролцоонд мөн л саад учруулна. Ялангуяа тэдгээр журам нь эмэгтэйчүүдийн төрийн албан тушаалд өрсөлдөхөөр нэр дэвших, намын дотоод шийдвэр гаргах үйл явцад оролцох, санхүүжилт болон намын бусад хөрөнгө нөөцөөс хүртэх боломж зэрэгт нөлөөлж байдаг. Иймээс улс төрийн намын дотоод үйл ажиллагааг илүү ардчилсан, тэнцвэртэй болгох зохицуулалт хийх нь эрэгтэй, эмэгтэй намын гишүүдийн өрсөлдөөний талбарыг тэнцвэртэй болгох эхний чухал алхам болно.

1.3. Гарын авлагын зорилго

ЕАБХАБ-ын гишүүн улс орнууд шударга, ардчилсан нийгмийн нэг үндсэн шалгуур нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдал гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч, улс төр, нийтийн бүхий л салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг бүрэн дүүрэн оролцуулах бололцоог чухалчлан дэмждэг гэсэн үндсэн ойлголт дээр тус гарын авлага тулгуурласан болно. Жендэрийн тэгш байдлыг дэмжих тухай ЕАБХАБ-ын 2004 онд батлагдсан Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу улс төр, нийтийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зорилгоор тэгш бололцоог хангаж ажиллахад нь ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх үүргийг АИХЭА-нд хариуцуулсан байдаг¹⁵.

Орон нутгийн болон үндэсний түвшний улс төрд эмэгтэйчүүд хэр зэрэг оролцох вэ гэдэгт улс төрийн нам нөлөө үзүүлж чадна гэдгийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр улс төрийн намд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг дээшлүүлэхэд АБХАБ-ын гишүүн улс орнуудад үзүүлэх дэмжлэгийн нэг хэсэг болгон энэхүү гарын авлагыг АИХЭА-наас эрхлэн бэлтгэлээ¹⁶. Эмэгтэйчүүдийг намын гишүүн, шийдвэр гаргагч, төрийн албанд нэр дэвшигчийн хувиар оролцуулахыг дэмжсэн арга хэмжээг улс төрийн намаас сайн дурын үндсэн дээр боловсруулж, хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх тодорхой арга замыг гарын авлагад тусгав. Түүнчлэн намын бодлого, дотоод тогтолцоо, үйл явцад жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг судалж, танилцуулав.

Улс төрийн намууд өөрийн улс орны хууль тогтоомж, олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөх ёстой. Үүний зэрэгцээ сонгуульд амжилттай үр дүн үзүүлэх, улс төрийн эрх мэдэл олж авах нь намуудын хамгийн их сонирхдог зүйл гэдэг өнцгөөс харж энэхүү гарын авлагыг боловсруулсан. Улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжсэн бодлого хэрэгжүүлэх хөшүүрэг байх хэрэгтэй бөгөөд уг хөшүүрэг нь нам сонгуульд хангалттай олон санал авах, төсвийн хөрөнгө нөөцөөс хүртэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх, олон нийтийн дунд дүр төрхөө сайжруулах, намын дотоод бүтэц, дүрэм журмаа боловсронгуй, үр ашигтай болгох зэрэгт нэмэр болохоор байгаа нөхцөлд л намууд ийм бодлого хэрэгжүүлэх магадлалтай.

Үнэндээ эмэгтэйчүүдийг улс төрд илүү оролцуулах нь намуудад бодит үр дүн авчирдагийг энэхүү гарын авлага нотлон харуулж байна. Нэг талаас, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад урт насалдаг тул сонгогчдын олонх болж байдаг. Мөн эмэгтэйчүүд сонгуульд илүү идэвхтэй оролцож, саналаа өгдөг бөгөөд “амжилттай нам, нэр дэвшигчдэд” ялалт авчрах саналыг эмэгтэйчүүд өгч чадна гэдгийг НҮБХХ, Ардчиллын үндэсний хүрээлэнгийн хамтарсан судалгааны тайланд дурджээ¹⁷. Иймээс

15 OSCE Ministerial Council, Decision No. 14/04, “OSCE Action Plan for the Promotion of Gender Equality”, Sofia, 7 December 2004, <<http://www.osce.org/mc/23295>>.

16 In this way, the handbook supplements the information in: Pippa Norris and Mona Lena Krook, “Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan”, (Warsaw: OSCE, 2011), <www.osce.org/odihr/78432>; OSCE/ODIHR and the Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010, <www.osce.org/odihr/77812>; and other OSCE publications or OSCE-commissioned publications.

17 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women’s Political Participation,

улс төрийн намууд эмэгтэй сонгогчдыг үл тоомсорлох аргагүй юм. Дэлхийн олон улс оронд улс төрийн намууд үүнийг хүлээн зөвшөөрч, намдаа эмэгтэй сонгогчдыг татах нэг арга нь олон эмэгтэйг нэр дэвшүүлэх явдал гэж үзэж байна¹⁸.

Нөгөө талаас, сонгогдоогүй эмэгтэйчүүд намын анхан шатны байгууллагад чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ сонгогдсон эмэгтэйчүүд ч намаа бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг¹⁹. Парламентын эмэгтэй гишүүд эрэгтэй гишүүдтэй харьцуулахад хууль тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ намдаа илүү үнэнч ханддаг, (мөн зөрүүтэй байр суурьтай байх үе гардаг ч) намын чиг шугамаас хазайх нь бага байдаг байна²⁰. Энэ нь нам тогтвортой байх, намаас бодлогын үр дүнг төлөвлөж зохицуулахад хялбар дөхөм болгодог. Эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд хууль тогтоох үйл ажиллагаанд илүү үр дүнтэй оролцдог ажээ. Тэд илүү олон хуралдаанд оролцож, илүү олон хуулийн төсөл санаачилж, сонгогчидтойгоо илүү олон удаа үүлздаг²¹. Энэ нь тухайн намд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлнэ. Хууль тогтоох байгууллагад олон эмэгтэй төлөөлөгч байх тусам түүний хүлээн зөвшөөрөгдөх байдал эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь дунд дээшилдэгийг судалгаагаар тогтоосон байна²².

Тиймээс ЕАБХАБ-ын бүс нутаг дах улс төрийн намуудын хувьд улс төрд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих нь норматив болон прагматик ач холбогдолтой тул тус гарын авлагыг эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр одоо үйл ажиллагаа явуулж байгаа эсэхээс нь үл хамааран улс төрийн намын удирдлагууд, парламентын гишүүд, нэр дэвшигчид, иргэний нийгмийн байгууллага, хувь хүмүүс зэрэг уншигчдад зориулаа. Гарын авлагын зорилго нь улс төрд эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх бололцоог нэмэгдүүлэх хамгийн үр дүнтэй практик арга хэмжээг ЕАБХАБ-ын бүс нутгийн туршлагад тулгуурлан танилцуулах замаар улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэхийн ач холбогдлыг харуулах явдал юм.

1.4. “Эмэгтэйчүүд улс төрийн намд” төсөл, гарын авлагын арга зүй

Энэхүү гарын авлагыг АИХЭА-наас хэрэгжүүлсэн “Эмэгтэйчүүд улс төрийн намд” төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв. Тус төсөл нь улс төрийн намын удирдлага, шийдвэр гаргагчид, нэр дэвшигчдийн зүгээс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадавхыг дээшлүүлэх зорилготой байв. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх үүднээс жендэрийн квот тогтоох

UNDP/NDI, 2011, p.25, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/em-pow-er-women-political-parties.html>>, p. 65.

- 18 Louise K. Davidson-Schmich, “Implementation of Political Party Gender Quotas: Evidence from the German Lander 1990–2000”, *Party Politics*, Vol. 12, No. 2, 2006, pp. 211–232; Miki Caul Kittilson, *Challenging Parties, Changing Parliaments: Women and Elected Office in Contemporary Western Europe* (Columbus: Ohio State University Press, 2006); Joni Lovenduski and Pippa Norris (eds.), *Gender and Party Politics* (London: Sage, 1993); Richard E. Matland and Donley T. Studlar, “The Contagion of Women Candidates in Single-Member District and Proportional Representation Electoral Systems: Canada and Norway”, *Journal of Politics*, Vol. 58, No. 3, 1996, pp. 707–733; Petra Meier, “The Mutual Contagion Effect of Legal and Party Quotas: A Belgian Perspective”, *Party Politics*, Vol.10, No. 5, 2004, pp. 583–600.
- 19 Jo Freeman, *A Room at a Time: How Women Entered Party Politics* (Lanham: Rowman & Littlefield, 2002); Joni Lovenduski and Pippa Norris (eds.), *Gender and Party Politics*, (London: Sage, 1993).
- 20 Ayşe Güneş Ayata and Fatma Tütüncü, “Critical Acts without a Critical Mass: The Substantive Representation of Women in the Turkish Parliament”, *Parliamentary Affairs*, Vol. 61, No. 3, 2008, pp. 461–475; Philip Cowley and Sarah Childs, “Too Spineless to Rebel? New Labour’s Women MPs”, *British Journal of Political Science*, Vol. 33, No.3, 2003, pp. 345–365. The literature suggests that the roots of women’s loyalty are diverse. In addition, some women may feel compelled to be loyal, knowing that they may be easily replaced on party lists if they do not adhere to the party and party leader’s line.
- 21 Sarah F. Anzia and Christopher R. Berry, “The Jackie (and Jill) Robinson Effect: Why Do Congresswomen Outperform Congressmen?”, *American Journal of Political Science*, Vol. 55, No. 3, 2011, pp. 478–493; Paul Chaney, “Critical Mass, Deliberation and the Substantive Representation of Women: Evidence from the UK’s Devolution Programme”, *Political Studies*, Vol. 54, No. 4, 2006, pp. 691–714; Rainbow Murray, “Second Among Unequals? A Study of Whether France’s ‘Quota Women’ Are Up to the Job”, *Politics & Gender*, Vol. 6, No. 1, 2010, pp. 93–118.
- 22 Leslie A. Schwindt-Bayer and William Mishler, “An Integrated Model of Women’s Representation”, *Journal of Politics*, Vol. 67, No. 2, 2005, pp. 407–428.

зэрэг хуулийн зохицуулалтад их анхаарал тавьж ирснийг харгалзан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тэгш бололцоо олгох үүднээс намууд өөрсдөө сайн дурын үндсэн дээр дотооддоо хэрэгжүүлж болох сайн түршлага олж, эмхэтгэн гаргахыг хичээв.

Гарын авлага нь төслийн хүрээнд хэрэгжүүлсэн олон ажлын үр дүнд бий болсон. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар дэлхийн хэмжээнд, тэр дундаа ЕАБХАБ-ын бүс нутгийн хүрээнд ЕАБХАБ, олон улсын бусад байгууллага, төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгааг нягтлан судалж үзсэн²³. Түүнчлэн төслийн хүрээнд сонгон авсан Албани, Гүрж, Казахстан, Киргизстан, Молдав таван улсын иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран судалгаа хийв²⁴. Судалгаагаар эдгээр улс оронд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд тулгарч буй нийтлэг бэрхшээлийг тодорхойлохыг зорьсон юм. Ялангуяа улс төрийн намын дотоод дүрэм журам нь эмэгтэйчүүдийн оролцоонд хэрхэн эерэг, сөргөөр нөлөөлж болох тухай мэдээлэл цуглуулахыг эрмэлзсэн. Ийм дүрэм журамд намд гишүүн элсүүлэх, намын дотоод бүтцэд шат ахиулах, нэр дэвшигчийг сонгож, нэр дэвшүүлэх журам, шийдвэр гаргах, бодлого боловсруулах үйл явц, намын хөрөнгө нөөц хуваарилах журам зэргийг хамааруулан үзэж судлав. Анхдагч мэдээллийг гурван асуулгатай судалгаагаар цуглуулсан. Санал асуулгын хуудсыг парламентын гишүүд, улс төрийн намын эмэгтэй гишүүд, иргэний нийгмийн төлөөлөгч, сонгууль зохион байгуулах байгууллага, жендэрийн тэгш байдлын асуудал хариуцсан төрийн байгууллагын албан хаагч зэрэг 150 гаруй оролцогчид тараан өгсөн. Судалгааны үр дүнд тулгуурлан 1000 гаруй өгөгдөлтэй өвөрмөц мэдээллийн санг бий болгосон.

АИХЭА-ны хөрөнгө нөөц, цаг хугацааны бололцоо болон улс төрийн оролцогчдоос мэдээлэл цуглуулахад тулгарсан зарим нэг бэрхшээлээс шалтгаалан тус судалгаа нь (цаашид АИХЭА-ны 2012 оны судалгаа гэх²⁵) ЕАБХАБ-ын бүс нутаг, мөн сонгон авсан таван улсын улс төрийн бүх намын хүрээнд дэх эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг статистикийн хувьд төлөөлөх боломжгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй²⁶. Гэлээ ч дээр өгүүлсэн нэгдсэн мэдээллийн сан нь сонгон авсан таван улсад эмэгтэйчүүдийн улс төрийн нам дах оролцоог дээшлүүлэхэд тулгарч буй бэрхшээл, сайн түршлага, сургамжийг агуулсан баялаг эх сурвалж болсон юм.

Судалгаанаас үлдэж хоцорсон зарим асуудлыг эдгээр таван улс тус бүрт зохион байгуулсан сургалтаар²⁷ нөхсөн гэж үзэж болох юм²⁸. Сургалт семинар бүрийн эхэнд улс төрийн намын удирдлагуудтай дугуй ширээний ярилцлага хийсэн бөгөөд үүний дараа намын гишүүн эмэгтэйчүүд, сонгуульд албан тушаалд нэр дэвшихээр төлөвлөж байгаа эмэгтэйчүүдэд хоёр өдрийн эрчимжүүлсэн сургалт зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээ тус бүр дээр улс төрийн намын хүрээнд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн

23 For example: Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation, UNDP/NDI, 2011, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>; "Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan", OSCE/ODIHR, 2011, <<http://www.osce.org/odihr/78432>>; Handbook for National Human Rights Institutions on Women's Rights and Gender Equality, OSCE/ODIHR, 2012, <<http://www.osce.org/odihr/97756?download=true>>. For a full list, see Bibliography.

24 These participating States were chosen as pilot countries for the project based on concrete requests for assistance by participating States and to achieve the objective of conducting research in States with different electoral and political systems. The relevant partner organizations in each country are as follows: Women in Development/Millennium Women Network (www.albania-mwn.org) (Albania); Women's Information Center (www.wicge.org) (Georgia); Feminist League (www.empowering-women.kz) (Kazakhstan); Alliance of Women Legislative Initiatives (AWLI)/Social Technologies Agency STA (<http://www.awli-kg.org>) (Kyrgyzstan); Partnership for Development Centre PROGEN (www.progen.md) (Moldova).

25 Henceforth referred to as "2012 ODIHR Survey on Women in Political Parties" or "2012 ODIHR Survey". This ODIHR Handbook on Promoting Women's Participation in Political Parties is the first publication to apply the data from this survey.

26 Specifically, challenges arose in reaching a set number of interviews, completing interviews, as well as ensuring a random sample of interviewees. Some of the gaps that remained following the field research were addressed through the implementation of training programmes

27 For more information on the training programmes conducted, see the OSCE/ODIHR website: <www.osce.org/odihr/gender>.

28 Training programmes were organized in Georgia in April 2012, Albania in June 2012, Moldova in September 2012, Kazakhstan in November 2012 and Kyrgyzstan in April 2013.

тэгш оролцоог дэмжиж ажиллахад намын удирдлага, жендэрийн тэгш байдлын төлөө ажилладаг идэвхтнүүд, нэр дэвшигч болон сонгогдсон албан тушаалтнуудад тулгардаг бэрхшээлийн талаар ярилцсан болно. Мөн гарын авлагын тодорхой бүлгийг сургалтын материал болгон оролцогчдод тараан өгч, агуулгыг өөр өөр улс орны нөхцөл байдалд туршин, шалган баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд өөрчлөн шинэчилсэн. Сонгон авсан бүс нутгийн таван улсын улс төрийн хөгжил, сонгуулийн тогтолцоо, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн түвшин өөр өөр байсан нь ЕАБХАБ-ын бүс нутгийн хувьд эмэгтэйчүүдийн оролцоо улс төрийн намд ямар байгаа тухай дүр зургийг бий болгосон гэж үзэж байна. Гэхдээ улс орон бүр тэр ч байтугай улс төрийн нам бүр өөрийн өвөрмөц онцлогтой гэдгийг мартаж болохгүй юм. Ийм ч учраас сонгон авсан таван улс орон ЕАБХАБ-ын бүс нутгийн нөхцөл байдлыг бүхэлд нь төлөөлөн харуулж чадахгүй билээ.

Шигтгээ 1.6. “Улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” гарын авлагыг хэрхэн бүтээсэн бэ?

Гарын авлагад мэдээллийг цуглуулж эмхэтгэн оруулахын тулд АИХЭА-ны төслийн баг олон үйл ажиллагаа явуулсан. Үүнд түнш байгууллагуудтай хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэв.

- Өмнө хийгдсэн судалгаа, бүтээл зэрэг хоёрдогч эх сурвалжийг судлав. Үүнд:
 - » 200 орчим ном, эрдэм шинжилгээний нийтлэл, цахим эх сурвалж, сургалт сурталчилгааны материал
 - » АИХЭА-наас гаргасан сонгуулийн ажиглалтын тайлан зэрэг баримт бичгүүд, олон улсын болон ТББ-уудын тайлан
- Англи, орос хэл дээр санал асуулгын хуудас боловсруулав.
 - » Гурван өөр фокус бүлэгт чиглэсэн санал асуулгын хуудас боловсруулж
 - жендэрийн асуудал хариуцсан төрийн/үндэсний байгууллагын төлөөлөгчид;
 - сонгуулийн зохион байгуулалт хариуцсан төрийн/үндэсний байгууллагын төлөөлөгчид;
 - сонгон авсан таван улсын улс төрийн гол намын удирдлага, парламентын гишүүд (эрэгтэй, эмэгтэй), улс төрийн идэвхтнүүдэд тарааж өгсөн.
- Ярилцлага зохион байгуулав (АИХЭА-ны 2012 оны судалгаа гэх):
 - » 2011 оны 8 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд Албани, Гүрж, Казахстан, Киргизстан, Молдав улсад 150 хагас бүтэцлэгдсэн ярилцлага зохион байгуулав.
 - » Тухайн улсын хэл дээрх хэвлэл, бусад мэдээллийг судалсан.
- Цогц мэдээллийн сан үүсгэв:
 - » Тус сан нь судалгааны үр дүн дээр

тулгуурласан 1,000 гаруй өгөгдөл бүхий мэдээлэлтэй.

- Улс орны нөхцөл байдлын талаар жишээ болгох тохиолдлыг олж, мэдээлэл болгон бэлтгэв.
 - » Улс төрийн намын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцоход тулгардаг бэрхшээлийн талаар сонгон авсан таван улсын иргэний нийгмийн байгууллагууд таван жишээ болох тохиолдлыг судлан, мэдээлэл бэлтгэж ирүүлсэн.
- Гарын авлагын загварыг боловсруулав:
 - » Гурван зорилтот бүлэг (улс төрийн намын удирдлага; эмэгтэй улс төрчид; иргэний нийгмийн байгууллага)-т чиглэсэн тодорхой арга хэмжээний саналыг боловсруулав.
- Дугуй ширээний ярилцлага, семинар, сургалт зохион байгууллаа:
 - » Дээр дурдсан зорилтот бүлэг тус бүрт чиглэсэн дугуй ширээний ярилцлага, сургалт, семинарыг сонгон авсан таван улсад зохион байгуулав.
 - » Гарын авлагад орсон арга хэмжээний саналын талаар улс төрийн намын удирдлага, эмэгтэй нэр дэвшигч, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын төлөөлөгчдөд танилцуулж, хэлэлцэж, шалган баталгаажуулсан.
- Олон тооны зөвлөлгөөнийг зохион байгуулав:
 - » Гарын авлагатай холбоотойгоор олон улсын 20 гаруй зөвлөхийн санал, зөвлөмжийг авав.
 - » ЕАБХАБ-ын төлөөлөгчийн газрууд, харьяа байгууллагын 20 гаруй ажилтан гарын авлагын тодорхой хэсгийг уншиж танилцан саналаа илэрхийлсэн.

1.5. Гарын авлагыг хэнд зориулсан тухай, гарын авлагын бүтэц

Гарын авлагыг боловсруулахдаа улс төрийн намын удирдлага, намын эмэгтэй гишүүд, нэр дэвшигчид, иргэний нийгмийн байгууллагууд гэсэн гурван онцлог зорилтот бүлгийг бодолцов. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог илүү учир холбогдолтой болгох чиглэлээр арга хэмжээ авах сэдэл төрүүлэх, зоригжуулах, итгүүлэн үнэмшүүлэхэд эдгээр зорилтот бүлэг тус бүрт өөр өөр тайлбар үндэслэл, санал зөвлөмж нөлөөлөх тул сайн туршлага, сургамжийг зорилтот бүлгийн онцлогийг харгалзсан байдлаар бэлтгэн танилцуулж байна.

- **Улс төрийн намын удирдлага** нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд дэмжлэг үзүүлэх эсвэл саад тотгор учруулахад гол үүрэгтэй байдаг тул тэднийг үндсэн зорилтот бүлгээ болгосон. Улс төрийн намын удирдлагуудад зориулсан бүлэгт намын дотоод бодлого, дүрэм журам, практикийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алинд нь илүү нээлттэй, шударга, тэнцвэртэй болгоход чиглэсэн арга хэмжээний саналыг тусгав.
- Хоёр дах зорилтот бүлэгт намын удирдлага, сонгуулийн сурталчилгааны ажлын менежер, намын нэр дэвшигч, сонгогдсон төлөөлөгч, намын идэвхтэн зэрэг **улс төрд оролцох, шат ахих эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийг** хамруулав. Улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдэд зориулан улс төрийн карьераа төлөвлөх, хэрэгжүүлэхэд нь хэрэг болох практик аргуудыг санал болгон дэвшүүлэв.
- Гурав дах зорилтот бүлэг нь жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод шинэчлэлийн бодлого санаачилж, хэрэгжүүлэхэд нь улс төрийн байгууллагад шахалт үзүүлж чадах **иргэний нийгмийн байгууллага**, эмэгтэйчүүдийн бүлгэм, холбоо, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагууд юм.

Гарын авлагын ерөнхий зорилго нь эмэгтэйчүүдийг улс төрийн нам, төрийн албаны хүрээнд илүү эрх мэдэлжүүлэхэд ашиглаж болох тайлбар үндэслэл, арга, сайн туршлагыг дээр дурдсан зорилтот бүлгүүдэд хүргэх явдал болно. Үүнээс гадна сонгууль, жендэрийн эрх тэгш байдлын асуудал хариуцсан төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага зэрэг шаардлагатай өөрчлөлтийг хийхэд улс төрийн намуудад нөлөөлж чадах байгууллагуудад ч энэхүү гарын авлага тустай. Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны ажил, нэр дэвшигчдийн талаар сурвалжлага бэлтгэн хүргэхдээ жендэрийн хэвшмэл ойлголтод баригдахгүй байх, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор гарын авлагыг ашиглаж болно.

Жендэрийн эрх тэгш байдал, улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн асуудлаар мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор мэргэжилтнүүд, практик туршлагатай хүмүүсийн боловсруулсан ерөнхий онол, үзэл санаа, зохион байгуулалтын санал, санаачилгыг гарын авлагад мөн багтаалаа. Тухайлбал сонгуульд өрсөлдөх эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийн тоо, тэдний мэргэжил, боловсролын байдал (нийлүүлэлт), улс төрийн элит бүлэг болон сонгогчдын дунд эмэгтэй нэр дэвшигчдийн хэрэгцээ (эрэлт)-г харгалзсан намын гишүүн болон нэр дэвшигч элсүүлэх “эрэлт, нийлүүлэлт”-ийн загварыг дурдаж болох юм.

Нэр дэвшигчдийн дунд нийгмийн олон янзын төлөөллийг нэмэгдүүлэхэд улс төрийн намуудын ашигладаг арга барилын загварыг гарын авлагын тодорхой хэсгүүдэд оруулсан. Тухайлбал, улс төрийн намуудын ашигладаг ийм арга барилд *эрх тэгш байдлын талаар ярих* (намын мөрийн хөтөлбөр, сонгуулийн сурталчилгаа, намын удирдагын хэлэх үгэнд тэнцвэртэй төлөөллийг уриалах зэрэг), *эрх тэгш байдлыг дэмжих* (эмэгтэйчүүдийг улс төрд ороход нь сургаж бэлтгэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх), *эрх тэгш байдлыг баталгаажуулах*

(намын жагсаалтад орох эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор жендэрийн квот тогтоох зэрэг бодлогын арга хэмжээг намын түвшинд авч хэрэгжүүлэх) багтана. Намын удирдлага болон эмэгтэйчүүд өөрсдөө улс төр дэх жендэрийн эрх тэгш байдлын талаарх онол, үзэл баримтлалыг сайн мэдэж авснаар уг асуудлыг сурталчлахдаа цэгцтэй хандах, зөв тайлбар өгөх чадвартай болно.

Гарын авлагад орсон мэдээлэл, жишээ нь ямар нэгэн улс төрийн бодлого, хөтөлбөр, улс төрийн намын байр суурийг дэмжсэн буюу санал нийлсэний улмаас биш харин улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд ач холбогдолтой сайн туршлага гэж үзсэнтэй холбоотойг онцлон тэмдэглэе.

Практик хэрэглээнд зориулсан гэдэг утгаараа гарын авлагыг уншигч хэрэглэхэд хялбар бүтэцтэйгээр боловсруулав. Бүлэг тус бүр бие даасан шинжтэй боловч эмэгтэйчүүдийн улс төрийн байдлыг дээшлүүлэх зорилгын үүднээс гарын авлагын бүх бүлгийг нэгтгэн хэрэглэвэл үр дүнтэй гэж АИХЭА-наас үзэж байна. Улс төрийн карьераа ахиулахын тулд эмэгтэйчүүд, жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид өөрсдийн хүч чадлаа сайтар дайчилж, зохион байгуулагдах шаардлагатай. Жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх шинэчлэлийг явуулахад эмэгтэй, эрэгтэй намын гишүүдийн аль алиных нь, мөн намын удирдлагын дэмжлэг хэрэгтэй. Түүнчлэн иргэний нийгмийн байгууллага болон гадны бусад оролцогч, байгууллагуудын үүрэг оролцоо ч чухал. Товчдоо, аль нэг бүлэг хүн эсвэл аль нэг арга барил дангаараа үр дүнд хүрэх боломжгүй: намын удирдлага, эмэгтэй улс төрчид, жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид, иргэний нийгмийн хүчин чадлыг нэгтгэсэн арга барил л үр дүнд хүргэнэ.

Эцэст нь, гарын авлагын 1.4 дэх хэсэгт дурдсанчлан судалгааны хязгаарлагдмал байдлын талаар цөөн үг хэлэх нь зүйтэй болов уу. Нэгдүгээрт, гарын авлага нь үндсэн зорилготой бүлгүүдэд санаа өгөх сайн туршлагын цомог юм. Гэхдээ улс төрийн намуудын хаагдмал шинж чанар болон гишүүн улс орнуудын хүрээнд тус асуудал харьцангуй шинэ сэдэв гэдгээс хамааран улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих бүхий л сайн туршлагыг багтааж чадаагүй гэдгийг тэмдэглэе. Цаашилбал, бусадтай харьцуулахад зарим нэг гишүүн улс орны жишээг түлхүү оруулсан мэт санагдаж болох юм. Энэ нь гарын авлагыг боловсруулах явцад тулгарсан судалгааны хязгаарлагдмал байдалтай холбоотой.

Түүнчлэн ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудын улс төрийн нөхцөл байдал өөр өөр бөгөөд улс төрийн нам бүр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой тул гарын авлагад тусгасан арга барилыг уншигчид өөртөө тохируулан хэрэглэх нь зүйтэй. Аль нэг арга барилыг сонгохдоо өөрийн улс орны ардчиллын туршлага, үндэсний онцлог, сонгуулийн болон улс төрийн тогтолцоо, улс төр, нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, нийгэм соёлын түүхэн байдлыг харгалзан үзэж, эдгээрт тохируулан хэрэглэхийг зөвлөж байна.

Эцэст нь хэлэхэд, намын удирдлага, намын идэвхтэн, намын гишүүдийн хоорондын ялгааг гарын авлагад төдийлэн тусгайлан харгалзаж үзээгүй гэдгийг хэлэх нь чухал юм. Намын гишүүд, удирдлагын дийлэнх нь эрэгтэй байдаг учраас намын хүрээнд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжсэн өөрчлөлт хийхэд намын жирийн гишүүд илүүтэй эсэргүүцэж болох талаар зарим судалгаанд өгүүлсэн байдаг²⁹. Жендэрийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх зорилгоор нам дотроо идэвхтнүүд эсвэл намын удирдлага энэхүү гарын авлагад тусгасан арга барилыг хэрэглэхээр сонгон авч болох ч хэн нь хэрэглэхэд зохимжтой болох талаар ялгаж өгөөгүйд гарын авлагын нэг хязгаарлагдмал тал оршиж байгаа юм. Ийм учраас намын удирдлага, жирийн гишүүний хоорондын харилцааны онцлогийг харгалзсан судалгаа, тусгайлсан арга барилыг цаашид боловсруулах хэрэгцээ бий.

29 See, for example, survey results captured in Women's Participation in Politics and Decision-Making in Ukraine: A Strategy Paper, developed by the Ukrainian Women's Fund in 2011. Available at: <<http://www.osce.org/odihr/85974>>. See also research undertaken by Professor Susan Scarrow.

Уншигчдад хялбар болгох үүднээс гарын авлагыг зургаан бүлэгт хуваасан.

Нэгдүгээр бүлэг. Оршил хэсэгт ЕАБХАБ-ын бүс нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ямар байгааг судалж, түүнийг дээшлүүлэхэд улс төрийн нам ямар онцлох үүрэг гүйцэтгэдэг талаар өгүүлэв.

Хоёрдугаар бүлэг. Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг улс төрийн албан тушаалд дэвшүүлэх асуудлыг яагаад дэмжин сурталчлах хэрэгтэй вэ? Энэ бүлэгт жендэрийн тэнцвэртэй байдлын хэрэгцээ шаардлага, энэ нь улс төрийн намуудад стратегийн ямар ач холбогдолтой болохыг танилцуулах замаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих ямар үндэслэл, тайлбар байдгийг толилуулав.

Гуравдугаар бүлэг. Улс төрийн намууд, намын удирдлага. Тус бүлэгт эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор сонгуулийн мөчлөгийн өөр өөр үе шатанд ашиглаж болох олон аргаас намын удирдлагад зориулан танилцуулсан. Намын дотоод үйл явц, дүрэм журам болон эдгээр нь эмэгтэйчүүдийн улс төрийн ахиц дэвшилд ямар эерэг болон сөрөг нөлөөтэй байж болох талаар өгүүлэв. Түүнчлэн эмэгтэйчүүдийг намын гишүүн, шийдвэр гаргагч, удирдагч болгох, төрийн албан тушаалд *намаас нэр дэвшүүлэн өрсөлдүүлэх эрэлт* бий болгох аргаас дурдав.

Дөрөвдүгээр бүлэг. Улс төрийн нам дах эмэгтэйчүүд. Энэ бүлэгт сонгуульт албан тушаалд өрсөлдөх, намын удирдлага буюу шийдвэр гаргагч, сонгуулийн сурталчилгааны ажлын менежер, намын идэвхтэн болохыг эрмэлзэж буй улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдийн асуудлыг онцлон авч үзсэн. Улс төрийн карьер хийх сонирхолтой эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл, мэдлэг, намын хөрөнгө нөөцөөс олж авах арга зам, намын удирдах албан тушаал хаших бололцоог нэмэгдүүлэх замаар *нийлүүлэлтийг* сайжруулахад чиглэсэн арга замыг толилуулав. Иймд улс төрд хөл тавьж байгаа эмэгтэйчүүдийн хандлага, шалтгаан болон жендэрийн талаарх амь бөхтэй хэвшмэл ойлголттой тэмцэх, улс төрийн шат дамжлагаар урагш ахихад шаардлагатай чадавх, нөөц бололцоог нэмэгдүүлэх асуудлыг онцлон авч үзлээ.

Тавдугаар бүлэг. Иргэний нийгмийн байгууллага, бусад оролцогчид. Улс төрийн нам, төрийн сонгуульт албан тушаалд жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох зорилтыг биелүүлэхэд улс төрийн намын удирдлага, намын эмэгтэй гишүүдэд иргэний нийгмийн зүгээс туслалцаа дэмжлэг үзүүлдэг чухал үүргийн талаар энэ бүлэгт авч үзнэ. Тухайлбал, хэвлэл мэдээллээр аян өрнүүлэх, санхүүжилт олох, чадавх дээшлүүлэх үйл ажиллагаа явуулах, мэдлэг мэдээллийн сүлжээ үүсгэх, жендэрийн аудит хийх зэргээр иргэний нийгмийн зүгээс эмэгтэйчүүд болон улс төрийн намд үзүүлж болох дэмжлэг туслалцааны аргаас толилуулав.

Зургаадугаар бүлэг. Дүгнэлт хэсэгт өмнөх бүлэг тус бүрийн гол дүгнэлт болон цаашид авах арга хэмжээг санал болгон дэвшүүлэв.

Хавсралт хэсэгт жендэрийн эрх тэгш байдлын талаарх ЕАБХАБ-ын болон олон улсын хэм хэмжээний холбогдох хэсэг, тоймыг танилцуулав. Түүнчлэн гарын авлагад ашигласан арга зүйн загвар хуудсуудыг нам дотооддоо жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шууд эсвэл өөрчлөн ашиглах боломжтой. Мөн хавсралтад жишиг тохиолдлууд, бусад хэрэгтэй мэдээллийг багтаасан. Гарын авлагатай хамт практик сургалтын материал боловсруулж гаргасан тул сонирхсон ямар ч байгууллага үүнийг ашиглаж болно.

Энэхүү гарын авлага нь улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог илүү ач холбогдолтой болгох зорилгоор үр дүнтэй арга барил, санал, санаачилгыг олж илрүүлэх үүднээс хийгдсэн анхны оролдлого бөгөөд цаашид олон ийм ном, товхимол гарна гэдэгт АИХЭА итгэж байна. Иймээс дараачийн хэвлэлд оруулж болох сайн туршлага, мэдээлэл байвал бидэнд ирүүлэхийг уншигчдаасаа хүсье.



Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг улс төрийн албан тушаалд дэвшүүлэх асуудлыг яагаад дэмжин сурталчлах хэрэгтэй вэ?

Хоёрдугаар бүлэг

Хоёрдугаар бүлгийн оршил

2.1. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж ирсэн учир шалтгаан

2.2. Улс төрийн намын удирдлагад ашигтай тал

2.2.1. Олон нийтийн дунд улс төрийн намын дүр төрх, нэр хүнд сайжирна

2.2.2. Намын мөрийн хөтөлбөр, бодлогыг боловсронгуй болгоно

2.2.3. Улс төрийн намын сонгуулийн сурталчилгаа хийх арга замыг сайжруулна

2.2.4. Намын гишүүнчлэл буурахаас сэргийлнэ

2.3. Улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдэд тусах ашигтай тал

2.3.1. Сонгуульт албан тушаалд өрсөлдөх сонирхолтой эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлнэ

2.4. Нийгэмд тусах ашигтай тал

2.4.1. Улс төрийн тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ

2.4.2. Бодлогод нөлөөлнө

2.4.3. Нийгэм-эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулна

2.4.4. Нийгэмд жендэрийн тэгш байдлын талаарх ойлголтыг дээшлүүлнэ

Хоёрдугаар бүлгийн дүгнэлт

Хоёрдугаар бүлгийн оршил

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдал бол шударга, аюулгүй, ардчилсан нийгмийн нэг суурь гэж ЕАБХАБ-ын гишүүн орнууд хүлээн зөвшөөрсөн байдаг. “Жендэрийн эрх тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ижил эрх, боломжийг хууль тогтоомж, бодлогоор баталгаажуулах, мөн гэр бүл, хамт олон, нийгэм доторх нөөц, үйлчилгээнээс тэгш хүртэх боломж бүрдүүлнэ гэсэн үг юм”³⁰. Энэ ойлголтонд улс төр, нийтийн салбарын бүх түвшин, хүрээнд тэгш эрхтэйгээр оролцох асуудал мөн багтана.

ЕАБХАБ-ын бүс нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо алгуур боловч нэмэгдсээр байна. Оршил хэсэгт дурдсанчлан, ЕАБХАБ-ын бүс нутгийн парламентууд дах эмэгтэйчүүдийн төлөөлөл 2013 онд 24.8 хувь байсан нь 2000 оны түвшнээс 17 хувиар илүү байгаа юм. Гэвч эмэгтэйчүүдийн төлөөллийн ялгаа нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудын дунд өндөр хэвээр, бүх шатны улс төрийн болон төрийн албаны шийдвэр гаргах түвшний албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн тоо хэт цөөн байна. АИХЭБ-аас явуулсан “Сонгуульт албан тушаал дах жендэрийн тэгш байдал: Зургаан алхамт үйл ажиллагааны төлөвлөгөө” суурь түвшин тогтоох судалгаагаар хэрэв эмэгтэйчүүдийн төлөөллийн өнөөгийн хандлага энэ хэвээр үргэлжилбэл ЕАБХАБ-ын бүс нутагт **50 жилийн** дараа, дэлхий дахинд **150 жилийн** дараа л сонгуульт албан тушаал дах жендэрийн эрх тэгш байдал бий болно³¹ гэсэн дүн гарсан байна.

Олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт байгаа ч ЕАБХАБ-ын бүс нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн идэвхтэй, бүрэн оролцоог дэмжсэн хүчин чармайлтыг улс төрийн намууд өөрсдөө тэр бүр манлайлж чадахгүй байна. Намын эмэгтэй гишүүдийн тоо эрэгтэйчүүдийнхтэй тэнцсэн тохиолдолд ч намын соёл, мөн тухайн намын үйл ажиллагаанд нөлөөлж байдаг албан болон албан бус практик нь эмэгтэйчүүд нам дотроо болон сонгуульд ахиц гаргахад бэрхшээл үүсгэж байх талтай. Улс төрийн намууд яагаад эмэгтэйчүүдийн улс төрийн байдлыг дээшлүүлэх, жендэрийн мэдрэмжтэй нам болоход анхаарах ёстой вэ? ЕАБХАБ-ын гишүүн орнуудын улс төрийн намууд

Жендэрийн эрх тэгш байдал гэдэг нь хууль, бодлогоор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ижил эрх, боломжийг баталгаажуулах, мөн гэр бүл, хамт олон, нийгэм доторх нөөц, үйлчилгээнээс тэгш хүртэх боломж бүрдүүлнэ гэсэн үг юм. Энэ ойлголт нь ардчилсан засаглал, шийдвэр гаргах, батлан хамгаалах гэх мэт амьдралын бүх салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил, тэгш оролцох, хүртэх боломжтой байхыг хэлж байгаа юм.

Эх сурвалж: “АИХЭА ба жендэрийн тэгш байдал” мэдээллийн хуудас, ЕАБХАБ/АИХЭА, <<http://www.osce.org/odihr/103449>>

Шигтгээ 2.1: ЕАБХАБ-ын бүс нутгийн улс орнуудын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь

ЕАБХАБ-ын бүс нутгийн парламентуудад эмэгтэйчүүдийн гийн төлөөлөл 24.8 хувь байна. АИХЭА-наас явуулсан “Сонгуульт албан тушаал дах жендэрийн тэгш байдал: Зургаан алхамт үйл ажиллагааны төлөвлөгөө” суурь судалгаанд ямар нэгэн хамтын хүчин чармайлт, бодлогын арга хэмжээ авахгүйгээр эмэгтэйчүүдийн төлөөллийн чиг хандлага энэ хэвээрээ үргэлжилвэл ЕАБХАБ-ын бүс нутагт 50 жилийн дараа, дэлхий дахинд 150 жилийн дараа л сонгуульт албан тушаал дах жендэрийн тэгш байдал бий болно гэжээ.

Эх сурвалж: АИХЭА-ны захиалгаар Pippa Norris, Mona Lena Krook нарын хийсэн Сонгуульт албан тушаал дах жендэрийн тэгш байдал: Зургаан алхамт үйл ажиллагааны төлөвлөгөө” судалгаа, 2011

30 See “Gender”, Legislationline, OSCE/ODIHR, <http://legislationline.org/topics/topic/7>; and “ODIHR and Gender Equality Fact Sheet”, OSCE/ODIHR <<http://www.osce.org/odihr/103449>>.

31 Pippa Norris and Mona Lena Krook, “Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan”, (Warsaw: OSCE/ ODIHR, 2011), p. 53, <<http://www.osce.org/odihr/78432>>.

болон улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж ирсэн уламжлалт учир шалтгааны ихэнх нь хүний эрхийн олон улсын тогтолцооны хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх, ардчилсан гэх нэр төрөө бэхжүүлэх шаардлага, ардчиллын институтууд, ялангуяа парламентын төлөөллийн чанарыг нэмэгдүүлэх сонирхлоос үүдэлтэй байдаг.

Ардчиллын бүхий л институт, түүний дотор улс төрийн намууд үйл ажиллагаандаа хүний эрхийн болон олон улсын нийтлэг хэм хэмжээг удирдлага болгох ёстой ч энэхүү гарын авлагад улс төрийн нам бол сонгуульд амжилттай үр дүн үзүүлэхийг л илүү сонирхдог гэсэн логикийг хүлээн зөвшөөрч байгаа билээ. Сонгуульд амжилттай оролцсоноор улс төрийн нам нь институтуудын ажиллаж буй арга хэлбэрт нөлөөлөх, төрийн бодлогыг тодорхойлох боломжтой болдог. Эмэгтэйчүүдийг улс төрд оролцуулах нь намууд сонгуульд ялахад нэмэр болно гэдгийг нотлон харуулсан нөхцөлд л намын удирдлагууд эмэгтэйчүүдийг улс төрд шат ахиулахыг дэмжих магадлалтай.

Гарын авлагын энэ бүлэгт ЕАБХАБ-ын бүс нутагт улс төрийн болон нийтийн салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэгш оролцуулах уламжлалт учир шалтгаанаас гадна эмэгтэйчүүдийн улс төрийн байдлыг дээшлүүлэх намын удирдлагад сонирхол төрүүлэх бусад тайлбар үндэслэлийг авч үзэх болно. Эмэгтэйчүүдийн улс төрийн байдлыг дэмжсэнээр бий болох ашигтай талыг намын удирдлага ойлгож, хүлээн зөвшөөрсний дараа энэ асуудлыг намын удирдлага, сонгогчдоос ч илүү эсэргүүцэж болзошгүй намын энгийн гишүүдэд өгөх тайлбар, үндэслэлээ бодож боловсруулах хэрэгтэй юм³². Түүнчлэн жендэрийн тэгш байдлыг хангаснаар улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүд, улмаар нийгэмд тусах ашигтай талыг тайлбарлах болно.

Зураг 2.2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих учир шалтгааны тойм

Уламжлалт	Намд ашигтай тал	Эмэгтэй улс төрчдөд ашигтай тал	Нийгэмд ашигтай тал
Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, боломжийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг.	Олон нийтийн дунд намын дүр төрх, нэр хүндийг нэмэгдүүлдэг.	Төрийн сонгуульд албан тушаалд өрсөлдөх сонирхолтой эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлнэ.	Сонгуульд албан тушаалд нийгэм тэгш төлөөлөгдөх боломжийг хангана.
Улс төр дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш төлөөлөл нь ардчилсан сонгуулийн нэг урьдач нөхцөл юм.	Намын мөрийн хөтөлбөр, бодлогын чиглэлийг сайжруулдаг	Эмэгтэйчүүдийн чадавхийн талаархи нийгэм, улс төрийн оролцогчдын ойлголтыг өөрчилнө.	Бодлогод нөлөөлнө.
Оролцоотой, бүгдийг хамарсан парламентын нийтээр хүлээн зөвшөөрөгдөх, төлөөллийг хангасан байдал нь сайжирдаг.	Намын сонгуулийн болон сурталчилгааны ажлын арга замыг бэхжүүлнэ.	Эмэгтэйчүүдийн намын болон парламентын бодлогын чиглэлд нөлөөлж чадна гэсэн итгэлийг нэмэгдүүлнэ.	Нийгэм дэх жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголтыг дээшлүүлнэ.
Жендэрийн тэгш байдал нь эдийн засгийн хөгжилд түлхэц болж байдаг.	Намын гишүүнчлэл буурахаас сэргийлнэ		

32 See, for example, Ukrainian Women's Fund, Women's Participation in Politics and Decision-Making in Ukraine: Strategy Paper, commissioned by the OSCE/ODIHR, 2011, p. 13

2.1. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэижиж ирсэн учир шалтгаан

Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх олон улсын хэм хэмжээ нь ЕАБХАБ-ын бүс нутагт ажиллаж буй улс төрийн бүхий л байгууллага, улс төрийн үйл хэрэгт оролцож буй хэн бүхний үйл ажиллагаандаа удирдлага болгох хүрээ хэвээр байгаа бөгөөд ЕАБХАБ-ын гишүүн орнууд эдгээр хэм хэмжээг хүндэтгэн сахих үүрэг амлалт авсан байдаг. Гарын авлагын энэ хэсэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг баталгаажуулсан хүний эрхийн түгээмэл хэм хэмжээг иш үндэс болгон эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжин тайлбарладаг үндэслэл, мөн ардчилсан институтуудын үйл ажиллагаандаа мөрддөг олон улсын хэм хэмжээ, зарчмуудын тухай авч үзнэ.

→ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг

1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) нь “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх”, түүний дотроо төрийг удирдахад оролцох эрхийг баталгаажуулсан³³. Энэхүү тунхаглал нь эмэгтэйчүүдийн эрхийн талаарх олон улсын бусад үүрэг, эрмэлзлийн үндэс суурь болсон бөгөөд үүнээс хамгийн цогц баримт бичиг нь 1979 онд батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУТК) юм³⁴. Эмэгтэйчүүдийн эрхийн тухай “хууль” гэж ихэвчлэн нэрлэгддэг ЭЯГБХУТК-д суурилсан 1995 оны НҮБ-ын Бээжингийн тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөр “шийдвэр гаргах болон эрх мэдлийн тогтолцоонд эмэгтэйчүүдийн тэгш, бүрэн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх”-ийг гишүүн орнуудад үүрэг болгосон байдаг³⁵. “Эмэгтэйчүүдийн төлөөх Нэгдсэн Үндэстний 10 жил” (1976-1985)³⁶ санаачилгын хүрээнд бий болсон үүрэг амлалтад тулгуурласан Бээжингийн тунхаглал нь бүх эмэгтэйчүүдийн төлөө тэгш байдал, хөгжил, энх тайвны зорилгыг хангахад чиглэсэн олон улсын шинэ үүрэг, амлалт болсон билээ.

НҮБ-аас 2000 онд баталсан Мянганы тунхаглал нь үнэт зүйл, зарчим болон Мянганы хөгжлийн зорилт гэж нэрлэгддэг тодорхой найман зорилтыг тодорхойлж, 21 дүгээр зууны олон улсын зорилго болгон баталсан билээ. Энэ тунхаглалын дагуу гишүүн орнууд “ядуурал, өлсгөлөн, өвчин эмгэгтэй тэмцэх, жинхэнэ тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс жендэрийн эрх тэгш байдлыг дэмжиж, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, чадавхжуулахаар” санал нэгдсэн³⁷. Гуравдугаар зорилт болох жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах зорилтыг биелүүлэх нь Мянганы хөгжлийн зорилтын бусад долоон зорилтыг биелүүлэх үндэс болохыг нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс 2000 онд баталсан “Эмэгтэйчүүд, энх тайван болон аюулгүй байдлын тухай” 1325 тоот тогтоол нь энх тайвныг сахин хамгаалах болон аюулгүй байдлын салбарт эмэгтэйчүүдийн оролцоо чухал болохыг дахин илэрхийлсэн ба “энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн тэгш, бүрэн дүүрэн оролцоо чухал” болохыг цохон тэмдэглэсэн байдаг³⁸.

33 “The Universal Declaration of Human Rights”, United Nations (UN), Article 2: “Everyone is entitled to all the rights and freedoms set forth in this Declaration, without distinction of any kind, such as race, colour, sex, language, religion, political or other opinion, national or social origin, property, birth or other status”, 1948, <<http://www.un.org/en/documents/udhr/>>.

34 “Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women New York, 18 December 1979” (CEDAW), Office of the United Nations High Commissioner of Human Rights (OHCHR), Article 7, <<http://www2.ohchr.org/english/law/cedaw.htm>>. The Convention has been ratified by 189 countries.

35 “The United Nations Fourth World Conference on Women. Beijing, China – September 1995. Action for Equality, Development and Peace. Platform for Action. United Nations (UN). Platform strategic objective G1”, <<http://www.un.org/womenwatch/daw/beijing/platform/decision.htm>>.

36 “United Nations. Global Issues. Women”, <<http://www.un.org/en/globalissues/women/>>.

37 “Resolution Adopted by the General Assembly, 55/2. United Nations Millennium Declaration”, A/55/L.2, <<http://www.un.org/millennium/declaration/ares552e.htm>>.

38 “Resolution 1325 (2000)”, UN Security Council, 31 October 2000, <http://www.un.org/events/res_1325e.pdf>.

ЕАБХАБ-ын гишүүн орнууд нь улс төр, нийтийн салбар дах жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтыг зогсоож, жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэх үүрэг амлалтаа удаа дараа баталгаажуулсан байдаг³⁹. Жишээлбэл, 1990 оны Копенгагений баримт бичигт эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад онцгой ач холбогдолтой үл ялгаварлах тухай заалт орсон. Энэ баримт бичгийн 5.9 дүгээр хэсэгт “бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг хориглох, хүн бүрийн аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхагдахаас адил тэгш, үр дүнтэй байдлаар хамгаалагдах эрхийг баталгаажуулах” үүргийг гишүүн орнуудад хүлээлгэсэн байдаг⁴⁰. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ЕАБХАБ-ын 2004 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь “энх тайван, тогтвортой ардчилал, эдийн засгийн хөгжилд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хангаснаар ЕАБХАБ-ын бүс нутагт аюулгүй, тогтвортой байдлыг” бий болгоход шүүд чиглэсэн билээ⁴¹. ЕАБХАБ-ын Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь өнөөдрийг хүртэл жендэрийн эрх тэгш байдлыг жинхэнэ, утга төгөлдөр бий болгоход ЕАБХАБ-ын институцууд, гишүүн орнуудын баримтлах хамгийн цогц зохицуулалт хэвээр байна.

Улс төр, нийтийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог хангах тухай 7/09 тоот шийдвэрийг баталсан ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн Афины 2009 оны 12 дугаар сарын хуралдааны үеэр ЕАБХАБ-ын Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан улс төрийн нам зэрэг улс төр, нийтийн салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах асуудлыг онцгойлон авч үзсэн байдаг⁴². ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн Афины 7/09 тоот шийдвэрт:

“Шийдвэр гаргах бүх түвшний сонгуульд албан тушаалд жендэрийн илүү тэнцвэртэй төлөөллийг бий болгох зорилгоор улс төрийн намд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог дэмжихийг улс төрийн үйл хэрэгт оролцогч хэн бүхэнд уриалж, хөхиүлэн дэмжих”⁴³-ийг улс орнуудад уриалсан байдаг.

Дээр дурдсан олон улсын хэм хэмжээ, үүрэг хүлээлгэсэн өргөн хүрээтэй баримт бичгүүд нь ЕАБХАБ-ын гишүүн орнууд улс төрийн салбарт, түүний дотор шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүдийн улс төрийн байдлыг сайжруулах зорилго, эрмэлзэлтэй байгааг харуулж байна.

→ **Улс төрийн салбар дах эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш төлөөлөл нь ардчилсан сонгуулийн урьдач нөхцөл юм.**

Ардчилсан сонгуулиар иргэд аль ч нам, нэр дэвшигчийг чөлөөтэй сонгох эрхтэй. Гэтэл аль нэг бүлэгт нөгөөгөөс (жишээлбэл, эмэгтэйчүүд) илүү таатай хандах бодлогоор дамжуулан сонгуульд хөндлөнгөөс нөлөөлж, тэгш боломжийг хязгаарлах нь шударга бус гэж үзэх хүмүүс бий.

Намын удирдлагаас эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг адил тэнцүү тоогоор нэр дэвшүүлэхэд хойрго ханддаг байдал нь сонгогчдын (эмэгтэй, эрэгтэй аль алины) эмэгтэйчүүдийг сонгох боломж/сонголтыг хязгаарлаж байна.

Гэтэл үнэндээ сонгуулийн аливаа тогтолцоо нь сонгогчдын саналыг улс төрийн аль нэг нам, нэр дэвшигчид таатай байдлаар суудал болгон хөрвүүлэх дүрэм журмыг агуулж байдаг. Үүний нэг тод жишээ

39 “OSCE Commitments Relating to Gender Equality and Non-Discrimination. A Reference Guide Prepared for the OSCE Human Dimension Seminar on Participation of Women in Public and Economic Life”, OSCE Office for Democratic Institutions and Human Rights Warsaw, 13–15 May 2003, <<http://www.osce.org/odihr/19575>>.

40 “Document of the Copenhagen Meeting of the Conference on the Human Dimension of the CSCE”, Conference on Security and Co-Operation in Europe (CSCE), 1990, www.osce.org/odihr/elections/14304

41 OSCE Ministerial Council, Decision No. 14/04, “OSCE Action Plan for the Promotion of Gender Equality”, Sofia, 7 December 2004, <<http://www.osce.org/mc/23295>>.

42 A more detailed overview of OSCE commitments on gender equality can be found in Annex 1.

43 OSCE Ministerial Council, Decision No. 7/09, “Women’s Participation in Political and Public Life”, Athens, 4 December 2009, <<http://www.osce.org/mc/40710>>.

нь тодорхой хувийн санал цуглуулж чадаагүй улс төрийн намд суудал хуваарилахгүй байхаар босго тогтоосон хуулийн заалт юм. Түүнчлэн сонгуулийн сурталчилгааны ажлын санхүүжилтийн зохицуулалт, хэвлэл мэдээлэл ашиглах, санал өгөхтэй холбоотой дүрэм журмууд бүгд л сонгуулийн өрсөлдөөн хэрхэн явагдах вэ гэдэгт нөлөөлж байдаг.

Сонгуульд иргэдийн хийх сонголтыг энэ өнцгөөс нь харвал эмэгтэйчүүдийг хангалттай тоогоор нэр дэвшүүлэхгүй байгаа нь сонгогчдын эмэгтэйчүүдэд саналаа өгөх сонголтыг хязгаарлаж байна гэсэн өөр тайлбар руу хөтөлж байгаа юм. Түүнчлэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн өрсөлдөх гарааны нөхцөл тэгш биш байгаа учраас энэхүү тэнцвэргүй байдлыг арилгахад чиглэсэн сайтар бодож боловсруулсан арга хэмжээг сайшаан дэмжих учиртай. Эмэгтэйчүүдийг сонгуульд албан тушаалд хүрэх бололцоог нэмэгдүүлэх чиглэсэн түр хугацааны тусгай арга хэмжээ нь сонгогчдын саналаа өгөх сонголтын хүрээг өргөжүүлнэ. Үүний үр дүнд парламент ч илүү өргөн төлөөлөлтэй, олон ургальч болж, нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдал нь сайжирна.

→ **Оролцоотой, бүгдийг хамарсан парламентын нийтэд хүлээн зөвшөөрөгдөх, төлөөллийг хангасан байдал нь сайжирдаг**

Улс орны парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ нь төрийн үйл хэрэгт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тухайн улсын гаргасан дэвшил, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлсэн байдлыг илэрхийлэх нэг түгээмэл хэмжүүр юм⁴⁴. Жишээлбэл, энэ нь 2015 он гэхэд НҮБ-ын гишүүн орнууд Мянганы хөгжлийн зорилтыг ямар хэмжээнд биелүүлсэн болохыг үнэлэх нэг шалгуур билээ⁴⁵.

“Парламентад эмэгтэйчүүдийг хангалттай хувь хэмжээгээр оруулсан засаг төр ардчилсан байдаг” гэдэгт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь итгэдэг болохыг судалгаа харуулж байна⁴⁶. Иймд төлөөллийн байгууллагадаа эмэгтэйчүүдийг оролцуулдаггүй улс орныг жинхэнэ ардчилсан улс гэж үзэхэд хэцүү. ЕАБХАБ-ын бүс нутгийн хүн амд эрэгтэй, эмэгтэй хүмүүс бараг тэнцүү хувийг эзэлдэг⁴⁷. Тиймээс тооны энэ харьцаа амьдралын бүхий л хүрээнд, түүний дотор улс төрийн салбарт хадгалагдаж байх ёстой билээ.

2.2. Улс төрийн намын удирдлагад тусах ашигтай тал

Өмнө дурдсан тайлбар үндэслэл нь улс төрийн бүхий л үйл явцад эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш оролцох боломж олгох нь хүний эрхийг хэрэгжүүлж буй явдал гэж үздэг “шударга ёсны” ойлголтоос эх авсан байдаг. Хүний эрхийг хүндэтгэх нь ардчиллыг нийтээр хүлээн зөвшөөрөх байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ засаглал бүх талыг хамарсан, оролцоотой байх чанарыг дээшлүүлнэ. Энэ утгаар нь авч үзвэл “шударга ёс”-ны ойлголт нь улс төрд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог нэмэгдүүлэх хүчтэй, бат бөх үндэслэл юм.

Гэвч хүний эрхийг хэрэгжүүлэх үүрэг, нийтээр хүлээн зөвшөөрөгдөх зарчмын улмаас эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг дэмжих итгэл үнэмшил улс төрийн намуудад тэр бүр бүрдээгүй байх талтай. Тиймээс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжихийн тулд намууд, тэр дундаа намын удирдлагын итгэл үнэмшлийг төрүүлэхэд

44 Ann Towns, *Women and States: Norms and Hierarchies in International Society* (New York: Cambridge University Press, 2010).

45 “What is the MDG Monitor?”, United Nations Development Programme (UNDP), 2007, <<http://www.mdgmonitor.org/index.cfm>>.

46 Leslie A. Schwindt-Bayer and William Mishler, “An Integrated Model of Women’s Representation”, *Journal of Politics*, Vol. 67, No. 2, 2005, pp. 407–428.

47 “Population trends”, UNFPA, <<http://www.unfpa.org/pds/trends.htm>>.

хөшүүрэгт суурилсан арга барил баримтлах нь илүү үр дүнтэй байж болно. Улс төрийн албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлснээр тухайн нам сонгуульд илүү амжилттай өрсөлдөж, намын тодорхойлсон бодлогын асуудлыг сонгогчид илүү өргөнөөр дэмжиж байгааг намын удирдлага харвал тэдний итгэл үнэмшил бүрдэх магадлал өндөр юм.

Энэ арга барил нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог сайжруулах зорилгоор нэлээд их ашиглагддаг хоёр үндэслэлээс уламжлан гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, өмнө дурдсан “шударга ёс”-ны онолоос гадна “ялгаатай байдал” болон “прагматик” буюу “хэрэгцээг голлосон” гэсэн хоёр үндэслэл бий⁴⁸. “Ялгаатай байдал”-ын тухай ойлголт нь улс төр, бодлогын мэтгэлцээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөрийн ялгаатай байр суурь, үзэл бодол, туулж өнгөрүүлсэн туршлагыг авчирч, баяжуулж байдаг гэж үздэг. Харин “прагматик” буюу “хэрэгцээг голлосон” онол нь эмэгтэйчүүдийг намын үйл хэрэгт татан оролцуулснаар улс төрийн намд сонгуульд ялах, хүлээн зөвшөөрөгдөх зэрэг ашигтай талууд бий болно гэж үздэг. Мөн эмэгтэйчүүд улс төрийн намд илүү баялаг туршлага, үр чадвар, мэдлэг авч ирэх давуу талтай гэж үздэг. Ийнхүү гарын авлагын энэ хэсэгт улс төрийн намын удирдлагуудад намын гишүүн, шийдвэр гаргагч, нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх сонирхол, сэдэл төрүүлэх гол учир шалтгаан, үндэслэлийг танилцуулан, намын удирдлагад хандсан дөрвөн гол хөшүүргийг авч үзэв. Үүнд:

- Олон нийтийн дунд улс төрийн намын дүр төрх, нэр хүнд сайжирна;
- Намын мөрийн хөтөлбөр, бодлогыг боловсронгуй болгоно;
- Улс төрийн намын сонгуулийн сурталчилгааны ажлын арга замыг сайжруулна;
- Намын гишүүнчлэл буурахаас сэргийлнэ.

Тухайн хөшүүрэг бүр нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлснээр улс төрийн намд ямар ач холбогдолтой талаар тодорхой тайлбар, үндэслэлийг агуулсан байна.

2.2.1. Олон нийтийн дунд улс төрийн намын дүр төрх, нэр хүнд сайжирна

→ Жендэрийн эрх тэгш байдлын талаар улс төрийн тодорхой байр суурь баримтлах

ЕАБХАБ-ын гишүүн олон улс оронд намуудаас нийгмийн аль нэгэн бүлгийг ялгаварлан гадуурхах нь хууль бус биш гэхэд олон нийтийн шүүмжлэлтэй тулгарч байдаг. Орчин цагт зарим улс төрийн нам зөвхөн хууль, журамд заасан учраас бус харин улс төрийн бүхий л хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш, бүрэн дүүрэн оролцоог хангах нь улс төрийн хувьд зохистой зүйл гэдэг үүднээс жендэрийн эрх тэгш байдалд ханддаг болжээ. Ийм чухал асуудлаар нам, намын удирдлага албан ёсны байр суурьгүй байвал сөрөг хүчин, хэвлэл мэдээлэл, сонгогчид хялбархан өлгөн авч, тухайн намд сөргөөр

Шигтгээ 2.3. Европын Зөвлөлийн “Жендэрийн эрх тэгш байдлын шагнал”

Энэ нь улс төрийн намын бүгд хурал, намын гүйцэтгэх байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд томоохон ахиц дэвшил гаргасан улс төрийн намуудад олгодог таван жил тутмын шагнал юм. Европын зөвлөлийн Парламентын Ассамблейн улс төрийн ямар ч хүчин, Европын Парламент, Европын Зөвлөлийн гишүүн улс орнуудын парламентаас тус шагналд нэр дэвшүүлэх боломжтой.

Эх сурвалж: Европын зөвлөлийн Парламентын Ассамблей, “Жендэрийн эрх тэгш байдлын шагнал, www.assembly.coe.int.

48 See, for example: Joni Lovenduski, *Feminizing Politics* (Cambridge: Polity Press, 2005); and Sarah Childs, Joni Lovenduski and Rosie Campbell, *Women at the Top 2005: Changing Numbers, Changing Politics?* (London: Hansard Society, 2005).

ашиглах эрсдэлтэй. Харин жендэрийн эрх тэгш байдлыг дэмжсэн тодорхой бодлого боловсруулж, түүнийгээ сурталчилбал тухайн улс төрийн намын хүлээн зөвшөөрөгдөх байдал, гишүүнчлэл, дэмжигч сонгогчдын тоо өсөхөд эерэг нөлөө үзүүлнэ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэх эрмэлзэл, зорилготой байгаагаа харуулах нь Европын Ард түмний Нам, Германы улс төрийн намуудын дэргэдэх сан зэрэг олон улсын нам хоорондын байгууллагуудтай хамтран ажиллахад нэг чухал урьдач нөхцөл болж байдаг. Олон улсын ийм сүлжээ байгууллагын гишүүн болсноор тухайн намын нэр хүнд өсөх, орчин үеийн улс төрийн хүчин гэж тооцогдох давуу талтайгаас гадна нэмэлт санхүүжилт, чадавх бэхжүүлэх туслалцаа авах бололцоог нээгдэнэ.

→ Намын дүр төрхийг сайжруулна

Дэлхий дахинд (ЕАБХАБ-ын бүс нутагт ч мөн адил) улс төрийн намд 45-64 насны эрэгтэйчүүд давамгайлсан хэвээр байгаагаас эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай өөр насны бүлэг, өөр намтар туршлагатай хүмүүст нам, сонгуульт албан тушаалд хүрэх бололцоо хязгаарлагдмал байна. Намын гишүүнчлэл хүн ам зүйн хувьд ийм бүтэцтэй байгаа тул улс төрийн намууд элитүүдээс бүрдсэн гэж харагдан, энгийн сонгогч, ялангуяа залуучуудаас тасарсан мэт санагддаг. Янз бүрийн насны, өөр өөр бүлгийг төлөөлөх эмэгтэйчүүдийг улс төрийн намд олноор татан оролцуулах замаар намын гишүүдийнхээ олон янз байдлыг өргөжүүлбэл гишүүдийн тоогоо нэмэхээс гадна сонгогчдын гол гол бүлгийн дунд намын нэр хүнд өснө. Энэ талаар доор дэлгэрэнгүй авч үзнэ.

2.2.2. Намын мөрийн хөтөлбөр, бодлогыг боловсронгуй болгоно

→ Улс төрийн намын бодлогыг өргөжүүлнэ

Олон улсын парламентын холбооноос⁴⁹ парламентын гишүүдийн дунд явуулсан судалгаанд оролцогчдын 90-ээс илүү хувь нь эрэгтэйчүүд зонхилдог батлан хамгаалах, аюулгүй байдал, эдийн засаг, бизнесийн салбарын бодлогод ч гэсэн эмэгтэйчүүд шинэ үзэл, хандлага оруулж, улс төрийг өөр санаа бодол, авъяас чадвараар баяжуулдаг гэдэгтэй санал нийлсэн байна. Энх тайван, эв нэгдлийг бий болгох, зөрчилдөөнөөс сэргийлэх, зөрчилдөөний дараах сэргээн босголт, энх тайвныг тогтоох үйлсэд эмэгтэйчүүд зөрчилдөөнөөс сэргийлэх, зохицуулах, шийдвэрлэх шинэ санаа оруулж ирдэг ажээ.

Түүнчлэн эмэгтэйчүүд тодорхой салбараар мэргэшсэн чадвар туршлага, ялангуяа боловсрол, эрүүлмэнд, халамжзэрэгнийгмийн асуудлаарх туршлагаа улстөрдавчирдаг гэлцдэг. Үнэн хэрэгтээ бусад бүхий л салбарт эмэгтэйчүүд хөдөлмөрлөж байдаг тул тэдний мэргэжил, мэргэшил, туршлага нийгмийн салбараар хязгаарлагдахгүй нь ойлгомжтой. Гэхдээ нийгэмд жендэрийн ийм хэвшмэл ойлголт байгаа гэдэг нь улс төрч эмэгтэйчүүдийн хувьд нийгмийн бодлогын асуудал дээр төвлөрвөл илүү амжилт гаргах боломжтой гэсэн үг бөгөөд сонгогчдын энэ хандлагыг сөрөг зүйл гэхээсээ давуу тал гэж үзэж болох юм⁵⁰. Улс төрийн намуудын зүгээс жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг даамжруулахгүйгээр эмэгтэйчүүдэд нийгмийн гол асуудлаар илүү итгэдэгийг хүлээн зөвшөөрч, намынхаа мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн жагсаалтыг өргөжүүлэхэд ашиглах нь зүйтэй.

Эмэгтэйчүүд улс төрийн албанд сонгогдон ажилласнаар намынхаа урьд өмнө анзаарч хараагүй бодлогын чухал асуудлыг онцлон, шинэ сонгогчдыг татаж, дэмжлэг авах

49 "Equality in Politics: A Survey of Men and Women in Parliaments", Inter-Parliamentary Union, Reports and Documents no. 54, 2008, p. 31.

50 Paul S. Herrmson, J. Celeste Lay and Atiya Kai Stokes, "Women running as women: Candidate Gender, Campaign Issues, and Voter-Targeting strategies", Journal of Politics, Vol. 65, No. 1, 2003, p. 244.

Шигтгээ 2.4: Улс төрд эмэгтэйчүүд: Ухаалаг сонголт*

Жэйн Дуу өөрийгөө Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч болно гэж хэзээ ч бодож байсангүй. Гэрийнх нь ойролцоо том үйлдвэр нээгдсэнээс хойш замын хөдөлгөөн ихэсч, улмаар зам дээр осол их гарч байгааг тэр анзаарсан байна.

Жэйн багш мэргэжилтэй бөгөөд сургуулиа тараад харьж яваа эсвэл тоглох газаргүйгээс гудамжинд тоглож буй хүүхдүүд ихэвчлэн осолд өртөж байгааг олж мэджээ. Жэйн үүнд санаа нь зовж, үйлдвэрийн орчмын замыг аюулгүй болгохоор иргэдийн бүлэг байгуулж, иргэдийн хуралд нөлөөлөх ажил хийж эхэлсэн байна. Хүүхдүүд сургуулиа тараад гэртээ хэрхэн харьдаг, хаана тоглож нааддаг талаар үйлдвэр барих зөвшөөрөл олгосон иргэдийн хурлын төлөөлөгчид (дийлэнх нь эрэгтэйчүүд) мэддэг ч үгүй, анхааран судалж үзээ ч үгүй байсан ажээ.

Ингээд иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль дөхөхөд Жэйн өмнө нь боловсрол, нийгмийн шударга ёсны асуудлаар сурталчилгааны ажлынхаа гол анхаарлыг хандуулж байсан улс төрийн намд

элсч, мэргэжлийн үр чадвар, эрмэлзэл, хүүхэдтэй ажилласан туршлагатай тул нэр дэвшвэл амжилт гаргах боломжтой гэдгээ танилцуулав. Намын удирдлага, сонгон шалгаруулах хорооныхон хэнийг нэр дэвшүүлэх талаар нэлээд маргалдаж байв. Харин Жэйн орон нутгийн боловсрол, замын аюулгүй байдал зэрэг шинэ асуудлыг намын бодлого, сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах санаачилга гаргаж ирснээрээ намдаа итгэл олж, нэр дэвших дэмжлэг авсан байна. Сонгуулийн сурталчилгааны ажлынхаа явцад тэрээр замын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж, цэцэрлэгт хүрээлэнд хүүхдийн тоглоомын газар барих асуудлыг дэвшүүлсэн нь нутгийн иргэдэд таалагдсан байна. Ингээд Жэйн Дуу сонгуульд ялж иргэдийн хурлын төлөөлөгч болсон бөгөөд замын аюулгүй байдлыг сайжруулах талаар шийдвэр гаргагчдад нөлөөлөх ажлаа үргэлжлүүлж, орон нутгийн нийгэм-эдийн засгийн асуудалд анхаардаг гэсэн нэр хүндийг намдаа авчирчээ.

**Нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшсэн эмэгтэйн бодит түүх дээр үндэслэв.*

замаар дараагийн сонгуульд илүү үр дүнтэй өрсөлдөх боломж бий болгодог нь судалгаанаас харагдаж байна⁵¹. Бодлого нь олон талын байр суурийг хамарсан, тэдний эрэлт хэрэгцээг харгалзан үзсэн байх нь тухайн намыг улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд анхаардаг, улмаар засаглал илүү сайн, үр дүнтэй ажиллахад хувь нэмэр оруулах чадвартай гэдгийг илтгэнэ.

Дүгнэн хэлэхэд улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл доогуур байгаа цагт бодлого боловсруулахад тэдний мэргэжил, туршлага, үзэл бодол дутуу ашиглагдсан хэвээр байна гэсэн үг юм. Эмэгтэй эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийг улс төрийн намууд бодлого боловсруулах ажилдаа оролцуулснаар тухайн намын бодлогын гол асуудлаарх байр суурь хүлээн зөвшөөрөгдөх байдал өсч, бодлогын хүрээ нь өргөжихөд чухал хувь нэмэр оруулж байдаг.

→ Намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэх нь

Улс төрийн нам мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа сонгогчдын санааг зовоож буй асуудлаар эсвэл сонгогчид сул эсвэл үр ашиггүй гэж үзэж байгаа одоо үйлчилж буй бодлогод шинэ чиг хандлага оруулснаар итгэл алдарсан болон шинэ сонгогчдыг татах боломж нэмэгдэх бөгөөд аль аль нь тухайн намд өгөх саналын тоог өсгөнө. Энэ арга барил нь цаг үеэсээ хоцорч хуучран, бодит байдлаас тасарсан байж болох мөрийн хөтөлбөрийг шинэчлэн сэргээхэд туслах бөгөөд тухай нам бодлогын одоо тулгарч буй болон шинээр үүсч буй асуудлыг багтаасан, шинэлэг, бүгдийг хамарсан, эрэлт хэрэгцээнд нийцсэн бодлогын мөрийн хөтөлбөртэй болох боломжтой.

51 "Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation", UNDP/NDI, 2011, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

Жендэрийн эрх тэгш байдлыг чухалчилдаг сонгогчдын тоо өсөн нэмэгдэж байгаа өнөө үед улс төрийн нам жендэрийн эрх тэгш байдлын талаар тодорхой байр суурь боловсруулж баримтлах нь сонгогчдын таашаалд нийцнэ.

Үүний нэгэн адилаар сонгуулийн мөрийн хөтөлбөртөө жендэрийн эрх тэгш байдлын талаар тодорхой зорилт дэвшүүлэх, эмэгтэйчүүдийн эрхийг сайжруулах тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлаар бодлогын асуудалд хандах нь бусад намаас ялгарах чухал арга хэрэгсэл болно. Энэ нь жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх ёстой гэж үздэг сонгогчдын таашаалд ч нийцнэ. Тухайлбал, Их Британийн Консерватив нам эмэгтэй сонгогчдын дэмжлэгийг авах зорилгоор бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, цалин хөлсний ялгааг бууруулах, хүүхэд асрах чөлөөг илүү уян хатан болгох, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх зэрэг бодлогын зорилтыг дэвшүүлж байв⁵².

→ Шинэ сонгогчдыг татах зорилгоор жендэрийн эрх тэгш байдлын талаар намаас баримталж буй байр сууриа илэрхийлэх нь

Жендэрийн эрх тэгш байдлын талаар улс төрийн байр сууриа тодорхойлох нь тухайн нам өөрийн итгэж үнэмшдэг үнэт зүйлсээ эргэн харах, сайжруулан шинэчлэх сайхан боломж юм. Ихэнх ардчилсан оронд сонгогчдын 50-иас илүү хувь нь эмэгтэйчүүд байдаг бөгөөд тухайн нам засгийн эрх барих болбол эмэгтэйчүүдийн төлөө юу хийх бол гэдгийг анхааран харж байдаг. Тиймээс жендэрийн эрх тэгш байдлын талаарх намын байр суурь болон тухайн намд эмэгтэйчүүд ямар үүрэгтэй байх вэ гэдгийг намын удирдлагууд авч үзэхээс өөр аргагүй.

Санал өгөх эрхтэй нийт хүн амын 50% нь эмэгтэйчүүд байдаг. Тиймээс тухайн намын үзэл баримтлалд эмэгтэйчүүд ямар үүрэг гүйцэтгэх, жендэрийн эрх тэгш байдлын талаар нам ямар байр суурь баримтлах вэ гэдгээ эргэн харж тодорхойлоход намын удирдлага анхаарал хандуулах хэрэгтэй болно.

Улс төрийн үзэл санаа, чиг хандлага нь ямар байхаас үл хамаараан аль ч нам жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих асуудлыг намын үнэт зүйл, мөрийн хөтөлбөрийн нэг хэсэг болгох боломжтой. ЕАБХАБ-ын бүс нутагт жендэрийн эрх тэгш байдалд улам их анхаарах болсон тул дэвшилтэт үзэлтэй улс төрийн намууд намынхаа байр суурийг эргэн харж, намын үнэт зүйлстэй нийцсэн жендэрийн бодлого, үзэл санааг боловсруулах нь зүйтэй. Жендэрийн эрх тэгш байдлын талаар баримтлах байр сууриа тодорхойлоод зогсохгүй бодитой зорилго, зорилт болгон илэрхийлэх

нь эмэгтэй сонгогчид, ер нь бүх сонгогчдод хүрч нөлөөлөх чухал арга хэрэгсэл юм.

2.2.3. Улс төрийн намын сонгуулийн сурталчилгаа хийх арга замыг сайжруулна

→ Нэр дэвшигчдийн хүрээг өргөжүүлэх замаар сонгуулийн арга замаа төрөлжүүлэн баяжуулах нь

Бүх нийтийн болон орон нутгийн сонгуулийн аль алинд нийгмийн олон өөр бүлэг, хэсгийг төлөөлсөн нэр дэвшигчдээр жагсаалтаа бүрдүүлбэл тухайн намыг сонирхож, анхаарах нийгмийн олон өөр бүлэг, хэсэгт хамаарах сонгогчдын тоо нэмэгдэнэ. Харин хүйс, нутаг, анги давхарга, нийгмийн байдал, шашин шүтлэг, нас, арьс үндэс зэрэг нийгмийн тодорхой бүлэг, хэсэгт хамаарах нэр дэвшигчдийг орхигдуулбал тэдгээрт хамаатах сонгогчдыг татаж чадахгүйд хүрнэ. Тухайлбал, намууд өөр өөр мэргэжлийн

⁵² “Where we stand”, UK Conservative Party website, <http://www.conservatives.com/Policy/Where_we_stand/women2.aspx>. The resources and examples referenced in this handbook are included owing to their value as effective good practices for the promotion of women’s participation in political parties. As such, their inclusion in no way represents an endorsement of or agreement with the policy agendas or political platforms of the organizations, platforms and political parties that produced them.

хүмүүсээс нэр дэвшигч бүрдүүлэх нь сонгогчдын анхаарлыг илүү татдаг болох нь Их Британи, Ирландын орон нутгийн сонгуулиас харагджээ. Багш, эмч, эмнэлгийн ажилтнууд, дэлгүүр, жижиг бизнес эрхлэгч зэрэг эмэгтэйчүүд зонхилдог салбараас орон нутгийн манлайлагч сонгогдох хандлагатай байдаг аж⁵³.

Эмэгтэй хүн нэр дэвшиж байгаа нь эмэгтэй сонгогчдын хувьд урам зориг, итгэл найдвар төрүүлдэг тул эмэгтэй нэр дэвшигч олон байх тусам эмэгтэй сонгогчдын дэмжлэг их байна гэсэн үг юм. Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлын талаар хэвшмэл ойлголт түгээмэл байдаг ч бүх шатны шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээ байна гэдгийг Украйны олон нийтийн дунд явуулсан санал асуулга харуулсан байна⁵⁴. Нэр дэвшигчдийн жагсаалтад буй эмэгтэйчүүдийн тоог нэмэх нь сонгогчдын анхаарлыг татах бас нэг арга зам юм. Энэ аргыг хэрэглэснээр намууд шинэ сонгогчид, түүний дотор эмэгтэйчүүдийг татах боломжтой.

→ Намын үр чадвар, мэдлэг, туршлагын санг өргөжүүлнэ

Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх асуудалд Скандинавын орнуудын түгээмэл хэрэглэж ирсэн нэг үндэслэл нь улс төрийн намд эмэгтэйчүүд орж ирснээр намын үр чадвар, мэдлэг, туршлагын сан баяжиж өргөжинө гэсэн санаа юм⁵⁵. Эдгээр орны улс төрийн зүтгэлтгүүд эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийн асуудлыг томъёолохдоо эмэгтэйчүүд зонхилдог салбарын асуудалд эмэгтэйчүүдийн өвөрмөц, онцлог үр чадвар, туршлага шаардлагатай гэж үздэгийн зэрэгцээ уламжлалт эрэгтэйчүүд давамгайлсан салбарт ч эмэгтэйчүүд онцгой хувь нэмэр оруулж чадна гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Эмэгтэйчүүдийн мэдлэг, үр чадвар, туршлага нь намын манлайллын нөөцийг бүрдүүлэхэд нэн чухал бөгөөд намд эмэгтэйчүүдийн төлөөлөл доогуур байвал тухайн намд үг нөөцийг дутуу ашиглаж байна гэсэн үг юм. Энэ цоорхой намын шийвэр гаргах түвшинд илүү тод ажиглагддаг. Бизнесийн салбарт энэ үзэгдлийг “авьяас чадварын цоорхой” гэж нэрлэдэг бөгөөд улс төрийн орчинд ч тохиолдож байдаг.

Шигтгээ 2.5. Шинжлэх ухаанаас улс төрд: Эмэгтэйчүүд улс төрийн намд ялалт авчирна

Польшийн сонгуулийн хуулиар өрсөлдөх суудлын тооноос хоёр дахин илүү тооны нэр дэвшигч нэр дэвшүүлэхийг намуудад зөвшөөрсөн байдаг. Үүний дагуу тус улсын нийслэл Варшав хотын тойрогт улс төрийн нам тус бүр 40 нэр дэвшигч санал болгох боломжтой бөгөөд энэ нь нийгмийн олон өөр төлөөллөөс нэр дэвшүүлэх бололцоо олгодог.

2007 онд Иргэний Платформ Нам Люблиний Католик Их сургуулийн нэр хүндтэй профессор Dr. Joanna Mucha-г нэр дэвшүүлж, намдаа суудал авчээ. Тэрээр 2011 оны 11 дүгээр сараас 2013 оны 11 дүгээр сар хүртэл Польшийн Засгийн газарт сайдаар ажиллажээ. Түүнчлэн эдийн засгийн ухааны чиглэлээр олон жил эрдэм шинжилгээний болон багшлах ажил хийсэн Профессор Professor Joanna Senyszyn (Гданскийн Их сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхмийн эрхлэгч байсан) 2001 онд Ардчилсан Зүүний Альянсаас нэр дэвшиж, ялалт байгуулж байсан бөгөөд одоо Европын Парламентын гишүүнээр ажиллаж байна.

Энэ хоёр эмэгтэй аль аль нь намын нэр дэвшигчдийн жагсаалтын хоёрдугаар байрт бичигдэж байсан бөгөөд намын удирдлагын зүгээс жагсаалтын эхэнд бичсэн нэр дэвшигчдээс хувь илүү амжилттай өрсөлджээ.


Эх сурвалж: Karolina Ó Beacháin Stefańczak-тай 2012 оны 10 дугаар сарын 31-нд хийсэн ярилцлага.

53 ODIHR, e-mail interview with Karolina Ó Beacháin Stefańczak, 31 October 2012.

54 Women's Participation in Politics and Decision-Making in Ukraine: Strategy Paper (Kiev: Ukrainian Women's Fund, 2011).

55 Lenita Freidenvall, Vågen till Varannan damernas: om kvinnorepresentation, kandidaturval och kvotering i svensk politik 1970–2002 [Every other one for the ladies: on women's political representation, candidate selection and gender quotas in Sweden 1970–2002], Ph. D. Diss. (Stockholm: Stockholm University, 2006); Lenita Freidenvall, Drude Dahlerup and Hege Skjeie, “The Nordic Countries: an Incremental Model”, in Drude Dahlerup (ed.), Women, Quotas and Politics (London: Routledge, 2006).

Зураг 2.6: Авьяас чадварын цоорхой



Эх сурвалж: Christina Ioannidis болон Nicola Walther нарын Танай алдагдал: Эмэгтэйчүүдийн үр чадварыг хэрхэн эргэн татах вэ? бүтээлээс хялбаршуулан оруулав (Richmond: Aquitide Publishing; 2010).

Жендэрээс үүдсэн “авьяас чадварын цоорхой”-г өөрчлөх талаар арга хэмжээ авснаар улс төрийн намуудад олон давуу тал бий болно. Зарим улс оронд хөдөлмөрийн хуваарьт жендэр чухал үүрэгтэй хэвээр байгаа учраас нийгэмд түлгэмдэж буй асуудалтай ихэнхдээ эмэгтэйчүүд нүүр тулж байдаг. Ийм учраас эмэгтэйчүүд эмзэг бүлэг, санал өгдөггүй сонгуульд оролцох эрхтэй хүмүүс зэрэг нийгмийн өргөн хүрээнд хүрч, анхаарлыг нь татах замаар намдаа туслалцаа үзүүлэх онцлог боломжийг тээж байдаг. Түүнчлэн зөрчилтэй нөхцөл байдалд харилцан буулт хийж, зөвшилцөлд хүрэх чадвараа нотлон, чадварлаг хэлэлцээр хийгчид гэдгээ эмэгтэйчүүд олон тохиолдолд харуулсан байдаг. Тухайлбал, хуучнаар Югослав улс болон Ирландад эмэгтэйчүүд энх тайвны төлөө идэвхтэй тэмцэгч байснаас гадна ЕАБХАБ-ын болон бусад бүс нутагт ардчилсан шинэчлэл хийхэд эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Дээрх жишээнээс үүдэн эмэгтэйчүүдийн үр чадвар, түршлага нь улс төрд өрсөлдөхөд зайлшгүй шаардлагатай мэргэжил, боловсрол, чадварыг хангаж байна гэж үзэж болох уу? Судалгаанаас харахад эмэгтэйчүүд асуудалд өөриймсөг⁵⁶ хандаж, хамтран ажиллах

зан үйлийг⁵⁷ хөхиүлэн дэмжиж, зөвшилцөлд хүрэхэд дэм болдог чанараараа улс төр, манлайлалд шинэ, өөр арга барил, үнэт зүйлсийг нэвтрүүлж байдаг аж. Шийдвэр гаргах, удирдах, төсвийн төлөвлөлт хийх, асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх бүхий л чиглэлд эмэгтэйчүүд үр чадварын хувьд эрэгтэйчүүдээс огт дутдаггүй, харин эдгээр үр чадварыг тэднээс өөр арга замаар хөгжүүлсэн байх талтай байдаг.

Түүнчлэн сайн дурын ажил, түүний дотор улс төрийн сайн дурын ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй оролцдог болохыг судалгаагаар тогтоосон байна⁵⁸. Ашгийн төлөө бус салбарт, ялангуяа орон нутгийн болон үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын хэмжээнд ч эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс илүү байдаг байна. Үүнээс гадна аливаа нам сонгуульд амжилт гаргаагүй байсан ч эмэгтэйчүүд нэг намдаа үнэнч байх хандлагатай байдаг. Жишээлбэл, Гүрж улсад сонгуулийн үеэр намын эмэгтэй гишүүд нь эрчүүдээсээ илүүтэй сонгуулийн сурталчилгааны ажилд намаа дэмжиж, айлуудаар явж сурталчлах зэрэг нүдэнд ил харагдахааргүй намын ажлыг гүйцэтгэж байсан бөгөөд нам нь парламентад олонхи болж чадаагүй, бүр суудал аваагүй байсан ч намын гишүүн хэвээр үлдэж байсан нь тогтоогджээ⁵⁹. Насаар залуу эмэгтэйчүүд сайн дурын ажилд онцгой идэвхтэй оролцдог⁶⁰ тул залуучуудад хүрч ажиллах замаар намынхаа дүр төрхийг сайжруулах зорилготой намуудын хувьд орон нутгийн болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцож байгаа залуу эмэгтэйчүүд үнэ цэнэтэй нөөц бололцоо гэсэн үг юм.

Эдгээр жишээнээс үзэхэд эмэгтэйчүүд өөрсдийгөө дайчлах чадвар сайтай байдаг тул тэдний үр чадварыг үр дүнтэй ашиглаж чадвал санал өгдөггүй сонгогчдыг татах зэргээр дэмжигч сонгогчдынхоо хүрээг өргөжүүлэх боломжтой нь харагдаж байна.

2.2.4. Намын гишүүнчлэл буурахаас сэргийлнэ

1980-аад оноос улс төрийн намын гишүүнчлэл ерөнхийдөө буурч эхэлсэн нь улс төрийн намуудад олон бэрхшээл дагуулж байгаа билээ. Үүнээс шалтгаалж намын зарим ажилд шаардагдах санхүүжилт хүрэлцэхгүй болж, (ялангуяа орон нутгийн салбарт) боловсон хүчин дутагдаж, төлөөлж байгаа гэх нийгмээсээ холдон хөндийрч эхэлсэн⁶¹. Улс төрийн нам ахимаг настай, чинээлэг эрэгтэйчүүдээс бүрдсэн хэвээр байвал устаж үгүй болох эрсдэлтэй тулгараад байна. Харин эмэгтэйчүүдийг намын ажилд оролцуулснаар нэг талаас тооны хувьд цөөрч буй гишүүнчлэлээ сэргээж, нөгөө талаас нийгмийн олон өөр хүрээллээс шинэ гишүүд элсүүлэх гэсэн хоёр замаар гишүүнчлэл буурч буй хандлагыг өөрчлөх боломж бий.

57 Maryann Barakso, "Is There a 'Woman's Way' of Governing? Assessing the Organizational Structures of Women's Membership Associations", *Politics & Gender*, Vol. 3, 2007, pp. 201–227.

58 For example: Hiromi Taniguchi, "Men's and Women's Volunteering: Gender Differences in the Effects of Employment and Family Characteristics", *Nonprofit and Voluntary Sector Quarterly*, Vol. 35, No. 1, 2006, p. 91–96; *Volunteering in the United States, 2012*, Bureau of Labor Statistics, United States Department of Labor, <http://www.bls.gov/news.release/volun.nr0.htm>.

59 Reflections from the conference "Political Party Funding and Women's Political Participation" held on 29–30 June 2011 in Tbilisi, Georgia, organized by ODHR, the Central Elections Commission of Georgia, the Netherlands Institute for Multiparty Democracy (NIMD) and the National Democratic Institute (NDI), see: <http://www.nimd.org/>.

60 *Volunteering Statistics*, The Centre for Volunteering, http://www.volunteering.com.au/tools_and_research/volunteering_statistics.asp.

61 "Lonely at the top: Is the mass political party on its way out, and does it really matter?", *The Economist*, 12 August 2012, <http://www.economist.com/node/21559901>.

Хүснэгт 2.7: Европын улс төрийн намуудад эрэгтэй гишүүдийн эзлэх хувь, 1990-ээд он болон 2000-аад он (%)

	1990-ээд он	2000-аад он	Хүйсийн зөрүү
Бельги	63	60	-3
Дани	60	67	+7
Франц	65	51	-14
Герман	69	64	-5
Их Британи	58	61	+3
Грек	73	63	-10
Ирланд	69	61	-8
Итали	73	77	+4
Люксембург	78	60	-18
Нидерланд	61	56	-5
Португали	72	66	-6
Испани	77	68	-9

Эх сурвалж: Сюзан Е. Скарров, Бурку Гезгор, “Гишүүдийн тоо цөөрч, гишүүнчлэл өөрчлөгдөх үү? Европын улс төрийн намын гишүүд шинэ эринд”, Улс төрийн нам, 16 дахь хэвлэл, Дугаар 6, 2010, 823 – 843 тал.

Хүснэгт 2.7-оос харахад ЕАБХАБ-ын гишүүн орнуудад эрэгтэйчүүд улс төрийн намын гишүүдийн гуравны хоёроос илүүг бүрдүүлж байна. Дани, Итали, Их Британи зэрэг зарим улс оронд улс төрийн намд эрэгтэй гишүүдийн тоо нэмэгдсэн боловч судалгаанд хамрагдсан ихэнх улс оронд энэ тоо буурсан нь харагдаж байна. ЕАБХАБ-ын хамрах бүс нутагт улс төрийн намын гишүүнчлэл ерөнхийдөө буурсан боловч эмэгтэй гишүүдийн хувь хэмжээ нэмэгдсэн байна. Намын гишүүнчлэл буурсан нь олон хүчин зүйлсээс шалтгаалсан байдаг. Улс төрийн намын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг олноор татан оролцуулах нь гишүүнчлэл буурах явдлыг сааруулахаас гадна улс төрийн намын дүр төрх, нэр хүндийг сайжруулах үр дүнтэй арга юм. Эмэгтэйчүүдийн намын гишүүнчлэлийг нэмэгдүүлж, одоогоор дутуу ашиглагдаж байгаа тэдний нөөц бололцоог ашигласнаар улс төрийн намын гишүүд цөөрөхөөс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ орон нутагт алга болж буй бүтцээ сэргээж, иргэдтэй нүүр тулан ажиллах боломжтой. Мөн энэ аргын үр дүнд намуудын нэр хүнд өсч, сонгогчдын дэмжлэг авах бололцоо нэмэгдэнэ.

2.3. Улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдэд тусах ашигтай тал

Улс төрийн албан тушаалд жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулахад эмэгтэйчүүд мөн л чухал үүрэг гүйцэтгэдэг. Гарын авлагын энэ хэсэгт төрийн сонгуульт албан тушаалд эмэгтэйчүүд ажиллахыг яагаад дэмжих шаардлагатай, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжүүлэхийн тулд эмэгтэйчүүд намын удирдлагад хэрхэн нөлөөлөх вэ гэсэн асуудлыг хөндлөө. Улс төрийн намын идэвхтэн эмэгтэйчүүд эдгээр тайлбар үндэслэлийг ашиглан төрийн сонгуульт албан тушаалд өрсөлдөх сонирхолтой эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлж, улс төрийн нам жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхахыг таслан зогсоох боломжтой юм.

2.3.1. Сонгуульт албан тушаалд өрсөлдөх сонирхолтой эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлнэ

→ Өөрийгөө болон өөртэйгөө ижил хүмүүсийг төлөөлөх

“Улс төрд яагаад олон эмэгтэй орох хэрэгтэй гэж?” гэсэн асуулт их гардаг. АНУ-ын Ратжерсийн их сургуулийн Америк эмэгтэйчүүд ба улс төр төвөөс “2012 төсөл”-ийн хүрээнд бэлтгэсэн видео сурталчилгаанд “Улс төрд яагаад олон эмэгтэй орж болохгүй гэж?” хэмээн асуултыг сэргүүлэн тавьсан байдаг⁶². Улс төрийн аль нэг намын талыг баримтлаагүй энэхүү видео сурталчилгаа нь төрийн сонгуульт албан тушаалд өрсөлдөхийг эмэгтэйчүүдэд уриалсан⁶³. Уг видеонд АНУ-ын Конгресст сонгогдсон нэг эмэгтэйгээс сонгуульд яагаад өрсөлдөх болсон талаар нь асуухад дараахь хариултыг өгч байгаа нь гардаг. Үүнд:

“Над шиг хүн л намайг төлөөлөөсэй гэж хүсдэг байсан, ингээд нэг л өдөр өөрийгөө толинд хараад “тэр хүн нь би өөрөө байх ёстой” гэж хэлсэн”.

Төлөөллийг хангасан засгийн газрыг бүрдүүлэхэд нийгмийн олон өөр бүлгийн, өөр өөр мэдлэг, туршлагатай эмэгтэйчүүдийг дэмжих нь амин чухал. Ингэснээр эмэгтэйчүүдийн янз бүрийн бүлэгт хамаатай асуудлаар бодлого боловсруулах үйл явцад эмэгтэйчүүд оролцох боломжтой болно. Гэвч дор Зураг 2.8-д харуулсанчлан, эмэгтэйчүүд өөртөө хамгийн их хамаатай асуудлаарх бодлогын хэлэлцүүлэгт оролцож чадахгүй байх явдал маш их тохиолдож байна.

Зураг 2.8. Улс төрд төлөөлөл байна уу?



Дан эрэгтэйчүүдээс бүрдсэн АНУ-ын Конгрессийн ажлын хэсэг жирэмслэлтээс хамгаалах асуудлаарх хуулийн төслийг хэлэлцэх гэж байна. 2012 оны 2 дугаар сар. Гэрэл зургийг: ABC news.

→ Үлгэр дууриал болж, иргэний үүргээ биелүүлэхэд бусдыг уриалан дайчлах

Бодит болон төсөөллийн олон төрлийн хүндрэл, бэрхшээлээс болж эмэгтэйчүүд улс төрд хөл тавихаас ихэнхдээ хойш суудаг⁶⁴. Гэвч улс төрд эмэгтэйчүүд оролцоо нэмэгдэхийн хэрээр бусад эмэгтэй улс төр сонирхож, сонгуулийн идэвх нь сэргэхээс гадна улс төрийн үйл ажиллагаанд намын гишүүн, бие даагчийн хувиар оролцох сонирхол ч бий болдог аж. Эмэгтэй хүн улс төрийн удирдах албан тушаалд ажиллах

62 Anne Phillips, *Улс төрийн оролцоо* (Кларендон хэвлэлийн үйлдвэр, Оксфорд, Их Британи, Нью Йорк, АНУ, 1995 он)

63 “2012 Төслийн видео сурталчилгаа”, Америкийн эмэгтэйчүүд болон улс төрийн төлөө төв, Улс төрийн Ийглтон институт, Рутжерсын их сургууль, <http://www.cawp.rutgers.edu/site/pages/news_2012videos.php>

64 Jennifer L. Lawless and Richard L. Fox, *It Takes a Candidate: Why Women Don't Run for Office* (New York: Cambridge University Press, 2005).

Шигтгээ 2.9. Эмэгтэйчүүд өөрчлөгчид болох нь

“Орон нутгийн засаг захиргааны байгууллагад ажиллах эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэнээр бусад эмэгтэйчүүдэд нийгмийн болон сэтгэл зүйн талаас сайнаар нөлөөлсөн. Эмэгтэйчүүдийн өөрийн үнэлэмж, өөртөө итгэх илтгэл нэмэгдэж, гэр бүлдээ болон нийгэмдээ илүү үүрэг оролцоотой болсон”.

Эх сурвалж: Элчин сайд Милани Вервеер, “Эмэгтэйчүүд өөрчлөгчид болох нь: Эмэгтэйчүүдийн улс төр, иргэний нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэх тухай”, АНУ-ын Төрийн департамент, 2010 оны 6 дугаар сарын 9

нь аль ч хүйсийн сонгогчдод эерэгээр нөлөөлдөг тул эмэгтэйчүүдийн улс төрийн чадварт эргэлзсэн жендэрийн хэвшмэл хандлагыг өөрчлөх хүчин зүйл болно.

Эмэгтэй улс төрчид бусад эмэгтэйчүүддээ иргэний хувьд, намын гишүүн, улс төрийн идэвхтний хувьд улс төрд оролцох үлгэр дууриал нь болж урам зориг төрүүлдэг гэдэг нь хэд хэдэн судалгаанаас харагдсан байна⁶⁵. Учир нь эмэгтэй улс төрчид байвал эмэгтэйчүүдэд тухайн улс төрийн тогтолцоо арай ойр санагдан, шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлж чадах юм байна гэсэн итгэл бий болж, улмаар оролцоо нь илүү ач холбогдолтой болдог. Нөгөө талаар, ийм нөлөө нь зөвхөн эмэгтэйчүүдээр хязгаарлагдахгүй; улс төрийн янз бүрийн албан тушаалд эмэгтэйчүүд ажиллахад улс төрийн тогтолцоонд итгэх эрэгтэйчүүдийн итгэл ч дээшилдэг аж⁶⁶. Ийнхүү улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийг олноор сонгосноор ардчилал бэхжих, олон нийт иргэний үүргээ биелүүлэн идэвх оролцоо нь дээшлэх сайн талтай.

→ Эмэгтэйчүүдийн чадавхын талаарх нийгэм, улс төрийн оролцогч талуудын хандлагыг өөрчлөх

Улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийг олноор сонгох нь эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, хууль тогтоомж, бодлогын үндэслэл, шийдэл сайжирч, улмаар улс төрийн тогтолцоонд итгэх иргэдийн итгэл дээшлэх сайн талтай. Мөн эмэгтэйчүүдийн чадавхын талаарх нийгэм, соёлын хандлага эерэгээр өөрчлөгдөхөд хувь нэмэр оруулдаг. Төрийн албанд хүчтэй, чадварлаг эмэгтэйчүүд ажилласнаар нийгмийн хандлага өөрчлөгдөж, жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалттай тэмцэхэд тус дөхөм үзүүлнэ.

2.4. Нийгэмд тусах ашигтай тал

Сонгуульт алба, улс төрийн намд эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэх нь нийгэмд мөн ач холбогдолтой. Эмэгтэйчүүд улс төрд оролцсоноор тэдэнд хамаатай бодлогын асуудлыг улс төрийн хүрээнд хэлэлцүүлэх, улс төр, нийгмийн бүхий л хүрээнд оршиж буй жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаар олон нийтэд ойлголт мэдлэг өгөх, нийгэм эдийн засгийн хөгжлийг урагшлуулах эерэг нөлөөтэй ажээ.

65 Lona Rae Atkeson, “Not all cues are created equal: The conditional impact of female candidates on political engagement”, *Journal of Politics*, Vol. 65, No 4, 2003, pp. 1040–1061; Christina Wolbrecht and David E. Campbell, “Leading by example: Female members of parliament as political role models”, *American Journal of Political Science*, Vol. 51, No. 4, 2007, pp. 921–939; Jeff A. Karp and Susan Banducci, “When politics is not just a man’s game: Women’s representation and political engagement”, *Electoral Studies*, Vol. 27, No. 1, pp. 105–115; David Campbell and Christine Wolbrecht, “See Jane run: Women politicians as role models for adolescents”, *Journal of Politics*, Vol. 68 No. 2, 2006, pp. 233–247.

66 Ana Espirito Santo, *The Symbolic Value of Descriptive Representation: The Case of Women*, Ph.D. Diss., European University Institute, 2011; Leslie A. Schwindt-Bayer and William Mishler, “An Integrated Model of Women’s Representation”, *Journal of Politics*, Vol. 67, No. 2, 2005, pp. 407–428.

2.4.1. Улс төрийн тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ

Эмэгтэйчүүд улс төрийн сонгогддог, томилогддог аль ч албан тушаал хашсан энэ нь тухайн улс төрийн тогтолцооны хүлээн зөвшөөрөгдөх байдал, түүнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг⁶⁷. Дээр дурдсанчлан эмэгтэйчүүд улс төрийн байгууллагад олноор ажиллах үед засгийн газар илүү ардчилсан болж байна гэсэн итгэл эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн иргэдэд төрдөг. Эмэгтэйчүүдийг улс төрийн албан тушаалд сонгох нь улс төрийн тогтолцоог сонгогчдод ойртуулж, сонгуулийн ирц нэмэгдэхэд нөлөөлдөг.

Улс төрийн намууд дотооддоо жендэрийн эрх тэгш байдлыг ханган хэрэгжүүлэхэд иргэдийн тухайн улс төрийн тогтолцоонд итгэх итгэл нэмэгдэж байдаг.

Түүнчлэн улс төрийн албан тушаалд нийгмийн хэсэг, бүлгүүдийн төлөөллийг хангаснаар улс төр илүү тогтвортой болох бөгөөд энэ нь зөрчилдөөн гарахаас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй аргын нэг юм. Иргэн бүр нийгмийн эрх тэгш нэгэн хэсэг гэдгээ мэдэрсэн цагт л нийгэм тогтвортой байх учраас төлөөллийг хангах, бүгдийг хамруулан оролцуулах асуудал чухал билээ.

2.4.2. Бодлогод нөлөөлнө

Эмэгтэйчүүд улс төрд хангалттай тоогоор⁶⁸ оролцсон нөхцөлд л эмэгтэйчүүдэд илүү хамаатай асуудалд зохих анхаарал хандуулах боломжтой⁶⁹. ЕАБХАБ-ын бүс нутагт боловсрол; цэрэг арми зэрэг зарим зэрэг хөдөлмөрийн зах зээлийн тодорхой салбарт ажил эрхлэх, цалин хөлс авах асуудал; эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд гэх мэт нийгмийн бодлого, эрүүл мэндийн салбар; өндөр настан, хүүхдийг асран хамгаалах зэрэг салбарт жендэрийн эрх тэгш байдлын хувьд томоохон бэрхшээлтэй тулгардаг хэвээр байна⁷⁰. Энэ бүс нутгийн ихэнх оронд улс төр, эдийн засгийн өөрчлөлтөөс улбаатай бэрхшээл, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүний наймаа зэрэгт эмэгтэйчүүд илүүтэй өртөж байна⁷¹. Хэрэв улс төрд эмэгтэйчүүд байхгүй, хууль тогтоох зэрэг иргэдийн төлөөллийн байгууллагад ялихгүй хувь хэмжээгээр оролцсон хэвээр байвал дээр дурдсан ноцтой асуудлыг эн тэргүүнд шийдвэрлэх нь байтугай анхаарал ч хандуулахгүй болов уу.

67 Ibid.

68 Critical mass of women in office—postulated as around 30 per cent of legislators in a given country—refers to the level of women’s representation in elected office when they can begin to influence policy and laws and, potentially, move the gender equality and women’s empowerment agenda forward.

69 Sarah Childs, *New Labour’s Women MPs: Women Representing Women* (London: Routledge, 2004); Michelle Swers, *The Difference Women Make* (Chicago: University of Chicago Press, 2002); Sue Thomas, *How Women Legislate* (New York: Oxford University Press, 1995).

70 Tanja van der Lippe and Eva Fodor, “Changes in gender inequality in six eastern European countries”, *Acta Sociologica*, Vol. 41, No. 2, 1998, pp. 131–149; Sylke Viola Schnepf, “Gender differences in subjective well-being in Central and Eastern Europe”, *Journal of European Social Policy*, Vol. 20, No. 1, 2010, pp. 74–85.

71 Janet Elise Johnson, “Domestic violence politics in post-Soviet States” *Social Politics*, Vol. 14, No. 3, 2007, pp. 380–405; Olga Avdeyeva, “When do states comply with international treaties? Policies on violence against women in post-communist countries”, *International Studies Quarterly*, Vol. 51, No. 4, 2007, pp. 877–900; Jane Hardy, Wiesława Kozek and Alison Stenning, “In the front line: women, work and new spaces of labour politics in Poland”, *Gender Place and Culture*, Vol. 15, No. 2, 2008, pp. 99–116; Tomas Sobotka, “Re-emerging diversity: Rapid fertility changes in central and eastern Europe after the collapse of the Communist regimes”, *Population*, Vol. 58, No. 4–5, 2003, pp. 511–547.

Ялангуяа олон талт асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхээр парламентад авч хэлэлцэх үед эмэгтэйчүүд асуудлыг илүү олон талаас нь харж, баялаг түршлага, өргөн хүрээний ашиг сонирхол, мэргэжлийн үүднээс ханддаг давуу талтайг нотлох баримт олон бий⁷². Олон өөр төрлийн мэргэжил мэдлэгтэй, өөр өөр намын эмэгтэйчүүдийг олноор сонгоход төрийн бодлогод эмэгтэйчүүдийн дуу хоолой тусах замаар нийгэмд өөр зэрэг нөлөөллүүд ч бий болдог.

2.4.3. Нийгэм-эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь зөвхөн зөв зүйл төдийгүй ухаалаг үйлдэл гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрөөд байна. Улс төрийн албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэхэд эдийн засагт ч ашигтай гэсэн нотолгоо байдаг аж⁷³. Жишээлбэл, жендэрийн эрх тэгш байдлыг хангаснаар улс орнуудад ажилтан бүрийн ажлын гарц 3-25 хүртэл хувиар нэмэгдэх тул энэ нь “ухаалаг эдийн засаг”-ийг бий болгодог гэж Дэлхийн Банк үзжээ. Тодруулбал:

“Охид, эмэгтэйчүүдэд өмнөхөөсөө сайн нөхцөл боллоцоо олгосон улс орнуудад ажлын бүтээмж дээшилж, хүүхдэд илүү ээлтэй нөхцөл бий болж, байгууллагууд нийгмийн төлөөллийг илүү сайн ханган, бүх нийтээр хөгжих үндэс болдог”⁷⁴.

Түүнчлэн Дэлхийн эдийн засгийн форумын 2011 оны Жендэрийн зөрүүтэй байдлын тайланд:

“Эмэгтэйчүүдэд боловсрол олгож, эдийн засгийн тулгуур бүтцүүдэд ажиллуулсан улс орон, байгууллага хөгжин дэвждэг бөгөөд удирдах бүрэлдэхүүнд төлөөлөл сайн хангагдсан байвал тухайн үеийн эдийн засгийн асудлуудыг шинэлэг санаачлагатайгаар шийвэрлэж, илүү тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг бий болгодог” гэжээ⁷⁵.

Мөн энэхүү тайланд эмэгтэйчүүд эрчүүдээс илүүтэйгээр гэр бүлийн орлогын ихэнх хувийг боловсрол, эрүүл мэнд, хүүхдийнхээ төлөө зориулдагийг тогтоосон тухай дурдсан байна⁷⁶. Мөн 2011 оны нэгэн судалгаагаар эмэгтэй хүнд хөгжлийн зориулалтаар нэг доллар өгвөл **90 хувийг** нь гэр бүл, нийгмийн сайн сайханд зориулдаг гэдгийг харуулсан байна. Харин 1 долларыг эрэгтэй хүнд өгөхөд **30-40 хувийг** нь л гэр бүл, нийгэмд зарцуулж үлдсэнийг нь өөртөө зарцуулах магадлалтай байдаг⁷⁷. Зураг 2.10-т хэрэв хөгжлийн зориулалтаар 1 доллар өгвөл эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хэдэн хувийг нь нийгэм, гэр бүлдээ болон өөртөө зарцуулахыг хувиар илэрхийлэн харуулав.

72 Anne Phillips, *The Politics of Presence* (New York: Oxford University Press, 1995); Jane Mansbridge, “Should Blacks Represent Blacks and Women Represent Women? A Contingent Yes”, *Journal of Politics*, Vol. 61, No. 3, 1999, pp.628–657.

73 Kofi Annan, *Quotes on Human Rights*, 2008, <<http://www.unfpa.org/rights/quotes.htm>>.


74 “World Development Report 2012: Gender Equality and Development”, The World Bank, 2012, <<http://go.worldbank.org/CQCTMSFI40>>.

75 “The Global Gender Gap”, World Economic Forum (WEF), 2011, <<http://www.weforum.org/issues/global-gender-gap>>.

76 Ricardo Hausmann, Laura D. Tyson and Saadia Zahidi, “The Global Gender Gap Report 2011”, World Economic Forum, 2011, <http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2011.pdf>.

77 Cherie Booth QC, “Seeking True Democracy: The Challenge and Promise of Full Equality for Women”, Chatham House, December 2011.

Зураг 2.10. Хөгжлийн зориулалтаар өгсөн нэг долларыг хэн хэрхэн зарцуулдаг вэ? (хүйсээр)



Эх сурвалж: АИХЭА-наас энэхүү гарын авлагад зориулж Чери Бүүт КиуСи, “Үнэн ардчиллын мөрөөр: Эмэгтэйчүүдэд тэгш байдлыг бүрэн утгаар нь бий болгохоор өгсөн амлалт, учирч буй бэрхшээл”, Чантам Хаус, 2011 оны 12 дугаар сар, бүтээлд үндэслэн бэлтгэв.

2.4.4. Нийгэм дэх жендэрийн тэгш байдлын талаарх ойлголтыг дээшлүүлнэ

ЕАБХАБ-ын бүс нутгийн олон улс оронд жендэрийн эрх тэгш байдлыг зөв ойлгон, хүлээн авч чадахгүй байна. Ялангуяа улс төрчид, шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшинд ажиллаж буй хүмүүсийн ойлгохгүй байгаа асуудлыг эн тэргүүнд анхаарах бодлогын асуудал болгон тавихад хэцүү. Улс төрчид жендэрийн эрх тэгш байдлыг зөв ойлгож, нийгэмд бий болох үр ашгийг нь олж харж чадвал нийгмийн гишүүн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэнд нь ч зөв, эерэг ойлголт, хандлага бий болох боломж илүү байна.

АИХЭА-ны 2012 оны судалгаанд оролцогчдын ихэнх нь жендэрийн эрх тэгш байдлын талаар ойлголт сайтай байгаа нь харагдсан⁷⁸. Жишээлбэл, тус судалгаанд оролцсон Казакстаны иргэн эрэгтэй жендэрийн эрх тэгш байдал нь “эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш байх орчин цагийн зайлшгүй шинж” гэж тодорхойлжээ.

“Улс төр, нийгэм, соёлын амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш нөхцөлтэй оролцоход жендэрийн эрх тэгш байдал шаардлагатай”.

Эх сурвалж: АИХЭА-ны 2012 оны судалгаанд Казахстан улсаас оролцсон эмэгтэйн хариулт

Харин Молдав улсын нэгэн эмэгтэй оролцогч “эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь байр сууриа илэрхийлэх, чадвараа батлан харуулах, амьдралаа сайжруулах үйл явцад оролцох, дүү хоолойгоо хүргэх, нийгмийн тусын тулд санаа бодол, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломж” гэж тодорхойлсон байна. Гүрж улсын нэгэн эрэгтэй оролцогчийн хувьд “Жендэрийн эрх тэгш байдал нь бүрэн дүүрэн ардчилал юм” гэсэн бол Киргизстан улсын эмэгтэй оролцогч харин “амьдралын бүхий л хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил эрх, үүрэгтэй, ижил орлоготой, нөөц бололцооноос хүртэх ижил тэгш боломжтой байх явдал юм” гэжээ. Судалгаанд оролцсон бусад хүмүүс жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль зүйн арга хэмжээ, эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш өрсөлдөх боломж шаардлагатай бөгөөд нийгмийн бүх давхаргад эрэгтэй, эмэгтэй хүмүүс оролцож, эрэгтэй,

“Жендэрийн эрх тэгш байдал гэдэг нь жендэрээс үл хамаарах ЭРХ ТЭГШ БАЙДАЛ юм.”

Эх сурвалж: АИХЭА-ны 2012 оны судалгаанд Молдав улсаас оролцсон эрэгтэйн хариулт

эмэгтэй хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг илүү ойлгож мэдэх явдал чухал гэж хариулцгаажээ.

Хоёрдугаар бүлгийн дүгнэлт

Энэхүү бүлэгт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих тухай асуудлыг улс төрийн нам талаас нь голлон авч үзлээ. Мөн олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг биелүүлэх үүрэг буюу уламжлалт үндэслэлээс гадна нийтээр хүлээн зөвшөөрөгдөх байдал, төлөөлөл, бүгдийг хамарсан байх зарчмыг хангахтай ямар учир холбогдолтойг харуулав. Түүнчлэн улс төрийн нам сонгогчдыг өөртөө татахад туслах буюу улс төрийн намд хөшүүрэг бий болгож байж эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны асуудлыг урагшлуулах нь зүйтэй гэсэн үндэслэлийг ч авч үзэв. Улс төрд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь зөв зүйл төдийгүй ухаалаг алхам болохыг улс төрийн намын удирдлага, эмэгтэй улс төрчид, иргэний нийгмийн байгууллагуудад харуулахыг зорив. Харин улс төрийн намын удирдлага, эмэгтэй улс төрч, иргэний нийгмийн байгууллага үүнийг бодит амьдралд хэрэгжүүлэх тодорхой арга замыг дараагийн бүлгүүдэд танилцуулна.

Улс төрийн намууд, намын удирдлага

Гуравдугаар бүлэг

Гуравдугаар бүлгийн оршил

3.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?

- 3.1.1. Намын тогтолцоо, үйл явц, практикт жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх нь
- 3.1.2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг сайн дурын үндсэн дээр авч хэрэгжүүлэх нь
- 3.1.3. Санхүүгийн нөөц болон сонгуулийн сурталчилгааны ажлын санхүүжилт олгоход жендэрийн тэгш байдлыг хангах нь
- 3.1.4. Жендэрийн асуудлыг намын сонгуулийн сурталчилгааны ажлын нэг хэсэг болгох нь
- 3.1.5. Жендэрийн мэдрэмжтэй засаглалыг дэмжих нь

Гуравдугаар бүлгийн дүгнэлт

Гуравдугаар бүлгийн оршил

Аливаа улс орны сонгуульд байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөлөлд улс төрийн болон сонгуулийн тогтолцооны шинж чанар, шийдвэр гаргах үйл ажиллагаа журамлагдсан байдал, улс орны эдийн засаг, соёлын хөгжил зэрэг хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байдаг. Гэхдээ орчин үеийн ардчилсан тогтолцоонд улс төрийн нам гол үүрэг гүйцэтгэдэг хэвээр байна. Тиймээс эмэгтэйчүүд улс төрд хэр зэрэг оролцох, уг оролцоо хэр чанартай байх вэ гэдгийг тодорхойлоход улс төрийн нам, түүний баримталдаг журам, үйл явц чухал үүрэг гүйцэтгэнэ.

Ийм ч учраас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны асуудалд улс төрийн намыг “тээн хэрэгжүүлэгч” гэж нэрлэх нь их. Улс төрийн намын дүрэм, журам, үйл ажиллагаан дах жендэрээс үүдэлтэй шууд болон шууд бусаар ялгаварлал, сонгуульд нэр дэвшигчийг сонгохдоо жендэрийн мэдрэмжгүй хандах, нэр дэвшигчдэд намын хөрөнгийг тэгш бус хуваарилах зэрэг нь намын гишүүн эмэгтэйчүүд, түүний дотор эмэгтэй нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаагаа зохион байгуулж, хэрэгжүүлэхэд цогц байдлаар хүндрэл бэрхшээл учруулдаг.

Иймээс ЕАБХАБ-ын бүс нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, нөлөөг дээшлүүлэх асуудлын хүрээнд улс төрийн намууд гол бай болоод байна. Энэ нь улс төрийн намууд улс төрийн төлөөлөгч, удирдагчийг сонгож, нийгэмд танилцуулах, мөн улс төрийн намын тогтолцооны дотор жендэрийн эрх тэгш байдлыг ахиулах замаар ардчилсан үйл явцад суурь үүрэг гүйцэтгэж байгаатай холбоотой. Чухамдаа энэхүү суурь үүргийн улмаас улс төрд жендэрийн эрх тэгш байдлыг тогтоох гол этгээд нь улс төрийн нам юм. Энэ үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж гэвэл улс төрийн нам дараах дөрвөн хүрээг бодолцох ёстой. Үүнд:

- Намын дотоод дүрэм, журам зэрэг намын дотоод үйл ажиллагаа;
- Нам эмэгтэй нэр дэвшигч, идэвхтэн, гишүүдтэйгээ ажиллаж байгаа байдал, нам доторх эмэгтэй, эрэгтэй гишүүдийн хоорондын харилцаа, хамтын ажиллагаа;
- Намын зүгээс иргэний нийгмийн эмэгтэй идэвхтэн, эмэгтэй сонгогчидтой ажиллаж байгаа байдал;
- Намаас улс орны болон орон нутгийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй удирдлагыг хэрэгжүүлж ирсэн түүх, туршлага.

Намын **дотоод үйл ажиллагаандаа** мөрддөг албан ба албан бус дүрэм, журмууд нь тухайн нам жендэрийн асуудалд хэр мэдрэмжтэйг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Бүтэц зохион байгуулалт нь сайтар хэвшсэн улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжсэн бодлого явуулах хандлагатай байдаг⁷⁹. Учир нь намын бүтэц зохион байгуулалт тодорхой, мөн шийдвэр гаргах, бодлого боловсруулах, тушаал дэвшүүлэх, намд элсүүлэхтэй холбоотой дүрэм нь тодорхой, ил тод байвал эмэгтэй, эрэгтэй гишүүдээс намын хөрөнгө нөөц ашиглах, удирдлагад ажиллах тэгш бололцоо хангагдах суурь тавигдсан байдаг. Түүнчлэн намын дотоод үйл явц тодорхой ойлгомжтой бол намын гишүүдээс намын бодлого, үйл явц, дүрэм журамд эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг дэмжсэн өөрчлөлт хийхэд хялбар дөхөм болно. Тухайлбал, тийм өөрчлөлт гэдэгт намаас сайн дурын үндсэн дээр нэвтрүүлэх квот, зорилт, бусад сайн дурын арга хэмжээ багтана.

Гэхдээ тодорхой үр дүнд хүрье гэвэл эдгээр арга хэмжээтэй зэрэгцүүлэн нам дотроо **эмэгтэйчүүдийн улс төрийн карьер ахиулахыг** идэвхжүүлэн дэмжсэн санаачилгыг авах шаардлагатай бөгөөд үүнд чадавх бэхжүүлэх, жендэрийн талаарх ойлголт мэдлэг

79 Pippa Norris and Mona Lena Krook, “Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan” (Warsaw: OSCE, 2011), <<http://www.osce.org/odihr/78432>>.

олгох, жендэрийн мэдрэмжтэй бодлого, дүрэм журам нэвтрүүлэх зэрэг ажлыг дурдаж болно. Жендэрийн эрх тэгш байдлыг тогтоох зорилго эрмэлзлээ зөвхөн намын дотоод хүрээнд төдийгүй мөрийн хөтөлбөр, сурталчилгааны ажлын гол агуулгаар дамжуулан **сонгогчдод** сурталчлан таниулах нь зүйтэй.

Эцэст нь, улс төрд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог дэмжсэн сонгуулийн сурталчилгааны амлалт, үүргээ улс төрийн намууд бодит амьдрал дээр биелүүлэх шаардлагатай. Улс орны болон орон нутгийн түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж батлуулах эсвэл хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нөлөөллийн ажил хийх гэх мэт арга замаар уг үүрэг, амлалтаа биелүүлж болно.

Энэ бүлэгт улс төрийн намын хүрээнд, ялангуяа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл, нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор улс төрийн намууд, түүний дотор намын удирдлагаас хэрэгжүүлж болох арга замыг судалж үзнэ. Эдгээр арга зам нь намын бүтэц тогтолцоо, үйл явцыг илүү ардчилсан, жендэрт ээлтэй болгох, эмэгтэйчүүд улс төрийн карьер ахихад тус дөхөм болоход чиглэж байгаа юм. Энэ бүлгийг боловсруулахдаа АИХЭА, Европын зөвлөл хамтран боловсруулсан *Улс төрийн намын зохицуулалтын талаарх удирдамжид* дурдсан олон улсын хэм хэмжээ, сайн туршлага, мөн энэ салбарт ажиллаж буй олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын мэдээлэл, туршлагаас ашиглав⁸⁰.

Түүнчлэн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд саад болж байгаа хүчин зүйл хэмээн судалгаагаар тодорхойлсон зургаан асуудлыг авч үзнэ. Үүнд:

- ✓ Намын суурь баримт бичигт намын бүтэц тогтолцоо, үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн төлөөллийг хангахад чиглэсэн заалт, арга хэмжээ тусгагдаагүй;
- ✓ Нэр дэвшигч элсүүлэх, сонгох үйл явц ил тод бус;
- ✓ Албан тушаал ахих дүрэм журам тодорхойгүй, ил тод бус;
- ✓ Намын хөрөнгө нөөцөөс олж авах боломж, хуваарилалт тэгш бус;
- ✓ Намын дотоод соёл нь жендэрийн мэдрэмжгүй;
- ✓ Байгууллагын болон зохицуулалтын орчинд эмэгтэйчүүдийг ялгаварлах явдал байдаг бөгөөд үүнтэй холбоотой гомдлыг барагдуулах механизм хангалтгүй.

Эдгээр асуудал тус бүрийг дор дэлгэрэнгүй авч үзэхийн зэрэгцээ түүнийг даван гаргах тодорхой арга хэмжээг танилцуулна.

Эмэгтэйчүүд улс төрийн намын үйл ажиллагаанд оролцоход тулгарч буй бэрхшээл

Улс төрийн нам дотроо болон гадагш чиглэсэн ямар ажил явуулж болох вэ гэдгийг намын **суурь баримт бичгээр** зохицуулдаг. Зарим улс төрийн нам суурь баримт бичгээрээ дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг сурталчлан, жендэрийн мэдрэмжтэй үг хэллэг хэрэглэсэн байдаг. Гэхдээ ихэнх тохиолдолд тэгш байдал, тэгш хандах асуудлын талаар огт дурддаггүй. Түүнчлэн улс төрийн намууд үйл явц, бодлогоо ил тод болгох чармайлт гаргадаг ч түүнийгээ бодит байдалд мөрддөггүй, энэ нь эргээд намын эмэгтэй гишүүдэд хохиролтой нөхцөл үүсгэдэг. Намын үндсэн үйл ажиллагаанаас зайлшгүй ил тод, шударга, тэгш болгох ёстой нэг асуудал бол **нэр дэвшигч элсүүлэх, сонгох** явц юм. Улс төрийн намын нэр дэвшигчдээс хэдэн эмэгтэй сонгогдож байгаа нь сонгогчдын зүгээс эмэгтэйчүүдэд ялгавартай хандаж байгаа эсэхийг харуулдаг⁸¹ бол

80 See OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010, <www.osce.org/odihr/77812>. See also, for example, Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation, UNDP/NDI, 2011, p. 25, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

81 The overwhelming finding in the academic literature, however, is that voters do not discriminate against women. For a review, see Rainbow Murray, Mona Lena Krook and Katherine A. R. Opello, "Why Are Gender Quotas Adopted?"

намын удирдлагаас хэдэн эмэгтэйг нэр дэвшүүлж байгаа нь тухайн нам эмэгтэйчүүдийг ялгаварладаг эсэхийг тодорхой илтгэж байдаг. Жишээлбэл, намын гишүүдийн тэн хагас нь эмэгтэйчүүд, намын удирдах албанд ч эмэгтэйчүүд ажилладаг гэж ярьдаг атлаа нэр дэвшигчийн жагсаалтад эмэгтэйчүүд 20 хүрэхгүй хувийг эзэлж байгаа бол энэ нь тухайн намын нэр дэвшигч сонгох явцад жендэрээс үүдэлтэй ялгаварлал байгаагийн нэг илрэл юм. Нэр дэвшигчийг сонгох дүрэм журмыг тодорхой ойлгомжтой бичиж, ил тод байлгах нь намууд гаргасан дүрмээ мөрдөх хамгийн сайн механизм болдог.

Цөөн тооны улс төрийн нам нэр дэвшигч элсүүлэх, сонгох ардчилсан, жендэрийн мэдрэмжтэй дүрэм журам нэвтрүүлж, эмэгтэй нэр дэвшигчийн тоог нэмэх тодорхой арга хэмжээ оруулсан байдаг. Харин ихэнх намын удирдлага тэр бүр мерит буюу мэдлэг чадварын зарчимд суурилсан шалгуураар нэр дэвшигчийг сонгож чадахгүй байна. Намын шийдвэр гаргах, удирдах **албан тушаалд дэвших асуудлыг зохицуулдаг дүрэм журмын** хувьд ч нөхцөл байдал адил байна. Хэдийгээр ардчилсан бус дүрэм журмаас болж намын эрэгтэй, эмэгтэй гишүүдийн аль аль нь хохирч болох ч жендэрийн мэдрэмжгүй дүрэм журмын улмаас намын эмэгтэй гишүүд нэр дэвшигч элсүүлэх, сонгох, албан тушаал дэвшихтэй холбоотой албан ба албан бус шийдвэр гаргах үйл явцын гадуур үлдэх магадлалтай. Тиймээс уг үйл явц ардчилсан бус, ил тод бус байгаа нь эмэгтэйчүүдэд, ялангуяа намын бүтэц, зохион байгуулалтын удирдлагад багтдаггүй эмэгтэйчүүдэд хамгийн хохиролтой тусдаг.

Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгардаг өөр нэг том бэрхшээл бол **намын хөрөнгө нөөцийг хуваарилах, хүртээхэд гардаг тэгш бус байдал** юм. Энэ нь нэг талаас эмэгтэй нэр дэвшигч санхүүжилт багатай, нөгөө талаас, сонгуулийн сурталчилгааны зардал өндөр байдагтай холбоотой. Намын нэр дэвшигчийг сонгох хороо ихэвчлэн эрэгтэйчүүдэд талтай ханддаг, учир нь хөрөнгө нөөц хуваарилах болоход эрэгтэйчүүд “найдартай”-д тооцогддог. Энэ нь одоо сонгуульд албан тушаалын дийлэнхийг эрэгтэйчүүд эзэлдэг, энэ утгаараа сонгогчдод танигдсан тул сонгуульд (болон намдаа) давуу тал авчирна гэж үздэгтэй холбоотой юм. Түүнчлэн ажил хэрэг, албан тушаалынхаа улмаас эрэгтэйчүүд хандивлагч, бизнесийн сүлжээтэй илүү ойр холбоотой байдаг бөгөөд сонгуулийн

Шигтгээ 3.1. Улс төрийн намын хүрээнд шат ахихад эмэгтэйчүүдэд тулгардаг үндсэн бэрхшээл

1. Жендэрийн асуудалд мэдрэмжгүй намын дүрэм журам: Намын суурь баримт бичигт эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг дэмжсэн арга хэмжээг тэр бүр тусгаагүй, харин ч шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах үг хэллэгээр бичигдсэн байх нь бий.
2. Нэр дэвшигч элсүүлэх/сонгох: Энэ үйл явцтай холбоотой албан ёсны, бичгээр гаргасан журам байхгүй тохиолдолд намын удирдлага овжноор ашиглах буюу үл тоомсорлох бололцоотой учраас нэр дэвших боломжтой эмэгтэйчүүдэд сөргөөр тусдаг.
3. Албан тушаал дэвшүүлэх: Намын албан тушаалд шат ахиулах, дэвшүүлэх журмыг баримт бичигт тусгаагүйгээс мерит буюу мэдлэг чадвар бус харин танил талын үндсэн дээр улс төрийн хувьд ахиж дэвших магадлалтай.
4. Хөрөнгө нөөцөөс олж авах: Ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх байгууллага, хүн олох нь эмэгтэйчүүдэд хялбар бус, санхүүжилт цуглуулах түршлагаар ч эмэгтэйчүүд дутмаг байдаг тул намын хөрөнгө нөөцөөс олж авах, хуваарилахад тэгш бус хандах нь эмэгтэйчүүдэд маш сөргөөр нөлөөлдөг.
5. Намын соёл: Мэдээлэл солилцох, хамт олны ажил зохион байгуулах, аян өрнүүлэхдээ уламжлалт арга барил, хэв маягт түшиглэх нь “эрчүүдийн клуб”-ыг санагалзүүлж,

эмэгтэйчүүдийг шоовдорлох, илт ялгаварлах, эсвэл жендэрийн хэвшмэл хандлага, алагчилж үзэх нөхцөлийг бүрдүүлдэг.

6. Намын үйл ажиллагааг зохион байгуулах: Ажлын цагийн хуваарь, орой үдэш, амралтын өдрүүдэд хурал цуглаан хийх зэрэг намын үйл ажиллагааг зохион байгуулах зарим хэлбэр нь эмэгтэйчүүдийн бусад үүрэг хариуцлага ялангуяа гэр бүлийн хариуцлагатай зөрчилдөх тал бий.

сурталчилгааны ажилдаа захиргааны хөрөнгө нөөцийг шууд бусаар зарцуулах аргаа олсон байдаг. Эдгээр бүх хүчин зүйлийн үр дүнд сонгуульд эрэгтэйчүүд өөртөө давуу тал бий болгодог.

Зарим улс төрийн намын мөн чанар, эмэгтэйчүүдэд хандах байдал нь намынхаа эмэгтэй гишүүдтэй, өөрөөр хэлбэл, эмэгтэй нэр дэвшигч, сурталчилгааны ажлын менежер, идэвхтэн, дэмжигчдэд хэрхэн хандаж байгаагаар илэрч байдаг. ЕАБХАБ-ын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй олон намын дүрэм, сонгуулийн хөтөлбөр жендэрийн эрх тэгш байдлыг дэмжсэн байдлыг энэ бүлгээс харж болно. Гэвч эмэгтэйчүүдийн улс төрийн чадвар бололцоог намын удирдлага, шийдвэр гаргах түвшинд үнэлж, хүлээн зөвшөөрсөн нь ховор. Цаг зав, хөдөлмөр их шаардсан сайн дурын гэх мэт албан тушаалд эмэгтэйчүүдийг сонгож томилох нь элбэг байгаа бол улс төрд танигдаж харагдах, жинтэй чухал ажил,

албан тушаалд эмэгтэйчүүдийг итгэж томилох нь түн цөөн байна⁸².

Түүнчлэн ажлын цагийн хуваарь (орой болтол олон цагаар ажиллуулах), бодит байдал дээр дүрэм журмаа мөрдөхгүй байх, албан хүчин хэвшил болсон ажил, бичигдээгүй заншил зэрэг **байгууллагаас шалтгаалсан** хүчин зүйлс эмэгтэйчүүдэд мөн бэрхшээл учруулж байна. Зарим **улс төрийн намын дотоод соёл** нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан хэвээр, улс төрийн шат ахихад шууд бусаар, заримдаа шууд хэлбэрээр саад тотгор учруулж байна. Ялангуяа хамт олны болон сурталчилгааны уламжлалт аян өрнүүлэхдээ эмэгтэйчүүдэд тохиромжгүй үйл ажиллагаа, байршлыг сонгодог. Намын дотоод соёл нь улс төрийн зонхилох соёлын илрэл бол ялгаварлан гадуурхалт илүү их байна. Жишээлбэл, улс төрийн карьерт чухалд тооцогддог шинж чанар эрэгтэйчүүдэд байвал эерэгээр (шийдэмгий, амбицтай, тууштай, цуцашгүй, зарчимч) магтан сайшааж, мөн адил шинж чанар эмэгтэйчүүдэд байвал сөргөөр хүлээн авч, тэдгээрийг сөрөг шинж чанар (түрэмгий ширүүн, эрх мэдэлд дуртай, хэрүүлч, чимээгүй эсэргүүцэгч, зөрүүд) болгон хүлээж авах нь бий.

3.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?

Дээр өгүүлсэн саад бэрхшээлийг арилгах, улс төрийн нам дах эмэгтэйчүүдийн үүрэг оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой арга замыг энэ хэсэгт танилцуулна. Зарим арга замыг хэрэгжүүлэхэд үр дүн нь шууд илэрч, өөрчлөлт гарах бол заримынх нь хувьд үр дүн аажим гарна. Гэхдээ дунд, урт хугацааны ерөнхий үр дүн нь улс төрийн намуудад ашигтай байх нь тодорхой юм. Аль нэг арга замыг дангаар нь сонгон хэрэгжүүлбэл хангалтгүй гэдгийг санаж байвал зохино. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн ялгааг залруулахад цогц хандлага шаардлагатай. Энэ нь улс төрийн намын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаан дах эрчүүд давамгайлсан байдлыг халж, аль аль хүйсийн төлөөллийг тэгш хангасан байгууллага болгон өөрчилнө гэсэн үг. Үүний тулд намын байгууллагын бүтэц, хэв загвар, нэр дэвшигч элсүүлэх, сонгох, албан тушаал дэвшүүлэх, хөрөнгө нөөц хуваарилахтай холбоотой дүрэм журам, намын бодлого, стратеги төлөвлөлт, намын соёлыг өөрчлөн шинэчлэх шаардлагатай болно.

82 2012 ODIHR Survey on Women in Political Parties; personal interviews with women MPs and local partners in pilot countries, 2011–2012.

Ийм хэрэгцээ шаардлага байгааг намын удирдлага шууд хүлээн зөвшөөрөхгүй байж болох ч уг өөрчлөлтийг эхлүүлэх талаар намын удирдлагад шахалт үзүүлэх жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгч, түүнчлэн намын удирдлагад өөрсдөд нь гарын авлагын энэ бүлэг чиглэж байгаа юм. Намын удирдлагаас тухайн өөрчлөлтийг санаачлах, зөвшөөрөн батлахад хэрэгтэй үндэслэл тайлбар, тодорхой арга замыг энэ бүлэгт оруулав. Эдгээр арга замыг хэрэгжүүлэх үед намын удирдлагад дэмжлэг хэрэгтэй тул жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгч идэвхтнүүд төлөвлөх, хэрэгжүүлэх, үр нөлөөг хянаж үнэлэх шатанд туслах боломжтой.

Энд толилуулж буй өөрчлөлт хийх арга замыг хэрэгжүүлэх нь эмэгтэйчүүд, жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгч идэвхтнүүд төдийгүй намын бүх гишүүдэд ашиг тустай. Тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд намын дотоод ямар бүлгийн дэмжлэгийг авч, эвсэл үүсгэх талаар намын удирдлага ч, жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгч идэвхтнүүд ч бодолцож үзвэл зохино. Тухайлбал, намын ёс зүйн дүрмийг баталж мөрдөх замаар нийгэм эдийн засгийн байдал, яс үндэс, нас, гарал угсаанаас үл хамааран намын бүх гишүүнд шударга, ялгаварлалгүй хандах явдлыг баталгаажуулж болно. “Жендэрийн аудит”-ыг “олон янз байдлын аудит” болгон өргөжүүлээд намын үйл явцаас ямар эрэгтэй, ямар эмэгтэй хамгийн их ашиг хүртэж байна вэ, бичигдээгүй дүрэм, заншлаас болж ямар эрэгтэй, ямар эмэгтэй шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтад өртөж байна вэ (жишээ нь, нэр дэвшигчийг сонгох, хөрөнгө нөөц хуваарилах) гэдгийг тодорхойлох боломжтой. Ур чадвар хөгжүүлэх сургалт зэрэг чадавх дээшлүүлэх санаачилга хэрэгжүүлэх нь намын залуу, шинэ гишүүд, орон нутгийн намын үүрийн ажилтнуудын чадварыг нэмэгдүүлэх, сайжруулахад тустай байж болно. Сонгуулийн сурталчилгааны ажлын орчин нөхцөл айх аюулгүй байх нь намын нэр дэвшигч, эрэгтэй, эмэгтэй сонгогчдод бүгдэд нь хэрэгтэй зүйл билээ.

Дээр дурдсан арга замыг танилцуулахдаа нам дотроо хийж болох ажлыг эхлэн, намын ойр орчимд хийж болох ажлыг дараа нь дурдсан бол төгсгөлд нь нам засгийн эрх барих эсвэл сөрөг хүчин болсон тохиолдолд хэрэгжүүлэх ажил гэсэн дарааллаар мэдээллийг бэлтгэв. Гэхдээ намын дотоод бүтэц, үйл явц, улс төрийн орчин, намд үзүүлж буй дэмжлэг, сонгуулийн тогтолцооны онцлогоос хамаарч намууд эдгээр ажлыг ямар дарааллаар хэрэгжүүлэхээ сонгох нь зүйтэй.

3.1.1. Намын тогтолцоо, үйл явц, практикт жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх нь

ЕАБХАБ-ын бүс нутаг дахь улс төрийн намуудын дотоод дүрэм журам, бүтэц зохион байгуулалт нэлээд ялгаатай ч ихэнх нь үйл ажиллагаандаа удирдлага болгох суурь баримт бичиг, дүрмээ баталсан байдаг. Тухайн аль нэг нам албан, албан бус байдлаар үйл ажиллагаа нь хэрхэн явагддагийг мэдэж авснаар эрэгтэй, эмэгтэй гишүүддээ улс төрийн шат ахихад ижил тэгш боломж олгодог эсэхийг нь мэдэх боломжтой. Ийм учраас жендэрийн эрх тэгш байдлыг намын баримт бичиг, үйл явц, дүрэм журамд зарчим болгон тусгах, мөн жендэрийн тэнцвэртэй байдал бий болгохыг нэг зорилго болгон дэвшүүлэх арга замыг энэ хэсэгт толилуулна.

→ Нам дотроо жендэрийн цогц аудит хийх нь

Намын дүрэм, үйл явц, практикт жендэрийн эрх тэгш байдлыг хангахад ямар сул тал байгааг илрүүлэх эхний чухал алхам бол жендэрийн аудит юм.

Улс төрийн намын **жендэрийн аудит** буюу “өөрийн үнэлгээ” гэдэг нь жендэрийн тэгш бус байдлыг тэтгэж, улс төрийн шат ахихад эмэгтэйчүүдэд саад тотгор учруулж буй шууд ба шууд бус, албан ба албан бус байдлаар ялгаварлан гадуурхах явдал байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор намын үйл явц, дүрэм журам, бүтэц тогтолцоо,

соёл, үйл ажиллагаанд жендэрийн өнцгөөс үнэлгээ хийх аргачлал билээ. Мөн намын бодлого, хөтөлбөр, сурталчилгааны ажлын арга замыг жендэрийн тэгш байдалд нийцүүлэн өөрчлөхөд шаардлагатай мэдээллийг бий болгон улс төрийн намын удирдлагад хүргэх нэг арга юм. Тухайн улс төрийн намаас намын идэвхтэн, шийдвэр гаргагч, жендэрийн мэргэжилтнүүдээс бүрдсэн дотоод ажлын хэсэг байгуулан, тодорхой хугацаа заан, жендэрийн аудит хийж болно. Ажлын хэсэг байгуулах боломжгүй бол намын эмэгтэйчүүдийн жигүүрт жендэрийн аудит хийх ажлыг хариуцуулж болно. Эсвэл жендэрийн шинжээч хөлсөлж авах буюу энэ асуудлаар мэргэшсэн, жендэрийн аудитын туршлагатай төрийн бус байгууллагатай хамтран ажиллах аргыг ч сонгож болно (иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэх үүргийн талаар 5 дугаар бүлгээс үзнэ үү). Гэхдээ жендэрийн аудит хийхэд намын удирдлагатай хамтран ажиллах нь чухал тул намын ерөнхий нарийн бичгийн дарга, ерөнхийлөгч, гүйцэтгэх хорооны тэргүүлэх гишүүд, эмэгтэйчүүдийн жигүүрийн ахлагч, жендэрийн шинжээч зэргээс бүрдсэн ажлын хэсэг байгуулах нь илүү ач холбогдолтой. Намын удирдлагыг татан оролцуулах нь жендэрийн аудитын мөрөөр арга хэмжээ авах бололцоо олгодог давуу талтай.

Шигтгээ 3.2. Улс төрийн намд жендэрийн аудит хийх багт орж болох гишүүд

Улс төрийн намд жендэрийн цогц аудит хийхдээ намын удирдлагаас Жендэрийн аудитын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж болно. Үүнд:

1. Тухайн **намын ерөнхий нарийн бичгийн дарга** эсвэл намын дарга;
2. Намын Гүйцэтгэх хороо эсвэл Удирдах зөвлөлийн гишүүд зэрэг **намын удирдах байгууллагын төлөөлөл**;
3. Намын **эмэгтэйчүүдийн жигүүртэй бол дарга эсвэл гишүүн** нь, эсвэл намын жендэрийн асуудал хариуцсан ажилтан, идэвхтэн;
4. Намын өөрийнх нь эсвэл иргэний нийгмийн байгууллагын **жендэрийн шинжээчид**.

Жендэрийн аудит хийхдээ намын дүрэм, бодлого, стратеги, мөрийн хөтөлбөр, дотоод журам (албан болон албан бус) зэрэг бичиг баримтыг бүгдийг нь шинжилж үзэх ёстой. Түүнчлэн намын гишүүд, удирдлагатай ярилцан, жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн дэвшлийн талаах хандлагыг тодорхойлж, намын одоогийн практикийг тэд хэр шударга, хэр жендэрийн мэдрэмжтэй гэж үздэгийг таньж мэдэхэд уг аудитыг ашиглаж болно. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн одоо хашиж буй намын албан тушаалын төрөл (манлайлах буюу шийдвэр гаргах), гүйцэтгэж буй ажлын байдал (цалинтай эсвэл сайн дурын) зэргийг жендэрийн аудитаар тодорхойлон гаргаж болно. Улс төрийн намын жендэрийн аудит хийх загвар хуудсыг Хавсралт 2-оос үзнэ үү.

Жендэрийн аудитыг намын ерөнхий түвшинд төдийгүй бус, анхан шатны намын үүрийн түвшинд ч хийж болно. Ингэснээр жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих талаар намын үүр, салбарууд ямар ахиц дэвшил гаргаж байгааг харьцуулах, ямар сайн туршлага, арга зам байгааг олж мэдэх, орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийг дэвшүүлэхэд ямар дэмжлэг хэрэгтэй байгааг тодорхойлох боломжтой болно. Мөн намын анхан шатны нэгжийн онцлогийг тусгасан жендэрийн аудит хийснээр намын удирдлага, жендэрийн тэгш байдлын төлөө тэмцэгчдийн зүгээс намын тухайн салбар бүрийн хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээний санал боловсруулах боломжтой болно. Эцэст нь, анхан шатны нэгжүүдийн ахиц дэвшлийг харьцуулах нь жендэрийн эрх тэгш байдлын талаар олигтой ажиллаагүй салбаруудыг идэвхжүүлдэг.

Улс төрийн нам жендэрийн эрх тэгш байдлын талаар ямар байдалтай байгаагаа ийнхүү өөрөө үнэлж үзсэнээр давуу, сул талаа аль алийг нь тодорхойлж, ялангуяа сул талыг нөхөх, сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах боломжтой болно. Жендэрийн аудит буюу өөрийн үнэлгээнээс тухайн нам жендэрийн асуудалд ээлтэй эсвэл ээлгүй гэсэн дүр зураг гарна. Мөн жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд ямар ажил хийж болох вэ гэдэг нь харагдана (Шигтгээ 3.3-ийг үзнэ үү).

Сонгуулийн өмнө эсвэл хойно жендэрийн аудит хийх нь хамгийн тохиромжтой үе юм.

- **Сонгуулийн өмнөх үе:** Энэ үед намын дүрэм, суурь баримт бичгүүд, стратеги, мөрийн хөтөлбөр, бодлого, дотоод журам зэргийг судалж, түүнд ялгаварлан гадуурхсан зүйл заалт, зааг ялгаа байгаа эсэхийг нягтлан, намын гишүүдтэй ярилцлага хийх замаар ялгаварлан гадуурхал гардаг эсэх, мөн нөхцөл байдлыг сайжруулахын тулд намын зүгээс ямар арга хэмжээ авбал зохих талаар саналыг нь сонсч болно. Уг мэдээллээ сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр боловсруулах, сонгуулийн санхүүжилтийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд тэнцвэртэй байдлаар олгоход ашиглах нь зүйтэй.
- **Сонгуулийн дараах үе:** Энэ үе бол сонгуулийн явцад хийсэн олон нийтийн санал асуулга, судалгаа, мөн сонгуульд санал өгсний дараа иргэдээс авсан санал асуулга, сонгуулийн үр дүнд жендэрийн өнцгөөс дүн шинжилгээ хийхэд тохиромжтой үе юм. Түүнчлэн намын удирдлага, сонгогчидтой ярилцлага хийж, эмэгтэй нэр дэвшигчдийн талаар, сонгуулийн сурталчилгааны ажил жендэрийн мэдрэмжтэй явагдсан эсэх талаар тэдний үзэл бодлыг тандах үнэлгээ хийж болно. Эдгээр нь тухайн намын хийж буй жендэрийн аудитын гадаад орчны мэдээллийг бүрдүүлэхэд ихэнхдээ хангалттай байдаг. Түүнчлэн жендэрийн аудит нь тухайн улс төрийн нам сонгуулийн сурталчилгааны амлалтаа хэр зэрэг биелүүлснийг харуулах бөгөөд дараагийн сонгуульд оролцох арга замаа боловсруулахад ч хэрэгтэй юм⁸³.

Шигтгээ 3.3. Улс төрийн нам жендэрт ээлтэй эсэхийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

- | | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> ✓ Намын шийдвэр гаргах бүх байгууллага, сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалт, сонгуульд болон томилогдох бүх албан тушаалд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэнцвэртэй оролцоог хангах талаар намын дүрэмд заасан байх ✓ Намын дүрэм, бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн эрх тэгш байдал бол намын баримтлах суурь үнэт зүйл, зарчмын нэг гэдгийг дурдсан байх ✓ Намын орон нутаг, бүс, төв буюу улсын түвшний байгууллага, түүний дотор Удирдах зөвлөлийн гишүүдийн бүртгэлийг тогтмол шинэчлэн хөтөлж, үг мэдээллийг хүйсээр ангилдаг байх ✓ Намын хүрээнд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан бодлого, практик байгаа эсэхийг илрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ямар ахиц дэвшил гарч байгааг үнэлэх зорилгоор жендэрийн аудитыг тогтмол хугацаанд хийдэг байх ✓ Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлыг тодорхойлж, холбогдох арга хэмжээг сонгуулийн сурталчилгааны ажлын санаа, намын амлалт болгодог байх ✓ Нам дотроо бие даасан, идэвхтэй, олонд | <p>танигдсан жендэрийн эрх тэгш байдлын механизм/байгууллага (эмэгтэйчүүдийн жигүүр, хэсэг г.м.)-тай болох, нам дотроо уг байгууллагад хүндэтгэлтэй ханддаг байх</p> <ul style="list-style-type: none"> ✓ Жендэрийн эрх тэгш байдлын механизм/байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар нам дотроо болон олон нийтэд чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулдаг байх ✓ Нам нь иргэний нийгмийн эмэгтэйчүүдийн ТББ, парламент, засгийн газрыг холбогч суваг болж ажилладаг байх ✓ Намын хөрөнгө нөөцийг эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдэд шударгаар хуваарилдаг байх ✓ Намын жендэрийн эрх тэгш байдлын механизм/байгууллага болон энэ чиглэлийн бодлого, хөтөлбөрт намын төсвөөс санхүүжилт хуваарилдах байх ✓ Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алийг нь жендэрээр ялгаварлан гадуурхсан, зүй бус харилцсан тухай асуудлыг намын анхааралд хүргэх гомдол шийдвэрлэх механизм, журамтай болсон байх <p><i>Эх сурвалж: Энэхүү гарын авлагад зориулж Соня Локарын бэлтгэсэн материалаас ашиглав.</i></p> |
|---|--|

83 See Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation, UNDP/NDI, 2011, p. 25, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-em-powerment/empower-women-political-parties.html>>.

→ **Жендэрийн асуудлаарх намын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах**

Жендэрийн аудит хийх нь эцсийн зорилго биш, харин жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор намын бодлого, стратеги, дүрэм журам, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаагаа сайжруулахад шаардагдах мэдээлэл олж авах арга зам юм. Хүйсээр ялгаварлан гадуурхах, гоочлон дарамтлахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр намын бодлого, ёс зүйн дүрэм боловсруулах эсвэл нэмэлт өөрчлөлт хийх, намын дүрэмд холбогдох өөрчлөлт хийх, намын эмэгтэй (эрэгтэй) гишүүдийн чадавхийг дээшлүүлэх арга хэмжээний санал боловсруулах, дараачийн сонгуульд өрсөлдөхөд шаардлагатай мэдээлэл олж авах зэрэгт жендэрийн аудитын дүнг ашиглаж болно.

Жендэрийн аудитаар илэрсэн дутагдалтай асуудлууд дээр тулгуурлан жендэрийн асуудлаарх намын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах боломжтой. Словенийн засгийн газар жендэрийн асуудлаарх намын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлахыг улс төрийн намуудаасаа шаардсан нэгэн чухал алхам хийсэн байдаг. Үүнийг Хавсралт 3-аас үзнэ үү. Намын төв байгууллагын хүрээнд жендэрийн аудит хийж, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болж болох ч намын анхан шатны байгууллага, салбарын түвшинд жендэрийн аудит хийвэл үйл ажиллагааны төлөвлөгөө нь нарийвчлалтай, оновчтой болно.

Жендэрийн аудит хийсэн ажлын хэсэг жендэрийн асуудлаарх намын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах нь хамгийн оновчтой болов уу. Уг төлөвлөгөөг боловсруулах явцдаа намын бүх гишүүдэд мэдээлэл өгч байх нь чухал. Түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг намын гишүүдэд танилцуулах нь уг төлөвлөгөөний талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлж, саналыг нь авах, мөн тэднээр хүлээн зөвшөөрүүлэхэд ач холбогдолтой. Төлөвлөгөөний төсөлд тусгагдсан саналыг танилцуулж, хэлэлцүүлэх зорилгоор ажлын хэсгээс фокус бүлгийн ярилцлага, зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж болно. Үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсаны дараа бүх шатны намын гишүүд түүнийг бүрэн дүүрэн ойлгож, зорилт, тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах нь зүйтэй. Хүснэгт 3.4-т жендэрийн асуудлаарх улс төрийн намын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж болох гол бүрдэл хэсгийг тайлбарын хамт орууллаа.

Хүснэгт 3.4. Жендэрийн асуудлаарх улс төрийн намын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах: үндсэн бүрэлдэхүүн

	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагаа
1	Намын дотоод дүрэм журамд жендэрийн аудит хийх	Намын гол үйл явц, практик, жендэрийн эрх тэгш байдлын асуудалтай холбоотой намын байр суурь, эрх мэдэл болон ажлын хуваарьт (намын гишүүдийн хүйсээр ангилж) өөрийн үнэлгээ буюу жендэрийн аудит хийх
2	Жендэрийн эрх тэгш байдлын асуудлаарх намын үйл ажиллагааны төлөвлөгөөг намын удирдлагаар дэмжүүлэх ажил зохион байгуулах	Жендэрийн аудитын дүнд тулгуурлан тухайн намын онцлогт тохирсон жендэрийн асуудлаарх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах <ul style="list-style-type: none"> • Намын гол байгууллагууд энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг наад тал нь дөрвөн жилд нэг удаа хэлэлцэж, гарсан ахиц дэвшлийг харгалзан үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчилж байхаар зөвшөөрсөн байх

3	Намын суурь баримт бичгүүдийг шинэчлэн сайжруулах	<ul style="list-style-type: none"> • Намын тогтолцоонд ялангуяа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг бий болгох доод хязгаарыг тусгасан заалтуудыг намын дүрэм зэрэг баримт бичигт оруулах • Хүйсээр ялгаварлан гадуурхах, гоочлон дарамтлахыг хориглосон намын дотоод ёс зүйн дүрэм юм уу бодлогыг бий болгох эсвэл шинэчлэн сайжруулах
4	Намын дүрмээр эмэгтэйчүүдийн байгууллага бий болгох	<ul style="list-style-type: none"> • Нам дотор эмэгтэйчүүдийн бие даасан байгууллага, нэгжийг байгуулах • Намын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн төлөөллийг бий болгох заалтыг намын дүрэмд оруулах
5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах намын механизм/ эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийг дэмждэг байх	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн байгууллага нь дагуулан сургах хөтөлбөр, mentorship programmes, сургалт, зөвлөлдөх уулзалт, нээлттэй хэлэлцүүлэг зэрэг тодорхой үйл ажиллагаа явуулах боломжтой байх • Дээрх үйл ажиллагааг явуулахад шаардагдах санхүүгийн дэмжлэг олгодог байх
6	Хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах	<ul style="list-style-type: none"> • Намын доод шатны байгууллагуудын мэдээллийг хамруулан гишүүнчлэлийн тоо баримтыг цуглуулж, хүйсээр ангилан, байнга шинэчилж байх
7	Намын дотоод үйл явцыг илүү ил тод, шударга болгох замаар намын дотоод ардчиллыг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Намд элсүүлэх, намын албан тушаал дэвшүүлэх, нэр дэвшигчийг сонгох, шийдвэр гаргах, хөрөнгө нөөц хуваарилах зэрэг дүрэм журмыг шинээр батлах буюу батлагдсан бол хэрэгжүүлэхдээ ойлгомжтой тодорхой, ил тод байдлаар, ардчиллын зарчимд нийцүүлэх талаар нөлөөллийн ажиллагаа явуулах • Намын дүрэм журмуудыг ойлгомжтой, жендэрийн мэдрэмжтэй байдлаар бичиж боловсруулах • Намд шинээр элссэн эрэгтэй, эмэгтэй бүх гишүүдэд үлс төрийн нам дах жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг багтаасан чиглүүлэх сургалт хийх ажлыг эхлүүлэх
8	Эмэгтэйчүүдийг намын удирдах албан тушаалд очих, нэр дэвшигч болохыг нь дэмжих намын дотоод арга хэмжээ зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> • Намын бүхий л бүтэц тогтолцоо, нөлөө бүхий албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг намын гишүүн эмэгтэйчүүдийн тоотой дүйцүүлэн алгуур нэмэгдүүлэх зорилгоор намын гүйцэтгэх дээд байгууллагын түвшинд ажлын төлөвлөгөө батлан гаргах • Намд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх үүднээс стандарт, зорилт, квот зэргийг сайн дурын үндсэн дээр тодорхой хугацаатай тогтоох
9	Сургалт, манлайллын үр чадвар хөгжүүлэх арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> • Намын эмэгтэй гишүүдэд зориулан тодорхой төрлийн сургалт бий болгох (манлайллын үр чадвар, эмэгтэй нэр дэвшигч бэлтгэх г.м.)
10	Намын гишүүдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн эрх тэгш байдлын асуудлаарх намын бодлогын талаар намын бүх гишүүдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх • Жендэрийн эрх тэгш байдлын зорилт, бодлоготой холбоотойгоор намын эрэгтэй, эмэгтэй бүхий л гишүүд, дэмжигчид, намыг төлөөлөн төрд ажиллаж байгаа албан тушаалтнуудын мэдлэг дээшлүүлэх семинар зохион байгуулах

11	Намын мөрийн хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар баримтлах байр суурийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой нэн тэргүүнд анхаарал хандуулах асуудлуудыг тодорхойлж, намын мөрийн хөтөлбөрт баримтлах байр суурийг томъёолох • Сөрөг хүчин болсон тохиолдолд тухайн нам /зөвхөн эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж бус/ мөрийн хөтөлбөрт тодорхойлсон асуудлыг төрийн бодлогод тусгуулах чиглэлээр нөлөөллийн аян зохион байгуулах; эрх барихаар сонгогдсон бол мөрийн хөтөлбөрт тодорхойлсон асуудлыг төрийн бодлогод тусгуулах ажлыг манлайлан, хэрэгжилтийг хангуулах
12	Намын гишүүд, гишүүнээр элсэх боломжтой хүмүүсийг намд элсүүлэх, албан тушаал дэвшүүлэхдээ жендэрийн эрх тэгш байдлын талаарх хүчин чармайлтыг нь харгалзах	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хүндэтгэн дэмжих хандлагыг намын гишүүнээр элсүүлэх нэг шалгуур болгох • Нам дотроо албан тушаал дэвших, шат ахих (намын удирдах албан тушаал, намын жагсаалтад оруулах, ялах магадлалтай тойрогт нэр дэвшүүлэх болон бусад эрх мэдэл, нөлөө бүхий үүрэг хариуцлагыг хуваарилах)-д эрэгтэй, эмэгтэй гишүүдийн аль алиных нь жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих үүрэг амлалт, амжилттай ажлын туршлагыг харгалзан үздэг болох

Эх сурвалж: Энэхүү гарын авлагад зориулж Соня Локар бэлтгэв.

Жендэрийн асуудлаарх намын үйл ажиллагааны төлөвлөгөөний дээрх загвар нь дараалал, агуулгын хувьд энэ бүлгийн үлдсэн хэсэгт толилуулах стратеги арга замуудтай зарим байдлаар үялдах болно.

→ **Намын шийдвэр гаргах байгууллагад байх эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаажуулсан дүрэм журам боловсруулах**

ЕАБХАБ-ын бүс нутгийн улс төрийн намууд гишүүн, удирдлагад буй эмэгтэйчүүдийн тоог тогтоосон судалгаа байдаггүй. Гэхдээ тус бүс нутгийн улс орнуудын намын гишүүдийн 40 хүрэхгүй хувь нь эмэгтэй, шийдвэр гаргах түвшин дэх төлөөлөл нь үүнээс ч доогуур гэсэн мэдээлэл бий. Зарим оронд намын удирдлагад буй эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдсэн байна. Тухайлбал, 2009 оны судалгаанд дурдсанаар, Испанид намын удирдах албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн эзлэх жин 31 хувь болж огцом өсчээ. 2008 оноос хойш Испанийн Социалист ажилчдын намын албан хаагчдын 50-иас илүү хувь нь эмэгтэй байна⁸⁴. Энэ нь намын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор нам дотроо болон гадаад орчинд хүчин чармайлт гаргаж ажилласан жендэрийн тэгш байдлын төлөө тэмцэгчдийн ажлын үр дүн юм (Шигтгээ 3.15-ийг үзнэ үү).

Шигтгээ 3.5. Намын шийдвэр гаргах байгууллага дах эмэгтэйчүүдийн төлөөлөл

ЕАБХАБ-ын оролцогч улс орнуудын улс төрийн намууд намынхаа дүрэмд намын шийдвэр гаргах байгууллагад байх эмэгтэйчүүдийн төлөөллийн доод хэмжээг баталгаажуулан зааж өгөх, эсвэл эмэгтэйчүүдийн төлөөлөл орох ёстой албан тушаалыг зааж өгдөг жишиг бий. Тухайлбал,

Их Британий Хөдөлмөрийн намын Үндэсний гүйцэтгэх хороо: Тус хороонд орох Парламентын гишүүн/сайд 3 хүний наад зах нь нэг нь эмэгтэй байх ёстой.

Германы Христийн ардчилсан холбоо: Намын албан тушаалд 33 хувийн квот мөрддөг, энэ тоонд хүрэхгүй бол дахин дотоод сонгууль явуулдаг.

Германы Ногоон нам: Хос удирдлага: Намын ерөнхийлөгчийн албан тушаалын эрэгтэй, эмэгтэй хоёр хүн хамтран хашдаг.

Эх сурвалж: Намын дүрмийн бүрэн жагсаалтыг Ном зүйгээс харна уу.

84 Soledad Ruiz Seguin and Marta Plaza, "Gender Equality Policies in Spain: The commitment of social democracy", Queries. See: http://213.192.236.136/sites/default/files/marta_plaza_genero_feps.pdf

Шигтгээ 3.6. Намын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл

Намын шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг баталгаажуулсан заалтыг намын дүрэм, суурь баримт бичигт тусгадаг жишиг бий.

Канад: Онтариогийн Либерал нам: Жилийн ерөнхий чуулганд оролцох эмэгтэй, эрэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг заасан байдаг (Тойргийн холбооны 18 гишүүнээс наад зах нь дөрвөн эрэгтэй, дөрвөн эмэгтэй байх ёстой).

Их Британий Хөдөлмөрийн нам: Намын бага хурал, Жилийн ерөнхий чуулганд орох төлөөлөгчдийн жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

АНУ-ын Ардчилсан нам: “Үндэсний чуулганд оролцох эрэгтэй, эмэгтэйчүүдийн төлөөлөл тэгш хангагдсан байх ёстой.”

АНУ-ын Бүгд найрамдах нам: “Муж бүр Бүгд Найрамдахчуудын Үндэсний чуулганд орох төлөөлөгчид нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш төлөөллийг хангасан байх арга хэмжээг авах ёстой.”

Эх сурвалж: Улс төрийн намын дүрмийн жагсаалтыг Ном зүйгээс харна уу.

Харин 2011 онд хийсэн судалгаагаар улс төрийн чиг баримжаанаас үл хамааран Гүржийн томоохон бүх намын гишүүдийн 40 хувь нь эмэгтэй байна. Тухайлбал, Гүржийн зам болон Хөдөлмөрийн намуудад гишүүдийн 60 ба 70 хувийг тус тус эмэгтэйчүүд эзэлж байв. Гэвч намын шийдвэр гаргах бүтцэд эмэгтэйчүүдийн төлөөлөл 10 хүрэхгүй хувиас 30 хүртэл хувийн хооронд хэлбэлзэж байжээ. Хөдөлмөрийн намын гишүүдийн бараг 60 хувь нь эмэгтэй боловч шийдвэр гаргах түвшний төлөөлөл нь 20 хүрэхгүй хувь байв⁸⁵.

Иймээс улс төрийн намын удирдлагууд намынхаа **шийдвэр гаргах байгууллагад** байх эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаажуулан нарийвчилсан журам батлах асуудлыг бодолцож үзэх нь зүйтэй. Тухайлбал, Их Британий Хөдөлмөрийн намын дүрэмд намын Үндэсний гүйцэтгэх хорооны бүрэлдэхүүнд байх эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаажуулсан заалт бий (Шигтгээ 3.5-ыг үзнэ үү)⁸⁶.

Түүнчлэн намын **удирдах бүрэлдэхүүнд** төлөөллийг хангах үүднээс намын дотоод бүтэц дэх жендэрийн эрх тэгш байдлыг зохицуулсан дүрэм гаргаж болно. Жишээ нь, Германы Ногоон нам “хос удирдлага” буюу эрэгтэй, эмэгтэй хоёр ерөнхийлөгч намаа хамтран удирдах журамтай. Энэ нь Ногоон намаас шударга ёс, эрх тэгш байдал зэрэг үнэт зүйлсээ дээдлэн хэрэгжүүлж байгаагийн илэрхийлэл юм. Гол чухал **хороод, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд** эмэгтэй гишүүд байх ёстой тухай заасан жендэрийн эрх тэгш байдлын зохицуулалт бүхий намууд ч бий. Тухайлбал, 1996 онд Германы Христосын ардчилсан холбоо намын албан тушаалын 33

хувийг эмэгтэйчүүдэд өгөх квот тогтоосон. Хэрэв энэ квотод хүрэхгүй бол нам дотроо дахин сонгууль явуулдаг аж⁸⁷. Молдавын Либерал ардчилсан нам, Социал демократ намын хувьд бүх шатны удирдах бүрэлдэхүүний 30 хувь нь эмэгтэй байхыг дэмждэг.

Намын дотоод шийдвэр гаргах байгууллага дах эмэгтэйчүүдийн төлөөллийн хувь нь сонгуульт албан тушаалд намаас нэр дэвших эмэгтэйчүүдийн тоонд дам байдлаар нөлөөлдөг⁸⁸. Тийм учраас жендэрийн эрх тэгш байдлын талаар тусгайлан зохицуулсан

85 Tamar Bagratia, Medea Badashvili, David Jijelava and Irakli Khmaladze, “Developing intra-party democracy from a gender perspective”, in Intra-party democracy and local governance (Tbilisi: NIMD Georgia), 2012, p. 12.

86 “Labour Party Rule Book”, 2010, <<http://www.leftfutures.org/wp-content/uploads/2011/02/Labour-Party-Rule-Book-2010.pdf>>. The resources and examples referenced in this handbook are included owing to their value as effective good practices for the promotion of women’s participation in political parties. As such, their inclusion in no way represents an endorsement of or agreement with the policy agendas or political platforms of the organizations, platforms and political parties that produced them.

87 “Voluntary Political Party Quotas for Europe”, Global Database of Quotas for Women, Quota Project, <<http://www.quotaproject.org/systemParty.cfm?region=50>>.

88 Miki Kittilson, Challenging parties, changing parliaments: Women and elected office in contemporary Western Europe (Columbus: Ohio State University Press, 2006); Mona Lena Krook, Joni Lovenduski and Judith Squires, “Gender Quotas and Models of Political Citizenship”, British Journal of Political Science, Vol. 39, No. 4, 2009, pp. 781–803.

эдгээр дүрэм журам нь тухайн намын жендэрийн стратеги эсвэл намын мөрийн хөтөлбөрт тусгасан жендэрийн асуудлаас урган гарсан байж болно, эсвэл түүнд үндэслэсэн байж болно.

→ Шийдвэр гаргах үйл явцад оролцох эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаажуулсан дүрэм журам нэвтрүүлэх

Намын удирдлагын зүгээс шийдвэр гаргах *байгууллагад* эмэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг баталгаажуулсан зүйл заалтаас гадна намын их хурал, бага хурал, жилийн ерөнхий хурал зэрэг шийдвэр гаргах *үйл явц, ажиллагаанд* эмэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг баталгаажуулсан зүйл заалт нэвтрүүлж болно (Шигтгээ 3.6). Жишээ нь, намын чуулганд орох төлөөлөгчдийг муж улсын буюу тойргийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны харьцааг баримтлан нэр дэвшүүлэх журмыг АНУ-ын Техас муж улсын Ардчилсан намын Гүйцэтгэх хороо дүрэмдээ заажээ⁸⁹. Мөн АНУ-ын Ардчилсан Нам Үндэсний чуулганд оролцуулахаар сонгосон төлөөлөгчид нь жендэрийн хувьд тэнцвэртэй байхыг шаарддаг бол Бүгд найрамдах нам муж улсуудын төлөөлөгчдийг жендэрийн хувьд тэнцвэртэй байдлаар нэр дэвшүүлэхийг хөхиүлэн дэмждэг⁹⁰. Их Британий Хөдөлмөрийн намын дүрэмд намын бага хуралд оролцуулах “төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд наад зах нь тухайн шатны намын байгууллагад эмэгтэйчүүдийн эзлэх хувьтай тэнцүү тооны эмэгтэйг сонгох шаардлага” тавьсан байдаг⁹¹.

Жилийн ерөнхий чуулганд оролцох төлөөлөгчдийн хувьд Канадын Либерал нам (Онтарио дах) тойргийн холбоо бүрээс эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн төлөөллийн доод хязгаарыг хангасан саналын эрхтэй төлөөлөгч сонгон явуулахыг шаарддаг. Эдгээр 18 гишүүний наад зах нь дөрөв нь эрэгтэй, дөрөв нь эмэгтэй, дөрөв нь 25-аас доош настай байх ёстой⁹². Их Британий Хөдөлмөрийн намын хувьд ч ялгаагүй Жилийн ерөнхий чуулганд оролцох “төлөөлөгчдийн 50 хувь нь эмэгтэй байх, ганц төлөөлөгч томилох боломжтой газарт жил бүр эрэгтэй, эмэгтэй хүйсээр ээлжлэн төлөөлөгч илгээх арга хэмжээ авна”⁹³.

→ Намын ёс зүйн дүрэм нэвтрүүлэх, сайжруулах, түүнд жендэрийн асуудлыг тусгах

Улс төрийн намууд дотооддоо мөрдөх ёс зүйн дүрэм боловсруулан гаргах, сайжруулан шинэчлэх, түүнд жендэрийн асуудлыг тусгах замаар эмэгтэйчүүдийн тухайн намд гүйцэтгэх үүрэг оролцоог бататгах боломжтой. Намын ёс зүйн дүрэм нь парламентын ёс зүйн дүрэмд байхгүй зүйлийг нөхөж, нам дотроо, парламент буюу бусад төрийн сонгуульд албан тушаалын хүрээнд болон олон нийтийн өмнө улс төрийн мэтгэлцээнд баримталбал зохих харилцааны наад захын хэм хэмжээ, бусдыг хүндэтгэх шаардлага тавих замаар улс төр дэх мэргэжсэн байдлыг нэмэгдүүлдэг⁹⁴.

ЕАБХАБ-ын бүс нутгийн зарим парламентад эмэгтэй гишүүдийг хэл амаар доромжлох, гутаах, басамжлах явдал олонтаа тохиолддог нь жендэрийн эрх тэгш байдлын зарчимд нийцсэн харилцааны хэм хэмжээг тодорхой тусгасан ёс зүйн дүрэм шаардлагатай

89 “The Rules of the Texas Democratic Party. State Democratic Executive Committee”, Texas Democratic Party, 2012, <<http://www.txdemocrats.org/wp-content/uploads/2012/2010-2012-TDP-Rules.pdf>>.

90 “Democratic Party Charter”, Democratic Party, amended 2002, <<http://www.democrats.org/pdfs/charter.pdf>> and “Republican National Committee”, Republican Party, <<http://www.gop.com/About/default.aspx?Section=32>>

91 “The Labour Party Rule Book 2010”, 2010, <<http://www.leftfutures.org/wp-content/uploads/2011/02/Labour-Party-Rule-Book-2010.pdf>>.

92 “Rules of Procedure for the Liberal Party of Canada (Ontario) and its Constituent Bodies”, Liberal Party of Canada, 2012, <<https://ontario.liberal.ca/files/2010/06/Rules-of-Procedure-2011-ENGLISH.pdf>>.

93 “The Labour Party Rule Book 2010”, 2010, <<http://www.leftfutures.org/wp-content/uploads/2011/02/Labour-Party-Rule-Book-2010.pdf>>.

94 Luc van den Brande, “The code of good practice for political parties”, Council of Europe, Parliamentary Assembly, No. 11210, 29 March 2007, <<http://assembly.coe.int/Main.asp?link=/Documents/WorkingDocs/Doc07/EDOC11210.htm>>.

байгааг харуулж байгаа юм (Шигтгээ 3.7-г үзнэ үү). 2011 онд Австрийн парламентын нэг гишүүн хэвлэл мэдээллээр мэдээлсэн хүчингийн гэмт хэрэгтэй холбогдуулан хошин шүлгийн мөрт хэлснийг нь парламентын олон гишүүн, ялангуяа эмэгтэйчүүд гутаан доромжилсон явдал гэж үзжээ. Харамсалтай нь, парламентын дүрэмд нь ийм тохиолдолд дэг журам сахиулах эсвэл уучлал гуйхыг тушаах заалт байхгүй аж⁹⁵.

2011 оны 4 дүгээр сард Их Британий Ерөнхий сайд Сангийн ерөнхий нарийн бичгийн даргад сөрөг хүчнээс хяналт тавьж ажилладаг парламентын эмэгтэй гишүүний хэлсэн саналын хариуд “тайвшир, хонгор минь” гэж хоёр удаа, “тайвшир” гэж дахин таван удаа хэлжээ⁹⁶. Ингэж хэлснийхээ төлөө Ерөнхий сайд албан ёсны сахилгын арга хэмжээ хүртээгүй боловч уучлалт гуйсан байна⁹⁷. Өөр нэг парламентын эмэгтэй гишүүний талаар Ерөнхий сайд “тэр сэтгэлээр унасан байх л даа” гэж, мөн бас нэг эмэгтэй гишүүнд хандан дорд үзсэн байдлаар “хонгор минь” гэж хэлсэн гэдэг⁹⁸.

Олон нийтийн нүдэнд ил байдаг парламентын хуралдаан дээр ийм тохиолдлууд гарч байгаа юм чинь хаалттай хаалганы цаана байдаг улс төрийн намын хүрээнд бүр юу болж байдаг бол гэсэн асуулт гарах нь гарцаагүй. Иймээс жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тэргүүн шугамд явж байдаг улс төрийн намын удирдлагууд ялгаварлан гадуурхсан, хүйсээр доромжилсон үг хэллэгийг хориглож, зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх хүчин чадалтай намын ёс зүйн дүрэм батлах асуудлыг бодолцох нь зүйтэй.

Шигтгээ 3.7: ЕАБХАБ-ын бүс нутгийн улс орнуудын парламентад хүйсээр ялгаварласан хандлагатай үг хэллэг хэрэглэсэн жишээ

2011 оны 11 дүгээр сард Грекийн парламентын нэгэн бүлгийн хуралдааны үеэр парламентын эмэгтэй гишүүн үг хэлэх боломж олгосонгүй гэж эсэргүүцэл илэрхийлжээ. Үүний хариуд нэгэн дэд сайд “Хөөе татуурга зүүсэн хүн гуай тайвширч үз” гэжээ. Энэ талаар Грекийн хэвлэлд нийтлэхдээ “өөр хэн нэг нь парламентын тэр эмэгтэй гишүүнийг хажуугаар зөрөхөд нь “Энэ [хүйсээр ялгаварласан зүйрлэл] хаачих нь вэ? Ичдэггүй юм байх даа? Бид энийг парламентын гишүүн болгосон. Гэтэл одоо миний байр суурь энээ тэрээ гээд юу яриад байнаа?” гэх мэтээр хэлсэн гэжээ.

2011 оны 12 дугаар сард Унгарын парламентын нэг гишүүн АТВ гэх тус улсын телевизийн сувгаар ярилцлага өгөхдөө парламентын эрэгтэй гишүүд эмэгтэй гишүүдийг дорд үзсэн, хүйсээр ялгаварласан үг хэллэг хэрэглэх нь элбэг тохиолддог гэжээ. Тухайлбал, “хувцсаа тайч”, “[хүйсээр ялгаварласан зүйрлэл] минь, амаа хамхи”, “харьж хүүхдээ асар” гэх зэргээр хэлдэг гэжээ. 2012 оны 11 дүгээр сард Молдавын парламентын дарга нэгэн эмэгтэй гишүүнд хандаж “гоё харгаддаг шигээ бас ухаантай байхыг хичээ” гэсэн байна.

Эх сурвалж: “The fall of Papandreu: sexist remarks in the parliamentary lobbies”, GR Reporter, 4 November 2011, <http://www.grreporter.info/en/fall_papandreu_sexist_remarks_parliamentary_lobbies/5384>; “MP claims sexism rampant in Hungarian Parliament”, Politics.Hu, 7 December 2011, <<http://www.politics.hu/20111207/male-policians-shout-sexist-obsenities-at-female-peers-in-parliament-says-one-mp/>>; and “Lupu către Şpac: Pe lângă faptul că sunteți simpatică, mai fiți, vă rog, și deşteaptă”, Publika.md, November 2012, <http://www.publika.md/lupu-catre-supac-pe-langa-faptul-ca-sunteți-simpatică-mai-fiti-vă-roგ-si-deşteaptă_1104161.html>.

95 For Austrian press coverage of this incident, see: <<http://derstandard.at/1304552182958/Grossruck-sorgt-mit-Strauss-Kahn-Reim-fuer-Empoerung>>; and <<http://www.oe24.at/oesterreich/politik/Aufregung-wegen-Sex-Sager-Eklat-um-VP-Politiker-im-Parlament/28082443>>.

96 “David Cameron’s ‘calm down dear’ outburst in Commons exposes flaws”, The Guardian, 27 April 2011, <<http://www.theguardian.com/politics/wintour-and-watt/2011/apr/27/davidcameron-michael-winner>>.

97 “David Cameron says sorry for comments to female MPs”, The Guardian, 2 October 2011, <<http://www.guardian.co.uk/politics/2011/oct/02/david-cameron-sorry-female-mps>>.

98 “David Cameron says sorry to ‘frustrated’ Nadine Dorries”, BBC News website, 8 September 2011, <<http://www.bbc.co.uk/news/uk-politics-14834867>>.

→ **Намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж, жендэрийн эрх тэгш байдлын асуудал хариуцсан бусад нэгжийг намын бүтцэд бий болгох, үүрэг оролцоог нь дэмжих**

Эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг хангах, жендэрийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх зорилгоор намын дүрэм, журам, арга замаа өөрчлөхөд шаардагдах мэдлэг туршлага, хөрөнгө нөөц, цаг хугацаа намын удирдлагуудад тэр бүр байдаггүй. Жендэрийн асуудлаар намын гишүүдэд байгаа мэдлэг туршлагыг (хэрэв байгаа бол) ашиглах үр ашигтай, үр дүнтэй нэг арга бол нам дотроо эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж байгуулах, түүнд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Намын удирдлагаас намын дүрэм, бусад суурь баримт бичигтээ зааж тусгах замаар эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж байгуулж болно. Намын эмэгтэйчүүдийн байгууллага буюу жигүүр нь тухайн улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх зорилгоор байгуулагддаг дотоод бүтцийн нэгж юм. Энэ нь анхаарал татсан асуудлуудыг гишүүдэд сурталчлан таниулах замаар эмэгтэйчүүдийн улс төрийн ахиц дэвшилд хувь нэмэр оруулах, эмэгтэйчүүдийн манлайллыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гишүүн элсүүлэх, нэр дэвшигч сонгоход туслалцаа үзүүлэх, төрийн албан тушаалд өрсөлдөж байгаа эмэгтэйчүүдэд тус дэм үзүүлэх зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг.

Түүнчлэн жендэрт ээлтэй бодлого, практик нэвтрүүлэх, жендэрийн аудит, үнэлгээ хийхэд намын удирдлагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажилд намын эмэгтэйчүүдийн байгууллагыг татан оролцуулж болно. Мөн томоохон асуудлаар намын байр суурь, нийтэд түгээх санааг боловсруулахад шаардлагатай хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах, эмэгтэй сонгогчдын хувьд ач холбогдолтой асуудлаар судалгаа хийх, тэдний дэмжлэгийг авч чадахуйц мөрийн хөтөлбөр боловсруулахад намын удирдлагад тусалж хувь нэмрээ оруулж байдаг.

Намын эмэгтэйчүүдийн байгууллага бүр дээр дурдсан ажлыг хийх мэдлэг, туршлагатай гэж үзэж болохгүй. Түүнчлэн намын баримт бичигт эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийг албан ёсоор баталгаалж байгуулаагүй, байгуулсан ч үйл ажиллагааг нь намын удирдлага дэмждэггүй, санхүүжилт олгодоггүй бол эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийг үл ойшооход хялбархан байх болно. Эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж намын удирдлагаас дуртай дургүй байгуулсан хоосон тогтолцоо байх уу эсвэл намын удирдлагадаа дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийг улс төрд ахиж дэвшихэд нь туслалцаа үзүүлдэг үр дүнтэй, идэвхтэй, жинхэнэ байгууллага байх уу гэдэг нь тэдгээрийн бүтэц, бие даасан байдал, зорилго, санхүүжилтийг намын дүрэм журамд тусгасан байдал, намын удирдлагын дэмжлэгээс шууд хамааралтай.

Тиймээс намын удирдлагын тогтолцоонд эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийг албан ёсоор оруулах нь хамгийн үр дүнтэй. Жишээ нь, Сербийн “Ж17+” гэдэг намын баримт бичигт намын эмэгтэйчүүдийн байгууллагыг албан ёсын бүтцийн нэгж болгон заасан байдаг⁹⁹. Намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн зорилго нь зөвхөн “эмэгтэйчүүдийн” буюу жендэрийн асуудлаар хязгаарлагдах ёсгүй бөгөөд эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн гишүүд бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэх боломжтой байх ёстой. Түүнчлэн намын эмэгтэйчүүдийн байгууллагын шийдвэр, саналыг намын удирдлагад хүргэх, намын удирдлагын хариуг буцааж илгээх харилцааны суваг маш тодорхой байх нь зүйтэй.

Намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийг зөвхөн “эмэгтэйчүүдийн асуудал”-тай холбож хардаг хандлагыг арилгахын тулд намыг илүү жендэрийн мэдрэмжтэй болгох

99 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation, UNDP/NDI, 2011, p.18, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/em-power-women-political-parties.html>>.

үүднээс эрэгтэй, эмэгтэй аль ч гишүүдийг татан оролцуулах зорилготой жендэрийн эрх тэгш байдлын асуудал хариуцсан хэлтэс, механизм байгуулж болно. Тухайлбал, Испанийн Социалист ажилчдын нам жендэрийн эрх тэгш байдлын бодлого хариуцсан алба байгуулсан бөгөөд уг алба нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар нам дотроо ахиц дэвшил гаргахад анхаарч ажилладаг. Тус албанаас энэ зорилгоор цахим хуудас ажиллуулж, түүнд жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл зэрэг тодорхой сэдвээр мэдээлэл өгөхөөс гадна энэ чиглэлээр болох үйл явдал, нийтийн арга хэмжээний талаар мэдээлж, намаас гаргаж буй мэдэгдлийг байршуулж, тогтмол шинэчилж ажилладаг. Түүнчлэн YouTube дээр зохион байгуулсан арга хэмжээний клип оруулах, Twitter, Facebook and Reddit-ээр мэдээллийг шуурхай дамжуулах зэргээр олон нийтийн сүлжээг мөн идэвхтэй ашигладаг¹⁰⁰. Izquierda Unida буюу Нэгдсэн зүүн нам цахим хуудсандаа “Эмэгтэйчүүдийн булан” нээсэн бөгөөд эмэгтэй гишүүд, нэр дэвшигчдийг чадавхжуулах талаар намаас хийж буй ажлаа тогтмол мэдээлдэг. Popular Party буюу Нийтийн нам ч мөн цахим хуудас ажиллуулж байсан үе бий¹⁰¹.

→ Шийдвэр гаргах байгууллага, үйл явцад эмэгтэйчүүдийн нэгж, байгууллагын төлөөллийг хангах

Намын удирдлагаас намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж байгуулах асуудлыг намын дүрэмд тусгуулж, чиг үүргийг нь тодорхой болгож өгөх замаар тус дэм үзүүлэх боломжтой талаар дээр өгүүлсэн билээ. Гэхдээ ингэснээр эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж нь намын бодлого, практикт шүүд томоохон өөрчлөлт хийх, намын удирдах ажилд гол үүрэг гүйцэтгэх эрх мэдэл, чадвартай болчихно гэсэн үг биш юм.

Эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийг шийдвэр гаргах байгууллага, үйл явцад оролцуулах нь тэднийг үл ойшоох, гадуурхахаас сэргийлэх нэг арга юм. Намын дүрэмдээ зааж өгөх замаар эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн төлөөллийг намын бүх шатны удирдах байгууллага, нэр дэвшүүлэх хороод, намын бодлого, хөтөлбөр, дүрэм журам болон сонгуулийн сурталчилгааны ажлын стратеги боловсруулах бүтцүүд, намын санхүүгийн удирдлага, захиргааг хэрэгжүүлэх болон гишүүн элсүүлэх үйл явцад оролцуулах боломжтой.

Шийдвэр гаргах *байгууллагад* оролцуулах зохицуулалтын хувьд АНУ-ын Виржиниа мужийн Ардчилсан намын төв хорооны гишүүнд Виржиниагийн Ардчилсан эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч орохоор заасан байдаг¹⁰².

Шигтгээ 3.8. Намын дүрэмд эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн төлөөллийг тусгах

Намын шийдвэр гаргах үйл явц, үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн байгууллагын (хэрэв байдаг бол) төлөөллийг оролцуулах талаар намын дүрэмд тусгайлсан зүйл заалт оруулж болох юм.

АНУ-ын Виржиниа муж улсын Ардчилсан намын төв хороо:

Виржиниагийн Ардчилсан Эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нар нь Муж улсын Ардчилсан намын төв хорооны гишүүн байхаар заасан байдаг.

Канадын (Онтарио дах) Либерал нам:

Эмэгтэйчүүдийн Либерал Клуб эсвэл Холбооны ерөнхийлөгч нь Тойргийн Холбооны гүйцэтгэх хорооны гишүүн байхаар заасан байдаг.

Шведийн Социал демократ нам:

Социал демократ Эмэгтэйчүүдийн Үндэсний холбооны төлөөллийн Намын үндэсний бага хуралд оролцох, Бага хуралд хандаж үг хэлэх, санал дэвшүүлэх эрхийг баталгаажуулсан байдаг.

Эх сурвалж: Намуудын дүрмийн талаар Ном зүйгээс үзнэ үү.

100 See: <<http://www.psoe.es/ambito/igualdad/news/index.do>>. Site available in Spanish only.

101 See: <<http://www.izquierda-unida.es/taxonomy/term/70>>. Site available in Spanish only.

102 Virginia Democratic Party Plan, December 2010, p.7, <http://www.leedems.org/wp-content/files/DPVA_Party_Plan_re

Канадад Эмэгтэйчүүдийн либерал клуб эсвэл Холбооны ерөнхийлөгч нь Тойргийн холбооны (Constituency Association) Гүйцэтгэх хорооны гишүүн байхаар заасан¹⁰³. Харин Шведийн Социал демократ эмэгтэйчүүдийн үндэсний холбооны дарга нь Гүйцэтгэх хорооны хуралд оролцож, үг хэлэх, санал дэвшүүлэх эрхтэй аж.

Зарим намын дүрэмд намын эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөллийг шийдвэр гаргах *үйл явцад* оролцуулах ёстой гэж заасан байдаг. Тухайлбал, Шведийн Социал демократ намын дүрэмд Социал демократ эмэгтэйчүүдийн үндэсний холбооны дор хаяж нэг төлөөлөгчийг үг хэлэх, санал дэвшүүлэх эрхтэйгээр Намын Үндэсний бага хуралд оролцуулах шаардлага тавьсан байдаг¹⁰⁴.

Шигтгээ 3.9. Жендэрт ээлтэй намуудын дүрмээс

Намын баримтлах Зарчмын тухай тунхаглалдаа жендэрийн эрх тэгш байдлыг дурдсан нь

Энэхүү дүрэм болон ОХУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн ОХУ-ын иргэн, тус намын гишүүн олон үндэстний эрэгтэй, эмэгтэйчүүдэд намын удирдах байгууллага, төрийн төв болон орон нутгийн сонгуульд албан тушаалд өрсөлдөх нэрийн жагсаалтад орох тэгш боломж олгоно (*ОХУ-ын Шударга Орос намын дүрмээс авав*).

Жендэрийн эрх тэгш байдлыг намын дотоод ардчиллын үндсэн зарчмын нэг болгон нэвтрүүлэх нь Намын удирдах болон гүйцэтгэх бүх шатанд эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш төлөөллийг бий болгохын төлөө ажиллана. Чуулганы төлөөлөгчөөр сонгохоор нэр дэвшүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих ба намын дотоод бүтцэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш төлөөллийг хангах зорилго тавьж байна (*Италийн Ардчилсан намын дүрмээс авав*).

Намын шийдвэр гаргах байгууллагын бүрэлдэхүүнд жендэрийн тэнцвэрт байдлыг нэмэгдүүлэх, намын шийдвэр гаргах дээд байгууллага (Чуулган, Бага хурал г.м.) дах төлөөллийг тэнцвэржүүлэх:

Бүх шатны төлөөлөгч, нэр дэвшигчийг сонгохдоо Нэр дэвшүүлэх хороо болон Чуулган өөрөө тухайн дүүрэг буюу муж улсын [...] эмэгтэйчүүдийн тооны харьцааг [...] нийт төлөөлөгчдийн тоонд үндэслэлтэйгээр тусгах бүхий л хүчин чармайлтыг гаргана. Аль ч түвшинд сонгогдсон төлөөлөгчдийн наад зах нь 1/3 нь өөр хүйсийн төлөөлөл байна. (*АНУ-ын Ардчилсан намын дүрмээс авав*).

Жендэрийн хувьд төвийг сахисан үг хэллэг хэрэглэх

Тухайлбал, дарга гэдэг үгийг хэрэглэхдээ эрэгтэй хүйсийг илэрхийлсэн үг ашиглахгүй байх, өөрөөр хэлбэл, “Chairman” бус “Chairperson” гэх эсвэл даргалагчийн хүйстэй дүйх үгийг сонгож хэрэглэх “Committeeman” юм үү “Committeewoman” г.м. (*АНУ-ын Бүгд Найрамдах Намын дүрмээс авав*).

→ Жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих талаар намын фракц, бүлгүүдийн хооронд эрүүл өрсөлдөөн бий болгох

Тодорхой бодлого, улс төрийн асуудлаар үзэл санаа нэгдсэн гишүүд нам дотроо фракц, бүлэг, хэсэг байгуулах явдал ЕАБХАБ-ын бүс нутгийн улс төрийн олон намд тохиолддог. Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг улс төрийн шат ахиулах асуудлаар намын фракц буюу бүлгүүдийн хооронд үзэл бодлын эрүүл өрсөлдөөн бий болгоход намын удирдлага, жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид тодорхой нөлөө үзүүлэх

vised_December_4_2010.pdf>.

103 “Constitution of the Liberal Party of Canada (Ontario)”, amended January 2012, <<http://ontario.liberal.ca/governance/>>.

104 “The Constitution of the Swedish Social Democratic Party”, Swedish Social Democratic Party, 2001, <http://www.socialdemokraterna.se/upload/Internationellt/Other%20Languages/SAPconstitution_eng.pdf>.

боломжтой. Мөн өөр өөр түвшин, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй намын салбар, үүрүүдийн хооронд ч ийм өрсөлдөөн бий болгож болно. Тухайлбал, өөрийн хариуцсан орон нутагт жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих стратеги боловсруулах уралдааныг намын салбар нэгжүүдийн дунд зарлаж болно.

Түүнчлэн жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор намд хамаарах нийгэмлэг, бүлгэмүүдийн (эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжээс бусад) дэмжлэг туслалцааг ч авах боломж бий. Тухайлбал, Их Британий Хөдөлмөрийн намд харьяалагдах Фабиан нийгэмлэгт Хөдөлмөрийн намаас сонгогдсон эмэгтэй гишүүд нэлээд хэд байдаг бөгөөд тэд нам дотроо жендэрийн тэгш байдлыг сайжруулах талаар намын удирдлагаас гаргасан шинэчлэлийн санаачилгыг дэмжих нь дамжиггүй. Фабиан эмэгтэйчүүдийн сүлжээ нь эмэгтэйчүүдийг улс төрийн хувьд шат ахиулах үйл ажиллагааг идэвхтэй дэмждэг төдийгүй Хөдөлмөрийн намын жил тутмын хурлын үеэр сургалт сурталчилгаа, чадавх дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг. Мөн энэ сүлжээ нь нийтлэг сонирхол хөндсөн тодорхой асуудлаар Хөдөлмөрийн нам дах бусад фракц, бүлэгтэй харилцаа, хамтын ажиллагаатай байдаг нь чухал ач холбогдолтой. Жишээ нь, эдийн засгийн хөгжлийн асуудлаар Хөдөлмөрийн санхүү, аж үйлдвэрийн бүлэгтэй, эхийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар Залуу Фабианчуудын эрүүл мэндийн сүлжээтэй хамтран ажилладаг байна¹⁰⁵.

Зарим фракц намын удирдлагатай өрсөлдөх, тэмцэх зорилгоор байгуулагддаг тул намын түршлага, дадлагатай бүлгүүдтэй үр дүнтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх нь нам доторх дэмжлэгээ бэхжүүлэх чухал арга юм.

3.1.2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг сайн дурын үндсэн дээр авч хэрэгжүүлэх нь

Өмнөх хэсэгт намын дүрэм, суурь баримт бичгийг жендэрийн үүднээс хэрхэн сайжруулж шинэчлэх арга замын талаар өгүүлсэн. Түүнчлэн эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж зэрэг намд дэмжлэг болох бүтцийн нэгжийн талаар авч үзсэн билээ. Мөн эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор намын дүрэм журамд ямар зүйл заалт тусгах, хүйсээр ялгаварлан гадуурхсан зүйл заалт, практикийг арилгах үүднээс намын удирдлага ямар арга хэмжээ авч болох талаар тодорхой мэдээлэл өгсөн.

Гэвч эмэгтэйчүүд улс төрийн шат ахихад тулгарч байгаа бэрхшээл намын албан ёсны баримт бичигт тэдний оролцоог дэмжсэн арга хэмжээ тусгагдаагүй байх, төлөөллийг нь намын тодорхой байгууллага, нэгж болгож зохион байгуулаагүй байх зэргээр хязгаарлагдахгүй юм. ЕАБХАБ-ын бүс нутагт ажиллаж буй улс төрч эмэгтэйчүүд хөрөнгө нөөц, мэдээлэл, сонгуулийн сурталчилгааны ажлын хэрэгслээр дутагдсан хэвээр байна. Энэ нь эрэгтэйчүүд улс төрийн салбарт эрт орж, илүү бололцоотой болсонтой холбоотой бөгөөд тус бүс нутгийн парламентуудад эрэгтэйчүүдийн төлөөлөл эмэгтэйчүүдийнхээс эрс илүү байна. Мөн парламентын болон намын шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд давамгайл хэвээр байна. Учир нь санхүүгийн нөөц бололцоонд хүрч, санхүүжүүлэгч олох боломжтой мэргэжлийн холбоо, бизнес клуб, сүлжээ, спорт клубын үүд хаалга эрт дээр үеэс эрэгтэйчүүдэд л нээлттэй байсаар ирсэн. Ийм давуу байдлын улмаас улс төрийг “эрчүүдийн бизнес”, “ахимаг насны эрчүүдийн клуб” гэж нэрлэх нь бий¹⁰⁶.

105 See: <<http://www.fabianwomen.co.uk/2013/08/fabian-womens-network-at-labour-party-conference-2013/>>.

106 Petr Kopecky and Maria Spirova, “Jobs for the Boys? Patterns of Party Patronage in post-communist Europe”, *West European Politics*, Vol. 34, No. 4, pp. 897–921.

Намд гишүүн элсүүлэх, нэр дэвшигч сонгох, манлайлал хөгжүүлэх, чадавх дээшлүүлэх, санхүүжилт олох, хөрөнгө нөөц хуваарилах зэрэг намын гол үйл явцад эмэгтэйчүүдийг үр дүнтэй байдлаар дэмжин туслахад ашиглаж болох арга замыг гарын авлагын энэ хэсэгт толилуулна. Үүний тулд нам хичнээн эмэгтэй гишүүнтэй, тэд ямар түвшинд ажилладаг, ямар үр чадвартай вэ гэдгийг юуны өмнө тодорхойлох нь зүйтэй.

→ Намын эмэгтэй гишүүдийг таньж мэдэх нь

Ихэнх нам гишүүдийн бүртгэл, мэдээллийн сантай байдаг ч хичнээн нь эмэгтэй, аль салбарт харьяалагддаг, ямар албан тушаал хашдаг талаар намын удирдлага мэдэхгүй байх нь элбэг. Ийм үндсэн мэдээлэл ч дутуу дулимаг байдаг тул мэргэжил, боловсрол, туршлага, үр чадвар зэрэг намын эмэгтэй гишүүдэд байгаа нөөц бололцооны талаар бүр ч мэдэхгүй болов уу. Тиймээс намын удирдлагаас эмэгтэй гишүүн элсүүлэх томоохон санаачилга эхлүүлэхээсээ өмнө намын гишүүн эмэгтэйчүүдийнхээ талаар илүү их зүйл мэдэж авахыг зориуд хичээх хэрэгтэй. Дараа нь үг мэдээлэл дээрээ тулгуурлан гишүүн элсүүлэх арга замаа боловсруулж, хэрэгжүүлэх нь оновчтой.

Ийм судалгааг өмнөх хэсэгт өгүүлсэн намын жендэрийн аудитын нэг хэсэг болгон хийх боломжтой. Тийм тохиолдолд эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид, жендэрийн аудит хийлгэхээр намын удирдлагаас томилсон намын эмэгтэйчүүдийн байгууллага, бусад нэгжийн төлөөлөгчид дээрх мэдээллийг цуглуулах боломжтой. Намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж, намын анхан шатны байгууллагуудад намын эмэгтэй гишүүдийн талаарх мэдээлэл угаасаа байгаа бол түүнийг цуглуулж, намын удирдлага, сонгон шалгаруулах хорооны гишүүдийн хэрэгцээнд зориулан эмхэтгэж бэлтгэх л шаардлагатай гэсэн үг. Хэрэв намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж, намын анхан шатны байгууллагуудад ийм мэдээлэл байхгүй бол эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид, эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн төлөөлөл эсвэл жендэрийн аудитын ажлын хэсгийн гишүүдийг дайчлан мэдээллийн сан бий болгох үүрэг өгч болно. Мэдээллийн санд намын эмэгтэй гишүүдийн тоо, аль түвшинд ямар ажил, албан тушаал эрхэлдэг, мэргэжил, боловсрол, үр чадвар, мэргэшил, туршлага, сонирхол зэрэг мэдээллийг багтаах боломжтой. Мэдээлэл цуглуулахдаа дараах асуулыг асуух нь зүйтэй.

- Яагаад тус намд элссэн бэ?
- Намын аль шатанд идэвхтэй ажиллаж байна вэ? Ямар албан тушаалд ажиллаж байна вэ?
- Боловсролын талаарх мэдээлэл?
- Өөр ямар нэгэн мэргэжил эзэмшсэн эсэх?
- Үр чадвар хөгжүүлэх сургалт эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж байсан эсэх?
- Орон нутгийнхаа ямар нэгэн холбоо, ТББ-д ажилладаг, идэвхтэй оролцдог эсэх?
- Нам дотроо эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн дээшлүүлэх талаар ямар нэгэн санал байгаа эсэх?
- Намд олон эмэгтэйг татах, шийдвэр гаргах түвшинд хүргэх талаар намын зүгээс юу хийвэл зүйтэй талаар санал байгаа эсэх?
- Нам дотроо жендэрийн эрх тэгш байдлыг хангах үр дүнтэй тогтолцоог хэрхэн бүрдүүлбэл зохих талаар санал байгаа эсэх?

→ Намд эмэгтэйчүүдийг элсүүлэх, тэднийг алдахгүй байх

Нэр дэвших эмэгтэй, сонгуулийн сурталчилгааны ажлын эмэгтэй менежер, намын эмэгтэй идэвхтний арвин нөөц бүрдүүлэхийн тулд хийх эхний чухал алхам нь намд эмэгтэйчүүдийг элсүүлэх явдал юм. Намын гишүүнчлэл, сонгогчдын ирц буурч байгаа

өнөө үед намд эмэгтэй, эрэгтэй ялгаагүй шинэ гишүүн, дэмжигч чухал хэрэгтэй байгаа билээ¹⁰⁷. Иймээс намын удирдлагын зүгээс эмэгтэйчүүдийг намд элсүүлэх стратеги, арга замаа тодорхойлж, ач холбогдол өгч хэрэгжүүлэхээс өөр аргагүй.

Уг стратегийг нам дотроо жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид боловсруулж болох бөгөөд түүнийг нам дотроо ялангуяа намын шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэнцвэрт байдлыг дээшлүүлэх зорилгоор ашиглаж болно. Сүүлийн үед намын гишүүнчлэл төдийгүй шийдвэр гаргах үйл явцад ч жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор намын дүрэмдээ тодорхой заалт оруулсан намын тоо олширч байгаа тул хүйс заасан гишүүн элсүүлэх санаачилга нь намын дүрмээ биелүүлж байгаа хэрэг юм. Уг санаачилгыг хэрэгжүүлэхийн өмнө намын удирдлага, гишүүн элсүүлэх хороо нь намын энгийн гишүүн, зөвлөх, сонгуулийн сурталчилгааны менежер, намаас сонгуульд өрсөлдөх нэр дэвшигч гэх мэтээр ирээдүйд ямар албан тушаалд чиглүүлэн шинэ гишүүд элсүүлэх вэ гэдгээ урьдчилан тодорхойлсон байх нь зүйтэй.

Гишүүн элсүүлэх нь хоёр урсгалтай үйл явц гэдгийг анхаарах нь зүйтэй. Эмэгтэйчүүдийг намдаа элсүүлэхийн тулд улс төрийн нам өөрөө тэдний сонирхлыг татах чадвартай байх хэрэгтэй. Жендэрт ээлтэй улс төрийн нам бол гарал үүсэл, нийгмийн байдал, түршлагаараа харилцан адилгүй олон эмэгтэйн анхаарал, сонирхлыг татах нь дамжиггүй. Зөвхөн уран яруу илтгэдэггүй харин тодорхой бодлого, стратеги, санаачилгаар дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг бий болгоход анхаардаг улс төрийн намыг эмэгтэйчүүд илүүтэй сонирхох нь мэдээж. Ийм учраас намын удирдлага нь эмэгтэйчүүдийг намдаа элсүүлэх *шууд болон дам* арга замыг ашиглаж болно¹⁰⁸.

Шууд элсүүлэх арга зам гэдэг нь мэргэжлийн өндөр мэдлэг, нарийн үр чадвар, тодорхой салбарын түршлагатай хүмүүсийг намд элсэхийг урих байдлаар хэрэгжинэ. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн байгууллага, холбоо, төрийн бус байгууллагуудад хандах, хамтран ажиллах замаар шинэ эмэгтэй гишүүд олж болно. Зөвхөн эмэгтэй гэлтгүй эрэгтэй гишүүдийг ч мөн ийм аргаар сонгох боломжтой. Жишээ нь, намд эмэгтэй гишүүн элсүүлэх зорилгоор Канадын Либерал нам Эмэгтэй нэр дэвшигч тодруулах асуудал эрхэлсэн захирлын албан тушаалыг бий болгожээ¹⁰⁹. Их Британий Хөдөлмөрийн нам саяхнаас Хөдөлмөрийн намын Ирээдүйн нэр дэвшигч гишүүн хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна¹¹⁰. Хөтөлбөрийг цахим хуудсаар зарлахаас гадна Хөдөлмөрийн намд ажиллаж буй эмэгтэй гишүүд, дэмжигчид өөрийн орон нутгийн эмэгтэйчүүдэд цахим шуудан илгээж, тус намд элсэхийг уриалдаг аж. Хөдөлмөрийн намын зөвлөх нэгэн эмэгтэйдгээс намд элсүүлэхээр өөр нэгэн эмэгтэйд хандаж бичсэн нэг захидлаас энэхүү хөтөлбөрийн үр дүнг харж болох юм (Шигтгээ 3.10).

Шинээр гишүүн элсүүлэх, ялангуяа эмэгтэй гишүүн элсүүлэхэд иргэний нийгмийн байгууллагад хандах нь тун тохиромжтой. АНУ-д иргэний нийгмийн байгууллагын 80 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг бол Их Британид 68 хувь байдгийг судалгаа харуулж байна¹¹¹.

107 “Lonely at the top”, The Economist, 4 August 2012, <<http://www.economist.com/node/21559901>>.

108 Emelie Lilliefeldt, “European Party Politics and Gender. Configuring Gender-Balanced Parliamentary Presence”, Stockholm Studies in Politics, Stockholm, 2011.

109 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women’s Political Participation, UNDP/NDI, 2011, p.25, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

110 “Future Candidates Programme 2012”, United Kingdom Labour Party, <<http://www.labour.org.uk/nextgeneration>>.

111 “Women in civil society: Breaking the glass pyramid”, Council for International Development, 7 March 2013, <<http://www.cid.org.nz/news/women-in-civil-society-breaking-the-glass-pyramid/>>. Leadership statistics from “Women in leadership: It’s not going to work the way we’re doing it”, The Guardian, 1 August 2013, <<http://www.theguardian.com/global-development-professionals-network/2013/aug/01/women-in-leadership-international-ngos>>.

Шигтгээ 3.10. Хөдөлмөрийн намын Ирээдүйн нэр дэвшигч гишүүн хөтөлбөр: Хувийн туршлагаас хуваалцахад

Хүндэт Каролина,

Намайг Жесс Филипс гэдэг. Хүүхэд өсгөхийн зэрэгцээ ажил эрхэлдэг эмэгтэй. Саяхан Бирмингэм хот дах Хөдөлмөрийн намын зөвлөхөөр сонгогдсон. Би Харри, Данни гэдэг хоёр хөөрхөн хүү, нөхөр Томын хамт амьдардаг. Нутгийн нэгэн буяны байгууллагад орон тооны ажилтан хийдэг.

Хоёр жилийн өмнө нийгэмд дургүйцэж, үзэн ядсан хүмүүсийн үйлдлээс болж манай гудамж сүйдсэнээс хойш орон нутгийнхаа ажилд идэвхтэй оролцож ирсэн. Миний энэ түүхийн талаар илүү мэдэхийг хүсвэл энэ видеог үзээрэй.

Ноднин Хөдөлмөрийн намын Ирээдүйн нэр дэвшигч гишүүн хөтөлбөрийн талаар Хөдөлмөрийн намаас надад нэг цахим шуудан ирлээ. Өмнө нь улс төрийн үйл ажиллагаанд оролцох талаар бодож байгаагүйн дээр над шиг хүнийг тэр хөтөлбөрт авах эсэхэд эргэлзэж л байлаа. Гэхдээ анкетын нь бөглөөд үзье гэж шийдсэн. Хэдэн долоо хоногийн дараа намайг хөтөлбөрт оролцуулахаар сонгон авсан тухай дуулаад үнэхээр алмайрсан. Хөтөлбөрт хамрагдаад Хөдөлмөрийн намын төлөөлөгч гэж хэн болох, ямар байх талаар мэдэж авч, энэ намаас нэр дэвшихэд

шаардлагатай сургалтад сууж, дэмжлэг туслалцаа авсан.

Над шиг жирийн л нэг гэр бүлтэй хүнийг улс төрийн намууд элсүүлэхийг сонирхдог гэж хэзээ ч бодож байсангүй. Харин Хөдөлмөрийн намын Ирээдүйн нэр дэвшигч гишүүн хөтөлбөрт хамрагдаад Хөдөлмөрийн нам үүнийг л хүсдэг юм байна гэдгийг ойлгосон.

Энэ хөтөлбөрийн тухай чамд ярьж өгөхийг хүсч байна. Чи өөрөө ч юм үү эсвэл чиний сайн мэддэг хэн нэгэн нь нутгийнхаа иргэд, Хөдөлмөрийн намд зориулж чадах нөөц бололцоотой ч улс төрд хөл тавих талаар бодож байгаагүй байх. Ноднин би энэ хөтөлбөрт хэрхэн хамрагдсан шиг чи бас анкетаа явуулаад үзвэл ямар вэ? Тэгээд надтай адил хөтөлбөрт тэнцэж хамрагдсаны чинь дараа нутгийнхаа төлөө санаа тавих, ажиллах боломжтойг чинь олж харах ч юм бил үү. Хөдөлмөрийн намын Ирээдүйн нэр дэвшигчийн хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, өргөдлөө явуулахыг хүсвэл энэ хаягаар олж үзээрэй: labour.org.uk/nextgeneration.

Хүндэтгэсэн, Жесс Филипс

Бирмингэм хотын Лонгбриж дүүргийн Хөдөлмөрийн намын зөвлөх

Эх сурвалж: Харлоу дах Хөдөлмөрийн намын тойргийн оршин суугчид илгээсэн хувийн цахим шуудан

Шигтгээ 3.11: Гишүүн сонгоход тулгардаг дөрвөн том асуудал

1. Албан бус, зохицуулалтгүй байдлаар гишүүн сонгох нь ил тод бус, хариуцлагагүй сонголт хийхэд хүргэдэг.
2. Гэнэтийн буюу тохиолдлын байдлаар гишүүн сонгох нь гишүүн болж байгаа нэр дэвшигчийн хувьд сонгуулийн кампанит ажилтай холбоотой төлөвлөлт хийх, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг.
3. Дээрээс зааварчлах байдлаар гишүүн сонгох нь намын дотоод ардчиллын зарчимд сөрөг нөлөө үзүүлж, намын анхан шатны дэмжлэгийг сулруулдаг.
4. Хөрөнгө харж гишүүн сонгох нь чадварлаг нэр дэвшигчдийн нөөцийг бууруулж, мерит буюу чадварт үндэслэх зарчмын ач холбогдлыг багасгадаг.

Иргэний нийгмийн байгууллагын ажилтнууд нөлөөллийн ажил, лобби хийх, төсвийн удирдлага, мэдээлэл харилцаа, тодорхой бүлгийн хүмүүст хүрч ажиллах үр чадварыг эзэмшсэн байдаг бөгөөд үүнийг улс төрд ч төвөггүй хөрвүүлэн ашиглах боломжтой.

Дам элсүүлэх арга зам гэдэг нь сонин хэвлэл, телевиз радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлал явуулах юм. ОХУ-ын Нэгдсэн Орос нам “мэргэжилтнүүдийн” үндэсний мэдээллийн санг бий болгох стратеги хэрэгжүүлсэн байдаг¹¹². Казахстаны Нур Отан нам, Украины Ногоон намд үүнтэй

112 Проект “Кадровый резерв – Профессиональная команда страны”, “Единая Россия” 2005–2012, [Project: Personnel reserve – National Team of Professionals], <<http://profkomanda.edinros.ru/>>.

төстэй мэдээллийн сан байдаг аж. Мэдээллийн санд намын гишүүн болох эрмэлзэлтэй эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүмүүсийн мэдээлэл байдаг ч энэ туршлагад тулгуурлан намын гишүүн болох эмэгтэйчүүдийг олох зорилгоор “зөвхөн эмэгтэйчүүдийн” мэдээллийн сан үүсгэж болох юм.

→ **Нэр дэвшигч сонгох үйл явцыг нээлттэй, зохицуулалттай, ил тод, эмэгтэйчүүдэд ээлтэй болгох нь**

Улс төрийн намд олон эмэгтэй элсүүлэх нь намын гишүүнчлэлийг өргөжүүлэх маш чухал эхний алхам билээ. Намд элссэний дараа улс төрийн шат ахихад эмэгтэйчүүдэд тулгардаг хамгийн хүнд бэрхшээл бол *нэр дэвшигч сонгох үйл явц* юм.

Нэр дэвшүүлэх үйл явц нь улс төрийн намын хүрээний цөөн хэдхэн хүний хооронд нууцлаг явагддаг учраас эрдэмтэд “нууц цэцэрлэг”, “хар хайрцаг” зэргээр нэрлэх нь бий. Ийм ч учраас намын гадна байгаа хүмүүст тухайн улсын болон тухайн намын онцлогийг мэдэж авах шаардлага тулгардаг¹¹³. Мөн улс орнуудын сонгуулийн тогтолцоо өөр өөр байдаг тул ЕАБХАБ-ын бүс нутгийн улс төрийн бүх намд нийтлэг хэрэглэж болох нэр дэвшигч сонгох стратеги боловсруулахад бэрхшээлтэй. Намаас нэр дэвшигчдийн жагсаалт гаргах үед саналын хуудас дээр бичигдэх эрэмбэ дээр нам доторх бүлгүүд тохирч, зөвшилцөх шаардлагатай болдог сонгуулийн тогтолцоо бий. Түүнчлэн улс дотроо намууд нэр дэвшүүлэх өөр өөр дүрэм журамтай, түүнийгээ сонгууль бүрт өөрчилж байж ч болох тул нийтлэг стратеги боловсруулахад бүр арвиштай.

Нэр дэвшигч сонгох үйл явцыг ил тод, зохицуулалттай, нээлттэй, эмэгтэйчүүдэд ээлтэй болгохын ач холбогдлыг дутуу үнэлж өөр болохгүй. Нэр дэвшигчийн жагсаалтын бүрэлдэхүүн ямар байгаагаа сонгогчид тухайн намыг хэрхэн хүлээж авч, үнэлэх нь шалтгаалах бөгөөд улмаар сонгуульд тухайн нам ямар дүн үзүүлэх нь ч түүнээс хамаарч болно. Иймээс улс төрийн үзэл баримтлалаас үл хамааран аль ч намын удирдлагын зүгээс нэр дэвшигч сонгохдоо сонгуульд аль болох олон санал авах

Шигтгээ 3.12. Нэр дэвшигч сонгох улс төрийн намын үйл явцад жендэрийн эрх тэгш байдлыг тусгах нь

Нэр дэвшигчдээ олон өөр төлөөллөөс бүрдүүлэхийг эрмэлзэж байгаа улс төрийн намуудад зориулан гурван түгээмэл аргыг онолын ном, гарын авлагад санал болгосон байдаг. Энэ нь эрх тэгш байдлын талаар байнга сурталчлах ярьж, бичих арга, эрх тэгш байдлыг дэмжих арга зам, эрх тэгш байдлыг баталгаажуулах арга зам юм.

Эрх тэгш байдлын асуудлыг байнга сурталчлан ярьж, бичих арга:

Тухайн нам эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог дэмжиж байгаагаа сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгааны ажил, намын удирдлагын хэлэх үг, нийтлэх материалаар дамжуулан илэрхийлнэ.

Эрх тэгш байдлыг дэмжих арга:

Тусгайлсан сургалт явуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тодорхой зорилт тавьж ажиллах зэргээр намын удирдлагын зүгээс төлөөлөл багатай хүйсийнхнийг улс төрд дэмжих чиглэлээр тодорхой, бодитой арга хэмжээ авахыг хэлнэ.

Эрх тэгш байдлыг баталгаажуулах арга:

Сайн дурын үндсэн дээр жендэрийн квот тогтоох зэргээр нэр дэвшигчийн хүйсийн төлөөллийг нэг шалгуур үзүүлэлт болгох замаар нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо, хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг хэлнэ.

Онолын энэхүү шаталсан загвар нь нэр дэвшигчдээ олон өөр төлөөллөөс бүрдүүлэх бололцоог олгодгоороо намын удирдлага, эрх тэгш байдлын төлөө тэмцэгчдэд ач холбогдолтой.

*Эх сурвалж: Joni Lovenduski, *Feminizing Politics*, (Cambridge: Polity Press, 2005); and Sarah Childs, Joni Lovenduski and Rosie Campbell, *Women at the Top 2005: Changing Numbers, Changing Politics?* (London: Hansard Society, 2005).*

113 Bonnie N. Field and Peter M. Siavelis, “Candidate Selection Procedures in Transitional Polities”, *Party Politics*, Vol. 14, No. 5, 2008, pp. 620–639; Michael Gallagher and Michael Marsh (eds.), *Candidate Selection in Comparative Perspective: The Secret Garden of Politics* (London: Sage, 1988); Reuven Y. Hazan and Gideon Rahat, *Democracy within Parties: Candidate Selection Methods and their Political Consequences* (New York: Oxford University Press, 2010).

гэсэн зорилгыг л урьтал болгодог. Өөрөөр хэлбэл, сонгуульд амжилт үзүүлэхэд нь нөлөөлдөг тул намын удирдлага нэр дэвшигч сонгох үйл явцыг өөрийн хатуу хяналтанд байлгах сонирхолтой байдаг.

Нэр дэвшигч сонгох үйл явцыг ил тод, зохицуулалттай болгоно гэдэг нь намын дүрэм, дотоод журам зэрэг баримт бичигт нэр дэвшигч сонгох журмыг оруулж тусгана гэсэн үг. Ийнхүү нэр дэвшигч сонгох журмыг албан ёсны болгож, тодорхой томъёолсон цагт аль ч түвшний нэр дэвшигч тодруулах ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг харгалзах тухай өөрчлөлтийг журамд тусгах боломжтой болно. Харин нэр дэвшигч сонгох үйл явц албан бус, ил тод бус бол дүрэмжурамд өөрчлөлт оруулсан ч мөрдөгдөхгүй, ердөө ёс төдий, хоосон уриагаас өөрцгүй болно. Нэр дэвшигч сонгох журмыг бичгээр тодорхой гаргасан байх нь сонгуулийн өмнөхөн намын удирдлага түүнийг өөрчлөхөөс сэргийлж, нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэйн аль алиных нь хувьд нэр дэвших стратегээ боловсруулан хэрэгжүүлэх бололцоо олгохоос гадна намын удирдлага дүрэм журмаа хэрэгжүүлэхгүй байх, зөрчих тохиолдолд хариуцлага тооцох үндэслэл болно.

Нэр дэвшигч сонгох үйл явцыг ил тод, жендэрт ээлтэй болгохын тулд *нэр дэвшигчид тавих наад захын шалгуурыг* холбогдох журамд тусгахаас гадна уг *үйл явцыг бүхэлд нь нарийвчлан тайлбарласан байх* шаардлагатай. Мөн нэр дэвшигчдэд хангалттай хугацаа олгох үүднээс сонгох үйл явц эхлэх, дуусах хугацааг журамд тодорхой заасан байвал зохино. Нэр дэвшигч сонгох үйл явц нь сонгуульд хэт ойрхон явагдвал нэр дэвшигчийн хувьд санхүүжилт олох, сурталчилгааны ажлаа төлөвлөн явуулахад хүндрэлтэй байх болно.

Нэр дэвшигч сонгох үйл явцыг намын гишүүнчлэлийн уламжлалт хүрээ, шатлалын гадна байгаа шинэ хүмүүст, ялангуяа эмэгтэйчүүдэд нээлттэй болгох нь зүйтэй. Нэр дэвшигч сонгохдоо одоо уг албыг хашиж буй хүмүүсийг эхлээд тодруулах хандлага байдаг, энэ нь албан тушаалтнууд хуучин эрчээрээ сонгогдох байдалд хүргэдэг¹¹⁴. Ер нь бол парламентын гишүүн болох хамгийн амархан арга нь угаасаа парламентын гишүүн байх явдал гэдэг нь ойлгомжтой. Сайн ажилласан (ядаж л муу ажиллаагүй), дээр нь улс төрийн карьераа үргэлжлүүлэх сонирхолтой байгаа улс төрчийг холдуулах амаргүй. Улс төрд (түүнчлэн улс төрийн намууд) одоо ажиллж буй улс төрчдөд талтай ханддаг нь хэд хэдэн шалтгаантай; тухайлбал, олон нийт таныгда болсон, хэвлэл мэдээллийн анхаарлыг татдаг, улс төрийн нөөц бололцоог ашиглах боломж сайтай зэргийг нэрлэж болно. Гэвч жендэрийн талаас нь авч үзвэл, эрэгтэйчүүд улс төрд

Шигтгээ 3.13. Нэр дэвшигч сонгох үйл явцыг ил тод болгох нь

Нэр дэвшигч сонгох үйл явцыг ил тод болгохын тулд намын удирдлага, сонгон шалгаруулах хороо холбогдох журамд дараах зүйл заалтыг тусгаж болно. Үүнд:

1. **Нэр дэвшигчид тавих наад захын шаардлагыг гаргахдаа** боловсролын түвшин өөр эсвэл доогуур гэсэн үндэслэлээр эмэгтэйчүүдийг хасуулахгүйн тулд хүйсийн харьцааг бодолцох.
2. **Нэр дэвшигч сонгох үйл явц**, холбогдох үе шат, хугацааны тов зэргийн талаар нэр дэвшихийг эрмэлзэж буй хүмүүс мэдээлэлтэй байх үүднээс нэр дэвших үйл явцыг бүхэлд нь тайлбарлан дурдаж, цаг хугацааны товлолыг зааж өгсөн байх.
3. Нэр дэвшигч сонгуульд өрсөлдөх бэлтгэлээ хангах, сонгуулиас өмнө сурталчилгааны ажлаа явуулах боломжтой байх үүднээс нэр дэвшигчийн **сонгон шалгаруулалт эхлэх, дуусах хугацааг** зааж өгөх.
4. **Холбогдох мэдээллийг түгээх суваг**. Жишээ нь, нэр дэвшигч сонгох үйл явцын талаарх мэдээллийг намын цахим хуудсанд нийтэлж, шаардлагатай үед шинэчилж байх нь нэр дэвшигч, тэдний багийнхан нэр дэвшүүлэхтэй холбоотой тавигдаж буй шаардлага, хугацааны асуудлаарх мэдээллийг цаг алдалгүй авах боломж олгоно.

114 Richard L. Fox and Jennifer L. Lawless, "If Only They'd Ask: Gender, Recruitment and Political Ambition", *The Journal of Politics*, Vol. 72, No. 2, April 2010, pp. 310–326.

Шигтгээ 3.14. Нэр дэвшигч сонгох онолын хандлага

Төвлөрсөн ба институтчилсэн

Тухайн намаас сонгуульд хэнийг нэр дэвшүүлэхийг шийддэг намын дотоод сонгон шалгаруулах явцыг ойлгоход зориулан “төвлөрсөн” ба “институтчилсэн” гэсэн хоёр арга барилыг онолын зарим судалгаанд тодорхойлсон байдаг.

Төвлөрсөн гэдэг нь нэр дэвшүүлэх үйл явцад намын удирдлагаас хэр зэрэг хяналт тавьж, нөлөөлж байгааг илэрхийлнэ. Нэр дэвшүүлэх үйл явцад оролцдог өөр бусад субъект гэвэл намын анхан шатны байгууллага, салбар байж болох бөгөөд тэдэнд зарим тохиолдолд намын төв байгууллагын шийдвэрийг өөрчлөх эрх хэмжээ олгосон байх нь бий. Олон шаттай энэхүү үйл явцад эрх мэдэл хаана төвлөрч байгааг тогтооход амаргүй.

Нэг туйлд нь иргэд, намын бүх гишүүд оролцсон сунгаагаар нэр дэвшигчийг сонгодог ардчилсан журам бий, үүний нэг жишээ нь АНУ. Тойргийн түвшинд аль нэг нэр дэвшигчийг дэмжихэд тухайн орон нутгийн нам бус байгууллага, дүүргийн олигархууд, санхүүгийн ивээн тэтгэгч, хэвлэл мэдээлэл зэрэг намд харьяалагддаггүй байгууллага, ажилтнуудын оролцоо чухал байдаг.

Европын улс төрийн намуудын хувьд намын гишүүд, албан хаагчид, намын бүс нутгийн хурал, намын төв байгууллага, намын удирдлага оролцсон олон үе шаттай дотоод үйл явцаар дамжин нэр дэвшигчийг сонгох нь түгээмэл байдаг. Нэр дэвшигч сонгох үйл явцын нөгөө туйлд нь, намын элитүүд буюу намын удирдлага, намын төв байгууллага, парламентад сүүдалтай намын бүлэг зэрэг цөөн хүн нэр дэвшигчийг сонгох шийдвэр гаргадаг.

Харин *институтчилсэн* гэдэг нь нэр дэвшүүлэх үйл явц хэр зэрэг албан журмын дагуу явагддаг, эсвэл албан бус байдлаар, чимээгүй тохиролцох байдлаар явагдаж байгааг илэрхийлсэн ойлголт юм. Нэр дэвшигч сонгох журам намын дүрэм зэрэг

албан ёсны бичигдсэн дүрэм журмын хэсэг болж, төлөвшиж тогтсон, ил тод, тодорхой байхыг “институтчилсэн” гэж үздэг. Харин албан бус хэм хэмжээ, чимээгүй заншлаар шийдвэрлэдэг бол “институтчилсэн” гэж үзэхгүй. Албан ёсны журмыг чухалчлан үздэг бол сонгон шалгаруулалтын явцад жендэрийн эрх тэгш байдлыг харгалзах талаар дүрэм журамд оруулах боломжтой. Харин сонгон шалгаруулалтыг албан бус байдлаар явуулдаг бол дүрэм журам байлаа ч ёс төдий, тунхаглалын шинжтэй, заавал мөрдөгдөх хүчин чадваргүй байна. Энэ ялгааг мэдэх нь чухал.

Төвлөрсөн ба хамран оролцуулах байдал

Reuven Y. Hazan, Gideon Rahat нарын бүтээл дээр суурилсан онолын зарим судалгаанд нэр дэвшигчийг сонгох “төвлөрсөн” ба “хамран оролцуулах байдал” гэж ялгаж үзэх нь нэмэгдэж байна. Энд “төвлөрсөн” гэдэг нь намын шийдвэр аль түвшинд гарч байгааг илэрхийлдэг бол “хамран оролцуулах байдал” гэдэг нь нам шийдвэр гаргалтанд оролцож буй нийт субъектийн цар хүрээг илэрхийлнэ.

Нэр дэвших үйл явц хэр “хамран оролцуулах байдал”-тай вэ гэдэг нь хууль тогтоомжоос шалтгаалах тохиолдол бий. Тухайлбал, АНУ-д нэр дэвшигч сонгоход намын дотоод дүрэм журам бус муж улсын хууль илүү хамаатай. Үндсэн шалгуурт нийцсэн хэн ч нэр дэвшигч байх болзлыг хангаж, өрсөлдөх боломжтой байдаг тул АНУ-ын нэр дэвшигч сонгох үйл явцыг хамран оролцуулах байдал сайн гэж үздэг. Харин Европын улс төрийн намуудын хувьд ялангуяа пропорционал тогтолцоотой улс оронд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг улс төрийн намууд өөрсдөө тогтоодог. Иймээс намын удирдлагаас бүх гишүүн эсвэл өргөн хүрээний гишүүд хангах боломжтой уян хатан шалгуур тогтоож болно. Эсвэл нэр дэвшигч сонгоход намын удирдлага, сонгон шалгаруулах хороонд үйл явцыг хянах боломж олгосон хатуу шалгуур тогтоох ч бололцоотой.

давамгайлж, албан тушаал хашиж ирсэн нь түүхэн үнэн бөгөөд иймээс одоо ажиллаж буй улс төрчдийг дэмжсэн арга барил нь шинээр орж ирэх эмэгтэйчүүдийн эсрэг үйлчилж болзошгүй.

Дээрх шалтгааны улмаас намын удирдлага нь гишүүдийнхээ дотроос болон намаас гадуур нэр дэвшигч хайхдаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алийг нь бодолцож үзэх

нь зүйтэй юм. Энэ тал дээр зарим нам аль хэдийн тодорхой ахиц гаргаад байна. Тухайлбал, Канадын Либерал нам нэр дэвшигч элсүүлэх хороо байгуулсан бөгөөг уг хороо нь эмэгтэй нэр дэвшигч элсүүлэхтэй холбоотой дүрэм журмын хэрэгжилтийг ханган, нэр дэвшигчдийг олон өөр төлөөллөөс бүрдүүлэх зарчмыг баримтлан ажилладаг байна¹¹⁵. Ийм шинэ хандлага нь улс төрийн намд тогтсон хуучин эрчээрээ явдаг байдлыг халахад тус болно.

Гаднаас нэр дэвшигч элсүүлэхдээ тухайн хүн жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг хүндэтгэдэг эсэх, энэ талаарх намын байр суурьтай санал нийлж байгаа эсэхийг тогтоох асуулт оруулах нь зүйтэй. Гэхдээ “од” болох нэр дэвшигчийг намын гаднаас эрж байхдаа нэр дэвшигчийн болзол хангасан намын гишүүдээ (эрэгтэй, эмэгтэй аль аль нь) анзааралгүй өнгөрөхөөс болгоомжлох хэрэгтэй. Гаднаас сонгосон шинэ нэр дэвшигчид хамгийн наад зах нь намын гишүүнээр элсэх, жендэрийн эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтын эсрэг намын бодлогыг хүндэтгэх үүрэг хүлээлгэх хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд, нэр дэвшигч сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнд анхаарал тавих ёстой бөгөөд энэ талаар доор өгүүлэв. Ихэнх улс төрийн намын хувьд нэр дэвшигч сонгон шалгаруулах хороо дан эрэгтэйчүүдээс бүрдсэн байдаг. Уг хорооны бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийг оруулах заалтыг намын дүрэмд тусгаж өгвөл сонгон шалгаруулах үйл явц жендэрт ээлтэй болоход чиглэсэн чухал алхам болно. Нэр дэвшигч сонгон шалгаруулах явцад эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлийн талаар Хавсралт 4-т дэлгэрэнгүй мэдээлэл бий.

→ Сайн дурын үндсэн дээр намын квот тогтоох

Нэр дэвшигч сонгох журмыг ил тод, шударга, тэнцвэртэй болгохоос гадна нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхийн тулд квот тогтоох зэрэг тодорхой арга замыг давхар авч үзэх нь зүйтэй¹¹⁶.

Намын квот гэдэг нь ихэвчлэн намын дүрэмд өөрчлөлт хийх замаар намаас сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг арга хэмжээ юм. Намын квот нэвтрүүлснээр тухайн нам нэр дэвшигчдэд, зарим тохиолдолд шийдвэр гаргах албан тушаалын тодорхой хувьд эмэгтэйчүүдийг сонгох, эсвэл аль нэг хүйсийн эзлэх дээд, доод хязгаарыг тогтоох амлалт авдаг (энэ тухай доор дэлгэрэнгүй өгүүлнэ)¹¹⁷. Намууд ихэнхдээ нэр дэвшигчдийнхээ 25-50 хувийг эмэгтэйчүүдээс сонгох амлалт авдаг. Ихэнхдээ улс төрийн намууд хуулиар квот тогтоохоос өмнө сайн дурын үндсэн дээр квот ашигладаг ч зарим нам хуульд заасан хувь хэмжээнээс ахиулан сайн дурын квот тогтоох тохиолдол бас бий¹¹⁸.

ЕАБХАБ-ын бүс нутаг дах улс төрийн намуудын тэн хагас нь нэр дэвшигч сонгохдоо жендэрийн квот тогтоосон байдаг (тэдгээр намын жагсаалтыг Хавсралт 5-аас үзнэ үү). ЕАБХАБ-ын бүс нутгийн ихэнх улс орон пропорциональ тогтолцоотой байдаг бөгөөд намын жагсаалтад орох нэр дэвшигчийг сонгохдоо намын квотоор зохицуулдаг. Харин Франц, Их Британи зэрэг сонгуулийн мажоритар тогтолцоотой улс оронд нэг мандаттай тойрогт санал цуглуулахад намын квот хэрэглэдэг. Зарим улс төрийн нам квотыг улам гүнзгийрүүлэн, эмэгтэйчүүдийг жагсаалтын “найдвартай” эрэмбэд

115 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women’s Political Participation, UNDP/NDI, 2011, p.15, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

116 Mona Lena Krook, Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide (New York: Oxford University Press, 2009).

117 Ibid.

118 Petra Meier, “The Mutual Contagion Effect of Legal and Party Quotas: A Belgian Perspective”, Party Politics, Vol. 10, No. 5, 2004, pp. 583–600.

байршуулах эсвэл “ялах бололцоотой” тойрогт хуваарилах зохицуулалт хийсэн байдаг бөгөөд энэ нь сонгогдсон эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх цор ганц арга гэж үздэг.

Олон улсын түршлагаас харахад сайн дурын үндсэн дээр тогтоосон намын квотыг үр ашигтай болгохын тулд намын удирдлагаас дараах асуудлыг ханган хэрэгжүүлэх ёстой байдаг аж. Үүнд:

- (1) намаас нэр дэвших эмэгтэйчүүдийн эзлэх жинг *харьцангуй өндөр* байлгах;
- (2) жагсаалтад бичигдэх *дарааллыг заасан заалт* оруулах;
- (3) квотыг олон нийтэд ойлгомжтой, өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн *соёл, уламжлалтай холбон* тайлбарлах;
- (4) квотыг намын бүтэц тогтолцоо, нэр дэвшүүлэх албан ёсны журмын нэг хэсэг болгон институтчилж, намын дотоод байгууллага түүнийг мөрдүүлэн сахиулах нөхцөл бүрдүүлэх¹¹⁹.

Шигтгээ 3.15. Улс төрийн намаас сайн дурын үндсэн дээр квот тогтоосон Испанийн түршлагын үр дүн: Аажим өсгөх арга барил уу?

Испанид сонгуульд албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх “түргэвчилсэн” бус харин “шат дараалсан” арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. 1979 онд парламентын суудлын зөвхөн 5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байжээ. Хуулиар жендэрийн квот нэвтрүүлсний үр дүнд парламент дах эмэгтэйчүүдийн төлөөлөл 2007 онд 36 хувь боллоо өссөн байна.

Олон нийт, намын гишүүдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ, намын эмэгтэйчүүдийн байгууллага, иргэний нийгмийн тэмцэгчдийн нөлөөллийн үйл ажиллагаа, олон улсын эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, үйл ажиллагаанд намаас идэвхтэй оролцох зэрэг үйл ажиллагааг сайн дурын квоттой хослуулсны үр дүнд энэ өөрчлөлт гарчээ. Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулахын төлөөх улс төрийн хөдөлгөөний тэргүүн шугамд Испанийн Социалист ажилчдын намын (ИСАН) эмэгтэйчүүдийн байгууллага ажиллаж байсан бөгөөд нам, түүний удирдах тогтолцоонд жендэрийн харьцаа тэнцвэргүй байгааг судалгаагаар нотолж, бусад улс орнуудын социалист намтай харьцуулахад ИСАН энэ талаараа хол хоцорч яваа гэдгийг сануулан, намын квот нэвтрүүлэх талаар 1980-аад оны дунд үед лобби хийж байжээ. Түүнчлэн ИСАН-ын эмэгтэйчүүдийн байгууллага сайн дурын квотын талаар намын гишүүдийн дунд санал асуулга явуулахад 67 хувь нь дэмжсэн байна. ИСАН

болон Коммунист нам 1980 оны сүүлээр намын жагсаалтын 25 хувийг эмэгтэйчүүдэд олгох намын квот баталсан байна.

Испанийн жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгчдийн явуулсан олон нийтийг гэгээрүүлэх аян болон иргэдийн 60 гаруй хувь нь ийм арга хэмжээг дэмжинэ гэсэн судалгааны дүн нь намын эмэгтэй гишүүдэд урам зориг өгсөн байна. Намын төв байгууллагад эрх мэдэл төвлөрсөн байдаг учраас бүсийн болон орон нутгийн сонгуульд ч квот тогтоохыг үүрэг болгожээ.

1994 онд ИСАН ялалт байгуулах магадлалтай тойргуудыг эмэгтэйчүүдэд хуваарилах шинэ заалтыг нэмж, квотын журмыг улам сайжруулсан байна. Намын эмэгтэй гишүүдийг улс төрийн маркетинг хийх, үр чадвар сайжруулах сургалтад хамрагдахыг хөхиүлэн дэмжих замаар эмэгтэй нэр дэвшигчдийн “нийлүүлэлт”-ийг дээшлүүлэх арга хэмжээ авчээ. 1997 онд ИСАН сөрөг хүчин байхдаа намын нэр дэвшигчдийн жагсаалтад аль ч хүйсийн төлөөллийг 40 хувиас доошгүй байлгах талаар жендэрийн хувьд төвийг сахисан өөрчлөлтийг намын дүрэм журамдаа оруулжээ. Эрх барьж буй Эмэгтэйчүүдийн Европын дээд хэмжээний үүлзалт (1992 онд Афинд болсон), Социалист Эмэгтэйчүүдийн Интернационал цуглаан зэрэг олон улсын, европын төрөл бүрийн үйл ажиллагаанд намын гишүүд идэвхтэй оролцож байсан болон 1995 онд Бээжингийн

119 Pippa Norris and Mona Lena Krook, “Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan” (Warsaw: OSCE/ ODIHR, 2011), <<http://www.osce.org/odihr/78432>>.

үйл ажиллагааны хөтөлбөрийг НҮБ-аас баталсан нь дээрх ахиц дэвшил гарахад нөлөөлсөн гэж үздэг.

Мөн ийм квотыг Коммунист намаас төрж гарсан Нэгдсэн зүүний холбоо 1997 онд шуурхай баталсан байна. Дараачийн 10 жилд нь “нам хоорондын халдвар” дэгдэж Нийтийн нам зэрэг илүү консерватив намуудыг оролцуулан Испанийн бүхий л

том намууд квотын талаар төстэй шийдвэр гаргажээ. Үүнээс хойш эмэгтэйчүүдийг улс төрийн шат ахиулахыг дэмжиж Испаний гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлын талаар цогц хууль тогтоомж, бодлого, стратегийг батлан гаргасан байна.

Эх сурвалж: “Улс төрийн албан тушаалд жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох талаарх Өмнөд Европын зохицуулалт: Грек, Португал, Испанийн туршлага” (Regulating Gender Equality in Political Office in Southern Europe: The Cases of Greece, Portugal and Spain, Tània Verge, Paper Prepared for the 3rd European Conference on Politics and Gender, Universitat Pompeu Fabra, Barcelona, 21–23 March 2013).

Дээр дурдсан санаануудыг дор жишээгээр үзүүлэв.

1) Квотыг харьцангуй өндөр тогтоох

Альянс 90 (Германы ногоон нам) болон Австрийн ногоонууд нам нэр дэвшигчдийн жагсаалтын 50 хувь нь эмэгтэйчүүд байх ёстой гэсэн дүрэмтэй. Испанийн Социалист ажилчдын нам, Австрийн социал демократ нам, Германы социал демократ намын хувьд нэр дэвшигчдийн жагсаалтын 40 хувь нь эмэгтэйчүүд байх заалттай. Люксембургийн Христийн социал иргэдийн нам, Германы Христийн ардчилсан эвлэл, Австрийн Ард түмний намын дүрэмд нэр дэвшигчдийн жагсаалтын 1/3 нь эмэгтэйчүүд байна гэж заасан байдаг. Туркийн Энх тайван, ардчиллын нам үндэсний болон орон нутгийн сонгуулийн аль алинд намаас нэр дэвшигчдийн жагсаалтын 40 хувь нь аль төлөөлөл багатай хүйсээс бүрдсэн байх дотоод квотыг саяхан шинээр бий болгосон байна. Түүнчлэн Бүгд найрамдах ардын нам нэр дэвшигчдийн жагсаалтын наад зах нь 33 хувийг эмэгтэйчүүдэд олгох квот баталжээ¹²⁰.

2) Жагсаалтад бичигдэх дараалал

Зарим намууд нэр дэвшигчдийн тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг (буюу аль аль хүйсийн доод, дээд хувь хэмжээ) заасан квот тогтоохын зэрэгцээ нэр дэвшигчдийн жагсаалтад бичигдэх дарааллыг тусгайлан зохицуулсан байдаг. Шведийн бараг бүх улс төрийн нам “солбих” (“цахилгаан товч”) зарчмыг баримталдаг болсон. Өөрөөр хэлбэл, жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг солбиж бичих замаар эмэгтэйчүүдэд нэр дэвшигчдийн 50 хувь төдийгүй сонгуулиар сонгогдогчдын 50 хувийг бүрдүүлэх боломж бий болгох үүднээс ийнхүү зохицуулдаг байна. Үүний үр дүнд эмэгтэйчүүд парламентын суудлын 45 хувийг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн төлөөлөөрөө Швед улс дэлхийд дөрөвдүгээрт жагсдаг. Германы Зүүний намын хувьд жагсаалтын эхний хоёр байрт эмэгтэйчүүдийг бичиж, доошхи байруудад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг солбиж бичдэг аж.

3) Соёл, уламжлалын онцлог

Квот тогтоох тухай заалтын хэлний томъёолол яг ижил байх боломжгүй. Шведийн “солбих” бодлогыг нэг дуу өнжсөний дараа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бүжигт урьдаг ардын уламжлалт бүжигтэй жишин “өнжөөд нэг нь эмэгтэйчүүдийнх” гэж

120 See “Global Database of Quotas for Women”, International IDEA, University of Stockholm and the Inter-Parliamentary Union, <<http://www.quotaproject.org/>>.

шоглоцгоодог. Францын Үндсэн хуулийн эрх тэгш байдал, “universal citizen” буюу түгээмэл харьяаллын зарчмыг зөрчиж байна гэсэн үндэслэлээр орон нутгийн сонгуульд 25 хувийн квот тогтоосон бодлогыг Үндсэн хуулийн зөвлөл нь 1982 онд хүчингүй болгож байжээ. Ийм учраас аль аль хүйсийн “түгээмэл харьяалал”-ын зарчмын утга санаанд нийцүүлж “тэнцвэрт байдал” гэдэг нэр томьёо хэрэглэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулсны үр дүнд 1999 онд Үндсэн хуулинд, 2000 онд сонгуулийн хуулинд өөрчлөлт хийжээ. Ерөнхийд нь авч үзвэл квот үндсэн хуульд нийцэж байгаа эсэх дээр мэтгэлцээн үүссэн тохиолдлуудад жендэрийн хувьд төвийг сахисан нэр томьёо ашиглах нь илүү үр дүнтэй байна. Учир нь квотоор аль нэг хүйст зориулж тусгай журам гаргаагүй харин тус бодлогын үр дүнг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэн хэн нь хүртэнэ гэдэг ойлголтыг төрүүлдэг¹²¹. Тухайлбал, Испанийн Социалист ажилчдын нам анх квотын тухай заалтыг зөвхөн эмэгтэйчүүдэд хамааруулсан үг хэллэгээр илэрхийлж байсан бол 1997 оноос “төлөөлөл доогуур хүйс” гэх жендэрийн хувьд төвийг сахисан үг хэллэг ашиглах болжээ.

Шигтгээ 3.16. Сайн дурын квотын талаарх Польшийн туршлага

Коммунизм задарч, 1989 онд болсон чөлөөт сонгуулийн дараа парламент дах эмэгтэй төлөөлөгчдийн тоо 1985 онд 23 хувь байсантай харьцуулахад 1991 онд 10 хувь болж эрс доошилжээ. Ардчилсан зүүний альянс (АЗА), Хөдөлмөрийн эвлэл (ХЭ), төвийг сахигч Чөлөөт эвлэл (ЧЭ) гэсэн гурван нам 30 хувийн сайн дурын квот тогтоосны үр дүнд дөрөв дэх удаагийн парламентын үед л эмэгтэйчүүдийн төлөөлөл 20 болж өсчээ. Энэ үр дүнд хүрэхэд намын удирдлагад нөлөөлсөн хоёр гол хүчин бол эдгээр намын эмэгтэй гишүүд, Парламентын Эмэгтэйчүүдийн бүлгийн дэмжлэгтэй Эмэгтэйчүүдийн сонгуулийн өмнөх эвсэл гэж үздэг. Хэдийгээр албан ёсоор квотыг эсэргүүцэж байсан ч барууны буюу консерватив намууд ч нэр дэвшигчдийн жагсаалтаа илүү олон эмэгтэйг оруулжээ. Тухайлбал, Польш Өрхүүдийн лигийн нэр дэвшигчдийн 25 хувь, сонгогдсон төлөөлөгчдийн 26.3 хувь нь эмэгтэй байсан байна (25 хувь нь жагсаалтын 1-3 дугаар байрт бичигдсэн). Families (LPR) included 25 per cent, with 26.3

Одоо эрх барьж буй Иргэний платформ (ИП) нам жагсаалтын эхний гурван байранд

Эх сурвалж: Malgorzata Fuszara, Case Study: Poland: It's Time for Women: Gender Quotas on Electoral Lists, "Electoral Gender Quota Systems and their implementation in Europe" (Brussels: European Parliament, 2011), p. 97.

эмэгтэй нэр дэвшигчдийн 15 хувийг бичсэн бөгөөд 2001 онд сонгогдсон эмэгтэйчүүдийн 20 хувийг бүрдүүлжээ.

Иргэний Платформ Намын гишүүн Iwona Śledzińska-Katarasińska-гийн гаргасан саналын дагуу жагсаалт бүрийн эхний гурван байрын аль нэгт эмэгтэй нэр дэвшигч бичих тогтоолыг 2007 оны сонгуулиас өмнө баталжээ. Энэ журмыг зөрчвөл хүлээлгэх хариуцлага байхгүй боловч үүнийг хэрэгжүүлэхийг намын удирдлагаас шаардах боломжтой болсон. 41 тойргийн 34 нь энэ журмыг баримталсан бол 3 тойрогт эмэгтэйчүүдийг жагсаалтын 4 дүгээрт бичжээ. Үүний үр дүнд эмэгтэйчүүд жагсаалтын 21 хувийг эзэлж, 23 хувь нь сонгогдсон байна.

121 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation, UNDP/NDI, 2011, p.34, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

4) Хэрэгжилтийг хангуулах механизм

Сайн дурын квотыг бодитой хэрэгжүүлэхийн тулд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй намын дүрэм журам, бодлогын хэсэг болгох хэрэгтэй. Ингээгүй тохиолдолд намын удирдлагад квотыг баримтлах, хэрэгжүүлэх сонирхол байхгүй болно. Квотыг хэрэгжүүлэх нэг арга нь квотын дүрэмд нийцээгүй бол нэр дэвшигчдийн жагсаалт, сонгон шалгаруулах, элсүүлэх үйл явцаас татгалзах эрх хэмжээг намын гүйцэтгэх хороо, сонгон шалгаруулах хороонд олгох явдал юм. Канадын Либерал намын төв хороо эмэгтэйчүүд нэр дэвшигчдийн 1/3-ийг бүрдүүлээгүй тохиолдолд нэр дэвшигчдийг батлахаас татгалзах ба төв хороо өөрийн сонгосон нэр дэвшигчээр солих хүртэл эрх хэмжээтэй байдаг аж¹²².

Намын удирдлага, эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж, намын гишүүдийн зүгээс сайн дурын квототогтоох аливаа санаачилга, хүчин чармайлт гаргахдаа улс төрийн эрх мэдэлд хүрэхэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд тэнцвэргүй, тэгш бус байсан түүхэн нөхцөл байдлыг өөрчлөн засахад чиглэсэн *тусгай арга хэмжээ* гэдгийг намын гишүүддээ ойлгуулах сурталчилгааг сайн хийх шаардлагатай. Квот нь ялгаварлан гадуурхсан бус харин улс төрийн нам, сонгуулийн үйл явц эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцох, өрсөлдөх талбарыг шударга, тэнцвэртэй болгох зорилготой гэдгийг намын гишүүдэд ойлгуулахад бүрэн анхаарах нь зүйтэй. Түүнчлэн улс төрийн хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох хүсэл эрмэлзэлтэй байгаагаар болон энэ үүднээс бодитой авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар сонгогчдод мэдээлэх, харуулах үүднээс сонгуульд өрсөлдөх намын мөрийн хөтөлбөртөө квотын талаар оруулж болох юм.

→ **Намын шийдвэр гаргах тогтолцоонд сайн дурын квот нэвтрүүлэх нь**

Намын удирдлагаас намын засаглалын гол тогтолцоо, үйл явцад сайн дурын квот тогтоох замаар шийдвэр гаргах дотоод бүтэцдээ эмэгтэйчүүдийн төлөөллийг дээшлүүлэх боломж бий. Намын хурлууд, нэр дэвшигч сонгон шалгаруулах хороо, намын гүйцэтгэх зөвлөл зэрэг удирдлагын тогтолцоонд байх эмэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг зааж болно. Тухайлбал, Германы Христийн ардчилсан эвлэл намын эмэгтэйчүүдийн 1/3-ээс бага хувь нь намын албан тушаалд өрсөлдөхөөр нэр дэвшсэн байвал тухайн дотоод сонгуулийн дүнг хүчингүй болгодог¹²³. Харин Германы Социал демократ намын хувьд намын зөвлөлд аль аль хүйсийн төлөөлөл наад зах нь тус бүр 40 хувь байхыг шаарддаг. Молдавын Либерал ардчилсан нам, Социал демократ намын дүрмээр бүх түвшний намын удирдлага болон сонгуульд албан тушаалд өрсөлдөх намын нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байх

Шигтгээ 3.17. Сайн дурын болон хуульд заасан квотын талаарх Словенийн туршлага

1992 онд Социал демократуудын нэгдсэн жагсаалтаас намын нэр дэвшигчдийн жагсаалтад аль аль хүйсийн төлөөлөл наад зах нь тус бүр 33 хувь байх квот тогтоожээ. 1996 онд тус намын нэр дэвшигчдийн 42 хувь нь эмэгтэйчүүд байсан боловч нэг нь ч сонгогдоогүй. 1997 онд сайн дурын квотыг уян хатан “зорилт” болгон өөрчлөхдөө босгыг өндөрсгөж намын жагсаалтад аль аль хүйсийн төлөөлөл наад зах нь 40 хувь байхаар тогтоожээ. 2005 онд Словенид үндэсний болон орон нутгийн сонгуульд квот тогтоосон сонгуулийн шинэ хууль батлагдсан байна. Сонирхолтой нь, орон нутгийн сонгуулийн квоттой холбоотой заалт дахин өөрчлөгдөж, аль аль хүйсийн төлөөллийн доод хязгаар цааш өссөн байна. Сонгуулийн хуульд заасны дагуу 2006 оны сонгуульд аль аль хүйсийн төлөөлөл 20 хувь байхыг шаардаж байсан бол 2010 оны сонгуулиар 30 хувь, 2014 оны сонгуулиар 40 хувь болж өсчээ.

Эх сурвалж: Эмэгтэйчүүдийн квотын глобал мэдээллийн сан, <<http://www.quotaproject.org>>.

122 Ibid.

123 “Statutenbroschüredere CDU Deutschlands 2007”, <<http://www.cdu.de/doc/pdf/080121-CDU-statut.pdf>>.

квот тогтоосон байдаг¹²⁴. Зураг 3.18 –д улс төрийн нам дах эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сайн дурын арга хэмжээг шат дараалан авах арга замыг танилцуулна. Энэ талаар дэлгэрэнгүйг Хавсралт 6-аас үзнэ үү.

→ Квотыг албан бусаар нэвтрүүлж хэрэгжүүлэх нь

ЕАБХАБ-ын бүс нутгийн хүрээнд олон улс төрийн нам албан ёсны квот батлахаас гадна *зорилт, зөвлөмжийн хэлбэрээр* албан бус квот мөн нэвтрүүлсэн байдаг. Энэ нь ялангуяа *квотын асуудал* өөрөө маргаан дагуулж байдаг консерватив намуудад голдуу ажиглагддаг ч улс орны тодорхой онцлог нөхцөл байдалд ч гардаг. Эдгээр нам албан ёсоор квот батлахыг эсэргүүцдэг боловч илүү олон эмэгтэйг нэр дэвшигчээр сонгохын тулд идэвхтэй алхам шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Ийм “уян хатан квотыг” тодорхой тоогоор илэрхийлэхэд хялбар биш. Гэхдээ улс төрийн янз бүрийн байгууллагад илүү олон эмэгтэйг сонгохыг (хэдийгээр баталгаажуулж чадахгүй ч) өдөөх, идэвхжүүлэх гэсэн тодорхой зорилготойгоор нэр дэвшүүлэх үйл явцад нөлөөлөн, эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх бодитой арга хэмжээ авахыг эрмэлздэгээрээ албан ёсны квоттой дүйцэх үүрэг гүйцэтгэж байдаг¹²⁵. Заримдаа нэр дэвших боломжтой эмэгтэйчүүдэд намаас анхаарал хандуулахад нөлөөлөх зорилгоор ч квот гэдэг нэр томьёог ашиглахад хүрдэг. Ийм ч учраас хэдий ижил зорилго агуулж байгаа ч уян хатан квот нь албан ёсны квотын бодлогын үзэл санаа, зорилгоос арай ухарсан арга хэмжээ юм.

→ Мажоритар тогтолцоонд намын квотын нэг хэлбэр болгон “зөвхөн эмэгтэйчүүдийн жагсаалт”- ашиглах нь

Сонгуулийн мажоритар тойрог, тогтолцоонд намаас нэр дэвших эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нэг арга нь “эмэгтэйчүүдийн жагсаалт” ашиглах явдал юм. Өөрөөр хэлбэл, пропорциональ тогтолцооны нэр солбин байршуулах буюу “цахилгаан товчны” аргатай адил үр дүн бий болгохын тулд тодорхой тойрогт зөвхөн эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлнэ гэсэн үг. Европын Зөвлөлийн Парламентын ассамблейн 2010 оны 1899 тоот “Сонгуулийн тогтолцоогоор дамжуулан улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх нь” зөвлөмжид “улс төрийн намууд дотроо жендэрийн заавал биелүүлэх шинэлэг квот тогтоох, буюу “эмэгтэйчүүдийн жагсаалт” эсвэл “хосолмол тойрог” бий болгох, түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг үр дүнтэй болгох замаар нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг мажоритар тогтолцоотой улс орнуудад уриалсан¹²⁶.


1997 онд Тони Блэйрийн Шинэ хөдөлмөрийн намаас (Хөдөлмөрийн намыг нэрлэсэн Блэйрийн шинэ нэр томьёо) 101 эмэгтэй парламентад сонгогдсоноор парламент дах эмэгтэй гишүүний тоо 60-аас 120 болж огцом хоёр дахин өссөн. Үүнд Хөдөлмөрийн намаас тухайн үед баримталж байсан “эмэгтэйчүүдийн жагсаалт”-ын бодлого чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Нэгэн үе “эмэгтэйчүүдийн жагсаалт”-ыг хууль бус гэж үзэж байсан ч (2001 онд Хөдөлмөрийн нам ялалт байгуулсны дараахан), 2002 онд Хөдөлмөрийн намын эрх барьж байсан засгийн газраас Хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглох тухай (сонгуульд нэр дэвшигч) хуульд “зөвхөн эмэгтэйчүүдийн жагсаалт”-ыг зөвшөөрсөн өөрчлөлт оруулсан байна. 2005 оны сонгуульд тус намаас эрэгтэйчүүдээс олон тооны эмэгтэй шинээр сонгогджээ: Хөдөлмөрийн намаас шинээр сонгогдсон 40 гишүүний 26 нь эмэгтэй байсан байна¹²⁷.

124 “Statutul Partidului Liberal Democrat din Moldova”, http://www.pldm.md/index.php?option=com_content&view=article&id=158&Itemid=50; “Statutul Partidului Social Democrat”, 2007, <http://psdm.md/?lang=md&menu_id=13>.

125 Mona Lena Krook, Joni Lovenduski and Judith Squires, “Gender Quotas and Models of Political Citizenship”, *British Journal of Political Science*, Vol. 39, No. 4, 2009, pp.781–803.

126 Parliamentary Assembly of the Council of Europe Recommendation 1899 (2010), “Increasing women’s representation in politics through the electoral system”, <<http://assembly.coe.int/Main.asp?link=/Documents/AdoptedText/ta10/EREC1899.htm>>.

127 “United Kingdom General Election, 2005”, Research Paper 05/33, 2005, <<http://www.parliament.uk/documents/commons/>>



Эх сурвалж: АИХЭА-наас дараах бүтээлд тулгуурлан боловсруулав. Үүнд: UNDP and NDI, *Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation*. UNDP/NDI, 2011; and "Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan", OSCE/ODIHR, 2011, <<http://www.osce.org/odihr/78432>>. See Annex 6 for more information on each step in the plan

➔ Намын эмэгтэй гишүүдийг дагуулан сургах хөтөлбөр нэвтрүүлэх

Дагуулан сургах (mentorship) хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн улс төрийн чадварыг сайжруулах нэн чухал бөгөөд зардал багатай арга зам юм. Дагуулан сургах гэдгийг хамтран зүтгэгчдийн хооронд явагддаг хувь хүний түвшний, суралцан, харилцан ярилцах замаар өсч хөгжих харилцаа гэж тодорхойлж болно. Намын эмэгтэй гишүүд сонгуульт албан тушаалд нэр дэвших, сонгуулийн сурталчилгааны ажлын менежер, сонгуулийн ажиглагч, намын удирдагч болоход шаардлагатай чадавх хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ийм хөтөлбөр хэрэгжүүлж болно.

Эмэгтэйчүүдийг дэмжин туслах хамтрагч нь эрэгтэй байх тохиолдолд тэдний туршлага, улс төрд амжилттай шат ахисан арга замаас нь суралцах боломжтой. Эрэгтэйчүүд ч улс төрийн карьерт эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлийн талаар илүү мэдээлэл, ойлголттой болно. Үүний үр дүнд намын эрэгтэй, эмэгтэй гишүүдийн хоорондын мэдээлэл, харилцаа, хамтын ажиллагаа сайжирч, намын дотоод бүтэц тогтолцоо, удирдах албан тушаалд эмэгтэйчүүд оролцохыг эрэгтэйчүүд илүү дэмжих болно. Түүнчлэн улс төрийн туршлагатай эмэгтэйчүүд шинээр элссэн эмэгтэйчүүдээ дэмжин тусалбал мөн л үр дүнтэй. Иймээс нам дотроо эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх зорилгоор удирдлагын зүгээс хэрэгжүүлж болох хамгийн зардал багатай аргын нэг нь энэ хөтөлбөр юм. Ийм хөтөлбөрийн ачаар улс төрд өргөн тохиолддог жендэрийн тэгш бус байдлын талаар намын эрэгтэй, эмэгтэй гишүүдийн аль алиных нь жендэрийн мэдрэмжийг нэмэгдүүлэх бололцоотой. Дагуулан сургах хөтөлбөрийн талаар Дөрөвдүгээр бүлэгт арай дэлгэрэнгүй өгүүлнэ.

→ Улс төрийн чадавх дээшлүүлэх сургалт

Ирээдүйтэй эмэгтэйчүүдийн улс төрийн чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах нь олон эмэгтэй улс төрд хөл тавих, улс төрийн удирдах албан тушаалд хүрэхэд тус дэм болдог. Энэ арга нь эмэгтэйчүүдийн улс төрийн сонирхлыг өдөөж, улс төрд нэн чухал үр чадвар, мэдлэгийг нь хөгжүүлэн, түүнийгээ улс төрийн карьертаа ашиглах бололцоо олгох зорилготой.

Эмэгтэйчүүд улс төрийн албан тушаал хашихад шаардлагатай мэргэжил, боловсрол, туршлагаар эрэгтэйчүүдээс дутахгүй боловч шууд, шууд бус ялгаварлан гадуурхалтын улмаас улс төрийн карьераа эхлүүлэх мэдээлэл, боломж нь эрэгтэйчүүдээс дутуу байх явдал гардаг. Иймд улс төрд хөл тавьсан эмэгтэйчүүдэд улс төрийн удирдагчийн албан тушаалд хүрэх, улс төрийн зорилгоо таниулан ойлгуулахад нь тулгарч буй жендэрээс үүдэлтэй бэрхшээлийг хэрхэн даван гарах талаар нэмэлт дэмжлэг, сургалт хэрэгтэй байдаг. Улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх нь эмэгтэй удирдагчийн шинэ үеийг өсгөж өндийлгөх чухал арга зам тул аливаа улс төрийн намын зүгээс эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээнийх нь нэг чухал хэсэг болж байдаг.

Шигтгээ 3.19. Улс төрийн намуудын бүл

Либерал интернационал: 1947 онд байгуулагдсан.

Социалист интернационал: 1951 онд байгуулагдсан.

Олон улсын ардчилсан Эвлэл: 1983 онд байгуулагдсан.

Зүүний ардчилсан интернационал: 1961 онд байгуулагдсан.

Глобал ногоон: 2001 онд байгуулагдсан.

Намуудын интернационал (Pirate Parties International): 2010 онд байгуулагдсан.

Чадавх дээшлүүлэх хөтөлбөр голдуу сонгуульд өрсөлдөж байгаа, өрсөлдөх бодолтой эмэгтэйчүүдэд зориулагдсан байдаг. Энэ тохиолдолд сургалт нь сонгуулийн сурталчилгааны ажлын төлөвлөлт, арга техник, санхүүжилт олох, хэвлэл мэдээлэлтэй ажиллах, сонгогчидтой харилцах, иргэдэд хүрч ажиллах зэрэг асуудлыг хамруулж болох юм. Ийм сургалтыг зохион байгуулахдаа намын эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжтэй хамтарч болох ч сургалтыг үр дүнтэй болгох төсөв хөрөнгө олгох нь чухал.

Түүнээс гадна гадаадын улс төрийн намын дэргэдэх сангаас дэмжлэг авах боломж бий. ЕАБХАБ-ын бүс нутагт хамрагдах ардчилал хөгжсөн улс орнуудын улс төрийн намуудын дэргэдэх сангууд сургалт, санхүүжилт, мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар хуучин социалист орнуудын улс төрийн намын

хөгжлийг дэмжсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Ингэхдээ үзэл баримтлалын чиглэлийн дагуу хамтарч ажилладаг. Тухайлбал, Германы Конрад Аденауэрын сан¹²⁸ нь Христийн ардчилсан намуудтай, Ханс Зайделийн сан, Фридрих Науманы сан нь либерал намуудтай, Фридрих Эбэртийн сан нь социал демократ намуудтай идэвхтэй хамтран ажилладаг¹²⁹. Төв болон Зүүн Европ, Төв Азийн улс орнуудад зориулж АНУ-аас санхүүжүүлдэг олон намын төслийг Олон улсын Бүгд найрамдахчуудын хүрээлэн, Ардчиллын үндэсний хүрээлэн¹³⁰ хариуцан хэрэгжүүлдэг. Мөн Ардчиллын төлөөх Вестминстерийн Хүрээлэн¹³¹, Олон намын ардчиллын төлөөх Нидерландын хүрээлэн¹³² зэрэг олон сан нам хоорондын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих ажил хийдэг. Эдгээр сангийн зарим нь үзэл баримтлал нэгтэй намуудыг дэмжин ажилладаг бол улс төрийн бүхий л намтай хамтран ажилладаг сан ч бий.

128 Konrad-Adenauer-Stiftung, <<http://www.kas.de/>>.

129 Pippa Norris, "Building political parties: Reforming legal regulations and internal rules", International IDEA, 2005, p. 15.

130 National Democratic Institute for International Affairs (NDI), <<http://www.ndi.org/>>.

131 Westminster Foundation for Democracy (WFD), <<http://www.wfd.org/>>.

132 Netherlands Institute for Multiparty Democracy (NIMD), <<http://www.nimd.org/>>.

Улс төрийн намуудын болон улс төрч, бодлого боловсруулагчдын олон улс, бүс нутгийн сүлжээ олон бий (Шигтгээ 3.19). Жишээлбэл, 1947 онд байгуулагдсан Либерал интернационал, 1951 онд одоогийн хэлбэрээрээ байгуулагдсан Социалист интернационал, 1983 онд байгуулагдсан Христийн ардчилсан улс төрчдийг нэгтгэдэг Олон улсын ардчилсан Эвлэл, дэлхийн өнцөг булан бүрийн ногоон намын гишүүдийг нэгтгэдэг Глобал ногоон зэрэг холбоог нэрлэж болно.

Олон улсын намын байгууллагын дэмжлэгтэй сургалтын нэгжишээ нь Норвегийн Хөдөлмөрийн намын эмэгтэй гишүүдийн боловсруулсан “Эмэгтэйчүүд чадна” сургалт юм. Норвегийн ардын тусламж гэдэг хөтөлбөрийн дэмжлэгтэй явагддаг энэ сургалт нь Албани, Беларусь, Босния Герцоговина, Хорват, Молдав, Монтенегро, Серб зэрэг ЕАБХАБ-ын гишүүдийг оролцуулан 25 гаруй улс оронд нэр дэвшигч эмэгтэйчүүдэд зориулсан сургалт зохион байгуулдаг. Сургалтын агуулгад ардчилал, эмэгтэйчүүдийн оролцоо, бодлогын асуудал, улс төрийн харилцааны ур чадвар, олон нийтийн өмнө ярих урлаг, мэтгэлцээнд оролцох, хэвлэл мэдээлэлтэй харилцах, хэлэлцээр хийх, хамтын ажиллагаа хөгжүүлэх, нөлөөллийн ажил зэрэг сэдэв багтдаг аж. Эмэгтэйчүүдийг сургахын зэрэгцээ танилцах, сүлжээ, хамтын ажиллагаа хөгжүүлэх бололцоо бий болгодогт сургалтын нэг ач холбогдол оршдог¹³³.

Улс төрийн намын удирдлагууд өөрийн улс орны бусад нам, ижил төстэй үзэл баримтлал бүхий намуудтай хамтран эмэгтэй нэр дэвшигчийн чадавх дээшлүүлэх ажил зохион байгуулах асуудлыг авч үзэх нь зүйтэй. Энэ зорилгоор дотоод, гадаадын төрийн бус байгууллага, засгийн газар хоорондын байгууллагатай ч хамтран ажиллаж болно (иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийн талаар Тавдугаар бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ). Улс төрийн намаас зохион байгуулж буй чадавх дээшлүүлэх ийм ажилд намын удирдлагаас тодорхой төсөв хуваарилан, сургалтын өмнө эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, намын удирдах түвшинд ажиллахыг нь хөхиүлэн дэмжих нь хамгаас чухал.

→ Эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөхийг нь хөхиүлэн дэмжих

Хэрэв эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөх итгэлгүй, дэмжлэггүй байвал одоо байгаа эрэгтэйчүүдэд тааламжтай эрх мэдлийн харьцаа хэвээр үлдэнэ. Улс төр бол эрэгтэйчүүдийн ажил гэж үздэг байсан эрт дээр үеийн уламжлал, хэм хэмжээ нь

Шигтгээ 3.20. Хөдөлмөрийн намын Хурал ба Фабиан Эмэгтэйчүүдийн сүлжээний үүрэг, оролцоо

Их Британийн Хөдөлмөрийн намын Жилийн ерөнхий хурлын үеэр Фабиан Эмэгтэйчүүдийн сүлжээ байгууллагаас сурталчилгаа, чадавх дээшлүүлэх төрөл бүрийн ажил зохион байгуулдаг. Тухайлбал, оройн арга хэмжээ, өглөөний цай зэргийг хурлын хөтөлбөрт төлөвлөн тусгуулах замаар намын бусад фракц, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчидтэй хамтын ажиллагаа, түншлэл бий болгохыг зорьдог. Тухайлбал, 2013 онд Хөдөлмөрийн намын Санхүү, аж үйлдвэрийн бүлэгтэй хамтран “Бизнес, эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг” сэдвээр салбар хуралдаан, Залуу Фабианчуудын Эрүүл мэндийн сүлжээтэй хамтран “Төрөлт, эхийн эрүүл мэндийн ирээдүй” сэдвээр ойлголт мэдлэг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулжээ. “Эмэгтэйчүүдийн эрх, гадаад бодлогын ирээдүй” сэдэвт салбар хуралдаанд олны танил төрийн бус байгууллагуудыг төлөөлсөн эмэгтэйчүүд, парламентын гишүүд оролцсон байна.

Эх сурвалж: Фабиан эмэгтэйчүүд, <<http://www.fabianwomen.co.uk/2013/08/fabian-womens-network-at-labour-party-conference-2013/>>

133 “Women can do it – an evaluation of the WCDI programme in the Western Balkans”, Gender in Norway, <http://www.gender.no/renderSearchResults?search_string=%22women+can+do+it%22>.

эмэгтэйчүүд улс төрд ороход тээг болдог хэвээр байгаа гэдгийг санаж байх нь чухал¹³⁴. Эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөх шийдвэр гаргахын өмнө маш олон асуудал, хүчин зүйлийг эргэцүүлж үздэг. Үүнд сонгуульд өрсөлдөхтэй холбоотой эрсдэл, цаг хугацаа, улс төрийн сүлжээ, санхүүгийн ивээн тэтгэгч олж чадах эсэхээ үнэлэх, нийгэмд өөрийн эзэлж буй байр сууриа үнэлэх, ялалт байгуулах магадлал, хувь хүний хувьд хэр шийдэмгий, хэр том зорилго тавьж байгаа, гэр бүл, олон нийтийн дэмжлэг, гэр бүл, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага зэрэг багтана. Улс төрийн намын зүгээс эмэгтэйчүүдэд үүрэг хариуцлагаа тэнцвэртэй авч үзэх, сонгуульд өрсөлдөхийг нь олон нийтэд нээлттэйгээр дэмжих, урам зориг төрүүлэх, намын болон сонгуулийн сурталчилгааны ажлын санхүүжилт авахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг нь эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөх шийдвэр гаргахад түлхэц болох чухал алхмууд юм.

Дээрх стратегийн хүрээнд сонгуульд ялсан эсэхээс үл хамааран сонгуульд өрсөлдөж байсан эмэгтэйчүүдийн сүлжээг улс төрийн намаас санаачлан ажиллуулах нь зүйтэй. Улс төрийн намаас тэднийг намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, сонгогчидтой байнгын харилцаатай байхад дэмжлэг туслалцааг нь авах, дараагийн сонгуульд өрсөлдөх сонирхлыг нь хадгалах, сургалт, чадавх дээшлүүлэх ажил зохион байгуулахад хамтрах, сонгуульд дахин нэрээ дэвшүүлэхийг нь хөхиүлэн дэмжих зэргээр идэвхтэй арга хэмжээ авах боломж бий.

Намын их хурлын үеэр намын эмэгтэйчүүдийн байгууллагаас тодорхой үйл ажиллагаа зохион байгуулахыг, эсвэл намын үйл хэрэгт эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмэр, ололт амжилтын талаар тусгайлсан хурал зохион байгуулахыг нь ч дэмжиж болно (Шигтгээ 3.20). Түүнчлэн намын гишүүн эмэгтэйчүүдийн хурал зохион байгуулахад нь ч туслалцаа үзүүлэх боломжтой. Эдгээр үйл ажиллагаа нь шинээр гишүүн элсүүлэхээс гадна соён гэгээрүүлэх, сонгогчдыг мэдээлээр хангах ач холбогдолтой.

→ Хувийн амьдрал, намын ажил, үүрэг хариуцлагаа тэнцвэржүүлэхэд нь эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэх

ЕАБХАБ-ын гишүүн улс орнууд засгийн газар, парламент зэрэг төрийн байгууллагад ажиллаж буй эмэгтэйчүүд (мөн эрэгтэйчүүд)-эд хувийн амьдрал, ажил, үүрэг хариуцлагаа тэнцвэржүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд нэлээд анхаарах болсон. Жишээлбэл, Норвегид хүүхэд нэг нас хүртэлх хугацаанд эцэг эхийн аль аль нь цалинтай чөлөө авах эрхтэй. Хүүхэд асрах үүрэг хариуцлагад эрэгтэйчүүдийг татан оролцуулах зорилгоор аавуудад арван 7 хоногийн амралт олгодог¹³⁵. Австрид хүүхдээ 7 нас хүртэл эцэг эхийн аль аль нь ажлын цагийн хуваариа өөрчлөх боломжтой бөгөөд тэр хугацаа дууссаны дараа ажилдаа бүтэн орон тоогоор эргэн орох эрхтэй¹³⁶. Эстонийн парламентын зөвлөл “3 хүртэлх насны хүүхдээ өсгөх шаардлагатай” бол эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн парламентын гишүүдэд бүрэн эрхээ түр түдгэлзүүлэх өргөдөл гаргахыг зөвшөөрдөг байна¹³⁷. Шведийн парламентад үйл ажиллагаагаа жендэрийн мэдрэмжтэй болгох зорилгоор Жендэрийн Эрх тэгш байдлын талаарх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлдэг бол Данийн парламент хуралдаантай өдрүүдэд оройн 7 цагаас хойш санал хураалт явуулдаггүй аж¹³⁸.

134 Richard L. Fox and Jennifer L. Lawless, “If Only They’d Ask: Gender, Recruitment and Political Ambition”, *The Journal of Politics*, Vol. 72, No. 2, April 2010, pp. 310–326.

135 “Parental benefits and paternity leave”, Norway: the official site in the United Kingdom, <<http://www.norway.org.uk/about-norway/society/welfare/benefits/>>.

136 Bock-Schappelwein, J., Eppel, R. und Mühlberger, U., “Sozialpolitik als Produktivkraft, Study for the Austrian Chancellery”, 2009, <http://www.wifo.ac.at/www/jsp/index.jsp?fid=23923&id=35602&typeid=8&display_mode=2>; Rebecca Ray, Janet C. Gornick and John Schmitt, “Parental Leave Policies in 21 Countries. Assessing Generosity and Gender Equality”, Center for Economic and Policy Research, September 2008/ Revised June 2009, <http://www.cepr.net/documents/publications/parental_2008_09.pdf>.

137 Sonia Palmieri, “Gender-Sensitive Parliaments: A Global Review of Good Practice”, Reports and Documents no.65 (Geneva: Inter-Parliamentary Union, 2011), <<http://www.ipu.org/pdf/publications/gsp11-e.pdf>>

138 Ibid.

Улс төрийн салбарт хөдөлмөрийн хууль тогтоомжийг шууд хэрэглэх нь бэрхшээлтэй байдаг тул хүүхэд асрах эцэг, эхийн чөлөө, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцлийн талаарх хууль тогтоомжийн зүйл заалтыг улс төрийн намын нөхцөлд тохируулан хэрэглэж болно. Тухайлбал, намын хурал, уулзалтын үеэр хүүхэд асрах түр газар, үйлчилгээг зохицуулах, хүүхдээ асарч байгаа намын гишүүдэд тэтгэмж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, уян хатан ажлын цагийн хуваариар ажиллахыг нь зөвшөөрөх зэрэг асуудлыг намын удирдлага, эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид анхаарч хэрэгжүүлэх боломжтой. Түүнчлэн намын эмэгтэй (мөн эрэгтэй) гишүүдийн албаны болон хувийн амьдрал хэрэгцээнд тааруулан, хувийн, гэр бүлийн болон эцэг эхийн чөлөө олгох бодлого, зохицуулалтыг бий болгож болно. Улс төрийн намаас эцэг, эх хүүхдээ асрахад зориулсан намын сан ч байгуулж болно.

3.1.3. Санхүүгийн нөөц болон сонгуулийн сурталчилгааны санхүүжилт олгоход жендэрийн тэгш байдлыг хангах нь

Улс төрийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хөрөнгө дайчилж олох, байгаа хөрөнгө нөөцөө тэгш шударга хуваарилах асуудал чухал үүрэгтэй. Эмэгтэйчүүд эдийн засгийн хөрөнгө нөөцөөс тэгш хүртэж чаддаггүй нь тэдний улс төрийн оролцоог ч хязгаарлаж байдаг бөгөөд энэ нь ялангуяа дараах байдлаар илэрч болно. Үүнд:

- ✓ Зарим хандивлагч, санхүүгийн хувьд дэмжих бололцоотой байгууллага, сүлжээний гадна үлдэх;
- ✓ Эдийн засгийн байдал доогуур, санхүүгийн хувьд хараат бус байж чадахгүй байх;
- ✓ Мэдээлэл, өөртөө итгэх итгэл дутмагаас санхүүжилт олох чадавх сүл байх.

Улс төрийн тогтолцооноос хамааран дээрх бэрхшээл нь эмэгтэйчүүдийн өрсөлдөх чадвар, улмаар улс төрийн карьерт нь ч сөргөөр нөлөөлж болно. Иймээс улс төрийн намын удирдлагууд эмэгтэйчүүдэд хөрөнгө дайчлан босгох арга замаас зааж сургах, сонгуульд ялах эсвэл ядаж сонгуульд эрэгтэйчүүдтэй ижил түвшинд өрсөлдөхөд хүрэлцэх санхүүжилт босгоход нь туслах зэргээр тэдэнд дээрх бэрхшээлийг давж гарах урам зориг өгөх нь чухал. Нэр дэвшигч эмэгтэйчүүдийн хамгийн чухал дэмжигч, ойрын хандивлагч нь нам, намын удирдлага байх ёстой.

→ Улс төрийн намын хөрөнгө санхүүжилтийг хуваарилахтай холбоотой дүрэм журмыг ил тод байлгах

Намын удирдлагаас дэмжлэг авч нэр дэвшихэд тулгардаг хамгийн гол бэрхшээл бол “сонгуулийн сурталчилгааны санхүүжилт олох” чадвар доогуур гэх шалтгаан гэж АИХЭА-ны 2012 оны судалгаанд оролцогчид хариулжээ. Эмэгтэйчүүд улс төрийн шат ахихад тулгардаг гол бэрхшээл нь санхүүгийн боломж хязгаарлагдмал байх явдал гэдэгтэй эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь санал нийлсэн байна. Энэ нь сонгуульд өрсөлдөх итгэл, улс төрийн туршлага, олон нийтийн өмнө ярих чадвар, иргэд, нам, гэр бүл, найз нөхдийн дэмжлэг авахад тулгардаг бэрхшээлээс ч хэцүү гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн хязгаарлагдмал байдал нь сонгуульд нэр дэвшихэд тулгардаг маш том саад бэрхшээл байдаг аж.

Санхүүжилт олоход эмэгтэйчүүдэд илүү хүнд гэдгийг “хөрөнгө чинээний жендэрийн ялгаа” гэх ойлголтоор дамжуулан судалгаагаар нотолсон байна. “Хөрөнгө чинээний жендэрийн ялгаа” гэдэг нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд буй санхүүгийн хөрөнгө нөөц, эдийн засгийн хараат бус байдлын ялгаа, зөрүүг илэрхийлсэн ойлголт юм. Хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс доогуур цалин хөлс авдаг гадна дэлхийн нийт баялгаас өмчилж буй хэмжээ нь ч доогуур байгааг судалгаа

Шигтгээ 3.21. Эмэгтэй нэр дэвшигчдийн гаргасан зардлыг нөхөн олгоё

Канадын Шинэ ардчилсан нам эмэгтэй болон үндэстний цөөнхөөс гаралтай нэр дэвшигчдэд нэр дэвших үеийн хүүхэд асрах зардалд зориулж 500 канад доллар, хол байрлалтай газарт очиж ажиллах зардалд 500 канад доллар, Шинэ ардчилсан намаас сонгогдсон төлөөлөгч тэтгэвэрт гарах болсон тойрогт өрсөлдөх тохиолдолд 500 канад долларын нөхөн олговор өгөх санхүүгийн туслалцааны хөтөлбөр хэрэгжүүлдэг. Ийм хөтөлбөр нь зөвхөн сонгуулийн сурталчилгааны зарим зардлыг нөхөн олгох төдий бус хувийн амьдрал, ажлын үүрэг хариуцлагаа тэнцвэржүүлэхэд ач холбогдолтой байдаг.

Эх сурвалж: Lisa Young, Chapter on Campaign Finance and Women's Representation in Canada and the United States in Funding of Political Parties and Election Campaigns in the Americas. (Stockholm: International IDEA, 2005), p. 137. <<http://www.iknowpolitics.org/en/node/175>>

харуулжээ. Үүний учир шалтгаан нь цалинтай амралт, эрүүл мэнд, ажилгүйдлийн даатгал, татварын хөнгөлөлт, нийгмийн даатгал, хамгаалал зэрэг хөдөлмөр, нийгмийн бодлого эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш үйлчилдэггүйтэй холбоотой. Мөн хүүхэд асрах үүрэг хариуцлагыг эмэгтэйчүүд голлон үүрдгээс баялаг хуримтлуулах бололцоо нь доошилж, хөрөнгө чинээний жендэрийн ялгаа үүсэх бас нэг нөхцөл болдог аж. Эмэгтэйчүүдийн дундаж орлого эрэгтэйчүүдийн орлогын 78 хувьтай тэнцэж байгаа боловч эмэгтэйчүүд баялгийн 36 хувийг л өмчилж, эзэмшдэг байна¹³⁹. Үүнийг сонгуулийн сурталчилгааны ажлын хөрөнгө санхүүтэй холбон авч үзвэл нэр дэвшигч эмэгтэйчүүд улс төрийн ажилд зориулах хөрөнгө мөнгө багатайгаас сонгуульд өрсөлдөх, ялах магадлал нь буурч байдаг гэсэн үг юм.

Иймд эмэгтэйчүүд улс төрд оролцох таатай орчин бүрдүүлэхийн тулд улс төрийн намууд эмэгтэйчүүдэд намын болон сонгуулийн сурталчилгааны хөрөнгө нөөцөөс авч хэрэглэхийг нь дэмжсэн ухамсартай хүчин чармайлт гаргах шаардлагатай. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд чөдөр тушаа болж буй эдийн засаг, санхүүгийн саад бэрхшээлийг арилгахад дэмжлэг үзүүлэх гол арга зам нь намын төсөв, хөрөнгийг хуваарилахтай холбоотой дотоод журам батлан мөрдөх явдал юм.

Наад зах нь намын хөрөнгө нөөцийг хуваарилахдаа тэгш хандах зарчим, ил тод байдлын зарчмыг баримталж эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдэд намын хөрөнгө нөөцийг тэнцвэртэй олгох, санхүүжилт,

улс төрийн дэмжлэг үзүүлэх байгууллагуудад хандах ижил тэгш боломж олгох зэргийг намын дотоод журамд зааж өгөх хэрэгтэй. Түүнчлэн намын удирдлагаас эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжийн ажлыг дэмжих зорилготой намын дотоод сан ч байгуулж болно. Мөн эмэгтэй нэр дэвшигчдийг бүртгэх, нэр дэвшүүлэх хураамжийг түдгэлзүүлэх эсвэл багасгах, сонгогдон ажиллах болон нэр дэвших хугацаанд нь зарим зардлыг намаас нөхөн олгох арга хэмжээ авч болно (Шигтгээ 3.21). Мөн сонгуульд нэр дэвших хөтөлбөрөө олон нийтэд хүргэхэд нь зориулж хэвлэл мэдээллээр төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх зэрэг мөнгөн бус хэлбэрээр нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих арга бий.

Нэр дэвшигч эмэгтэйчүүдэд зориулсан намаас санхүүгийн дэмжлэгийг намын үйл ажиллагааны байнгын механизм болгохын тулд намын удирдлага дараах тодорхой арга хэмжээг санаачлан хэрэгжүүлж болно. Үүнд:

- ✓ Нэр дэвшигч бүртгэх намын хураамжаас (хуулиар тогтоосон хураамж байдаг бол) эмэгтэй нэр дэвшигчдийг чөлөөлөх эсвэл үг зардлыг санхүүжүүлэх зорилгоор сан байгуулах;
- ✓ Намын хандивлагчдын жагсаалтыг эмэгтэйчүүдэд тусгайлан өгөх, эмэгтэй улс төрчдийг дэмжих сонирхолтой хандивлагчдын жагсаалтыг тусгайлан гаргах;

139 Mariko Lin Chang, Shortchanged (New York: Oxford University Press, 2010), p. 3.

- ✓ Нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор санхүүжилт олох тусгай сүлжээ бий болгох, хөрөнгө босгох ажил зохион байгуулах;
- ✓ Эмэгтэйчүүдийн бүлэг, нэр дэвшигч эмэгтэйчүүд болон тэднийг чадавхжуулах сургалтад зориулан намын төсвийн тодорхой хувийг зориуд хуваарилах (улсын төсвөөс олгосон санхүүжилт байдаг бол түүнийг оролцуулан);
- ✓ Сургалтанд хамруулах, олон нийтийн телевиз, радиогоор мэдээлэл хүргэх төлбөргүй цаг олгох, хувийн өмчийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон намын өмч хөрөнгө ашиглах (биет хөрөнгө болон намын хөрөнгө нөөц) зэргээр мөнгөн бус дэмжлэг тусалцаа үзүүлэх;
- ✓ Хөрөнгө мөнгө олох, сонгуулийн сурталчилгааны ажлыг зардал багатай явуулах үр чадварыг хөгжүүлэх сургалт, зөвлөгөө өгөх, нэр дэвшигчийн нэрийг олонд таниулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

Дээрх санаачилгыг намын удирдлага ч, эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид ч гаргаж болно. Гэхдээ гол нгуагжлыг намын бүтэц, зохион байгуулалт, байнгын үйл ажиллагааны нэг хэсэг болгон суулгахын тулд намын удирдлагын (намын гүйцэтгэх хороо, бүгд хурал, намын ерөнхий санхүүч г.м.) дэмжлэгийг авсан байх нь чухал. Түүнчлэн дээрх арга хэмжээг байнгын үндсэн үйл ажиллагааны нэг хэсэг болгон суулгахын тулд намын дотоод журмыг сайтар судалж, уялдуулбал үр дүнтэй. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг байнга албан бусаар зөвшилцөх, тухайн тохиолдол бүрт тохиролцоо хэлэлцээ хийх, үр дүнг нь хүртэж байгаа хүмүүсийг шийдвэр гаргаж, баталж буй албан тушаалтнуудаас хамааралтай байдалд оруулахаас сэргийлэхийн тулд эдгээр арга хэмжээг намын дүрэм, журамд тусган албан ёсны болгох нь зүйтэй.

Дээрх хүчин зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр намын удирдлага (эрх тэгш байдлын төлөө тэмцэгчид болон сонгон шалгаруулах хорооныхонтой хамтран) эмэгтэйчүүдийн сонгуулийн сурталчилгааны ажилд дараах байдлаар тусалцаа дэмжлэг үзүүлэх боломжтой. Үүнд:

- ✓ Санхүүгийн их хөрөнгө нөөц шаардахааргүй, ялангуяа ялалт байгуулах магадлалтай тойрогт эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, намын жагсаалтын эхний байруудад нэрийг нь оруулах;
- ✓ Сонгуулийн сурталчилгааны ажлыг нэгдсэн, мэргэжлийн удирдлагаар хангах. Тухайлбал, сурталчилгааны материалыг нэгдсэн журмаар хөнгөлөлттэй үнээр хэвлэх зэргээр нэр дэвшигч эмэгтэйчүүдэд сонгуулийн сурталчилгааны ажлаа мэргэжлийн түвшинд, зардал багатай явуулахад дэмжлэг үзүүлэх;
- ✓ Санхүүгийн бэрхшээлтэй нэр дэвшигч эмэгтэйчүүдэд хүүхэд асрах болон гэр бүлийн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь тусалцаа үзүүлэх үүднээс санхүүжилт олгох;
- ✓ Нэр дэвшигч эмэгтэйчүүдэд зориулан хувийн санхүүгийн байгууллагатай зээлийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх (хялбаршуулсан нөхцөлтэй).

Улс төрийн оролцох зардал өндөр, улмаар уг зардлыг гаргах санхүүгийн хөрөнгө нөөц байхгүйтэй холбоотой бэрхшээлээс ангижирч чадвал эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөх илүү итгэлтэй, илүү чадвартай байх болно (хөрөнгө нөөцийг эмэгтэйчүүдэд тэнцвэртэй хуваарилах бусад арга замын талаар Дөрөвдүгээр бүлэгт өгүүлнэ).

3.1.4. Жендэрийн асуудлыг намын сонгуулийн сурталчилгааны ажлын нэг хэсэг болгох нь

Жендэрийн асуудлыг намын сонгуулийн стратегийн нэг хэсэг болгох нь сонгуулийн сурталчилгааг үр дүнтэй болгож, бүр ялалт авчрах ч боломжтой. 2012 онд Францын Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигч Франсуа Олланд Ерөнхийлөгч болсон тохиолдолд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлэх 40 үйл ажиллагаа бүхий жагсаалт гарган танилцуулж байжээ (Шигтгээ 3.22)¹⁴⁰. 2004 онд Испанид Хосе Запатеро төрийн үйл хэрэгт эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүчтэй болгож, эмэгтэйчүүдийн болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болно гэж сонгуулийн сурталчилгааны ажлынхаа үеэр амлаж байв. Ерөнхий сайдаар сонгогдсоноос зургаан сарын дараа тэрээр “Би эрэгтэй хүний дээрэнгүй үзлийг эсэргүүцдэг төдийгүй феминист үзэлтэй хүн” гэж мэдэгдэж байжээ. Сонгогдсоноосоо хойш хамгийн анх санаачилсан хууль нь жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сайжруулах өөрчлөлт байв. Тэрээр Эрх тэгш байдлын асуудал хариуцсан яам байгуулсан бөгөөд эмэгтэй, эрэгтэй тус бүр 50 хувийн төлөөлөлтэй Засгийн газрыг Европт анх удаа байгуулсан. Энэхүү Засгийн газарт анх удаа эмэгтэй хүн Испанийн батлан хамгаалахын сайдаар ажилласан байна¹⁴¹.

Шигтгээ 3.22. Францын Ерөнхийлөгчөөр сонгогдсон нэр дэвшигч: Франсуа Олланд

2012 оны 4 дүгээр сарын 13-нд Францын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Франсуа Олланд эмэгтэй, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдлын талаар 40 амлалт танилцуулжээ. Хамгийн эхний амлалт нь төрийн бодлого жендэрийн эрх тэгш байдалд ямар нөлөө үзүүлж байгааг судалж, үнэлгээ, дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Эмэгтэйчүүдийн эрхийн асуудал хариуцсан яамыг Ерөнхий сайдын харъяанд байгуулна гэжээ. Хоёрдугаар амлалт нь жендэрийн асуудлын түгээмэл шинжийг харгалзан яам бүрт жендэрийн эрх тэгш байдлын асуудал хариуцсан газар байгуулна гэсэн байна. Мөн өөрийн кабинетад жендэрийн тэнцлийг хангана гэжээ (22 дугаар амлалт). Улс төрийн намын санхүүжилтийн талаар

тусгайлан авч үзсэн 23 дугаар амлалт нь хууль тогтоох байгууллагын сонгуульд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг адил тоогоор нэр дэвшүүлээгүй улс төрийн намд төсвөөс санхүүжилт олгохгүй байхаар тусгажээ. Түүнчлэн төрийн сонгуульд албан тушаал давхар хашихыг болиулж (24 дугаар амлалт), Үндэсний ассамблейд пропорциональ хуваарилалтыг нэвтрүүлэх (25 дугаар амлалт) болно гэжээ. Энэ мөрийн хөтөлбөрийг бэлтгэхэд нь “Эрх тэгш байдлын лаборатори” хэмээх ТББ тусалсан аж (Тус ТББ-ын үйл ажиллагааны талаар Тавдугаар бүлгээс үзнэ үү). 2012 онд Ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш Олланд 34 гишүүнтэй кабинетыг эрэгтэй, эмэгтэй тэнцүү тооны сайд нараас бүрдүүлж жендэрийн тэнцвэрт байдлыг хангажээ.

*Эх сурвалж: “François Hollande 2012. Election présidentielle 22 avril 2012 40 Engagements Pour L'égalité Femmes – Hommes”, 2012, <http://www.laboratoiredeegalite.org/IMG/pdf/40_Engagements_pour_l_egalite_F-H_Francois_Hollande.pdf>; Agnès Poirier, “Hollande’s cabinet shows Sarkozy how to do gender equality – see, easy”, *The Guardian*, 17 May 2012, <<http://www.guardian.co.uk/commentisfree/2012/may/17/hollande-france-gender-equality>>.*

140 Francois Hollande, “40 Engagements Pour L'égalité Femmes – Hommes”, Laboratoire de l'Égalité, 2012, <http://www.laboratoiredeegalite.org/IMG/pdf/40_Engagements_pour_l_egalite_F-H_Francois_Hollande.pdf>.

141 See, for example: “Jose Zapatero’s feminist agenda”, *The Guardian*, 1 April 2011, <http://www.theguardian.com/world/2011/apr/01/jose-zapatero-feminism-spain>; and <http://www.euroresidentes.com/Blogs/archivesnews/2004_04_18_>.

2010 оны сонгуулийн өмнө Их Британийн Хөдөлмөрийн нам “Эмэгтэйчүүдийн төлөө ялалт” сэдэвт аян эхлүүлжээ. Аяны хүрээнд хэвлэсэн хуудсанд тус намаас эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах талаар хүрсэн бүх ололт амжилтаа жагсаан бичсэн байна¹⁴². Мөн онд болсон парламентын сонгуулиар парламентын доод танхимд өмнөх сонгуулиудтай харьцуулахад хамгийн олон эмэгтэй сонгогдсон байна¹⁴³: 650 гишүүний 143 эмэгтэй байсан бөгөөд үүний 81 нь Хөдөлмөрийн намаас сонгогдсон байв.

Их Британийн Консерватив намын цахим хуудсанд жендэрийн асуудлаар намаас баримталж буй бодлого, эмэгтэйчүүдийн аж байдлын талаарх өмнөх ололт амжилт, ирээдүйн төлөвлөгөөгөө дэлгэрэнгүй мэдээлдэг аж. Энэ талаар Шигтгээ 3.23-аас үзнэ үү.

Шигтгээ 3.23. Их Британийн Консерватив намын эмэгтэйчүүдийн төлөөх үүрэг амлалт

Их Британийн Консерватив намын цахим хуудсанд намын **ерөнхий үүрэг амлалтыг** дурдсан эмэгтэйчүүдэд зориулсан булан бий. Үүнд:

- Бид жендэрийн эрх тэгш байдалд нөлөөлж буй саад бэрхшээлийг үгүй хийнэ.
- Бид эмэгтэйчүүдий эсрэг хүчирхийлэлд цэг тавих арга хэмжээ авч байна.

Дараа нь илүү **тодорхой үүрэг амлалтыг** дурдсан байдаг. Үүнд:

- Топ компаниудад эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх
- Цалин хөлсөнд жендэрийн ялгавартай хандахыг багасгах
- Эмэгтэйчүүд аж ахуй эрхлэхийг дэмжих
- Эцэг эхийн хүүхэд асрах чөлөөг уян хатан зохицуулах явдлыг нэвтрүүлэх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд анхаарал хандуулах

Мөн тухайн асуудалтай холбоотойгоор **өнөөг хүртэл хэрэгжүүлсэн болон цаашид авах арга хэмжээг** дурджээ. Тухайлбал: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд анхаарал хандуулах

Өмнө хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Бид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх засгийн газрын

стратегийг эхлүүлсэн.

- Бид хүчингийн гэмт хэргийн хохирогчдын хандах төвүүдэд жилд 9.8 сая паундын төсөв хуваарилж, урт хугацаанд тогтвортой ажиллах баталгааг хангасан.
- Бид гэр бүлийн хүчирхийллийн тодорхойлолтод 16-18 настай иргэд багтааар болгож, мөн албадсан болон хяналтандаа байлгасан харьцааг хамааруулах өөрчлөлт хийсэн.
- Бид даган мөшгих үйлдэл, хүчирхийллийн айдас төрүүлсэн мөшгих үйлдлийг гэмт хэрэгтэй тооцуулах арга хэмжээ авсан.
- Бид албадан гэрлүүлэхийг гэмт хэрэгт тооцох эсэх талаар зөвлөлгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Цаашид авах арга хэмжээ

- Бид цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод туслалцаа үзүүлэх арга барилыг үнэлэх “Clare’s law” түршилтын төсөл хэрэгжүүлж байна. Дараагийн арга хэмжээний талаар шийдвэр гаргахын өмнө түршилтын үр дүнг анхааралтай судлан үзэх болно.
- Бид албадан гэрлүүлэхийг гэмт хэрэгт тооцох шинэ хуулийг 2013/14 онд батлуулахаар ажиллаж байна.

Эх сурвалж: “Women”, Conservatives, <http://www.conservatives.com/Policy/Where_we_stand/women2.aspx>.

142 “Winning for Women. A guide to what Labour has delivered for women”, United Kingdom Labour Party, 2010, <<http://www.labour.org.uk/uploads/746d1524-6792-d714-252f-e40e1e93b64d.pdf>>.

143 “Women MPs & parliamentary candidates since 1945”, United Kingdom Political info. A source for voters, students, journalists and politicians, <<http://www.ukpolitical.info/FemaleMPs.htm>>.

→ **Намын улс төрийн мэдээлэл, харилцаанд жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг тусгах**

Зүү сонсохоор нэг үз гэдэг үг бий. Намын болон сонгуульт албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нэг үр дүнтэй арга бол илтгэж яриад зогсохгүй эмэгтэйчүүдийг олон нийтэд таниулах, харагдуулах арга билээ. Сонгуулийн сурталчилгааны ажлын үеэр эмэгтэй нэр дэвшигч, сурталчилгааны ажлын менежер, идэвхтэн гишүүд ихэвчлэн хөшигний цаана үлдэж, харин намын удирдлага (ихэвчлэн эрэгтэй) сурталчилгааны зурагт хуудас, сурталчилгаа, хэвлэл мэдээллээр гардаг.

Намын цахим хуудас, зурагт хуудас, телевиз, радиогийн болон видео мессеж, сонин хэвлэл, олон нийтийн цахим сүлжээ зэрэг сувгаар эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэйчүүдийг олон нийтэд идэвхтэй танилцуулснаар тэднийг байгаа гэдгийг мэдрүүлэх, нэрийг нь олны танил болгох боломжтой. Түүнчлэн улс төрийн уулзалт цуглаан, сонгуулийн сурталчилгааны ажлын хүрээнд зохион байгуулж буй бусад үйл ажиллагаа, телевизийн мэтгэлцээн, намын өргөн нэвтрүүлэгт эмэгтэйчүүдийг оролцуулах боломж бий.

Ялангуяа эмэгтэйчүүдийг санал өгөхөд уриалах, улс төрийн эрхийнх нь талаар мэдээлэх зорилготой сонгогчдын боловсролын хөтөлбөр, аян хэрэгжүүлэхэд намууд улс төрийн мэдээлэл, харилцааны аргыг ашиглах нь зүйтэй. Ийм хөтөлбөр, аян нь тухайн намд үзүүлэх сонгогчдын дэмжлэгийг дээшлүүлэх төдийгүй тэднийг гэгээрүүлэх өргөн ач холбогдолтой байдаг. Эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тэдний боловсролын түвшин, гэр бүл, ойрын хүмүүсийн нөлөөгөөр санал өгөх магадлал болон тухайн улсын нийгэм соёл, эдийн засгийн орчин нөхцөлийг бодолцох шаардлагатай. Түүнчлэн сонгогчдын боловсролын хөтөлбөр, аяныг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх үе шатанд эмэгтэйчүүдийг зайлшгүй оролцуулах нь чухал¹⁴⁴. Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих талаар тусгайлан эрэгтэй сонгогчдод чиглэсэн боловсрол, мэдээллийн хөтөлбөр, аяныг ч хэрэгжүүлж болно.

→ **Эмэгтэй нэр дэвшигч, сонгуулийн сурталчилгааны ажлын менежер, ажиглагчид, эмэгтэй сонгогчдын аюулгүй байдлыг хангах**

Дэлхий дахинд сонгуулийн бүхий л үе шатанд эмэгтэйчүүд сонгогч, нэр дэвшигч, дэмжигч, эсэргүүцэгчийн хувиар гүйцэтгэх үүрэг нь өсөн нэмэгдэж байна. Сонгуулийн сурталчилгааны ажлын үе, сонгуульд санал өгөх өдөр, сонгуулийн дүнг олон нийтэд зарлах өдөр нь улс орны дотоод улс төрийн амьдралын эмзэг цаг үе байдаг¹⁴⁵. Урьд өмнө нь эмэгтэйчүүд аливаа нэг үйлдэл гэхээсээ эвлэлдэн нэгдсэнийхээ төлөө сонгуулийн үеэр хүчирхийлэлд өртдөг байсан бол “ардчилсан үйл явцад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөхийн хэрээр эмэгтэйчүүд сонгуулийн хүчирхийллийн хохирогч болох хэлбэр олон янз болж байна” гэдгийг саяхны судалгаанд дурдсан байна¹⁴⁶. Улмаар улс төрийн намын нэр дэвшигч, дэмжигч, сонгогчийн хувьд сонгуулийн хүчирхийлэлд эмэгтэйчүүд түрүүлж өртөх нь их байна.

Эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигч, сонгуулийн сурталчилгааны ажлын менежер, ажиглагч, сонгогчдын аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн боловч ЕАБХАБ-ын бүс нутгийн олон оронд сонгуулийн үеийн хүчирхийлэл гарсаар байна. Ялангуяа эмэгтэй улс төрчдийн аюулгүй байдлыг найдвартай хангах нь сонгуульд нэр дэвшиж өрсөлдөх эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлж, хүчирхийллээс шалтгаалан санал өгөхөөс татгалзах сонгогчдын тоог бууруулна.

144 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation, UNDP/NDI, 2011, p.25, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

145 Gabrielle Bardall, “Breaking the Mold: Understanding Gender and Electoral Violence”, International Foundation for Electoral Systems (IFES), White Paper Series, December 2011, <<http://www.ifes.org/Content/Publications/Articles/2011/Breaking-the-Mold-Understanding-Gender-and-EElectoral-Violence.aspx>>.

146 Ibid.

Эмэгтэй нэр дэвшигчдийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийллээс эмээж санал өгөхийг хүсэхгүй байгаа сонгогчдыг ирүүлэх талаар улс төрийн намууд хэд хэдэн арга хэмжээ авах боломжтой. Нэгдүгээрт, сонгуулийн үеэр ямар нэгэн хүчирхийлэл гаргахгүй байхыг сонгуульд оролцож байгаа бүх хүмүүст хандан уриалж болно. Хоёрдугаарт, өөрийн намын гишүүд, дэмжигчдэд сонгуулийн үеэр үймээн дэгдээхгүй байх, хүчирхийлэл үүсгэхгүй байхыг уриалж, үүнийг хянах дотоод тогтолцоо бий болгож болно. Мөн нэр дэвшигчид, сонгогчдын аюулгүй байдлыг хангах үүднээс төрийн хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэг бүхий тусгай ажлын хэсэг байгуулж болно. Хэрэв эмэгтэй нэр дэвшигчдэд шаардлагатай бол хувийн хамгаалалтын албатай хамтран ажиллаж аюулгүй байдлыг нь хангах боломжтой.

→ **Намын гишүүн эмэгтэйчүүдийн тоог өсгөх өнгөц хуурмаг арга хэмжээнээс зайлсхийх**

Намын гишүүн эмэгтэйчүүдийн тоог өсгөх өнгөц, хуурмаг арга хэмжээнээс зайлсхийх нь тухайн улс төрийн нам олон нийтийн дунд эерэг дүр төрх бүрдүүлэх, хадгалах, цаашилбал, сонгуульд амжилттай оролцоход чухал юм. *“Улс төрийн намыг бэхжүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх нь”* гарын авлагад намын зүгээс авч хэрэгжүүлдэг хэд хэдэн “өнгөц хуурмаг” арга хэмжээг дурдсан байдаг¹⁴⁷. Үүнд:

- Эрх хэмжээ, хөрөнгө нөөцийн асуудлыг нь дүрэм журамд тусгаж батлалгүйгээр эмэгтэйчүүдийн байгууллага, нэгж бий болгох;
- Хуульд заасан квотыг л нэр төдий хангах зорилгоор намын нэрийн жагсаалтыг “бөглөх” эмэгтэй нэр дэвшигч сонгох;
- Ялалт байгуулах боломжгүй тойрогт эмэгтэй нэр дэвшигчийг өрсөлдүүлэх;
- Хамгийн сүүлийн мөчид нэрийн жагсаалтаас эмэгтэй нэр дэвшигчийг хасах¹⁴⁸;
- Сонгууль болсны дараахан суудлаа өгөхийг “зөвлөж” эрэгтэй нэр дэвшигчээр солих;
- Сонгогдсоных нь дараа эмэгтэйчүүдийг үл тоох.

Зөвхөн сонгуульд ялахын тулд жендэрийн эрх тэгш байдлын талаар уран яруу ярьдаг бөгөөд эмэгтэйчүүдийг улс төрийн хувьд ахиж дэвшихэд үнэн хүчин чармайлт гаргадаггүй намууд дээр дурдсан аргуудыг хэрэглэдэг байна.

3.1.5. Жендэрийн мэдрэмжтэй засаглалыг хөхиүлэн дэмжих нь

Энэ хэсэгт засгийн эрх барих эрх бүхий намаар сонгогдсоны дараа эсвэл хамтран засаг барих эвсэлд нэгдсэн эсвэл парламентын цөөнх болсон тохиолдолд жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих талаар улс төрийн намууд ямар үүрэг гүйцэтгэх боломжтой талаар авч үзнэ. Засгийн эрхийг авсан бол одоо тэр эрх мэдлийг ашиглан хийж бүтээх цаг ирлээ гэсэн үг.

147 Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women’s Political Participation, UNDP/NDI, 2011, p.25, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.

148 “Democracy and the Challenge of Change. A Guide to Increasing Women’s Political Participation” (Washington: National Democratic Institute for International Affairs (NDI), 2010), <http://www.ndi.org/Democracy_and_the_Challenge_of_Change>.

→ **Хууль тогтоох байгууллагад жендэрт ээлтэй шинэчлэл явуулах**

ЕАБХАБ-ын гишүүн бүх улс оронд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих бодлого, хууль тогтоомж батлагдсан ч төрийн байгууллагуудад, түүний дотор парламент ч жендэрийн хувьд тэнцвэргүй хэвээр байна. Энэ нь төрийн үүрэг хариуцлагыг зөвхөн эрэгтэйчүүд сонгогдон ажиллаж байсан тэр үеийн ойлголтоор тодорхойлсон дүрэм журам одоо ч мөрдөгдсөөр байгаатай холбоотой юм. Парламентыг жендэрийн мэдрэмжтэй болгоё гэвэл хууль тогтоох байгууллагад жендэрт ээлтэй шинэчлэл явуулах нь нэн чухал билээ.

Парламентад сонгогдсоныхоо дараа ч гэсэн эмэгтэйчүүд өрх гэрийн үндсэн үүрэг хариуцлагаа гүйцэтгэсэн хэвээр байдаг. Парламентын гишүүдтэй хийсэн ярилцлагын судалгаагаар хүүхэд асрах чөлөөг зохицуулсан журам, хуралдааны үргэлжлэх хугацаа, ажлын ерөнхий хуанли, парламентын газар зүйн байршил, хүүхэд асрах байгууллага, үйлчилгээг анхаарах нь эмэгтэй гишүүдэд дэмжлэг болно гэжээ¹⁴⁹. Парламент дах байгууллагын соёл, үйл ажиллагааны журам, улс төрийн уур амьсгалд судалгаа эсвэл жендэрийн аудит хийвэл эмэгтэй гишүүдийн идэвхтэй оролцоонд саад болж буй тохиромжгүй практикийг тодорхойлон, анхаарч авч үзэхэд ач холбогдолтой.

Зураг 3.24. Италийн парламентын гишүүн Licia Ronzulli охинтойгоо Европарламентын хурал дээр



Эх сурвалж: <<http://grradio.tistory.com/2>>.

149 Sonia Palmieri, "Gender-Sensitive Parliaments. A Global Review of Good Practice", Reports and Documents no.65, Inter – Parliamentary Union, 2011, <<http://www.ipu.org/pdf/publications/gsp11-e.pdf>>.

Парламентад сонгогдсон улс төрийн намууд парламентын бодлого, практикийг жендэрт ээлтэй болгох ажлыг манлайлан хэрэгжүүлж болно. Тухайлбал, парламентын ажлын хуанлиг сургуулийн хуанлитай уялдуулах, эцэгт хүүхэд асрах чөлөө олгохыг хөхиүлэн дэмжих (зөвхөн эхэд олгох бус), хүүхэд асрах үйлчилгээ зохион байгуулах, оройн цагаар болон амралтын өдөр хурал, уулзалт төлөвлөхгүй байх зэргийг дурдаж болох юм. Ийм санаачилга нь сонгуульт албан тушаалд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар улс төрийн намаас гаргаж буй хүчин чармайлтын илэрхийлэл төдийгүй улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих сонгуулийн амлалтаа биелүүлэхэд нь түсална.

Парламентыг жендэрийн мэдрэмжтэй болгох санал боловсруулах ажлын хэсгийг Шведийн Риксдаг буюу парламентад байгуулж байсан туршлага бий. Тус ажлын хэсэг жендэрийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх шинэчлэлд парламентын удирдлагын гүйцэтгэх үүргийг онцолсон “Риксдагт жендэрийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх 15 санал” хэмээх баримт бичиг боловсруулж байжээ. 2006 онд парламентад дарга буюу спикер ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн парламентад төлөөлөлтэй бүх улс төрийн намыг оруулсны үр дүнд жендэрийн эрх тэгш байдлыг баталгаажуулах үүднээс парламентын авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тодорхойлсон Жендэрийн эрх тэгш байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг (эхнийх нь 2006-2010 онд, удаах нь 2010-2014 онд) баталсан байна¹⁵⁰.

→ Жендэрийн эрх тэгш байдлын хууль тогтоомжийг сайжруулах

Парламентад жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих шинэчлэлээс гадна энэ чиглэлийн хууль тогтоомж шинээр батлуулах, хэрэгжилтийг сайжруулахад улс төрийн намууд нөлөө үзүүлж чадна. Энэ нь сонгуулийн сурталчилгааны ажлын үеэр сонгогчдод өгсөн амлалтаа биелүүлж байгаа хэрэг юм.

Мөн хууль тогтоомжийн төсөлд жендэрийн үнэлгээ хийж, тухайн хууль тогтоомж эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдэд ямар нөлөөтэйг тодорхойлох практик тогтоох лоббиг улс төрийн намууд хийх бүрэн боломжтой. Үүний зэрэгцээ нам дамнасан эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааны сүлжээ, бүлгийн нэгдсэн санал, шийдвэрийг парламентын спикерт хүргэх, парламентаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгах механизм бий болгох ажлыг улс төрийн нам санаачилж, дэмжин хэрэгжүүлж болно. Парламентад суудалтай намуудын хэрэгжүүлж болох өөр нэг арга хэмжээ бол жендэрийн асуудлаарх олон улсын хэм хэмжээ, бусад мэдээллийг өөрийн улсын хэл дээр орчуулж түгээх мэдээллийг аянг санаачлан хэрэгжүүлэх, дэмжих явдал юм.

Тухайн улс орны жендэрийн холбогдолтой хууль тогтоомжийн байдлаас хамааран парламентад суудалтай улс төрийн намууд дараах саналыг дэвшүүлэн хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

Шигтгээ 3.25. Жендэрийн мэдрэмжтэй парламентууд

Парламентыг жендэрийн мэдрэмжтэй болгох шинэчлэл хийхэд парламентын удирдлагад тус дөхөм үзүүлэх үүднээс “Жендэрийн мэдрэмжтэй парламентүүд: Дэлхий дахины сайн туршлага” хэмээх гарын авлагыг Олон улсын парламентын холбооноос бэлтгэн хэвлүүлжээ.

Эх сурвалж: *Sonia Palmieri, Gender-Sensitive Parliaments, Inter-Parliamentary Union, Reports and Document No. 65, 2011. Available at: <<http://www.ipu.org/pdf/publications/gsp11-e.pdf>>.*

150 See Hillevi Engström, “Gender Sensitive Parliaments: The Swedish Experience”, in Is Parliament Open to Women? An Appraisal, Inter-Parliamentary Union Conference, 28–29 September 2009, Available at: <<http://www.ipu.org/pdf/publications/wmn09-e.pdf>>.

- Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль;
- Төрийн сонгуульд албан тушаал, төрийн албан дахь жендэрийн квотыг Үндсэн хууль эсвэл бусад холбогдох хуульд (улс төрийн намын тухай, төрийн албаны тухай зэрэг) тусгах;
- Жендэрийн мэдрэмж сайтай улс төрийн намд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх, үүнд зөвхөн мөнгөн урамшуулал бус, сонгуулийн сурталчилгааны ажлын үеэр төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглах боломж зэрэг мөнгөн бус урамшууллыг хамруулах;
- Хангалттай эрх мэдэл, санхүүгийн хөрөнгө нөөц бүхий жендэрийн эрх тэгш байдлын асуудал хариуцсан хараат бус байгууллагыг байгуулах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх мониторингийн механизмыг бий болгох.

→ Улс төрийн намд төсвөөс олгох санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах

Намын төсөв, хөрөнгө нөөцийг эрэгтэй, эмэгтэй гишүүдэд хуваарилахад байгууллагын бүтэц тогтолцоо, дүрэм журам чухал нөлөөтэй. Канад зэрэг ЕАБХАБ-ын зарим улсад хүүхэд, гэр бүлээ асрах болон өрх гэрийн үүрэг хариуцлагаа гүйцэтгэхтэй холбоотой зардалд сонгуулийн сурталчилгааны ажлын санхүүжилтээс хэрэглэхийг хуулиар зөвшөөрсөн байдаг¹⁵¹.

Улсын төсвөөс намуудад санхүүжилт олгодог орнуудад улс төрд жендэрийн эрх тэгш байдлыг хангах өөр нэмэлт механизмууд бий (Хүснэгт 3.26). Санхүүгийн хөрөнгө нөөцийн тэгш бус хуваарилалтаас үүдэлтэй жендэрийн тэгш бус байдлыг арилгах зорилготой хууль тогтоомж нь дараах гурван асуудлын аль нэгийг зохицуулсан байдаг. Үүнд: эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөхөд зөвхөн тэдэнд тусдаг эсвэл тэдэнд харьцангуй хүндээр тусдаг зардал; улс төрийн нам улсын төсвөөс олгох санхүүжилтийг хүлээн авч, хуваарилж буй байдал; их хэмжээний хандив болон зарлагад тодорхой хязгаар тогтоох.

Сайтар бодож боловсруулсан улс төрийн санхүүжилтийн тогтолцоо нь эмэгтэй нэр дэвшигчийн хамгийн сайн найз нөхөр гэж хэлэхэд болно. Учир нь их хэмжээний хувийн хандив (ихэвчлэн эрэгтэйчүүдэд л олддог)-ын оронд улсын төсвөөс намуудад санхүүжилт олгох тогтолцоонд шилжсэнээр хувийн баялаг, санхүүжилт олох чадварыг чухалчлахаа больдог тул эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн өрсөлдөөний талбар харьцангуй тэгш болж ирдэг. Хууль тогтоомжийн ийм зохицуулалтаас гадна улсын төсвийн санхүүжилтийг нэр дэвшигчийн мерит буюу чадвар, хэрэгцээ, боломжид тулгуурлан хуваарилах, эсвэл ивээн тэтгэгчийн дэмжлэг муутай эмэгтэйчүүд зэрэг тодорхой бүлгийг дэмжих зорилготойгоор хуваарилдаг байхаар намын дотоод журмыг батлан мөрдөж болно.

Түүнчлэн төрөөс намын жагсаалтдаа заасан хувь хэмжээний эмэгтэй нэр дэвшигчдийг оруулсан улс төрийн намд л улсын төсвийн санхүүжилт олгох зэргээр жендэрт ээлтэй байдлыг харгалзан үзэх зохицуулалтыг ч бий болгож болно. Францад нэр дэвшигчдийн 50 хувь нь эрэгтэй, 50 хувь нь эмэгтэй байх квотын шаардлагыг зөрчсөн хувь хэмжээгээрээ намууд торгууль төлдөг аж. Гэхдээ энэ нь том, жижиг намуудад өөр

151 Canada Elections Act § 409(1) “Personal expenses of a candidate are his or her electoral campaign expenses, other than election expenses, that are reasonably incurred in relation to his or her campaign and include (a) travel and living expenses; (b) childcare expenses; (c) expenses relating to the provision of care for a person with a physical or mental incapacity for whom the candidate normally provides such care; and (d) in the case of a candidate who has a disability, additional personal expenses that are related to the disability”. <<http://www.elections.ca/content.aspx?section=res&document=index&dir=loi/fel/cea&lang=e>>.

өөр үр дагавартай байсныг анхаарах хэрэгтэй болов уу. Энэ тохиолдолд жижиг намууд улсын төсвийн санхүүжилтээс хараат болж хувирдаг бол том намууд олон эрэгтэй нэр дэвшигчтэй байх “чадвартай” болдог байна¹⁵².

Хэрэв эмэгтэйчүүд бүх нийтийн сонгуульд нэр дэвшигчдийн 30 (хожим 40) хувьд хүрэхгүй байвал тухайн намд улсын төсвөөс олгох санхүүжилтийг тал хувиар хасах хуулийн шинэчлэлийг Ирландад саяхан хийсэн байна¹⁵³. Гүржийн 2012 оны сонгуулийн хуулиар “шаардлага хангасан” буюу сүүлийн парламентын сонгуульд доод тал нь 4 хувийн санал авсан, сүүлийн орон нутгийн сонгуульд доод тал нь 3 хувийн санал авсан намуудад парламентын болон орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэхийг нь дэмжих зорилгоор санхүүгийн урамшуулал олгох заалт шинээр оруулжээ. Түүнчлэн 5 хувийн босго давсан улс төрийн намуудад хэрэв 10 нэр дэвшигч түтмын наад зах нь 2 нь эмэгтэй бол улсын төсвөөс нэмэлт 10 хувийн санхүүжилт олгохоор заасан байна¹⁵⁴. Санхүүгийн урамшууллын энэхүү зохицуулалт нь 2012 оны 10 дугаар сард болсон Гүржийн парламентын сонгуулийн үеэр томоохон улс төрийн намуудад хангалттай нөлөө үзүүлж чадаагүй тул 2013 оны 8 дугаар сард улс төрийн намууд тус хуулийн заалтыг эргэн харж, улсын төсвөөс олгох санхүүжилтийг нэмэгдүүлэхээр санал нэгджээ. Ингээд 2013 оны 8 дугаар сард Улс төрийн эвлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулж, намын жагсаалтын 10 нэр дэвшигч тутам наад нь 3 эмэгтэй нэр дэвшигчтэй байх, үүнтэй уялдуулан санхүүжилтийг 10 хувиас 30 хувь болгож нэмэгдүүлэхээр болсон байна (30х30 дүрэм гэж нэрлэх болсон энэхүү өөрчлөлт нь нэр дэвшигчдийн наад зах нь 30 хувь эмэгтэйчүүд байх тохиолдолд улсын төсвөөс 30 хувийн нэмэлт санхүүжилт олгоно гэсэн утгатай)¹⁵⁵.

Хүснэгт 3.26. Улсын төсвийн санхүүжилтээ нэр дэвшигчдийн жендэрийн эрх тэгш байдалтай уялдуулсан ЕАБХАБ-ын гишүүн улс орнууд

Улс орон	A1	Хуулийн зүйл, заалт	A2
Серби	Тийм	Намын жагсаалтад эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн төлөөлөл наад зах нь 1/3 байхыг сонгуулийн хуулиар шаарддаг. Энэ шаардлагыг хангаагүй улс төрийн намууд сонгуулийн үйл явцад оролцох болон улсын төсвөөс санхүүжилт авах боломжгүй.	33
Португал	Тийм	Нэр дэвшигчдийн жендэрийн тэнцвэрийг хангаагүй нам улсын төсвөөс олгох санхүүжилтийн 25-80 хувийг алддаг.	29
Франц	Тийм	Нэр дэвшигчдийн жендэрийн ялгаа 2 хувиас дээш гарвал энэ зөрүүний 3/4 –аар улсын төсвөөс олгох санхүүжилтийг бууруулдаг.	27
Хорват	Тийм	Парламентын гишүүн бүрт олгодог санхүүжилтийн 10 хувьтай тэнцэх нөхөн олговрыг төлөөлөл доогуур хүйсээс сонгогдсон парламентын гишүүн бүрийн тоогоор улс төрийн намд олгоно.	24
Босни Герцоговин	Тийм	Улсын төсвийн санхүүжилтийн 10 хувийг “төлөөлөл доогуур хүйсийн” авсан суудлын тоонд харьцуулан намуудад хувааж олгоно.	22

152 Rainbow Murray, Parties, Gender Quotas, and Candidate Selection in France (London: Palgrave, 2010).

153 “Political Finance data for Ireland”, International IDEA, Political Finance Database, <<http://www.idea.int/political-finance/country.cfm?id=102>>.

154 Article 30(71), Organic Law of Georgia on Political Union of Citizens, 1997. See “Political Finance Database”, Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), <<http://www.idea.int/political-finance/question.cfm?id=281>>.

155 See “Change of Party Funding Rules Proposed”, Civil Georgia, 23 July 2013, <<http://www.civil.ge/eng/article.php?id=26299>>.

Ирланд	Тийм	Нэр дэвшигчдийн дунд аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувьд хүрэхгүй нөхцөлд тухайн намд санхүүжилтийнх нь 50 хувийг олгохгүй (2012 онд бий болгосон журам. 2020 оноос хойш 30 хувийн шаардлагыг 40 хувь болгохоор хуульд заасан).	15
Итали	Тийм	2004, 2009 оны Европын парламентын сонгуулийн үеэр аль нэг хүйсийн төлөөлөл намын жагсаалтад сонгогдсон нэр дэвшигчдийн 2/3-оос илүүгүй байх шаардлага тавигдаж байсан. Энэ зүйл заалтыг биелүүлээгүй нөхцөлд зөвшөөрөгдсөн хязгаараас илүү гарсан нэр дэвшигчдийн тоогоор улс төрийн намд олгох сонгуулийн кампанит ажлын татаасыг бууруулж олгоно (50 хүртэл хувиар). Олгогдоогүй санхүүжилтийг хуулийг биелүүлсэн бусад улс төрийн намд “урамшуулал” болгож олгоно.	22
Гүрж	Тийм	2011 оны 12 дугаар сард оруулсан нэмэлтээр намын жагсаалтад аль аль хүйсийн төлөөллийг наад зах нь 20 хувьд хүргэж хангасан улс төрийн намд улсын төсвийн санхүүжилтийн 10 хувийг нэмж олгоно.	12
Румын	Тийм	Сонгуульд эмэгтэй нэр дэвшигчдийн авсан суудлын тоогоор улсын төсвийн санхүүжилт нэмэгддэг.	11

A1: Улсын төсвөөс улс төрийн намуудад санхүүжилт олгоход нэр дэвшигчдийн жендэрийн эрх тэгш байдлыг харгалзан үздэг эсэх?

A2: Парламент дах эмэгтэйчүүдийн хувь хэмжээ

Эх сурвалж: “Political Finance Database”, Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), <<http://www.idea.int/political-finance/index.cfm>>; “Women in national parliaments”, Inter-Parliamentary Union, December 2012, <<http://www.ipu.org/wmn-e/classif.htm>>.

Улсын төсвөөс олгох санхүүжилтийг намын жагсаалт дах жендэрийн эрх тэгш байдалтай уялдуулахаас гадна тус санхүүжилтийн зарцуулалтыг ч жендэрийн асуудалд чиглүүлэх талаар нам дотооддоо дэвшилтэт алхам хийх боломжтой. Тухайлбал, Финляндын хуулиар “Бүх улс төрийн нам жилийн татаасынхаа 12 хувийг намын эмэгтэйчүүдийн байгууллагыг санхүүжүүлэхэд ашиглана” гэж заасан байдаг бол Ирланд, Италид улсын төсвийн санхүүжилтийн талаарх хуулийн заалтад эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд ашиглахыг үүрэг болгосон байдаг¹⁵⁶. Ирландын сонгуулийн хуулийн 18 дах хэсэгт “Шаардлага хангасан улс төрийн намуудад олгосон санхүүжилтийн тодорхой хэсгийг эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн үйл ажиллагааг дэмжихэд зарцуулна” гэж заажээ¹⁵⁷.

Хуулийн зохицуулалтаас шалтгаалахгүйгээр намын болон сонгуулийн сурталчилгааны ажлын санхүүгийн тайланд тавигдах шаардлагыг хангах зэргээр сурталчилгааны ажлын эрүүл орчин бүрдүүлэх талаар улс төрийн намын удирдлагууд анхаарах ёстой юм. Улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод, хариуцлагатай байлгах нь цаашид улс төрийн үйл явцыг илүү ардчилсан, оролцоог хангасан болгох бөгөөд энэ нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алинд ашигтай билээ.

156 “Political Finance Database”, Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), <<http://www.idea.int/political-finance/question.cfm?id=281>>.

157 Ibid.

Гуравдугаар бүлгийн дүгнэлт

Гарын авлагын энэ хэсэгт намын бүхий л үйл явц, бүтэц тогтолцоонд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, ахиц дэвшлийг дэмжих зорилгоор улс төрийн намаас сайн дурын үндсэн дээр авч хэрэгжүүлж болох төрөл бүрийн стратеги, арга хэмжээний талаар авч үзлээ. Намууд улс төрийн оролцоог сахиулагч гол субъект гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс эхлээд эмэгтэйчүүдийг улс төрийн шат ахихад тус дөхөм үзүүлж буй эсвэл саад тотгор болж буй намын бодлого, үйл явц, дүрэм журам, практикийн талаар энэ хэсэгт дэлгэрэнгүй оруулав. Намын дотоод дүрэм журамд эмэгтэйчүүдийг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхсан байдлыг өөрчлөх болон намын суурь баримт бичгүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг баталгаажуулах үйл явцыг анхааран авч үзлээ. Намд гишүүн элсүүлэх, нэр дэвшигч сонгох, албан тушаал дэвшүүлэх, хөрөнгө нөөц хуваарилах зэрэг намын дотоод тодорхой үйл явцад жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх талаар намын удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж болох хэд хэдэн арга хэмжээний саналыг танилцуулсан. Төгсгөлд нь, улс төрийн намуудын сонгуулийн стратеги болон засаглалын үйл явцаар дамжуулан улс төрд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих талаар намууд ямар ажил хийж болох тухай авч үзэв. Дараагийн бүлэгт улс төрийн шат ахихын тулд эмэгтэйчүүд өөрсдөө юу хийх, намын өдөр тутмын үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг нэвтрүүлэхэд намын удирдлага, шийдвэр гаргагчдын дэмжлэгийг хэрхэн авах талаар тусгайлан авч үзэх болно.

Улс төрийн нам дахь эмэгтэйчүүд

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

Дөрөвдүгээр бүлгийн оршил

4.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?

- 4.1.1. Карьераа амжилттай хөгжүүлж, улс төрийн албан тушаал ахих
- 4.1.2. Эмэгтэйчүүд өөр хоорондоо хамтран ажиллах, хамтын сонирхлыг хөндсөн асуудлаар нэгдэж ажиллах
- 4.1.3. Улс төрийн намын бодлого, журам, практикт жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх

Дөрөвдүгээр бүлгийн дүгнэлт

Дөрөвдүгээр бүлгийн оршил

ЕАБХАБ-ын бүс нутагт эмэгтэйчүүд улс төрд орох нь олширч байна. Гэвч эмэгтэйчүүдийн тэгш төлөөлөлд хүрэх хол хэвээр байна. Хорин нэгдүгээр зуунд ЕАБХАБ-ын гишүүн олон орны хувьд улс төрийн намын дээд албан тушаал, хууль тогтоох байгууллагад ажиллаж буй эмэгтэйчүүдийн төлөөлөл маш доогуур байна. Одоогийн байдлаар улс төрийн цөөн намыг эмэгтэй хүн даргалж, цөөн парламентын дарга, дэд даргаар эмэгтэй хүн ажиллаж байна. (Хоёрдугаар бүлгийг үзнэ үү).

Өмнөх бүлэгт дурдсанчлан, эмэгтэйчүүдийн улс төр, төрийн хэрэгт оролцох гол үүд хаалга нь улс төрийн нам гэдгийг хүлээн зөвшөөрөх нь нэмэгдсэн. Улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн хувьд идэвхтэй байхыг дэмжсэн арга хэмжээ авч, намын үйл ажиллагааны журам, соёлдоо шударга, ил тод, тэгш байдлын зарчмуудыг тусган хэрэгжүүлэхийн хэрээр эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Эсрэгээрээ, улс төрийн намын дүрэм, журам, практик ил тод бус, шууд ба шууд бусаар эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхдаг бол эмэгтэйчүүд улс төрөөс гадуур үлдсэн хэвээр байна.

Улс төрийн намаа эмэгтэйчүүдэд нээлттэй, ээлтэй, тэгш болгохын тулд улс төрийн нам, түүний удирдлагаас хэрэгжүүлж болох арга хэмжээний талаар Гуравдугаар бүлэгт дурдсан билээ. Харин энэ бүлэгт улс төрийн шатаар ахихын тулд эмэгтэйчүүд өөрсдөө юу хийж болох талаар авч үзэв. Тухайлбал, улс төрийн нам дотор жендэрийн тэгш байдлыг институтчилж, албажуулахын тулд эмэгтэй хүн дангаараа хэрэгжүүлэх, эмэгтэйчүүд өөр хоорондоо хамтарч, мөн эрэгтэйчүүдтэй хамтарч хэрэгжүүлэх арга замын талаар авч үзэв.

Энэхүү гурван тулгуурт арга барил нь эмэгтэйчүүд улс төрд тэгш төлөөлөлтэй болох, намын дотоод бүтэц зохион байгуулалт, үйл явцад тэгш оролцоход эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээлийг арилгахад нэн чухал юм. Энэхүү арга барил нь улс төр, төрийн хэрэгт эмэгтэйчүүдийн эдлэх ёстой эрхийн төлөө түүхэн тэмцэлд эмэгтэйчүүдийн (мөн эрэгтэйчүүдийн) хэрэглэж ирсэн янз бүрийн аргыг харгалзан үзсэн болно.

Эмэгтэйчүүдийг төрийн хэрэгт доогуур үзэж, гадуурхаж ирсэн түүхэн уламжлал гашуун үл мөр үлдээсэн билээ. ЕАБХАБ-ын гишүүн орнуудад жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголттой эмэгтэйчүүд тулгардаг хэвээр байна. Эдгээр хэвшмэл ойлголт, төсөөлөл, мөн ялгаварлан гадуурхдаг практикийн улмаас эмэгтэйчүүд улс төрийн тавцанд үр дүнтэй ажиллахад эрэгтэйчүүдээс дутуу бэлтгэлтэй, тэдэнд дэм болох арга хэрэгсэл ч цөөн байдаг. Энэ нь тэд үр чадвар, эрдэм мэдлэг дутуугаас бус харин улс төрийн талбар тэгш бус байгаатай холбоотой юм. Бодит амьдрал дээр улс төр хэрхэн ажиллаж буй байдал нь эдгээр бэрхшээлийг улам ч хүндрүүлдэг. Өрсөлдөж буй улс

Шигтгээ 4.1. Улс төрд ороход эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээл

- Намын эрэгтэй удирдлагууд зүгээс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх хэрэгцээний талаар ойлголт муутай, дэмжлэг үзүүлдэггүй;
- Намын бодлого, мөрийн хөтөлбөрийг боловсруулахад эмэгтэйчүүдийн нөлөө бага байх;
- Намын гүйцэтгэх байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл байхгүй, эсвэл цөөн тоотой байх;
- Намын удирдлагад эмэгтэй хүн байхгүй байх;
- Нам дотроо эмэгтэйчүүдийн байгууллага нь гадуурхагдсан байдалтай байх;
- Улс төрийн албан бус “тоглоомын дүрмийн” талаар ойлголт муутай байх;

Эх сурвалж: “Эмэгтэйчүүдийн улс төрийн намын хөтөлбөрийг үнэлэх нь: сайн туршлага, зөвлөмж” (Washington: NDI, 2008) материалыг ашиглан боловсруулав.

төрчид албан болон албан бус “тоглоомын дүрмээр” ажиллаж байдаг. Гэтэл улс төрд оролцох боломж хязгаарлагдмал байдгаас эмэгтэйчүүд улс төр “бодит амьдрал” дээр яаж ажилладаг талаар ойлголт муутай байдаг. Тиймээс улс төрд амжилт гаргая гэвэл эмэгтэйчүүд улс төрийн тогтолцооны мэргэжлийн болон албан ёсны ойлголттой болохоос гадна улс төрийн янз бүрийн намууд дотроо болон өөр хоорондоо улс төрийн ямар тоглоомын дүрмээр тоглодогийг мэдэх шаардлагатай.

Шигтгээ 4.2. Эмэгтэйчүүд яагаад улс төрд ордоггүй вэ?

- **Институцийн** хүчин зүйл буюу дүрэм, журмаар тавигдах шаардлага, сонгуулийн болон намын тогтолцоо, эрх зүйн орчин.
- **Нийгмийн** хүчин зүйл буюу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, боловсрол, гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарь.
- **Соёлын** хүчин зүйл буюу улс төр, төрийн хэрэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаарх итгэл үнэмшил.

Эх сурвалж: Сара Чайлдс, Жони Ловендаски, Роза Кемпбэл, Дээд тушаал хашиж буй эмэгтэйчүүд 2005: Тооны өөрчлөлт, улс төрийн өөрчлөлт? (London: Hansard Society, 2005), хуудас 78.

Ялгаварлан гадуурхалтын нэг ул мөр нь *эмэгтэйчүүд өөрсдөө* нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголтоос нэлээдийг нь хүлээн авч, хэрэгжүүлж байдаг явдал юм. Зарим эмэгтэй улс төр бол “эрэгтэйчүүдийн” хүлээх үүрэг хариуцлага, эмэгтэйчүүдэд сайн улс төрч болох чадвар, шинж чанар дутагдалтай, улс төр бол “бохир тоглоом” тул эмэгтэйчүүд тэнд байх шаардлагагүй эсвэл сурталчилгаа хийх, хөрөнгө босгох нь эмэгтэйчүүдэд зохимжтой үйлдэл биш гэж боддог. Түүнчлэн хандивлагчаас хөрөнгө гүйх, намын хязгаарлагдмал хөрөнгө нөөцийн төлөө тэмцэхэд эмэгтэйчүүдэд эвгүй санагдаж болно.

Эдгээр учир шалтгааны улмаас улс төрийн хэцүү орчинд ажилладаг, улс төрийн нөхцөл байдлыг сай мэддэг ирээдүйтэй, хүсэлтэй олон эмэгтэй улс төрийн албан тушаалд очих, сонгуульд өрсөлдөхөс цааргалж, өөрсдийгөө улс төрд тохиромжгүй гэж үздэг. Ийм итгэлгүй байдлын улмаас улс төрд орох сонирхолтой эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс доогуур хэвээр байна.

Тэгвэл эмэгтэйчүүд нийгэмд тулгарч буй болон өөртөө шингээн авсан жендэрийн хэвшмэл ойлголтоос хэрхэн салах вэ? Түүхийн сургамжаас үүнийг харж болно. Сонгуулийн эрхийн төлөөх улс төрийн тэмцлийг олон эмэгтэй эхлүүлж, үеийн үед үлгэр жишээ болсоор ирсэн. Европ, Хойд Америкийн эмэгтэйчүүд сонгох эрхийн төлөө чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэднээс дурдвал Их Британий Эммелин Панкурст, Марион Коутс Хансен, АНУ-ын Элизабет Кэйти Стантон, Виктория Вуудхал, Сьюзан Б.Антони, мөн Австрийн Марианн Хэйнич, Германы Клара Цеткин, Ирландийн Анна Хаслан, Италийн Анна Мариа Моззони, Нидерландын Алет Жакобс, Оросын Александра Коллонтай, Шведийн Сигне Бергман нар юм. Өнөөдөр бид эдгээр болон бусад олон нэрийг эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөөх түүхэн тэмцэлтэй холбон дурсдаг билээ¹⁵⁸.

Гэхдээ тэдний үйл хэргийг өргөн хүрээнд дэмжиж, энэхүү дэмжигч хэсэг нь олонх болж, нэн даруй арга хэмжээ авах нөхцөл үүсгэсний үндсэн дээр л улс төрийн түүштэй өөрчлөлт гарч байсан. Ардчилсан орнууд, ардчиллыг шинээр тогтоож буй орнууд дахь сонгуулийн эрхийн хөдөлгөөн энэхүү арга замыг хүч чадлыг харуулж, дэлхий даяар эмэгтэйчүүд санал өгөх эрхтэй болсон билээ¹⁵⁹. Ялангуяа бүх нийтийн сонгуулийн эрхийг үндсэн хууль, үндэсний хууль тогтоомждоо тусгаснаар эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх ирээдүйд ч үйлчилж байх баталгаа болж байна. Өнөөдөр эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн төрийн хэрэг, улс орны амьдралд оролцох тэгш эрхийг олон улсын гэрээ конвенцуудад тусгасан бөгөөд ЕАБХАБ-ын бүсийн улс орнуудын эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажсан байна.

158 “List of suffragists and suffragettes”, Wikipedia, <http://en.wikipedia.org/wiki/List_of_suffragists_and_suffragettes#American_28United_States.29>.

159 “Timeline of women’s suffrage”, Wikipedia, <http://en.wikipedia.org/wiki/Timeline_of_women%27s_suffrage>.

Түүхэн үйл явцаас ямар дүгнэлт хийж болох вэ? Юуны өмнө, эмэгтэйчүүд өөрсдөө улс төрийн замыг идэвхтэй сонгох шаардлагатай; эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн өмнөөс уг сонголтыг хийхгүй, хийх ч ёсгүй. Хоёрдугаарт, тоо чухал, яагаад гэвэл эмэгтэйчүүд олон байж л эвсэл, түншлэл үүсгэн, улс төрийн асуудалд нөлөө үзүүлж чадна. Эмэгтэй улс төрийн идэвхтнүүд ухамсартайгаар өөр хоорондоо хамтран ажиллавал эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ахихад маш их тус нэмэр болно. Эцэст нь, эмэгтэйчүүд жендэрийн тэгш бус байдлаас хамгийн их хохирсон тал түл тэд ихэнхдээ жендэрийн тэгш байдлыг бодлого, эрх зүйн орчинд тусгах үйл явц, өдөр тутмын журам, практикт мөрдүүлэхэд гол санаачлагч, хөдөлгүүр нь байдаг.

Улс төрийн намын хувьд энэ нь эмэгтэйчүүдийг дэмжсэн бүтэц бий болгох, жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтыг хориглосон бодлого нэвтрүүлэх, намын гишүүн эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш талбар бий болгох арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, эсвэл эмэгтэйчүүдэд хамаатай нийгмийн гол асуудлаар сурталчилгаа хийх зэрэг ажил үйлэж байж болно. Гэвч улс төрийн намын бодлогод жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх нь дан ганц эмэгтэйчүүдийн нуруун дээр үлдэх ёсгүй. Улс төрийн нам дотроо жендэрийн тэгш байдлыг журамлаж нэвтрүүлэхэд улс төрийн намын удирдлага, шийдвэр гаргагчид, намын эрэгтэй, эмэгтэй идэвхтэн, гишүүдийн чин эрмэлзэл нэн чухал.

Түүнээс гадна, улс төр бол ул үндсээрээ өрсөлдөөнт тоглоом гэдгийг ойлгох нь чухал. Улс төрч бүр, эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, улс төрийн эрх мэдэлд хүрэх, уг эрх мэдлээрээ дамжуулан өөрчлөлт хийхийн тулд сонгогдох гэсэн үндсэн зорилготой байдаг. Тиймээс энэ бүлгийн уншихдаа хэд хэдэн санааг анхаарах нь чухал. Нэгдүгээрт, эмэгтэй улс төрчид өөрсдөө эдгээр арга замын заримынх нь санаачлагч байх ёстой, мөн үүнийг хэрэгжүүлэхэд нам дотроо эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй. Энэхүү бүлэгт эмэгтэйчүүд, түүний дотор эмэгтэйчүүдийн дэвшлийг эсэргүүцэж буй ахмад эмэгтэйчүүдтэй хэрхэн ажиллах талаар дэлгэрэнгүй оруулаагүй бөгөөд энэ талаар ЕАБХАБ-аас тус гарын авлагын дараагийн шинэчилсэн хувилбарт тусгах санаатай байна. Хоёрдугаарт, өмнө дурдсанчлан, улс төр бол өрсөлдөөнт мэргэжил бөгөөд албан ба албан бус дүрэмтэй. Эмэгтэйчүүд шударга, ил тод, тэгш байдлыг тогтоохыг оролдохдоо ойрын хугацаанд ялагдах магадлалтай. Ялангуяа улс төрийн үйл явцад сөрөг сурталчилгаа эсвэл сонгуулийн будлиан гардаг, сонгуульд мөнгөний нөлөө ихтэй үед ийм байх боломжтой.

Эцэст нь, “дүрэм өөрчлөхийг” оролдох, бодлогын шинэчлэл хийх нь цаг хугацаа, хүчин чармайлт шаардах бөгөөд эмэгтэй хүнд өөрийн карьерт анхаарах, улс төрийн сурталчилгаандаа зориулах цаг бага үлдэх талтай. Гэхдээ эмэгтэйчүүд санаа, үзэл бодол тусгаж, бодлогын зүйл заалт болон практикт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан зүйлийг илрүүлж, хасуулахын тулд бодлогын шинэчлэлд идэвхтэй оролцох нь чухал. Институцийн, бодлого, эрх зүйн орчин нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хангаагүй цагт эмэгтэйчүүд улс төрд ахиж дэвшихэд улам хүнд байх болно.

Тус бүлэгт дурдсан зарим арга зам нь улс төрийн эдгээр бэрхшээлийг даван туулахад нь эмэгтэйчүүдэд тус болно. Гэвч энд дурдсан зүйлийн нэлээд олон нь улс төрийн намын үйл ажиллагаа болон эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн улс төрийн тоглогч болгон дэмжиж буй байдлыг өөрчлөхөд чиглэсэн урт хугацааны стратеги юм.

4.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?

Энэ бүлэгт эмэгтэйчүүдийн улс төрийн нам дахь бодит оролцоо, жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэхийн тулд улс төрийн нам дахь эмэгтэйчүүд тус тусдаа болон хамтдаа хэрэгжүүлж болох арга хэмжээнээс дурдав. Үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эмэгтэй улс төрчид дараах зүйлд анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Карьераа амжилттай хөгжүүлж, улс төрийн албан тушаал ахих;
- Эмэгтэйчүүд өөр хоорондоо хамтран ажиллах, хамтын сонирхлыг хөндсөн асуудлаар нэгдэж ажиллах;
- Улс төрийн намын бодлого, журам, практикт жендэрийн тэгш байдлыг институтчлан тусгах, эрэгтэйчүүдийг түнш, жендэрийн тэгш байдлыг сурталчлагч болгон хамтран ажиллах

Өмнөх бүлэгт дурдсанчлан, тухайн улс төрийн байгууллагын хэлбэр, эмэгтэйчүүдийн өрсөлдөж буй албан тушаал, нөхцөл байдлын онцлог, улс төрийн ерөнхий орчин зэрэгт тулгуурлан хамгийн оновчтой арга замыг сонгон авах нь зүйтэй.

4.1.1. Карьераа амжилттай хөгжүүлж, улс төрийн албан тушаал ахих

Энэ хэсэгт улс төрийн карьераа ахиулахын тулд эмэгтэй улс төрч хэрэгжүүлж болох арга хэмжээ, санаачлагыг оруулав. Үүнд аль улс төрийн намд элсэхээ сонгохоос эхлэн улс төрийн намууд бодит байдал дээр хэрхэн ажилладагийг ойлгож мэдэх арга замыг дурдав. Энэ ойлголт мэдлэг нь тухайн эмэгтэй сонгуульд өрсөлдөх, улс төрийн кампанит ажлыг голлон гүйцэтгэх эсвэл намын шийдвэр гаргагч болох зэргээр улс төрийн шат ахихаа төлөвлөх, ийнхүү ахихад шаардлагатай дэмжлэг авахад чухал суурь болж өгнө. Хэсгийн төгсгөлд уг төлөвлөгөөгөө үйл хэрэг болгоход шаардагдах зарим практик арга хэмжээг дурдсан бөгөөд ингэхдээ улс төр, сонгуулийн сурталчилгааны ажлыг голлон авч үзэв.

1) Улс төрийн намд элсэх

Эмэгтэйчүүд ЕАБХАБ-ын бүсийн чухам хаана амьдарч байгаагаас үл хамааран улс төрийн идэвхтэй байх магадлалтай байдаг. Өөрөөр хэлбэл, улс төрч гэдэг албан утгаар биш боловч намын дэмжигч, улс төрийн ажиглагч, буяны байгууллагын сайн дурын ажилтан, иргэний нийгмийн идэвхтэн, эсвэл нутаг, хамт олны идэвхтэн, сонгогч байж болно. Үнэндээ, зарим судалгаанаас харахад АНУ-ын иргэний нийгмийн байгууллагын 80 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг (гэхдээ АНУ-ын хамгийн том төсөвтэй ТББ-уудын дөнгөж 12 хувийг л эмэгтэй хүн тэргүүлдэг)¹⁶⁰. Түүнчлэн Их Британид иргэний нийгмийн байгууллагын гишүүдийн 68 хувь нь эмэгтэйчүүд байдаг, гэхдээ хамгийн том төсөвтэй ТББ-уудын 27 хувийг эмэгтэй хүн тэргүүлдэг¹⁶¹. Энэ нь улс төрд орох үр чадвар, туршлага, мэдлэг, үнэлэмжийг өөртөө бий болгосон олон эмэгтэй бэлэн байгааг харуулж байна.

Тиймээс энэ хэсэгт эмэгтэйчүүд улс төрд орохоор албан ёсоор шийдсэний дараа авах арга хэмжээг тоймлон хүргэв.

160 160 "Women in civil society: Breaking the glass pyramid", 7 March 2013, Council for International Development, <<http://www.cid.org.nz/news/women-in-civil-society-breaking-the-glass-pyramid/>>. Leadership statistics from "Women in leadership: It's not going to work the way we're doing it", The Guardian, 1 August 2013, <<http://www.theguardian.com/global-development-professionals-network/2013/aug/01/women-in-leadership-international-ngos>>.

161 Ibid.

→ Гишүүн элсүүлэхэд тавигдах шаардлагыг мэдэж авах

Эмэгтэй хүн улс төрд орох хамгийн чухал эхлэлийн нэг нь улс төрийн аль нэг намд элсэх явдал юм. Аль нэг намыг сонгоно гэдэг нь өөрийн үнэлэмж, үзэл суртал болон бодлогын чиг хандлагыг тодорхойлж, түүнд таарч нийцэж буй улс төрийн намыг олно гэсэн үг юм. Тийм намыг олмогц улс төрийн намууд янз бүрийн учир шалтгаанаар гишүүн элсүүлж, янз бүрийн шалгуур тавьдаг гэдгийг анхаарах нь зүйтэй. Тиймээс хамгийн эхний алхмын нэг нь тухайн **улс төрийн намаас гишүүн элсүүлэхдээ ямар шаардлага** тавьдагийг олж мэдэх хэрэгтэй. Тухайлбал, дараах шалгуур байж болно. Үүнд:

- ✓ Нас;
- ✓ Иргэншил;
- ✓ Боловсрол;
- ✓ Оршин суугаа газар;
- ✓ Ажил эрхлэлтийн байдал (тухайлбал, цэргийн эсвэл төрийн албан хаагч биш байх гэх мэт);
- ✓ Анх элсэхэд болон байнга төлөх гишүүнчлэлийн татвар;
- ✓ Намын үзэл суртал, үнэлэмжийг дагах, намаас гишүүн гэж хүлээн зөвшөөрөгдөх¹⁶².

Намд гишүүн элсүүлэх олон улсын сайн туршлагаас үзэхэд дээрх шалгуур бүгд зохистой хэмжээнд байх ёстой бөгөөд эмэгтэй, эрэгтэй аливаа иргэн намд элсэхэд нь хөрөнгө нөөц эсвэл чадварын хэт өндөр шалгуур тавих ёсгүй юм¹⁶³. Түүгээр ч барахгүй эдгээр шалгуурыг намын дүрэмд зааж өгсөн эсвэл цахим хуудсанд тавьсан байх ёстой. Эмэгтэйчүүд тухайн намд элсэхэд ямар шалгуур тавигддагийг мэдэж авахын тулд зохих баримт бичгийг авч эсвэл тухайн намын цахим хуудсанд хандах нь зүйтэй.

Бизнесийн харилцаа, гэр бүл, нийгэм, сургууль боловсролын хүрээгээр дамжин эмэгтэйчүүд аль намд элсэхээ мэдэж байгаа тул намд элсүүлэх шалгуурыг мэдэх шаардлагагүй гэж үзэж байж болно. Нөгөөтэйгүүр, улс төрийн намууд дүрэмдээ зааснаас өөр шалгуур хангасан гишүүд эрэлхийлж байж болно, эсвэл янз бүрийн шалгуурт харилцан адилгүй ач холбогдол өгдөг байж болно. АИХЭА-наас Албани, Гүрж, Казахстан, Киргизстан, Молдав гэсэн 5 оронд хийсэн судалгаанд оролцогчид улс төрийн намын удирдлагууд нь бизнесийн хүрээ, хамтран ажиллагч, их сургуульд хамт суралцаж байсан хүмүүс, мөн нутагтаа нэр хүндтэй хүмүүсийг элсүүлдэг гэж хариулжээ.

Аль ч тохиолдолд эмэгтэйчүүд намд элсэхэд тавигддаг албан болон албан бус шалгуурын талаар ойлголттой байх нь чухал. Уг шалгуурыг мэддэг байснаараа эмэгтэйчүүд намын гишүүн болсныхоо дараа намын удирдлага, шийдвэр гаргагчид тэдгээр шалгуурыг шударга, тэгш, ил тод хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлэх боломжтой болно.

Шигтгээ 4.3. Судалгаанд хамрагдсан 5 орны улс төрийн намын гишүүн элсүүлэлт

“Эмэгтэйчүүд улс төрийн намд” төсөлд хамрагдсан 5 орны улс төрийн намууд дараах шалгуураар гишүүн элсүүлдэг. Үүнд:

- Улс төрийн намын удирдлага таньж мэдэх эсэх (найз, хамаатан);
- Нутаг, хамт олондоо нэр хүндтэй;
- Хөрөнгө нөөцийн байдал, өөрөөр хэлбэл, нэр нь танигдсан эсэх, хөрөнгө;
- Намын удирдлагад үнэнчээр харуулсан байх.

162 See: OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010, para. 116; and “Parties and candidates”, ACE Electoral Knowledge Network, <<http://aceproject.org/ace-en/topics/pc/onePage>>.

163 OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010, para. 116

→ Тухайн нутаг, хамт олны асуудалд хувь нэмэр оруулах

Шинэ гишүүн намд ямар нэмэлт үнэ цэнэ, үр чадвар, мэдлэг авчирч чадахаа харуулах нь чухал. Ихэнх улс төрийн намаас шинэ гишүүн элсүүлэхдээ эрэлхийлдэг чадварыг эзэмшсэн гэдгээ харуулахын тулд эмэгтэйчүүд албан ёсны улс төрөөс гадуур **тухайн нутаг, хамт олондоо оруулж буй хувь нэмрээ** дурдан ашиглаж болно.

Тухайлбал, амьдарч буй газрынхаа хандив цуглуулах ажилд оролцдог байх нь иргэний үүргээ биелүүлэх, нийтийн төлөө ажиллах эрмэлзлийг харуулна. Түүнчлэн мэргэжлийн холбоодод элсч ажиллах нь эмэгтэйчүүдэд мэргэших, чадвараа хөгжүүлэхэд тусалдаг. Олон нийтийн ажлын бусад хэлбэр, тухайлбал, эцэг эхийн зөвлөл, спортын багийн дасгалжуулагчаар ажиллах, орон нутгийнхаа холбоог тэргүүлэх, сайн дурын ажил хийх зэрэг нь тухайн эмэгтэйн орон нутгийнхаа хөгжлийн төлөө зүтгэх эрмэлзэл, мөн тийнхүү оролцсоны ачаар менежмент, хөрөнгө босгох, сайн дурынхныг дайчлах зэрэг чухал үр чадвар эзэмшсэнийг харуулна. Иргэдийн нийтийн хуралд оролцож байх нь иргэний оролцоог сонирхдогийг харуулахаас гадна тухайн орон нутгийн улс төрийн талаар мэдлэгтэйг харуулна.

Олон нийтийн ажилд оролцох нь эмэгтэйчүүдийн үнэлэмж, чадвараа харуулах боломж олгоод зогсохгүй юу хийж чаддаг, ямар үр чадвартай, ямар хувь нэмэр орон нутагтаа оруулсныг иргэд, намын удирдлагууд мэдэж авах боломж олгодог. Эмэгтэйчүүд яг энэ чадвараа өөрийн элсэхээр сонирхож буй намд “зарах” ёстой юм.

→ Намын орон нутаг дах салбартай холбогдох, сайн дурын ажил хийх

Их Британий Консерватив намаас эмэгтэйчүүдийг элсүүлэх 9 алхам бүхий төлөвлөгөө гаргасны хамгийн эхнийх нь эмэгтэйчүүдийг амьдарч буй газрынхаа **намын үүрт** хандахыг уриалах гэж дурджээ¹⁶⁴. Тиймээс аль нэг намд элсэх сонирхолтой байгаа эмэгтэйчүүд тэр намынхаа орон нутгийн намын үүрт хандаж, тухайн намын талаар, мөн ямар чадвар, туршлага, боловсрол, мэргэжилтэй хүн эрэлхийлдэгийг мэдэж авч болно. Ийм уулзалт нь эмэгтэйчүүд намын тэрхүү шалгуурыг хангаж байгаа эсэх, мөн эмэгтэйчүүд нөхөж чадах ямар чадвар одоогийн гишүүнчлэлд дутагдалтай байгааг мэдэж авахад тустай. Мөн тус намын үүрийн эмэгтэй гишүүдтэй уулзаж болно. Энэ нь холбоо тогтоох, намын үнэлэмж, соёл, үйл ажиллагааны талаар ойлголттой болох, соёл, үйл ажиллагааны талаар ойлголттой болох, тухайн нам эмэгтэйчүүд болон тэдний дэвшилд хэрхэн ханддагийг мэдэж авах сайхан бололцоо юм.

Шигтгээ 4.4. Нидерландын 2012 оны сонгуулийн сурталчилгаа: Европын ногоон нам

Нидерландын 2012 оны парламентын сонгуулийн үеэр Европын ногоон намын сайн дурынхны гаргасан хүчин чармайлт анзаарагдалгүй өнгөрөөгүй юм. Тус нам сайн дурынхны ажлыг тодруулан харуулах, тэднийг хөдөлмөрийн зохих ёсоор хүлээн зөвшөөрүүлэх үүднээс блог ажиллуулсан.

Эх сурвалж: *European Green Party*, <<http://europeangreens.eu/blogs/dutch-election-campaign-2012>>.

Түүнчлэн эмэгтэйчүүд намаас зохион байгуулж буй шинэ гишүүн элсүүлэхээр олон нийтийн дунд явуулж буй аян ашиглах нь зүйтэй. Ийм ажлыг их сургуулиуд (залуу гишүүдийг татахын тулд), орон нутгийн болон соёлын төв, спорт заал, бизнесийн зөвлөгөөн, бусад олон нийтийн газар зохион байгуулдаг. Шинэ байгуулагдсан намууд ийм ажлыг явуулах илүү сонирхолтой байдаг. Тухайлбал, Чехэд 2011 онд ажиллаж байсан намаас салж шинээр байгуулагдсан нэг нам олон нийтэд зар гарган гишүүд элсүүлсэн¹⁶⁵.

164 See “Women2Win” programme, <<http://www.women2win.com/being-mp>>. The resources and examples referenced in this handbook are included owing to their value as effective good practices for the promotion of women’s participation in political parties. As such, their inclusion in no way represents an endorsement of or agreement with the policy agendas or political platforms of the organizations, platforms and political parties that produced them.

165 Brian Kenety, “Billionaire’s new party ANO 2011 in recruitment drive”, Checposition.com, 29 May 2012, <<http://www.>

→ Сонгуулийн сурталчилгааны ажилд сайн дураар оролцох

Улс төрийн аль нэг намын анхааралд өртөх хамгийн үр дүнтэй аргын нэг нь ирэх сонгуулийн сурталчилгааны ажилд **сайн дураар оролцох** явдал юм. ЕАБХАБ-ын бүсэд үндэсний болон орон нутгийн намууд сонгуулийн сурталчилгааны ажлаа сайн дурынхны дэмжлэгт тулгуурлан явуулдаг. Хийх ажил бол янз бүр, тухайлбал, айлуудаар явж сурталчилгаа хийх; утасны дуудлагад хариу өгөх; хандивлагчдыг олох; сурталчилгааны материал боловсруулж, шуудангаар илгээх, тараах; сонгогчидтой ажиллах; хөрөнгө босгох ажиллагаанд туслах гэх мэт байж болно. Орон нутгийн түвшинд ч улс төрийн намын удирдлага, шийдвэр гаргагчдад танигдах боломж олгосон улс төрийн ажлыг орон нутгийн сонгуульд байгууллага, холбоод, орон нутгийн намын үүр, бүлгээр дамжуулан хийж болно.

2) Нам, намын удирдлагыг мэддэг болох

Эмэгтэйчүүд намд элссэнийхээ дараа уг нам яаж ажилладагийг мэдэж авах нь зүйтэй. Энэ нь намын зохион байгуулалтын талаарх албан ёсны дүрэм, журамтай танилцах; гишүүн хэрхэн элсүүлж сонгон авдаг; гишүүдээ хэрхэн дэмждэг; удирдлагыг хэрхэн нэр дэвшүүлж, эсвэл томилж, сонгодог; шийдвэрээ хэрхэн гаргадаг зэргийг мэдэж авна гэсэн үг. Мөн тоглоомын “албан бус” дүрэм, улс төрийн тохироог бодит амьдрал дээр хэрхэн хийдгийг мэдэж авч ч болно. Аль нь бай, улс төрийн карьераа төлөвлөж буй эмэгтэйчүүдэд нам хэрхэн ажилладагийг мэдэж авах нь хамгийн чухал эхний алхам юм. Энэ хэсэгт уг мэдлэгийг хэрхэн дээшлүүлэх арга замын талаар өгүүлэв.

→ Намын талаар, хэрхэн яаж ажилладагийг олж мэдэх

Тухайн эмэгтэй сонгуулийн менежер, эсвэл улс төрийн зөвлөх, нэр дэвшигч, намын удирдлага болох гэх мэтээр улс төрийн карьераа ахиулахын тулд намын хэд хэдэн **дүрэм журам, үйл явцыг** мэддэг болох шаардлагатай. Үүнд:

- ✓ Намын гишүүдийг хэрхэн **элсүүлдэг**;
- ✓ Шийдвэр, бодлогыг (хэн) хэрхэн гаргадаг;
- ✓ Нэр дэвшигчийг хэрхэн **дэвшүүлж, сонгон авдаг**;
- ✓ Гишүүдээ хэрхэн **дэмждэг**;
- ✓ Намын хөрөнгө нөөцийг (санхүү, өмч, нэвтрүүлгийн цаг) хэрхэн **хуваарилдаг**;
- ✓ Нам **хэвлэл мэдээлэлтэй** хэрхэн ажилладаг.

Хавсралт 2-т буй шалгах хуудсыг ашиглан дээрх үйл явцаас алийг нь мэдэж байгаагаа шалган, тэмдэглэх боломжтой. Мэдээлэл авах эх сурвалж гэвэл намын дүрэм гэх мэт албан ёсны баримт бичгүүд; үйл ажиллагааны журам, ёс зүйн дүрэм гэх мэт журмууд; ажлын төлөвлөгөө, үл ялгаварлан гадуурхах бодлого зэрэг бодлого, стратегийн баримт бичгүүд; тухайн намын улс төрийн болон сонгуулийн мөрийн хөтөлбөр; намын уриа, хэвлэлийн мэдээ, мессэж/санаа гэх мэт сонгуулийн сурталчилгааны материал; мөн намын удирдлага, нэр дэвшигчдийн хэлсэн үг гэх мэт бусад баримт бичиг багтана. Эдгээр нь тухайн нам албан болон албан бус байдлаар хэрхэн ажилладагийг эмэгтэйчүүд мэдэж авахад тус болно.

Мөн эмэгтэйчүүд 3 дугаар бүлэгт дурдсаны дагуу **жендэрийн аудит** эсвэл үнэлгээ хийж, тухайн нам хэрхэн ажилладаг, түүний бодлого, журам, үйл явц нь эмэгтэйчүүдийг шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхаж байгаа эсэхийг тодорхойлж болно.

Ийнхүү намаас баримталж буй журмуудын талаар мэдээлэлтэй болсноор эдгээр журмыг ил тод, шударга, тэгш хэрэгжүүлэхийн төлөө эмэгтэйчүүд нөлөөлж ажиллахад дөхөм болно. Тухайлбал, намын эрх зүйн баримт бичигт гишүүн элсүүлэх, дэвшүүлэх

шалгуурыг оруулж тусгахыг уриалж болно. Ийм журмыг бичгээр гаргаагүй байгаа бол эмэгтэйчүүд эрх зүйн ийм баримт бичгийг боловсруулж, бичгээр албажуулан гаргахын төлөө нөлөөлөн ажиллаж болно. Түүнчлэн тэгш эрх, жендэрийн тэгш байдлыг намын журмуудад баримтлах нэг зарчим болгон хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө, намын албан болон албан бус баримт бичгүүдэд жендэрийн мэдрэмжтэй үг хэллэг ашигладаг болгохын төлөө ажиллаж болно.

→ Намын удирдлагад очих, албан тушаал дэвших замыг мэдэж авах

Намын удирдлага, түүний ажилдаа баримталдаг дүрмийг мэдэж авах нь мөн л чухал. Албан ба албан бус, бичгээр болон заншлаар хэрэгждэг байж болох эдгээр дүрэм, журмыг баримтлан намын удирдлагад ажиллаж буй хүмүүс улс төрийн намын стратеги зорилго, хүний нөөцийн удирдлага, гишүүн элсүүлэлт, тушаал дэвшүүлэх, нэр дэвшигчийг сонгох, сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаарх шийдвэрээ гаргаж байдаг. Мөн хэвлэл мэдээлэлтэй хэрхэн хамтарч ажиллах, улс төрийн бусад байгууллагатай хэрхэн харьцах зэрэг асуудлыг ч тэдгээр журмаас мэдэж авч болно.

Олон улсын стандарт, сайн туршлагаас үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүст улс төрийн нам дотроо дэвших, намын бүх шатны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох тэгш боломжтой байх эрхийг онцолсон байдаг. Тиймээс тухайн эмэгтэй нэр дэвших эсвэл нам дотроо шат ахих сонирхолтой байгаа бол намын **албан тушаал ахиулах үйл явцыг** мэдэж авах нь зүйтэй. Дараах мэдээллийг олж, цуглуулж болно. Үүнд:

- ✓ Шийдвэр гаргах ямар ямар албан тушаал байна вэ? Эдгээрийг сонгодог уу, нэр дэвшүүдэг үү?
- ✓ Эдгээр албан тушаал хэзээ, хэр ойр чөлөөтэй болох вэ? Тодорхой давтагдах хугацаа бий юу?
- ✓ Томилдог эсвэл сонгодог албан тушаалуудад ямар шалгуур тавьдаг вэ? Тэдгээр шалгуурыг бичгээр гаргасан байна уу?
- ✓ Албан тушаал ахихад эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш боломж олгоход чиглэсэн механизм бий юу?
- ✓ Албан тушаал дэвшүүлэх шийдвэрийг хэн, хэрхэн гаргадаг вэ?
- ✓ Албан тушаал дэвшүүлэх үйл явц хэзээ явагддаг вэ, өөрөөр хэлбэл, тодорхой давтамжтай хугацаанд, намын их хурал, чуулганы үеэр, эсвэл шаардлагатай тохиолдолд гэх мэт?
- ✓ Намын их хуралд оролцоход ямар журам үйлчилдэг вэ? Түүнд эмэгтэйчүүд оролцох, саналыг эрхтэй байхад чиглэсэн ямар нэг механизм, зорилт байгаа юу?
- ✓ Нам дотор одоо байгаа болон ирээдүйд сулрах ямар албан тушаал байна вэ?

Намын дотоод ардчиллын сайн практикаас үзэхэд ил тод, шударга, тэгш байдлын зарчмыг зөвхөн нэр дэвшигч олох, дэвшүүлэх үйл явцад төдийгүй намын доторх албан тушаал ахих үйл явцад ч мөрдөх ёстой. Судалгаанд хамрагдсан 5 орны хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь дийлэнх нь намын доторх албан тушаал ахих үйл явцыг шударга, ил тод гэж үзсэн байна. Гэхдээ шударга, ил тод байдлын тухайд эмэгтэйчүүд намдаа эрэгтэйчүүдээс доогуур оноо өгсөн байв. Уг судалгааг шилжилтийн орнуудад улс төрийн хувьд амжилттай ажиллаж байгаа (парламентын гишүүн болох гэх мэт) эмэгтэйчүүд (мөн эрэгтэйчүүдээс) авсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хариултад гарч буй зөрөө нь улс төрийн хувьд амжилттай яваа эмэгтэйчүүдийн хувьд ч намын дотоод албан тушаал ахиулах үйл явц эрэгтэйчүүдэд илүү ээлтэй гэсэн ойлголттой явдагийг харуулж байна.

Хүснэгт 4.5. Албан тушаал дэвшүүлэх үйл явц хэр шударга, ил тод байдаг талаарх санаа бодол

	% Эмэгтэйчүүд	% Эрэгтэйчүүд	Зөрөө
Нам дотор албан тушаал дэвшүүлэх үйл явц хэр шударга явагддаг вэ? (‘маш шударга’ болон ‘ер нь’ шударга гэж хариулсан хариултын эзлэх жин)	85	96	-11
Нам дотор албан тушаал дэвшүүлэх үйл явц хэр ил тод явагддаг вэ? (‘маш ил тод’ болон ‘ер нь ил тод’ гэж хариулсан хариултын эзлэх жин)	77	95	-18

Эх сурвалж: ЕАБХАБ/АИХЭА, Эмэгтэйчүүд улс төрийн намд судалгаа 2012.

Түүнээс гадна, дээрх 5 оронд “намын удирдлагатайгаа сайн харилцаатай байх” гэсэн зүйлийг нам дотроо дэвшихэд нэн чухал, энэ тухайд жендэрийн асуудал нөлөөлдөг гэж үзсэн эмэгтэйн тоо эрэгтэйчүүдийнхээс олон байна. Гэхдээ эмэгтэй, эрэгтэйчүүдийн аль аль нь “намдаа удаан хугацаагаар үргэлжлүүлэх ажиллах, зүтгэлтэй байх” нь илүү чухал гэдэгтэй санал нийлсэн байна.

Хүснэгт 4.6. Улс төрийн нам дотроо албан тушаал ахихад юу хэрэг болдог талаарх санаа бодол

	% Эмэгтэйчүүд	% Эрэгтэйчүүд	Зөрөө
Боловсрол	81	59	+22
Намдаа удаан хугацаагаар үргэлжлүүлэн ажиллах, зүтгэлтэй байх	81	73	+8
Орон нутагтаа нэр хүндтэй байх	70	67	+3
Намын гишүүн байсан хугацаа	54	44	+10
Намын удирдлагатай сайн харилцаатай байх	50	33	+17
Мөнгөн хандив	50	50	0
Жендэр	29	6	+23
Намын удирдлагатай төрөл садны холбоотой байх	13	10	+3

Эх сурвалж: ЕАБХАБ/АИХЭА, Эмэгтэйчүүд улс төрийн намд судалгаа 2012.

→ Нам доторх эмэгтэйчүүдийн (мөн эрэгтэйчүүдийн) талаар илүү зүйл мэдэж авах

Нэгэнт намын эмэгтэй гишүүн болохын хувьд намын **бусад эмэгтэй (эрэгтэй) гишүүдийн** талаар, өөрөөр хэлбэл, тэд хэр идэвхтэй ажилладаг, ямар албан тушаал хашдаг, ямар үр чадвартай зэргийг мэдэж авах нь чухал. Нэг намын гишүүд үзэл суртал, улс төрийн хувьд тодорхой хэмжээгээр холбоотнууд боловч тухайн эмэгтэйн хувьд намын албан тушаал, ялангуяа шийдвэр гаргах албан тушаал, нэр дэвшилтийн хувьд өрсөлдөгчид юм. Эмэгтэйчүүд өөрийн холбоотон ба өрсөлдөгчөө тодорхойлохын тулд намын бусад эмэгтэй (эрэгтэй) гишүүдийг, мөн тэд хэр идэвхтэйг зураглан үзэж болох юм.

Үүнд тэдгээр эмэгтэйчүүд орон нутаг, бүс, үндэсний гэх мэт намын аль шатанд ажилладаг, шийдвэр гаргах ямар албан тушаал хашдаг (жишээлбэл, гүйцэтгэх хороо, удирдах зөвлөлийн гишүүн, намын их хурлын төлөөлөгч, сурталчилгааны менежер, намын фракц, эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч гэх мэт), мөн ямар сонгууль албан тушаал хашдаг (орон нутаг, хотын зөвлөлийн гишүүн, засаг дарга, парламентын гишүүн гэх мэт) зэрэг мэдээллийг цуглуулж болно.

Намын албан тушаал сулрах, нэр дэвших ажиллагаа эхлэхэд эдгээр эмэгтэй дахин томилогдох эсвэл сонгогдохыг эрмэлзэх магадлал хэр вэ? Тэд нам дотроо, намын удирдлага, мөн сонгогчдын дунд хэр танигдсан бэ? Эцэст нь, тэдгээр эмэгтэйн боловсрол, мэргэжил, үр чадвар, мэргэшлийн талаар мэдэж авах нь зүйтэй. Ингээд уг мэдээллээ эмэгтэйчүүдийн дунд эвсэл, сүлжээ, эв санааны нэгдэл бий болгоход, тухайлбал, намын эмэгтэйчүүдийн бүлэг зэргийг байгуулахад ашиглаж болно. Түүнчлэн нам дотор зарим асуудлаар байр сууриа ахиулахад тэд холбоотон болж, шийдвэр гаргах түвшний албан тушаалд очиход дэмжих, сонгуульд өрсөлдөхөд дэмжих боломжтой.

Хүснэгт 4.7. Нам доторх эмэгтэйчүүдийн талаар юу мэдэгдэж байна вэ?

Намын гишүүдийн хэд нь эмэгтэй вэ?
Эмэгтэй гишүүдийн хэд нь орон нутаг, бүс, үндэсний түвшинд ажилладаг вэ?
Орон нутгийн намын үүргийн дарга эмэгтэй хэд байна вэ?
Намын идэвхтнүүдийн хэд нь эмэгтэй вэ?
ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэд вэ?
Намаас засаг даргаар ажиллаж буй эмэгтэй хэд вэ?
Намаас хэдэн эмэгтэй парламентын гишүүнээр сонгогдсон бэ?
Хотын намын байгууллага удирдаж буй эмэгтэйчүүд хэдэн хувийг эзэлж байна вэ?
Тус намд эмэгтэй сайд байгаа юу?
Намын шийдвэр гаргах байгууллагын гишүүн хэдэн эмэгтэй байна вэ?
Үндэсний түвшинд намын гүйцэтгэх байгууллагад гишүүнээр ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо хэд вэ?
Намаас хэдэн эмэгтэй үндэсний түвшний танигдсан улс төрч вэ?
Намын их хуралд хэдэн эмэгтэй ордог вэ?
Намын их хуралд хэдэн эмэгтэй саналын эрхтэйгээр ордог вэ?
Тухайн намын хамгийн чухал 7 албан тушаалыг жагсаана уу:
1.
2.
3.
4.
5.
6.
7.
Эдгээрээс хэдийг нь эрэгтэй, хэдийг нь эмэгтэй хүн хашиж байна вэ?
Эмэгтэй гишүүдийн хувь хүний талаарх ямар мэдээлэл байна вэ: хэдэн настай; ямар боловсрол эзэмшсэн; ямар ажил эрхэлж байгаа, бизнес эрхлэгч эсвэл ажилгүй байгаа эсэх; тэдэнд нийгмийн халамжийн туслалцаа хэрэгтэй эсэх? Тэд аль чиглэлээр мэргэшсэн бэ?
Намд саналаа өгдөг сонгогчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэд вэ?


Эх сурвалж: Энэхүү гарын авлагад зориулж Сонжа Локарын бэлтгэсэн материалыг ашиглав.

→ Нам дотор эмэгтэйчүүд (болон эрэгтэйчүүд) хашиж буй албан тушаалыг тодруулах

Намаас янз бүрийн түвшинд идэвхтэй ажиллаж буй хэдэн эмэгтэй (эрэгтэй) байгааг тодорхойлсны дараа аль албан тушаалыг эмэгтэй, эрэгтэй хүмүүс хаших хандлагатай байгааг, яагаад тийм байгаа шалтгааныг мэдэх нь зүйтэй. Тухайлбал, Гүржид шинжээчид нам дотроо эмэгтэй, эрэгтэй гишүүд ямар үүрэг гүйцэтгэж байгааг зураглаж үзжээ¹⁶⁶. Тус судалгаагаар эрэгтэйчүүд голдуу шийдвэр гаргах түвшний албан тушаал, ялангуяа хөрөнгө нөөц, намын менежмент, мөрийн хөтөлбөр боловсруулахтай холбоотой албан тушаал хашдагийг тогтоожээ. Харин эмэгтэйчүүд ихэвчлэн намын хэвлэлийн төлөөлөгчийн алба хашдаг, гэхдээ зөвхөн улс орныхоо түвшинд ийм үүрэг гүйцэтгэх бөгөөд харин олон улсад намаа эрэгтэйчүүд төлөөлдөг байна. Түүнчлэн эмэгтэйчүүд голдуу анхан шатны түвшинд ажиллаж, сайн дурынхныг зохион байгуулж, сайн дурын ажил хийдэг, мөн энэ дашрамд дурдахад, нам ялагдал хүлээхэд намдаа үнэнч үлддэг байна.

Эмэгтэйчүүд намынхаа эмэгтэйчүүдийн албан ёсны байгууллагын дэмжлэгтэйгээр ийм зураглал гарган, нам дотроо эрэгтэй, эмэгтэй гишүүд ямар албан тушаал хашиж байгааг тодорхойлох нь зүйтэй. Энэ мэдээлэл нь тухайн эмэгтэйн карьер ахихад чиглэсэн алсын арга замыг боловсруулахад туслахаас гадна улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын шатлал дотор **хөдөлмөрийн жендэржсэн хуваарь** хэрхэн үйлчилж байгааг харуулах ач холбогдолтой. Энэ ажлыг хийх явцад намын ямар албан тушаал сул байгаа, ирээдүйд ямар албан тушаал сулрах, мөн намын албан тушаалыг хуваарилахад жендэрийн ялгаварлал байгаа эсэхийг мэдэж авах боломжтой.

Зураг 4.8. Гүржийн улс төрийн намын албан тушаалууд, хүйсээр



Эх сурвалж: Тамар Баграриа, Медея Бодошвили, Дэвид Жижлава, Иразли Хмаладзе, “Намын дотоод ардчиллыг жендэрийн үүднээс хөгжүүлэх нь, Намын дотоод ардчилал ба орон нутгийн засаглал (Тбилиси: NIMD Гүрж, 2012).

166 Tamar Bagratia, Medea Badashvili, David Jijelava and Irakli Khmaladze, “Developing intra-party democracy from a gender perspective”, in Intra-party democracy and local governance (Tbilisi: NIMD Georgia, 2012), p. 13.

3) Улс төрийн карьераа төлөвлөх

Өмнөх хэсэгт эмэгтэйчүүд улс төрийн намаа албан ба албан бус байдлаар хэрхэн ажилладагийг мэдэж авахад туслах наад захын мэдээллийг өгсөн билээ. Харин энэ хэсэгт уг мэдээллээ ашиглан улс төрийн карьераа хэрхэн төлөвлөх талаар авч үзэв. Сургалтын материал, гарын авлагүүдэд хөрөнгө нөөц олох, нийтэд танигдахад эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээл, түүнийг даван туулахад ашиглах арга техник гэх мэт улс төр, сонгуулийн сурталчилгааны ажлын бодит үйл явцад голлон анхаарсан байдаг.

Эмэгтэйчүүд олноороо сонгуульд нэр дэвшдэг болоход улс төрийн кампанит ажлын ур чадвар чухал гэдэг нь дамжиггүй. Гэхдээ олон тохиолдолд улс төрийн ажлын *төлөвлөлтөнд* тэр бүр анхаарал хандуулдаггүй тал байна. Улс төрийн карьер бол эмэгтэй хүн нэр дэвшихээр шийдэх эсвэл нэр дэвших болсноор бий болдог зүйл биш. Юу хүсч байгаагаа, тэнд яаж очихоо нягт нямбай төлөвлөсөн эмэгтэйчүүд улс төрийн карьераа урт хугацаанд амжилттай ахиулах магадлалтай.

Энэхүү төлөвлөлтийн үеийг эмэгтэйчүүд тухайн сонгууль, улс төрийн тогтолцоо, мөн бусад эрэгтэй, эмэгтэйчүүдийн зүгээс ямар өрсөлдөөн гарч болох талаар **мэдээлэл цуглуулах үйл явц** гэж харах хэрэгтэй. Уг мэдээлэл нь тухайн эмэгтэйн улс төрийн карьерийг ойрын үед болон урт хугацаанд төлөвлөхөд хэрэг болж, өрсөлдөөнд нэг алхмын түрүүнд явахад тусална.

Тиймээс улс төрийн нам доторх албан тушаалаа ахиулах, мөн сонгуульд албан тушаалд бэлтгэх ажлаа төлөвлөхдөө эмэгтэйчүүд анхаарвал зохих гол хэдэн хүчин зүйлийг энэхүү хэсэгт дурдав.

→ Улс төрийн ямар албан тушаал сул байгааг, мөн хэзээ сулрахыг мэдэж авах

Улс төрийн амжилттай карьер гэдэг бол зөвхөн сонгогдохыг хэлэхгүй гэдгийг анхнаасаа сайн санах нь зүйтэй. Намын дотор янз бүрийн түвшинд олон **албан тушаал** бий, эмэгтэйчүүд тэнд ажиллаж, улс төрийн манлайллын чадвараа хөгжүүлж, харуулах боломжтой. Тухайлбал, дараах албан тушаалыг дурдаж болно. Үүнд:

- ✓ Нэр дэвшигч
- ✓ Нэр дэвшигчийн сонгох/нэр дэвшүүлэх зөвлөлийн гишүүн
- ✓ Сонгуулийн сурталчилгааны ажлын менежер
- ✓ Эмэгтэйчүүдийн бүлгийн дарга/дэд дарга/гишүүн
- ✓ Хандивлагчтай харьцах, хөрөнгө босгох асуудал хариуцсан ажилтан
- ✓ Гадаад харилцааны ажилтан
- ✓ Ерөнхий нарийн бичгийн дарга
- ✓ Залуучуудын бүлгийн ахлагч
- ✓ Намын их хурлын гишүүн
- ✓ Намын хэвлэлийн төлөөлөгч/хэвлэл мэдээллийн ажилтан
- ✓ Үндэсний түвшний намын үүрийн дарга
- ✓ Орон нутаг, бүсийн намын үүргийн дарга
- ✓ Бодлого, улс төрийн зөвлөх, стратегич
- ✓ Мөнгөн санч

Сонгууль, улс төрийн тогтолцоо нь улс төрийн карьераа ахиулах цаг хугацааг ихэвчлэн тодорхойлж байдаг. Зарим тогтолцоонд намын албан тушаал бусад тогтолцоотой харьцуулахад ойр ойр суларч байдаг. Тухайлбал, намын төлөвшсөн тогтолцоотой улс орнуудад тухайн албан тушаалыг хашиж буй хүн нь сонгуулийн сурталчилгааны үеэр давуу байдалтай байх бөгөөд намын албан тушаал сонгуулийн мөчлөгийн тодорхой цаг үед, тухайн хүн нэр дэвшихгүй гэж шийдсэн тохиолдолд л суларч байдаг. Харин олон намтай, шинэ намууд улс төрийн талбарт үүсч байдаг тогтолцоонд албан тушаал ялангуяа орон нутгийн түвшинд хурдан сулрах талтай, учир нь тухайн албан тушаалыг одоо хашиж буй хүний хүч сул байдаг.

Сонгуульд өрсөлдөх сонирхолтой эмэгтэйчүүд тухайн албан тушаалд ямар шалгуур, ямар чадвар шаардагддаг, уг албан тушаал сулрах магадлалтай эсэхийг олж мэдэхийг хичээх хэрэгтэй. Одоо байгаа болон ирээдүйд суларч болзошгүй албан тушаалыг тодорхойлохдоо намын албан тушаалд буй эмэгтэйчүүдийн талаарх зураглалаа ашиглаж болно (Хүснэгт 4.7, Зураг 4.8). Эсвэл уг албан тушаалд ямар нэг шалгуур байхгүй, түүнд хэн очихыг намын дарга нар тухай бүрт нь бусад гишүүдтэй зөвлөлдөлдгүй шийддэг байж болно. Тэгвэл эмэгтэйчүүд энэхүү тохиолдлын шинжтэй, ил тод бус арга барилыг эсэргүүцсэн тодорхой арга хэмжээ авч болно. Эсвэл өмнө хэсэгт дурдсанчлан, зарим албан тушаалыг байнга эрэгтэй хүн хашиж ирсэн, эрэгтэйчүүд л тохирно гэж үздэг байж болно. Ихэвчлэн стратеги шинжтэй шийдвэр гаргах, санхүүгийн хөрөнгө нөөцийг удирдах, үндэсний болон олон улсын түвшинд, мөн хэвлэл мэдээллээр намыг төлөөлөх зэрэг албан тушаалыг ингэж үзэх тал бий.

Эмэгтэйчүүд ийм практикийг ч эсэргүүцэж болно. Түүхэнд намын доторх хөдөлмөрийн уламжлалт хуваарийг эмэгтэйчүүд эсэргүүцсэн жишээ олон бий. Тухайлбал, Ангела Меркель¹⁶⁷ Христийн ардчилсан холбооны анхны эмэгтэй дарга болж, улмаар Германы анхны эмэгтэй канцлер болсноос гадна одоо дэлхий дээрх хамгийн хүчирхэг эмэгтэйчүүдийн нэгд тооцогдож байна¹⁶⁸. Тэрээр ажиллах хугацаандаа улс төрийн намын дотор эмэгтэйчүүдээр гүйцэтгүүлж ирсэн үүргийг эсэргүүцээд зогсохгүй намын шударга бус практикийн талаар намын дарга нарыг идэвхтэй эсэргүүцэж байв¹⁶⁹.

167 “Angela Merkel”, Wikipedia, in German, English and Russian, <http://de.wikipedia.org/wiki/Angela_Merkel>.

168 “The 100 women who run the world. The World’s 100 most powerful women” 2012, <<http://www.forbes.com/power-women/>>.

169 “Меркель, Ангела”, Wikipedia, <<http://ru.wikipedia.org/wiki/>>; Gerd Langguth, “Germany’s Schreiber Affair: The Scandal that Helped Merkel Become Chancellor”, <<http://www.spiegel.de/international/germany/germany-sschreiber-affair-the-scandal-that-helped-merkel-become-chancellor-a-640938.html>>; “The scandal that rocked the government of Helmut Kohl”, 2010, <<http://www.dw.de/the-scandal-that-rocked-the-government-of-helmut-kohl/a-5137950-1>>.

Шигтгээ 4.9. Ангела Меркелийн дэвшсэн замнал

1954: Хамбургт төрсөн.

1989: Зүүн Европын 1989 оны хувьсгал гарахын өмнөхөн улс төрд орсон; Герман улс нэгдэхийн өмнөхөн Зүүн Германы ардчилсан сонгуулиар бүрдсэн засгийн газарт Лотар де Мазьерын хэвлэлийн төлөөлөгчийн ажлыг богино хугацаанд хийсэн.

1990: Mecklenburg-Vorpommern мужаас Бундестагт сонгогдсон.

1991: Хелмут Колийн 4 дэх кабинетэд Эмэгтэйчүүд, залуучуудын асуудал хариуцсан Холбооны сайд болсон.

1994: Хелмут Колийн 5 дах кабинетэд Байгаль хамгаалах, цөмийн аюулгүй байдал хариуцсан Холбооны сайд болсон.

1998: ХАХ-ны хувьд 1949 оноос хойш хамгийн муу дүн үзүүлсэн сонгууль. ХАХ эрх баригч намаас сөрөг хүчин рүү шилжив. Вольфганг Шаубле ХАХ-ны шинэ дарга, Ангела Меркель намын ерөнхий нарийн бичгийн дарга, Хелмут Коль намын хүндэт дарга болов.

1999: ХАХ орон нутгийн сонгуульд амжилттай оролцов.

1999: Нэргүй хандив авахыг хориглосон улс төрийн намын тухай хуулийг зөрчсөн,

намын хууль бус санхүүжилтийн асуудал босч ирэв. Коль хандивлагчийн нэр, хандивын хэмжээг дурдахаас татгалзав. Ангела Меркель нээлттэй захидал бичиж, үндэсний хэмжээний *Frankfurter Allgemeine Zeitung* сонинд нийтлүүлсэн бөгөөд түүнд Хелмут Коль хууль зөрчиж байгааг шүүмжлэн, “хуучин нөхрийг” солихыг намдаа уриалсан.

2000: Намын удирдах зөвлөл Колийг хандивлагчийн нэр, хандивын хэмжээг дэлгэхгүй бол огцрохыг хүсэв. Коль намын хүндэт даргын албан тушаалаас огцров. Шаубле мөн намын санхүүжилтийн талаар авцалдаагүй мэдээлэл өгч, огцроход хүрснээр нам хэдэн долоо хоногийн түрш удирдлагагүй байв. ХАХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын хувиар Ангела Меркель Герман даяар намын үүрүүдийн бүсчилсэн хурлуудад оролцов. Нэр цэвэр, мөн сонинд хүчтэй захидал нийтэлсэн тэрбээр намын хүчийг нэгтгэж, намын шинэ дарга, уг албан тушаалд сонгогдсон анхны эмэгтэй болов.

2005: Меркель Германы Канцлераар сонгогдов. Мөн уг албан тушаалыг хашсан анхны эмэгтэй болов.

Эх сурвалж: “Ангела Меркел”, Wikipedia, герман, англи, орос хэлээр, <http://de.wikipedia.org/wiki/Angela_Merkel>; Gerd Langguth, “Germany’s Schreiber Affair: The Scandal that Helped Merkel Become Chancellor”, <<http://www.spiegel.de/international/germany/germany-s-schreiber-affair-the-scandal-that-helped-merkel-becomechancellor-a-640938.html>>; “The scandal that rocked the government of Helmut Kohl”, 2010, <<http://www.dw.de/thescandal-that-rocked-the-government-of-helmut-kohl/a-5137950-1>>.

→ Намын дотоод шийдвэр гаргах албан тушаал ахих асуудлыг төлөвлөх

Улс төрийн албан тушаал ахих төлөвлөгөө гаргахын тулд эмэгтэйчүүд ямар албан тушаал байдаг, хэзээ сулрах, тухайн сонирхож буй албан тушаалд нь ямар мэдлэг чадвар шаардагдахыг олж мэдэх нь чухал. Ингээд уг төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн стратеги алхам хийнэ. Шведийн Социал демократ эмэгтэйчүүдийн холбоо буюу Социал демократ намын эмэгтэйчүүдийн байгууллагаас “Эрх мэдлийн товхимол”¹⁷⁰ гаргасан бөгөөд түүнд **улс төрийн нам дотроо эрх мэдэлд хэрхэн хүрэх** талаар удирдамж өгсөн байдаг. Намын эмэгтэй гишүүдэд зориулсан уг товхимолд уг зорилгод хүрэхэд хэрэг болох дараах хэдэн алхмыг дурджээ. Үүнд:

- 1) Тоглоомын дүрмийг мэдэж ав;
- 2) Эмэгтэйчүүдийг жагсаалтын эхэнд оруулах;
- 3) Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр сайн дураар ажилла;
- 4) Нэр дэвшүүлэх хорооны дарга бол;
- 5) Эмэгтэй нэр дэвшигчдийг дэвшүүл;
- 6) Нам дотроо байр сууриа эзэл.

170 “Power booklet”, Swedish Social Democratic Party, S-Kvinnor Sveavägen, Stockholm, 1995.

Өмнө тэмдэглэсэнчлэн, нам дотроо албан тушаалыг албан ба албан бус байдлаар хэрхэн хуваарилдагийг (“тоглоомын дүрэм”) мэдэх нь эхний алхам юм. Дараа нь тухайн тодорхой албан тушаалд эмэгтэйчүүд өөрсдийнхөө нэрийг дэвшүүлж (эсвэл дэмжигч талуудаар дэвшүүлүүлэх), намын удирдлагад уг албан тушаалыг сонирхож байна гэдгээ мэдэгдэх нь зүйтэй.

Гурав дах арга зам нь эмэгтэйчүүд намын шийдвэр гаргах бүтцэд ихэнхдээ дутуу төлөөлөлтэй байдгийг хүлээн зөвшөөрөх явдалд тулгуурлана. Нэр дэвшүүлэх хороо гэх мэт намын шийдвэр гаргах албан тушаалуудад намын эмэгтэй гишүүд нэр дэвшихийг дэмжих нь бусад эмэгтэйчүүдийн албан тушаал ахихад ч дэмжлэг болно.

Харин дөрөв дэх алхам нь нэр дэвшүүлэх, сонгох хорооны дарга гэх мэт намын бүтцийн удирдах албан тушаал хашихыг зорих явдал юм. Эмэгтэйчүүд, тэднийг дэмжигчид нам дотроо шийдвэр гаргах албан тушаалд очмогц бусад эмэгтэйчүүдэд нэр дэвшигч (5 дах арга зам), эсвэл намын шийдвэр гаргагч, удирдагч (6 дах арга зам) болох замыг нээж өгдөг.

Намын эмэгтэй гишүүд, идэвхтнүүд тухайн улс орныхоо улс төрийн онцлогийг тусгасан дээрхтэй адил товхимол гаргахыг бодолцож үзэж болно. Уг товхимолд нам дотроо тушаал ахих ямар боломж байгааг тодорхойлоод, тэдгээр албан тушаалд хэрхэн очих талаар тодорхой удирдамж өгч болно. Мөн уг товхимолыг шаардлагатай бол тогтмол шинэчилж байж болно. Гол албан тушаалд очихыг сонирхож буй эмэгтэй өөрийн дэвших магадлалаа нэмэгдүүлэхийн тулд намын бусад гол гишүүд, идэвхтнүүдтэй (эрэгтэй, эмэгтэйн аль аль нь) холбоо үүсгэх асуудлыг бодолцож үзэх нь зүйтэй.

→ Эмэгтэй нэр дэвшигчээс намд авчрах “нэмэлт үнэ цэнийг” тодорхойлох

Эмэгтэйчүүд улс төрд оруулах хувь нэмэр багатай эсвэл тэдний үр чадвар, мэдлэг тохирохгүй гэсэн байр суурь байнга гарч байдаг. Хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явцын үеэр эмэгтэйчүүдийн санааг хэлээгүй юм шиг, эсвэл сонсоогүй юм шиг өнгөрөөх явдал их гардаг. Энэ бэрхшээлийг шийдэхийн тулд эмэгтэйчүүд намдаа ямар **хувь нэмэр** оруулж чадах, тэд улс төрийн шат ахиснаар намд ямар ач холбогдолтойг мэдэж байх нь чухал. Тиймээс оруулсан хувь нэмрээ намын бусад гишүүд, шийдвэр гаргагч, ялангуяа намын удирдлагад мэдэгдэж, харуулж байх нь зүйтэй.

Эмэгтэй гишүүний оруулах нэмэлт үнэ цэнийг тодорхойлох эхний алхам нь тэрхүү зүйл нь юу вэ гэдгийг тодорхойлох явдал юм. Шигтгээ 4.19-т дурдсанчлан, улс төрийн **давуу, сүл тал, боломж, эрсдлээ** тодорхойлох нэг арга нь SWOT шинжилгээ хийж үзэх явдал юм. Үүнийг яг зорилтот шинжилгээ байдлаар хийж үзэх нь чухал. Энэ бол тухайн эмэгтэй, түүний үр чадварын талаар ерөнхий үнэлгээ биш, харин чухам юу түүнийг намдаа чухал улс төрийн тоглогч болгох, аль талаа сайжруулах ёстойг харуулах нарийвчилсан шинжилгээ юм.

Эмэгтэйчүүд уг шинжилгээг хийхдээ намын нэр дэвшигчийг тодорхойлоход намын сонгон шалгаруулагч, удирдлагаас баримталдаг шалгуур хэрэв байдаг бол түүнийг ашиглах ёстой. 3 дугаар бүлэгт тайлбарласанчлан, нэр дэвшигчийг сонгох үйл явц улс орон бүрт, улс төрийн нам тус бүрт харилцан адилгүй байдаг. Тиймээс тухайн намын удирдлагаас нэр дэвшигч, шийдвэр гаргагчид ямар чадвар, мэдлэгийн шалгуур чухал гэж үздэгийг эмэгтэйчүүд олж мэдэх нь зүйтэй.

Нэр дэвшигч элсүүлэх, сонгох талаар намын дүрмэнд заасан шалгуураас үл хамааран намын удирдлага сонгуульд сайн дүн үзүүлэхэд аль болох их нэмэр болох нэр дэвшигчийг тодорхойлж, дэмжих магадлалтай. Өөрөөр хэлбэл, намаа ялуулах нэр

дэвшигч гэсэн үг юм. Ийм тохиолдолд нам үнэнч байдал, улс төрийн туршлага гэх мэт үзүүлэлт, хөрөнгө санхүү дайчлах, нийгмийн бодол санаанд нөлөөлөгч, нийгмийн эрх мэдэл бүхий талуудтай холбоо тогтоох зэрэг чадвар; мөн өөрийн хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь, хэлхээ холбоо зэрэг тухайн хүний агуулж буй зүйлсийг харгалзаж үзэх талтай.

Тиймээс намаас хайж буй эдгээр үзүүлэлт, үр чадварын багцыг хангахыг оролдохоосоо өмнө нэр дэвшигч элсүүлэх, сонгох албан ба албан бус шалгуурыг мэдсэн байх хэрэгтэй. Эмэгтэйчүүд тэдгээр шалгуурыг намын баримт бичигт тусгаж, түүнийг нэр дэвшигч элсүүлэх, сонгох ажилдаа шударга, тэгш хэрэглэдэг болгох үүднээс нөлөөллийн ажлыг эхлүүлэх хэрэг гарч болно. Ер нь, сонгох шалгуур нь тодорхой үзүүлэлт, үр чадвар, шинж чанарын холимог байх бөгөөд хамгийн чухал нь аль ч шалгуурыг эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах зорилгоор хэрэглэж болохгүй, мөн улс төрийн карьер хөөж буй эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэдгээр шалгуур нь нээлттэй байх ёстой. Шигтгээ 4.10-д улс төрд карьераа ахиулах сонирхолтой намын гишүүн эмэгтэйн зохиомол SWOT шинжилгээг харуулав.

Шигтгээ 4.10. SWOT шинжилгээг ашиглах нь

Давуу тал: Ур чадвар, мэргэжил, хобби буюу сонирхлын хувьд намдаа юу авчирч чадахаа тодорхойл. Энэ бүхэн нь намд ямар түстэй вэ?

- *Катарина бол хүүхдийн эмч. Тэрээр хүүхдийн эмч нарын хоёр ч холбооны (нэг нь үндэсний, нэг нь олон улсын) гишүүн, мөн орон нутагтаа спортын уралдаан тэмцээн зохион байгуулах замаар эрсдэлтэй залуучуудад дэмжлэг үзүүлдэг сайн дурын нийгэмлэгт санхүү хариуцаж ажилладаг.*

Сагс тоглох дуртай, 12 жилийн турш эрсдэлтэй залуучуудад дэмжлэг үзүүлэх нийгэмлэгийн дасгалжуулагчаар ажилласан. Орон нутгийн улс төрд идэвхтэй оролцох хүсэлтэй.

- **Катарина өөрийгөө улс төрийн намуудад хэрхэн танилцуулах ёстой вэ?**

Чаддаг зүйлээ тодотгож хэлэх: үүнд орон нутагтаа үнэнч, зүтгэж ирсэн, сайн дурын нийгэмлэгт ажилласан, өөрийн мэргэжил;

Чадавхтай гэдгээ тодотгож дурдах: үүнд төсөвлөл, мөнгө босгох (сайн дурын нийгэмлэгийн санхүүч), боловсрол (мэргэжил, ур чадвар), олон нийтэд хүрч ажиллах, сүлжээ болж ажиллах (мэргэжлийн болон сайн дурын нийгэмлэгт идэвхтэй ажилладаг; залуучуудтай холбогдож ажиллаж чаддаг);

Мэргэжлээ онцлон дурдах: нэр нь танигдсан (орон нутагтаа нэр хүндтэй, түүний дотор залуучуудын дунд).

Сул тал: Таны сул тал юу вэ? Эдгээрийг та хэрхэн давуу тал болгон ашиглах эсвэл сул талаа хэрхэн шийдвэрлэх вэ?

- *Катаринад улс төрийн ажлын туршлага гэхээр зүйл байхгүй. Одоо хийж байгаа ажлын улмаас маш завгүй байдаг.*

- **Эдгээр сул талыг хэрхэн давуу тал болгох вэ?**

Катарина мэргэжлийн карьерынхаа үр дүнд, мөн сайн дураар хийж байсан ажлынхаа үр дүнд хөрөнгө босгох, төсөвлөлт, олон нийтэд хүрч ажиллах, сүлжээ бий болгох зэрэг хөгжүүлж чадсан. Тэр эдгээр мэргэжлийн болон хувийн сүлжээгээ улс төрийн карьераа болон намын үйл хэргийг ахиулахад ашиглах хүсэлтэй байна.

Боломж: Таныг үр чадвараа дээшлүүлэхэд танай намаас ямар боломж бололцоо олгож байна вэ, тухайлбал, шийдвэр гаргах түвшний сул суудал, сонгоуль дөхөж байгаа тул мэргэжилтнүүд хэрэгтэй байх, эсвэл намаас болон бусад газраас чадавх бэхжүүлэх сүргэлт хийж байгаа гэх мэт.

- *Катаринагийн элсэхээр сонирхож буй намын орон нутгийн салбарт намын*

санхүүг сайжруулахад туслах төсвийн мэргэжилтэй хүн хэрэгтэй байв. Намаас хэлхээ холбоо тогтоох зориулалттай арга хэмжээг тогтмол зохион байгуулж, түүнд нэр нь танигдсан улс төрчдийг урьж, туршлага, сайн жишээ, сургамжаас нь яриулдаг; Катариныгийн таньдаг олон хүн эдгээр арга хэмжээнд уригдан ярьж болохоор юм байна.

Эрсдэл: Таны ахиц дэвшилд хэн, юу эрсдэл учруулж байна вэ?

Улс төрийн хөгжил, өрсөлдөөн, нам доторх эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг эсэргүүцэгч зэргийг бодно уу.

• *Намын зарим гишүүд эмэгтэйчүүдийг улс төрийн мэдэлжүүлэх асуудалд хойрго ханддаг, эмэгтэйчүүд шийдвэр гаргах албан тушаалд очиход дургүй байдаг. Намын гишүүн нэг эрэгтэй өөр нэг эмэгтэй гишүүнийг доромжилсон үг хэлээр шүүмжилснээс үүдээд саяхан дуулиан шуугиан гарсан. Катарины тус намд элсвэл түүний хийсэн бусад ажилд сөргөөр нөлөөлж болзошгүй.*

2005 онд Их Британий Консерватив намаас нэр дэвшигчдэд тавих гол мэдлэг чадварын дараах 6 шалгуурыг тодорхойлсон. Үүнд:

- ✓ Харилцааны үр чадвар (сонсох, үг хэлэх);
- ✓ Оюуны үр чадвар (хэцүү, нарийн мэдээллийг боловсруулах);
- ✓ Хүнтэй харьцах чадвар (янз бүрийн хүмүүстэй);
- ✓ Манлайлал, эрмэлзэл (санаачлага гаргах, дэмжих, боломж олгох);
- ✓ Тууштай, няцахгүй байх (их зан гаргахгүй байх);
- ✓ Итгэл үнэмшил (консерватив үзэл санаа, төрийн албанд зүтгэх эрмэлзэл)¹⁷¹.

Нэмэлт үнэ цэнэ, давуу байдлаа тодорхойлохдоо намаас нэр дэвшигч, удирдлага, шийдвэр гаргагчдын хайж буй тэр зүйлийг харгалзвал тухайн эмэгтэй намын удирдлагад илүү сонирхол төрүүлнэ. Мэдээж энэ нь намаас тийм шалгуур тавьж байгаа гэдгээ мэдэгдсэн тохиолдолд л боломжтой. Харин тийнхүү мэдэгдээгүй бол эмэгтэйчүүд намын шийдвэр гаргагчидтэй уулзах, өмнөх нэр дэвшигчдийн чадвар, туршлагыг судлах, намын баримт бичгүүдтэй танилцах зэрэг өөр бусад арга хэмжээ авч, намын удирдлагаас ямар чадвар хайж байгаа талаар ойлголт авна.

→ Дэмжих сүлжээг бий болгож, өргөжүүлэх

Улс төрд амжилт гаргах эсэх нь тухайн оронд улс төрийн намууд яаж ажилладаг, мөн улс төрчдийн авчрах үр чадвар, туршлагаас ихээхэн хамаардаг. Гэвч эмэгтэйчүүдэд **дэмжлэг үзүүлэх сүлжээ** байхгүй бол, ялангуяа гэр бүлийн ойрын гишүүдээс дэмжлэг үгүй бол улс төрийн карьераа ахиулах маш хэцүү. Эмэгтэйчүүд улс төрийн нэлээд өндөр түвшинд гарч чадсан ч тухайн туулж өнгөрүүлсэн үе нь таатай, урамтай байж чадахгүй юм. Ийм дэмжих сүлжээ нь өөр хоорондоо өрсөлдөгч тэргүүлэх чиглэлийг тэнцвэртэй авч үзэх, улс төрийн ажилд суралцахад туслахын зэрэгцээ эмэгтэй нэр дэвшигчдэд заавар, удирдамж, дэмжлэг үзүүлж чадна.

Карьераа ахиулах төлөвлөгөө гаргахдаа эмэгтэйчүүд одоо байгаа болон ашиглах боломжтой нөөцөөс гадна дэмжих сүлжээгээ хөгжүүлэхэд анхаарах ёстой. Тийм дэмжих сүлжээг гурван аргаар хөгжүүлж болно. Үүнд:

- ✓ **Одоо байгаа хувийн сүлжээ:** Үүнд гэр бүл (хүүхэд, эхнэр, нөхөр, эцэг эх, ах, эгч, дүү, хамаатнууд), найз нөхөд, нийгмийн сүлжээ, хөршүүд;

171 Sarah Childs, Joni Lovenduski and Rosie Campbell, Women at the Top 2005: Changing Numbers, Changing Politics? (London: Hansard Society, 2005), p. 32.

- ✓ **Мэргэжлийн сүлжээ:** Үүнд мэргэжлийн холбоод (ажлын байр, мөн тухайн чиглэлийн мэргэжилтнүүдийг нэгтгэсэн холбоод), буяны байгууллагууд, нутгийн холбоо, оюутны сүлжээ, багш-эцэг эхийн холбоо зэрэг багтана. Үүнд эмэгтэйчүүдийн үнэлэмж, зарчмыг тусгасан үзэл санааны болон шашны сүлжээ ч багтаж болно. Мөн эмэгтэйчүүдтэй холбоотой чиглэлээр бизнес эрхлэгч буюу хандивлагч болж болзошгүй хүмүүс байж болно. Эцэст нь, улс төрийн ментор буюу дагуулан сургагч нь мэргэжлийн сүлжээдийн нэг хэсэг байж болох бөгөөд сонгуульд өрсөлдөх, нам дотроо албан тушаал ахих сонирхолтой эмэгтэйчүүдэд тусалж болно.
- ✓ **Бусад сүлжээ:** Үүнд тухайн орон нутгийн бизнесийн зөвлөл, нутгийн удирдлагын байгууллага, сайн дурын эсвэл буяны нийгэмлэг, намтай холбоотой бүлгүүд, мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээлэл ба харилцааны бүлгүүд, мөн эмэгтэйчүүдийн үнэлэмж ба итгэл үнэмшлийг тусгасан бусад холбоод, эмэгтэйчүүдийг хандивлагчид, кампанит ажилд дэмжлэг үзүүлэгчидтэй холбоход туслах байгууллагууд багтана.

→ **Мэргэжлийн болон хувийн амьдралаа тэнцвэртэй авч үзэх нь**

Дэмжих сүлжээ нь эмэгтэй, эрэгтэйчүүдийн аль алинд нь мэргэжлийн болон хувийн амьдралаа тэнцвэртэй авч явахад тусалдаг; эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь улс төрийн карьер өөрийнх нь хувийн амьдралд ямар нөлөө үзүүлж байгааг анхаардаг байх нь чухал. Улс төр бол томилолтоор явах, олон цагаар ажиллах, бүх зүйлээ зориулахыг шаарддаг мэргэжил юм. Улс төрийн карьер хөөх гэж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүс аль аль нь үүнийг сайтар санаж байх хэрэгтэй. Мэргэжлийн болон хувийн амьдралаа тэнцвэртэй авч явах гэдэг нь улс төр, сурталчилгааны үр чадвар бий болгох сургалтын хамгийн сүүлд ордог сэдэв юм. Гэвч энэ нь гэр бүл, найз нөхдийн дэмжлэгийг авах асуудалтай нэгэн адил тухайн эмэгтэйн улс төрийн карьер ахих эсэх, хэрхэн ахиж дээшлэх, мөн өөрөө сэтгэл ханамжтай байх эсэхэд ихээхэн нөлөөлдөг.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс амьдралын болон улс төрийн карьерынхаа янз бүрийн үе шатанд чухам юу тулгарч болох талаар ойлголттой байх нь чухал. Их сургуульд орох, гэрлэх, гэр бүлтэй болох, эцэг эхдээ анхаарал тавих, хүүхдээ их сургуульд суралцахад нь туслах, ажлаа солих, өөр хот руу шилжих зэрэг бүхий л томоохон үйл явдлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс амьдралынхаа тодорхой цаг үед түүлж өнгөрүүлж байдаг. Тухайн эмэгтэй өөрийнхөө тэргүүлэх чиглэлийг, мөн амьдралын янз бүрийн үе шатанд гэр бүл, найз нөхөд нь түүнээс юу хүлээхийг үнэлж үзэх нь улс төрийн карьераа бодитой төлөвлөх, биелүүлэхэд хэрэг болно.

Цаашилбал, ЕАБХАБ-ын гишүүн олон оронд хөдөлмөрийн уламжлалт жендэрийн хуваарь хүчтэй оршиж байгаа тул энэхүү тэнцвэрийг хангахад эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс хэцүү байна. Эмэгтэйчүүдэд гүйцэтгэх ёстой олон үүргийг оноосон байдаг. Хичнээн дэвшилттэй байсан ч аль ч улс оронд эмэгтэйчүүд гэр орон, үр хүүхдээ асрах гол халамжлагч байдаг. Энэ нь эмэгтэйчүүд төрийн алба хашихад нэг бэрхшээл үүсгэж байдаг. Улс төрийн нам дотроо карьераа ахиулах сонирхолтой байгаа эмэгтэйчүүд улс төрийн карьераа төлөвлөхдөө мэргэжлийн болон хувийн амьдралаа тэнцвэртэй авч үзэх шаардлагатай.

Шигтгээ 4.11. 2012 АИХЭА-ны судалгаанаас

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль аль нь гэр бүл, найз нөхдөөсөө дэмжлэг авах нь нэр дэвшихээр шийдэх, сонгогдох үед гардаг асуудлаас хамгийн хялбар нь гэж үзэж байна. **Гэвч гэр бүл, мэргэжлийн ажлаа тэнцвэртэй хөтлөх асуудлыг нэг ч эрэгтэй бэрхшээл гэж дурдаагүй байхад олон эмэгтэй түүнийг улс төрийн карьер хөөхөд хамгийн гол бэрхшээл гэж тодорхойлсон байна.**

Шигтгээ 4.12. Тэнцвэртэй авч үзэх асуудал: Францын орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүд

2008 оны Францын орон нутгийн сонгуулийн өмнөхөн орон нутгийн ИТХ-ын төлөөлөгч олон эмэгтэй, сонгуульд дахин өрсөлдөхгүй гэж шийдсэн бөгөөд мэргэжлийн болон гэр бүлийн амьдралаа улс төрийн ажилтай тэнцвэртэй авч явахад бэрхшээлтэй байгааг цохон тэмдэглэсэн байна.

Эх сурвалж: Европын комисс, Европын улс төр дэх эмэгтэйчүүд, Арга хэмжээ авах цаг, 2009.

Түүнчлэн гэрлэж, гэр бүлтэй болохгүй гэсэн сонголт хийсэн эмэгтэйчүүд эсвэл амьдралын өөр жим сонгосон эмэгтэйчүүдэд хэвшмэл ойлголтоор хандах явдал байсаар байна. Улс төрийн орчинд эмэгтэйчүүдийг амьдралдаа хийсэн сонголт эсвэл тухайн амьдарч буй нөхцөл байдлаар нь (сонголтоор эсвэл өөрөөр) гадуурхах явдал гарч болох бөгөөд ялангуяа уг сонголт, нөхцөл байдал нь уламжлалт үнэлэмж, замналаас өөр байх үед ийм явдал тохиолддог. Тухайлбал, эмэгтэй хүн хүүхэд гаргахгүйгээр шийдсэн бол, эсвэл гаргаж чадахгүй бол шүүмжлэл, дүгнэлтэнд өртөж, түүний эмэгтэйлэг шинж, үнэлэмжийг асуудал болгон гаргаж тавьдаг. Эмэгтэйчүүд тийм шүүмжлэл, дүгнэлтэд хариу өгөх эсэхээс үл хамааран ийм сөрөг хандлагад бэлтгэлтэй байх нь чухал.

Польшид эрэгтэй улс төрчдийн зүгээс эмэгтэй улс төрчдөд хандаж хэлсэн жендэрийн ялгаварлал бүхий эсвэл доромжилсон үгийг Интернет дээр нэр, зураг, хэлсэн үг, он сар өдөртэй нь тавих болсон¹⁷². Ийм үг

хэллэг, зан үйлийг улс төрд, ер нь нийгэм тэсээд өнгөрүүлээд байж болохгүй гэсэн санааг нийгэмд цацаж, энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд өөрийн карьерын эсвэл амьдралдаа хийсэн сонголтын улмаас дайралтанд өртөж буй эмэгтэйчүүд улс төрч эмэгтэйчүүдийг доромжилдог зантай улс төрчдөд дээрхтэй адил “нэрлэж, ичээх” аргыг ашиглаж болно.

4) Улс төрийн хөрөнгө нөөцийг удирдаж сурах

Карьерын төлөвлөгөө гаргасны дараах алхам нь түүнийг хэрэгжүүлэх явдал юм. Энэ хэсэгт эмэгтэйчүүдийн улс төрийн карьерын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийн асуудлыг дэлгэрэнгүй авч үзэв. “Хөрөнгө нөөц” гэж зөвхөн санхүүжилт биш харин намын бусад хөрөнгө нөөц, өөрөөр хэлбэл, хүмүүн капитал, түршлага, намын өмч, хэвлэл мэдээллийг ашиглах боломжийг бас хэлнэ.

→ Санхүүгийн төлөвлөлтөд оролцох

Улс төрийн намууд хөрөнгө нөөцийн хуваарилалтын шударга, ил тод байдлыг дээшлүүлэх төлөвлөгөө гаргах шаардлагатай талаар 3 дугаар бүлэгт дурдсан билээ. Тэгвэл намын эмэгтэй гишүүд **санхүүгийн төлөвлөлтөнд** оролцох санаачилга мөн гаргах ёстой. Үүнд:

- Эмэгтэй улс төрчид хандивлагчдын сүлжээтэй холбогдох хэрэгтэй, тийм холбоо бий болгох арга зам, төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Хандивлагчдын мэдээллийн сан, эсвэл намыг дэмжигчдийн жагсаалтыг асууж олж авах хэрэгтэй. Хэрэв бичгээр гаргасан тийм жагсаалт байхгүй бол намын удирдлага, намын шийдвэр гаргагчидтай холбоотой байдаг итгэлтэй нөхдөөсөө албан бусаар хүсч болно.
- Эмэгтэйчүүд сонгуулийн сурталчилгааны санхүүжилтээс яаж олж авахаа үнэлэн, төлөвлөх хэрэгтэй. Сурталчилгааны эхэн үед мөнгөтэй байх нь маш чухал, учир нь бусад хүмүүс хөрөнгө босгон дайчилж байх үед эмэгтэйчүүд хандивлагчтай биш сонгогчидтой ажиллан, сурталчилгаагаа хийгээд эхэлсэн байх нь зүйтэй.

172 See (in Polish only): <<http://wiadomosci.onet.pl/prasa/seksistowskie-zarciki-politykow/2vk4t>>.

- Эмэгтэйчүүд хувийн мөнгөө маш ухаалаг зарцуулах хэрэгтэй. Улс төрийн тогтолцооноос шалтгаалан улс төр бол цалин сайтай ч ажил байж болно, хувиасаа маш их зардал гаргадаг ажил ч байж болно. Тиймээс эмэгтэйчүүд өөрийн хөрөнгө мөнгөний байдал, улс төрийн карьертаа хэр зэрэг мөнгө зарцуулахыг хүсч байгаагаа урьдчилан үнэлсэн байх хэрэгтэй.

Сонгуулийн ямар тогтолцоотой, төрөөс улс төрийн намуудад санхүүжилт олгох хуулийн ямар журам үйлчилдэгээс үл хамааран эмэгтэйчүүдэд улс төрийн карьерынхаа янз бүрийн үе шат, үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө нөөц шаардагдаж байдаг. Тиймээс хэр зэрэг зардал гарахыг тооцоолж, зохих ёсоор төлөвлөсний үндсэн дээр эмэгтэйчүүд улс төрийн карьерынхаа гол цаг мөчид, тухайлбал, сонгуульд өрсөлдөх үедээ төсөвлөх, хөрөнгө нөөцөө удирдах үр чадвартай болсон байна. Тухайлбал, дараах төрлийн зардал гарч болно. Үүнд:

Шигтгээ 4.13. Бэлэн мөнгөний ач холбогдол

“Мөнгө бол улс төрд эхийн сүү юм.”

Жессе Марвин Унрух, АНУ-ын Ардчилсан намын нэртэй улс төрч, Калифорни мужийн төрийн сангийн дарга

1) Нэр дэвшихийн өмнөх үйл явц, сунгаа: Нэр дэвших, сонгох үйл явц эхлэхээс ч өмнө өрсөлдөх сонирхолтой байгаа нэр дэвшигчид өөрийгөө таниулах зорилгоор сонгогчдод хүрэх ажлаа эхэлсэн байдаг. Үүнд замын зардал, материал бэлтгэх, арга хэмжээ зохион байгуулах зардал шаардагдана. Мөн сонгуулийн зарим тогтолцоонд, тухайлбал, АНУ-д, эхлээд нам доторх сунгаа болж, нэр дэвшигчид үүнд нэмэлт зардал гаргадаг. Тиймээс тухайн нэр дэвшигч амжилт гаргах эсэхэд “мөнгөө эрт олсон байх” нь нэн чухал хүчин зүйл гэж тооцогддог.

2) Сонгуулийн үйл явцад ярилцлага өгөх, нэр дэвших зардал: ЕАБХАБ-ын зарим улс оронд парламентын сонгуульд өрсөлдөж буй хүмүүс нэр дэвшихтэй холбоотой хэд хэдэн зардал гаргахаас өөр аргагүй болдог. Үүнд сонгогчдын янз бүрийн бүлэгтэй уулзалт хийх замын зардал, ярилцлаганд орохдоо өмсөх хувцас, улс төрийн уулзалт ба намын хуралд суухад гарах зочид буудлын зардал зэргийг нэр дэвшигч ихэвчлэн хувиасаа төлнө. Намаас зарим зардлыг нөхөн олгодог ч зөвхөн ярилцлага өгөхөд гарах зардал л гэхэд эмэгтэйчүүд цааш үргэлжлүүлэхээс татгалзахад хүргэхээр өндөр байх талтай¹⁷³.

3) Сонгуулийн сурталчилгааны өмнөх ажлууд: Нэр дэвшсэний дараа сонгуулийн сурталчилгааны өмнөх үеийн буюу олонд танигдахтай холбоотой зардал голдуу гарна. Үүнд тухайн орон нутагт судалгаа хийх, сурталчилгаанд ажиллах хүмүүс элсүүлж авах, шийдвэр гаргагч, хүмүүсийн санаа бодолд нөлөөлөгч талуудтай харилцахын тулд уулзалт, арга хэмжээнд очиж оролцох зэрэг ажил багтана.

4) Сонгуулийн сурталчилгаа: Сонгуулийн сурталчилгааны зардалд зар сурталчилгааны талбар худалдан авах (телевиз, хэвлэл, интернет, радио), сурталчилгааны материал боловсруулах, өөрийн цахим хуудсыг хөгжүүлэх, айлуудад шуудан хүргэх, телемаркетинг зэрэг нийтэд сурталчлахтай холбоотой зардал, мөн тойрогтоо эсвэл улс орноор (тухайн сонгуулиас хамааран) тойрон уулзалт хийхэд гарах замын зардал, буудал, хоолны мөнгө, нийтэд зориулсан арга хэмжээний зардал (байр, хоол, материал) гарна.

5) Байнгын улс төрийн харилцаа: Улс төрийн карьер бол сонгуулиар эхэлж, сонгуулиар дуусдаггүй. Улс төрд амжилт гаргахын тулд дэмжигч талуудтайгаа байнга холбоо харилцаатай байж, дэмжигчдийнхээ тоог нэмж байх шаардлагатай. Ингэж

173 Pippa Norris and Joni Lovenduski, *Political Recruitment: Gender, Race and Class in the British Parliament* (Cambridge: Cambridge University Press, 1995), p. 145.

байнгын харилцаатай байхад замын зардал, сурталчлах зардал, ажлын албатай байх, мөн сонгогч, хандивлагчидтай ажиллах зардал шаардагдана. Улс төрийн эрх мэдлийн бүтцэд тухайн албан тушаал өндөр байх тусам сонгуулийн өрсөлдөөн төдий чинээ ширүүн болж, улмаар санхүүгийн хөрөнгө нөөцийн ач холбогдол төдий чинээ нэмэгдэж байдаг. Сонгуулийн сурталчилгааны зардал тухайн сонгуулийн тогтолцоо, тойргийн хэмжээ, сурталчилгаа үргэлжлэх хугацаанаас шалтгаална гэдгийг санаж байх нь зүйтэй.

→ Намын санхүүгийн хөрөнгө нөөцийг тодорхойлох, түүнээс олж авах

Судалгаанд хамрагдсан 5 улс орон, мөн ЕАБХАБ-ын бусад олон оронд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь хувьд сонгуулийн сурталчилгааны хөрөнгө босгох нь нэр дэвших, сонгогдоход хамгийн хэцүү ажил байдаг. 2012 оны АИХЭА-ны судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн 63 хувь, эрэгтэйчүүдийн 67 хувь нь “сонгуулийн сурталчилгааны санхүүжилт олох” нь нэр дэвшихэд хамгийн хэцүү алхам байсан гэж дурджээ.

Шигтгээ 4.14. 2012 оны АИХЭА-ны судалгаанаас:

Судалгаанд оролцсон 5 оронд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй улс төрийн бүх тоглогч нар “хөрөнгө нөөц хязгаарлагдмал байх” нь тухайн улс оронд эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөхөд тулгарч буй хамгийн эхний гол бэрхшээл мөн гэжээ.

Хөрөнгө чинээний жендэрийн ялгаанаас үүдэн эмэгтэйчүүд санхүүгийн хувьд ихээхэн сул нөхцөлд байдаг бөгөөд санхүүгийн хүндрэл нь улс төрийн карьер эхлүүлэхээс татгалзахад хүргэдэг гол шалтгаан юм¹⁷⁴. Судалгаанаас үзэхэд сонгуульд өрсөлдөх, улс төрийн карьераа ахиулахад тулгарч буй гол саад нь хөрөнгө чинээний жендэрийн ялгаа, санхүүжилт олох боломж эмэгтэйчүүдэд хязгаарлагдмал байгаа явдал юм. Дээр нь, эмэгтэйчүүдийн компани, бизнесийн сүлжээ хязгаарлагдмал байдаг нь улс төрийн санхүүжилт босгох чадварыг сулруулдаг. Улс төрийн нам хөрөнгө босгох дотоод механизмдаа ч эмэгтэйчүүдийг оруулдаггүй бөгөөд тэд намын хөрөнгө босгох асуудал хариуцсан хүмүүс,

хандивлагчидтай ойр байдаггүй. Эдгээр бүхий л хүчин зүйлийн улмаас эмэгтэйчүүд хөрөнгө босгох зохих үр чадвар, түршлага хуримтлуулаагүй байдаг тул санхүүжилт олох ажлыг эрчимтэй хийхээс цааргалдаг.¹⁷⁵

Дээр нь, бизнесийн өндөр албан тушаалыг мөн л эрэгтэйчүүд хашдаг.¹⁷⁶ Улмаар, сонгуулийн сурталчилгааны ажлын хандивлагч нь голдуу эрэгтэй байх бөгөөд тэдэнд улс төрийн хувьд өөрсдийнх нь үзэл бодлыг төлөөлж буй нэр дэвшигч, өөрсөдтэй нь адил төстэй хүмүүсийг дэмжихэд хялбар байдаг. Ингээд хандивлагчийн тооны хувьд ч, хандивын хэмжээний хувьд ч хэн хэнд хэр зэрэг санхүүжилт олгохоо тодорхойлоход орлого гол хүчин зүйл болж байгаа тохиолдолд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давуу байдалд байна.

3 дугаар бүлэгт дурдсанчлан, улс төрийн намуудад гишүүний татвараас гадна хувийн болон төрийн эх үүсвэрээс тодорхой санхүүжилт орж ирдэг. ЕАБХАБ-ын орнуудын ихэнх улс төрийн нам төрөөс нэлээд их хэмжээний санхүүжилт авдаг бөгөөд энэ нь

174 “Democracy and the Challenge of Change. A Guide to Increasing Women’s Political Participation”, Washington: National Democratic Institute for International Affairs (NDI), 2010, <http://www.ndi.org/Democracy_and_the_Challenge_of_Change>.

175 iKNOWpolitics, Summary of E-Discussion: Forum on Financing Women in Politics, October 2008, <<http://dev.iknowpolitics.org/files/E-disc%20Forum%20on%20Financing%20Women%20in%20Politics%20EN.pdf>>.

176 Stephanie Coontz, “The Myth of Male Decline”, The New York Times, 2012, <http://www.nytimes.com/2012/09/30/opinion/sunday/the-myth-of-male-decline.html?pagewanted=all&_r=0>; Catherine Rampell, “Women Earn Less Than Men, Especially at the Top”, The New York Times, 2009, <<http://economix.blogs.nytimes.com/2009/11/16/the-gender-pay-gap-persists-especially-for-the-rich/>>; “Women on Boards report”, Lords Select Committee, House of Commons, 2012, <<http://www.parliament.uk/business/committees/committees-a-z/lords-select/eu-internal-market-sub-committee-b/news/gender-balance-report-and-evidence/>>.

ихэнхдээ намын төсвийн 80-90 хувьтай тэнцдэг. Олон улсын сайн туршлагаас харахад улс төрийн намууд дотооддоо намын хөрөнгө нөөц, түүний дотор сонгуулийн сурталчилгааны мөнгө, намын өмч, сурталчилгааны материал зэргээс хүртэх боломж эмэгтэй, эрэгтэй хүмүүст адил тэгш байлгах шаардлагатай.¹⁷⁷

Намууд олон улсын стандарт, сайн туршлагын дагуу хөрөнгө нөөцөө хуваарилж байгаа эсэхийг тогтоохын тулд эмэгтэйчүүд дараах зүйлийн талаар мэдээлэлтэй болох хэрэгтэй. Үүнд:

- ✓ Намууд төрөөс ямар санхүүжилт авах эрхтэй, хэдийг авдаг вэ;
- ✓ Намын санхүүжилтийн өөр ямар эх үүсвэр байна вэ (гишүүний татвар, хувийн хэвшлийн тогтмол хандив, сонгуулийн сурталчилгааны хандив гэх мэт);
- ✓ Хөрөнгө санхүүжилтийг хуваарилахад дотоод ямар дүрэм, журам үйлчилж байна вэ? Энэ нь намын дүрэм, бусад баримт бичигт бичигдсэн үү эсвэл дүрмээр зохицуулагдаагүй байна уу?;
- ✓ Эдгээр хөрөнгө нөөцийг хэн мэдэж, хянаж байна вэ;
- ✓ Нам ямар үйл ажиллагааг санхүүжүүлж байна вэ.

Ийм мэдээллээр зэвсэглэснээр, хөрөнгө нөөцийг намын эрэгтэй гишүүдэд ашигтай ажиллагаанд зарцуулж байгаа эсвэл эрэгтэй гишүүдийн сурталчилгаанд зориулж байгаа бол эмэгтэйчүүд намын хөрөнгийн тэгш хуваарилалтын төлөө нөлөөллийн ажил хийх боломжтой болно. Гэвч намууд зөвхөн төрөөс биш хувийн хэвшлээс, түүний дотор хувь хүн, компаниас санхүүжилт авдаг гэдгийг санах нь зүйтэй. Тиймээс өмнө тэмдэглэсэнчлэн, намын хандивлагч, дэмжигчдийн жагсаалт байгаа эсэхийг олж тогтоон, тэндээс мэдээлэл авах хэрэгтэй.

→ Намын хэвлэл мэдээлэл, өмчийн талаар олж мэдэх, ашиглах

Улс төрийн намын хөрөнгө нөөц бол зөвхөн мөнгө төдийгүй бусад хэлбэрийн хөрөнгө нөөцөөс бүрддэг. Үүнд: хэвлэл мэдээлэлтэй харьцах хэлхээ холбоо; төрийн болон хувийн хэвлэл мэдээллийн эх сурвалжтай холбогдох; төрөөс олгосон үнэгүй нэвтрүүлгийн цаг; телевиз, радио, сонин сэтгүүлийн сэтгүүлчдийн мэдээллийн сантай холбогдох; зар сурталчилгаа, олон нийтийн байр суурьт нөлөөлөгч талуудтай холбогдох; мөн нийгмийн сүлжээ, шинэ технологи ашиглан нэр дэвшигчийн сурталчлах (Шигтгээ 4.15-аас зарим жишээг харна уу). Олон улсын сайн туршлагаас үзэхэд улс төрийн намууд хөрөнгө нөөцийн хуваарилалтанд ардчилсан байдлаар хандах ёстой бөгөөд үүнд намын хэвлэл мэдээллийн эх сурвалжийг эмэгтэй, эрэгтэй гишүүд ашиглах явдал мөн багтана.

Шигтгээ 4.15. Хэвлэл мэдээлэлтэй харьцахад хэрэг болох удирдамж, гарын авлага

Эмэгтэй нэр дэвшигчийг хэвлэл мэдээлэлтэй ажиллахад нь дэмжлэг болох үүднээс олон байгууллага гарын авлага, удирдамж боловсруулсан байдаг. Үүнд:

- **Эмилигийн жагсаалт, Сонгуульд өрсөлдөх гэж байна уу? Ардчилсан намын эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан удирдамж** 2003: <<http://emilyslist.org/sites/default/files/TORFO.pdf>>.
- **Хэвлэл мэдээллийн жэндэрийн мэдрэмжийн талаарх нэр дэвшигчдэд зориулсан удирдамж** 2012: <<http://www.sheshouldrun.org/assets/documents/name-it-change-it-candidate-guide.pdf>>.
- **Эмэгтэйчүүдийн мэдээллийн төв** <<http://www.womensmediacenter.com/>>.
- **Улс төрийн нам, хэвлэл мэдээллээр эмэгтэй нэр дэвшигчдэд хандаж буй байдал** <<http://www.politicalparity.org/research-inventory/media-coverage-of-women-candidates/>>.
- **НҮБХХ, Ардчиллын үндэсний хүрээлэн, Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн намуудын үүрэг** 2011: <<http://www.undp.mn/publications/Empowering-women-for-stronger-political-parties-eng.pdf>>.

177 See OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010, paras. 179–180.

Хэвлэл мэдээлэлтэй холбоотой байх, хэвлэлийн сурталчилгаа хэр чухал үүрэг гүйцэтгэх нь сонгуулийн тогтолцооноос тодорхой хэмжээгээр хамаарна. Тухайлбал, пропорционал тогтолцоотой үед намын удирдлага хэвлэл мэдээлэлтэй харьцах бүх асуудлыг зохицуулж, хүссэн мессэжээ өгөх магадлал өндөр. Тиймээс намын хэвлэлийн төлөөлөгчийн албыг эмэгтэй хүн хашиж байсан ч түүний өгч буй мэдээлэл нь намын аль нэг гишүүнийг дэмжих зорилготой байгаагаас бусад тохиолдолд аль нэг нэр дэвшигчийнх бус харин намынх (буюу намын удирдлагынх) байна. Ерөнхийдөө, эмэгтэйчүүд сонгуулийн сурталчилгааны үеэр бага харагддаг, ялангуяа улс төрийн намуудын явуулж буй сурталчилгааны материалд бага ордог. Тиймээс эрэгтэйчүүдтэй өрсөлдөж буй эмэгтэйчүүдэд сонгогчдын дунд өөрсдийгөө таниулах, харагдах байдлаа нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны бусад сүвгийг ашиглахад бэрхшээлтэй байдаг.

Мажоритар тогтолцооны хувьд эсрэгээрээ хэвлэл мэдээлэлтэй харьцахад нэр дэвшигч хувь хүмүүс гол үүрэг гүйцэтгэдэг. Эмэгтэйчүүдийн хувьд сонин, хэвлэлийн мэдээ, редакцийн зурвас, Твиттер, блог, Facebook, редакцид бичсэн захидал зэрэг одоо байгаа бүхий л сувгаар санаа, мэдээгээр хүргэх нь чухал. Тухайн үйлчилж буй тогтолцооноос үл хамааран эмэгтэйчүүд намын хөрөнгө нөөцөөс ашиглах тэгш боломжийн төлөө нөлөөллийн ажил хийх шаардлагатай. Үүнд:

- ✓ Сонгуулийн сурталчилгаа, арга хэмжээнд намын өмчийг ашиглах;
- ✓ Сайн дурынхныг дайчлах, сурталчилгааны материал бүрдүүлэх, хөрөнгө босгоход намын өмчийг ашиглах;
- ✓ Сонгуулийн сурталчилгааны материалыг санхүүжүүлэхэд намын хөрөнгийг ашиглах;
- ✓ Намын удирдлага (зураг авахуулах, сурталчилгааны уулзалтанд ирэх);
- ✓ Үндэсний болон орон нутгийн түвшинд намаас гаргасан хэвлэл мэдээллийн ажилтнуудын мэдээллийн сан буюу жагсаалт;
- ✓ Төрөөс улс төрийн намуудад олгосон үнэгүй нэвтрүүлгийн цагийн тодорхой хувь;
- ✓ Үндэсний болон орон нутгийн түвшинд намын нэр дэвшигчдийн дунд зохион байгуулах нээлттэй хэлэлцүүлэг;
- ✓ Намын сонгуулийн сурталчилгааны ажлыг дамжуулах сэтгүүлчид.

Шигтгээ 4.16. ЭМИЛИ жагсаалт: Ардчилсан эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан удирдамж

ЭМИЛИ жагсаалт бол эмэгтэйчүүдийг сонгуульд дэмжих зорилгоор байгуулагдсан АНУ-ын ТББ юм. ЭМИЛИ (EMILY) гэдэг нь “Early Money Is Like Yeast” буюу Санхүүжилт эрт олох нь гурил исгэгч л гэсэн үг (“исгэгч нь гурил өсгөдөг”) гэсэн үгсийн товчлол юм. Энэ нь өрсөлдөөний эхэнд босгосон хөрөнгө нь дараа, дараачийн хандивлагчийг татдаг зүй тогтлыг харуулсан хэллэг юм. Дээрх байгууллагын боловсруулсан *Ардчилсан намын эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан удирдамжид* мажоритар тогтолцоонд өрсөлдөж буй эмэгтэйчүүдэд зориулсан практик алхмуудыг дурджээ. Үүнд:

1. **Эхлэх:** Мөнгө босгох, өөрийн нэр дэвшилтийг үнэлж үзэх.
2. **Өөртөө тохирсон өрсөлдөөнийг тодорхойлох:** Өөрийн бэлэн байдлыг үнэлэх, зөв тойргоо сонгох.
3. **Хөрөнгө босгох:** Таны сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэх хандивлагч, хөрөнгө босгох.
4. **Санаагаа тодорхойлох:** Улс төрийн хувьд ямар байр суурь, өнгө төрхтэй байхаа тодорхойлох.
5. **Судалгаа хийх:** Өөрийн байр суурь, мөн өрсөлдөгчийнхөө байр суурийг батлах баримт боловсруулж бэлтгэх.
6. **Сонгуулийн сурталчилгааны баг бүрдүүлэх:** Таныг сонгогдоход туслах дэмжигчдийг тодорхойлох.
7. **Сонгогчидтойгоо холбогдох:** Ялалт байгуулахын тулд сонгогчиддоо хүрч ажиллах.

Эх сурвалж: EMILY's List, Thinking of Running for Office: A guide for Democratic Women Candidates, 2003.

5) Ялалтаа төлөвлөх: Сонгуульд ялах, дэвших

Өмнөх хэсэгт эмэгтэйчүүд улс төрийн амжилттай карьер хийхийн тулд урт хугацааны бэлтгэл хэрэгтэй талаар өгүүлсэн билээ. Харин энэ хэсэгт сонгуульд ялах магадлалаа дээшлүүлэхийн тулд намын эмэгтэй нэр дэвшигч юу хийх ёстойг авч үзье.

→ Улс төрийн сурталчилгаагаа эхлэх тохиромжтой цаг хугацааг тогтоох

Улс төрийн сонгуульд албан тушаалд өрсөлдөх (эсвэл нам дотроо албан тушаал ахихад) цаг хугацаа, төлөвлөлт хэрэгтэй. Энэхүү гарын авлагад эмэгтэйчүүд улс төрийн карьераа ахиулахын тулд стратеги, урт хугацааны арга барилаар хандахыг уриалсан аргуудыг дурдсан билээ. Намууд ер нь нэр дэвшигч элсүүлэх, сонгох ажлаа цаг хугацаанд нь хийдэг бол өрсөлдөхийг сонирхож буй намын гишүүд нэр дэвших эсэхээ эрт мэдэх боломжтой. Хамгийн сайнаар бодоход тийм нэр дэвшигчид сурталчилгааны ажлаа төлөвлөх, эхлүүлэхэд наад зах нь жилийн хугацаа олгогдоно.

Гэвч улс төрийн орчин эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдэд тийм тансаг хугацаа өгч тэр бүр чаддаггүй. ЕАБХАБ-ын олон оронд, түүний дотор судалгаанд оролцсон орнуудад, нэр дэвшигчдэд маш орой, хамгийн сүүлчийн мөчид хандсан байдаг. Зарим тохиолдолд, сонгуулийн өдрөөс нэг сарын өмнө л тэдэнд мэдэгдсэн байна.

Нэр дэвшигчид намын жагсаалтанд хаагуур байгаагаа мэддэггүй, улмаар сурталчилгааны ажил нь үнэхээр бодитой, боломжтой эсэхэд эргэлзэх тал гарна. Энэхүү цагийг нь тулгадаг, тохиолдлын шинжтэй арга барил нь эмэгтэйчүүдэд (мөн эрэгтэйчүүдэд) улс төрийн сурталчилгаагаа амжилттай төлөвлөхөд бэрхшүүл учруулдаг. Ийм орчинд эмэгтэйчүүд намын удирдлага нь сонгуулиас наад зах нь 3 сарын өмнө нэр дэвшигчээ сонгохыг хүссэн нөлөөллийн ажлыг нам дотроо хийж болно. Эмэгтэйчүүд ийм санаачилгыг сонгуулиас бүр өмнө, тухайлбал, хоёр жилийн өмнөөс гаргаж ёстой бөгөөд энэ нь улс төрийн сурталчилгаа эхлэхээс өмнө намын удирдлагад уг саналыг авч үзэх хугацаа олгоно.

Үүний зэрэгцээ эмэгтэйчүүд дээр дурдсан аргууд, тухайлбал, намын үйл ажиллагаа хэрхэн явагддагийг мэдэж авах, намын өрсөлдөөний талаар зураглал хийх, улс төрийн давуу сул талаа тодорхойлох, намын хөрөнгө нөөцийн байдлыг мэдэх, дэмжих сүлжээ бий болгох зэрэг ажлаа хэрэгжүүлээд эхэлсэн байх нь зүйтэй.

→ Улс төрийн сурталчилгаа эхлэх тохиромжтой тойргоо тодорхойлох

Улс төрийн өрсөлдөөнд амжилт гаргах эсэх нь сонгогчид аль нэр дэвшигчийг сонгох вэ гэдгээс гадна нэр дэвшигч өөрөө **сонгогчдын зөв буюу тохиромжтой** хэсгийг сонгосон эсэхээс шалтгаална. (Сонгогчдын тойргийн талаар хэрхэн судалгаа хийх зарим аргын талаар Шигтгээ 4.17-гоос харна уу).

Аль тойрогт дэвшвэл хамгийн тохиромжтой вэ гэдгээ тодорхойлохын тулд эмэгтэйчүүд хэд хэдэн асуулт асуух ёстойг эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан Эмили жагсаалтанд дурджээ (EMILY's List). Үүнд:

- ✓ Таны үзэл бодол тус тойргийн сонгогчдынхтой таарч байна уу?
- ✓ Энэ нь сул байгаа суудал уу эсвэл одоо байгаа хүнтэй нь өрсөлдөх ёстой юу?
- ✓ Одоо ажиллаж байгаа хүн байгаа бол түүний сул тал юу вэ?
- ✓ Сонгуульд голлон өрсөлдөх хүмүүс нь хэн хэн бэ?
- ✓ Өрсөлдөгчдийн дэвшүүлж буй санаа юу вэ, таны санаа түүнийхээс юугаараа дээр вэ?
- ✓ Таны намтар, үнэлэмж, сонирхол зэргийн улмаас дэмжинэ гэж үзэж болох сонгогчдын суурь бий юу?

- ✓ Тус тойрогт нам хэр зэрэг амжилттай байсан бэ?
- ✓ Сонгогчдын ирц өндөр үү, тэнд та танигдсан үү?
- ✓ Тэр цаг мөчид өөр бусад сонгууль явагдаж байна уу (орон нутгийн, парламентын гэх мэт), энэ нь сонгуулийн ирцэд нөлөөлж болзошгүй эсэх?
- ✓ Тус тойргийн хүн ам зүйн онцлог юу вэ, тэр бүлэгтэй та ямар нэг холбоотой юу?
- ✓ Тус тойргийн улс төрийн орчин ямар байна вэ, одоогийн чиг хандлага нь танд нааштай байна үү?
- ✓ Сонгуульд ялах саналыг та хаанаас авах вэ?¹⁷⁸

Шигтгээ 4.17. Сонгогчийн мэдээлэл авах

Санал хураалттай холбоотой мэдээлэл, түүний дотор сонгуулийн ирц, дахин сонгогдсон хувь, тухайн намын ялалт байгуулж байсан түүх, сонгогчдын хүн ам зүйн мэдээлэл зэрэг нь эмэгтэй нэр дэвшигчид чухал ач холбогдолтой. Дараахь эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж болно. Үүнд:

- Сонгогчийн санаа бодлын талаарх судалгаа;
- Сонгуулийн ерөнхий хороо (СЕС);
- Сонгуулийн ерөнхий хорооны орон нутаг, бүсийн салбар
- Сонгуулийн байр;
- Үндэсний болон орон Нутгийн статистикийн газар;
- ТББ ба судалгааны байгууллагууд;
- Олон улсын байгууллагуудын тайлан (ЕАБХАБ/АИХЭА сонгуулийн ажиглалтын тайлан гэх мэт).

Тухайн нэг дэвшигч аль тойрогт очихыг сонгох эрхийг ихэнхдээ намын удирдлага эдэлдэг. Тиймээс эмэгтэйчүүдийн цуглуулсан мэдээлэл нь намын удирдлагад өөртөө болон намдаа ялалт авчрах ямар магадлал байгааг харуулж, нөлөөлөхөд чухал хэрэг болно. Эмэгтэйчүүд уг мэдээллийн санг ашиглан тухайн тойрогт яагаад ялна гэж бодож байгаагаа тайлбарлах боломжтой. Уг тайлбарын үндсэн дээр тухайн эмэгтэй намын удирдлагын итгэлийг төрүүлэн, мажоритар тогтолцооны хувьд тухайн тойргийг, харин пропорционал тогтолцооны хувьд тухайн тойргийн намын жагсаалтад дээгүүр бичигдэх боломжтой. Аль ч тохиолдолд, нэр дэвшигч тойргийн талаар судлах нь сонгуулийн сурталчилгааны ажлаа хэрхэн явуулах талаар чухал мэдээлэл өгнө.

→ Санхүүжилт олох албан ба албан бус дүрмийг мэдэж авах

Сонгуулийн болон намын тогтолцоо нь тухайн нэр дэвшигч сурталчилгааны зардлынхаа хэр зэргийг өөрөө хариуцах, сурталчилгааны санхүүжилтээ яаж олох вэ гэдэгт нөлөөлж байдаг. Санхүүжилт олох **албан ба албан бус дүрмийг** мэдэж авах нь улс төрийн карьераа амжилттай хэрэгжүүлэхэд нэн чухал. Яг хэр зэрэг хөрөнгө хэрэгтэй болох, хэзээ хөрөнгө босгох, хэнээс санхүүжилт хүсэх вэ гэдэг нь аль ч тогтолцооны хувьд улс төрийн нууц байдаг.

Хандивлагчдад хандахын өмнө эхлээд сонгууль, улс төрийн нам, сонгуулийн сурталчилгаатай холбоотой хуулиуд, мөн намын дүрэм, журмаар сонгуулийн

сурталчилгааны хөрөнгө босгох ажлыг хэрхэн журамласан байдгийг олж мэдэх хэрэгтэй. Үүнд бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, хүлээн авах хандив болон зардлын хязгаарлалт, цаг хугацаа ба санхүүжилтийн эх сурвалж, тайлагналт ба ил тод болгох асуудал, мөн эдгээр журмыг даган мөрдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэрэг багтана. Түүнчлэн намын дотоод дүрмээр нэр дэвшигчийн хураамж, сонгуулийн сурталчилгаанд хөрөнгө хуваарилах, сурталчилгааны хураамж, намын хандивлагчидтай холбогдох зэрэг асуудлыг зохицуулсан байж болно.¹⁷⁹

178 EMILY's List, Thinking of Running for Office: A Guide for Democratic Women Candidates, 2003, <<http://emilyslist.org/>>.

179 See OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation, 2010.

Хүснэгт 4.18. Хөрөнгө босгохтой холбоотой хууль, журам, дүрэм

Албан ёсны дүрэм	Албан бус дүрэм
<ul style="list-style-type: none"> • Бүртгүүлэх, нягтлан бодох бүртгэлийн хувьд ямар шаардлага тавигдах вэ? • Сонгуулийн сурталчилгаанд хэн, хэр зэрэг хэмжээтэй хандив өгөхийг зөвшөөрсөн байдаг вэ (зөвшөөрсөн хандивлагч гэдэгт хувь хүн, иргэн, хуулийн этгээд багтах уу)? • Нэр дэвшигч хэр зэрэг мөнгийг сонгуулийн сурталчилгаанд хандивлаж болох вэ? • Нэр дэвшигч өөрийн сурталчилгаанд хэр зэрэг мөнгө зарцуулж болох вэ? • Нэр дэвшигч сурталчилгаанд мөнгөө хэзээнээс эхлэн цуглуулж, зарцуулж, хэзээ дуусгах ёстой вэ (сурталчилгааны хугацаанд гэх мэт)? • Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хандив өгсөн хүмүүс, зардлын хэмжээг хэрхэн хэзээ тайлагнаж, ил тод болгох ёстой вэ? • Сонгуулийн сурталчилгааны журмыг зөрчвөл ямар хариуцлага хүлээлгэх вэ? 	<ul style="list-style-type: none"> • Нам хөрөнгөө хэрхэн хуваарилдаг вэ? • Нам доторх хөрөнгө босгох ажил нь төвлөрсөн үү, төвлөрсөн бус үү? • Хөрөнгө босгох ажил, намын хөрөнгийг хуваарилах асуудлыг хэн хариуцдаг вэ? • Нэр дэвшигч нэр дэвшсэний хураамж төлдөг үү? • Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны санд хувь нэмэр оруулах үүрэг хүлээдэг үү? • Сонгуулийн сурталчилгааны материал гаргахад хөнгөлөлт үзүүлдэг үү? • Дотооддоо зардлын ямар нэг хязгаарлалт тавьдаг үү? • Намын хандивлагчдын жагсаалт нэр дэвшигчдэд нээлттэй байдаг үү?

Эх сурвалж: ЕАБХАБ/АИХЭА ба Европын Зөвлөлийн Венецийн комисс, Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамж, 2010

→ Санхүүжилтийн гадаад, дотоод эх үүсвэрийг тодорхойлох нь

Дээр дурдсанчлан, нэр дэвшигчийн **сонгуулийн сурталчилгааны санхүүжилт** гадны хандивлагч эсвэл намаас өөрөөс нь гарч болно. З дугаар бүлэгт цохон тэмдэглэсэнчлэн, намуудад олгох төрийн санхүүжилтийг хуваарилах журмын дагуу тодорхой хэсгийг эмэгтэй нэр дэвшигчдэд зориулахаар зааж болно. Тухайлбал, Ирланд, Финлянд, Италид ийм журам бий. Түүнчлэн зарим нам өөрсдөө эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан тусгай сан байгуулдаг; ийм сангийн хөрөнгөөр нэр дэвшигчийн бүртгэлийн хураамж, сурталчилгааны замын зардал, сурталчилгааны материалын зардлыг төлдөг. Эсвэл улс төрийн намын эмэгтэйчүүдийн байгууллага эмэгтэй нэр дэвшигчдээ дэмжих зорилгоор тусгай хөтөлбөр бий болгож болно. (дор 4.2.2 хэсгийг харна уу).

Гэвч сонгуулийн сурталчилгааны ажлын хамгийн том эх сурвалж нь хувийн хандивлагчид болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө байдаг. Тиймээс амжилттай улс төрч бол боломжит хандивлагч хэн болох, түүгээр дэмжүүлэхэд юу чухал вэ гэдгийг ойлгох шаардлагатай. Ерөнхийдөө, хандивлагчдыг “ашиг тусын 5 бүлэгт” хувааж болно (дор Зураг 4.19-ийг харна уу).¹⁸⁰

Эдгээр бүлэг нь улс төрийн хандивлагчдын янз бүрийн хэлбэрийг харуулж байгаа бөгөөд нэр дэвшигчид хамгийн ойр хэсгээс (нэр дэвшигчийн гэр бүл, найз нөхөд) эхлэн, түүний ойрын сүлжээ (хамт олны бүлэг, бизнесийн түнш, дэмжих сүлжээ, мөн нэгдмэл үнэлэмжид суурилсан бүсэд сүлжээ), мөн нийгэмд эрх мэдэл, нөлөө, тодорхой байр суурь бүхий хандивлагчдыг (эрх мэдэл бүхий бизнесийн өмчлөгчид, мэргэжлийн холбоод, сонирхлын тусгай бүлгүүд) багтаана. Бүлэг тус бүр нь тухайн нэр дэвшигчийг дэмжих өөр өөр учир шалтгаантай. Тиймээс эмэгтэйчүүд янз бүрийн эх үүсвэрээс

180 iKNOWPolitics, Summary of E-Discussion: Forum on Financing Women in Politics, October 2008, p. 5, <<http://dev.iknowpolitics.org/files/E-disc%20Forum%20on%20Financing%20Women%20in%20Politics%20EN.pdf>>.

улс төрийн болон санхүүгийн хувьд дэмжлэг авахын тулд тухайн хандивлагчийн сонирхлыг юу татах вэ гэдгийг мэдэж авах хэрэгтэй.

Мөн эмэгтэй хандивлагчийн сонирхлыг татах чадвартай эсэхээ бодолцож үзэх хэрэгтэй. Компаниудын удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн тул эмэгтэй хандивлагчид ч бизнест амжилтанд хүрэхийн тулд улс төрд байдагтай адил бэрхшээл туулсан байдаг¹⁸¹.

Жендэрийн тэгш байдлын төлөө эрмэлзэлтэй, бусад эмэгтэйчүүдэд үлгэр жишээ болох боломжтойгоо харуулах замаар энэ талаар санаа зовдог эмэгтэй хандивлагчдаас хөрөнгө босгож чадах бөгөөд улмаар эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг бэрхшээлийг даван гарч чадах юм¹⁸².

Зураг 4.19. “Ашиг тусын” 5 бүлэг



Хөрөнгө босгох, хандивлагчтай холбоотой албан ба албан бус дүрмийг, түүнчлэн тэд ямар сонирхол, шалгуураар дэмжлэг олгодогийг мэдэж авсны дараа эмэгтэйчүүд хөрөнгө босгох бэлтгэлтэй болно. Энэхүү гарын авлагад хөрөнгө босгох аргыг дэлгэрэнгүй дурдаагүй ч энэ сэдвээр эмэгтэй нэр дэвшигчдэд тус болох тодорхой, алхам бүрийг заасан хэд хэдэн чухал материалын жагсаалтыг оруулав (дэлгэрэнгүйг Шигтгээ 4.20-оос харна үү).

181 Currently women make up just 4.2 per cent of CEOs listed among Fortune’s top 1000 companies. “Women CEOs of the Fortune 1000”, Catalyst 1 January 2013, <http://www.catalyst.org/knowledge/women-ceos-fortune-1000>.

182 iKNOWPolitics, Summary of E-Discussion: Forum on Financing Women in Politics, October 2008, p. 5, <<http://dev.iknowpolitics.org/files/E-disc%20Forum%20on%20Financing%20Women%20in%20Politics%20EN.pdf>>.

→ **Сонгогчиддоо зориулан улс төрийн байр сууриа тодорхойлох: танигдах**

Улс төрд амжилттай байгаа эсэхийг харуулах ганц үзүүлэлт бол нэр, юу хийснийг нь мэдэж байгаа хүний тоо гэж зарим хүн үздэг.¹⁸³ “Танигдах” гэдэг нь тухайн улс төрчийг аливаа шалтгаанаар мэдэж буй хүний тоо юм. Энэ нь сонгуулийн үр дүнд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйлийн нэгд тооцогддог.

2011 оны судалгаагаар “хүмүүс таньдаг нэрэнд таатай ханддаг төдийгүй танил нэртэй нэр дэвшигчийг илүү дээр гэж боддог. Танигдсан байх нь мэдээлэл муутай сонгуульд чухал байдаг, учир нь хүмүүс ялж магадгүй гэсэн хүнийг дэмжих хандлагатай байдаг.”¹⁸⁴ Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд байсан уу, шинээр дэвшиж байгаа юу гэх мэт бусад мэдээлэл байхгүй тохиолдолд сонгогчид тухайн хүний талаар дуулсан, мэддэг эсэхдээ тулгуурлан гол шийдвэрээ гаргадаг. Өөрөөр хэлбэл, тухайн нэр дэвшигчийн хэр тохиромжтой талаар шийдвэр, дүгнэлт хийх мэдээлэл байхгүй тохиолдолд “боловсронгүй таамаг” хийхдээ түүний талаар дуулсан эсэхдээ тулгуурладаг байна. Иймээс танигдсан байх гэдэг нь сонгогчийн шийдвэр гаргахад нөлөөлөх улс төрийн итгэл үнэмшил, үнэлэмж, мөнгөө юунд зарцуулдаг, хувь хүний шинж чанар, олон нийтийн дундах дүр төрх, ажлын гүйцэтгэл зэрэг нэр дэвшигчийн шинж чанарыг орлох үзүүлэлт болдог байна.¹⁸⁵

Сонгогчдод танигдах нь эмэгтэйчүүд улс төрийн байр суурь, өнгө төрхөө бүрдүүлэх үйл явцын нэг хэсэг байх ёстой. Хэрэв тухайн эмэгтэй бизнес, спорт, урлаг, хэвлэл мэдээлэл зэрэг өөр салбарт сайн танигдсан бол түүнд сонгогчдын тодорхой бүлэг аль хэдийн байна гэсэн үг юм. Ийм үед тэрээр тухайн салбарт гаргасан амжилтаа улс төрийн капитал болгон хувиргаж, бусад сонгогчдыг татах хэрэгтэй.

Түүнчлэн тухайн эмэгтэй нэр дэвшиж буй тойрогтоо сайн танил биш бол бодлогын гол чиглэлээр өөрийнх нь улс төрийн байр

Шигтгээ 4.20. Эмэгтэй нэр дэвшигчдэд зориулан сонгуулийн сурталчилгааны хөрөнгө босгох талаарх лавлах материалууд

Эмэгтэйчүүдэд сонгуулийн сурталчилгааны хөрөнгө босгоход нэмэр болгох удирдамж, гарын авлага зэргийг олон байгууллага бэлтгэж гаргасан байдаг. Заримыг нь дор дурдав:

- 1. Эмэгтэйчүүдэд зориулсан глобал сан, Өөрчлөхийн төлөө хөрөнгө босгох нь: эмэгтэйчүүдийн эрхийн төлөө ажилладага байгууллагуудад зориулсан практик удирдамж.** <<http://www.globalfundforwomen.org/storage/images/stories/downloads/Handbook2007.pdf>>.
- 2. Бид чадна, эмэгтэй нэр дэвшигчид ба сонгуулийн сурталчилгааны санхүү.** 2007. <http://www.fcm.ca/Documents/tools/Women/Election_Toolkit_for_Women_The_Candidates_Guide_to_Municipal_Elections_EN.pdf>.
- Канадын орон нутгийн холбоо, **Эмэгтэйчүүдэд зориулсан сонгуулийн багц.** <http://www.fcm.ca/Documents/tools/Women/Election_Toolkit_for_Women_The_Candidates_Guide_to_Municipal_Elections_EN.pdf>.
- 4. Улс төрийн тэнцвэр, улс төрийн ба манлайллын талаарх материал.** <<http://www.politicalparity.org/politicaland-leadership-resources/>>.
- Үндэсний ардчиллын хүрээлэн, **Сонгуулийн сурталчилгааны ажлын хөрөнгө босгох.** <http://www.ndi.org/files/1925_gy_candidateskills_010104_251_308.pdf>.

Түүнчлэн, эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан хэд хэдэн цахим хуудас, эх сурвалж бий:

1. Эмилигийн жагсаалт: <<http://emilyslist.org/>>.
2. KNOW Politics: <<http://iknowpolitics.org/en>>.
3. Сонгууль, ардчиллын туслалцааны олон улсын хүрээлэнгийн Улс төрийн санхүүгийн мэдээллийн сан: <<http://www.idea.int/politicalfinance/>>.

183 Cindy Kam and Elizabeth Zechmeister, “Name Recognition and Candidate Support”, Center for the Study of Democratic Politics at Princeton University, April 2011, <<http://www.princeton.edu/csdp/events/Kam04282011/Kam04282011.pdf>>.

184 Ibid.

185 See, for example, Louis H. Abramowitz, The United States, its people and leaders (New York: Globe Book Co, 1975).

суурийг илтгэсэн; улс төр, үзэл суртал, хувь хүний үнэлэмжийг тусгасан; мөн сонгогчдын төлөө юу хийж чадахыг нь тодотгосон улс төрийн байр суурийг боловсруулах хэрэгтэй. Улс төрийн байр сууриа боловсруулахын тулд ямар үнэлэмж тусган баримтлах, улс төрийн ямар санаа буюу мессэж өгөхөө сайтар бодох хэрэгтэй. Улс төрийн байр сууриа боловсруулж, сайжруулахад дараах асуулт тусална. Үүнд:

Шигтгээ 4.21. Улс төрийн хувьд илүү сайн танигдах

Сонгуулийн сурталчилгааны үеэр нэр дэвшигчид өөрсдийгөө таниулах олон арга ашигладаг. Тухайлбал, радио, телевиз, сонингийн зар сурталчилгаа; сонгуулийн сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр түгээх; нэр дэвшигчийн талаар өгүүлэг бичих, клип хийх; том зурагт хуудас, нугалбар зэрэг сурталчилгааны материал хийх; үзэг, энгэрийн зүүлт, наалт, футболк, кофены аяга, маусны суурь гэх мэт сурталчилгааны бүтээгдхүүн гаргах зэрэг багтана.

- ✓ Та улс төрд яагаад орсон бэ?
 - ✓ Танд намтар, үнэлэмж, сонирхол зэргээс тань үүдсэн дэмжлэгийн суурь энэ нутаг орчимд бий юу?
 - ✓ Намын бодлогын байр суурийн талаарх таны бодол? Энэ санаа бодол, байр суурийг танай нутаг орчмынхон дэмжих үү?
 - ✓ Танд, таны сонгогчдод тулгарч буй нийгэм, эдийн засаг, улс төрийн хамгийн чухал асуудал юу вэ, та тэдгээрийг яаж шийдвэрлэх саналтай байна вэ?
 - ✓ Одоо хэлэлцэгдэж буй, шинэчлэл хийгдэж буй бодлогын гол асуудал, эрх зүйн санаачилгын талаарх таны байр суурь?
 - ✓ Та улс төрч болохын хувьд ямар санаа буюу мессэж өгмөөр байна вэ, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд улс төрийн талбарыг хэрхэн ашиглах вэ?
 - ✓ Та хувь хүний хувьд нутаг орчимдоо хэр нэр хүндтэй вэ?
- ✓ Таныг улс төрийн хувьд итгэж болох хүн, удирдагч гэж хардаг уу?¹⁸⁶
 - ✓ Та арван жилийн дараа өөрийгөө хаана байна гэж төсөөлж байна вэ?

→ Сонгуулийн сурталчилгааны баг бүрдүүлэх

Санхүүжилтийн эх үүсвэрүүдийг тодорхойлж, улс төрийн байр сууриа боловсруулсны дараа эмэгтэйчүүдэд сурталчилгааны ажлаа хийхэд туслах дэмжигчдийн баг элсүүлэх цаг ирнэ. Сонгуулийн сурталчилгааны ажлаа бүхэлд нь ганцаараа хийж чадах нэг ч нэр дэвшигч байхгүй. Сонгуулийн сурталчилгааны баг нь хэр том байх, сайн дурынхан уу эсвэл цалинтай хүмүүс байх уу гэдгээс үл хамааран уг **баг нь** эмэгтэйчүүдэд сонгуулийн сурталчилгааны ажлаа зохион байгуулалттай, үр ашигтай хийхэд тусална.

Санхүүгийн хязгаарлагдмал нөөцтэй нэр дэвшигчид сайн дурынхан, дэмжигчдийн сүлжээнд (гэр бүл, найз нөхөд, мэргэжил нэгтнүүд), мөн сурталчилгааны ажлын менежер (цалинтай эсвэл сайн дурын) голлон тулгуурлаж, улс төрийн сурталчилгааны ажлаа хэрэгжүүлнэ. Тус баг хэдэн хүнтэй байх гэдэгт бусад хүчин зүйл ч нөлөөлнө. Үүнд:

- **Сонгуулийн тогтолцоо:** Мажоритар тогтолцоотой буюу нэр дэвшигчид тойрогт өрсөлдөх бол, дээр нь намын хөрөнгө нөөц хязгаарлагдмал бол сонгуулийн сурталчилгааны багтай байх нэн чухал. Харин пропорционал тогтолцоотой, намын жагсаалтаар сонгогдох бол нам гол сурталчилгааг хийх тул сурталчилгааны том баг шаардлагагүй, зөвхөн сонгогчидтой ажиллах сайн дурынхан/дэмжигчид байхад болох юм;

186 See EMILY's List, Thinking of Running for Office: A Guide for Democratic Woman Candidates, 2003, <<http://emilyslist.org/>>.

- **Тойргийн хэмжээ:** Тойргийн хэмжээ томрох тусам утсаар ярих, айлаар явах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах гэх мэт сонгогчидтой ажиллахад дэмжих, туслах хүний хэрэгцээ нэмэгдэнэ;
- **Өрсөлдөөнт байдал:** Тухайн эмэгтэй нэр дэвшигч сүүдлын одоо байгаа эзэнтэй өрсөлдөж байгаа эсвэл ер нь сонгууль их өрсөлдөөнтэй байгаа бол түүнд илүү их дэмжлэг шаардагдана. Сонгогчидтой ажиллаж, хөрөнгө босгон, эмэгтэй нэр дэвшигчийг танигдахад нь туслах сонгуулийн сурталчилгааны баг хэрэгтэй болно.

Дараах хэсэгт сонгуулийн сурталчилгааны багт байвал хэрэгтэй гол албан тушаалыг дурдав (Шигтгээ 4.22). Эмэгтэйчүүд эдгээр албан тушаалын алиныг нь ч эсвэл бүгдийг нь сайн дурын хүмүүсээр хийлгэж болно. Дээр дурдсанчлан, сурталчилгааны баг бол 1) бие даан өрсөлдөж буй эмэгтэй нэр дэвшигч; мөн 2) мажоритар тогтолцоонд өрсөлдөж буй эмэгтэй нэр дэвшигчдэд илүү чухал юм. “Хаалттай жагсаалт” бүхий пропорционал тогтолцоотой, эсвэл нэн чухал гэж үзсэн сонгуульд (сенат, хотын дарга гэх мэт) нам тухайн нэр дэвшигчийг дэмжих хариуцлагыг өөр дээрээ авах тал бий. Тиймээс сонгуулийн сурталчилгааны багийн талаарх дараах тайлбар бол мажоритар тогтолцоонд илүү хамаатай бөгөөд сонгуулийн сурталчилгааны ажлын янз бүрийн талыг хамарсан мэдээлэл өгөх зорилгоор оруулав.

Сонгуулийн сурталчилгааны багийг **сурталчилгааны менежер** удирдаж, нэр дэвшигчид стратеги зөвлөгөө өгч, хэвлэл мэдээлэлтэй харьцах болон хөрөнгө босгох ажиллагаанд оролцох зэргээр нэр дэвшигчийн санааг нийтэд хүргэхэд тусална. **Санхүүгийн зөвлөх буюу хөрөнгө босгох ажил хариуцсан ажилтан** нь нэр дэвшигчид сурталчилгаагаа хийх хөрөнгө босгох, түүнийг удирдан зарцуулах, түүний дотор төсөв боловсруулах, хандивлагчийг олж тотоох, хөрөнгө босгох талаар утсаар ярих, хөрөнгө босгох арга хэмжээ зохион байгуулж, хойноос нь хөөцөлдөх зэргээр нэр дэвшигчид тусална.

Хуулийн зөвлөх нь нэр дэвшигчийн өмгөөлөгч бөгөөд сурталчилгааны бүхий л ажил, арга хэмжээ үндэсний хууль тогтоомж, журмын дагуу явагдаж байхад анхаарал тавина. Түүнчлэн сонгуулийн гол санаа буюу мессэж, улс төрийн байр суурийг бүрдүүлж, түүнийг хэвлэл мэдээллийн сүвгуудаар хүргэхэд нэр дэвшигчид туслах **хэвлэл мэдээллийн ажилтан** хэрэгтэй. Хэвлэлийн ажилтан нь нэр дэвшигчийн хэвлэлийн төлөөлөгчийн ажлыг мөн хийж, аль нэг асуудлын талаар судалгаа хийх, мөн сурталчилгааны эхэн үед санал асуулга явуулах зэрэгт тусална. **Талбар хариуцсан ажилтан** нэр дэвшигч ба сонгогчид холбоотой ажиллахад тусалж, айлаар явах, сонгогчдод хүрэх, сонгуульд оролцохыг уриалах зэргээр сурталчилгааны ажлыг гардан хийнэ.

Мөн сайн дурын ажилтан элсүүлэх, сонгогчидтой ажиллах зэрэг сайн дурынхны ажлыг удирдан хяналт тавих **сайн дурын ажилтан хариуцсан**

Шигтгээ 4.22. Үндэсний болон парламентын сурталчилгааны багийн байж болох бүрэлдэхүүн

- 1. Сурталчилгааны ажлын менежер:** Сурталчилгааны ажлыг бүхэлд нь хариуцана.
- 2. Санхүүгийн зөвлөх/хөрөнгө босгох ажилтан:** Хөрөнгө босгоход тусална.
- 3. Хэвлэл мэдээллийн ажилтан:** Хэвлэлийн төлөөлөгчөөр ажиллаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.
- 4. Хуулийн зөвлөх:** Сурталчилгааны ажил хуулийн дагуу явагдахад анхаарал тавина.
- 5. Талбарын ажилтан:** Сурталчилгааны ажлыг газар дээр нь зохицуулна.
- 6. Сайн дурын ажилтнуудын зохицуулагч:** Сайн дурын ажилтнуудыг элсүүлж, удирдана.
- 7. Зохион байгуулалтын дэмжлэг:** Нэр дэвшигчид очих ёстой газраа, цагтаа очиж байхад анхаарна.

Эх сурвалж: Эмилигийн жагсаалт, Сонгуульд өрсөлдөх гэж байна уу: Ардчилсан намын эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан удирдамж, 2003.

зохицуулагч байх нь нэр дэвшигчдэд хэрэгтэй байдаг. Эцэст нь, **ложистик буюу зохион байгуулалт, хуваарь хариуцсан ажилтан** нэр дэвшигчийн ажлын хуваарийг зохицуулж, арга хэмжээнүүдэд цагтаа очих зэрэгт тусална.¹⁸⁷

Эмэгтэйчүүд олон ажилтан авах боломжгүй байж болно, тэр тохиолдолд чадварлаг, түршлагатай сонгуулийн сурталчилгааны менежер авахад гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Бусад ажлын хувьд хувийн болон мэргэжлийн сүлжээгээ ашиглан сурталчилгааны ажлын аль үе шатанд хэн сайн дураар тусалж чадахыг тодорхойлж болно. Эсвэл сурталчилгааны багт хүн ажиллуулахад намын сурталчилгааны ажлын санг ашиглаж болох юм.

→ **Хамгийн сүүлийн үеийн технологи ашиглаж, үйл явдлын тэргүүнд байх**

ЕАБХАБ-ын бүс нутагт **нийгмийн сүлжээний шинэ хэлбэрүүд** нь сонгуулийн сурталчилгаа хийх, ер нь улс төр хийх аргыг өөрчилж байна. Вэбэд суурилсан хэрэгслүүд нь улс төрчид, улс төрийн байгууллагууд, сонгогчдын хоорондын харилцааны шинэ сүлжүүд бий болгоход тусалж байна. Нийгмийн сүлжээний арга хэрэгслүүдээс дурдвал:

- Facebook
- Твиттер
- Блог
- Нийгмийн сүлжээний цахим хуудсууд
- Гар утасны мессэж үйлчилгээ.

Шигтгээ 4.23. Нийгмийн сүлжээгээр дамжуулан нэр дэвшигч эмэгтэй, түүний намын ардчилсан дүр төрхийг сайжруулах нь

АНУ-д 2008 онд Барак Обама сонгуулийн сурталчилгаагаа хийхдээ нийгмийн сүлжээний давуу талыг ашиглан, Ардчилсан намыг олон нийт, сонгогчдын амьдрал, бодит нөхцөл байдалтай илүү ойр гэсэн санааг тархаагаад зогсохгүй тийм болгож чадсан. Түүний цахим хуудсанд олон төрлийн вэбэд суурилсан үйл ажиллагаа, арга техник байгаа бөгөөд нэр дэвшигч тэдгээрийг сонгогчидтойгоо харьцахад ашиглаж болох юм.

Эх сурвалж: <<http://www.barackobama.com>>.

Эмэгтэйчүүд улс төрийн харилцаа үүсгэх эдгээр шинэ хэлбэрийг ашиглах боломжийг алдаж болохгүй. Юуны өмнө, эдгээр нь сонгогчидтой холбогдох зардал багатай арга бөгөөд нэр дэвшигч замд гарах тоог бууруулна. Хоёрдугаарт, нийгмийн сүлжээ нь нэр дэвшигч, сонгогч хоёр шууд харилцах боломж олгодог бөгөөд нам, хэвлэл мэдээллийн байгууллагаас нэр дэвшигчдэд олгох нэвтрүүлгийн цаг, сурталчилгааны ажлын санхүүжилтээс хамааралгүй байдаг. Гуравдугаарт, нийгмийн сүлжээгээр дамжуулан сонгогчидтой шууд холбогдох боломжийг ашиглан эмэгтэй нэр дэвшигчид залуу сонгогчдыг хэрхэн ойлгож, хүндэтгэж байгаагаа илэрхийлж

болно. Учир нь вэбэд суурилсан нийгмийн сүлжээг ашиглагч нь голдуу залуучууд байдаг.

Шинээр үүсэн бий болж буй энэхүү сүлжээг бүрэн ашиглахыг хүсэхгүй байгаа эсвэл түүнийг ашиглах механизм байхгүй эмэгтэйчүүд цахим хуудас зэрэг уламжлалт цахим хэлбэрийг ашиглаж болно. Тухайлбал, намын цахим хуудсыг ашиглан эмэгтэйчүүд сонгогчдынхоо сонирхож буй бодлогын асуудлыг сурталчилж болно. Гэвч ЕАБХАБ-ын олон улс оронд интернетийн хэрэглээ, ялангуяа эмэгтэйчүүдийн дунд сайнгүй гэдгийг санах нь зүйтэй. Айлаар явах, олон нийтийн уулзалт хийх, шуудан илгээх, хөрөнгө босгох эсвэл хэвлэл мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг сонгуулийн сурталчилгааны уламжлалт хэлбэрийг нийгмийн сүлжээ дэмжих боловч орлох ёсгүй.

187 Adapted from: "Thinking of Running for Office: A Guide for Democratic Women Candidates", EMILY's List, 20 03, <<http://emilyslist.org/>>.

→ Сонгуулийн сурталчилгааны ажлын талаар тэмдэглэн үлдээх

Нийгмийн сүлжээ, вэбэд суурилсан бусад арга нь эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны ажлын **ой санамж** бүрдүүлж, үлдээх практик, үлдэцтэй арга юм. Энэ нь эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд эзлэх хувь доогуур байгаа улс орнуудад илүү чухал. Сурталчилгааны ажлын сайн практик, авсан сургамж зэргийг цуглуулж, бусад эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих, дайчлах, хүсэл эрмэлзэл төрүүлэхэд ашиглаж болно. Тухайлбал, 2007 оны Казакстаны орон нутгийн сонгуульд бие даан нэр дэвшсэн Ирина Уншакова өөрийн сурталчилгааны ажлын туршид онлайн тэмдэглэл хөтөлж¹⁸⁸, бараг өдөр тутам хийсэн зүйл, тулгарсан бэрхшээлээ бичиж байв. Уг тэмдэглэлдээ тэрээр “Би өрсөлдөж байна, энэ айх, өвдөх, ичих, инээд хүрмээр зүйл биш” гэсэн гарчиг өгсөн байв. Тэрээр сонгогдож чадаагүй ч бусад эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдэд хэрэгтэй мэдээлэл, зөвлөгөө, урам зориг өгсөн билээ.

Эмэгтэй нэр дэвшигч сонгогдсон ч бай, сонгогдоогүй ч бай, нэр дэвшсэн үйл явцаа баримтжуулж үлдээвэл дараа удаа нэр дэвшихэд мөн хэрэг болно. Эмэгтэйчүүд үг мэдээллийг шинжлэн үзэж, юу болсон, юу болохгүй байсныг тогтоон, сонгуулийн стратегээ боловсруулахдаа харгалзан үзэж болох юм.

→ Жендэрээс үүдэлтэй улс төрийн манипуляцийг ялгаж сурах

Эмэгтэйчүүд болон тэдний өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгааны ажлаа хэрхэн явуулж, улс төрийн талбарт биеэ авч явж байна вэ гэдгийг судлан үзвэл улс төрийн карьераа хэрхэн зохицуулж, ахих тухайд хэрэгтэй зүйл олж мэдэж болно. Тухайлбал, жендэрээс үүдэлтэй улс төрийн манипуляц хийх аргыг мэдэж авснаар улс төрийн карьер, нэр дэвших үедээ тулгарах саадыг даван гарч чадна.

1) Улс төрийн давамгайлал үзүүлэх аргыг мэдэж авах

Нийгэмд, ялангуяа улс төрийн хүрээнд улс төрийн нам, улс төрчид ухамсартай болон ухамсаргүйгээр эрэгтэйчүүдийн давамгайллыг хэрэгжүүлж байдаг. Энэ сэдвээр хийсэн судалгаанаас үзвэл¹⁸⁹ үүнд дараах арга багтдаг: эмэгтэйчүүдийг үл үзэгдэгч болгох, дорд үзэх, тэдэнд мэдээлэл өгөхгүй байх эсвэл улс төрийн үйл ажиллагааг нь буруутгаж, үгүйсгэх, ичээх.

Зарим улс төрийн нам эмэгтэйчүүдийн санаа бодол, байр суурийг нухацтай хүлээж авдаггүй.¹⁹⁰ Ялангуяа эмэгтэйчүүд гэр бүл, нийгэмд гүйцэтгэдэг үүрэг, хариуцлагатай нь холбоотой, өөрт нь нэн чухал асуудлаар саналаа хэлэхэд үл тоомсорлодог. Намын эрэгтэй гишүүд эмэгтэйчүүдийн санал, байр суурийг сонсохгүй эсвэл тэдний дэвшүүлсэн асуудлыг сонирхохгүй байгаагаа ил харуулж, үг асуудлыг “эмэгтэйчүүдийн асуудал” гэж тооцоход эмэгтэйчүүдэд үл үзэгдэгч болсон мэт сэтгэгдэл төрдөг. Энэ бол эмэгтэйчүүдийг **чухал биш, үл үзэгдэгч** болгох арга юм. Эмэгтэйчүүдийг **шоолж, тохуурхах, дорд үзэх нь** эрэгтэйчүүд өөрсдийн давамгайллаа үзүүлж буй бас нэг арга бөгөөд үүнийг зарим эмэгтэй ч ашиглаж байж болно. Эмэгтэйчүүдийн гадаад байдал, нас, сэтгэл хөдлөлийн байдлыг нь онцолсон үг хэллэг оруулж ярих нь энэ аргын нэг жишээ юм.

188 188 Ирина Уншакова, “Смотрите, Я Баллотируюсь – И Это Совсем Не Страшно, Не Больно, Не Стыдно И Не Смешно. Даже не победив, можно чувствовать себя выигравшей” Народный сетевой журнал: про женщины мужчин. [Irina Unzhakova. “Take a look, I am running, and it is not scary, painful, shameful or funny. Even if you are not elected, you can feel yourself a winner”. People’s web journal: about women and men], 2007, <http://caucasia.at.ua/publ/iz_zhurnala_quotdialog_zhenshinquot/dnevniki/vybyro_kandidatskij_dnevnik_iriny_unzhakovoj_2007/6-1-0-8>.

189 189 Professor Berit, as cited in “Power Booklet”, Swedish Social Democratic Party, S-Kvinnor Sveavägen, Stockholm, 1995, p.13.

190 “Assessing women’s political party programs: best practices and recommendations” (Washington: NDI, 2008).

Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг албан ёсны уулзалт, хэлэлцүүлэгт оруулахгүй үлдээх, өөрсдийгөө туршлагатай тул тэдний өмнөөс шийдвэр гаргах эрхтэй гэж үзэх замаар ухамсартай эсвэл ухамсаргүйгээр **мэдээллийг эмэгтэйчүүдээс нуух** нь нэлээд их тохиолддог. Мэдээлэл өгөхгүй байх энэ арга нь эмэгтэйчүүдийн санал бодлоо илэрхийлэх, шийдвэрт нөлөөлөх боломжийг үгүйсгээд зогсохгүй эмэгтэйчүүд бол шийдвэр гаргах туршлага, мэдлэг, чадваргүй гэсэн хэвшмэл ойлголтыг бататгаж байдаг.

Шигтгээ 4.24. Улс төрд давамгайлах аргууд

- ✓ Эмэгтэйчүүдийг үл үзэгдэгч болгох;
- ✓ Эмэгтэйчүүдийг шоолж, дорд үзэх;
- ✓ Мэдээлэл өгөхгүй нуух;
- ✓ Эмэгтэйчүүдийг давхар шийтгэлд өртүүлэх;
- ✓ Эмэгтэйчүүдийг буруутгах, үгүйсгэх замаар дарамт учруулах.

Эх сурвалж: “Эрх мэдлийн брошюр”, Шведийн социал демократ нам, S-Kvinnor Sveavägen, 68 O.O. Box 70458, S-107 26 Stockholm, 1995.

Эмэгтэйчүүд **давхар шийтгэлд өртөх** гэдэг нь тэд хувийн болон мэргэжлийн ажлаа тэнцвэртэй авч явахад тулгарч буй бэрхшээлийг хэлнэ. Гэр бүл болон албаны ажлаа аль алийг нь тэнцвэртэй авч явахыг оролдож буй эмэгтэйчүүдийг аль алинд нь хангалттай цаг зарцуулсангүй гэж буруутгах явдал их гардаг. Тэд дарга, хамт ажиллагчиддаа зорилго, зүтгэлгүй гэж харагдаж байхад гэр бүл, нийгэм ерөнхийдөө тэднийг гэр бүлээ орхигдуулсан гэж дүгнэдэг. Эцэст нь, тэдэнд хүлээлгэдэг асран халамжлах үүргийн улмаас эмэгтэйчүүд гэр бүлдээ ч, ажилдаа ч амжилт гаргаж чадахгүй байгаад өөрийгөө буруутгаж, өөрөөс нь шалтгаалаагүй алдааны төлөө хариуцлагыг өөр дээрээ авч байдаг. Зарим тохиолдолд эмэгтэйчүүдийг буруутгаж, үгүйсгэх аргыг ашиглан эрэгтэйчүүд үүнийг улам дэвэргэж байдаг.

Түүнчлэн эмэгтэйчүүдийн эсрэг ашигладаг өөр хоёр арга нь эрэгтэйчүүдэд зөвхөн үг хэлүүлэхийн тулд үг хэлэх боломж олгох (улмаар тухайн хэлэлцэгдэж буй асуудлаар гол зүйлийг ярих байсан эмэгтэйн цагаас хасах), мөн тухайн эмэгтэйн хэлсэн зүйлийг заавал эрэгтэй хүнээр давтуулах байдлаар үг эрэгтэйд тус санааг гаргасан мэт давуу байдал олгох явдал юм. Давамгайлдаг эдгээр аргыг мэдэж авч, түүнийг даван гарах аргыг боловсруулах нь эмэгтэйчүүдэд улс төрийн карьераа үр дүнтэй ахиулахад тусална.

ii) Ямар ч дарамт, шахалт ирсэн парламентын суудлаа бүү өг

ЕАБХАБ-ын зарим улс орон дахь сонгуулийн дараа улс төрийн намууд эмэгтэйчүүдийг зөвхөн “жендэрийн заль/квот” буюу хуулийн заалтыг хангах зорилгоор нэр дэвшүүлэх явдал гарч байгаа нь ажиглагдсан. ЕАБХАБ/АИХЭА-ны *Сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог хянах гарын авлагад* дурдсанчлан “жендэрийн заль/квот” гэдэг нь “эмэгтэйчүүдийг зөвхөн хуулийн заалт хангах эсвэл тэнцвэртэй жагсаалт мэт харагдуулах зорилгоор жагсаалтад оруулаад, сонгуулийн дараа өдөр тэднийг гаргах эсвэл нэрээ татахад хүргэдэг” практикийг хэлнэ.”¹⁹¹

Энэхүү гарын авлагын хүрээнд судалгаанд хамрагдсан зарим улс оронд ч дээрх үзэгдэл гарсан бөгөөд ЕАБХАБ-ын бусад улс оронд ч гарч байхыг үгүйсгэхгүй.¹⁹² Зарим тохиолдолд, эмэгтэйчүүдийг жагсаалтад оруулахын өмнө урьдчилан нэрээ татах захидалд гарын үсэг зурдуулдаг байна. Энэ нь жендэрийн квотыг хуулиар тогтоогоод удаагүй байгаа, зохицуулалтын механизм сүл эсвэл байхгүй улс орнуудад гарч байж болох юм.

191 OSCE/ODIHR, Handbook for Monitoring Women's Participation in Elections, 2004, p. 31.

192 Findings from the 2012 ODIHR Survey in the five pilot countries.

Эмэгтэйчүүдэд суудлаа буцааж өгөх дарамт шахалтыг давахад маш хэцүү. Энэ дарамтыг давах зарим арга гэвэл нам дотроо эмэгтэйчүүдийн байгууллага гэх мэт дэмжих сүлжээ бий болгох явдал юм. Түүнчлэн бусад намын эмэгтэйчүүдтэй холбогдон тэдэнд мөн ийм асуудал тулгарч буй эсэхийг мэдэж авч болно. Нам үл харгалзан хамтран ажиллах нь энэ асуудлыг гарган тавьж, шийдвэрлэхэд чухал байдаг. Мөн эмэгтэйчүүдийн бүлэг, ТББ зэрэг өөрийнх нь өмнөөс сонгогчидтой харьцан, уг асуудлыг босгон тавьж чадах намаас гадуурх дэмжигчидтэй холбогдож болно. Эмэгтэйчүүд, тэгш байдлын төлөө тэмцэгчид өгүүллэг, бичих, редакцийн зурваст оруулах зэргээр уг асуудлыг хэвлэл мэдээллийн анхааралд хүргэж, эсвэл уг асуудлаар орон нутгийн болон үндэсний телевиз, радиооор мэтгэлцээн өрнүүлэх хүсэлт гаргаж болно.

Бусад эмэгтэй нэр дэвшигч, нам доторх жендэрийн асуудлыг дэмжигчид зохион байгуулалтанд орж, намын даргад лобби хийн, намын дүрэм, журмаар ийм зүйлийг албан ёсоор хориглохыг шаардаж болно. Эцэст нь, эмэгтэй хүний эзэлж байсан суудал суларвал эмэгтэй хүнээр нөхдөг байх журмыг намын албан ёсны баримт бичигт тусгах талаар урт хугацааны нөлөөллийн ажлыг намын удирдлагад хандан явуулж болно. Эмэгтэйчүүд шинэчлэгч сэтгэлгээтэй сэтгүүлчидтэй түншлэн, энэ асуудлыг нийтэд хүргэн, түүнийг хориглосон улс төрийн шинэчлэл хийхэд олон нийтийн дэмжлэгийг авч болно.

Эмэгтэй гишүүд чөлөөлөгдөх хүсэлт гаргах нь улс төрчдийн шахалтаас өөр шалтгаантай ч байж болно. Эмэгтэйчүүд засгийн газарт, эсвэл өөр албан тушаалд очихын тулд парламентын үүргээсээ чөлөөлөгдөж болно. Ийм тохиолдолд, дээр дурдсанчлан, намын удирдлагадаа эмэгтэй хүний суудлыг эмэгтэй хүнээр нөхөх албан ёсны бодлого гаргах талаар нөлөөлөл хийж болно.

iii) Сонгуульд ялагдсан ч улс төрийн карьераа бүү орхи

Хүн амьдралынхаа тодорхой цаг мөчид ялагдаж байдаг, улс төрд ч мөн адил. Тиймээс хамгийн чухал сургамж бол бууж өгөхгүй байх явдал юм. Улс төр бол олон жижиг ялагдал, цөөн гол ялалт ирдэг үйл явц юм. Тиймээс эмэгтэйчүүд эерэг ч бай, сөрөг ч бай, энэ туршлагаа дараагийн өрсөлдөөнд ашиглах мэдлэг болгон хувиргах хэрэгтэй. Эмэгтэйчүүд тухайн сонгуулийн өрсөлдөөн, үр дүнг сайтар судлан, мэдлэг, чадвар, хэлхээ холбоогоо хэрхэн сайжруулж болохыг, мөн цааш өргөжүүлэх ёстой сайн зүйл юу байгааг харж болно.

Түүнчлэн өрсөлдөгч тал, өрсөлдөгч нам, уг намын удирдлагад дургүйцэх, буруутгах байдал гаргахгүй байх нь чухал. Тухайн эмэгтэй яаж ялагдсан нь түүний чадварын талаар их зүйлийг намд нь хэлж өгч байдаг. Түүнчлэн цааш үргэлжлүүлэх нь намынхаа зорилгод үнэнч байгаагаа харуулж буй хэрэг юм. Гэвч эмэгтэйчүүд хэр зэрэг үнэнч байх вэ гэдгээ мэддэг байх ёстой. Хэрэв нам түүнийг ялах боломжгүй тойрогт дахин

Шигтгээ 4.25. Суудлаа өг гэсэн дарамт шахалтыг давж гарах нь

1. Намын удирдлагад уг практикийг хориглох талаар шахалт үзүүлэхийн тулд **эмэгтэйчүүдийн бүлгийн** болон нам доторх жендэрийн асуудлыг сурталчлагчдын дэмжлэгийг дайчлах.
2. Энэ практикийг намын дүрмээр хориглох шахалтыг намын удирдлагад үзүүлэх.
3. Эмэгтэй хүний суларсан орон тоог өөр эмэгтэйгээр нөхөх заалтыг оруулах **урт хугацааны сурталчилгааны ажлыг** эхлүүлэх.
4. Энэхүү практикийг онцлох, мөн улс төрийн ерөнхий асуудал гэдэг утгаар ойлголт мэдлэг нэмэгдүүлэхэд **хэвлэл мэдээллийг оролцуулах**.
5. Энэ асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх, хэвлэл мэдээллийн өгүүллэг, мэдээллийн ажлаар дамжуулан олон нийтийн ойлголт мэдлэг нэмэгдүүлэх ажилд **иргэний нийгэм/ эмэгтэйчүүдийн бүлгийг** татан оролцуулах.

дахин тавьж байгаа бол тэр нам улс төрийн карьераа ахиулах хамгийн сайн талбар мөн эсэхийг бодож үзэх нь зүйтэй. Тухайлбал, Албанид улс төрийн намын идэвхтэн эмэгтэй орон нутгийн болон үндэсний сонгуульд нэр дэвшихэд байнга гадуур үлдэж ирсэн. Удаан хугацаанд намын удирдлагаас түүнийг үгүйсгэсний эцэст тэрээр бие даан нэр дэвшээд, орон нутгийн сонгуульд ялалт байгуулсан байна.¹⁹³

4.1.2. Эмэгтэйчүүд өөр хоорондоо хамтран ажиллах, хамтын сонирхлыг хөндсөн асуудлаар нэгдэж ажиллах

Өмнөх хэсэгт эмэгтэйчүүд сонгуульд албан тушаал хаших, бусад нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны ажлыг удирдах, эсвэл улс төрийн нам дотроо албан тушаал ахих зэргээр улс төрийн карьераа ахиулахын тулд ямар ямар алхмыг хийх талаар дэлгэрэнгүй өгүүлсэн билээ.

Улмаар эмэгтэйчүүд дангаараа хэрэгжүүлэх арга, алхам, санаачлагын талаар ихэвчлэн дурдсан. Харин энэ хэсэгт эмэгтэйчүүд бусад эмэгтэй, эрэгтэйчүүдтэй түншлэх замаар хэрхэн улс төрийн карьераа ахиулж, мөн улс төрийн намын үйл явцад жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх талаар авч үзэв.

→ Улс төрд бусад эмэгтэйчүүдийг элсүүлэх

Шигтгээ 4.26. Анита Градин, Жендэрийн тэгш байдлын төлөө тэмцэгч

Шведийн парламентын гишүүн Анита Градин янз бүрийн уулзалт, нийтийн сонгол, арга хэмжээн дээр уулзсан эмэгтэйчүүдийнхээ талаар тэмдэглэж авдаг жижиг хар тэмдэглэлийн байнга авч явдаг байв. Сонирхолтой танилцуулга, дүн шинжилгээ хийж, түүнд сэтгэгдэл төрүүлсэн эмэгтэйчүүдийг тэрээр уг дэвтэртээ бичиж авдаг байв. Ингээд намаас нь аль нэг албан тушаалт нэр дэвшүүлэх хэрэгтэй

Эмэгтэйчүүд хамтран хэрэгжүүлж болох эмэгтэйчүүдийн төлөөллийг дээшлүүлэх маш энгийн боловч үр дүнтэй нэг арга бол **олон эмэгтэйг намдаа элсүүлэх** явдал юм. Үүнийг намын хязгаарлагдмал хөрөнгө нөөц, албан тушаалын төлөө эмэгтэйчүүдийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэхээс хэтрэхгүй гэж харж байж болно. Гэвч намд, ялангуяа намын удирдлагад эмэгтэйчүүдийн төлөөлөл дээшилсний ашиг түс, мөн тухайн эмэгтэйн өөрийнх нь улс төрийн карьер ахихад тэд дэмжлэг үзүүлж чадна гэдгийг бодолцох нь чухал.

Улс төрд, ялангуяа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа тул улс төрд орох эмэгтэйчүүд, эмэгтэй манлайлагчдыг тодорхойлж, дэмжих нь нэн чухал. Үүнийг Анита Градины жишээ сайн харуулж байна (Шигтгээ 4.26). Эмэгтэйчүүд намынхаа бусад эмэгтэйчүүдтэй

үг мэдээллийн сангаа хуваалцаж, улс төр хөөх боломжтой эмэгтэйчүүдийн сан бүрдүүлж болно. Мөн янз бүрийн тохиолдлоор уулзаж, өндөр сэтгэгдэлтэй үлдсэн эмэгтэйчүүдийнхээ талаар тэмдэглэл хийж, тэднийг ирээдүйд хэрхэн татан оролцуулахаа бодож болно. Энэ нь орон нутгийн сонгуульд өрсөлдөхийг хүсч буй тухайн орон нутгийнхаа намын үүрт идэвхтэй ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд бас чухал арга юм.

→ Нам доторх бусад эмэгтэйчүүдийг дагалдан сурч, мөн дагуулж ажиллах

Эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралын үе шат бүрт дагуулан сургах ажил маш чухал үүрэгтэй байдаг. **Улс төрийн хувьд дагуулан сургах** гэдгийг тухайн хоёр хүний хооронд түршлага, үр чадвар, мэдлэгээсээ хуваалцах, улс төрийн амьдрал дахь төсөөлж буй болон бодит бэрхшээлийг даван туулахад нь туслах зорилго бүхий дэмжих харилцаа гэж тодорхойлж болно.¹⁹⁴ Үүнийг тухайн оролцож буй хоёр хүнд хоёуланд нь тустай хоёр талын харилцаа гэж харах нь чухал.

Дагуулах сургах нь янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд үргэлжилсэн харилцаа хэлбэртэй байвал илүү сайн. **Дагуулан сургах уламжлалт хэлбэрийн** хүрээнд арай түршлагатай, мэдлэгтэй нь хувийн, итгэлтэй зөвлөх байдлаар ажиллаж, арай түршлага багатайдаа зөвлөгөө, удирдамж, дэмжлэг үзүүлдэг байсан. Ийм хэлбэр бол цаг хугацааны туршид аяндаа үүсч болно. Гэвч эмэгтэйчүүд улс төрийн намд элсэн орсон даруйдаа намын удирдлагаас өөрийн сонирхол, нам дотроо тавьж буй зорилготой нийцсэн хүнийг дагуулан сургагчаар хуваарилж өгөхийг хүсч болно.

Гишүүд бие биеэ дагуулан сургах гэдэг нь түршлагын хувьд адил түвшинд, магадгүй, ойролцоо насны хүмүүсийн хооронд явагдана. Энэ тохиолдолд тэд хувийн түршлага, сайн практик, улс төрийн карьер, улс төрийн асуудлуудын талаарх санаа бодлоо хуваалцана. Тэд бие биеэ карьерынхаа янз бүрийн үе шатанд харилцан дэмжих бөгөөд бие биеийнхээ түршлагаас суралцана. **Өөр өөр үеийн хүмүүс дагуулан сургах** гэдэг нь мөн л хоёр талтай харилцан тустай харилцаа бөгөөд арай түршлагатай нь залуугаасаа улс төрийн шинэ санаа, чиг хандлага, технологи, практик, хөгжлөөс суралцах бол залуу нь намын ахмад гишүүний түршлагаас суралцана. Тухайлбал, арай түршлагатай эмэгтэй улс төрчид залуу эмэгтэйчүүдээс нийгмийн сүлжээний шинэ хандлагыг сурч болох бөгөөд шинээр намд элссэн эмэгтэйчүүд түршлагатай эмэгтэйчүүдийн түршлага, мэдлэгээс суралцаж болно. Ийм харилцааны хувьд сурах, сургах тал нь тухайн сэдвээсээ хамааран өөрчлөгдөнө. Эцэст нь, **дагуулан сургах нөөц** нь эмэгтэй улс төрчдийн авчрах янз бүрийн мэдлэг, нөөц, үр чадварыг тодорхойлж, цуглуулахад хэрэгтэй арга юм.

болоход тэр дэвтрээ харна. Түүний дэвтр бол чадвартай, мэргэжлийн эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийн сан байсан тул тохирох эмэгтэй нэр дэвшигчийг намдаа олж өгч чаддаг байснаас гадна **улс төр сонирхдог эмэгтэйчүүд алга** гэх намын ажилтнуудын үгийг няцааж чаддаг байв.

Хожим Градин Шведийн засгийн газарт сайд болж, үндэсний хороод дахь жендэрийн тэгш байдлын үндэсний комисс байгуулсан. Мөн Социалист Интернационал эмэгтэйчүүд байгууллагыг даргалж, дэлхий даяар хөдөлмөрийн намуудад жендэрийн квот тогтоох санааг нэвтрүүлснээс гадна 1995-1999 онд Европын комисст төлөөлөгчөөр ажиллажээ.

Шигтгээ 4.27. Дагуулан сургах ажлын хэлбэр

а) Түршлага суурилсан хэлбэр: Арай илүү түршлагатай нь хувийн зөвлөгөө өгч ажиллана.

б) Гишүүд бие биеэ дагуулах сургах хэлбэр: Адил түвшний мэдлэгтэй, улс төрийн карьерынхаа төстэй үе шатанд байгаа гишүүд өөр хоорондоо түршлага солилцоно.

с) Өөр үеийн хүмүүс бие биеэ дагуулан сургах хэлбэр: Түршлага багатай боловч шинэ санаа, технологи, улс төрийн стратеги мэддэг гишүүнээс суралцах, харилцан суралцах.

д) Дагуулан сургах нөөц: Харилцан бие биедээ хэрэг болох тодорхой мэдлэг, үр чадвар зэргийг тодорхойлж, нөөц сан бүрдүүлэх.

194 Rising through the ranks: A Young Woman's Guide to Leadership and Political Party Engagement, Part III, Chapter 4, "Mentoring and Nurturing Your Network of Support", 2011, p. 62.

Дагуулан сургах нь улс төрчдөд бүхий карьерынх нь туршид хэрэгтэй байдаг ч анх нэр дэвшиж буй хүмүүст илүү чухал. Энэхүү гарын авлагын хүрээнд дагуулан сургах бол нэг хүйсийн (эмэгтэй хүн эмэгтэй хүнээ) улс төрчдийг хамрахаас өөр хүйсийн улс төрчдийг ч (эрэгтэй хүн эмэгтэйг, эмэгтэй хүн нь эрэгтэйг) хамрах ёстой гэдгийг тэмдэглэх нь чухал. Ялангуяа улс төрийн намын удирдлагын дийлэнхийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нөхцөлд, хэрэв тэд эмэгтэйчүүдийг дэмжье гэсэн үнэхээр хүсч байгаа бол намын өндөр түшаалд буй эрэгтэй гишүүд эмэгтэй улс төрчдөд, ялангуяа шинээр элссэн гишүүдэд өгөх мэдлэг, туршлага ихтэй байдаг.

Дагуулан сургахын ЕАБХАБ-ын бүс нутаг дахь улс төрийн олон нам хэрэгжүүлдэг бөгөөд зарим нь намын сургалтын хөтөлбөрийн хүрээнд ийнхүү дагуулан сургах ажлаа тогтмолжуулсан байдаг. Тухайлбал, Их Британий Консерватив намаас “Women2Win” буюу “Эмэгтэйчүүдэд ялалт” хөтөлбөрийн хүрээнд дагуулан сургах ажил хийдэг. Уг хөтөлбөр нь тус намаас дэвшсэн эмэгтэй парламентын гишүүн болоход чиглэсэн 9 алхмыг агуулсан байна. (Шигтгээ 4.28).¹⁹⁵

Түүнчлэн Их Британий Хөдөлмөрийн намтай холбоотой Фабиан эмэгтэйчүүдийн сүлжээ нь 2011 онд олон улсын эмэгтэйчүүдийн өдөр буюу 3 дугаар сарын 8-нд Фабиан эмэгтэйчүүдийн дагуулан сургах хөтөлбөр бий болгосон. Энэ хөтөлбөр нь улс төрийн карьер хөөх сонирхолтой Фабиан эмэгтэйчүүдэд нийт 10 сарын турш туршлагатай эмэгтэй улс төрчтэй дагалдан суралцах боломж олгодог. Дагалдан сурч буй эмэгтэйчүүд нь сургалтанд сууж, сүлжээ хэлхээ холбоо бий болгох, үр чадвар хөгжүүлэх ажиллагаанд оролцохын хамт Лондон, Европын парламенттай танилцах аялалд оролцдог. Туршлагатай эмэгтэй улс төрчдийг дагуулан сургагчаар урьж ажиллуулдаг. Тус хөтөлбөрийн үр дүнд нэг эмэгтэй парламентанд нэр дэвшиж, өөр нэг эмэгтэй сонгуулийн жагсаалтанд орж, мөн хэд хэдэн эмэгтэй сургуулийн захирал, эсвэл буяны байгууллагын удирдах зөвлөлийг тэргүүлэх болсон байна.¹⁹⁶

Дагуулан сургах ажлыг бүсийн болон олон улсын түвшинд адил төстэй үзэл санаа бүхий улс төрийн намын гишүүдийн дунд явуулж болно. Тухайлбал, Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэнгийн Эмэгтэйчүүдийн ардчилсан сүлжээнээс зохион байгуулж, эмэгтэй удирдагчдад бусад орны улс төр, иргэний нийгэм, засгийн газрын туршлагатай эмэгтэйчүүдээс суралцах боломж олгодог.¹⁹⁷ Энэ тохиолдолд дагуулан сургагч нь тухайн улс оронд буй салбараараа дамжуулан туршлага багатай улс төрч эмэгтэйчүүдэд манлайллын үр чадвар хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг.

195 See Conservative Party “Women2Win” programme, <<http://www.women2win.com/being-mp>>.

196 See the Fabian Women website, <<http://www.fabianwomen.co.uk/2013/03/the-fabian-womens-network-is-re-cruiting-for-its-201314-mentoring-programme/>>.

197 197 Women’s Democracy Network (WDN) is an initiative of the International Republican Institute. See: <<http://www.wdn.org>>.

Шигтгээ 4.28. Консерватив намаас парламентын гишүүнээр сонгогдоход шаардагдах 9 алхам: Консерватив намын “Эмэгтэйчүүдэд ялалт” хөтөлбөр

1. Консерватив намын орон нутаг дахь салбартай холбогдож, сайн дурын ажил хийх, эсвэл тухайн орон Нутгийн буяны байгууллагад ажиллан нам, нийтийн албанд зүтгэх эрмэлзэлтэй байгаагаа харуулах.
 2. Өөрийн сул тал, дутагдалтай байгаа үр чадвараа хэрхэн зохицуулах талаар ажлын нтөлөвлөгөө гаргах.
 3. Бүтэн орон тоогоор улс төрийн карьер хөөх нь өөрт тань тохиромжтой эсэх, гэр бүлээсээ холдох, сонгуулийн сурталчилгааны амьдралын хэцүү хэв маягт дасан зохицож чадах эсэхээ тогтоох.
 4. Орон Нутгийн зөвлөлийн төвд захидал бичиж, нэр дэвшихийг хүсч байгаагаа илэрхийлэн, намтраа хавсаргах.
 5. Нүүр захидалдаа орон Нутгийн холбоод, мэргэжлийн бүлэг, буяны байгууллага, ер нь тухайн оршин буй газрынхаа үйл амьдралд хэрхэн оролцож ирсэн тухай мэдээлэл оруулах.
 6. Таны зан чанар, мэргэжлийн чадварыг гэрчилж чадах гурван хүнийг олж, тодорхойлолт ач хавсаргах.
 7. Консерватив намд элсээд 3 сар болмогц Парламентын холбоонд гишүүний татвараа төлөх.
 8. Намын удирдах тушаалын гишүүд бүтэн өдрийн түрш ярилцлага авахад бэлтгэлтэй байх.
 9. Нэр дэвшихээр батлагдмагц сул суудал бүхий тойрог олж, өрсөлдөөнд бэлтгэх.
- Эх сурвалж: Консерватив нам, Эмэгтэйчүүдэд ялалт хөтөлбөр <<http://www.women2win.com/being-mp>>.*

→ **Нам дотроо эвсэл, эв нэгдэл бий болгох**

Эмэгтэйчүүдийг, мөн тэд өөрсдийгөө хүнтэй харилцахдаа сайн, зөвшилцөл бий болгож чаддаг, холбож чаддаг гэж үздэг. Гэвч эрэгтэйчүүд ч **улс төрийн сүлжээг**, ялангуяа албан бус аргаар сайн бүрдүүлж чаддаг. Улс төрд сүлжээ, эвсэл бий болгох аргуудаас дурдвал:

- ✓ Бизнес эрхлэгчидтэй холбоо үүсгэх;
- ✓ Эрхэлж буй ажлынхаа холбоог ашиглах, мөн уг холбоог ашиглан танилын сүлжээгээ өргөжүүлэх;
- ✓ Клуб, паб, фитнес, бусад газар албан бусаар уулзах;
- ✓ Хандивлагч, ивээн тэтгэгчид цугларч буй арга хэмжээнд очих;
- ✓ Хэн хэнд нь хэрэгтэй албан бус “хэлэлцээ” хийх;
- ✓ Санаа, амжилтаа сурталчлахын тулд хэвлэл мэдээллийг бүрэн ашиглах.

Хувийн ч бай, ажилтай холбоотой ч бай, уулзалт бүрийг өөрийн дүр төрх, ололт амжилт, улс төрийн байр сууриа танилцуулах боломж гэж харна.

Тиймээс улс төрийн карьераа ахиулахыг сонирхож буй эмэгтэйчүүд дор бүрнээ уулзалт, арга хэмжээ бүрийг өөрийн санаа, хувь нэмрийг хүргэх боломж гэж харж; нөлөө бүхий шийдвэр гаргагч, олон нийтийн санаа бодолд нөлөөлөгч талуудтай холбоо тогтоон; дэмжигчдийн сүлжээг бий болгож эхлэх нь зүйтэй. Харин хамтдаа дэмжлэг үзүүлэх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн албан ба албан бус сүлжээ байгуулан, нам дотроо карьераа ахиулахад бэлэн чадвартай олон тооны эмэгтэй байгаа талаар сурталчилж, намын эмэгтэй гишүүдийн санаа зовж буй асуудлаар хамтран ажиллаж, тэдэнд тулгамдаж буй асуудал, бэрхшээлээ илэрхийлэх эерэг, аюулгүй орон зай бий болгоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

→ Нам үл харгалзан эмэгтэйчүүдтэй хамтран ажиллах

Нам дотроо эмэгтэйчүүдтэй эв санааны нэгдэлтэй байж, хамтран ажиллахаас гадна адил сонирхолтой асуудлаар **нам үл харгалзан** хамтран ажиллаж болно. Тухайлбал, нийгэмд буй жендэрийн ялгаварлан гадуурхлын талаар ойлголт нэмэгдүүлэх ажлыг нам үл харгалзан хийж болно. ЕАБХАБ-ын бүсийн сонгогч, төрийн албан хаагчдын дунд улс төрийн хүрээн дэх жендэрийн тэгш бус байдлын талаар, ардчиллыг бэхжүүлэхийн тулд олон эмэгтэйг сонгох шаардлагатай талаар сурталчилгааны ажил явагддаг. Үр дүнтэй болсон нэг жишээ гэвэл Португалд хэрэгжүүлсэн Парити буюу тэгш төлөөлөлтэй Парламент бөгөөд түүнийг Европын парламентын 3 эмэгтэй гишүүний санаачилгаар Европын парламентын 1994 оны сонгуулийн өмнөхөн өрнүүлсэн. Тэд нийт 115 эмэгтэй улс төрч, 115 эрэгтэй улс төрчийг парламентын нэг өдрийн хуралд урьж, ардчиллын асуудал, төрийн үйл хэрэгт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, иргэншил, төлөөлөл тэгш тоотой байх зэрэг асуудлыг хэлэлцсэн. Европын комиссоос зарим санхүүжилт авсан уг арга хэмжээ нь суудлын 50 хувийг эмэгтэй, 50 хувийг эрэгтэйчүүд эзэлж буй тохиолдолд бодлого боловсруулах үйл явц ямар байхыг харуулахыг эрмэлзсэн¹⁹⁸.

Шигтгээ 4.29. Украйны эмэгтэйчүүдийн сангийн судалгаа: Эмэгтэйчүүд улс төрд

Украйны ТББ болох Эмэгтэйчүүдийн сан тус улсад эмэгтэйчүүд улс төрд орох тухайд хэрхэн ханддаг талаар судалгаа явуулсан байна. Эмэгтэйчүүдийн хорь гаруй хувь нь эмэгтэй хүний төлөө саналаа өгнө гэсэн бол эрэгтэйчүүдийн хорь арай хүрэхгүй хувь нь эмэгтэй хүнд саналаа өгнө гэсэн байна. Эмэгтэйчүүдийн 10 гаруй хувь, эрэгтэйчүүдийн 20 гаруй хувь эрэгтэй хүний төлөө саналаа өгнө гэсэн байна. Мөн сонирхолтой нь, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн 60 орчим хувь нь хүйс хамаагүй гэсэн бол судалгаанд оролцогчдын 10 орчим хувь нь л “эмэгтэйчүүд улс төр хийж чадахгүй” гэсэн үгтэй санал нийлжээ.

Эх сурвалж: Украйны эмэгтэйчүүдийн сан, <http://www.uwf.kiev.ua/en_news_261010.htm>.

Түүнчлэн улс төрд орж буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж болно. Исландад олон нам бүхий парламентын хорооноос санхүүжүүлсэн хэвлэлийн аянг 1997-2002 онд явуулж, хошин зар сурталчилгаа, сургалтын хөтөлбөр, боловсролын арга хэмжээ, олон нийтийн хурал цуглаан, дагуулан сургах хөтөлбөр зэргээр дамжуулан улс төрд буй эмэгтэйчүүдийг тоог нэмэгдүүлэх ажил хийсэн. Зар сурталчилгаа нь засгийн газрын өндөр албан тушаалын талаарх хэвшмэл ойлголтыг эвдэх, жендэрийн тэгш байдлыг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алинд нь хамаатай асуудал гэдгийг нийтэд хүргэхийг эрмэлзсэн. Нэг зурагт хуудсанд эмэгтэй парламентын гишүүнийг сахлаа хусч байгаагаар харуулсан бол нөгөөд нь тухайн үед эрэгтэй хүн хашиж байсан Гадаад хэргийн сайдыг шилэн оймс барьж байгаагаар харуулаад, доор нь “улс орны тал хувь нь парламентад ардчилсан төлөөлөлгүй байна”; мөн “зарим зүйлийг та түүлж мэдрэх боломжгүй” гэсэн үгсийг тус тус оруулсан байв.¹⁹⁹

Түүнээс гадна эмэгтэйчүүд парламентад жендэрийн тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажиллаж болно. Ажлын цаг, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд зориулсан хүүхэд харах газар, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан

ажлын нөхцөл, нэгдсэн чуулганд үг хэлэх цаг хуваарилах зэрэгт эмэгтэйчүүд хүчээ нэгтгэн ажиллах боломжтой. Ийнхүү нам үл харгалзан хамтран ажиллахад тодорхой нэг асуудлыг барьж авах нь илүү ач холбогдолтой. Тухайлбал, Австрид 2011 онд парламентын янз бүрийн бүлгийн эмэгтэйчүүд хамтран төрийн дууллын үг буюу Австрийн хөвгүүд гэж байсныг хөвгүүд, охид болгож өөрчлүүлсэн.²⁰⁰

198 Alison Woodward, *Going for Gender Balance. A guide for balancing decision making* (Strasbourg: Council of Europe, 2002), p. 34.

199 Pippa Norris and Mona Lena Krook, “Gender Equality in Elected Office: A Six-Step Action Plan” (Warsaw: OSCE, 2011), <www.osce.org/odihr/78432>.

200 “Austrian anthem to give daughters a mention”, 14 July 2011, <<http://www.bbc.co.uk/news/world-europe-14155830>>.

Нам дамнан хамтран ажиллах бас нэг жишээ бол жендэрийн тэгш байдлын төлөө эмэгтэйчүүдийн олсон амжилтыг тэмдэглэн, тэмдэглэлт өдрөөр хамтарсан мэдэгдэл гаргах явдал юм. ЕАБХАБ-ын олон улс оронд 3 дугаар сарын 8-ныг Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр болгон өргөн хүрээнд тэмдэглэдэг. Энэ өдрийг ашиглан сонгогдсон эмэгтэйчүүд улс орныхоо эмэгтэйчүүдийн төлөө юу хийж байгааг танилцуулж, мөн учирч буй саад бэрхшээл зэргийг цохон дурдаж болно.

→ “Зөвхөн эмэгтэйчүүдээс” бүрдсэн нам байгуулах

Шигтгээ 4.30. Польшийн Эмэгтэйчүүдийн нам

2006 онд улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаа нь “Польш бол эмэгтэй” нийгмийн хөдөлгөөний ачаар олон нийтийн хэлэлцүүлгийн халуун сэдэв болсон. Тус хөдөлгөөн сүүлдээ Эмэгтэйчүүд нам болсон бөгөөд нэрт зохиолч эмэгтэй Мануэла Гретковска санхүүжүүлсэн байна. Тус нам нь бизнес, урлаг, хөгжим зэрэг салбараас олны танил эмэгтэйчүүдийг цуглуулсан бөгөөд хэвлэл мэдээллээр маш их цацагдаж байв. Тус нам нь улс төрийн зүүн, баруун намуудын аль алианаас дэмжлэг авна гэж хүлээж байсан ч намын удирдлагууд амлалтаа биелүүлээгүй.

Гэвч Эмэгтэйчүүдийн нам намынхаа статусыг хадгалж, 7 тойрогт дангаараа өрсөлдөхөөр шийдсэн. Сонгуулийн сурталчилгаандаа PLN30,000 буюу (7,500 евро) зарцуулсан. Ийм бага санхүүжилттэй, сонгууль болоход дөнгөж хоёр сар үлдсэн байхад тус нам Польш даяар намын бүтцээ бэхжүүлэх боломжгүй байв. Тиймээс гишүүд намыг үндэслэгчдийн нүцгэн зураг бүхий зурагт хуудас гарган, Бүхний ирээдүйн төлөө, нуух зүйл үгүй-Эмэгтэйчүүдийн нам гэсэн уриатайгаар тараасан. Ийм хүчин чармайлт гаргасан ч нам 2007 оны сонгуульд 5 хувийг давж чадаагүй бөгөөд аль ч танхимд суудал авч чадаагүй.

Эх сурвалж: M. Druciarek, M. Fuszara, A. Nizynska, J. Zbieranek, ISP and ODIHR, Women on the Polish Political Scene, Warsaw, 2012.

Жендэрийн тэгш байдал, улс төрд эмэгтэйчүүд гадуур үлддэг талаар болон эмэгтэйчүүдийн улс төрийн тэргүүлэх чиглэлийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх тийм ч түгээмэл бус хэрэглэгддэг нэг арга бол **эмэгтэйчүүдийн нам байгуулах явдал юм**. Зарим үед уламжлалт улс төрд итгэл гүн алдарсан, улс төрийн дэглэмийн өөрчлөлт явагдаж байх үед эмэгтэйчүүдийн нам байгуулагддаг. Тиймээс ихэнхдээ одоо байгаа улс төрийн намуудаас “дээгүүр” гарч, эмэгтэйчүүдэд өөрсдийгөө илэрхийлэх боломж олгохыг эрмэлзсэн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөөс урган гарсан байдаг.

Үүний нэг жишээ нь 1993 онд улс төрийн хөдөлгөөн болж байгуулагдсан Оросын эмэгтэйчүүд нам юм. 1993 оны парламентын сонгуульд тус нам нийт саналын 10 хувийг авч, Оросын Төрийн дүмд 25 суудалтай болсон. Төрийн думын анхны сонгуулиар (1993-1995) нийт 130 суудлын 51-ийг эмэгтэйчүүд эзэлж байв.²⁰¹ Улмаар, тус нам Чеченд цэргийн үйл ажиллагаа 1994 онд эхлүүлэхэд эсэргүүцэх гэх мэтээр олон асуудал дээр идэвхтэй байр суурь баримталж ирсэн. 1995 оны парламентын сонгуульд Оросын эмэгтэйчүүд нам бусад либерал намтай эвсэл бололгүй өөрийн мөрийн хөтөлбөрийг солилгүй орохоор шийдсэн бөгөөд хүүхэд, эмэгтэйчүүдийн хамгаалал зэрэг нийгмийн асуудлыг голлон дэвшүүлсэн. Тус нам шинэ Төрийн думын пропорционал тогтолцооны босго болох 5 хувийн саналыг авч чадаагүй бөгөөд дөнгөж 3 суудал авсан. 1996 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ илгээх асуудлыг судалж байсан ч эцэст нь, олон нэр дэвшигч байсан тул өөрийн намаас нэр дэвшүүлээгүй.

Арай жижиг байгууллага болох Оросын эмэгтэйчүүдийн нам хэд хэдэн намтай эвсэл байгуулан 1995 оны сонгуульд орсон ч амжилтгүй болсон. Оросын бүгд найрамдах нам-Ардын эрх чөлөөний намын Элла Панфилова, Социалист Ажилчдын намын дарга

<<http://state.rin.ru/cgi-bin/main.pl?r=287>>; “Bundesgesetz über die Bundeshymne der Republik Österreich (1758/A)”, 2011, <http://www.parlament.gv.at/PAKT/VHG/XXIV/A/A_01758/index.shtml#tab-Uebersicht>.

201 “Государственная дума Федерального собрания Российской Федерации | созыва”, Wikipedia, <<http://ru.wikipedia.org/wiki/>>.

Людмила Вартазарова, Ардчилсан хлобооны удирдагч Валерия Новодворская²⁰² зэрэг цөөн эмэгтэй нөлөө бүхий улс төрчид болсон. Панфилова эмэгтэйчүүд, ахмад настны асуудлаар дуугардаг гэдгээрээ танигдсан. Өөр нэг жишээ нь Литвын Ерөнхий сайд асан Казимира Прускиений тэргүүлдэг Литвын Эмэгтэйчүүдийн нам юм²⁰³. Уг нам нь 1995 онд эмэгтэйчүүдийн 13 байгууллагын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд улс төрийн бие даасан хүчин байхад заавал квот шаардлагагүй гэдгийг харуулах зорилго тавьсан байв. Тус нам 1996 онд 24 намаас 7-д жагссан нь улс төрийн уламжлалт намуудад цохилт болсон байна²⁰⁴.

Хойд Ирландад энхтайван тогтооход Эмэгтэйчүүдийн эвслийн нам нөлөө бүхий үүрэг гүйцэтгэсэн. 1996 онд бий болсон уг намын цаад зорилго нь эмэгтэйчүүдийн байр суурь, санаа бодлыг Хойд Ирландын олон нам бүхий энхийн хэлэлцээрийн гадуур үлдээхгүй байх явдал байв. Эхлээд тус энхийн хэлэлцээрт оролцож буй намын төлөөлөгчдөөс зөвхөн Эмэгтэйчүүдийн эвслийн гишүүд л эмэгтэй байв. Хойд Ирланд дахь хүчирхийллийг төгсгөл болгох, албан ёсны хэлэлцээрийн ширээний ард эмэгтэйчүүд очиход Эмэгтэйчүүдийн эвсэл тусалсан гэж үздэг.²⁰⁵

Ерөнхийдөө, зөвхөн эмэгтэйчүүдээс бүрдсэн улс төрийн намууд иргэний нийгэмд эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, тэдэнд тулгарч буй бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлэхэд тус болдог. Түүнчлэн эмэгтэй улс төрчдийн өөр хоорондын эв санааны нэгдэл, итгэлийг бэхжүүлдэг. Мөн улс төрчид анзаарахгүй байгаа боловч эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг хөндөж буй, эмэгтэйчүүдэд тулгарч буй онцлог асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулж чаддаг. Эмэгтэйчүүдийн нам нь улс төрд идэвхтэй, сонирхолтой байх хүсэлтэй эмэгтэйчүүдийн хувьд дамжин өнгөрөх цэг байж болно.

Гэвч хэд хэдэн учир шалтгааны улмаас эмэгтэйчүүдийн нам удаан хугацаагаар оршин тогтноход хэцүү байдаг. Юуны өмнө, тийм намууд эрэгтэйчүүд буюу сонгогчдын тэн хагасыг орхигдуулдаг. Хоёрдугаарт, эмэгтэйчүүдийн улс төрийн намын босгож тавьсан асуудлын ач холбогдлыг ихэнхдээ бууруулж байдаг бөгөөд уг намын зөвхөн эмэгтэйчүүдийн асуудлаар хийж буй ажил эсвэл шинэ содон гэдгийг л хэвлэл мэдээллээр онцлон гаргаж, сонгуулийн сурталчилгааных нь гол асуудлууд анхаарал сайн таталгүй өнгөрдөг. Гуравдугаарт, эмэгтэйчүүдийн нам амжилт гаргаж чадаагүй бол эмэгтэйчүүд улс төрд төдийлөн зохимжтой биш гэсэн түгээмэл хэвшмэл ойлголт улам нэмэгдэн, эмэгтэйчүүдийн оролцооны эсрэг хатуу зогсон жендэрийн тэгш байдлыг эсэргүүцдэг талынханд нэмэр болох талтай. Түүнчлэн сонгуулийн саналын тоонд босго тавьж, мөн том намуудад давуу байдал олгосон намын санхүүжилтийн тогтолцоо үйлчилж байгаа нь эмэгтэйчүүдийн нам амжилттай өрсөлдөхөд том саад болж байна.

202 The Democratic Union and the Socialist Workers' Party are unregistered parties, <http://www.russciavotes.org/duma/list_parties_2003_2007.php>.

203 "Kazimira Prunskienė", Wikipedia, <http://en.wikipedia.org/wiki/Kazimira_Prunskienė%C4%97>.

204 John T. Iishiyama, "Women's parties in post-communist politics." East European Politics and Societies, Vol. 17, No. 2, 2003, pp. 266-304; Alison Woodward, Going for Gender Balance. A guide for balancing decision making (Strasbourg: Council of Europe, 2002).

205 Carmel Roulston, "Inclusive Others: The Northern Ireland Women's Coalition in The Peace Process", Scottish Affairs, Vol. 26, winter, 1999.

4.1.3. Улс төрийн намын бодлого, журам, практикт жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлэх

Өмнөх хэсэгт эмэгтэйчүүд улс төрийн тоглогч болохын хувьд улс төрийн карьераа ахиулахын тулд дангаараа болон хамтаараа боловсруулж хэрэгжүүлэх арга замын талаар дурдсан билээ. Хувь хүний хувьд дангаараа хэрэгжүүлэх арга нь нам хэрхэн ажилладаг, түүнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар үүрэг гүйцэтгэдэг, намын хөрөнгө нөөцөөс хэрхэн олж авч ашиглах, мөн сонгуулийн сурталчилгааны ажлыг хэрхэн явуулах талаар талаар мэдэж авахад чиглэсэн. Харин хамтаар хэрэгжүүлэх арга гэдэгт нам дотроо болон нам үл харгалзан эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг авчрахын тулд өөр хоорондоо хамтарч ажиллахтай холбоотой аргуудыг дурдсан.

Эдгээр арга зам нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст улс төрд өрсөлдөх гарааны тэгш нөхцөл бүрдээгүй байгаатай холбоотой. Эдгээр нь эмэгтэйчүүдийн улс төрийн энэхүү бодит нөхцөлийг даван гарахад туслах боловч улс төрийг өөрийг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш боломж олгодог болгон хувиргана гэж хэлэхэд хэцүү. Тиймээс энэ хэсэгт эмэгтэйчүүд, мөн эрэгтэйчүүд, жендэрийн мэдрэмжтэй улс төрийн нам болж, жендэрийн тэгш байдлыг бодитой, тогтвортой институтчлахад ямар арга ашиглах болох талаар авч үзэв.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс улс төрийн тэгш эрх, тэгш боломжийг бодит амьдрал дээр эдлэхэд жендэрийн тэгш байдлыг институтчлах нь нэн чухал. Олон эмэгтэйг улс төрд оруулах нь жендэрийн асуудлыг сурталчлагчдын гол зорилго ч гэсэн улс төрд, улс төрийн намд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлснээр ийм институтчлал явагдахгүй. Эмэгтэйчүүд, жендэрийн тэгш байдлыг дэмжсэн ийм албан бүтэц, бодлого, хөтөлбөр байхгүй бол НҮБ-аас зөвлөмж болгосон улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог 30 хувьд буюу “нөлөө үзүүлэхүйц” хувь хэмжээнд хүргэх нь улс төр явагддаг арга ажиллагааг дангаараа өөрчилж чадахгүй.

Их Британи дахь эмэгтэйчүүдийн бодит төлөөллийн талаарх судалгаанд дурдсанчлан²⁰⁶, улс төрийг жендэрт ээлтэй болгохын тулд засгийн газрын жендэрийн тэгш байдлын механизм, улс төрийн намууд дахь эмэгтэйчүүдийн байгууллага, сонгуулийн болон улс

Шигтгээ 4.31. Улс төрд буй эмэгтэйчүүдийн тоо ба түүний цаана байгаа утга: “Нөлөө үзүүлэхүйц” хувь хэмжээ гэдгийг ойлгох нь

Жендэр, эмэгтэйчүүд, улс төрийн салбарт “нөлөө үзүүлэхүйц” хувь хэмжээ гэдэг нь улс төрийн зах үйл, институц, төрийн бодлогод агуулгын нөлөө үзүүлэхэд шаардагдах эмэгтэйчүүдийн тоог хэлнэ. Энэ нь эмэгтэйчүүдийг зүгээр “жендэрийн тоо гүйцээх” төдий биш улс төрийн хэлэлцүүлэгт бодитой нөлөөлөх хэмжээг харуулсан босго юм. Нийтээр хүлээн зөвшөөрөөд буй нөлөө үзүүлэхүйц хэмжээ нь **30 хувь юм**.

Гэвч улс төрд бодит төлөөллийг бий болгоход тоо дангаараа хангалтгүй гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрөх болсон тул эмэгтэйчүүд дорвитой хувь нэмэр оруулахад мар хүчин зүйл нөлөөлж, ямар боломж гарч байгааг авч үзэх нь чухал юм. Үүнд:

- ✓ Эрх мэдэл бүхий албан тушаалд эмэгтэйчүүд байх (намын дарга, улс төрийн зөвлөх, нэр дэвшигч сонгох хорооны дарга, гишүүн);
- ✓ Дадлага түршлага (хөрөнгө босгох, эрх зүй, бодлого, хуулийн дадлага түршлага гэх мэт тухайн намд хэрэг болох чадвар);
- ✓ Засгийн газарт жендэрийн механизм байгаа эсэх;
- ✓ Улс төрийн намд жендэрийн механизм байгаа эсэх (эмэгтэйчүүдийн байгууллага; жендэрийн бодлого, стратеги);
- ✓ Бодлогын орчин (сонгуулийн хэлбэр);
- ✓ Иргэний эрүүл нийгэм, түүний дотор эмэгтэйчүүдийн бүлгүүд байгаа эсэх.

Эх сурвалж: Sarah Childs, Joni Lovenduski and Rosie Campbell, Women at the Top 2005: Changing Numbers, Changing Politics? Hansard Society, 2005.

206 Pippa Norris and Joni Lovenduski, Political Recruitment: Gender, Race and Class in the British Parliament (Cambridge: Cambridge University Press, 1995), p. 145.

төрийн таатай нөхцөл, түүний дотор үл ялгаварлан гадуурхсан хуулийн заалт, дүрэм, журам, хариуцлагын арга хэмжээ, мөн эмэгтэйчүүдэд шийдвэр гаргах албан тушаалд очих, шийдвэр гаргах үйл явцад нөлөө үзүүлэх боломж олгох, иргэний нийгэм, түүний дотор эмэгтэйчүүдийн бүлгүүд идэвхтэй, бодитой оршин ажиллах зэрэг холбогдох бүхий л бүтцийг бүрдүүлэх хэрэгтэй болно. (Шигтгээ 4.31).

Энэ хэсэгт намын эмэгтэй гишүүд эрэгтэйчүүдтэй түншлэн жендэрийн тэгш байдлыг улс төрийн нам дотроо институтлахын тулд хэрхэн нөлөөллийн ажил хийх талаар авч үзэв.

→ Тухайн нам, намын удирдлагын хэр “жендэрт ээлтэйг” тодорхойлох

Жендэрийн тэгш байдлыг улс төрийн нам дотор албажуулах зорилгоор авах арга хэмжээг тодорхойлохын өмнө тухайн намын **жендэрийн мэдрэмж** одоо ямар байгааг судалж үзвэл хэрэгтэй байж болох юм. Жендэрийн тэгш байдлын асуудалд тухайн нам хэрхэн хандаж байгааг харах нэг арга нь дараах 3 ерөнхий ангилалд хувааж үзэх явдал юм. Үүнд:

- ✓ жендэрийн тэгш байдалд *илэрхий сөрөг* хандлагатай нам;
- ✓ *жендэрт ээлтэй*, түүнийгээ харуулдаг нам;
- ✓ улс төрийн оноо авах зорилгоор жендэрийн тэгш байдлыг *өнгөц* буюу үгээр л дэмждэг нам.²⁰⁷

i) Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшилд **илэрхий сөрөг** хандлагатай нам нь эмэгтэйчүүдэд нам дотроо дэвших боломж өгөхгүй байх, эмэгтэйчүүд намын янз бүрийн ажил, үйл явцад оролцохыг хориглосон дүрэм, журам мөрддөг байх гэх мэтээр гишүүдээ хүйсээр ялгаварлах янз бүрийн аргыг ашигладаг байж болно.

ii) **Жендэрийн тэгш байдал**, эмэгтэйчүүдийн дэвшлийг бодитой дэмждэг нам нь түүнийгээ харуулж байдаг. Энэ нь эмэгтэйчүүдийг шууд дэвшүүлж, нэр дэвшигч болгодог гэсэн үг биш. Гэхдээ ийм нам нь улс төрийн дэвшлийн төлөө өрсөлдөхөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хамаагүй тэгш гарааны нөхцөл олгодог байх магадлалтай. Жендэрийн тэгш байдлыг дэмждэг нам нь эмэгтэйчүүдийн дэвшлийг зөвхөн онолын хувьд, эсвэл үгээр биш харин түүнийг нэвтрүүлж, чадавх бэхжүүлэх, сургалт хийх, эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэйчүүдийн байгууллагад хөрөнгө нөөц хуваарилах зэргээр боломжит арга хэмжээг авдаг.

iii) Жендэрийн тэгш байдлыг **өнгөн дээрээ** дэмждэг намыг танихад хэцүү: улс төрийн хувьд ашигтай бол эмэгтэйчүүдийн дэвшлийг дэмжинэ, гэвч энэ нь зарчмын хувьд дэмжиж буй хэрэг биш юм. Ийм намууд жендэрийн тэгш байдлыг нээлттэй зарлан дэмжих боловч хаалттай хаалганы цаана эмэгтэйчүүдээс мэдээллээ нуух, шийдвэр гаргах үйл явцад оруулахгүй байх зэргээр эмэгтэйчүүдийн ахих дэвших нөхцөлийг хааж байдаг.

Тухайн эмэгтэй ямар хэлбэрийн намд элссэнээ мэдэж авсны дараа уг орчинд таарсан жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх аргаа боловсруулахад хялбар болно.

Өмнөх 3 дугаар бүлэгт дурдсанчлан, нэр дэвшигчийнхээ намтар, туршлагыг олон янз болгох сонирхолтой намууд *тэгш байдлын үг хэллэг ашиглах* (намын мөрийн хөтөлбөр, сурталчилгаа, намын даргын хэлсэн үг зэрэгт тэгш төлөөллийн талаар дурдах); *тэгш байдлыг дэмжих* (эмэгтэйчүүд улс төрд ороход зориулан сургалт хийх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэтээр тодорхой арга хэмжээ авах); *тэгш байдлын*

207 Sonja Lokar, materials developed for the OSCE/ODIHR training “Women in Political Parties”, held in Tirana, Albania, 19–20 June 2012

баталгаа өгөх (намын жагсаалтанд орох эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхийн тулд намын бодлогын түвшинд квот тогтоох зэрэг арга хэмжээ авах) зэрэг арга ашиглаж болохыг санана уу.

Тухайн нам аль бүлэгт багтаж байгаагаас шалтгаалан эмэгтэйчүүд намаа тэгш байдлын үг хэллэг ашигладаг төдий намаас тэгш байдлыг дэмждэг, баталгаа өгдөг нам болгохын төлөө ажиллаж болно.²⁰⁸

→ **Жендэрийн тэгш байдлын төлөө тэмцэгчидтэй эв санааны нэгдэл бий болгох (эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль алинтай)**

Нам дотроо жендэрийн тэгш байдлыг сурталчлахад хэн холбоотон, хэн эсэргүүцэгч байхыг тодорхойлж, мэдэх нь чухал. Намын удирдлагуудын дундаас хэн нь “жендэрийн асуудлаар манлайлагч” эсвэл дэмжигч вэ? Хэн ямар учраас эсэргүүцэж байна вэ? Жендэрийн тэгш байдлыг дэмжлэг гэдэг нь танигдсан намын ямар эрэгтэй, эмэгтэй гишүүн байна вэ? Ямар эрэгтэй, эмэгтэй гишүүн дэмжихгүй байна вэ? Ямар шалтгаанаар?

Эмэгтэйчүүд жендэрийн тэгш байдлыг дэмждэг эрэгтэй, эмэгтэй гишүүдийн аль алиныг олж тогтоох хэрэгтэй. Тэд бол түүний улс төрийн ахиц дэвшлийг дэмжих, мөн намыг жендэрийн мэдрэмжтэй, эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш боломж олгодог болоход хамтран ажиллах холбоотнууд юм.

→ **Улс төрийн намын дүрэм, бодлого, ёс зүйн дүрэмд жендэрийн тэгш байдлыг журамлан тусгах**

Шигтгээ 4.32. Жендэрийн асуудлыг бүхий л үйл ажиллагаандаа тусгах тухай ойлголт

Жендэрийн асуудлыг бүхий л үйл ажиллагаандаа тусгах гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс бодлого, хөтөлбөрөөс тэгш хүртэж, тэгш бус байдал газар авахгүй байх үүднээс эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн санаа зовж буй асуудал, түүлж өнгөрөөсөн түршлагыг бодлого, хөтөлбөрийн дизайн, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд тусгаж байхыг хэлнэ. Эцсийн зорилго бол жендэрийн тэгш байдал юм.

Эх сурвалж: “Democracy and the Challenge of Change. A Guide to Increasing Women’s Political Participation”, NDI, 2010.

Жендэрийн тэгш байдлыг нам үйл ажиллагаандаа удирдлага болгох зарчим, үнэт зүйл болгон институтчлах, ялангуяа дүрэм гэх мэт намын суурь баримт бичигтээ тусгах нь чухал. Намын удирдлагаас жендэрийн тэгш байдлын талаар мэдэгдэл хийсэн бол эмэгтэйчүүд түүнийг цуглуулан, түүний үг хэллэгийг ашиглан намын бодлогын одоо байгаа баримт бичигт өөрчлөлт оруулж болно. Дараа нь, намын дүрэм, мөрийн хөтөлбөр зэрэг жендэрийн тэгш байдлын талаарх эрмэлзлээ бататгасан агуулга оруулах асуудлыг дэвшүүлэхийг зөвшөөрөх намын их хурлын төлөөлөгч эрэгтэй, эмэгтэй гишүүнийг олно.

Түүнчлэн энэ аргыг намын үйл явц, бүтэц зохион байгуулалт, шийдвэр гаргах үйл явцад жендэрийн тэнцвэртэй төлөөлөл нэвтрүүлэхэд ашиглаж болно. Намын гишүүдэд ялгаварлан гадуурхах, бэлгийн дарамт учруулах зэргийг хориглосон намын гишүүдийн биеэ авч явах дүрэм, бодлого байхгүй бол эмэгтэйчүүд тэдгээрийг боловсруулах ажлыг хэсэг байгуулах ажлыг санаачилж эсвэл

зөвлөмж гаргаж болно. Үлгэр жишээ авахуйц парламентын ёс зүйн дүрмийн жишээ олон бий (3 дугаар бүлгээс улс төрийн намын ёс зүйн дүрэм боловсруулах талаар харна уу).

208 See: Joni Lovenduski, *Feminizing Politics* (Cambridge: Polity Press, 2005); and Sarah Childs, Joni Lovenduski and Rosie Campbell, “Women at the Top 2005: Changing Numbers, Changing Politics?”, (London: Hansard Society, 2005).

→ **Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн намын хөтөлбөр боловсруулах, сургалт хийх асуудлыг лоббидох**

Эмэгтэйчүүд дангаараа эсвэл хамтдаа намын шинэ гишүүдэд зориулсан сургалт бүрт жендэрийн тэгш байдлыг нэг сэдэв болгон оруулж байхаар нам дотроо нөлөөллийн ажил хийж болно. Энэ сэдвийг эмэгтэйчүүдийн байгууллагын гишүүд (хэрэв байдаг бол), нам доторх жендэрийн нэр хүнд бүхий тэмцэгч эсвэл гаднаас жендэрийн эсвэл улс төрийн мэргэжилтэн урьж авчран заалгаж болно. Намын удирдлага, шийдвэр гаргагчид мөн уг сургалтанд ядаж нэг удаа суух хэрэгтэй бөгөөд жендэрийн асуудлыг тусгаж чадах эсэх нь намын удирдлагаас ирэх дэмжлэгээс ихээхэн хамааралтай.

Намаас гишүүддээ зориулан чадавх бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр гаргасан бол эмэгтэйчүүд жендэрийн тэгш байдал, жендэрийн асуудлыг тусгах гэсэн сэдвийг заавал үзэх сэдэв болгохын төлөө нөлөөллийн ажил хийж болно. Түүнчлэн намаас зохион байгуулж буй сургалтанд эмэгтэй, эрэгтэй гишүүд хамрагдах тэгш боломжтой байх үүднээс сургалтанд хэн хамрагдах талаар шалгуур байгаа эсэхийг олж мэдэх хэрэгтэй. Эмэгтэйчүүд намын удирдлагадаа нөлөөлөн, намын гишүүдээс жендэрийн асуудлыг намын бүх үйл явц, журам, практикт тусган авч үзэх мэдлэг туршлага бий болгож, хөгжүүлэхийн тулд жендэрийн тэгш байдал, жендэрийн төсвийн ахисан шатны сургалтанд суух сонирхолтой намын гишүүдэд санхүүжилт олгуулахаар хөөцөлдөж болно. Энэ нь жендэрийн тэгш байдлын талаарх тухайн сэдвээр дотоод чадавхи бүрдүүлэхэд ач холбогдолтой.

→ **Намаас хэрэгжилтийн байдал дээр хариуцлага нэхэх**

Нам доторх жендэрийн идэвхтнүүдийг (эмэгтэй, эрэгтэй) цуглуулан, намын удирдлагаас жендэрийн тэгш байдлын үүрэг амлалтаа хэрхэн хэрэгжүүлэх гэж байгааг нь асууж болно. Эсвэл эмэгтэйчүүдийн байгууллагаас эдгээр мэдэгдэл, үүрэг амлалтыг судлан үзэж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах, намын удирдлагаар батлуулж болно.

→ **Намаас гадуур буй дэмжигчдийг ашиглан намын удирдлагад жендэрийн тэгш байдлыг дэмжих шаардлага тавих**

Дээрх аргатай мөн адил, хэвлэл мэдээлэл, эмэгтэйчүүдийн бүлгүүд, ТББ, нөлөө бүхий сонгогчид, олон нийтийн санаа бодол, байр суурьт нөлөө үзүүлэгч талууд зэрэг намаас гадуур буй эх сурвалжийг ашиглан намын удирдлагаас жендэрийн тэгш байдлын талаар гаргасан мэдэгдэл, түүнийг хэрэгжүүлэхийн тулд юу хийх гэж байгааг нь асууж болно. Түүнчлэн сонгуулийн үеэр жендэрийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих чиглэлээр авсан амлалтын хэрэгжилтийн явцыг хянахад нам, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэмтэй хамтран ажиллаж болно.

→ **Нам дотроо эмэгтэйчүүдийн бүлэгт нэгдэх эсвэл тийм бүлэг байгуулах**

Эмэгтэйчүүдийн бүлэг, жигүүр гэх мэтээр нэрлэгддэг намын эмэгтэйчүүдийн байгууллагууд нь намын эмэгтэй гишүүдээс бүрдсэн намын дотоод нэгж юм. Тэдгээр нь эмэгтэйчүүдэд бодлогын тэргүүлэх чиглэлээ илэрхийлэх, тодорхой асуудлаар хамтарсан нөлөөллийн ажил хийх, эмэгтэйчүүд карьераа ахиулах чадавх бэхжүүлэхэд нь туслах, жендэрийн тэгш бус байдал, жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхлын талаар ойлголт мэдлэгийг дээшлүүлэх зэрэг янз бүрийн ажил хийх зорилго тавьдаг. Эмэгтэйчүүдийн зарим байгууллага жендэрийн аудит зэрэг судалгаа, үнэлгээний ажил хийж, намын дүрэм, бодлого, хөтөлбөрт жендэрийн тэгш байдал, тэнцвэрийн талаар тусгуулах нөлөөллийн ажил хийн, намын мөрийн хөтөлбөр боловсруулахад хувь нэмэр оруулдаг. Тухайлбал, Испаний Социалист ажилчны нам дотор байгуулагдсан жендэрийн тэгш байдлын бодлогын алба бол үүний нэг жишээ бөгөөд аль 1984

онд эмэгтэйчүүдийн ажлын алба байдлаар намын үндэсний гүйцэтгэх түвшинд институтлагдсан байв. Тус алба нь намын их хурлын шийдвэр, мөрийн хөтөлбөр, бусад албан баримт бичигт эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг оруулах тал дээр амжилттай ажиллаж иржээ.²⁰⁹

Намын эмэгтэйчүүдийн байгууллага ЕАБХАБ-ын бүс нутгийн улс төрийн олон нам байгуулагдан, нам дотроо эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж ирсэн. Тухайлбал, Британий Либерал демократ намын эмэгтэй гишүүд 1990-ээд оны сүүлээр парламентад олон эмэгтэй оруулахаар 50:50 кампанит ажил зохион байгуулж, “Мөнгө, итгэл, соёл” гэсэн уриатай ажиллаж байв. Тэд энэ гурван хүчин зүйлийг улс төрд анх орж буй хүмүүст тулгарч буй гурван том бэрхшээл хэмээн тодорхойлсон. Энэ зорилгоор Нэнси Сиэр итгэлцлийн санг 1997 онд байгуулж, эмэгтэйчүүд жендэрийн үүргийнхээ дагуу хүлээхээс өөр аргагүй болдог хүүхэд, ахмадуудаа асрах зэрэг зардал, замын зардлыг санхүүжүүлэх болсон. Түүнчлэн тус сангаас эмэгтэйчүүд парламентын гишүүний сүүдрийн гишүүнээр ажиллах (өөртөө итгэлтэй болох үүднээс), шинээр эмэгтэй хэвлэлийн төлөөлөгч нэр дэвшигч элсүүлэхэд хэрэг болох мэдээллийн сан бүрдүүлэхэд (эрэгтэй давамгайлсан соёлтой тэмцэх) дэмжлэг үзүүлж иржээ.²¹⁰

Албанид парламент дах нам дамнанас эмэгтэйчүүдийн бүлэг байгуулах ажил хэцүү байсан тул хэд хэдэн улс төрийн намын эмэгтэй гишүүд хамтран эмэгтэйчүүдийн форумууд байгуулсан, үүнд Ардчилсан намын дэргэд байгуулагдсан Албаний Ардчилсан эмэгтэйчүүдийн лиг, Социалист намын дэргэд байгуулагдсан Албаний Социалист эмэгтэйчүүдийн лиг зэрэг болно. Эдгээрийн аль аль нь эмэгтэйчүүдийн сонирхол, оролцоог тухайн нам дотроо дээшлүүлэх зорилготой байв. Гүржид эмэгтэйчүүдийн байгууллага ихэнх улс төрийн намд бий, мөн үндэсний болон бүс, орон нутгийн түвшинд ч бий. Гүржийн улс төрийн намуудын дэргэдэх Эмэгтэйчүүдийн байгууллагын талаарх судалгаанаас үзэхэд эдгээр нь өөр өөр зорилготой, янз бүрийн түвшинд институтлагдсан, мөн өөр өөр зорилгыг эрхэмлэдэг байна. (Хүснэгт 4.33).

Хүснэгт 4.33. Гүржийн улс төрийн намуудын дэргэдэх Эмэгтэйчүүдийн байгууллага

Улс төрийн нам	Эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагаа
Үндэсний нэгдсэн хөдөлгөөний	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн тэгш байдлын газрыг 2010 онд байгуулсан. • Намын дүрэмд уг газрын талаар дурдаагүй; намын дүрэмд намын жендэрийн тэгш байдлын үнэт зүйлийн талаар дурдсан. • Тус газрын зорилго нь үндэсний болон орон нутгийн түвшинд, мөн гүйцэтгэх байгууллагын бүтцэд жендэрийн тэнцвэртэй байдлыг бий болгох; эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хамгаалах; Гүржийн нийгмийн бүхий л хэсэгт тэгш байдлын үзэл санааг сурталчлах.
Шинэ баруун	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн клубыг 2001 онд буюу нам бүртгүүлэх үед байгуулсан. • Намын дүрэмд энэ клубын талаар дурдаагүй • Тус клубын анхны зорилго нь улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн идэвхтэй орлоцоог дэмжих; эмэгтэйчүүдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх; хөвгүүд, охидын аль алийг нь хамран залуучуудын нөхцөл байдлыг дээшлүүлэх арга хэмжээ авах явдал байв. • 2005 оноос хойш эмэгтэйчүүдийн клуб нь намд шинэ дэмжигч авчрах; эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх; намын гишүүн эмэгтэйчүүдийн чадавхыг хөгжүүлж, нам, сонгуульд байгууллагад оролцоог нь идэвхжүүлэх ажил хийж байв.

209 See Celia Valiente, “Spain at the Vanguard in European Gender Equality Policies”, 2006, <http://e-archivo.uc3m.es/bitstream/id/22095/spain_valiente_2008_ps.pdf/>.

210 Alison Woodward, Going for Gender Balance. A guide for balancing decision making (Strasbourg: Council of Europe, 2002), p. 40.

Христийн ардчилсан хөдөлгөөн	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн байгууллагыг намын бүтцийн нэг нэгж байдлаар байгуулсан. • Намын дүрэмд уг байгууллагын талаар заагаагүй боловч нэгж байгуулж болох талаар дурдсан. • Эмэгтэйчүүдийн байгууллагын зорилго нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог идэвхжүүлэх; эмэгтэйчүүдэд улс төрийн карьераа ахиулахад нь дэмжлэг үзүүлэх; шийдвэр гаргахад идэвхтэй оролцоход нь дэмжих; жендэрийн тэнцвэр бий болгох явдал байв.
Бүгд найрамдах нам	<ul style="list-style-type: none"> • Нам дотроо жендэрийн асуудлаар ажиллах жендэрийн тэгш байдлын бүлэг байгуулсан. • Намын дүрэмд тэгш байдлын зарчмыг тунхаглаж, хүйсээс үл хамааран бүгд тэгш эрхтэй байх тухай заасан, гэхдээ дээрх бүлгийн талаар тусгайлан дурдаагүй. • Тус бүлгээс “намын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийн нэмэгдүүлэх нь намын дотоод ардчиллын нэг үзүүлэлт мөн” гэсэн стратегийн баримт бичиг боловсруулсан. • Эмэгтэй нэр дэвшигчийн сонгон авах журмыг боловсруулж байна. • Тус бүлгийн зорилго нь сонгуульд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн тэнцвэрийг хангах явдал юм.
Хөдөлмөрийн нам	<ul style="list-style-type: none"> • 2003 он хүртэл Эмэгтэйчүүдийн зөвлөл ажиллаж байсан. • Жендэрийн тэгш байдлын механизмыг дахин сэргээх төлөвлөгөөтэй байна. • Тус зөвлөл ажиллаж байх хугацаандаа төрөөс явуулж буй нийгмийн хамгааллын хөтөлбөр, тус хөтөлбөрийн зардлын талаар хяналтын судалгаа хийж байсан.
Үйлдвэржилт Гүржийг аварна*	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн клубыг 1999 онд буюу нам байгуулагдсан жил байгуулсан. • Намын төв ба дүүргийн түвшинд ажилладаг. • Зорилго нь Гүржийн нийгмийн эмзэг бүлэгт голлон анхаарах, дүүгийн түвшний клубууд нийгэм, эдийн засгийн асуудлаар судалгаа хийдэг. • Бусад зорилго гэвэл эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр, мөн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих явдал юм.
Манай Гүрж – Чөлөөт ардчилагчид	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн байгууллага байхгүй; намын дүрэмд жендэрийн тэнцвэрийн талаар заалт бий.
Гүржийн зам	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн байгууллага байхгүй, дүрэмд жендэрийн талаар дурдсан зүйл байхгүй.

Эх сурвалж: Tamar Bagratia, Medea Badashvili, David Jijelava and Irakli Khmaladze, “Developing intra-party democracy from a gender perspective”, in Intra-party democracy and local governance (Tbilisi: NIMD Georgia, 2012), pp. 10–11. () одоор тэмдэглэсэн хэсгийг дараах бүтэлээс авав. Ghia Nodia and Alvaro Pinto Schlotbach, The Political Landscape of Georgia: Political Parties: Achievements, Challenges and Prospects (Delft: Eburon Delft, 2006).*

Намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага нь тогтмол уулзалддаг, намын удирдлагаас тодорхой хөрөнгө нөөц авдаг, тодорхой гишүүнчлэл бүхий (зөвхөн эмэгтэйчүүд, эсвэл эмэгтэй, эрэгтэй аль аль нь) албан ёсны бүтцийн нэгж байж болно. Эсвэл эмэгтэйчүүд шаардлагатай тохиолдолд уулздаг албан бүс хэлбэртэй байж болно. Яг ямар хэлбэртэй байх нь тухайн улс төрийн намын үйл ажиллагааны нөхцөл байдал, албан ёсны нэгж байх хэрэгцээ, мөн уг нэгжийн эцсийн зорилго юу байх вэ гэдгээс шалтгаална. Нам дамнасан хамтын ажиллагааг мөн үгүйсгэж болохгүй; парламентын түвшинд ийм бүтэц байхгүй бол тодорхой асуудлаар нөлөөллийн ажил хийх, ирэх сонгуульд эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих зорилгоор улс төрийн намын төлөөлөгчдийг хамруулан байгуулах нь зүйтэй.²¹¹

Зарим үед нэг улс төрийн нам дотор хэд хэдэн эмэгтэйчүүдийн байгууллага өөр өөр

211 For more on structures for women established within parliaments, see A Comparative Study of Structures for Women MPs in the OSCE Region, OSCE/ODIHR, 2013, <<http://www.osce.org/odihr/105940>>.

зорилгоор зэрэг ажиллах тохиолдол бий. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдал гэх мэт тодорхой бодлогын эсвэл намын асуудлаар нөлөөлөл хийх зорилгоор эмэгтэйчүүдийн бүлэг байгуулагдаж болох ба түүнд зөвхөн тухайн асуудлаар ажиллах сонирхолтой намын гишүүд (эрэгтэй, эмэгтэй) орно. Үүнтэй зэрэгцээд намын нийт эмэгтэй гишүүдийг багтаасан сайн дурын сүлжээ ажиллаж байж болно. Мөн намын жендэрийн мэдрэмжтэй бодлогын талаар нөлөөлөл хийх зорилготой намын эмэгтэй, эрэгтэй гишүүдийн аль алийг нь нэгтгэсэн жендэрийн тэгш байдлын бүлэг ажиллаж байж болно. Мөн боловсрол, эрүүл мэнд, шүүх ба хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, эсвэл олон улсын намуудын сүлжээтэй (Олон улсын социалист эмэгтэйчүүд гэх мэт) хамтран ажиллах зорилго бүхий мэргэжилд суурилсан эмэгтэйчүүдийн бүлгүүд ажиллаж болно.

→ **Намын эмэгтэй гишүүдийг дэмжих судалгааны байгууллага эсвэл ТББ байгуулах**

Намын бүтцийн дотор эмэгтэйчүүдийн байгууллага байгуулахаас гадна эсвэл түүний оронд эмэгтэйчүүд намын бүтцээс гадуур анхан шатны түвшинд, хараат бус байгууллага байгуулахаар шийдэж болно. Тухайлбал, АНУ-д улс төрийн гол намуудад эмэгтэйчүүдийн байгууллага байхгүй. Харин Бүгд найрамдах намын эмэгтэй гишүүд Бүгд найрамдах эмэгтэйчүүдийн үндэсний холбоо гэсэн байгууллагын дор нэгдсэн байдаг. Нэг хэсэг Бүгд найрамдах намын Үндэсний хорооны нэг салбар байсан тус байгууллага санхүү, бүтэц зохион байгуулалтын хувьд биеэ даагаад байна. Тус байгууллагын зорилго нь Бүгд найрамдах намын зарчим, зорилго, бодлогыг дэмжих; Бүгд найрамдах намын нэр дэвшигчийг сонгох; улс төрийн боловсрол, үйл ажиллагаагаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх; мөн сайн засаглалын зорилгод эмэгтэйчүүд үр дүнтэй ажиллах зэрэг юм. Эдгээр зорилгод хүрэхийн тулд тус байгууллага боловсрол мэдлэг олгох, харилцах, шинээр элсүүлэх, сурталчилгааны ажил хийх, хөрөнгө босгох,

Шигтгээ 4.34. Эмэгтэйчүүдийн бүлэг, байгууллагууд Эмэгтэйчүүдийн бүлгүүд: хийх ажлын жагсаалт

- Жендэрийн тэгш байдлын асуудлаар намын бодлогын томъёолох.
- Эмэгтэй сонгогчдод чиглэсэн намын стратегийг боловсруулах.
- Намд эмэгтэй гишүүд элсүүлэх.
- Намын эмэгтэй гишүүд, идэвхтэй, ажилтнууд, нэр дэвшигчдэд чадавх бэхжүүлэх, дагуулан сургах ажил зохион байгуулах, сонгуульд албан тушаалд буй намын гишүүн эмэгтэйчүүддээ дэмжлэг үзүүлэх.
- Намын гишүүн эмэгтэйчүүдийг гадаад орны адил төстэй намын эмэгтэйчүүд, олон улсын адил төстэй эмэгтэйчүүдийн холбоо, улс төрийн сангуудтай холбох.
- Эмэгтэйчүүдийн иргэний нийгмийн байгууллага ба намын эмэгтэйчүүдийн байгууллагыг холбосон механизм бий болгох, иргэний нийгмийг засгийн газар, парламентын гишүүдтэй холбох.
- Намын гишүүдийг бусад намын янз бүрийн түвшний эмэгтэйчүүдтэй холбон, асуудлаар нэгдсэн эвсэл байгуулах, нэгдмэл ашиг сонирхолтой асуудлаар хамтарсан нөлөөллийн ажил хийх бололцоо гаргах.

Эмэгтэйчүүдийн бүлэг, байгууллагын хийж болох, болохгүй зүйл

Болох зүйлс:

- Хэлэлцэх асуудал нь ил тод, ажлын төлөвлөгөө тодорхой байх явдлыг хангах.
- Уулзалт, хурлыг эрэгтэй гишүүдэд нээлттэй байлгах.
- Идэвхтэй байх, намын эрэгтэй гишүүдтэй бүтээлч яриа хэлэлцүүлэг өрнүүлэх.
- Жендэрийн тэгш байдлын төлөө байгаа эрэгтэйчүүдийн санаачилгыг дэмжих.

Болохгүй зүйлс:

- Намын эрэгтэй гишүүдтэй сөргөлдөөнд орох.
- Намын удирдлагатай зөрчилдөх.
- Намын өмнөөс буяны, хүмүүнлэгийн ажил хийж бараг ТББ болох.

Эх сурвалж: энэ гарын авлагад зориулан Сонжа Локер бэлтгэв.

сургалт хийх, хууль эрх зүйн ажил хийх зэрэгт гол анхаарлаа хандуулдаг.²¹²

Ардчилсан эмэгтэйчүүдийн үндэсний холбоо бол Ардчилсан намын эмэгтэйчүүдийн албан ёсны байгууллага юм. Тус байгууллага нь эмэгтэйчүүдийн дүү хоолойг сонгох, тэднийг сонгуульд өрсөлдөхөд дэмжих, мөн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, тэгш цалин хөлс зэрэг чухал асуудлаар эмэгтэйчүүд, сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх ажил хийдэг.²¹³

→ **Эрэгтэйчүүдийг улс төрийн түнш, жендэрийн асуудлаар тэмцэгч болгон хамтран ажиллах**

Олон эмэгтэй эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны асуудлаар тууштай тэмцэгч байдаг бол олон эрэгтэй ч тийм байдаг. Гэвч жендэрийн тэгш байдлын зорилго, түүнд харагдахуйц хувь нэмэр оруулахад эрэгтэйчүүдийг оролцуулахад бэрхшээлтэй хэвээр байна. Эрэгтэйчүүдийн хөрөнгө нөөц, дэмжлэгийг авснаар эмэгтэйчүүдийн бүлгийн ажлын үр дүн дээшлэх бөгөөд эмэгтэй улс төрчдийн дэвшүүлж буй асуудал илүү өргөн хүрээний дэмжлэг авч чадна. Түүний зэрэгцээ эмэгтэй улс төрч жендэрийн тэгш байдлын асуудлаар эрэгтэйчүүдээс дэмжлэг авч чадвал энэ нь тэднийг зөвхөн эмэгтэйчүүдийн асуудлаар л хөөцөлддөг гэх шүүмжлэлийг сулруулна. Үнэндээ жендэрийн тэгш байдлыг тогтоох нь эрэгтэйчүүдэд ч адил тэгш хамаатай бөгөөд эрэгтэй улс төрчдөд ч ашиг тустай байдаг. Энэ эвслийг амжилттай бий болгохын тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүс харилцан зөвшилцөлд хүрч чадахуйц жендэрийн тэгш байдлыг асуудлыг олж тогтоох нь чухал.

Дөрөвдүгээр бүлгийн дүгнэлт

Энэ бүлэгт эмэгтэйчүүд, мөн зарим үед эрэгтэйчүүдтэй хамтран улс төрийн нам дотроо ахиж дэвшихдээ ямар арга ашиглаж, арга хэмжээ авч, санаачилга гаргах талаар дэлгэрэнгүй авч үзэв. Тус бүлэг нь эмэгтэйчүүд улс төрийн карьераа ахиулахын тулд өөрөө хэрэгжүүлэх аргуудаас дурдав. Мөн эмэгтэйчүүд сонгосон намдаа элсэн орох; нам хэрхэн ажилладаг талаар мэдэж авахад нь эмэгтэйчүүдэд туслах; сонгуулийн сурталчилгаа хийхэд дэмжлэг үзүүлэх аргуудын талаар өгүүлэв. Нам дотроо эмэгтэйчүүдэд тэгш боломж гаргахын төлөө хамтран ажиллах ямар арга байж болохыг мөн дурдав. Ингээд тус бүлгийн төгсгөлд жендэрийн тэгш байдлын асуудлыг намын бүтэц зохион байгуулалт, бодлого, хөтөлбөр, практикт туслахын тулд эмэгтэйчүүд ямар санаачилга гаргаж болох талаар өгүүлэв. Харин дараагийн бүлэгт улс төрийн нам, эмэгтэй улс төрчид жендэрийн тэгш байдлыг намын үйл явц, бодлого, үйл ажиллагаанд тусгахад иргэний нийгмийн байгууллагууд хэрхэн тусалж чадах талаар авч үзэв.

212 For more information on the National Federation for Republican Women, visit <<http://www.nfrw.org/>>.

213 National Federation of Democratic Women (NFDW), <<http://www.nfdw.com/>>.

Иргэний нийгмийн байгууллага, бусад оролцогчид

ТАВДУГААР БҮЛЭГ

Тавдугаар бүлгийн оршил

5.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?

- 5.1.1. Эмэгтэйчүүд улс төрд орох, улс төрийн карьераа ахиулахыг дэмжих
- 5.1.2. Улс төрийн намуудтай ажиллах
- 5.1.3. Олон нийтийн эерэг хандлага бүрдүүлж төлөвшүүлэх
- 5.1.4. Хэвлэл мэдээлэлтэй ажиллах
- 5.1.5. Эрдэм шинжилгээний байгууллагатай ажиллах
- 5.1.6. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллагатай ажиллах
- 5.1.7. Үйл явдлын тэргүүнд явах

Тавдугаар бүлгийн дүгнэлт

Тавдугаар бүлгийн оршил

Өнгөрсөн хэдэн арван жилийн хугацаанд ЕАБХАБ-ын бүс нутагт ардчилалд шилжих, сорилтыг даван туулах үйл явцыг хянахад иргэний нийгэм амин чухал үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Үүний үр дүнд идэвхтэй, өргөн хүрээний, бүх талыг хамарсан иргэний нийгэм бол төлөвшсөн ардчилсан нийгмийн нэг салшгүй бүрдэл хэсэг, чухал үзүүлэлт гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрдөг боллоо.

ЕАБХАБ-ын бүс нутгийн томоохон газар нутаг дээр 1990-ээд оноос эхэлсэн ардчилсан нийгэм рүү шилжих шилжилт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс үндэсний болон олон улсын үйл хэрэгт илүү өргөнөөр оролцох хувь хүний, иргэний болон улс төрийн эрх чөлөөг эдлэх ховор боломж олгосон билээ. Түүнээс хойш ЕАБХАБ-ын улс орнуудад ардчилсан сонгууль тогтмол явагдаж, институцийн чухал шинэчлэл хийгдэж байна. Иргэний нийгмийн байгууллагууд шилжилтийн олон орны орон нутгийн болон үндэсний түвшний эдгээр үйл явцад гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ЕАБХАБ-ын нийт улс орны хувьд ардчиллыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд олон улсын түвшинд болон ЕАБХАБ-ын ажилд ялангуяа бүсийн арга хэмжээнд идэвхтэй оролцсоор ирлээ. Үүнд тус бүс нутгийн хүний эрхийн идэвхтнүүдийн жилийн хамгийн том цугларалт болох Хүний хөгжлийн хэрэгжилтийн уулзалт, мөн Хүний хөгжлийн семинар зэрэг тус байгууллагын сэдэвчилсэн уулзалтуудыг дурдаж болно. Тэдний байнгын үйл ажиллагаа нь үндэсний шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж, үндэсний болон олон улсын түвшинд бодлого, шийдвэр гаргах үйл явцад оруулж буй иргэний нийгмийн хувь нэмрийг өргөнөөр хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн билээ.

Жендэрийн тэгш байдлыг ардчилсан нийгмийн нэг шинж чанар гэдэг утгаар сурталчлах нь иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны, ялангуяа улс төрийн салбарт хийж буй ажлын нэг үндсэн хэсэг болоод байна. Энэ утгаараа иргэний нийгмийн бүлгүүд нь жендэрийн тэгш байдал, нээлттэй, ил тод, оролцоотой шийдвэр гаргах үйл явцыг дэмжих замаар ардчилсан засаглалын механизмыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж чадах юм. Үндэсний болон бүсийн түвшинд иргэний нийгмийн байгууллагууд эмэгтэйчүүдийн сонгуульд оролцож буй байдалд хяналт тавих; эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод туслалцаа үзүүлэх, хүний наймаатэй тэмцэх, хүний наймаа эрхлэгчдийг шүүхэд өгөх зэргээр эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг зарчмыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн сонгогддог болон томилогддог гол албан тушаалд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхийн төлөө тэмцдэг. Иргэний нийгмийн байгууллагууд эмэгтэйчүүдийн дэвшлийн төлөө үндэсний механизмын ажлыг дэмжих, олон улсын гэрээ, хэлэлцээрийн болон үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавихад хувь нэмэр оруулж ирсэн билээ.

Иргэний нийгмийн байгууллагууд, мөн ТББ гэгддэг байгууллагууд нь засгийн газрын бус хувь хүн, хуулийн этгээдийн байгуулсан, засгийн газрын аль нэг байгууллагаас хараат бус ажилладаг, ашиг олох зорилго агуулдаггүй байгууллагууд юм.

Засгийн газраас бүрэн эсвэл зарим санхүүжилт авдаг ТББ-ын хувьд тэд төрийн бус гэсэн эрх зүйн байдлаа хадгалахын тулд гишүүнчлэлдээ засгийн газрын төлөөллийг оруулдаггүй. Энэ нэр томъёогоор ихэвчлэн зөвхөн нийгмийн ерөнхий зорилгын төлөө ажилладаг, хэдий зарим улс төрийн шинж байвч улс төрийн намууд шиг цэвэр улс төрийн байгууллага биш тийм байгууллагуудыг нэрлэдэг.

Эх сурвалж: “Non-governmental organization”, Wikipedia, <http://en.wikipedia.org/wiki/Civil_society_organisation#Track_II_Diplomacy>.

Иргэний нийгэм бол гэр бүл, төр, зах зээлээс гадуур орших, хүмүүс нэгдмэл сонирхлынхоо төлөө харилцан нэгдэх талбар юм.

Эх сурвалж: CIVICUS Civil Society Index Methodology, <http://www.civicus.org/new/media/CSI_Methodology_and_conceptual_framework.pdf>.

Иргэний нийгмийн байгууллагууд эмэгтэйчүүдийг улс төрд орох, нэр дэвшихийг нь дэмжих; улс төрд ороход эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлийн талаар сонгогчид болон улс төрийн бусад талын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх; олон нийтэд эмэгтэйчүүдийн улс төрийн хувь нэмрийг танилцуулж мэдэгдэх; эмэгтэйчүүдийн улс төрийн чадавхын талаарх жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдэхийн төлөө ажиллах; улс төрийн оролцогч талуудын дунд яриа хэлэлцээр өрнөхийг дэмжих; жендэрийн тэгш байдлын талаар бодлого, эрх зүйн шинэчлэл хийхэд шаардагдах судалгаа, дүгнэлт хийх зэргээр эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, улс төр дэх жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

5.1. Ямар арга үр дүнтэй байна вэ?

Энэ бүлэгт намтай холбоотой болон холбоогүй иргэний нийгмийн байгууллагуудаас (ИНБ) эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих, улс төрийн намд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх ажилдаа хэрэглэх аргаас танилцуулна. Улс төрд олон эмэгтэй байх хэрэгцээ шаардлагын талаар олон нийтэд ойлголт мэдлэг өгөх, мөн улс төрд орох сонирхолтой эмэгтэйчүүд буюу “нийлүүлэлт” улс төрийн дээд шат, улс төрийн намын удирдлага, сонгогчдын дунд эмэгтэй нэр дэвшигчийн “эрэлт” бий болгоход үр дүнтэй байж болох аргуудаас дурдав. Мөн ИНБ төдийгүй хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагууд эмэгтэйчүүд улс төрд ороход саад учруулдаг жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдэхэд чухал үүрэг гүйцэтгэх тул тэдний хэрэгжүүлж болох аргуудаас оруулав. Иргэний нийгмээс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, улс төрийн намууд дах жендэрийн тэгш байдлыг хангах талаар хийх ажлыг дараах б чиглэлийн дагуу оруулав. Үүнд:

- **Эмэгтэйчүүд улс төрд орох**, улс төрийн карьераа ахиулахыг нь дэмжих;
- **Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих**, намын бүтэц зохион байгуулалт, бодлого, үйл явц, практикт жендэрийн тэгш байдлыг хангахын тулд улс төрийн намуудтай ажиллах;
- Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх замаар **улс төрд буй эмэгтэйчүүдийн талаар эерэг хандлага** бүрдэхэд хувь нэмэр оруулах;
- Жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдэх, жендэрийн тэнцвэртэй сурвалжлахыг дэмжих үүднээс хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны эерэг нөлөөний талаар олон нийт, улс төрийн холбогдох талуудад ойлгуулахын тулд **эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай** хамтарч ажиллах;
- Жендэрийн тэгш байдлыг бүтэц, бодлогын орчинд институтчлахын тулд **гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллагатай** хамтарч ажиллах.

Тус бүлгийн эхэнд эмэгтэйчүүдийг улс төр, улс төрийн намд элсүүлэх, мөн нэгэнт элсэн орсны дараа улс төрийн карьераа ахиулахад хөрөнгө нөөцийн дэмжлэг үзүүлэх гэх мэтээр ИНБ-аас хийж болох ажлын талаар дурдав. Түүнчлэн хэдий ИНБ, улс төрийн намууд улс төрийн үйл явцад гүйцэтгэх үүргийнхээ улмаас өөр хоорондоо таарч нийлдэггүй ч тэд улс төрийн эрх мэдэл, олон нийтийг татах чадварыг дээшлүүлэхэд тусалж чадна. Ялангуяа улс төрийн намтай ямар нэг холбоотой ажилладаг ИНБ-ууд (зарим намтай адил эрхэм зорилго, үнэт зүйлтэй), мөн тодорхой бодлогын асуудлаар зарим улс төрийн намтай адил байр суурьтай ажилладаг байгууллага ийм дэмжлэг үзүүлж чадна. Жендэрийн тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй шинэчлэл, төрийн

хэрэгт жендэрийн тэнцвэр бий болгох талаар мөрийн хөтөлбөртөө оруулсан улс төрийн намуудыг эмэгтэйчүүдийн бүлгүүд, холбоод, ТББ, зэрэг нь дэмжиж, уг намын өмнөөс сурталчилгаа хийж болно.

Жендэрийн тэгш байдлын асуудлаар иргэний нийгмийн хийх ажил нь хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллагыг оролцуулбал илүү үр дүнтэй. Хэвлэл мэдээлэл ардчилсан үйл явцад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Мэдээлэл, санаа, байр суурийн чөлөөт үрсгалыг хангах нь төлөвшсөн ардчиллыг хадгалах, шилжилтийн ардчиллыг дэмжихэд чухал хэвээр байна.

Гэвч хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн дүр төрх, илэрхийлэл бол болгоомжлох сэдэв байсаар ирсэн билээ. Жендэрийн хэвшмэл ойлголтыг улам бататгадаг, нийгэмд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаар ялгаварлан гадуурхсан ойлголтыг тараадаг, эмэгтэйчүүдийн улс төр, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүргийг мушгин гүйвүүлдэг хэмээн хэвлэл мэдээллийг шүүмжлэх нь их.²¹⁴ Тухайлбал, судалгаанаас үзэхэд, телевизээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн уламжлалт үүргийг бататгасан зураглал их гаргадаг; хэвлэл мэдээллийн гол хэрэгслээр эрэгтэйчүүд илүү гардаг, мөн эмэгтэйчүүдийг гаргасан ч хэвшмэл ойлголтоор харуулдаг байна.²¹⁵

Ардчилсан үйл явцад гүйцэтгэх үүргийг нь тэр бүр дурддаггүй ч эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд ардчиллын гол тулгуур болох төлөөллийн засгийн газар, чөлөөт сонгууль, хууль дээдлэх ёс, чөлөөт хэвлэл зэргийг дэмжиж байдаг.²¹⁶ Судалгааны байгууллага ардчиллыг дараах 4 хэлбэрээр дэмждэг гэж үзэж болно. Үүнд: 1) үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шинэ санааг тэтгэх хамгаалалт бүхий талбар болох; 2) ардчилал, төрийн ажлыг үнэлж, хүндлэн хүлээн авах соёлыг тэтгэх; 3) хувь хүмүүст авьяас билгээ нээн хөгжүүлэх бололцоо олгох; 4) эдийн засгийн өсөлт, улмаар хувь хүнд тусах боломжийг нэмэгдүүлэх.

Судалгааны байгууллагууд жендэрийн тэгш байдлыг дэмжин хэрэгжүүлж, жендэрийн асуудлаарх судалгааны ажлыг бодлого боловсруулах үйл явцтай холбож өгөх нь улс төрд эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд нэн чухал юм. Хэвлэл мэдээлэл, ИНБ-үүд ардчиллыг хөгжүүлэхэд адил төстэй үүрэг гүйцэтгэдэг тул тэдний хамтын хүчин чармайлт ихэвчлэн илүү үр дүнтэй, илүү үр нөлөөтэй байдаг.

Эцэст нь, иргэний нийгэм нь жендэрийн тэгш байдлыг дэмжсэн, үл ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, бодлого батлуулж, хэрэгжүүлэхийн тулд парламент, яам, үндэсний хүний эрхийн байгууллагууд, жендэрийн тэгш байдлын асуудал хариуцсан байгууллагууд зэрэг хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай зориуд хамтран ажиллах хэрэгтэй. Иргэний нийгэм хэдий үндэсний байгууллагуудын хувьд “хоточ нохой” буюу хяналтын чиг үүрэг гүйцэтгэдэг ч тэд санаа нэгтэй албан тушаалтнуудтай хамтран эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлын талаар төрийн албанд ойлголт нэмэгдүүлэх зорилготой ажиллах боломжтой.

Өмнө дурдсан 6 аргыг дор дэлгэрэнгүй тайлбарлав.

214 Julia T. Wood, “Gendered media: The Influence of Media on Views of Gender”, <<http://www.udel.edu/comm245/readings/GenderedMedia.pdf>>;

215 Jean Kilbourne, *Two Ways a Woman Can Get Hurt: Advertising and Violence*, Rereading America (Boston: Bedford/St. Martin’s, 2004), pp. 455–75.

216 Richard M. Freeland, “Academia’s Role in Strengthening the Foundation of a Democratic Society”, *Solutionsforourfuture.org*, 2006, <http://www.solutionsforourfuture.org/guest_RichardMFreeland.htm>.

5.1.1. Эмэгтэйчүүд улс төрд орох, улс төрийн карьераа ахиулахыг дэмжих

ЕАБХАБ-ын бүх улс оронд эмэгтэйчүүдийн төлөөлөл сонгуульд албан тушаалд маш доогуур байгааг өмнө дурдсан билээ. Сонгуульд эрэгтэйчүүдээс цөөн эмэгтэйг улс төрийн намууд дэвшүүлдэг. Гэтэл судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөхөд, ямар ч албан тушаал бай, ялах магадлал нь эрэгтэйчүүдтэй адил байдаг байна.²¹⁷ Украинд иргэний нийгмийн хийсэн судалгаагаар сонгогчид жендэрийн тэнцвэрийг дэмжиж байгаа байдал нь улс төрийн намынхаас илүү байгаа нь харагдсан бөгөөд энэ нь сонгогчийн итгэл үнэмшлийн тухайд жендэр гол хүчин зүйл биш гэдгийг харуулж байна (судалгааны байгууллагын талаар дор харна уу).²¹⁸ Гэвч өмнөх хэсэгт дурдсанчлан, эмэгтэйчүүд улс төрд эхлэн ороход саад бэрхшээлтэй хэвээр байгаагийн дээр эрэгтэйчүүдтэй ижил нөхцөлөөр өрсөлдөхөд хөрөнгө нөөц дутагддаг хэвээр байна.

Энэхүү хэсэгт иргэний нийгмийн байгууллагууд эмэгтэйчүүдийг улс төрд орох, улс төрийн карьераа ахиулахад хэрхэн туслах талаар авч үзлээ. Үүнд эмэгтэйчүүдийг улс төрд элсүүлэх, тэдний улс төрийн чадварыг дээшлүүлэх, улс төрийн хөрөнгө нөөцөөс хүртэх боломжийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрийн эв санааны нэгдлийг бэхжүүлэх зэрэг арга багтана.

→ Илүү олон эмэгтэйг улс төрийн намд элсүүлэх

Улс төрийн намд, улс төрд илүү олон эмэгтэйг элсүүлэх нь иргэний нийгмийн санаачилж, дэмжиж чадах нэг чухал ажил юм. Элсүүлэх хөтөлбөрт эмэгтэйчүүдийг намд элсүүлэх, тэднийг удирдах албан тушаалд бэлтгэх, мөн нэр дэвшихийг итгүүлэн хүсэх зэрэг ажил багтдаг.

Зураг 5.1. 2012 төсөл



“Бүү уурла, харин сонгогд”

Эх сурвалж: Улс төр дэх Америк эмэгтэйчүүдийн төв, Ратжерс Их сургууль, <http://www.cawp.rutgers.edu/>.

АНУ-д иргэний нийгмийн олон байгууллага нэр дэвших эмэгтэйчүүдэд сэдэл өгч, улс төрд элсүүлж ажилласан хэд хэдэн сайн жишээ бий.²¹⁹ Ялангуяа улсын чанартай явагдсан гишүүн элсүүлэх нэг аян бол “2012 төсөл” буюу Ратжерс их сургууль дээрх Америк эмэгтэйчүүд, улс төрийн төвийн санаачилсан нам бус сурталчилгааны

217 Jennifer L. Lawless and Richard L. Fox, *It Takes a Candidate: Why Women Don't Run for Office* (Cambridge: Cambridge University Press, 2005); Melinda Henneberger, “Why women don't run for political office” *The Washington Post*, 25 March 2012, <http://www.washingtonpost.com/blogs/she-the-people/post/why-womendont-run-for-political-office/2012/03/25/gIQAXLttZS_blog.html>.

218 Ukrainian Women's Fund, *Women's Participation in Politics and Decision-Making in Ukraine: A Strategy Paper*, Kiev, 2011, p.13.

219 “Political and Leadership Resources for Women”, Center for American Women and Politics, Eagleton Institute of Politics, Rutgers University, <http://www.cawp.rutgers.edu/education_training/trainingresources/index.php>.

The resources and examples referenced in this handbook are included owing to their value as effective good practices for the promotion of women's participation in political parties. As such, their inclusion in no way represents an endorsement of or agreement with the policy agendas or political platforms of the organizations, platforms and political parties that produced them.

Шигтгээ 5.2. Сонгуульд өрсөлдөх – эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил мэдлэг туршлагатай боловч сонгуульд өрсөлдөх талаар нухацтай бодох нь 50 хувь бага, нэр дэвших ба өндөр албан тушаалд өрсөлдөх магадлал бага байдаг.

Эх сурвалж: Jennifer L. Lawless, Richard L. Fox. It Takes a Candidate: Why Women Don't Run for Office. Cambridge University Press, 2005; Melinda Henneberger, "Why women don't run for political office" The Washington Post, 25 March 2012.

ажиллагаа юм.²²⁰ Тус төсөл 2012 он гэсний учир нь 2010 оны хүн амын тооллогын дараа конгресс болон мужийн хууль тогтоох байгууллагыг сонгох сонгуулийн тойргийн хилийг шинэчилсний улмаас олон суудал суларч байсантай холбоотой юм. “Үүнийг өөрт тань илгээсэн урилга гэж бод” гэдэг нэртэй видео клип бүхий сурталчилгааны ажил нь²²¹ 45 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдэд хандсан бөгөөд ялангуяа төлөөлөл муутай салбар болох улс төр, санхүү, байгаль орчин, шинжлэх ухаан, эрүүл мэнд, технологи, жижиг бизнесийн эмэгтэйчүүдэд хандсан. Тус төслөөс тийм насны эмэгтэйчүүдэд хандсаны учир нь яг энэ насандаа буй эмэгтэйчүүд тухайн мэргэжлийнхээ дээд түвшинд хүрсэн байдаг, мөн гэр бүлийн үүрэг хариуцлага багассан (хүүхдүүд нь насанд хүрсэн), санхүүгийн хувьд биеэ даасан байдагтай холбоотой юм. Нэр дэвшиж, дараагийн алхмыг хийх сонирхолтой эмэгтэйчүүдийг манлайллын хүрээлэн, think tank, сонгуулийн

сурталчилгааны хөтөлбөр, хөрөнгө босгох сүлжээтэй холбон, өөр өөрийн мужид ялалт байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна.

Харин “Өрсөлдөх эхлэл” нэртэй байгууллага арай залуу хүмүүст чиглэж ажилладаг бөгөөд АНУ-д эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх гол арга нь аль болох олон эмэгтэйг залуу наснаас нь улс төрд татан оролцуулж, сонгох явдал гэж үздэг.²²² “Залуу эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын хөтөлбөр”²²³ нь дунд сургуулийн ахлах ангийн охидод улс төрийн манлайллын ач холбогдлыг ойлгуулахыг зорьдог бөгөөд 5 өдрийн эрчимтэй семинар хийж, олон нийтэд үг хэлэх, сүлжээ үүсгэх, камерын өмнө буюу хэвлэл мэдээлэлтэй харьцах сургалт, сонгуулийн гол санаа буюу мессэж, мөрийн хөтөлбөр боловсруулах зэрэг сэдвийг заадаг. Энэ хөтөлбөрийн хүрээнд “Улс төрд орох зам”²²⁴ санаачилга нь жилийн турш залуу эмэгтэйчүүдийг хууль тогтоогчид, нэр дэвшигч, сурталчилгааны ажлын менежерүүдтэй үүлзүүлдэг байна. Тэд залуу эмэгтэйчүүдэд сонгуульд оролцохыг бодолцож үзэхийг хүсэхээс гадна хөрөнгө босгохоос эхлээд сонгогчидтой ажиллах, залуу эмэгтэй хууль тогтоогч гэж нэр хүндээ бүрдүүлэх зэрэг асуудлаар практик зөвлөгөө өгдөг.

Түүнчлэн “Өрсөлдөх эхлэл/Уолл Март од тэтгэлэг”²²⁵ хөтөлбөр нь жил бүр 14 хүртэл тооны коллежийн оюутан эмэгтэйг Вашингтонд авчран улс төрийг газар дээр нь сурч мэдэх боломж олгодог. Тус хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүд парламентын эмэгтэй гишүүн, сенаторын албанд нэг семестр дадлагажин ажиллаж, Баасан гариг бүрт улс төрийн ажлын дотоод асуудлыг мэдэж авах сургалтанд оролцдог. Тус хөтөлбөрийн дараа “Өрсөлдөх эхлэл дараагийн алах”²²⁶ санаачилга хэрэгжих бөгөөд энэ нь 23-27 насны, хоёроос дөрвөн жилийн ажлын туршлагатай, улс төрд орох сонирхолтой залуу эмэгтэйчүүдэд хандсан 5 хоногийн мэргэжлийн эрчимтэй хөтөлбөр юм. Семинарын үеэр улс төрийн мэргэжилтнүүд өөртөө итгэх итгэл бий болгох, эмэгтэй улс төрийн

220 See: <http://www.cawp.rutgers.edu/education_training/2012Project/index.php>.

221 See: <<http://www.youtube.com/watch?v=4Mn601QUwP0>>.

222 “Running Start. Bringing Young Women to Politics”, runningstart.org, <<http://www.runningstartonline.org>>.

223 “Young Women’s Political Leadership Program”, runningstart.org, <<http://www.runningstartonline.org/programs/young-womens-political-leadership>>.

224 “Path to Politics”, runningstart.org, <<http://www.runningstartonline.org/blog/path-to-politics-networking-lunch>>.

225 Running Start/Wal-Mart Star Fellowship”, runningstart.org, <<http://www.runningstartonline.org/programs/starfellowship>>.

226 “Next Step”, runningstart.org, <<http://www.runningstartonline.org/programs/next-step>>.

манлайлагчдын дараагийн үеийг дэмжихэд зориулан практик, бодит алхмуудыг агуулсан сургалт хийдэг байна.

АНУ-д явагддаг иргэний нийгмийн өөр хоёр санаачилга бол “Тэр өрсөлдөх ёстой”, “Түүнийг томил” нэртэй. Эмэгтэйчүүд нэр дэвших талаар бодох магадлал эрэгтэйчүүдээс доогуур байгаа статистикийн үзүүлэлтээс үүдэн (Шигтгээ 5.2),²²⁷ гарсан “Тэр өрсөлдөх ёстой” санаачилга бол онлайн нэр дэвшүүлэх арга хэрэгсэл бөгөөд сонгуульд нэр дэвших ёстой гэж үзэж буй эмэгтэйнхээ нэрийг оруулах боломжийг иргэдэд олгодог. Тус хөтөлбөрөөс ийнхүү нэр нь дурдагдсан эмэгтэйчүүдэд урам өгч, дараагийн алхмаа хийхэд шаардлагатай хүмүүстэй уулзуулж, хөрөнгө нөөц олгодог.²²⁸

Түүнчлэн “Түүнийг томил” төслийн хувьд АНУ-ын Эмэгтэйчүүдийн сонгуулийн сурталчилгааны сангаас зохион байгуулдаг бөгөөд сонгуульд өрсөлдөх гэж буй эмэгтэйчүүдэд ямар албан тушаал сул байгааг мэдэгдэн, одоо сонгуульд алба хашиж буй эмэгтэйчүүдийн үр чадвар, шинж чанартай танилцах, тэд яаж өөрсдийн карьерыг эхлүүлсэн талаар хэлэлцэх боломж олгодог.²²⁹

Түүнчлэн Ирландын “Эмэгтэйчүүд сонгуульд” санаачилга нь эмэгтэйчүүдэд улс төрд амжилт гаргах урам өгөх, зохих бэлтгэлийг хангуулах зорилготой байгуулагдсан. Тус санаачилгын танилцуулгад ил захидал орсон бөгөөд иргэд түүнийг сонгуульд өрсөлдөх ёстой гэж бодсон эмэгтэйчүүддээ илгээдэг байна (“Та надад итгэл, урам өгсөн, Та сонгогчдод ч итгэл, урам өгнө гэдгийг би мэдэж байна” гэсэн бичигтэй). Энэхүү “Тасалбар авах” санаачилга нь орон нутаг, үндэсний түвшинд өрсөлдөх эмэгтэйчүүдийг тоог олшруулах зорилготой.²³⁰

Зураг 5.3. Тасалбар авах санаачилга: Ирланд



227 See Jennifer L. Lawless and Richard L. Fox, *It Takes a Candidate: Why Women Don't Run for Office* (Cambridge: Cambridge University Press, 2005); Melinda Henneberger, “Why women don't run for political office”, *The Washington Post*, 25 March 2012, <http://www.washingtonpost.com/blogs/she-the-people/post/why-womendon't-run-for-political-office/2012/03/25/gIQAXLttZS_blog.html>.

228 “She should run”, *sheshouldrun.org*, 2011, <<http://www.sheshouldrun.org/>>; the nomination form can be found at: <http://support.wcfonline.org/site/Survey?ACTION_REQUIRED=URI_ACTION_USER_REQUESTS&SURVEY_ID=1420>.

229 “Women's Campaign Fund”, 2011, *wcfonline.org*, <<http://www.wcfonline.org/>>.

230 See “Women for Election”, *womenforelection.ie*, <<http://www.womenforelection.ie/>>.

Шигтгээ 5.4. Улс төрд элсүүлэх – Зорилтот бүлэг нь хэн бэ?

Эмэгтэй улс төрч элсүүлэх, дэмжих санаачилгыг хэрэгжүүлэхдээ иргэний нийгмийн байгууллага нь ямар эмэгтэйчүүдийг зорилтот бүлэг гэж үзэж байгаагаа тодорхойлох хэрэгтэй. Дараах шалгуур байж болно. Үүнд:

- Насны бүлэг
- Мэргэжил
- Эдийн засгийн байдал
- Боловсрол
- Яс үндэс
- Байршил (бүс нутаг эсвэл үндэсний санаачилга)
- Гэр бүлийн байдал
- Улс төрийн сонирхлын бүлэг

Өмнөх жишээнд дурдсанчлан, тодорхой нас, мэргэжлийн эмэгтэйчүүдэд зориуд хандах нь янз бүрийн намтар, туршлагатай эмэгтэйчүүдийг хамруулж элсүүлэх нэг үр дүнтэй арга байж болно. Үүний зэрэгцээ улс төрийн карьерынхаа янз бүрийн шатанд буй эмэгтэйчүүдэд ямар бэрхшээл тулгардагийг судалж, түүнийг сурталчилгааныхаа ажилд харгалзан үзэж байх нь чухал. Эмэгтэйчүүдэд ерөнхийд нь хандах бус тодорхой бүлэгт чиглэх, мөн хөрөнгө нөөц, үр чадвар, ойлголт мэдлэг дутагдах зэрэг эмэгтэйчүүдэд тулгардаг тодорхой асуудал хөндвөл гишүүн амжилттай элсүүлэх магадлал нэмэгдэнэ. Улс төрд эмэгтэйчүүд элсүүлэхдээ аль бүлэгт чиглэх вэ гэдгийг тодорхойлохдоо ИНБ нь тухайн зорилтот бүлгийнхээ эдийн засгийн байдал, гарал үүсэл, нас, мэргэжил зэрэг

нийгмийн үзүүлэлтийг судалж, өмнө элсээгүй хэсгийг нөхөхийг зорьж болно. (Шигтгээ 5.4).

→ Чадавх бэхжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх

ЕАБХАБ-ын бүс нутагт ИНБ-уудаас эмэгтэйчүүдийг улс төрд бэлтгэх, улс төрийн карьераа ахиулахад нь чадавхи бэхжүүлэх санаачилгаар дамжуулан дэмжлэг үзүүлж байна. ЕАБХАБ/АИХЭА-ны судалгаанд хамрагдсан 5 орон тус бүр²³¹ жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх сургалтын хөтөлбөртэй байв.

Казахстанд Бизнес эмэгтэйчүүдийн холбоо улс төрийн манлайлын сургалт тогтмол зохион байгуулдаг²³² бол Парламентын хөгжлийн сан эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн талаар тусгай хичээл заадаг²³³ Молдав эмэгтэйчүүдийн клуб 50/50 мөн л сургалт явуулж, эмэгтэйчүүдийг улс төрд орох, сонгуульд өрсөлдөх урам зориг өгдөг.²³⁴ Словений иргэний нийгмийн байгууллага болон Жендэрийн асуудлаарх Төв, Зүүн Европын сүлжээ нь²³⁵ Норвегийн Хөдөлмөрийн намын боловсруулсан “Эмэгтэйчүүд чадна” сургалтын хөтөлбөрийг суурь болгон авч, Зүүн, Төв Европын хэд хэдэн оронд тогтмол сургалт хийж байна. Ирландад Эмэгтэйчүүд сонгуульд нэртэй иргэний нийгмийн байгууллага INSPIRE гэдэг хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг. Энэ нь улс төрд орохыг хүсч буй эмэгтэйчүүдэд өөртөө итгэх итгэл, үр чадвар бүрдүүлэх төлбөртэй сургалт юм.²³⁶

Чадавх бэхжүүлэх хөтөлбөр бүгд зөвхөн эмэгтэйчүүдэд зориулагдсан биш юм.

231 The relevant partner organizations in each country are as follows: Women in Development/Millennium Women Network (www.albania-mwn.org) (Albania); Women's Information Center (www.wicge.org) (Georgia); Feminist League (www.empowering-women.kz) (Kazakhstan); Alliance of Women Legislative Initiatives (AWLI) / Social Technologies Agency STA (<http://www.awli-kg.org>) (Kyrgyzstan); Partnership for Development Centre PROGEN (www.progen.md) (Moldova).

232 “Женское политическое лидерство”, Ассоциация деловых женщин Казахстана, (“Women's political leadership”, Association of Business Women of Kazakhstan), [businesswomen.kz](http://www.businesswomen.kz), 2007 – 2012, <http://www.businesswomen.kz/zhenskoe_poiticheskoe_liderstvo/>.

233 “Фонд развития парламентаризма в Казахстане” начал проект “Женские политические права”, forum.gender.ru, 11 December 2011, <<http://www.forum.gender.ru/node/7175>>.

234 Sonja Lokar, “The Shift in International Actors” Approach to the Situation of Women in Conflict and Post-conflict Regions 1999–2008: The Cece of the Balkans” in Erhard Busek / Björn Kühne (eds.), “From Stabilisation to Integration. The Stability Pact for South Eastern Europe”. Vol. 1, pp. 65–74.

235 European Forum for Democracy and Solidarity, <<http://www.europenforum.net/gendernetwork>>.

236 See “Women for Election”, <<http://www.womenforelection.ie/>>.

Шигтгээ 5.5. Эмэгтэй сонгогчдын лигийн гаргасан Face to Face удирдамж

Face to Face удирдамжийг Эмэгтэй сонгогчдын лигээс албан тушаалтан, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн зүгээс нэр дэвшигчийн мэтгэлцээнийг үр дүнтэй, шударга, сонирхолтой зохион байгуулахад туслах зорилгоор боловсруулжээ. Түүнд эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан зөвлөгөө орсон бөгөөд түүнийг эмэгтэй нэр дэвшигчидтэй мэтгэлцээн зохион байгуулахыг хүсч буй иргэний нийгмийн байгууллагууд ашиглах боломжтой юм.

Эх сурвалж: Face to Face. The League of Women Voters' Guide to Candidate Debates, 2007, <<http://www.lwv.org/files/Face%20to%20Face.pdf>>.

Киргизстаны Төв Азийн Америк их сургуулийн улс төрийн менежментийн сургууль нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алийг нь хөтөлбөртөө оролцуулдаг. Түүнчлэн Молдавын Оролцоот ардчиллын холбоо (ADEPT)²³⁷ Улс төрийн залуу манлайлагчдын сургалтыг тогтмол зохион байгуулдаг.²³⁸ Тус холбоо нь бүхий л улс төрийн намын залуучуудын байгууллагын төлөөлөгчидтэй ажиллаж, тэдэнд сонгуульд өрсөлдөх урам сэдэл өгч, улс орондоо ардчилсан үнэт зүйл, улс төрийн олон ургальч үзлийг хөгжүүлэхийг эрмэлздэг. Эдгээр хөтөлбөр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хамтдаа суралцаж, улс төрийн манлайллын үр чадвараа хөгжүүлэх боломж олгож байгаа ч зөвхөн эмэгтэйчүүдэд хандсан арга хэмжээ нь ялангуяа эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал улс орнуудад эмэгтэйчүүдэд тулгарч буй улс төрийн чадавхийн онцлог бэрхшээлийг даван туулахад чухал юм.

Нэлээд хэдэн жилийн турш Германы улс төрийн намтай холбоотой ажилладаг хэд хэдэн иргэний нийгмийн бүлэг эмэгтэйчүүд болон олон нийтэд чиглэсэн сургалт, ойлголт, мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагаа хийж ирсэн. Үүнд нэр хүнд бүхий эмэгтэй улс төрчидтэй уулзаж ярилцах, судалгааны ажлын талаар танилцуулга хийх, үр чадвар хөгжүүлэх семинар хийх гэх мэт ажил багтдаг. Тухайлбал, Фридрих Эбертийн сан²³⁹ “Тэгш цалин хөлсний өдөр” гэдэг арга хэмжээ зохион байгуулж, социал-демакрат удирдлаган дор эмэгтэйчүүд ямар дэвшил гаргаж байгаа талаар лекц унших зэрэг ажил хийдэг.²⁴⁰ Ханс Зайдэл сангаас²⁴¹ “Хүчтэй эмэгтэйчүүд, хүчтэй үгс”²⁴² нэртэй цуврал лекцийг “Улс төр ба боловсрол” хөтөлбөрийнхөө хүрээнд зохион байгуулсан. Түүнчлэн Фридрих Науманы сангаас Олон улсын манлайллын академи, улс төр сонирхдог залуу эмэгтэйчүүдэд зориулан цахим Академи ажиллуулдаг.²⁴³ Эдгээр үйл ажиллагаа нь эдгээр байгууллагаас эмэгтэйчүүдийн улс төрд орох, ахих чадавх бэхжүүлэх урт хугацааны хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд өөр өөр газар нутгийн эмэгтэйчүүдийн хооронд хэлхээ холбоо үүсгэхэд чухал ач холбогдолтой байв.

Сургалтын хөтөлбөр бол АНУ-д ч сайн хөгжсөн үйл ажиллагаа юм. “Emerge America” гэдэг санаачилга бол сонгуульд өрсөдөхийг хүсч буй эмэгтэйчүүдэд зориулан 9 мужид зохион байгуулагдаж буй 7 сарын сургалтын хөтөлбөр юм.²⁴⁴ Түүнчлэн “Цагаан ордон төсөл” 2-3 цагийн онлайн харилцаа, биеэр ирж суух сургалт, бүтэн өдрийн бага хурал, 3 өдрийн дээд хэмжээний чуулган зэрэг арга хэмжээнээс бүрдсэн интерактив манлайллын хөтөлбөрийг эмэгтэйчүүдэд зориулан явуулдаг.²⁴⁵ Бүгд найрамдах эмэгтэйчүүдийн үндэсний холбооноос хэрэгжүүлдэг “Эмэгтэйчүүд ялалт” хөтөлбөр

237 Association for Participatory Democracy (ADEPT), <<http://www.e-democracy.md/en/>>.

238 “Leadership School for Young Political Leaders”, Association for Participatory Democracy (ADEPT), 2009–2010, <<http://www.e-democracy.md/en/leadership/politic/>>.

239 Friedrich-Ebert-Stiftung, <<http://www.fes.de/>>.

240 The 2013 event, held on March is entitled: “From Bluestocking to Minister”, <http://www.fes.de/sets/s_ver.htm>.

241 Hanns-Seidel-Stiftung, <<http://www.hss.de>>.

242 “Starke Frauen Starke Worte. Im Gespräch mit Charlotte Knobloch”, 2012, <<http://www.hss.de/politik-bildung/themen/themen-2012/starke-frauen-starke-worte-im-gespraech-mit-charlotte-knobloch.html>>.

243 Friederich-Naumann-Stiftung, <<http://www.freiheit.org/>>.

244 Emerge America: Women leaders for a democratic future, 2011, <<http://www.emergeamerica.org/home>>.

245 The White House Project, 2012, <<http://thewhitehouseproject.org/>>.

сонгуульд өрсөлдөх эмэгтэйчүүдэд зориулсан сонгуулийн сурталчилгааны ажлын талаарх сургалт явуулдаг.²⁴⁶

Түүнчлэн АНУ-д төвтэй Эмэгтэй сонгогчдын лиг²⁴⁷ эмэгтэйчүүдийг байгууллагадаа өсөх боломж, бусдад мэдэгдэж танигдахад чиглэсэн сургалтын хөтөлбөр, нэр дэвшигчийн мэтгэлцээн, форум зэргийг тогтмол зохион байгуулдаг.²⁴⁸ Мөн сонгуульд өрсөлдөх эмэгтэйчүүдэд зориулан материал бэлтгэж гаргадаг. Тухайлбал, *Face to Face* гэдэг заавар нь эмэгтэйчүүдэд сонгуулийн мэтгэлцээнд оролцоход тус болох удирдамж өгсөн байна (Шигтгээ 5.5).

Үндэсний түвшинд ИНБ-уудын гаргаж буй хүчин чармайлтад олон улсын засгийн газрын болон засгийн газрын бус янз бүрийн байгууллага, түүний дотор улс төрийн тодорхой намтай болон бүх намтай адил холбоотой ажилладаг байгууллагууд дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, 4 дүгээр бүлэгт дурдсанчлан, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Ардчиллын үндэсний хүрээлэн, Германы улс төрийн намуудын хэд хэдэн сан, Ардчиллын Вестминстер сан, Нидерландын Олон намын ардчиллын хүрээлэн зэрэг нь бүгд л ЕАБХАБ-ын улс орнуудтай хамтран ажиллаж, улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдэд зориулан чадавх бэхжүүлэх ажил хийж байдаг.

Түүнчлэн НҮБ-ын байгууллагууд, ЕАБХАБ-ын тухайн улс оронд буй салбарын үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийг улс төрд элсүүлэхэд нь улс төрийн намуудад дэмжлэг үзүүлдэг. Үндэсний иргэний нийгмийн байгууллагууд нь эмэгтэй улс төрчдөд зориулсан хөтөлбөр боловсруулахдаа олон улсын сангуудаас явуулж буй сургалтанд сууж, чадавхи бэхжүүлэх практикийг ажиглан, олон улсын засгийн газрын болон ТББ-тай хамтран ажиллах боломжийг эрэлхийлж болох юм.

Шигтгээ 5.4-т дурдсан шалгуурыг эмэгтэйчүүдийн улс төрийн чадавх бэхжүүлэх зорилтот бүлгээ сонгоход мөн ашиглаж болно. Янз бүрийн газар нутгаас ирсэн, өөр өөр туршлага мэдлэгтэй эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлэг харилцан адилгүй байх тул зорилтот бүлгээ сайн сонгосноор ИНБ-ууд чадавх бэхжүүлэх хөтөлбөрөө түүнд тааруулан нийцүүлэх боломжтой болно.

→ Эмэгтэй улс төрчдөд зориулсан дагуулан сургах хөтөлбөрийг санаачилж дэмжих

Улс төрийн намууд албан ба албан бус дагуулан сургах хөтөлбөр бий болгож чадах бол иргэний нийгмийн байгууллагууд ч үндэсний болон олон улсын түвшинд улс төрд орох, карьераа ахиулах сонирхолтой эмэгтэйчүүдэд зориулсан дагуулан сургах хөтөлбөрийг санаачилж иржээ. Бизнесийн салбарт түгээмэл байдаг ч улс төрд энэхүү дагуулан сургах хөтөлбөр нь харьцангуй шинэ зүйл бөгөөд бизнесийн сүлжээ, чадавх бэхжүүлэх хөтөлбөрөөс урган гарчээ.

Данийн ТББ Kvinfo (Жендэр, тэгш байдал, яс үндэс)²⁴⁹ Данийн эмэгтэй улс төрчдөд зориулсан дагуулах сургах санаачилгыг эхлүүлсэн бөгөөд хотын удирдлагатай хамтран хэрэгжүүлдэг. Мөн Данийн нам, ардчиллын хүрээлэнтэй хамтран бусад орны эмэгтэй улс төрчидтэй тус дагуулан сургах аргачлалаа хуваалцдаг.²⁵⁰ Эдгээр амжилттай санаачилгад тулгуурлан Европын эмэгтэйчүүдийн лобби байгууллага

246 The National Federation for Republican Women, <<http://www.nfrw.org/>>.

247 League of Women Voters, <<http://www.lwv.org/>>.

248 “FAQ’s Candidate Forums-Debates”, League of Women Voters, <<http://www.lwv.org/content/faqs-candidateforums-debates>>.

249 See: <<http://www.kvinfo.dk/side/661/>>.

250 See, for example, the Danish Institute for Parties and Democracy, “DIPD and KVINFO team up on mentoring for women in political parties in Bhutan, Malawi and Tanzania”, <<http://dipd.dk/2013/02/dipd-and-kvinfo-team-upon-mentoring-for-women-in-political-parties-in-bhutan-malawi-and-tanzania/>>.

Европын улс төрийн дагуулан сургах сүлжээг²⁵¹ 2013 онд өөрийн 50/50 кампанит ажлын хүрээнд байгуулсан. Европын түвшний анхны ийм төрлийн хөтөлбөр болох тул Европын парламентын янз бүрийн улс төрийн намыг төлөөлж буй 11 гишүүн дагуулан сургагчаар ажиллахыг зөвшөөрсөн бөгөөд тэд Бельги, Дани, Франц, Герман, Унгар, Нидерланд, Швед, Их Британий үндэсний цөөнхөөс гаралтай улс төрийн идэвхтэй эмэгтэйчүүдтэй ажиллахаар болсон. Тус хөтөлбөрийн хүрээнд оролцогч хоёр тал байнга уулзаж, чадавхи бэхжүүлэх 3 ажиллагаанд оролцоно. Мөн дагуулан сургагчийнхаа Брюссел дэх Европын парламентын чуулган, Страсбург дахь нэгдсэн чуулганд сүүдрийн гишүүнээр ажиллах боломж олгоно.

→ Эмэгтэйчүүд улс төрийн хөрөнгө нөөцөөс хүртэхэд дэмжлэг үзүүлэх

Эмэгтэйчүүдэд улс төрийн карьераа ахиулах, сонгуульд өрсөлдөх хөрөнгө нөөц олгох нь амжилт гаргах эсэхэд ихээхэн нөлөөлдөг. Иргэний нийгмийн улам олон байгууллага эмэгтэй нэр дэвшигчдэд урам өгөх, тэдэнд сонгуулийн сурталчилгаагаа хийх шаардлагатай хөрөнгө нөөц олгох үүднээс хөрөнгө босгох ажил хийх болсон. Санхүүгийн хувьд саадгүй болох нь сурталчилгааны ажилд их мөнгө шаарддагдгаг төрөөс нэр дэвшигч, улс төрийн намуудад санхүүжилт олгодоггүй улс орнуудад нэн чухал юм.

Сонгуульд өрсөлдөж буй эмэгтэйчүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэгээрээ нэртэй иргэний нийгмийн байгууллага гэвэл АНУ-д төвтэй EMILY's List бөгөөд энэ нь эмэгтэй нэр дэвшигчдийг элсүүлж, сургалтанд хамруулан, улс орон даяаг тэдний дэмжигчдээс хандив цуглуулж, нэр дэвшигчийн нэрийг сурталчилдаг бүлэг юм (Шигтгээ 5.6).²⁵² Тус байгууллага 1985 онд байгуулагдсанаасаа хойш Төлөөлөгчдийн танхимд 100 гаруй, Сенатад 19 эмэгтэй сонгогдоход, мөн 10 эмэгтэй мужийн захирагчаар, 500 эмэгтэй мужийн болон орон нутгийн түвшинд сонгогдоход тусалжээ.²⁵³ Энэ загвараар ЕАБХАБ-ын бусад улс орон, түүний дотор Их Британи, Итали, мөн түнш орон болох Австралид хөрөнгө босгох ийм байгууллага байгуулагдсан.²⁵⁴

EMILY's жагсаалт байгууллага нь АНУ-ын Ардчилсан намаас үр хөндүүлэх эрхийн төлөө үзэл санаатай эмэгтэйчүүд сонгогдоход дэмжлэг үзүүлдэг бөгөөд уг санаачилга амжилттай байсан нь үр хөндүүлэхийн эсрэг байр суурьтай эмэгтэй улс төрчдөд зориулан хөрөнгө босгох бүлгүүд үүсэхэд нөлөөлсөн. "Susan B. Anthony List" 1993 онд дээрх EMILY's жагсаалт байгууллагын хамтрагч болон байгуулагдсан бөгөөд үр хөндөлтийг зогсоохын төлөө байдаг эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, сургалтанд

Шигтгээ 5.6. Эмилигийн жагсаалт хэрхэн ажилладаг вэ?

Эмилигийн жагсаалт нь эмэгтэй нэр дэвшигчдийг илрүүлж, тэднийг дараахь 4 алхмаар дамжуулан дэмжигчидтэй нь холбож өгдөг. Үүнд:

1. Нэр дэвшүүлэх маш нарийн үйл явцыг ашиглан Эмилигийн жагсаалт нь Төлөөлөгчийн танхим болон Сенатад, мөн мужийн захирагчийн албан тушаалд өрсөлдөх Ардчилсан намын эмэгтэй нэр дэвшигчийг тодруулдаг.
2. Эмилигийн жагсаалт нь эдгээр эмэгтэйг улс орон даяаг тархсан сая гаруй гишүүддээ зөвлөмж болгон, эдгээр эмэгтэйн сонгуулийн сурталчилгаанд хандив өгөхийг хүсдэг.
3. Эмилигийн жагсаалтын гишүүд нь тухайн нэр дэвшигч бүрийн байр суурь, намтар, сурталчилгааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, хэнийг дэмжихээ шийддэг.
4. Гишүүдийн өгсөн хандив 100 хувь шууд сурталчилгааны ажилд зарцуулагдан, улс төрийн нөлөө үзүүлж, Эмилигийн жагсаалтын нэр дэвшигчдэд томоохон мөнгөн дэмжлэг болж өгдөг.

Эх сурвалж: EMILY's List, <<http://www.emilyslist.org/>>

251 See European Women's Lobby, <<http://www.womenlobby.org/spip.php?article4862>>.

252 EMILY's List, <<http://www.emilyslist.org>>.

253 Testimonies from some of these women are available at: <http://emilyslist.org/who/we_are_emily/>.

254 See: <<http://www.emilyslist.org.au/>>.

хамруулах, дэмжихэд анхаарч, мөн үр хөндөлтийг зогсоох бодлогыг баримталж ирсэн.²⁵⁵ 1992 онд байгуулагдсан “WISH List” (эмэгтэйчүүд Сенат ба Төлөөлөгчийн танхимд) нэртэй байгууллага нь орон нутаг, муж, үндэсний түвшинд өрсөлдөж буй Бүгд найрамдах намын эмэгтэйчүүдэд стратеги зөвлөгөө өгч, сургалтанд хамруулан, санхүүгийн дэмжлэг өгөх зорилготой.²⁵⁶

Ерөнхийдөө, хөрөнгө амжилттай босгоё гэвэл сонгуулийн сурталчилгааны санхүүжилт бол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх нэг арга гэдгийг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль алинд нь ойлгуулж, мэдлэг олгох явдал чухал юм. Эмэгтэйчүүдэд зориулан хөрөнгө босгох тодорхой аргын талаар 4 дүгээр бүлэгт, харин улс төрийн намуудаас хөрөнгө нөөцийг тэгш хуваарилах талаар ямар санаачилга гаргаж болох талаар 3 дугаар бүлэгт дурдсан билээ.

→ **Нэгдмэл байр суурьтай асуудлаар иргэний нийгмийн бүлгүүдийн дунд эв санааны нэгдэл бий болгох**

ИНБ-ууд нийгэм дотор өөр өөр бүлгийн сонирхлыг илэрхийлж, засгийн газрын эсвэл бусад санхүүжилтийн төлөө өөр хоорондоо өрсөлдөх явдал байдаг ч тухайн аль нэг асуудлаар байнгын эсвэл түр хугацааны эвсэл байгуулах нь улс төрд жөндөрийн тэгш байдлыг хангахад ихээхэн үр дүнтэй арга юм. Энэ арга ЕАБХАБ-ын бүс нутаг даяар үр дүнтэй байсан. Тухайлбал, Киргизстанд 2005 оны сонгуулийн дараа нэг ч эмэгтэй хүн сонгогдож чадалгүй үлдсэний дараа үндэсний ТББ-уудын эвсэл парламент дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх томоохон зорилт бүхий Хамтын үйл ажиллагааны хөтөлбөр гаргасан. Энэ тохиолдолд хууль тогтоох байгууллагад нэг ч эмэгтэй байгаагүй нь Киргизийн эмэгтэйчүүдийн ТББ-ын хувьд яаралтай шийдэх асуудал болж, хамтын ажиллагааны нөхцөл бүрдсэн. Хамтарсан, харилцан уялдаатай ажиллагаа явуулсны үндсэн дээр ТББ-уудын эсвэл 5 хүрэхгүй жилийн дотор парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг 27 хувьд хүргэж чадсан. (Шигтгээ 5.7).

Шигтгээ 5.7. Парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 3 жилийн дотор 0-27 хувь болов

Киргизэд 2005 оны сонгуулиар парламентад нэг ч эмэгтэй сонгогдсонгүй. Ийм юм болно гэдгийг улс төрийн эмэгтэй идэвхтнүүд, жөндөрийн асуудлаар ажилладаг ТББ-ууд хэлж байсан бөгөөд тэд сонгуулийн өмнө сонгуулийн хуулийг өөрчилж, эмэгтэйчүүд нэр дэвшихийг дэмжих талаар уриалж байв. 2005 онд Киргизийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн 2010 он хүртэл хэрэгжүүлэх Хамтын ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд түүний нэг тэргүүлэх чиглэл нь хуулиар жөндөрийн квот тогтоох нөлөөллийн ажил хийх явдал байв. Гэвч иргэний нийгмийн байгууллагаас гаргасан хуульд орох өөрчлөлтийн саналыг парламентын олон гишүүн шүүмжилсэн: тэд ийм өөрчлөлт орвол өөрсдийнх нь суудал эрсдэлд орно гэдгийг мэдэж байсан тул уг асуудлыг

дараагийн парламент хүртэл хойшлуулах хүсэлтэй байв.

Түүний хариуд эмэгтэйчүүдийн байгууллагууд үйл ажиллагаагаа өргөжүүлж, тус асуудлыг сурталчлах шинэлэг аргыг хэрэглэхээр шийдэв. Нийгмийн технологийн агентлаг ТББ, эмэгтэйчүүдийн үндэсний сүлжээ “Эмэгтэйчүүд чадна”, мөн ЕАБХАБ/АИХЭА-ны дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээллийн томоохон стратеги боловсруулав. Уг стратеги нь хоёр тэргүүлэх чиглэлтэй байв: эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжихэд эмэгтэйчүүдийн бүлгийн дунд эв санааны нэгдэл бий болгох, мөн нийгэмд эмэгтэйчүүдийн оруулж буй чухал хувь нэмэр, тэдний манлайлах бололцоог сурталчлах.

Ингээд 2006-2007 онд ЕАБХАБ/АИХЭА-ны

255 The Susan B. Anthony List, <<http://www.sba-list.org/>>.

256 The WISH List, <<http://www.thewishlist.org/>>.

дэмжлэгтэй хэвлэлийн аяны хүрээнд дараах ажлыг хийжээ. Үүнд:

- “Өөр 3 дугаар сарын 8” хэмээх бэлэгдлийн арга хэмжээ явуулж, жендэрийн тэгш байдалд тулгарч буй бэрхшээлийг харуулж, эдийн засаг, нийгэм, улс төрийн тэгш байдлын төлөө тэмцэх Олон улсын эв санааны өдөр болгох.
- Парламентын үүдэн дээр “олон эхнэртэй байхыг төгсгөл болго! Киргизийг шашны нөлөөнөөс салга!” гэх мэт бичиг барьж жагссан.
- “Янз бүрийн ээжүүд хэрэгтэй, улс төрд ч чухал” гэсэн сэдэвтэй бэлэгдлийн ажиллагааг Олон улсын хүүхдийн баяр 6 дугаар сарын 1-нд зохион байгуулсан.
- Парламентын ойролцоо жижиг хэвлэлийн бага хурлууд зохион байгуулж, сонгуулийн хуульд түр тусгай арга хэмжээ оруулах шаардлагатай байгааг цохон тэмдэглэсэн.
- Орон даяар сонгогчдын дунд гарын үсэг цуглуулж, парламентын гишүүдэд факс хүргүүлэх, сонгуулийн хуульд түр тусгай арга хэмжээ тусгах нөлөөллийн ажил хийсэн. Дарамт шахалт хүчтэй байсан тул парламентын зарим гишүүн жендэрийн квотыг нийтийн нүдэн дээр дэмжиж эхэлсэн.
- Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах талаар парламентын сонсгол. Түүнд 18 гишүүнээс 16 нь оролцож, квот оруулахыг дэмжсэн.
- ТББ-уудын үндэсний Форум 2007-оос алаг тахь буюу “Зебра” хэмээх ажиллагаа явуулж, намын жагсаалтанд тэнцвэртэй байх зарчмыг оруулахад анхаарал хандуулсан. “Эмэгтэйчүүд + эрэгтэйчүүд = хүчтэй парламент” гэсэн

Эх сурвалж: энэхүү гарын авлагад зориулан Киргизстаны Нийгмийн технологийн агентлагийн Зулфия Качорбаева боловсруулав.

- уриатай эв санааны нэгдэлтэй байгаагаар илэрхийлэхийн тулд оролцогчид хар, цагаан өнгийн судалтай алчуур, ороолт зүүж, намын жагсаалтанд эрэгтэй, эмэгтэй дараалах зарчмыг илэрхийлсэн.
- ТББ-ын удирдах зөвлөлөөс Киргизийн Ерөнхийлөгчтэй хийсэн уулзалтын үеэр сонгуулийн хуульд жендэрийн квот оруулах зайлшгүй шаардлагатайг цохон тэмдэглэсэн.

Эдгээр санаачилгын үр дүнд тус хөдөлгөөн Ерөнхийлөгчийн анхааралд өртөж, сонгуулийн хуулинд уг өөрчлөлтийн заримыг тусгасан. 2007 оны 10 сарын 21-нд бүх нийтийн санал асуулга болж, сонгуулийн хууль, үндсэн хуулийн өөрчлөлтийн аль алийг нь баталсан. Шинэ үндсэн хуульд парламентын сонгууль пропорционал тогтолцоогоор явагдана гэж заасан. Мөн сонгуулийн хуулийн 72 дугаар зүйлд жендэрийн давхар квот (зөвхөн тоон квот төдийгүй жагсаалт дах байрлалыг зааж өгсөн) оруулахын хамт үндэсний цөөнх, залуучуудын квот мөн оруулсан.

2007 оны 12 дугаар сард парламентын сонгууль шинэ хуулиар явагдсан. Зөвхөн хуулиар тавьсан шаардлагыг хангасан намууд л сонгуульд оролцсон бөгөөд 12 намаас парламентад зөвхөн 3 нам суудал авч чадсанаас 24 эмэгтэй (27 хувь) сонгогдсон. Тус улсын түүхэнд анх удаа парламентын дэд даргын албан тушаалыг эмэгтэй хүн хашиж, 5 байнгын хороог эмэгтэй хүн тэргүүлсний дотор уламжлал ёсоор эрэгтэйүүд давамгайлдаг салбар болох батлан хамгаалах, аюулгүй байдал, хууль сахиулах, шүүх ба хууль эрх зүйн шинэчлэл, хөдөө аж ахуй, экологи, онцгой байдал зэрэг салбар багтаж байв.

→ Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар салбар дамнанас хамтын ажиллагааг санаачилж, дэмжих

ИНБ-ууд өөр хоорондоо түншилж ажиллахын зэрэгцээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, жендэрийн тэгш байдлын төлөө нийгэмд өргөн хүрээний дэмжлэг бий болгож чадна. ИНБ-ууд нийгмийн янз бүрийн хэсгийн хэрэгцээ шаардлагыг төлөөлж, уг хэрэгцээг хангах бодлого батлахыг сурталчилж, хэрэгжилтэнд нь хяналт тавьдаг үүргийнхээ улмаас иргэдийн итгэлийг хүлээж чадсан байдаг. Жендэрийн тэгш байдлыг дэмжихэд ашиглахгүй үлддэг нэг хэлбэр бол жендэрийн тэгш байдлын төлөө тэмцэгчдийг элсүүлэхийн тулд нийгмийн янз бүрийн салбарт хүрч ажиллах явдал юм.

Бизнес, урлаг, хэвлэл мэдээлэл, спорт, технологи, шинжлэх ухаан ба анагаах ухаан

зэрэг салбарт нэр хүнд бүхий албан тушаал хашдаг эмэгтэйчүүд үлгэрлэн дуурайх хүний үүрэг гүйцэтгэж, эмэгтэйчүүдийн чадавх, үр чадвар, боломжийг харуулж болно. Тийм эмэгтэйчүүдийг (мөн жендэрийн асуудлаар тэмцэгч эрэгтэйчүүд) нэгтгэн цуглуулах нь улс төрийн маш хүчтэй санаа буюу мессэж өгнө.

Тухайлбал, Польшийн эмэгтэйчүүдийн чуулган янз бүрийн салбар дахь эмэгтэйчүүдийн амжилтыг тэмдэглэх зорилгоор Польшийн нийгмийн өнцөг булан бүрээс эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг авчирсан.²⁵⁷ Чуулган тус бүр тодорхой уриа гаргаж, нийтийн албан тушаалтнуудад хандсан тодорхой уриалга гаргадаг тул нэг төрлийн улс төрийн талбар юм. Польшийн улс төрийн намын хэд хэдэн төлөөлөгч, парламентын гишүүд уг санаачилгыг дэмжин тус чуулганы уриалгад хариу өгсөн. Тус чуулган нь улс төрийн намуудад Польшийн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд эмэгтэйчүүдийн дэвшил, жендэрийн тэгш байдлыг хэрэгжүүлэхийг дэмжиж байгаагаа илэрхийлэх стратеги арга юм (Шигтгээ 5.8).

Шигтгээ 5.8. Польшийн Эмэгтэйчүүдийн чуулган

Анх 2009 онд байгуулагдсан Польшийн Эмэгтэйчүүдийн чуулган нь эмэгтэйчүүдийн сонирхол, жендэрийн тэгш байдлыг сурталчлах зорилгоор улс төр, боловсрол, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, иргэний нийгэм, урлаг, шинжлэх ухаан, үйлдвэрчний эвлэл зэрэг Польшийн нийгмийн бүхий ч хэсгээс эмэгтэйчүүдийг (мөн эрэгтэйчүүдийг) цуглуулдаг. 2009 онд тус чуулганаас “Эмэгтэйчүүд Польшийн төлөө, Польш эмэгтэйчүүдийнхээ төлөө” уриа гаргаж, 4,000 гаруй эмэгтэйг цуглуулсан. Оролцогчид нь нийт 135 гаруй шаардлага тавьснаас хамгийн чухал нь тэнцвэртэй байдлын талаар хууль батлах явдал байв. 2010 оны чуулган мөн л квот хэлбэрээр тусгай арга хэмжээ авахыг уриалсан бөгөөд түүнийг 2011 онд Польшийн парламент баталсан байна.

2011 онд Польшийн эмэгтэйчүүдийн чуулган Польш улс Европын холбоог даргалж байгаа боломжийг ашиглан Европын эмэгтэйчүүдийн чуулганыг нутагтаа хийсэн. Уг чуулганд Европ, Польшийн өнцөг булан бүрээс 6,000 гаруй мэргэжилтэн, жендэрийн төлөө тэмцэгч ирж оролцов. 2011 оны Европын эмэгтэйчүүдийн чуулган нь Польш, Европын эмэгтэйчүүдэд эн тэргүүнд тулгарч буй асуудлаар зэрэгцээ хүрлүүд хийсэн бөгөөд үүнд улс төр, бизнест эмэгтэйчүүдийн оролцоо, гэр бүлийн хүчирхийлэл, жендэрээс үүдэлтэй соёлын хэвшмэл ойлголт зэрэг сэдэв багтсан байна.

Тус чуулган нь 2011 оны парламентын сонгууль өрсөлдөж буй улс төрийн намуудад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн. 2011 оны сонгуулийн үеэр шинэчлэн баталсан Сонгуулийн хуулийг ашигласан бөгөөд (жендэрийн квот бүхий) эмэгтэй нэр дэвшигчийн тоо хоёр дахин нэмэгдэж 44 хувьд хүрсэн. Улс төрийн намууд ихэнх тохиолдолд хуульд заасан квотоос илүү олон эмэгтэйг нэр дэвшүүлсэн байна. Иргэний хөтөлбөр нам хамгийн олон эмэгтэй нэр дэвшигч (41 тойргоос 14-т нь) дэвшүүлжээ. Тус нам нь Польшийн Сеймд зургаан удаа суудал авахдаа сонгуулийн бүх тойргийн жагсаалтын эхний гуравт, хэдийгээр хуулиар тийм шаардлага тавигдаагүй ч, наад зах нь нэг эмэгтэй нэр дэвшигчийг байрлуулсан ганц нам юм. Түүнчлэн Польшийн бүс нутгуудад тухайн улс төрийн намд үзүүлэх дэмжлэг харилцан адилгүй байдаг тул Иргэний хөтөлбөр нам тойргийн 38 хувьд буюу “ялах магадлалтай” тойргууд дахь жагсаалтын эхэнд хамгийн олон эмэгтэйг байршуулсан байна.

Польшийн Эмэгтэйчүүдийн чуулганаас авах хоёр сайн жишээ бол: нэгдүгээрт, тухайн улсын зохион байгуулж буй улс төрийн эсвэл улс төрийн болон бусад (соёл, спорт гэх мэт) арга хэмжээг ашиглан эмэгтэйчүүдийн асуудал, жендэрийн тэгш байдлыг анхаарлын төвд оруулах; хоёрдугаарт, тухайн санаачилгаа аль нэг улс төрийн намтай холбох бус өргөн хүрээтэй нийгмийн хөдөлгөөн болгож өргөжүүлэх.

Эх сурвалж: Malgorzata Druciarek, Malgorzata Fuszara, Aleksandra Nizynska and Jaroslaw Zbieranek, Women on the Polish Political Scene (Warsaw: Institute of Public Affairs/ODIHR), 2012, p. 9.

2013 оны 6 дугаар сард Прагад Эмэгтэйчүүдийн чуулган болж, иргэний нийгэм, байгууллага, судалгааны газрууд, урлаг, хэвлэл мэдээлэл, төрийн болон хувийн хэвшлийн эмэгтэйчүүд, жендэрийн асуудлын төлөө тэмцэгчдийг цуглуулсан.²⁵⁸ “Эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээл” сэдэвт тус чуулганаас зөвлөмж гаргаж, 2013 оны 6 дугаар сарын 19 буюу Олон улсын тэгш байдлын өдөр Ерөнхий сайдад албан ёсоор хүргүүлсэн байна. Мөн тэр жил Унгарт ч Эмэгтэйчүүдийн чуулган болжээ. Тус чуулганд бэлтгэх ажлын хүрээнд Унгарын эмэгтэйчүүд янз бүрийн салбар дахь иргэний нийгэм, жендэрийн асуудлыг төлөө тэмцэгчидтэй зөвлөлдөх үүлзалт хийсэн байна. Эмэгтэйчүүдийн чуулган 2013 оны 11 дүгээр сард буюу 2014 оны парламентын сонгуулийн өмнөхөн болж байгаага ашиглан, тус улсын парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл маш доогуур буюу ЕАБХАБ-ын бүс нутгаас хамгийн доогуур буюу 8.8 хувьтай байгааг цохон тэмдэглэсэн байна.

→ Үндэсний болон орон нутгийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг дайчлах, хамтарч ажилах

Үндэсний түвшний эмэгтэйчүүдийн хөдөлгөөн бол ЕАБХАБ-ын улс орнуудын иргэний нийгмийн байгууллагуудын төгс түнш байх боломжтой. Заримдаа эмэгтэйчүүдийн хөдөлгөөн аль хэдийн ИНБ эсвэл эмэгтэйчүүдийн холбоо болж бүртгэгдсэн байдаг. Заримдаа эмэгтэй идэвхтнүүд, жендэрийн тэгш байдлын төлөө тэмцэгчдийн задгай хэлбэрийн ажиллагаа бөгөөд нэг бол иргэний нийгмийг төлөөлж, нэг бол улс төр, төрийн албаны төлөөллийг мөн багтаасан байдаг. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн бол ЕАБХАБ-ын тухайн орны онцлог нөхцөлөөс урган гарсан байдаг бөгөөд улс төрийн амьдралд янз бүрийн үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бүс нутгийн түвшинд нийтэд нь хамаатуулан тодорхойлох боломжгүй.

Жендэрийн улс төр ба төрийн талаар судалгааны сүлжээ (RNGS) эмэгтэйчүүдийн хөдөлгөөний талаар хэд хэдэн аж үйлдвэржсэн орныг хамруулан судалгаа хийснээс 13 нь ЕАБХАБ-ын улс орон байв (Австри, Бельги, Канад, Финлянд, Франц, Герман, Ирланд, Итали, Нидерланд, Испани, Швед, Их Британи, АНУ).²⁵⁹ Уг судалгаанд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг тодорхойлохдоо эмэгтэйчүүдийн төлөөллийг төр, нийгмийн талбарт нэмэгдүүлэх санаа зорилго бүхий хүмүүсийн хөдөлгөөн гэжээ. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нийгмийн ерөнхий хөдөлгөөнөөс ялгаатай нь эмэгтэйчүүд гэдэг бүлгийг зориуд ялган, эмэгтэйчүүдийг төр, нийгмийн амьдралд төлөөлөхийг эрмэлздэг.

Ийм учраас эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь эмэгтэйчүүдийг улс төрийн тоглогч гэдэг утгаар тодруулж, дэмжлэг үзүүлэхэд тохиромжтой холбоотон байх боломжтой. Үнэндээ улс төрийн хувьд идэвхтэй эмэгтэйчүүд ямар нэг байдлаар эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд оролцож байсан эсвэл уг хөдөлгөөний дэмжлэгтэйгээр амжилтанд хүрсэн байх тохиолдол олон бий. Тухайлбал, Баруун Балканд олон эмэгтэй улс төрч, парламентын гишүүд эмэгтэйчүүдийн хөдөлгөөний гишүүн хэвээр үлддэг. Баруун Балкан сүүлийн жилүүдэд ардчилалд шилжихэд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тийнхүү гүйцэтгэсээр байна.

Тус судалгаагаар 13 орны эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь жендэрийн тэгш байдалтай холбоотой төрийн бодлогод нөлөө үзүүлсэн гэсэн дүн гарчээ. Судлаачид тэдгээр чиглэлээр эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хийсэн тодорхой ажил, гаргасан бодлогын саналыг нягтлан үзэж, хэдэн арван жилийн туршид эдгээр саналын хариуд бодлогын хэлэлцүүлэг хэрхэн өрнөж ирснийг хөөн судалсан бөгөөд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн бодлогын хэлэлцүүлгийн хэв маяг, агуулгын аль алинд нөлөөлсөн гэж тэмдэглэжээ.²⁶⁰

258 See “Women’s Congress: About Women, Not Only For women”, kongreszen.cz, <<http://www.kongreszen.cz/o-kongresu/18>>.

259 Research Network on Gender Politics and the State (RNGS), <<http://libarts.wsu.edu/pppa/rngs/index.html>>.

260 Ibid.

Эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөлөлд бодлого боловсруулагчид, улс төрчид хэрхэн хандаж байгаа талаарх судалгаагаар Нордикийн орны бодлого боловсруулагчид эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд хамгийн нааштай хариу өгдөг болох нь харагджээ. Их Британид, Францад нэлээд эсэргүүцэлтэй тулгардаг бөгөөд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн удаан хугацаанд тасралтгүй ажилласны дараа амжилт аажим ирж байжээ. Судалганы дүнгээс үзэхэд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн төрийн бодлого, ялангуяа эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийн чиглэлээр үр дүн үзүүлж чаддаг байна. Энэхүү үр дүнг бодлого жендэрийн мэдрэмжтэй болсноос төдийгүй эмэгтэйчүүд, эмэгтэй идэвхтнүүд бодлого боловсруулахад бодитой оролцох талбар бий болсноос харж болно.²⁶¹

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй өгүүлэх нь энэхүү гарын авлагын зорилгоос хэтэрсэн зүйл болох билээ. Тиймээс аливаа улс орны эмэгтэйчүүдийн хөдөлгөөн бол эмэгтэйчүүдийн улс төрийн нам, улс төр дэх оролцоог дээшлүүлэхэд аливаа иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах нэг боломжит түнш, дэмжин туслагч гэж харах ёстой гэдгийг тэмдэглээд зогсьё.

5.1.2. Улс төрийн намуудтай ажиллах

ИНБ, улс төрийн намууд ерөнхийдөө өөр өөр хүрээнд ажилладаг, өөр зорилготой, ажлаа өөр өөр арга хэрэгслээр гүйцэтгэдэг. Улс төрийн намууд нь иргэний нийгмийн чадахгүй тийм хэлбэрээр төлөөлж, сонирхлыг нэгтгэж, хэлэлцээрт орж байдаг бөгөөд сонгогчдын төлөөлөл болохын хувьд тэрхүү сонирхлыг тодорхой сувгаар дамжуулж байдаг. Харин иргэний нийгэм улс төр, нийтийн салбарт “хоточ нохойн” чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч ардчилсан нийгэмд улс төрийн нам, иргэний нийгэмд оноосон үүрэг зарим байдлаар давхцаж байдаг. Ийм талбарын нэг нь улс төр юм.

ИНБ, бүлгүүд нь улс төрийн намын гүйцэтгэдэг үйл ажиллагаанд оролцох нь нэмэгдсэн, ялангуяа сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг илрүүлэх, бэлтгэх, улс төрийн асуудлаар ойлголт мэдлэг нэмэгдүүлэх ажил хийх, улс төр болон бодлогын шинэчлэлд оролцох зэргийг дурдаж болно. Үүний нэг жишээ нь хууль заасны дагуу ИНБ-уудыг парламентад төлөөлөхийн урьдаг, тэдгээр нь сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй байдаг ЕАБХАБ-ын улс орнууд юм. Тухайлбал, Гүржид хэдий парламент эцсийн шийдвэрийг гаргадаг ч иргэний нийгмийн эвсэл Улсын өмгөөлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.²⁶² 2012 онд ТББ-үүдын бүлэг нэр дэвшүүлж байсан, уг нэр дэвшигч томилогдож чадаагүй ч хэвлэл мэдээллийн анхааралд ихээхэн өртөж, түс улсад зохион байгуулалттай иргэний нийгмийн нөлөө хүчтэй байгааг харуулсан. ЕАБХАБ-ын зарим оронд иргэний нийгэм сонгогчдыг зохион байгуулах, улс төрийн намтай адил бодлогын тодорхой байр суурь баримтлах, бодлогын шийдэлд нөлөөлөх зэргээр улс төрийн ажиллагаа их явуулдаг. Нэг туйл гэвэл иргэний нийгмийн байгууллагууд улс төрийн намын үргэлжлэл болж, улс төрд хараат бус, хяналтын үүрэг гүйцэтгэхээ болих явдал юм.

Үнэндээ, улс төрийн олон нам иргэний нийгмийн байгууллагаас эхлэлтэй, улс төрийн аль нэг нам авч үзэхгүй байгаа нэг эсвэл хэд хэдэн тулгамдсан асуудлын эргэн тойронд нэгдсэн байдаг. Үүний нэг жишээ нь Оросын Иргэний хөтөлбөр нам юм. Энэ тохиолдолд ИБН-үүд иргэдэд улс төрд оролцох өөр хувилбар олгох зорилгоор улс төрд орсон бөгөөд тухайн үед оршиж тогтнож байсан улс төрийн намууд аль нь ч иргэд, тэдний асуудлыг бүрэн төлөөлж чадахгүй байна гэж үзсэн. Түүнчлэн олон улс төрч, нэр дэвшигч өмнө дурдсан эмэгтэйчүүдийн хөдөлгөөн гэх мэт зохион байгуулалттай иргэний нийгмийн гишүүн байсан хүмүүс байдаг. Ялангуяа иргэний нийгмийн

²⁶¹ Ibid.

²⁶² “Group of NGOs names preferred Public Defender”, Civil Georgia, 11 October 2012, <<http://www.civil.ge/eng/article.php?id=25342>>.

удирдагч, шинэчлэгчид сүүлдээ сонгуульд өрсөлдөх нь ардчилсан шинэчлэл хийж буй бүс нутагт их тохиолддог. Энэ нь улс төрийн намууд, иргэний нийгмийн хооронд хамтын ажиллагааны өргөн боломж байгааг харуулж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд аль алиных нь сургамж, туршлагаасаа олж авсан хэлхээ холбоо тус болох билээ.

Идэвхтэй иргэний нийгэм, үр дүнтэй улс төрийн намын аль аль нь эрүүл ардчилалд хэрэгтэй. Үр дүнтэй ажиллаж буй улс төрийн тогтолцоонд аль аль нь бие даан ажиллахын зэрэгцээ бүтээлч шүүмжлэлт харилцаатай байдаг. Энэ утгаараа иргэний нийгэм улс төрийн талбарыг жендэрт ээлтэй, эмэгтэй улс төрчдийг найрсаг хүлээж авдаг болоход нь улс төрийн намуудад тусалж чадна.

Тиймээс энэхүү хэсэгт иргэний нийгмийн байгууллагуудаас **улс төрийн намууд** үйл явц, практикаа эмэгтэй улс төрчдөд ээлтэй болгоход хэрхэн туслах талаар авч үзэв. Эхлээд иргэний нийгмийн байгууллагууд намын дотоод бодлого, журмыг жендэрт ээлтэй болгох талаар, дараа нь намууд жендэрийн тэгш байдлыг улс төрийн намын мөрийн хөтөлбөртөө хэрхэн нэгтгэн тусгах, улмаар сонгогчдыг татах талаар авч үзэв. Төгсгөлд нь, эдгээр байгууллагууд улс төрийн намууд жендэрийн тэгш байдлын талаарх өгсөн амлалтаа хэрхэн биелүүлж байгааг хянахад ашиглах аргаас дурдав.

→ Улс төрийн намууд жендэрийн аудит хийхэд туслах

Өмнө 3 дугаар бүлэгт дурдсанчлан, жендэрт ээлтэй бодлого, журам, практик нэвтрүүлэхийн тулд улс төрийн намууд эхлээд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж байж болзошгүй эх үүсвэрийг илрүүлэх шаардлагатай. Жендэрийн аудит бол ийм зорилгоор хийдэг өөрийн үнэлгээ юм. Улс төрийн намууд түүнийг дотоод эмэгтэйчүүдийн байгууллагын дэмжлэгтэйгээр өөрөө хийж болно эсвэл иргэний нийгмийн жендэрийн мэргэжилтнээр хийлгэж болно.

Жендэрийн аудит нь эхлээд тухайн байгууллага өөрчлөлт хийхэд бэлэн байгаа эсэхийг, дараа нь шууд ба шууд бус

Шигтгээ 5.9. Жендэрийн аудит: Алхам алхмаар явагдах үйл явц

- Байгууллагын бэлэн байдлыг үнэлнэ;
- Жендэрийн талаарх хандлагыг нь ойлгох үүднээс судалгаа авах;
- Жендэрийн асуудлыг нэгтгэн тусгах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах;
- Тус байгууллагад жендэрийн тэгш байдлыг бий болгохын төлөө хийж буй ажилд хяналт тавих.

Эх сурвалж: “Жендэрийн аудит: байгууллагын өөрийн үнэлгээ, өөрчлөлт хийх аргачлал”, InterAction, 2010, <<http://www.interaction.org/sites/default/files/Gender%20Audit%20Handbook%202010%20Copy.pdf>>.

Шигтгээ 5.10. BANDIAR төслөөс хийсэн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх SWOT шинжилгээ

BANDIAR-ын хийсэн SWOT шинжилгээнд улс төрийн намын жендэрийн аудитад холбогдолтой дараах асуулт оржээ.

Давуу тал

- Эмэгтэйчүүдийг улс төрд [улс төрийн намд] татан оролцуулах,
- Эмэгтэйчүүдийг [нам дотроо] таниулж дэмжихэд бид юуг амжилттай сайн хийсэн бэ, бидэнд түүнд зориулсан ямар хөрөнгө нөөц байгаа вэ?

Сул тал

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн [намд] хашиж буй албан тушаалд ямар нэг ялгаа байна уу?

Улс төрд [намд] эмэгтэйчүүдийг татан оролцуулж, таниулж харагдуулахад ямар хөрөнгө нөөц дутагдалтай байна вэ?

Боломж

- Эмэгтэйчүүдийг улс төрд [намд] татан оролцуулах,
- Эмэгтэйчүүдийг [нам дотроо] таниулж дэмжих ямар боломж бидэнд байна вэ?

Эрсдэл

Эмэгтэйчүүдийг улс төрд [намд] татан оролцуулах, [нам дотроо] таниулж дэмжихэд бидэнд ямар томоохон бэрхшээл, саад тулгарч байна вэ?

Эх сурвалж: BANDIAR төслөөс авав, <<http://www.balticfem.com/en/completedprojects/bandiar-2009>>.

Шигтгээ 5.11. ЕАБХАБ-ын бүсэд эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй манлайлагчдад явуулж буй сургалт

Эмэгтэйчүүд улс төрийн намд төслийн хүрээнд, ЕАБХАБ/АИХЭА-ны тухайн улс орнуудад байдаг салбар, мөн Ардчиллын үндэсний хүрээлэн (NDI), Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI), NIMD, НҮБХХ (UNDP), UN Women зэрэг түнш байгууллагуудтай хамтран эмэгтэй нэр дэвшигч, нам дотроо улс төрийн карьераа ахиулахыг эрмэлзэж буй эмэгтэйчүүдэд манлайллын сургалт явуулсан. Сургалтын эрчимтэй хөтөлбөрийг Албани, Армени, Гүрж, Казахстан, Киргиз, Молдав, Тажикстанд зохион байгуулжээ.

ялгаварлан гадуурхалтын эх сурвалж байгаа эсэхийг тогтоохын тулд тухайн байгууллагаас мөрдөж буй бодлого, журам, практикийг үнэлж, улмаар жендэрийн тэгш байдлыг дэмжих эрмэлзэл, дадал байгаа эсэхийг тогтоодог. Тус аудитын хүрээнд эмэгтэйчүүд, ер нь жендэрийн тэгш байдлын талаарх хандлага, ойлголтыг тогтоохын тулд намын удирдлага, гишүүдтэй уулзаж ярилцаж болно. Ингээд ямар дутагдал, бэрхшээл, ялгаварлан гадуурхалтын эх сурвалж байгааг тогтоосны дараа тэдгээрийг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, уг үйл явцын ахицыг хянах намын идэвхтэй, гишүүн томилох зэргээр хяналтын арга хэмжээг мөн тодорхойлно. Гаднаас ИНБ-ын шинжээч авч ажиллуулан жендэрийн аудит хийлгэх нь уг ажлын хараат бус байдлыг дээшлүүлэх бөгөөд намын гишүүд, түүний дотор жендэрийн тэгш байдлыг дэмждэг хүмүүс ч анзааралгүй хэрэгжүүлж байсан жендэрийн ялгаварлалыг илрүүлэх сайн талтай.

Тухайлбал, засгийн газрын бус, бүс нутаг хоорондын байгууллага болох BalticFem эмэгтэйчүүдийн улс

төрийн оролцооны ерөнхий үнэлгээг Европын 5 орны орон нутгийн удирдлага, улс төрчидтэй хамтран хийжээ. Шведэд төвтэй тус байгууллага нь бүсийн санаачилга, төсөл хэрэгжүүлэх замаар Балтийн тэнгис орчмын бүсэд жендэрийн тэгш байдлыг сайжруулах зорилготой. 2009 онд Европын комиссын “Европ иргэдийн төлөө” хөтөлбөрийн хүрээнд BANDIAR төслийг Франц, Итали, Испани, Шведийн орон нутгийн удирдлага болон ТББ-ын консорциум эхлүүлсэн бөгөөд орон нутаг, бүс, үндэсний болон Европын олон улсын түвшинд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжихийг зорьж байна.²⁶³ Төслийн нэг үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээл, Европын парламентад эмэгтэйчүүд өрсөлдөхөд ашиглах боломж зэргийг тодорхойлохын тулд дээрх 5 орон дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны SWOT шинжилгээг хийх явдал байв. Хэдий улс төрийн байгууллагыг голлон авч үзсэн ч тус шинжилгээг иргэний нийгмийн байгууллага өөртөө тохируулан өөрчилж, намын үйл явц, дадал, журмын талаар нэмэлт асуултууд оруулах замаар улс төрийн намаас эмэгтэйчүүдийн дэвшлийг дээшлүүлэхэд үзүүлж буй дэмжлэгийг үнэлэхэд хэрэглэж болно (Шигтгээ 5.10).

→ Улс төрийн намын гишүүдэд жендэрийн тэгш байдал, үр чадвар хөгжүүлэх сургалт хийх

Намын удирдлага, эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигч, улс төрийн намын идэвхтнүүдэд сургалт хийх нь ИНБ-аас сонгуульт албан дахь жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх чиглэлээр хийх хамгийн үр дүнтэй аргын нэг юм. Улс төрийн нам өөрөө эмэгтэй улс төрчдийнхөө чадавх бэхжүүлэх ажил хийх боломжгүй эсвэл намын гишүүдэд жкндэрийн тэгш байдлын сургалт явуулах хангалттай чадавх байхгүй бол жендэрийн тэгш байдал, жендэрийн асуудлыг тухайн байгууллагын үйл ажиллагаанд нэгтгэн тусгах чиглэлээр мэргэшсэн ИНБ-аас туслалцаа авч болно.

Өмнө дурдсанчлан, ЕАБХАБ-ын олон оронд улс төрийн манлайллын сургалт хийдэг хүрээлэн бий. Зарим нь эрэгтэй, эмэгтэй гишүүдээ сургах сонирхолтой улс төрийн

263 <<http://www.balticfem.com/en/bandiar-2009>>.

намуудад зориулан сургалт хийдэг. Улс төр, манлайллын сургалтын ийм байгууллага Казахстан, Киргиз, Тажикстанд бий. Зарим нь аль нэг улс төрийн намтай холбоотой байж болно, тухайлбал, Төв Европын улс төрийн академи нь Болгарын Ардчилсан хүчний холбооны сургалтын байгууллага юм²⁶⁴.

Улс төрийн намууд гишүүддээ жендэрийн тэгш байдал зэрэг сэдвээр сургалт хийж, дараа нь тэднийг бусад гишүүдэд сургалт хийхийг даалгах маягаар “сургагч багш бэлтгэхэд” хөрөнгө зарцуулж болно. Олон улсын олон байгууллага, ТББ-ууд улс төрийн салбарт сургагч багшийн сургалт хийдэг. Энэ нь жендэрийн тэгш байдлын асуудлаар намын дотоод чадавх бий болгох тогтвортой, зардал багатай арга юм. Эсвэл улс төрийн намууд шинэ гишүүдэд зориулсан сургалтыг тогтмол хийдэг бол түүнд жендэрийн тэгш байдлын талаарх сэдэв, мөн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, дэвшлийн төлөө нам юу хийж байгаа талаар оруулж болно.

Түүнчлэн улс төрийн шинжлэх ухааны байгууллагууд залуу эмэгтэй манлайлагчдад зориулсан сургалт хийх, өөрийн сургалтын хөтөлбөртөө жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны сэдвийг оруулах болсон байна. Тухайлбал, Европын зөвлөлийн дэмжлэгтэй улс төр судлалын сургуулиудыг энд дурдаж болно (Шигтгээ 5.12. Европын зөвлөлийн улс төр судлалын сургуулиудын жагсаалт). ЕАБХАБ/АИХЭБ ч эдгээр болон залуу улс төрийн манлайлагчдад чиглэж ажилладаг бусад адил төстэй сургуультай түншлэн ажиллаж байна. Тухайлбал, Польшийн залуу манлайлагчийн сургууль, Гүржийн Улс төр судлалын сургууль (Олон намт ардчиллын Нидерландын хүрээлэн дэмжлэг үзүүлдэг), Украйны Улс төрийн сургууль (Европын зөвлөлийн дэмжлэгтэй). Судалгааны байгууллагаас жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн манлайллын чиглэлээр явуулж буй тусгайлсан хөтөлбөрийн талаар дор судалгааны байгууллагын үүргийн тухай хэсэгт оруулав.

Шигтгээ 5.12. ЕАБХАБ-ын бүсэд буй улс төр, улс төр судлалын сургуулиуд

Улс төр, улс төр судлалын сургуулийн Европын комисс, бусад байгууллагаас ЕАБХАБ-ын хэд хэдэн оронд байгуулсан. Үүнд:

- Албани
- Армени
- Азербайжан
- Беларусь
- Босни Герцеговина
- Болгар
- Хорват
- Гүрж
- Македони
- Молдав
- Монтенегро
- Румын
- ОХУ
- Серби
- Украйн

Эх сурвалж: Европын зөвлөл, <http://www.coe.int/t/dgap/sps/default_en.asp>.

Эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг дэмжихэд шаардагдах мэдлэг түршлага, эсвэл нам дотроо жендэрийн тэгш байдлын мэдлэг түршлага бүрдүүлэх гэх мэт тухайн зорьж буй чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн хэлбэрээс үл хамааран улс төрийн намууд түүнд хөрөнгө зарцуулах хүсэлтэй байх ёстой.

→ Сонгуулийн үеэр сонгогчдыг дайчлах, дэмжиж болох улс төрийн намуудыг нэрлэх

Иргэний нийгмийн байгууллагууд бол сонгогчийн боловсролын ажлыг санаачилж, хийдгээрээ нэртэй билээ. Тэдгээр хөтөлбөрөөр дамжуулан сонгогчдыг саналаа өгөхийг уриалахын зэрэгцээ сонгогчийн эрхийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд тусалдаг. Эсвэл намтай холбоотой ажилладаг ИНБ-үүд өөрсдийнх нь улс төрийн зорилгод нийцсэн тодорхой аль нэг нам, нэр дэвшигчид санал цуглуулахын төлөө ажиллаж болох бөгөөд аль нэг намын сурталчилгааны ажилд оролцож болно. Мөн

264 USAID, Civil Society Groups and Political Parties: Supporting Constructive Relationships, 2004, <http://transition.usaid.gov/our_work//democracy_and_governance/publications/pdfs/pnacu631.pdf>.

сонгууль хоорондын хугацаанд улс төрийн намуудын өмнөөс сонгогчдод, түүний дотор эмэгтэйчүүдэд эрхийнх нь талаар таниулах гэх мэтээр үйлчилгээ үзүүлж, зорилтот бүлгийн дунд ойлголт мэдлэг нэмэгдүүлэх ажил хийх маягаар сонгогчидтой холбоотой байж, тэднийг дайчилж чадна.

Газар дээр нь иргэдтэй ажилладаг ТББ бүхий улс төрийн намууд бол сонгогчийн эрхийн талаар мэдээлэл түгээхээс гадна боловсрол мэдлэг олгох ажил хийдэг. Тухайлбал, Баруун Балканд янз бүрийн ИНБ-ууд Рома хүмүүс, Рома эмэгтэйчүүдтэй ажиллаж, тэдэнд иргэний эрхийн талаар ойлголт мэдлэг өгч, гэр бүлийнхнийхээ өмнөөс санал өгөх, орлож санал өгөх зэргээс сэргийлэх ажил хийдэг.

→ **Тодорхой асуудлаар нөлөөлөл хийх, судалгаа хийхэд улс төрийн намуудад туслах**

ИНБ-ууд нь тухайн сонгогч, онцлог бүлэгт тулгамдсан тодорхой асуудлаар нотолгоонд суурилсан судалгаа хийхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм судалгаа нь улс төрийн намуудад тухайн асуудлаарх мөрийн хөтөлбөр, сурталчилгааны санаагаа боловсруулахад асар тустай. Өмнө дурдсанчлан, ИНБ-ууд аль нэг намыг (нам дагасан) дэмжсэн эсвэл олон намын арга барилыг баримтлан, улс төрийн олон намд судалгааны суурь бүрдүүлж өгдөг.

Аль ч тохиолдолд уг судалгааг улс төрийн намууд жендэртэй холбоотой асуудлаар эсвэл тухайн тойрог дахь эмэгтэйчүүдийн дийлэнхэд тулгамдаад буй асуудлаар байр сууриа тодорхойлоход ашиглаж болно. Үүнд тухайн аль нэг бодлого, эрх зүйн өөрчлөлт эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хөвгүүд, охидод хэрхэн тусах талаарх жендэрийн нөлөөллийн шинжилгээ багтана. Тухайлбал, улс төр, засаглалын хүрээнд сонгууль, улс төрийн нам, намын сурталчилгааны ажлын санхүүжилт, төвлөрлийг сааруулах зэрэг асуудлаар жендэрийн шинжилгээ хийснээр зарим заалт нэр дэвшиж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгаатай нөлөө үзүүлж байгааг тогтоох боломжтой.

→ **Улс төрийн намууд жендэрийн тэгш байдлын мөрийн хөтөлбөр боловсруулах, гарын үсэг зурахыг хөхиүлэн дэмжих**

ИНБ-ууд нь жендэрийн тэгш байдлын мөрийн хөтөлбөр боловсруулах эсвэл иргэний нийгмийн тийм ажилд нэгдэн орох талаар улс төрийн намуудад шууд чиглэсэн нөлөөллийн ажил хийж, улс төрд жендэрийн тэгш байдал, тэнцвэртэй байдлыг хангахыг шаардаж болно. Тухайлбал, 2010 онд Францын нийгмийн бүхий л салбарт тэгш хандахыг сурталчлах зорилготой үүссэн Тэгш байдлын лаборатор гэдэг байгууллага 2012 оны 1 дүгээр сард Францад “Тэгш байдлын төлөөх гэрээ” аянг эхлүүлэн, ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчдээс засаглалд жендэрийн тэгш байдлыг хангах амлалт өгөхийг хүссэн.²⁶⁵ Улс төрийн янз бүрийн үзэл бодолтой эрэгтэй, эмэгтэй нийт 700 гаруй гишүүнтэй гэгддэг тус байгууллага 2012 оны сонгуулийн сурталчилгааны ажилд эрчимтэй оролцож, сонгогчдод ямар нэр дэвшигч дээрх гэрээнд гарын үсэг зурсан, хэн нь зураагүй вэ гэдгийг мэдээлж байв.²⁶⁶

Польшийн нийгмийн янз бүрийн салбарыг төлөөлсөн эмэгтэйчүүдийг (мөн эрэгтэйчүүд) хамран Варшавт жил бүр болдог Польшийн Эмэгтэйчүүдийн чуулганы оролцогчид²⁶⁷, эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг дэмжих чиглэлээр улс төрийн намуудад хандсан 135 шаардлага бүхий тунхаг бичиг гаргасан. Иргэний мөрийн хөтөлбөр нам түүнд хариу өгч, сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хэд хэдэн зүйл тусгасан бөгөөд засгийн эрхэнд гарвал түүнийг хэрхэн хэрэгжүүлэхээ дурдсан байв.

265 See Laboratoire de l'égalité, <<http://www.laboratoiredeegalite.org/>>.

266 Laboratoire de l'égalité, <<http://www.laboratoiredeegalite.org/spip.php?page=recherche&recherche=Pacte+po+ur+I%E2%80%99%C3%A9galit%C3%A9>>.

267 Polish Congress of Women, <<http://www.kongreskobiet.pl/en-EN/>>.

Шигтгээ 5.13. Украйны “Сармис” кампанит ажил, 2012 оны парламентын сонгууль

Тус ажлын хүрээнд нийт 56 ТББ-ын идэвхтнүүд нэгдэн Украйны 2012 оны сонгуулийн өмнө нэр дэвшигчдийн ёс зүйн байдлын талаар сонгогчдод мэдээлэл хүргэх зорилго тавьсан. Нэр дэвшигчдийг дараах 6 шалгуураар үнэлсэн. Үүнд:

- хүний эрхийн зөрчил гаргаж байгаагүй;
- авлигад холбогдож байгаагүй;
- хөрөнгө орлогоо ил тод мэдүүлдэг;
- парламентын чуулганд өөрөө саналаа өгдөг;
- парламентад сонгогдсон намын суудалдаа үнэнч;
- парламентын хуралдаан, нэгдсэн чуулганд оролцдог.

Эдгээр шалгуурт үндэслэн тус хөдөлгөөнөөс нийт 450 парламентын гишүүн, 2309 нэр дэвшигчийг үнэлснээс 935 нь уг шалгуурыг хангаагүй. Тус эвслээс улс төрийн намуудад Санамж бичигт гарын үсэг зурах, тус кампанит ажил болон улс төр дэх шударга ёс зүйтэй байдлыг дэмжиж байгаагаа илэрхийлэх замаар нэгдэх боломж олгосон.

Эх сурвалж: Сармис иргэний хөдөлгөөн, <<http://www.chesno.org>>.

Түүнчлэн иргэний нийгмийн олон байгууллага сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалтаа улс төрийн нам, нэр дэвшигчид хэрхэн биелүүлж байгааг, мөн нам, нэр дэвшигчид янз бүрийн салбарт ямар амжилт гаргасныг судлан гаргах зорилго бүхий ойлголт мэдлэг нэмэгдүүлэх, хяналт тавих аян өрнүүлдэг. Тухайлбал, Украйнд 2012 оны парламентын сонгуулийн өмнөхөн иргэний нийгмийн нэг эвсэл парламент дахь авлига, эзэнгүй санал өгөлтийн асуудлыг хөндөж, олон нийтэд тухайн нэр дэвшигчдийн ёс зүйн асуудлыг хөндсөн мэдээлэл өгч байв. Тус эвслээс нэр дэвшигчийг 6 шалгуураар үнэлсэн. Үүнд: хүний эрхийн зөрчил гаргаж байгаагүй, авлигад холбогдож байгаагүй, хөрөнгө орлогоо ил тод мэдүүлдэг, парламентын чуулганд өөрөө саналаа өгдөг, парламентад сонгогдсон зорилгодоо үнэнч, парламентын хуралдаан, нэгдсэн чуулганд оролцдог (Шигтгээ 5.13).²⁶⁸ Үүнд жендэрийн тэгш байдлын төлөөх эрмэлзэл багтаагүй боловч ИНБ-аас жендэрийн тэгш байдлын амлалттай холбоотой иймэрхүү сурталчилгаа хийж, сонгогчдод улс төрийн нам, нэр дэвшигчдэд дүгнэлт хийхэд нь туслах асуудлыг бодож үзэж болох юм. Ингэснээр аль нам өнөөг хүртэл ямар амжилт гаргасан, аль нь жендэрийн тэгш байдлын зарчмыг хэрэгжүүлэх үүрэг

өөртөө хүлээсэн талаар маш чухал баримт бүхий мэдээллийн сан үүсэн юм.

→ Улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, жендэрийн тэгш эрхийн асуудлаар улс төрийн намуудын дунд хэлэлцүүлэг хийх

Иргэний нийгмээс улс төрийн нам, нэр дэвшигчдийг жендэрийн тэгш байдал, улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн талаар өөрийн бодол, байр сууриа нээлттэй илэрхийлэхийг нь хөхиүлэн дэмжсэн тодорхой нэг ажил бол олон нийтийн хэлэлцүүлэг юм. Түүнд улс төрийн намын удирдлага, намын нэр дэвшигчид орох нь зүйтэй.

Оролцогчдоос улс төр дэх жендэрийн тэгш байдлын талаар юу гэж боддог, намаас эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийн төлөө тодорхой юу хийсэн зэргийг асуун, энэ чиглэлээр нам эсвэл тухай нэр дэвшигч ямар амлалт өгөх, юу хийх санаатай байгааг тодруулж болно. Эндээс аль нам, нэр дэвшигч нь эмэгтэйчүүдэд ээлтэй хөтөлбөртэй, аль нь тийм зүйлгүйг харах боломжтой. Нам, нэр дэвшигчийн энэ сэдвээр баримталж буй байр суурийн талаар олон нийтийн ойлголт мэдлэг үүсгэх, сонгогчдын зүгээс энэ чиглэлээр илүү ажил хийхийг хүссэн шахалт бий болгох зэрэгт ийм хэлэлцүүлгийг ашиглаж болно. ЕАБХАБ/АИХЭА-наас Албани, Армени, Гүрж, Казахстан, Киргиз, Молдав, Польшид дугуй ширээний хэлэлцүүлэг хийж, улс төрийн намын удирдлага, төлөөлөгчдийг урьж, эмэгтэй улс төрчдийг дэмжих талаар гаргаж буй хүчин

Шигтгээ 5.14. Европын түвшин дэх намын хөтөлбөрийн жендэрийн аудит

Европын эмэгтэйчүүд лобби байгууллагын Ардчиллын төлөөх 50/50 сурталчилгааны хүрээнд 2009 оны 5 дугаар сарын 20 буюу Европын парламентын 6 дугаар сард болох сонгуулийн өмнөхөн *Сонгуулийн жагсаалт, намын хөтөлбөрийн жендэрийн аудитын тайланг* хэвлэн гаргасан. Түүнд сонгуульд өрсөлдөж буй бүх намын үлс төрийн хөтөлбөр, сонгуулийн жагсаалтыг нягтлан, нам тус бүрийн жендэрийн тэгш байдлын төлөөх эрмэлзэл, амлалтыг үнэлжээ. Тус тайланд Европын холбооноос бодлогын хүчтэй баримт бичиг гаргаж, стандарт боловсруулсан ч үлс төрийн намуудын дийлэнх нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш байдлыг 2009 оны сонгуульд тэргүүлэх асуудал болгон авч үзээгүй байна гэж дүгнэжээ.

Эх сурвалж: Жендэрийн аудитын тайланг Европын эмэгтэйчүүдийн лобби-гийн цахим хуудаснаас татаж авна уу: <<http://5050campaign.wordpress.com/>>.

явдал юм. Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагуудаас хэд хэдэн сонгууль дамнан нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа өөрчлөгдөж байгаа эсэхийг судлан харуулж болно. Уг мэдээллийг ашиглан эмэгтэйчүүдийг нэрийн жагсаалтанд оруулсан байдал, мөн сонгогдсон болон томилогдсон албан тушаал дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн хувьд хамгийн сайн, хамгийн муу байгаа намыг тодруулах боломжтой. Тухайлбал, 2010 онд Их Британийн парламентын сонгуулийн өмнөхөн иргэний нийгмийн байгууллага Либерал Ардчилсан намд Хөдөлмөрийн болон Консерватив намтай харьцуулахад эмэгтэй парламентын гишүүн маш цөөн байгаад хэвлэл мэдээллийн анхаарлыг хандуулсан.²⁷¹ Энэ нь эмэгтэйчүүдийн төлөөллийн асуудлыг олон нийтийн анхаарлын төвд хүргэсэн бөгөөд улмаар намууд улс төрийн нам дахь эмэгтэйчүүдийн оролцооны асуудлын талаар намынхаа нөхцөл байдлыг зөвтгөж тайлбарлан ярихаас өөр аргагүй болсон байна.

Молдавт Хөгжлийн төлөөх түншлэлийн төв (Progen) гэдэг байгууллага сонгуулийн үйл

чармайлтынхаа талаар ярихыг хүсч байсан билээ.²⁶⁹

Түүнчлэн иргэний нийгмийн олон байгууллага үлс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт аудит хийж, намын удирдлага, нэр дэвшигчдээс сурталчилгааны ажилдаа жендэрийн холбогдолтой асуудал оруулсан эсэхийг, мөн хэрэглэсэн үг хэллэг зэргийг судалдаг болсон. Тухайлбал, Их Британийн Фасет нийгэмлэг 1866 оноос хойш эмэгтэйчүүдийн эрхийн төлөө ажиллаж байгаа бөгөөд сонгуулийн үеэр нам тус бүрийн мөрийн хөтөлбөрт аудит хийдэг.²⁷⁰ Үүнтэй төстэй ажлыг 2009 оны Европын парламентын сонгуулийн өмнө Европын эмэгтэйчүүдийн лобби хийж байв (Шигтгээ 5.14).

→ Улс төрийн намууд жендэрийн тэгш байдлын амлалтаа хэр биелүүлж байгаад хяналт тавих

Мэдээж, улс төрийн намын хувьд жендэрийн тэгш байдлын талаар сонгуулийн мөрийн хөтөлбөртөө оруулж, амлалт өгөх, эсвэл жендэрийн тэгш байдлын ерөнхий аянд нэгдэн орох нь хангалттай биш. Харин тэд үг эрмэлзэл, амлалтаа *биелүүлж байх* нь илүү чухал. ЕАБХАБ-ын олон улс оронд ИНБ намуудын сонгуулийн амлалтын биелэлтийг хянах, жендэрийн тэгш байдлыг хангахад гаргаж буй ахицыг үнэлж хянахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн.

Намын жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийн чиглэлээр хийсэн ажлыг үнэлж эхлэх нэг тодорхой алхам бол нь улс төрийн намын нэр дэвшигчдийн жагсаалтыг хүйсээр харуулж, одоо тус намаас сонгогдсон, томилогдсон албан тушаалтнуудын хүйсийн харьцааг нийтэд харуулах

269 See the OSCE/ODIHR website on gender equality for selected News Items on these events: <<http://www.osce.org/odihr/gender>>.

270 Fawcett Society, <<http://www.fawcettsociety.org.uk/>>.

271 "Election 2010: Where the Women Candidates are", A Report from the Centre for Women and Democracy, April 2010, <<http://www.cfwd.org.uk/uploads/pdfs/WomenCandidatesApril2010.pdf>>.

явцад гардаг жендэрийн тэгш байдлын асуудлыг илүү сайн ойлгохын тулд сүүлийн 4 жилд үндэсний гурав, орон нутгийн хоёр сонгуульд жендэрийн ажиглалт, хяналт хийсэн.²⁷² Үүнд нэр дэвшигчийн жагсаалтанд орсон эмэгтэйчүүд, мөн улс төрийн нам бүрийн сонгуулийн удирдлагын албан тушаалд ажилласан эмэгтэйчүүдийн тоог харьцуулж үзсэн байна. Түүнчлэн сонгуулийн сурталчилгааны үеэр эмэгтэй нэр дэвшигчийг хэвлэл мэдээллээр хэр гаргаж байсныг ажигласан. Өмнө нь Молдавт сонгуулийг ингэж жендэрийн өнцгөөс ажиглаж байгаагүй; тиймээс Progen өмнө байгаагүй хэрэгтэй мэдээлэл, судалгааг бий болгосон юм.

Намууд жендэрийн тэгш байдлын талаарх сонгуулийн амлалтаа хэр биелүүлж байгааг хянах үүднээс явцын хяналтыг сонгуулийн дараа хийж болно, ер нь хийх хэрэгтэй. Тухайлбал, парламентын хувьд л гэхэд ИНБ-ууд улс төрийн намуудаас жендэрийн холбогдолтой хуульд хэрхэн санал өгснийг хянах боломжтой.

5.1.3. Олон нийтийн эерэг хандлага бүрдүүлж төлөвшүүлэх

Улс төрийн намын удирдлага, эмэгтэй улс төрч зэрэг улс төрийн оролцогч талуудын дунд улс төр дэх жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг ойлголт нэмэгдүүлэхээс гадна иргэний нийгмийн байгууллагууд нь жендэрийн асуудал, сэдвээр олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэ хэсэгт эмэгтэйчүүдийн төлөөлөл улс төрд сул байгаа талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрд оролцох чадавхын талаарх жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг няцаах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар олон нийтийн дунд эерэг хандлага бүрдүүлэх үүднээс гишүүн улс орнуудын ИНБ-уудын зохион байгуулсан хэд хэдэн аяны жишээг танилцуулав. Энэ хэсэг нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар олон нийтийн хандлагад хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүргийн талаарх дараагийн хэсэгтэй нягт холбоотой юм.

Зураг 5.15. Чехийн “Форум 50%” сурталчилгааны ажил



Эх сурвалж: Форум 50%, <<http://www.5050democracy.eu/>>.

272 “Delivering on Gender Equality in elections”, Center “Partnership for Development”, 09 March 2010, progen.md, <<http://www.progen.md/index.php?pag=proiecte&opa=view&id=134&tip=&start=&l=en>>.

Зураг 5.16. Туркийн Ka-Der сурталчилгааны ажил



Эх сурвалж: Ka-Der,
<<http://www.ka-der.org.tr/>>

Зураг 5.17. Франц дахь Тэгш байдлын лаборатори сурталчилгааны ажил



Эх сурвалж: Тэгш байдлын лаборатори,
<<http://www.laboratoiredelegalite.org/>>

→ **Улс төрийн статус кво буюу одоо байгаа нөхцөл байдлыг хөндсөн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх**

Чех улсад “Форум 50%” гэдэг иргэний нийгмийн бүлэг 2006 оны парламентын сонгуулийн өмнө том зурагт хуудасны сурталчилгааны ажил өрнүүлсэн. Тэд Прагийн метро, гудамжинд “Та үнэхээр сонголт байна уу” гэсэн асуулт бүхий эрэгтэй өмд, зангианы урт жагсаалт бүхий зураг хуудсууд байрлуулсан байна. Энэ нь хэдий өрсөлдөж буй улс төрийн намууд зарим талаар ялгаатай ч нэгэнт дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа тул үнэндээ “сонголт” бараг алга гэсэн санааг дэвшүүлсэн байв. (Зураг 5.15).

Туркад Эмэгтэй нэр дэвшигчдийн дэмжих нийгэмлэг “Ka-Der” мөн олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн цуврал, шинэлэг сурталчилгааны ажил явуулсан байна. 2007 оны сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд тэд нэртэй бизнес эмэгтэйчүүд, эмэгтэй урлагийн зүтгэлтнүүдийг зангиатай эсвэл сахалтайгаар зурагт хуудас болгон “Парламентад сонгогдоход заавал эрэгтэй байх шаардлагатай юу?” бичигтэйгээр тараажээ (Зураг 5.16).

Харин 2009 оны орон нутгийн сонгуулийн өмнө Ka-Der улс төрийн гол намуудын эрэгтэй удирдагч нар мөр зэрэгцэн буй зургийн том самбаруудад байршуулан, эдгээр гурван нам эмэгтэй биш эрэгтэй хүнийг илүүд үзэж, нэр дэвшүүлэхээр өөр хоорондоо нэгдлээ гэсэн утгатай бичиг оруулсан байна.

Тэгш байдлын лаборатор гэдэг франц байгууллага 2010 онд улсын салбарт жендэрийн хувьд тэгш ханддаг байх, тэгш төлөөлөлтэй байх явдлыг дэмжих зорилгоор байгуулагдсан. Тэд 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө “Тэгш байдлын төлөөх пакт” гэсэн уриатай мэдлэг ойлголт нэмэгдүүлэх сурталчилгааны ажил хийсэн байна. Ерөнхийлөгчид нэр дэвшсэн хүмүүст дээрх пактад нэгдэхийг уриалан шахалт үзүүлэхийн зэрэгцээ эмэгтэй хүний дээр сууж буй эрэгтэй хүний зургийг “Бид эмэгтэйчүүдийг хаана суулгахад бэлэн байна вэ” гэсэн тайлбартайгаар гаргасан байна (Зураг 5.17).

Шигтгээ 5.18. Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр – 3 дугаар сарын 8

3 дугаар сарын 8-нд өргөнөөр тэмдэглэдэг Олон улсын Эмэгтэйчүүдийн өдрийг Германы Социал Демократ Намын удирдагч Клара Цеткин 1910 онд олон улсын социалист эмэгтэйчүүдийн бага хурал дээр анх ийм өдөр болгохоор санал гаргасан. 1910 онд 82,000 эмэгтэй гишүүнтэй байсан түүний нам эмэгтэйчүүдийн эрх, түүний дотор бүх нийтээр сонгуульд санал өгөх эрхтэй байх, эмэгтэйчүүд улс төрийн хувьд эвлэлдэн зохион байгуулагдах эрхийн төлөө тэмцэж байв. Тэр үед Европод эмэгтэйчүүд ажиллах хүчний эгнээнд олноороо шилжин орж байсан бөгөөд бага цалинтай байв.

Тэрээр дэлхий даяар эмэгтэй ажилчдын сонгуульд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх, эмэгтэйчүүдийн дунд болон эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дунд эв санааны нэгдэл бий болгохын тулд Олон улсын хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн өдрийг тусгайлан гаргаж, жил бүр тэмдэглэж байх санал гаргасан. Үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүдийн байгууллага, Европын социалист намуудын төлөөлж ирсэн 17 орны 100 гаруй эмэгтэй Цеткины саналыг нэгэн дуугаар дэмжин баталсан. Түүнээс хойш 3 дугаар сарын 8-ныг Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр болгон дэлхий даяар тэмдэглэж иржээ.

Эх сурвалж: *Кэти Дуркин*, “Эмэгтэйчүүдийн тэмцэл, эв нэгдэл”, 2009, <http://www.workers.org/2009/world/women_0326/>.

Мөн тус байгууллагаас эмэгтэйчүүд нийгэмд хэрхэн үл үзэгдэгч болж байгаа, эрэгтэйчүүд тэдний хувь нэмрийг хэрхэн үгүйсгэж, янз бүрийн орчин нөхцөлд тэдний өмнүүр дайран гарч байгааг харуулсан видео бүтээсэн.²⁷³ Зурагт хуудсууд, мөн дээрх видеоны хэсгээс сонин, Интернет дээр тавьж, зурагт хуудсыг олон нийтийн газруудад байршуулан, францын нийгмийн амьдрал, түүний дотор улс төрийн амьдралд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, энэ талаар хэлэлцүүлэг өдөөхийг зорьсон байна.²⁷⁴

Үүнээс гадна, иргэний нийгмийн байгууллагууд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, эмэгтэй улс төрчид болон иргэний нийгмийн идэвхтнүүдийн хэлхээ холбоог дэмжих, хамтарсан мэдэгдэл гаргах, бусад ажил хийх үүднээс байнгын болон түр зуурын эвслүүд байгуулж болно. Өмнөх хэсэгт дурдсан Украйны “Сармис” сурталчилгааны ажил амжилттай болсон нь уриа, материал сайн байснаас гадна иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллаж, хөрөнгө, мэдлэг чадвараа нийлүүлэн, олон нийтэд өргөн хүрээтэй хүрч чадсантай холбоотой. Тийм эвсэл нь Эмэгтэйчүүдийн өдөр, Үндсэн хуулийн өдөр, Тусгаар тогтнолын өдөр зэрэг үндэсний болон улсын улс төрийн ач холбогдолтой тэмдэглэлт өдрүүдээр хамтарсан мэдэгдэл гаргаж болно (Шигтгээ 5.18). Мэдлэг ойлголт нэмэгдүүлэх ажлыг хамтран амжилттай хийсэн өөр нэг жишээ бол “Нэг тэрбум хүн шаардаж байна” гэсэн дэлхий дахиныг хамарсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх санаачилга юм. 2013 онд тэрбум орчим эрэгтэй, эмэгтэй хүн гудамжинд, улсын байгууллагуудын өмнө бүжиглэж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсоохыг шаардсан. Энэ ажил 2014 онд мөн хийгдэх юм.²⁷⁵

Энэ бүхний нийлүүлэн авч үзвэл мэдлэг ойлголт нэмэгдүүлэх эдгээр санаачилга нь улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийг орхигдуулж байгааг ардчиллын хүлээн зөвшөөрөгдөх байдал, итгэгдэх чанарт нөлөөлөх асуудал болгон гарган тавьж, эмэгтэй нэр дэвшигчдэд ээлтэй орчин бий болгохыг эрмэлзэж байгаа юм. Ийм сурталчилгааны ажил нь хэвлэл мэдээллийг дайчилснаар илүү үр дүнтэй болох бөгөөд энэ талаар дараагийн хэсэгт авч үзэв.

273 “Laboratoire de l'égalité”, YouTube, 19 January 2012, <http://www.youtube.com/watch?v=O7W8z5DTqwo>.

274 “Campagne de sensibilisation”, Laboratoire de l'égalité, <<http://www.laboratoiredelegality.org/spip.php?rubrique67>>.

275 <<http://www.onebillionrising.org/>>.

5.1.4. Хэвлэл мэдээлэлтэй ажиллах

Хэвлэл мэдээллээр сурталчилгааны аян явуулах нь ЕАБХАБ-ын орнуудын ихэнх сонгуульд нам, нэр дэвшигчдийн ашигладаг хамгийн түгээмэл хэлбэр хэвээр байна. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдөө ч сонгуулийн үйл явцыг сурвалжлах, өрсөлдөж буй нам, нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг нийтэд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ үүргээ гүйцэтгэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага ихэнхдээ мэдээллийг шүүлтүүрээр оруулж, тайлбартайгаар хүргэдэг. Ялангуяа тухайн суваг, сонин нь үзэл суртлын хувьд аль нэг нам, намуудын бүлэгтэй ойр гэж тооцогддог бол ийм байдал бүр их гардаг. Мөн ухамсартай болон ухамсаргүй байдлаар жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг өгшүүлж эсвэл няцаахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хэвлэл мэдээлэл нь нийгэм эрэгтэй, эмэгтэй хүмүүс, тэдний гүйцэтгэх үүрэгт хэрхэн хандаж хүлээн авахад голлох нөлөө үзүүлж чадна. Зар сурталчилгаа, телевизийн хөтөлбөр, сонин, сэтгүүлээс эхлээд комик буюу зурган ном, хөгжим, кино, видео тоглоом хүртэл бүх зүйлд эмэгтэйчүүдийг ихэвчлэн юм угаах, хоол хийх зэрэг гэрийн ажилхийж байгаагаар эсвэл бэлгийн харьцааны хэрэгсэл байдлаар эсвэл өөрийгөө хамгаалах чадваргүй хохирогч байдлаар дүрсэлдэг. Харин эрэгтэйчүүдийг биеэ даасан, өрсөлдөөнт, сэтгэл хөдлөл багатай, түрэмгий, хүчирхийлэл зэрэг эрэгтэйлэг чанартай холбон хэвшмэл байдлаар дүрслэн үзүүлдэг. Судалгаанаас үзэхэд хэвлэл мэдээллээр ийм түйлширсэн жендэрийн мэдээлэл өгөх нь нийгэмд асар их сөрөг нөлөө үзүүлдэг байна.²⁷⁶

Түүнчлэн шинжээчид хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг ийм хэвшмэл байдлаар дүрслэх, нөгөө талаас, улс төр, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийг огт харуулахгүй, эсвэл сул төлөөлүүлэн харуулах нь улс төрд эмэгтэйчүүд дутуу төлөөлөлтэй байхад хэрхэн нөлөөлж байгааг судалж эхлээд байна. Тухайлбал, “Мисс төлөөлөл” гэдэг саяхны баримтат кинонд энэ холбоог авч үзсэн байна (Шигтгээ Vox 5.20).

Иймээс энэ хэсэгт иргэний нийгмийн байгууллагаас улс төр дэх эмэгтэйчүүдийн талаарх жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг няцаах, эмэгтэй, эрэгтэй улс төрчдийг хэвлэл

Шигтгээ 5.19. Жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголт

Хэвшмэл ойлголт гэдэг нь тухайн хүн эсвэл бүлэг хүнийг явцуу, ихэнхдээ буруу таамаглалд үндэслэн тодорхойлох, тэдэнд хандах санаа бодол юм.

Жендэрийн хэвшмэл ойлголт гэдэг нь хувь хүмүүс, бүлэг хүмүүсийн жендэрийн шинж чанар, ялгаа, үүргийн талаар хэт энгийн ерөнхийлсөн ойлголтыг хэлнэ. Жендэрийн хэвшмэл ойлголт нь эерэг эсвэл сөрөг байж болно, гэхдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаар зөв мэдээллийг дамжуулах нь ховор байдаг.

Эх сурвалж: 'Stereotype', Wikipedia, <<http://en.wikipedia.org/wiki/Stereotype>>; 'Gender stereotypes', Cliffs Notes, <http://www.cliffsnotes.com/study_guide/Gender-Stereotypes.topicArticleId-26957, articleId-26896.html>.

Шигтгээ 5.20. Эс төлөөлөл → Мисс Төлөөлөл

Женнифер Сибелийн найруулсан, шагнал хүртсэн *Miss Representation* буюу Хатагтай Төлөөлөл баримтат кинонд хэвлэл мэдээлэл эмэгтэйчүүдийг буруу дүрслэн харуулдагийн улмаас эрх мэдэл, нөлөө бүхий албан тушаалд эмэгтэйчүүд дутуу төлөөлөлтэй байгаа тухай өгүүлдэг.

MissRepresentation.org бол ашгийн төлөө бус нийгмийн сурталчилгаа, хэвлэл мэдээллийн байгууллага бөгөөд хүмүүсийн ухамсрыг дээшлүүлэх, хувь хүн болон хамтдаа арга хэмжээ авах сэдэл өгөх, улмаар хүйс, нас, нөхцөл байдлаас үл хамааран хүн бүр өөрийн бодит бололцоогоо бүрэн дүүрэн ашигладаг соёл бий болгохын төлөө ажилладаг.

Эх сурвалж: *Miss Representation*, <<http://www.missrepresentation.org/>>.

276 MediaWatch, <<http://www.mediawatch.com/>>.

мэдээллээр тэнцвэртэй хүргэх, мөн улс төрд жендэрийн тэгш байдлыг дэмжих зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн ажиллах талаар авч үзэв.

→ **Хэвлэл мэдээллээс улс төр дэх эмэгтэйчүүдийн талаар хэрхэн жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтоор хандаж байгааг илрүүлэх**

ЕАБХАБ-ын хэд хэдэн оронд хийгдсэн олон нийтийн мэдээллийг хэрэгслийн судалгаанд²⁷⁷ улс төрд жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг хэвлэл мэдээлэл бүтээж, улам лавшруулж байдгийг харуулсан. Тухайлбал, эмэгтэйчүүд улс төрд өрсөлдөх шаардлагагүй гэсэн ойлголт нь эрэгтэйчүүдийг төрийн хэрэг, эмэгтэйчүүдийг гэр бүлтэй хамаатуулж ойлгодогтой ихэвчлэн холбоотой байдаг. ИНБ-уудаас хэвлэл мэдээллээр түгээж буй жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг илрүүлэх, анхаарал хандуулахад чухал үүрэг гүйцэтгэж чадна. Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлын суурь болгон түгээмэл хэрэглэж буй хэвшмэл ойлголтуудыг цуглуулж, түгээж болно. Тухайлбал, Оросын иргэний нийгэм, жендэрийн шинжээч эмэгтэй Людмила Воронова Орост эмэгтэй улс төрчдийн талаар хэвлэл мэдээллээс түгээж буй худал ойлголтын талаар судалгаа хийж, зургаан худал ойлголт, түүний ард буй зургаан бодит үнэнийг багтаасан жагсаалт гаргасан байна (Шигтгээ 5.21).

Хүснэгт 5.21. Эмэгтэй улс төрчдийн талаар хэвлэл мэдээллээр түгээж буй худал ойлголт ба бодит байдал

Худал ойлголт	Бодит байдал
Худал ойлголт № 1. Эмэгтэй хүн бүрт гадаад харагдах байдал чухал. Үнэхээр сайхан эсвэл онцгүй харагдаж байвал тэр эмэгтэй юу ярих нь сонин гэж үү?	Бодит байдал № 1. Ямар улс төрчийн хувьд гадаад харагдах байдал чухал, энэ нь түүний дүр төрхөө бүрдүүлэх аргын нэг хэсэг болж байдаг.
Худал ойлголт № 2. Эмэгтэй хүн эхнэр, ээж байх ёстой. Улс төрийн карьерыг гэр бүлийн амьдралтай хослуулах боломж үнэхээр бий гэж үү? (“Нөхөр юу гэх бол? Хүүхдээ хэнтэй үлдээх вэ?”) Тэр эмэгтэй улс орны иргэдэд сайн “ээж”, “үнэнч эхнэр” байж чадах үү?	Бодит байдал № 2. Ямар ч улс төрч, ялангуяа эмэгтэй удирдагч нар “ердийн” эмэгтэй хүний оруулж буй хувь нэмэр, нийгэмд гүйцэтгэх үүргийг үнэлж, эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралд идэвхтэй оролцохыг нь дэмжиж байх ёстой.
Худал ойлголт № 3. Тухайн эмэгтэй хүн эрх мэдэлд хүрэх боломж олгосон бол тэр ямар ч алдаа гаргах эрхгүй. Тухайн эмэгтэй мүү улс төрч бол эмэгтэй юм чинь гэдэг, харин сайн улс төрч бол тэр жинхэнэ эмэгтэй хүн биш, хувийн амьдралгүй хүн гэдэг.	Бодит байдал № 3. Эмэгтэй улс төрч гэдэг бол бас эмэгтэй л хүн. Түүний хүйс эерэг шинж чанар байх ёстой болохоос эрх мэдэлд хүрэхэд учрах саад бэрхшээл байх ёсгүй. Эмэгтэй улс төрчийг эмэгтэй гэдгээр нь шүүмжлэх нь шударга бус.
Худал ойлголт № 4. Улс төр бол бохир ажил, эмэгтэй хүн бо цэвэр, ариун ... тиймээс эмэгтэй хүнд улс төрд орох зай талбар байна уу? Эмэгтэй хүнд улс төрд орох хэрэг ер нь байна уу?	Бодит байдал № 4. Эмэгтэй улс төрчид гэдэг бол нэгдмэл/ нэг янзын бүлэг биш. Тэд өөр өөр, мөн улс төрд илүү олноороо байх ёстой. Улс төрд эмэгтэйчүүдийн тоо өсөх нь заавал феминизм өсөн дэлгэрч буй хэрэг биш. Улс төрд хүйс/жендэрээс үл хамааран бүгд адил хууль тогтоомж, дүрэмд захирагдах ёстой.

277 “Imagina Femeii si a barbatului in presa scrisa. Studiu de gen”, Center “Partnership for Development”, 2007, <http://www.progen.md/files/4290_studiu_img_fb_presa.pdf>; Людмила Воронова, “Женщины-политики в СМИ: мифы и анти-мифы”, (Ljudmila Voronova, “Women-politicians in Mass Media: myths and anti-myths”) Mediascop, Vol. 2, 2009, <<http://mediascope.ru/node/345>>.

Худал ойлголт № 5.

Эмэгтэй хүн бол улс төрд онцлог ховор зүйл юм, тиймээс хэвлэл мэдээлэл тэрхүү өвөрмөц нөхцөл байдлыг онцлон тэмдэглэж, эрх мэдэлд хүрэх хичнээн хэцүү болохыг, мөн эрэгтэйчүүдээс дарамт учруулдаг зэргийг өгүүлдэг байх ёстой.

Бодит байдал № 5.

Тэгш байдал, тэгш эрхийг тогтоох нь аливаа улс орны хамгийн чухал зорилго байх ёстой. Эмэгтэйчүүдийг улс төрд ховор зүйл гэж хардаг байж таарахгүй.

Худал ойлголт № 6.

Эмэгтэй хүн өөрөө улс төрд орж чадахгүй: түүнд нөлөө бүхий эрхтэй улс төрчийн дэмжлэг хэрэгтэй.

Бодит байдал № 6.

Эмэгтэй улс төрч бол “өөрчлөлтийн элч” байх ёстой. Тэр эрх мэдлийг улс орныхоо (дэлхий ертөнцийн) сайн сайхны төлөө өөрчлөлт хийхэд ашигладаг.

Эх сурвалж: Людмила Воронова, “Женщины-политики в СМИ: мифы и анти-мифы”, (*Liudmila Voronova, “Womenpoliticians in Mass Media: Myths and anti-myths” Mediascop, Vol. 2, 2009. <<http://mediascope.ru/node/345>>*).

→ Эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн дүрсэлж байгаа талаар судалгаа хийх

Өмнөаргатай адил, ИНБ-ууд нь судалгааны болон хэвлэлийн хүрээлэнтэй хамтран улс төрд буй эмэгтэйчүүдийн талаар, ялангуяа сонгуулийн сурталчилгааны үеэр тэднийг хэвлэл мэдээллээр хэрхэн дүрслэн харуулж байгаа талаар судалгаа хийж болно. Одоо хийгдээд буй судалгаанаас үзэхэд эмэгтэй улс төрчдийг эрэгтэй улс төрчдөөс ихэнхдээ өөрөөр дүрслэн харуулдаг. Эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд гадаад байдал, гэрлэсэн эсэх, гэр бүлийн байдал, эмэгтэйлэг шинж зэргийг нь дүрслэн харуулдаг бол эрэгтэйчүүдийг улс төрийн үйл ажиллагаагаар нь үнэлэх байдал их гардаг.²⁷⁸

Түүнчлэн зарим ажиглагчдын үзэж байгаагаар, ялангуяа нэр дэвшигчийн хувийн болон албаны үүрэг хариуцлагаа тэнцвэртэй авч явах чадвартай эсэх асуудлаар сэтгүүлчид эрэгтэй, эмэгтэй хүмүүст өөр өөр асуулт тавьдаг. Заримдаа эмэгтэй улс төрчөөс нөхөр, хүүхдийнх нь үйлдлийн төлөө хариуцлага нэхдэг бол эрэгтэй улс төрчөөс яг адил зүйлийг бараг шаарддаггүй.²⁷⁹ Мэдээж эмэгтэй улс төрчдийг хэвлэл мэдээллээр дүрслэн гаргаж харуулж байгаа тохиолдлын хувьд ийм байна. ЕАБХАБ-ын олон орны хувьд

Шигтгээ 5.22. Польш: Сонгуулийн сурталчилгааны үеэр эмэгтэйчүүдийг системтэйгээр ялгаварлан гадурхаж байв

Польшийн Төрийн захиргааны хүрээлэнгээс сонгуульд өрсөлдөөд сонгогдох эсэхэд нэр дэвшигчийн дүр төрх чухал үүрэгтэй байдгийг үндэслэн 2011 оны парламентын сонгуулийн үеэр нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр хэрхэн сурталчилж байгаа талаар судалгаа хийжээ. Судалгааны дүн эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийг сурталчлахад жендэрийн ялгаа их байгааг харуулсан байна. Юуны өмнө, эмэгтэйчүүд олон нийтийн телевизийн сувгаар үнэгүй олгодог нэвтрүүлгийн цагаар эрэгтэйчүүдээс цөөн гарсан байна. Хоёрдугаарт, ихэнх хугацаанд тэднийг гэр бүлийн талаар баримтлах бодлогын тухай ярьж байхад эсвэл уламжлалт гэр бүлийн үүргээ гүйцэтгэж байгаагаар харуулж байв. Гуравдугаарт, аль ч эмэгтэй нэр дэвшигчийг гадаад бодлого, үндэсний түвшний бусад тулгамдсан асуудлаар ярьж байгаагаар гаргаагүй байна.

Эх сурвалж: E. Rekosz, “Women and men in television electoral campaign, Parliamentary elections of 2011”, *Institute of Public Affairs, Warsaw, 2012.*

278 For example, see “Куда заведут ножи Кондолизы?”, Московский комсомолец, 8 February 2005.

279 “Media Coverage of Women Political Candidates”, <<http://www.saddleback.edu/faculty/agordon/documents/WomanCandidates.pdf>>.

эмэгтэй улс төрчид хэвлэл мэдээллээр тэр бүр гардаггүй бөгөөд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийн тооны харьцааг бодолцож үзсэн ч хэвлэл мэдээллийнхэн эмэгтэй гэхээсээ эрэгтэй нэр дэвшигчийг л илүү гарган харуулдаг.

Польшийн Төрийн захиргааны хүрээлэнгээс 2011 оны парламентын сонгуулийн өмнө ба дундуур нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр хэрхэн дүрслэн харуулж байгаа талаар судалгаа хийж, эрэгтэй нэр дэвшигчдэд илүү таатай хандан, жендэрийн илэрхий ялгаа гаргаж байсныг илрүүлсэн (Шигтгээ 5.22). Түүнчлэн Сербид 2008 онд Жендэрийн тэгш байдлын хүрээлэн, UNIFEM (одоогийн UN Women)-ээс Нова Садын Сэтгүүл зүйн сургуулийн “Эмэгтэй нэр дэвшигч” төсөлд дэмжлэг үзүүлсэн бөгөөд тус төсөл нь 2008 онд Сербийн Войводина мужид орон нутгийн болон аймгийн сонгуулийн үеэр эмэгтэй нэр дэвшигчдийн хэвлэл мэдээллээр хэрхэн дүрслэн харуулж байгааг судалсан. Төслийн хүрээнд оюутнууд тоон болон чанарын мониторингийн аргыг ашиглан сонгуулийн сурталчилгаа зогсоох өдөр хүртэл ажиглалт хийсэн. Төслийн тайланд дээрх сонгуулийн үеэр эмэгтэй нэр дэвшигчид бараг харагдаагүй болохыг илрүүлж, тайланг олон нийтэд хүргэсэн байна.²⁸⁰

→ **Улс төр дэх эмэгтэйчүүдийг хэрхэн жендэрийн мэдрэмжтэй сурвалжлах талаар сэтгүүлчдийн сургалт хийх**

Улс төрд буй эмэгтэйчүүдэд жендэрийн хэвшмэл ойлголтоор хандсаар байгаа, түүнийг хэвлэл мэдээлэл улам лавшруулж байгаа тул сонгууль, сонгуулийн сурталчилгааны үеэр эмэгтэйчүүдийг хэрхэн бодитой сурвалжлан харуулах талаар сэтгүүлчдийг сургахад ИНБ чухал үүрэг гүйцэтгэдэг. Сонгуулийн сурталчилгааны ажлын жендэрийн мэдрэмжийн талаар сэтгүүлчдэд ойлголт өгснөөр тэдэнд улс төрийн нам, удирдлагын жендэрийн тэгш байдлын талаар өгсөн амлалтыг хянах, мөн засгийн эрхэнд гарсны дараа түүнийг хэр биелүүлж байгааг тайлагнах урам зориг бий болно. Хэвлэл мэдээллийн тусламжтайгаар ИНБ эмэгтэй нэр дэвшигч, идэвхтэн, сонгогчдод тулгарч буй онцлог бэрхшээлийг олон нийтийн анхааралд хүргэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн ололт амжилтыг ч мэдээлж болно. Мөн улс төрийн сурвалжлага хийдэг эмэгтэй сэтгүүлчдийн тоог нэмэгдүүлэхийн тулд эмэгтэй сэтгүүлч, сэтгүүлч болохыг хүсч буй эмэгтэйчүүдэд ч сургалт хийж болно.

→ **Олон нийтийн хэлэлцүүлэг, арга хэмжээнд эмэгтэйчүүд оролцоход нь дэмжлэг үзүүлэх**

Иргэний нийгмийн бүлгүүд эмэгтэйчүүд улс төрийн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэгт ороход нь дэмжлэг үзүүлж, практик зөвлөгөө өгөх, сургалт явуулах, мөн гол асуудлаар бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулж, эмэгтэй улс төрчдийг оролцуулах замаар тэдний олон нийтийн дунд нэр хүндээ өсгөхөд нь дэмжлэг үзүүлж болно. Мөн хэвлэл мэдээлэл, жендэрийн шинжээчид, шинэчлэх хүсэлтэй хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагатай хамтран эмэгтэй нэр дэвшигчид болон олон эмэгтэй нэр дэвшүүлсэн улс төрийн намууд, мөн сурталчилгаандаа эмэгтэйчүүдийг оруулж буй намуудад нэвтрүүлгийн үнэгүй илүү цаг олгох нөлөөллийн ажил хийж болно.

280 For more information on this project and the report findings, see <http://www.novinarska-skola.org.rs/NNS2/index_en.html>.

Шигтгээ 5.23. Хэвлэл мэдээлэл дэх эмэгтэй улс төрчдийн дүр төрх: ОУПХ-ны зөвлөмж

- Улс төрчдийн дүр төрхийг бүрдүүлэх хэвлэл мэдээлэл асар чухал. Нийгэм, соёлын уламжлалт зүй тогтлыг даган дуурайхын оронд хэвлэл мэдээлэл өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлж, улс төрд эмэгтэйчүүдийн эерэг дүр төрхийг бүтээх боломжтой.
- Редактороос сэтгүүлч хүртэл, хэвлэлийн газраас тоймч хүртэл хэвлэл мэдээллийн бүхий л ажилтан борлуулалтад нөлөөлдөг “материал” бол жендэрээс үүдэлтэй зүй тогтол, хэвшмэл ойлголтыг бататгаж, төлөөллийн ардчиллыг сулруулж байдаг гэдгийг мэддэг байх хэрэгтэй.
- Улс төрд санхүүжилт чухал байгаа орчин нөхцөлд нэр дэвшигчийг хэвлэл мэдээллээр сайн сурталчилах нь санхүүгийн дутмаг байдлыг зарим талаар нөхөх боломжтой.
- Эмэгтэй улс төрчид хэвлэл мэдээллийг илүү сайн ойлгодог, мөн ярилцлага, хэвлэлийн бага хурал, илтгэл, хэвлэлийн мэдээ зэргээр дамжуулан өөрийн санааг хэрхэн хүргэх талаар мэдэж авах хэрэгтэй.
- Эмэгтэйчүүд санаагаа, ололт амжилтаа илүү өөртөө итгэлтэй илэрхийлдэг байх хэрэгтэй. Учир нь хүйсээс үл хамааран хэвлэл мэдээлэл санаагаа тод гаргаж, өөрийн зорилгод итгэлтэй байгаа хүнийг нэвтрүүлэх, дамжуулах хандлагатай байдаг.
- Хэвлэл мэдээлэл эмэгтэй улс төрчдийг улс төрийн гол тоглогч гэхээсээ эмэгтэй хүн, эд зүйл маягаар хандах тал бий.
- Эмэгтэй улс төрчдийг хэвлэл мэдээлэл эрэгтэй улс төрчидтэй адил сурвалжилж гаргадаггүй. Аливаа асуудлыг сурвалжлахдаа сэтгүүлч нар зөвхөн эрэгтэй улс төрчдөөс ярилцлага авдаг байж болохгүй.
- Хэвлэл мэдээлэл эмэгтэй улс төрчдийн санаа зовж буй зүйл, тэдний ололт амжилтанд эрэгтэй улс төрчдийнхөөс бага анхаарал хандуулдаг.
- Хэвлэл мэдээллийн байгууллага эмэгтэйчүүдийг улс төрд оруулснаар ардчилал бэхжинэ гэдгийг ойлгож байгаа бол ардчилсан үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг байгууллага болохын хувьд үг санааг байж болох бүх л хэлбэрээр нь түгээх ёстой.
- Засгийн газрууд мэдээлэл харилцааны бодлогоо жендэрийн мэдрэмжтэй болгож, эмэгтэй улс төрчдийн дүр төрхийг тэгш, шударга хүргэдэг байх үүднээс үг бодлогоо өөрчлөх ёстой.

Эх сурвалж: Улс төр дэх эмэгтэйчүүд, Олон улсын парламентын холбоо, <<http://www.ipu.org/wmn-e/media.htm>>.

5.1.5. Судалгааны байгууллагатай ажиллах

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих үүднээс судалгааны байгууллагатай ажиллах нь ЕАБХАБ-ын олон улс оронд түгээмэл биш байна. ИНБ, эмэгтэй улс төрчид энэ ажлыг үр нөлөөг дутуу үнэлдэг. ИНБ-үүд эмэгтэй нэр дэвшигч элсүүлэх, сургах, олон нийтэд мэдлэг ойлголт өгөх, мөн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжсэн нотолгоо бүхий судалгаа хийх, жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтын талаар нийгэмд мэдээлэл өгөх зэрэгт судалгааны байгууллагатай хамтран ажиллаж болно. Амжилттай хамтран ажилласан зарим жишээг дор өгүүлэв.

→ Эмэгтэйчүүдэд зориулсан улс төр, бодлогын асуудлаарх академик сургалтыг санаачлан зохион байгуулах, дэмжих

Зарим улс оронд нэр дэвших сонирхолтой эсвэл нэр дэвшсэн эмэгтэйчүүдэд зориулсан тусгай сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Тухайлбал, АНУ-д Ратжерс их сургуулийн Улс төр дэх Америк эмэгтэйчүүдийн төвөөс их сургуулийн эмэгтэй оюутнуудын улс төрийн мэдлэг оролцоог өргөжүүлэх зорилготой

хөтөлбөрийг нийт 25 мужийн сургалтын байгууллагуудыг хамруулан зохион байгуулдаг.²⁸¹ Тус хөтөлбөр нь их сургуулийн эмэгтэй оюутнуудад улс төр, бодлого боловсруулах мэдлэг олгох, мөн улс төрийн идэвхтэй байх сэдэл төрүүлэх зорилгоор зун явагддаг 6 хоногийн эрчимтэй сургалт юм.

Сургалт нь улс төрийн янз бүрийн соёл, газар зүйн байршил, хүн амын бүлэг, байгууллагаас ирсэн хүмүүст зориулан тохируулж болох суурь бүхий зургаан бүрдэл хэсэгтэй (Шигтгээ 5.24).

Сант Луис-Миссурийн их сургууль мөн Улс төр дэх эмэгтэйчүүдийн Сью Шиэр хүрээлэн ажиллуулдаг бөгөөд уг хүрээлэнгээс²⁸² эмэгтэйчүүдийг бодлого боловсруулах үйл явцад бүрэн оролцохыг дэмжих замаар засгийн газар Миссурийн бүх иргэдэд хүртээмжтэй байхад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Тус хүрээлэнгээс оюутнуудад 21 дүгээр зууны манлайллын академийн хүрэнд улс төр, төрийн хэрэгт эмэгтэйчүүдийн манайллын хэрэгцээний талаар мэдлэг боловсрол олгодог. Мөн тус хүрээлэнгээс улс төрд орох сонирхолтой эмэгтэйчүүдийн мэдээллийн сан ажиллуулахын зэрэгцээ эмэгтэйчүүдийн улс төрд орох хүслийн талаар албан тушаалтнуудад мэдлэг ойлголт өгч, “Улс төрд орох зам” сурталчилгааны ажлаар дамжуулан эмэгтэйчүүдэд төрийн албанд ажиллах арга замын талаар мэдээлэл өгдөг.²⁸³

→ **Улс төр дэх эмэгтэйчүүд, жендэрийн тэгш байдлын талаар материал, судалгааны мэдээлэл цуглуулах**

Иргэд, улс төрд орох сонирхолтой хүмүүст хэрэгтэй мэдээлэл, тоо баримт цуглуулах, мэдээллийн сан бий болгоход судалгааны байгууллагууд их тус болдог. Тухайлбал, Ратжерс Их сургуулийн Улс төр дэх Америк эмэгтэйчүүдийн төвөөс эмэгтэй улс төрчдөд хэрэгтэй нийт улс орныг хамарсан мэдээллийн интерактив санг бий болгосон. Энд нам бус манлайллын хөтөлбөрөөс эхлээд сонгуулийн сурталчилгааны ажлын сургалт, түүнчлэн улс төрийн намын улс төрийн ажлын хороод хүртэл үндэсний болон мужийн түвшний мэдээлэл бий. Уг мэдээллийн санг АНУ-д төвтэй Хант Алтернатив сан гэдэг нам бус санаачилгын хүрээнд байгуулжээ²⁸⁴. Квинс Белфаст Их сургуулийн Улс төрд эмэгтэйчүүдийн дэвшил төвийн хувьд Их Британи, Ирландын улс төр дэх эмэгтэйчүүдийн талаарх судалгаа, мэдээллийг цуглуулдаг. Тус байгууллагын цахим хуудсанд “Ажиглагч” гэдэг мэдээллийн сан байдаг бөгөөд үндэсний болон орон нутгийн эмэгтэй төлөөлөгч, мөн нам тус бүрээс сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь зэргийг харуулдаг²⁸⁵.

Шигтгээ 5.24. АНУ-ын Шинэ манлайллын хөтөлбөр: 3 бүрдэл хэсэг бүхий хөтөлбөр

1. Эмэгтэйчүүдийн улс төр, бодлого боловсруулахад оролцох асуудлын түүхэн явц болон орчин үеийн олон янзын арга замын талаар оюутнуудад заах.
2. Оролцогчдыг нийтийн амьдралд өөрчлөлт гаргасан эмэгтэй улс төрчидтэй холбох.
3. Олон янзын нөхцөл байдал бүхий нийгэмд манлайллын эрэлт хэрэгцээ ямар байгааг оюутнууд олж мэдэхэд туслах.
4. Оролцогчдын манлайллын үр чадварыг хөгжүүлэх.
5. Оюутнууд үйлдлээрээ манлайллыг хэрэгжүүлэх бололцоо олгох.
6. Оюутнуудад карьераа ахиулах, өргөжүүлэхэд дэмжлэг болох ажилд татан оролцуулах.

Эх сурвалж: “Шинэ манлайлал”, Америк эмэгтэйчүүд ба улс төр төв, Улс төр судлалын Ийглтон хүрээлэн, Ратжерс их сургууль, <http://www.cawp.rutgers.edu/education_training/NEWLeadership/index.php>.

281 “New Leadership”, Education and Training, Center for American Women and Politics, Eagleton Institute of Politics, Rutgers University, <http://www.cawp.rutgers.edu/education_training/NEWLeadership/index.php>.

282 Sue Shear Institute for Women in Public Life, <<http://www.umsl.edu/sueshear/>>.

283 “21st Century Leadership Academy”, Sue Shear Institute for Women in Public Life, <<http://www.umsl.edu/sueshear/21st%20Century%20Leadership%20Academy/index.html>>.

284 Political Parity, <<http://www.politicalparity.org>>.

285 Centre for Advancement of Women in Politics, <http://www.qub.ac.uk/cawp/observatory.html>.

Шигтгээ 5.25. Украйны улс төр дэх эмэгтэйчүүдийн талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа

Украйны Эмэгтэйчүүдийн сан гэдэг ТББ-д зориулан Ардчилсан санаачилгын сан ба Украйны социологийн үйлчилгээ гэдэг байгууллагаас хийсэн судалгаанаас дараахь дүгнэлт хийжээ. Үүнд:

- Украйны сонгогчид улс төрд жендэрийн тэнцвэртэй оролцоог хангах асуудлыг улс төрийн намаас илүү дэмжиж байна;
- Сонгогчдын 47% нь орон нутагт эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийг дэмжиж байгаа бол дөнгөж 25% нь эсрэг байр суурьтай байна;
- Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 34% нь улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжиж байгаа бол 34% нь “шаардлагагүй” гэж үзжээ;
- Судалгааны оролцогчдын 53% нь намын жагсаалтанд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш төлөөлөлтэй байхыг хуулинд тусгахыг дэмжиж байна (үүнд эмэгтэйчүүдийн 61%, эрэгтэйчүүдийн 40% дэмжсэн);
- Улс төрийн нам, улс төрийн байгууллагын удирдах албан тушаалд тохирох эсэхийг тодорхойлоход жендэр нэг хүчин зүйл байх ёсгүй гэж үзсэн байна;
- Харин харгалзан үзэх ёстой хүчин зүйлд “зөв зан чанар, үр чадвар, чадавх” зэргийг дурдсан байна.

Эх сурвалж: Украйны эмэгтэйчүүдийн сан, Украйны улс төр, шийдвэр гаргалтанд эмэгтэйчүүдийн оролцоо: Арга зам, 2011.

Улс төр судлалын шинжлэх ухааны болон бусад холбогдох хэд хэдэн судалгааны сүлжээ бий болж, жендэрийн тэгш байдал, улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн асуудлаар тайлан илтгэл, нийтлэл, тоо баримтыг тогтмол гаргаж байна. Үүнд Жендэрийн улс төр батер судалгааны сүлжээ,²⁸⁶ Улс төр судлалын нийгэмлэг,²⁸⁷ Эмэгтэйчүүд ба улс төр бүлэг, Улс төр судлалын судалгааны Европын консорциумын Жендэр ба улс төрийн байнгын бүлэг,²⁸⁸ Ирландын Улс төр судлалын нийгэмлэгийн Жендэр ба улс төр сэдвээр дагнасан бүлэг²⁸⁹, мөн Эмэгтэйчүүд ба улс төр бүлэг болон эмэгтэйчүүдийн бүлгийн аль алиныг агуулдаг Америкийн улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг зэргийг дурдаж болно. Их Британий Сара Чайлдс зэрэг эрдэмтэд улс төрийн намын мөрийн хөтөлбөр, сонгуулийн амлалт гол гол сонгууль болохоос өмнө жендэрийн өнцгөөс тогтмол хянан аудит хийж байна.

Литвад байршилтай Жендэрийн тэгш байдлын Европын хүрээлэн²⁹⁰ мөн анхан шатны байгууллагууд жендэрийн тэгш байдлыг дэмжих, хүйсээр ялгаварлах явдалтай тэмцэх, жендэрийн тэгш байдлын асуудлаар ойлголт мэдлэг нэмэгдүүлэх чиглэлээр өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж болох олон зүйлийг цахим хуудсандаа тавьсан байдаг.

Олон улсын Ардчилал, сонгуулийн туслалцааны хүрээлэн, Стокгольмын их сургууль, Олон улсын парламентын холбооноос Эмэгтэйчүүдийн квотын олон улсын мэдээллийн санг²⁹¹ ажиллуулж байгаа бөгөөд түүнд нийт улс орны хуулиар тогтоосон болон сайн дурын квотын талаар мэдээллийг оруулж, байнга шинэчилж байдаг. Түүнчлэн хэд хэдэн байгууллага жендэрийн тэгш байдлын үзүүлэлт бүхий жагсаалтыг жил бүр гаргадаг. Үүнд:

286 Research Network on Gender Politics and the State (RNGS), <<http://libarts.wsu.edu/pppa/rngs/index.html>>.

287 Political Studies Association (PSA), <<http://www.psa.ac.uk/>>.

288 Standing Group on Gender and Politics, <<http://www.ecpr.eu/StandingGroups/StandingGroupHome.aspx?ID=8>>.

289 Gender and Politics Specialist Group, <<http://psai.ie/specialist/gender.asp>>.

290 European Institute for Gender Equality (EIGE), <<http://www.eige.europa.eu/>>.

291 Global Database of Quotas for Women, International IDEA, Stockholm University and Inter-Parliamentary Union, <<http://www.quotaproject.org/>>.

- НҮБХХ-ийн Жендэрийн тэгш байдлын индекс;²⁹²
- Дэлхийн эдийн засгийн форумын²⁹³ Жендэрийн ялгаатай байдлын тайлан;²⁹⁴
- Олон улсын парламентын холбооны тайлан.²⁹⁵

Эдгээр материалыг жендэрийн тэгш байдал, улс төр, төрийн ажилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бодлого, эрх зүйн шинэчлэл хийхэд нотолгоо болгох ашиглахад хэрэгтэй бөгөөд тодорхой асуудал, бодлогын сурталчилгаа хийж буй улс төрийн намууд ч ашиглахад тохиромжтой.

→ Улс төр дэх эмэгтэйчүүдийн талаар нотолгоонд суурилсан судалгаа хийх

ИНБ дангаараа эсвэл судалгааны байгууллагатай хамтран улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар сонгогчдын байр суурь, хандлагын талаар судалгаа хийж болно. Тухайлбал, Украйнд Украйны эмэгтэйчүүдийн сангаас Ардчилсан санаачилгын сан, Украйны социологийн үйлчилгээ гэдэг байгууллагатай хамтран улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар улс орныг хамарсан судалгаа хийсэн бөгөөд түүнд сонгогчдын хандлагыг хүйсээр ялган гаргажээ.

Улмаар улс төрд тэнцвэртэй оролцоотой байхыг сонгогчид улс төрийн намуудаас ч илүү дэмжиж байгааг тогтоосон байна. Сонирхолтой нь, Украйнд жендэрийн хэвшмэл ойлголт хүчтэй байгаа ч судалгаанд оролцогчдын 53 хувь нь намын жагсаалтанд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш тоотой байхыг дэмжсэн хуулийн заалт батлахыг дэмжсэн байна. Гэхдээ ийнхүү дэмжсэн ч судалгааны оролцогчдын хандлагын хувьд хүйсийн ихээхэн ялгаа ажиглагдсан бөгөөд дээрх арга хэмжээг эмэгтэйчүүдийн 61 хувь, эрэгтэйчүүдийн 40 хувь дэмжсэн байжээ. Уг судалгаанд улс төрийн нам, улс төрийн байгууллагад удирдах албан тушаал хашихад тохирох эсэхийг тодорхойлоход жендэр чухал үзүүлэлт биш гэж судалгаанд оролцогчид үзэж байгааг онцлон тэмдэглэсэн байна. Судалгаанд оролцогчид “зөв зан чанар, үр чадвар, чадавх” зэргийг л улс төрийн өндөр албан тушаалд тохирох эсэхийг тодорхойлохдоо харгалзаж үзэх ёстой гэжээ.²⁹⁶

→ Бодлогын шинэчлэлийг дэмжихийн тулд төрийн бодлогын жендэрийн мэдрэмжийн талаар судалгаа хийхийг дэмжих

ЕАБХАБ-ын улс орнуудад ИНБ, судалгааны байгууллагаас гадна think tank байгууллагууд бодлогын шинэчлэл хийх сурталчилгаа хийх, засаглалын асуудлаар иргэн, төрийн байгууллагыг холбоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

АИХЭА-наас ЕАБХАБ-ын улс орнуудад төрийн бодлогын чиглэлээр ажиллаж буй think tank-ууд улс төрийн намын тухай хууль тогтоомж нь олон улсын улс төрийн намын зохицуулалтын стандарт, сайн практикт хэр нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Үүнд намын бүртгэл, нэр дэвшигчийн бүртгэл, нам ба сурталчилгааны ажлын санхүүжилтийн хуваарилалт, тайлагналтанд тавигдах шаардлага, зохицуулалтын байгуулалтын гүйцэтгэх үүрэг зэргийг судлан шинжлэх ажил багтдаг. Тухайлбал, өнгөрсөн таван жилд АИХЭА-наас Гүрж дэх Кавказын Энх тайван, ардчилал, хөгжлийн хүрээлэн, Молдавын IDIS-Viitorul, Тажикистаны Улс төр судлаачдын үндэсний нийгэмлэг, Украйны Эрх зүйн санаачилгын агентлаг зэрэг байгууллагатай хамтран ажиллаж, хүчинтэй үйлчилж буй улс төрийн намын талаарх хууль тогтоомж нь олон улсын стандартай хэр нийцэж байгааг шинжлэн судалсан байна.

292 “Gender Inequality Index (GII)”, Human Development Reports, UNDP, <<http://hdr.undp.org/en/statistics/gii/>>.

293 World Economic Forum (WEP), <<http://www.weforum.org/>>.

294 “The Global Gender Gap” World Economic Forum (WEP), <<http://www.weforum.org/issues/global-gender-gap>>.

295 Inter-Parliamentary Union (IPU), <<http://www.ipu.org/gpr-e/about/index.htm>>.

296 Ukrainian Women’s Fund, Women’s Participation in Politics and Decision-Making in Ukraine: A Strategy Paper, Kiev, 2011, p.13.

Улс төрийн намын тухай хууль тогтоомжийг шинжлэн үзсэнээр эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарч буй эрх зүйн болон практик бэрхшээлийг илрүүлэн гаргах боломжтой. Тухайлбал, АИХЭА, Европын зөвлөлийн Венецийн зөвлөлөөс гаргасан Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамжид үндэсний улс төрийн намын тухай хууль тогтоомж даган мөрдөх ёстой жендэрийн тэгш байдлыг олон улсын стандартыг тодорхойлсон. Түүнчлэн тус Удирдамжид намын дотоод үйл явц, журмаа ил тод болгох, эрэгтэй, эмэгтэй хүмүүст шударга, тэгш болгох үүднээс улс төрийн намууд дотооддоо нэвтрүүлж болох механизмуудыг заасан байдаг. Төрийн бодлогоын чиглэлээр ажиллаж буй think tanks ИНБ, жендэрийн шинжээчидтэй хамтран улс төрийн намын зохицуулалтын (дотооддоо болон улс орны хэмжээнд) жендэрийн дүн шинжилгээг хийж, хууль тогтоомжид оршин буй жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхлыг илрүүлэн, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй эн тэнцүү улс төрийн үйл явцад оролцоход саад болж буй заалтуудыг судлан гаргах боломжтой.




Эх сурвалж: Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамж (Warsaw: OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, 2010), <<http://www.osce.org/odihr/77812>>.

АИХЭА-наас тухайн улс оронд улс төрийн намын тухай хууль тогтоомж нь эмэгтэйчүүдэд, мөн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэн нөлөөллийн шинжилгээ хийхийг дэмждэг. Тухайлбал, Тажикистанд NAPST улс төрийн намын тухай хууль тогтоомж дахь нэр дэвшигчийн бүртгэлийн талаарх заалт нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан байж болохыг тогтоосон. Тажикистаны парламентын сонгуульд нэр дэвшигчээс байршуулах ёстой мөнгөн дүн нь хэт өндөр байв. 2005 оны байдлаар нэг нэр дэвшигчийн бүртгэлийн урьдчилан байршуулан мөнгө нь €600 байсан бол 2010 онд €1,100 болж өссөн. Энэ шинэчилсэн дүн нь сарын дундаж цалингаас ойролцоогоор 24 дахин өндөр юм. Энэ заалт нь бүх нас, хүйс, мэргэжлийн хүмүүст нөлөөлж байгаа нь ойлгомжтой боловч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс хамаагүй бага цалин авдаг тул эмэгтэйчүүдийг илүү хохиролтой байдалд оруулж байж болзошгүй юм.

Түүнчлэн Тажикистаны сонгуулийн тухай хуульд парламентын сонгуульд нэр дэвшигч нь дээд боловсролтой байхаар заасан. Тажикистаны эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмшсэн байдлыг харгалзан үзвэл энэ заалт нь мөн эмэгтэй нэр дэвшигчдэд илүү хохиролтой тусч байх магадлалатай. Тухайлбал, 2008 онд дээд боловсрол эзэмшиж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа 40:1 байв.²⁹⁷ Мөн “наад захын дэмжлэг” авсан гэдгээ харуулахад шаардагдах гарын үсгийн тоо өндөр байгаа нь дэмжигч, холбоотны сүлжээ бий болгож амжаагүй байгаа эмэгтэйчүүд, ялангуяа эмэгтэй нэр дэвшигчдийн эсрэг үйлчлэх боломжтой.

297 “Ratio of female to male tertiary enrolment (%)”, Data, World Bank Development Indicators, <<http://data.worldbank.org/indicator/SE.ENR.TERT.FM.ZS>>.



Эх сурвалж: *Парламентын гишүүдийн мэргэжлийн болон ёсзүйн стандартын талаарх судалгаа (Warsaw: OSCE/ODIHR, 2012), <<http://www.osce.org/odihr/98925>>.*

Шигтгээ 5.26. Гүржийн Сонгуулийн ерөнхий хорооны жендэрийн тэгш байдлын асуудлаарх байнгын комисс

Гүржийн Сонгуулийн ерөнхий хорооноос байгууллага дотроо болон сонгуультай холбоотой жендэрийн тэгш байдлын асуудлаар бусад талтай хамтран ажиллах зорилгоор “Жендэрийн тэгш байдлын асуудлаарх Сонгуулийн ерөнхий хорооны байнгын комисс” байгуулжээ.

Тус байнгын комисс нь Гүржид сонгуулийн шинэчлэлийг дэмжих, шинэчлэлийн үйл явц болон батлагдан гарах баримт бичгүүдэд жендэрийн асуудлыг тусгахад идэвхтэй оролцож ирэв. Тус комиссоос Финлянд, Нидерланд, Норвеги, Польшийн адил төстэй байгууллагад танилцах аялал зохион байгуулж, сонгууль хариуцсан байгууллага дахь жендэрийн тэгш байдлын сайн практикаас суралцсан бөгөөд зохицуулалтын болон парламентын төлөөлөлтэй уулзахаас гадна иргэний нийгмийн байгууллагуудтай уулзсан байна.

5.1.6. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллагатай ажиллах

ИНБ-уудаас албан тушаалтнууд амлалт, үүргээ хэр биелүүлж байгаагаа тайлагнадаг болгохын тулд гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ жендэрийн тэгш байдлын шинэчлэл хийхэд адил байр суурьтай албан тушаалтнуудтай хамтран ажиллаж болно. Тийм шинэчлэлийн дэмжих парламентын гишүүн байгаа бол жендэрийн тэгш байдлын төлөө институцын болон бодлогын суурь бий болгоход маш үр дүнтэй байдаг. Тиймээс энэ хэсэгт ЕАБХАБ-ын улс орнуудад улс төрд жендэрийн тэгш байдлыг дэмжих зорилгоор ИНБ-аас төрийн янз бүрийн байгууллагатай хэрхэн ажиллаж болох талаар авч үзлээ.

→ Жендэрийн мэдрэмжтэй институцын шинэчлэл хийх талаар парламенттай хамтран ажиллах

Парламент болон түүний гол гол хороод, байгууллага, гишүүдтэй ажиллах нь сонгуульд байгууллагад эмэгтэйчүүдийн нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд төдийгүй нийгэмд жендэрийн тэгш байдлыг тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд нэн чухал. Олон улс оронд ИНБ-ууд гол гол хууль хэлэлцэгдэх үед парламентын чуулганд оролцох эрх авсан байдаг. Мөн тэд жендэрийн тэгш байдлын асуудлаарх тухайн хуулийн заалтын талаар нам тус бүр ямар байр суурьтай байгааг хянаж, шинжлэн, түүнийг олон нийтэд мэдээлж болно. Сонгуулийн сурталчилгааны үеэр намуудын жендэрийн тэгш байдлын талаар баримталсан байр суурийг сонгогдсоны дараах бодит байдалтай харьцуулан шалгахад уг мэдээллийг мөн ашиглаж болно.


Түүнчлэн парламентын гишүүд чуулганы үеэр мэргэжлийн болон ёс зүйн хувьд биеэ хэрхэн авч явж байгааг иргэний нийгмийн байгууллага хянаж болох бөгөөд ялангуяа жендэрийн мэдрэмж шаардсан асуудлаар чуулганы үеэр эмэгтэй, эрэгтэй гишүүд өөр хоорондоо харилцаж буй байдлыг онцлон судалж болно. АИХЭА-наас 2012 онд парламентын гишүүдийн мэргэжлийн болон ёс зүйн стандартыг талаар судалгаа хийж нийтэлсэн. Сонгуульд албан тушаалтнуудыг хийсэн үйлдэл, зан үйлийнх нь төлөө хариуцлага тооцоход эдгээр стандартыг ашиглах боломжтой.

Үндэсний парламенттай хамтран ажиллах өөр нэг хэлбэр бол байгууллагын үйл ажиллагааны журамд жендэрийн тэгш байдлын асуудал хэрхэн туссаныг хянах зорилгоор жендэрийн аудит, мониторинг

хийхийг парламентын удирдлагаас хүсч, дэмжих явдал юм. Парламентын дүрэм журмыг эргэн нягтлах нь эрэгтэй, эмэгтэй улс төрчдөд ажлын тэгш талбар бий болгоход ихээхэн тустай юм. Эмэгтэйчүүдийн уламжлалт үүрэг нь улс төрийн карьертай авцалдахгүй гэсэн үзэл бодлыг үйл ажиллагааны дүрэм журам хэрхэн шууд ба шууд бусаар дэмжиж, эмэгтэйчүүд ба намын удирдлагуудыг тэгж бодоход хүргэж байгааг парламент авч үзэхийг нь дэмжих хэрэгтэй.²⁹⁸

→ Сонгууль зохион байгуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах

Сонгуулийг удирдан зохион байгуулдаг байгууллагын анхдагч зорилго бол иргэдийг *сонгох, сонгогдох эрхийг* хэрэгжүүлэх, хамгаалах явдал юм. Иймээс эдгээр байгууллага сонгуулийн үйл явцыг зохицуулах, олон улсын стандартай нийцүүлэх, сонгогчдын боловсрол олгоход гол үүрэг гүйцэтгэдэг. ИНБ эдгээр сонгууль зохион байгуулдаг байгууллагатай хамтран ажиллахын зэрэгцээ тэдний ажилд хараат бусаар хяналт тавих боломжтой. Хамтын ажиллагааны тухайд, ИНБ, сонгууль зохион байгуулдаг байгууллагууд сонгогчийн боловсролын төсөл хэрэгжүүлж, эмэгтэй, эрэгтэй сонгогчдод хуулиар олгогдсон эрхийг нь ойлгуулж, танилцуулах ажлыг хамтран хийж болно. Гэр бүл нэгнийхээ өмнөөс санал өгөх зэрэг жендэртэй холбоотой сонгуулийн тодорхой аль нэг будлианы эсрэг эсвэл ялангуяа хөдөө орон нутагт эрэгтэй, эмэгтэй хүмүүс аль аль нь саналаа өгөхийг уриалсан сурталчилгааны ажлууд хийж болно. Сонгуулийн зарим байгууллага жендэрийн тэгш байдлын асуудлаар тусдаа нэгж байгуулсан, мөн сонгогчийн боловсролын сурталчилгааны ажил болон бусад асуудлаар ажиллах сонирхолтой иргэний нийгмийн байгууллагын хандах цэг болгон ажиллуулж байна.



Эх сурвалж: Эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдлын асуудал. Хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан удирдамж (Warsaw: OSCE/ODIHR, 2012), <<http://www.osce.org/odihhr/97755>>.

Мөн ИНБ сонгуулийн зохицуулалтын байгууллага олон улсын болон үндэсний сонгуулийн стандартыг хангаж байгаа эсэхийг үнэлэх замаар тэдний ажилд хяналт тавьж болно. Тэд сонгуулийн хууль, түүнд оруулахаар санал болгож буй өөрчлөлт зэрэгт жендэрийн өнцгөөс шинжээчийн дүн шинжилгээ хийж болно. Мөн сонгуулийн орчныг сонгуулийн өмнө, үеэр болон дараа дотоодын сонгуулийн ажиглагч байдлаар үнэлж, сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр эмэгтэй нэр дэвшигчдэд хэр тусч байгаад дүгнэлт хийж болно. Тухайлбал, Орост хэд хэдэн ТББ, түүний дотор Оросын Чөлөөт сонгуулийн төлөөх сан, Иргэдийн сонгуулийн эрхийг хамгаалах зохицуулах хороо, Иргэний хяналтыг нийгэмлэг, мөн “Иргэний нийгмийн төлөөх хуульчид” ашгийн төлөө бус түншлэл²⁹⁹ зэрэг нь сонгуулийн үйл явцад идэвхтэй хяналт тавьдаг. Гэвч ИНБ, ялангуяа улс төрийн ямар нэг чиглэлийг баримталдаг бол сонгуулийн ажиглалт хийж буй төлөөлөгчдөө ямар нэг байдлаар сонгуульд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглож, ажиглалт хийхдээ хөндлөнгийн байр сууринаас ханддаг

298 See, for example: 15 förslag för en jämställd riksdag: Rapport från arbetsgruppen för en jämställd riksdag, [15Proposals for a Gender-equal Parliament], Riksdagstryckeriet, Stockholm, 2005, <http://www.riksdagen.se/sv/Dokument-Lagar/Ovriga-dokument/Ovrigt-dokument/15-forslag-for-en-jamstalld-ri_GSA5URF1/>.

299 Statement by Ms. Tatiana Voronova, Member of the Central Election Commission of the Russian Federation, at the supplementary human dimension meeting on democratic elections and election observation, 2012, <<http://www.osce.org/odihhr/elections/92169>>. Source: Handbook for National Human Rights Institutions on Women's Rights and Gender Equality (Warsaw: OSCE/ODIHR, 2012), <<http://www.osce.org/odihhr/97755>>.

байхад нь анхаарах шаардлагатай.³⁰⁰

Иргэний нийгэм, парламентын хоорондын мэргэжлийн түвшний хамтын ажиллагаа нь жендэрийн асуудлын хувьд харилцан суралцах үйл явц байж болно. Тухайлбал, жендэрийн асуудлыг илүү сайн ойлгодог болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Казахстаны Феминист лиг гэдэг байгууллага хэд хэдэн богино шторк хийж, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, тэгш бус цалин хөлс, эмэгтэйчүүдийн нийгэмд оруулж буй хувь нэмэр зэрэг сэдвийг хөндсөн. Түүнчлэн эдгээр шторкыг жендэрийн тэгш байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэх янз бүрийн үүлзалт, арга хэмжээн дээр тарааснаас гадна Казахстаны парламентын гишүүдэд CD-г илгээсэн байна.

→ **Үндэсний засгийн газрын жендэрийн тэгш байдлын механизм/ байгууллагатай ажиллах**

Жендэрийн тэгш байдлын стандартыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх суурь шинжтэй үүргийн улмаас үндэсний жендэрийн тэгш байдлын хороо, хүний эрхийн комисс зэрэг нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийг дээшлүүлэх чиглэлээр иргэний нийгмийн хамтран ажиллах гол эх сурвалж юм. ИНБ, үндэсний жендэрийн тэгш байдлын хорооны хамтын ажиллагаа нь маш өргөн хүрээтэй байж болно: үүнд эмэгтэйчүүдийн эрх жендэрийн тэгш байдлын асуудлаар мэдээлэл солилцох, түүний дотор аль нэг зорилтот бүлгийн тодорхойлох; ИНБ-уудад үндэсний болон олон улсын түвшинд жендэрийн тэгш байдлын асуудлаарх гомдол шийдвэрлэх талаар сургалт хийх; жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхийн талаар ойлголт мэдлэг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг хамтран хийх зэрэг багтана.

Ялангуяа иргэний нийгэм нь төрийн байгууллагатай харьцуулахад үндэсний болон олон улсын түвшинд сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх санхүүжилт, хөрөнгө нөөц муутай улс орнуудын хувьд үндэсний жендэрийн тэгш байдлын асуудал хариуцсан байгууллагууд нь иргэний нийгмийн тодорхойлсон асуудлыг хамгийн өндөр түвшинд аваачих мэдэл, бололцоотой байдаг. Дээрх ажлаас гадна, ИНБ-ууд нь жендэрийн тэгш байдлын механизм/байгууллагууд, хүний эрхийн комиссын нүд, чих болж, гомдол гаргагчтай холбох, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг илрүүлэх зэрэгт тусалж байдаг. Жендэрийн тэгш байдлын үндэсний механизм, хүний эрхийн комиссын хувьд иргэний нийгэм ямар ач холбогдолтой талаар нэмэлт мэдээллийг ODIHR-ын *Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлын асуудлаарх Үндэсний хүний эрхийн байгууллагуудад зориулсан гарын авлагаас* авна үү.³⁰¹

5.1.7. Үйл явдлын тэргүүнд явах

21 дүгээр зуун бол технологи, шинэчлэл хурдацтай явагдаж буй зуун билээ. Ялангуяа Интернет онлайн мэдлэг хуваалцах мэдээллийн хэрэгтэй арга хэрэгсэл болоод байна. Энэ нь өөр хоорондоо харилцах, суралцах, санаа солилцох өртөг зардал багатай, үр ашигтай арга юм. Түүнийг олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эмэгтэй нэр дэвшигчийг олж тодруулах, мөн эмэгтэйчүүд сурталчилгааны ажлаа амжилттай хийхэд ашиглах боломжтой.

Улс төрд эмэгтэйчүүдийг хэрхэн мэдэлжүүлэх талаар хамгийн сайн тархсан онлайн мэдлэгийн порталын нэг нь Улс төр дэх эмэгтэйчүүдийн талаар Олон улсын мэдлэгийн сүлжээ буюу iKNOW Politics³⁰² юм. Уг цахим хуудсыг ажиллуулах НҮБ-ын Хөгжлийн

300 Please refer to the OSCE/ODIHR Election Observation Mission Final Report, Georgia: Parliamentary Elections 1 October 2012, p. 24, <<http://www.osce.org/odihr/98399?download=true>>.

301 Handbook for National Human Rights Institutions on Women's Rights and Gender Equality (Warsaw: OSCE/ODIHR, 2012), pp. 55–59.

302 International Knowledge Network of Women in Politics (iKNOW Politics), <<http://www.iknowpolitics.org/>>.

хөтөлбөр, UN Women, Үндэсний ардчилсан хүрээлэн, Олон улсын парламентын холбоо, Ардчилал, Сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн зэрэг хэд хэдэн учир холбогдолтой байгууллага дэмжлэг үзүүлдэг. Уг төслийг сонгуульт албан тушаалтнууд, улс төрийн намын удирдагч, гишүүд, судлаачид, оюутнууд, энэ чиглэлээр ажилладаг хүмүүс зэрэг улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжигч талуудын хэрэгцээг хангах зорилгоор бий болгосон онлайн ажлын талбар гэж хэлж болно (Шигтгээ 5.27). Тус iKNOW Politics төсөл болон бусад онлайн хэрэгсэл нь ИНБ-үүд арга техникээ өргөжүүлэх, олон хүнд хүрч ажиллах, мөн жендэрийн тэгш байдлын талаарх сурталчилгааны үр нөлөөг дээшлүүлэхэд маш чухал юм.

Шигтгээ 5.27. iKNOW Politics цахим хуудас

Улс төрд эмэгтэйчүүд Олон улсын мэдлэгийн сүлжээ (iKNOW Politics) нь дэлхий даяар улс төрд эмэгтэйчүүдийн оролцооны нөхцөл байдал ямар байгаа талаар мэдээлэл солилцох вэбэд суурилсан талбар юм. Зорилго нь технологийн ололтын ашиглан улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо, үр нөлөөг дээшлүүлэхэд оршино. Тус цахим хуудас нь цахим номын сан зэрэг *материал ашиглах боломж*, мөн бусад шинжээч, энэ чиглэлээр ажиллагчдын туршлагаас олж мэдэх; хэлэлцүүлэг, мэдээлэл солилцох, мөн гишүүдийн хүсэлтэнд шинжээч хариу өгөх зэргээр *мэдлэг бий болгох*; мөн гишүүд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр сургамж, сайн туршлага зэргээ зориуд бий болгосон арга хэрэгслээр дамжуулан *өөр хоорондоо солилцох* боломж олгодог. Хэрэглэхэд хялбар, өргөн хүрээнд ашиглах боломжтой байлга хүүднээс агуулга, тавигдсан материал нь араб, англи, франц, испани хэл дээр байдаг.

Тус төсөл нь улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог сайжруулах эрмэлзэлтэй хэд хэдэн байгууллагын хамтын санаачилга бөгөөд үүнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, UN Women, Үндэсний ардчиллын хүрээлэн, Арчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн, Олон улсын парламентын холбоо багтаж байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нийт 166 орны засгийн газар, иргэдэд үндэсний болон олон улсын түвшинд хөгжлийн бэрхшээлийг даван туулах шийдэл олоход нь дэмжлэг үзүүлдэг. Мөн улс төрийн намын эмэгтэй гишүүд, нэр дэвшигчдэд улс төрийн талбарт ороход нь чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлдэг.

Харин UN Women бол эмэгтэйчүүдийг мэдэлжүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах шинэлэг хөтөлбөрт санхүүгийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэг. Тус байгууллагаас засгийн газрын бүхий л түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхийн тулд эмэгтэй удирдагчдад сургалт хийх, тэдэнд нэр дэвшигч, сонгогч байдлаар сонгуульд оролцоход шаардагдах үр чадвар олгохыг зорьж ажилладаг.

Үндэсний ардчиллын хүрээлэн бол ардчиллын үнэт зүйлс, практик, институцийн хөгжил дэвшлийг ахиулж буй иргэний болон улс төрийн манлайлагч нарт практик туслалцаа үзүүлдэг. Тус байгууллагын Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөтөлбөр нь сонгуульд албан тушаалд буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, улс төрийн нам, иргэний нийгэмд эмэгтэйчүүдийн манайллыг сайжруулахыг эрмэлзэж ажилладаг.

Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн нь олон улсын засгийн газар хоорондын байгууллага бөгөөд ардчилсан институц, үйл явцыг бэхжүүлэх зорилготой. Тус байгууллагаас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх талаар харьцуулан шинжилгээ хийж, арга хэрэгсэл боловсруулж гаргадаг. Эцэст нь, Олон улсын парламентын холбоо бол тусгаар улсуудын парламентуудаас бүрдсэн байгууллага юм. Тус багууллагаас улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны чиг хандлагын талаа рсудалгаа хийж, энэ талаар ойлголт мэдлэг нэмэгдүүлэх ажил хийхийн зэрэгцээ парламентын эмэгтэй гишүүд, нэр дэвшигчдэд зориулсан төслүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэг.

Эх сурвалж: International Knowledge Network of Women in Politics (iKNOW Politics), <<http://www.iknowpolitics.org>>.

Тавдугаар бүлгийн дүгнэлт

Энэхүү бүлэгт эмэгтэйчүүд улс төрийн карьераа ахиулахад дэмжлэг үзүүлэх, улс төрийн намуудад эмэгтэйчүүдээ дэмжиж, жендэрийн тэгш байдлыг хэрэгжүүлэхэд нь түслах, мөн сонгогчид болон улс төрийн холбогдох талуудын дунд эмэгтэйчүүдийн улс төрийн чадавх, хувь нэмрийн талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх зэрэгт иргэний нийгмийн байгууллагаас гүйцэтгэж буй чухал үүргийн талаар авч үзлээ. Түүнчлэн хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллагыг улс төрд эмэгтэйчүүдийг мэдэлжүүлэхэд татан оролцуулах иргэний нийгмийн гол оролцогч талууд гэж тодорхойлов. Олон нийт эмэгтэйчүүд, тэдний улс төрийн чадавхийг хэрхэн үнэлэх гэдэгт хэвлэл мэдээллийн байгууллага асар чухал нөлөө үзүүлж байдаг. Хэвлэл мэдээллийн байгууллага жендэрийн хэвшмэл ойлголтыг ихэнхдээ лавшруулан баталгаажуулж байдаг тул тэд иргэний нийгмийн зүгээс хийх жендэрийн мэдрэмжийг дээшлүүлэх ажлын зорилтот бүлэг болохын зэрэгцээ улс төрд эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголтыг эвдэхэд чиглэсэн ажлын гол түнш болж байдаг. Түүнчлэн судалгааны байгууллага, сургалтын байгууллага, аливаа нэг асуудлаар дагнасан ТББ, төрийн бодлогын асуудлаар дагнан ажилладаг think tanks зэрэг нь эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллыг дэмжих баримт нотолгоонд суурилсан судалгаа хийхэд гол үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ эмэгтэй нэр дэвшигчдэд сургалт хийх боломжтой байдаг. Янз бүрийн талтай хамтран ажиллаж, хөрөнгө нөөцөө хуваалцсаны үндсэн дээр ИНБ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарч буй саадыг бүрэн даван туулж, улс төр, түүний дотор улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадах юм.

ДҮГНЭЛТ

Жинхэнэ бодит ардчилсан нийгэмд улс төрийн байгууллагын **жендэрийн тэгш байдал** үнэхээр чухал асуудал юм. Ардчилсан засаглалыг бэхжүүлэх нь бүх нийтийг оролцуулсан, хэрэгцээг мэдэрсэн улс төрийн үйл явц өрнөх орчин бүрдүүлэхийг шаарддаг бөгөөд тэр орчин нь мөн эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил тэгш оролцуулж, мэдэлжүүлдэг байх ёстой. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг аль алиныг нь оролцуулдаг оролцоотой, төлөөлөлтэй засаглалын тогтолцоо бол ардчилсан засаглалын урьдчилсан нөхцөл төдийгүй сонгогч, улс төрийн нам, сонгуульт төлөөлөгч зэрэг улс төрийн бүлгүүдэд ашиг тусаа өгч байдаг.

ЕАБХАБ-ын улс орнууд эмэгтэйчүүдийн эрхийг бүрэн, тэгш хэрэгжүүлэх нь энх тайван, аюулгүй, ардчилсан ЕАБХАБ-ын бүс нутгийг бий болгоход нэн чухал гэдгийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр улс төр, төрийн хэрэгт эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш боломж олгох, жендэрийн тэгш байдлын асуудлыг бодлого, практиктаа тусган хэрэгжүүлэх амлалт аваад байгаа билээ. Гэвч энэхүү гарын авлагад харуулсанчлан, ЕАБХАБ-ын бүс нутаг даяар эмэгтэйчүүд шийдвэр гаргах байгууллагад дутуу төлөөлөлтэй хэвээр байна. Үндэсний парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь аажим өсөн нэмэгдэж байгаа ч ямар нэг арга хэмжээ авахгүйгээр энэ хурдаар явбал тус бүс нутагт сонгуульт байгууллага дахь жендэрийн тэгш байдлыг тогтооход 50 жил шаардагдахаар байна. Хүний эрх, эрх чөлөөг тунхагласан Хельсинкийн актанд 1975 онд гарын үсэг зурсныг санавал ахиц дэвшил сайн байна гэж үзэх боломжгүй юм.

Түүнчлэн ЕАБХАБ-ын бүс нутагт ахиц дэвшил жигд биш байна; ЕАБХАБ-ын улс орнуудын дунд томоохон ялгаа зааг байна. Парламент нь жендэрийн хувьд бараг тэнцвэртэй болж, нэлээд хэдэн жилийн турш уг чиг хандлагаа хадгалж чадсан улс орон тун цөөн, мөн НҮБ-ын 1995 оны Бээжингийн үйл ажиллагааны тунхагалд заасан 30 хувийг хангасан улс орон мөн цөөн байна. Үүний зэрэгцээ хэд хэдэн улс орон уг зорилтод хүрэхэд маш хол буюу парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нь 15 хувьд ч хүрэхгүй байна. Эмэгтэй хүн намын дарга болох, парламентын гишүүн болох, парламентын дарга болох, сайд, ерөнхий сайд болох магадлал ЕАБХАБ-ын бүс нутагт эрэгтэйчүүдээс бага хэвээр байна. Тиймээс ЕАБХАБ-ын бүс нутагт эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн улс төрийн тэгш оролцооны асуудал шийдэгдээгүй асуудал хэвээр байгаа бөгөөд энэ нь улс төрд буй эмэгтэйчүүдийн тооны хувьд ч, улс төрд гүйцэтгэх үүрэг, нөлөө, үр дүн талаас нь авч үзсэн ч ийм байна.

Энэхүү гарын авлагад улс төрд жендэрийн тэгш байдлыг тогтоохын тулд хамтран ажиллах шаардлагатай хэд хэдэн зорилтот бүлгийн тодорхойлов. Улмаар эмэгтэйчүүдийн улс төр дэх сул төлөөллийн асуудлыг хөндөж, эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг хангах, ялангуяа улс төрийн намаар дамжуулан шинэчлэл хийхийн тулд тэдгээр бүлэг тус бүртэй хамтран ажиллах тодорхой үйл ажиллагааг ангилан оруулав. Энд дурдсан арга замыг боловсруулахдаа ЕАБХАБ-ын оролцогч улс орнууд нь эмэгтэйчүүдийг улс төр, төрийн хэрэгт бүрэн оролцуулах тэгш боломж бий болгох зорилготой, эрмэлзэлтэй байгаа гэсэн төсөөлөлд үндэслэв.

Энэхүү гарын авлагын гол зорилтот бүлэг бол улс төрийн нам, **улс төрийн намын удирдлага юм**. Улс төрийн намууд ардчилсан нийгэмлэг болохын хувьд аливаа ардчилсан нийгэмд онцгой үүрэг гүйцэдгэдэг: тэд иргэдийг төлөөлөн, хүсэл санааг нь нийтийн шийдвэр гаргах үйл явцад хүргэх суваг болдог. Улс төрийн нам ардчиллыг “тээн хэрэгжүүлэгч” болохын зэрэгцээ улс төрд эмэгтэйчүүдийн оролцооны асуудалд ч тийм үүрэг гүйцэтгэж, эмэгтэйчүүд улс төрийн эрх мэдэлд хүрэхэд дэмжлэг үзүүлж (заримдаа саад учруулж) байдаг. Энэхүү гарын авлагад улс төрийн намын бодлого, үйл явц, практикт эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг хангах аль эсвэл эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж, улс төрийн хөгжлийг нь хязгаарлах олон арга, хэлбэр байдгийг дурдав.

Улс төрийн намууд, ялангуяа улс төрийн намын удирдлагууд намын бодлого, практик, дүрэм журам нь жендэрийн тэгш байдлыг бодитой дэмжиж байхад гол үүрэг гүйцэтгэнэ. Улс төрийн намууд ардчилсан байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг байх үүднээс улс төрийн намуудын дотоод ажиллагааг журамлан зохицуулах нь намын эрэгтэй, эмэгтэй гишүүдэд ажлын адил тэгш нөхцөл бүрдүүлэхэд эхний чухал алхам юм. Улс төрийн намын албан ба албан бус практик, тухайн улс төрийн намд давамгайл үйлчилж буй соёл, жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголт зэрэг нь эмэгтэйчүүд нам дотроо ч, сонгуулийн үеэр ч эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшилд бэрхшээл учруулдаг бөгөөд ийм бэрхшээл нь эмэгтэй, эрэгтэй намын гишүүдийн тоо бараг адил, намын жагсаалтанд адил тоогоор орсон нөхцөлд ч тохиолддог. Эцэст нь, намын шийдвэр гаргах бүтцэд эмэгтэйчүүд оролцох нь уг байгууллага төдийгүй нийгэмд жендэрийн тэгш байдлыг дэмжихэд чухал ач холбогдолтой.

Улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлийг дээшлүүлэхэд илүү ихийг хийх шаардлагатай. Энэхүү гарын авлагад тэмдэглэсэнчлэн, улс төрийн намуудад нам дотроо, мөн сонгуульт албан тушаалд эмэгтэйчүүдийг дэмжих олон боломж, арга бий. Үүнд нам дотроо жендэрийн тэгш байдлын сан байгуулж, холбогдох журмыг батлах; намаас нэр дэвшигч, гишүүд, дэмжигч, сонгогчидтой жендэрийн мэдрэмжтэй харьцах; улс төрийн намын санхүүгийн хөрөнгө нөөц, сурталчилгааны хөрөнгөнөөс хүртэх жендэрийн тэгш боломжоор хангах; намын сонгуулийн сурталчилгаандаа жендэрийг нэг арга болгон тусгах; мөн үндэсний түвшинд жендэрийн мэдрэмжтэй засаглалыг дэмжин нэвтрүүлэх зэрэг багтана.

Улс төрийн нам дотроо жендэрийн тэгш байдлыг институтчилна гэдэг нь намын баталсан бодлого журмыг гишүүд бодит амьдрал дээр даган мөрддөг, ялангуяа орон нутаг, бүс, үндэсний түвшинд намын удирдлага, сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлдэг байхыг хэлнэ. Улс төрийн намууд тус бүртээ жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, нийтэлж, хэрэгжүүлж, түүндээ хяналт тавьдаг байх хэрэгтэй бөгөөд түүнд тодорхой хэмжигдэхүйц, цаг хугацаатай зорилго тавьсан байх нь зүйтэй. Энэ нь намын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, түүний дотор тусгай хороод байгуулах, чадавхийг нь бэхжүүлэх, эсвэл эмэгтэйчүүдийн бүлэг, парламентын эмэгтэйчүүдийн нэгж, намын эмэгтэй гишүүдийн гаргасан шийдвэр, зөвлөмж намын бодлого боловсруулах үйл явцад хэлэлцэгдэж, тусгагддаг байх үүднээс энэ асуудлыг хариуцсан ажилтан томилох зэрэг арга хэмжээ авахыг шаардаж болно. Намын үйл ажиллагаа, бодлого, журмын талаар жендэрийн шинжилгээ хийх чадавхийг намын эрэгтэй, эмэгтэй гишүүдэд бий болгох шаардлагатай.

Гэвч бодлогын амлалт авах, тэр ч байтугай тодорхой зорилго тавьсан ч нам дотроо эмэгтэй, эрэгтэй гишүүд харилцан үялдаатай арга хэмжээ авахгүй бол тэдгээр нь олигтой үр дүнд хүрэхгүй. Намын удирдлагын бүтцэд эрэгтэйчүүд давамгайл байдаг, ихэнх парламентад ч эрэгтэй гишүүд давамгайл байгаа тул өөрчлөлт хийхэд эрэгтэйчүүд чухал түнш юм. Эмэгтэйчүүдийн байр суурь, тэргүүлэх чиглэл, тэдний санааг эрэгтэй

гишүүд нухацтай авч үздэг болгоход намын удирдлагын эрмэлзэл, улс төрийн хүсэл зориг нэн чухал. Түүнчлэн намын гишүүдэд жендэрийн тэгш байдал, тэгш боломжийн талаар байнга мэдлэг ойлголт өгөх, ялангуяа хоосон үг, амлалтаар бус үйлдлээрээ дэмжихэд намын удирдлага маш чухал үүрэг гүйцэтгэнэ.

Түүнчлэн энэ гарын авлагад улс төрд эмэгтэйчүүдийг мэдэлжүүлэх ажлыг дэмжиж, жендэрийн тэгш байдлыг намын бодлого, практик, журамд тусгаснаар улс төрийн намд ямар ач тустайг тодорхойлов. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нээлттэй, албан ёсоор, байнга дэмжсэнээр улс төрийн нам дэмжигчдийн хүрээгээ өргөжүүлж, шинэ гишүүдийг өөртөө татан, мөн нийтийн санхүүжилтээ нэмэх, олон нийтийн байр суурийг өөрчилж, олон улсад ч өөрсдийн нэр хүндийг дээшлүүлэх боломжтой.

Энэ гарын авлагын хоёр дахь зорилтот бүлэг нь улс төрийн намын удирдлага, сонгуулийн сурталчилгааны ажлын менежер, нэр дэвшигч, парламентын гишүүн, намын идэвхтэн болох зэргээр улс төрийн карьераа ахиулах хүсэлтэй байгаа эмэгтэйчүүд юм. Эмэгтэйчүүд нам дотроо дуу хоолойгоо бодитой илэрхийлэх боломжтой байж л олон нийтийн хэлэлцүүлэгт эрэгтэйчүүдтэй тэгш оролцож, тэдний болон гэр бүл, нутаг орон, улс орныхоо ирээдүйг шийдэх шийдвэрт нөлөө үзүүлж чадна. Тиймээс эмэгтэйчүүдийн оролцооны саад бэрхшээлийг арилгах нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн ажилладаг жендэрийн мэдрэмжтэй улс төрийн нам, парламент бий болгоход чухал ач холбогдолтой. Жендэрийн тэгш байдлын төлөөх санаачилгад эрэгтэйчүүдийн дэмжлэг чухал ч эмэгтэйчүүд өөрсдөө ч идэвхтэй байр сууринаас хандаж, жендэрийн тэгш байдлын асуудал улс төрийн намын журамд тусгагдан, бүх намын бүх түвшинд хэлэлцэгддэг байхад анхаарах нь зүйтэй.

Улс төрийн карьераа ахиулах, нам дотроо жендэрийн тэгш байдлыг институтчлахад эмэгтэйчүүд хувь хүний хувьд болон хамтдаа хэрэгжүүлж болох хэд хэдэн арга хэмжээг энэ гарын авлагад дурдав. Намын үйл ажиллагаа ил тод бус, мөн тоглоомын бодит дүрмийг мэдэхгүйгээс намын эмэгтэй гишүүд улс төрийн карьераа ахиулахдаа саад бэрхшээлтэй тулгарах нь элбэг. Ялангуяа намын үйл явцыг бичгээр тодорхой, ил тод баримтжуулаагүй эсвэл бичгээр гаргасан журмаа амьдралд мөрддөггүй тохиолдолд ийм байдал үүсдэг. Тиймээс энэ гарын авлагад нам хэрхэн ажилладаг, намд эмэгтэйчүүд ямар албан тушаал хаших боломжтой, мөн намын одоо үйлчилж байгаа бодлого, практикийн хүрээнд улс төрийн карьераа хэрхэн төлөвлөх талаар эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн хэд хэдэн аргыг дурдав. Нам хэрхэн ажилладаг, практик юуг удирдлага болгодогийг мэдэж авснаар эмэгтэйчүүд сонгуулийн сурталчилгааны ажлын хөрөнгө нөөц, хандивлагч, сүлжээ, хэвлэлийн эх сурвалж, намын өмч зэргийг ашиглах боломжийг олж харах бөгөөд эдгээр нь нэр дэвшигч, сонгуулийн сурталчилгааны менежер, намын шийдвэр гаргагч болж карьераа хөгжүүлэхэд нэн чухал юм.

Эмэгтэйчүүд сонгогдсоныхоо дараа ч эрэгтэйчүүд давамгайлсан орчинд орох бөгөөд тэнд даган мөрдөх дүрэм, журам нь эрэгтэйчүүдийн тэргүүлэх чиглэл, байр суурь, хэрэгцээ, сонирхолд тулгуурлан боловсруулагдсан байна. Сонгуульт байгууллагын дүрэм журамд жендэрийн аудит, үнэлгээ хийх нь эмэгтэйчүүд карьераа ахиулахад тулгарч буй тодорхой бэрхшээлийг илрүүлэх, үг төлөөллийн байгууллагыг жендэрийн ээлтэй болгоход юу хийх хэрэгтэйг тодорхойлоход тусална. Улс төрийн нам, парламентын төлөөлөл болохын хувьд эмэгтэйчүүд (мөн эрэгтэйчүүд) хууль тогтоох байгууллагын тогтсон улс төрийн соёлын өөрчлөхийн төлөө ажиллах боломжтой. Улс төрийн намын ажлын хуваарь, парламентын чуулганы хугацаа, хуваарь, эмэгтэй гишүүдэд зориулсан байр хэрэгслийн байршил, хүүхэд асрах чөлөө зэрэг асуудал нь эмэгтэйчүүдэд оролцоог дэмжсэн эерэг шинэчлэл авчрах боломжтой. Жендэрийн аудит, үнэлгээг намууд өөрсдөө ч хийж болно. Аль ч тохиолдолд, түүнийг хийсний үр дүнд улс төрийн оролцогч

талууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны тухайд илэрсэн бэрхшээл, орхигдсон асуудлыг шийдвэрлэх тодорхой арга, ажлын төлөвлөгөө боловсруулах ёстой.

Энэхүү гарын авлагын гурав дахь зорилтот бүлэг бол **иргэний нийгэм**, ялангуяа, жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн дэвшлийн төлөө гадаад, дотоод шинэчлэл хийх улс төрийн хүчнүүдэд шахалт үзүүлэх чадвартай иргэний нийгмийн байгууллагууд юм. Жендэрийн тэгш байдлыг бодлогын асуудал болгон анхаарлын төвд хүргэхэд улс төрийн намууд ба иргэний нийгмийн хамтын ажиллагаа нэг үр дүнтэй арга гэдгийг тус гарын авлагад тэмдэглэв. Олон тохиолдолд, ялангуяа улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх үүднээс үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсвэл хууль тогтоомж батлахыг хичээж буй тохиолдолд иргэний нийгмийн байгууллагатай ойр хамтран ажилласан тохиолдолд хамгийн үр дүнтэй байдаг.

Бусад тохиолдолд ИНБ-ууд, түүний дотор эмэгтэйчүүдийн байгууллагууд бодлогын тухайн өөрчлөлтийн талаар сурталчилгаа, нөлөөллийн ажил хийхийн тулд намын эмэгтэй идэвхтнүүдээ зориуд түшин ажиллаж болно. Аль ч тохиолдолд ИНБ-ууд шинэчлэл хийх олон нийтийн шахалт бий болгож, улмаар улс төрийн намууд, засгийн газарт өөрсдийн практик, журмыг олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэх шаардлага тавьж чаддаг. Тус гарын авлагад ИНБ-ууд хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллагатай хамтран эмэгтэйчүүдийг элсүүлэх, эмэгтэй нэр дэвшигчдийн чадавх бэхжүүлэх, улс төр дэх эмэгтэйчүүдийн эсрэг жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг няцаах, жендэрийн тэгш байдлын талаарх бодлого, эрх зүйн өөрчлөлт хийхэд хэрэг болох баримт нотолгоонд суурилсан судалгаа хийх зэрэг арга замаар эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшилд хувь нэмэр оруулах арга замуудаас авч үзэв.

Тус гарын авлага нь тухайн зорилтот бүлгүүд улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх ямар арга хэмжээ авч болохыг ЕАБХАБ-ын улс орнуудын улс төрийн нам, эмэгтэй улс төрч, ИНБ-аас хэрэгжүүлсэн сайн туршлагыг тодорхой жишээнд үндэслэн гаргав.

ЕАБХАБ-ын улс орнуудад ийнхүү өргөн хүрээтэй туршлага хуримтлуулснаас үзэхэд бүх цаг үед, хаана ч тохирох цорын ганц арга эсвэл үйл ажиллагааны тодорхой дараалал байхгүй байна. Тус бүс нутгийн улс орон бүр өөрийн гэсэн засаглалын бүтэцтэй, улс төрийн нам бүр өөрийн удирдлага болгодог дүрэм, журам, практикай. Тиймээс энд дурдсан арга тус бүрийг өөрийн улс орны ардчиллын онцлог нөхцөл, олон улсын өмнө хүлээсэн амлалт, үндэсний тогтолцоо, сонгуулийн болон улс төрийн намын тогтолцоо, нийгэм-соёлын уламжлал, өнөө үед тулгарч буй улс төрийн сорилт зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Гэхдээ тухайн тогтолцооноос үл хамааран ЕАБХАБ-ын улс орнуудын улс төрийн намын дотор жендэрийн тэгш байдлыг сайжруулах, эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг хангахад үр дүнтэй гэдэг нь нотлогдсон хэд хэдэн арга байна. Үүнд улс төрийн намын удирдлагаас намын дотоод дүрэм, журам, бодлого, практикаа ил тод, шударга, тэгш болгох (энэ бүгд нь намын дотоод ардчиллыг бэхжүүлэх чиглэнэ); эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих сайн дурын арга хэмжээ болох намын квот нэвтрүүлж, эмэгтэйчүүдэд зориулсан чадавх бэхжүүлэх ажиллагаа, эмэгтэйчүүд намын хөрөнгө нөөцөөс ашиглах боломж олгох тусгай санаачилгыг хэрэгжүүлэх; намын үйл явц, бодлого, ялангуяа намын үндсэн дүрэмд жендэрийн тэгш байдлыг институтчлан тусгах; мөн нам дотроо байгуулсан эмэгтэйчүүдийн бүлэг гэх мэт жендэрийн тэгш байдлын механизм дэмжлэг үзүүлэх гэх мэт арга хэмжээ багтана. Цаашилбал, улс төрийн намд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх хамгийн үр дүн аргууд бол намын эрэгтэй, эмэгтэй гишүүдийн хамтгын ажиллагаа; нэгдмэл сонирхолтой асуудлаар нам дамнан хамтран ажиллах; улс төрийн нам өөр хоорондоо болон иргэний нийгмийн байгууллага зэрэг бусад талуудтай хамтран ажиллах зэрэг юм.

Улс орнууд, тэдгээрийн улс төрийн гол намууд эмэгтэйчүүдээ улс төрд зохих эрхийнх нь дагуу оролцуулах хүсэлтэй, тийм бэлтгэлтэй биш бол тэднийг ардчиллыг бэхжүүлэхийг эрмэлзэж байна гэж үзэхэд хэцүү юм. Улс төрд эмэгтэйчүүдийн бодит оролцоог хангах зорилгыг улс төрийн улам олон нам дэмжин хүлээж авч байгаа бөгөөд нөгөө талаар эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж, орхигдуулсаар байгаа улс төрийн оролцогч улам бүр эрсдэлтэй байдалд орж байна. Тус гарын авлагад тайлбарласанчлан, улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх нь намын улс төрийн бүхий л түвшинд, түүнчлэн нийгэмд ерөнхийд нь ач тусаа өгч байдаг. Оролдож, түршиж үзсэн эдгээр аргыг үр дүнтэй хэрэгжүүлснээр ЕАБХАБ-ын бүс нутагт улс төрийн бүх намд эмэгтэйчүүдийн тэгш, бодит оролцоо биеллээ олоход түс дэм болно.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. ЕАБХАБ-ын Жендэрийн тэгш байдлын амлалт

- **Мадрид, 1983 (“Европын аюулгүй байдалтай холбоотой асуудлууд”, 16 дугаар догол мөр)**
[Оролцогч Улс орнууд] улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш, үр дүнтэй оролцоог хангахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авахаар тохиров.
- **Вена, 1989 (“Европын аюулгүй байдалтай холбоотой асуудлууд”, 15 дугаар догол мөр)**
(15) Оролцогч Улс орнууд [...] Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцэд нэгдэн ороогүй байгаа бол тийнхүү нэгдэн орох боломжийг судална.
- **Парис, 1990 (“Хүний эрх, ардчилал, хууль дээдлэх ёс”, 3, 5 дугаар догол мөр)**
Хүн бүр аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал хийх эрх чөлөө, хөдлөн явах эрх чөлөө эдлэх эрхтэй; хүн бүр чөлөөт, шударга сонгуульд оролцох, [...] эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх эрхтэйг бид баталж байна.
- **Москва, 1991 (40-40.13 дугаар догол мөр)**
(40) Оролцогч улс орнууд [...] нийгмийн бүрэн дүүрэн хөгжил, түүний гишүүдийн сайн сайхан байдлыг хангахын тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүрэн дүүрэн, тэгш оролцох тэгш боломжийг бүрдүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Энэ чиглэлд улс орнууд:

(40.6) – [...] эмэгтэй, эрэгтэй ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг гэр бүлийн үүрэг хариуцлагатайгаа үялдуулахад дэм болох арга хэмжээ авахыг дэмжих; түүнчлэн бүтцийн өөрчлөлтийн аливаа бодлого, хөтөлбөр нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж, сөргөөр нөлөөлөхгүй байх явдлыг баталгаажуулахыг эрмэлзэнэ;

(40.8) – эмэгтэйчүүд улс төр, төрийн хэрэг, шийдвэр гаргах үйл явц, олон улсын хамтын ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох тэгш боломж олгохын дэмжинэ;

(40.9) – эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн байгууллагуудын зүгээс эмэгтэйчүүдэ шүүд үйлчилгээ үзүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх, мөн эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах зорилгоор засгийн газартай бодит түншлэл бий болгохыг дэмжих зэрэг арга замаар эмэгтэйчүүдийн эрхийг хангахад үндэсний болон олон улсын түвшинд хийж буй хүчин чармайлтад үзүүлж буй энэ чухал нөлөөг хүлээн зөвшөөрч байна;
- **Стамбул, 1999 (Европын аюулгүй байдлын харти, 23, 24 дүгээр догол мөр)**
23. Эмэгтэйчүүд хүний эрхээ бүрэн дүүрэн, тэгш эдлэх нь ЕАБХА-ын илүү тайван, хөгжил дэвшилтэй, ардчилсан бүс нутаг бий болгоход нэн чухал.
- **Софи, 2004 (Жендэрийн тэгш байдлыг дэмжих ЕАБХАБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө)**
44. Тэргүүлэх чиглэлүүд
(d) Эмэгтэйчүүдийн улс төр, төрийн хэрэгт оролцох тэгш боломжийг хангах — ODIHR-аас ардчилсан үйл явцад эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх сайн туршлагыг бий болгоход нь Оролцогч улс орнуудад дэмжлэг үзүүлнэ;
— АИХЭА ба ЕАБХАБ-ын улс орнууд дахь салбар нь жендэрийн асуудлаар орон нутгийн чадавх, мэргэшлийг бий болгох, мөн олон нийтийн бүлгийн ахлагч нар ба улс төрчдийг холбосон сүлжээ бий болгоход дэмжлэг үзүүлнэ;
— АИХЭА Оролцогч улс орнуудад эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжихэд нь үргэлжлүүлэн туслалцаа үзүүлнэ.
- **Афин, 2009 (Эмэгтэйчүүдийн улс төр, төрийн хэрэгт оролцох оролцооны талаарх Сайд нарын зөвлөлийн шийдвэр) Шийдвэр No. 7/09 Эмэгтэйчүүдийн улс төр, төрийн хэрэгт оролцох оролцоо**

Сайд нарын зөвлөл,
Жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, улс төр, төрийн хэрэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хангах ЕАБХАБ-ын зорилгыг санан,

ЕАБХАБ-ын бүс нутагт хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, түүний дотор цагдаа, шүүхийн байгууллагын шийдвэр гаргах бүтцэд эмэгтэйчүүдийн төлөөлөл сул хэвээр байгааг тэмдэглэн,

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах байдал өргөн тархсан нь тэдний бүх шатны улс төр, төрийн хэрэгт үр дүнтэй оролцоход саад болсон хэвээр байгаа санаа зовнин,

ЕАБХАБ-ын зорилгыг байнга эргэн нягталж, хянах нь илүү үр дүнтэй арга барил, арга хэмжээ бий болгоход тус дэмтэйг хүлээн зөвшөөрч,

Эмэгтэйчүүд хүний эрхээ бүрэн дүүрэн, тэгш эдлэх нь ЕАБХА-ын илүү тайван, хөгжил дэвшилтэй, ардчилсан бүс нутаг бий болгоход нэн чухал гэдгийг дахин баталгаажуулан,

Оролцогч улс орнууд 2004 онд баталсан ЕАБХАБ-ын Жендэрийн тэгш байдлыг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө, Люлянагийн Сайд нарын зөвлөлийн зөрчилдөөнөөс сэргийлэх, түүнийг зохицуулах, зөрчилдөөний дараахь нөхөн сэргээх ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцооны талаарх Nos. 14/05 тоот шийдвэр, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх 15/05 тоот шийдвэрийг идэвхтэй хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа дахин нотолж,

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөрчилдөөнөөс сэргийлэх, зөрчилдөөний дараахь сэргээн босголтын үеэр шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн, тэгш оролцоог хангахын үриалсан 1325 (2000) тоот тогтоолыг эргэн санаж, энх тайван, аюулгүй байдлыг хангахад эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн, тэгш оролцоог бүх талаар хангахын ач холбогдлыг цохон тэмдэглэн,

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн олон улсын болон бүсийн байгууллагуудыг энх тайвныг тогтоох бүхийл үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог сайжруулах арга хэмжээг авахыг шаардсан 1889 (2009) тоот тогтоолыг тэмдэглэн,

2009 оны 12 дугаар сарын 18-нд эмэгтэйчүүдийг улс төр, төрийн хэрэгт оролцоход гарч буй ялгаварлан гадуурхлыг зогсоох зорилго бүхий Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 30 жилийн ой болж байгааг тэмдэглэн, мөн 12 дугаар сарын 10-нд тус конвенцийн Протоколыг гарын үсэг зурахад зориулан нээсний 10 жилийн ой болж байгааг тэмдэглэн,

Эмэгтэйчүүд улс төр, төрийн хэрэгт оролцоход жендэрээс үүдэлтэйгээс гадна өөр бусад бэрхшээл учирч байж болохыг хүлээн зөвшөөрөн,

Оролцогч Улс орнуудад дараах арга хэмжээг авахыг үриалж байна. Үүнд:

1. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллага, түүний дотор цагдаа гэх мэт аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад жендэрийн тэгш байдлыг хангах тодорхой арга хэмжээ авах асуудлыг анхаарч үзэх;

2. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс улс төр, төрийн хэрэгт, ялангуяа шийдвэр гаргах үйл явцад илүү тэнцвэртэй оролцоход дөхөм болох хуулийн арга хэмжээ авах асуудлыг анхаарч үзэх;

3. Шийдвэр гаргах бүх шатны сонгуульт байгууллагад жендэрийн тэнцвэр бий болгох зорилгоор улс төрийн намд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжин хангахыг улс төрийн бүх талуудад хөхиүлэн дэмжих;
4. Аюулгүй байдлын үйлчилгээ, түүний дотор хэрэв хамаатай бол зэвсэгт хүчинд, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг элсүүлэх, үргэлжлүүлэх ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх тэгш боломжоор хангах арга хэмжээ авах асуудлыг анхаарч үзэх;
5. Хууль тогтоомж, хөтөлбөр, бодлого боловсруулах бүхий л үе шатанд нээлттэй, оролцоотой үйл явцыг бий болгож, нэвтрүүлэх;
6. Энх тайван тогтоох ажиллагаанд эмэгтэй, эрэгтэй хүмүүс адил тэгш хувь нэмэр оруулах бололцоо олгох;
7. Эмэгтэйчүүдийн тэгш оролцоо, төлөөллийг хэмжих үндэсний зохистой, үр дүнтэй механизм бий болгоход шаардлагатай арга хэмжээ авах;
8. Эмэгтэйчүүдийн улс төр, төрийн хэрэгт оролцоход тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлэн тодорхойлох, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломж бий болгох зорилгоор төрийн бус байгууллага, судалгааны байгууллага зэрэг нь энэ сэдвийг зориуд сонгон судалгаа хийх, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх ажил хийхэд дэмжлэг үзүүлэх;
9. Эмэгтэйчүүд улс төр, төрийн хэрэгт үр дүнтэй оролцох тэгш боломж олгох зорилгоор эмэгтэй, эрэгтэй хүмүүс ажил болон эцэг эхийн үүрэг хариуцлагаа хуваан гүйцэтгэхийг нь хөхиүлэн дэмжих.

Эх сурвалж: Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ), <<http://www.osce.org/>>

Хавсгалт 2. Улс төрийн намын жендэрийн аудит – Маягт**1. НАМЫН ГИШҮҮН ЭЛСҮҮЛЭХ**

- Намд гишүүн хэрхэн элсүүлдэг вэ?
- Намын удирдлагуудын найз нөхөд?
- Бизнесийн хамтрагчид?
- Их сургуульд хамт суралцагчид?
- Гэр бүлийн гишүүд?
- Намын удирдлагын хувиараа танилцсан хүмүүс?
- Тухайн орон нутагт нэр хүндтэй байдал?

Танай намд гишүүн элсүүлэх ажлыг хэн хариуцдаг вэ?

Намын дүрэмд гишүүн элсүүлэх журмыг заасан байдаг уу?

Бичгээр гаргасан журмыг ил тод мөрддөг үү?

Шинээр гишүүн болсон эрэгтэй, эмэгтэй хүмүүст намаас танилцуулах сургалт хийдэг үү?

2. ЭРХ МЭДЭЛ, ШИЙДВЭР ГАРГАЛТАНД ОРОЛЦОХ

Намын их хуралд нэр дэвшүүлэх ямар журам үйлчилдэг вэ?

Намын гишүүд i) намын удирдлага, ii) намын их хурлын төлөөлөгч, iii) намаас нэр дэвшигчдийг сонгоход саналын ямар эрхтэй байдаг вэ?

Намын их хурлын төлөөлөгчдөөс төсөв батлахад саналын ямар эрхтэй оролцдог вэ?

Намын мөрийн хөтөлбөрийг батлах, түүнд нөлөөлөхөд төлөөлөгчид (саналын) ямар эрхтэй байдаг вэ?

Эдгээр журмыг намын дүрэмд бичгээр тусгасан үү?

Намын дүрэмд өөрчлөлт оруулахад ямар журам үйлчилдэг вэ (жишээ нь, намын дотоод квот гэх мэт сайн дурын арга хэмжээ нэвтрүүлэх гэх мэт)?

3. НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОХ/НЭР ДЭВШҮҮЛЭХ

Нэр дэвшигчийн буюу нэр дэвшүүлэх зөвлөлийн гишүүдийг хэрхэн нэр дэвшүүлж, томилдог вэ?

- Намын удирдлагын хувийн шийдвэрээр?
- Намын шийдвэр гаргагчид, зөвлөхүүд томилдог?
- Намын дүрэмд заасан журмын дагуу сонгодог?

Энэхүү журмыг намын дүрэмд бичгээр тусгасан үү?

Тус журмыг бичигдсэний дагуу ил тод мөрддөг үү?

Нэр дэвшигчийг сонгох зөвлөлд хэдэн эмэгтэй байдаг вэ?

Тус Зөвлөл эмэгтэйчүүдийн байр суурь эрэгтэй гишүүдийнхтэй адил жинтэй байдаг үү?

4. НАМ ДОТРОО АЛБАН ТУШААЛ ДЭВШИХ

Намын гишүүд нам дотроо хэрхэн албан тушаал дэвшдэг вэ?

- Намын даргын шийдвэрээр
- Намын шийдвэр гаргагчид, зөвлөхүүдийн шийдвэрээр?
- Намын дарга, шийдвэр гаргагчидтэй тухайн гишүүн холбоотой байснаар?
- Үнэнч, амбицтай, зүтгэлтэй байдал

Энэхүү албан тушаал дэвших журам намын дүрэмд бичигдсэн үү?

Уг журмыг бичигдсэний дагуу ил тод мөрддөг үү?

Нам дотроо эмэгтэй, эрэгтэй хүмүүст ахиж дэвшихэд тэгш боломж бүрдсэн үү?

5. НАМЫН ХӨРӨНГӨ НӨӨЦ АШИГЛАХ БОЛОМЖ

Нам хөрөнгө босгох ажлаа яаж хийдэг вэ?

Намын гишүүд (эрэгтэй, эмэгтэй аль аль нь) намын хандивлагчдын талаарх мэдээллийг авах боломжтой байдаг үү?

Эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаандаа намын хандивлагчдын хөрөнгөснөөс ашиглах боломжтой юу?

Мамаас нэр дэвшигчиддээ хөрөнгийг хэрхэн хуваарилдаг вэ?

- Намын санхүүжилт
- Намын өмчийг ашиглах боломж
- Сонгуулийн сурталчилгааны материал авах боломж
- Намд хуваарилсан олон нийтийн нэвтрүүлгийн цагийг ашиглах боломж
- Олон нийтийн хурал цуглаан, хэвлэл мэдээллийн сурвалжлага, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох боломж

Намын гишүүдэд манлайллын хөгжилдөө зарцуулах төсвийг тусгайлан хуваарилдаг үү? Хэрэв тийм бол, эмэгтэй гишүүд үг төсвөөс ашиглах тэгш боломж бий юу?

Хөрөнгө хуваарилах журмыг намын дүрэмд бичгээр тусгасан байдаг үү?

Хавсралт 3. Словений улс төрийн намууд, Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2002 оны 7 дугаар сард Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хууль хүчин төгөлдөг болсон (Словений төрийн мэдээлэл, No. 59/2002) бөгөөд уг хуулинд эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэм, боловсрол болон бусад салбарт эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш боломж бүрдүүлэх суурь үндэслэлийг тодорхойлсон.

Тус хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу улс төрийн намын бүртгэлд орсон намууд дөрвөн жил тутамд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэнцвэртэй төлөөллийн асуудлаарх байр сууриал илэрхийлсэн, мөн уг байр суурийн дагуу намын байгууллагууд дотроо болон үндэсний парламентын сонгууль, орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалт, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэхдээ эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн илүү тэнцвэртэй төлөөллийг хангахын тулд баримтлах арга, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тусгасан байх ёстой.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн (Словений төрийн мэдээлэл, No. 59/2002) дагуу Словений Либерал Ардчилал намын Гүйцэтгэх зөвлөл 2013 оны 10 дугаар сарын 11-ний 15 дугаар хуралдаанаасаа дараах шийдвэрийг гаргажээ.

Жендэрийн тэнцвэртэй төлөөллийн талаарх Словений Либерал ардчилал намын ТӨЛӨВЛӨГӨӨ

Жендэрийн тэгш байдлын бодлого бол СЛА-ын ерөнхий бодлогын нэг хэсэг мөн. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш байдлыг идэвхтэй хэрэгжүүлэх бодлого нь өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг СЛА нь жендэрийн тэгш боломжийг бий болгох үйл явцыг түргэсгэх эрмэлзлээ ямар эргэлзээгүй илэрхийлж ирсэн билээ. СЛА нь бодлогоо хэрэгжүүлэх эхлэлийн цэг болгон эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх, түүнчлэн хүний эрхийг бүрэн дүүрэн, цогц хангахад шаардлагатай арга хэмжээг авахыг эрмэлзэн, зорьж байгаа болно.

СЛА нь бүх шатны шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд төлөөлөл дутуу, зарим тохиолдолд огт байхгүй байгаа нь ноцтой асуудал, мөн улс төр, төрийн хэрэгт эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах нь нийгмийн хөгжлийн нэг хэсэг гэж үзэж байна. Нийгмийн шийдвэр гаргах үйл явцад эмэгтэй, эрэгтэй хүмүүс аль аль нь оролцоход нийгэмд бүхэлд нь чухал ач холбогдолтой юм. Жендэрийн тэгш байдлыг бодитой тогтоохын тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн сонирхлыг тэгш авч үзэх шаардлагатай. Үүнийг жендэрийн шууд ба шууд бус ялгаварлан гадуурхлыг устгах замаар хэрэгжүүлэх боломжтой гэж СЛА үзэж байна.

СЛА-ын хөтөлбөрийн хүрээ нь бодлого төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлэх явцад жендэрийн тэгш байдлын асуудлыг байнга авч үзэх байх явдлыг тухайн хүн бүрийн үүрэг хариуцлага болгон зааж өгсөн тогтолцоо бий болгохыг тууштай зорих ёстой. Тэгш боломж, жендэрийн тэгш байдлыг бий болгон хангахад нэг удаагийн, саланги арга хэмжээ, үйл ажиллагааг ашиглаж болохгүй, өөрөөр хэлбэл, нэгдсэн, олон салбарыг хамарсан үйл явцыг хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг бид ойлгож байна.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш хандахаас гадна жендэрийн тэгш бус байдлыг үүсгэж буй саад бэрхшээлийг арилгах янз бүрийн арга хэмжээ авах замаар жендэрийн тэгш боломж бүрдүүлэх шаардлагатай. СЛА-гийн дүрмийн 15 дугаар зүйлд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломжийг сайжруулах талаар зарим эерэг арга хэмжээг зааж өгсөн.

Эдгээр арга хэмжээг цаашид улам ссайжруулж, нэмэлт зорилго, аргыг тодорхойлох шаардлагатай.

Төлөвлөгөөний зорилго

1. Үндэсний ассамблейн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалтанд эмэгтэйчүүдийг илүү олноор оруулах, мөн сонгогдох бодитой боломж бүхий сонгуулийн орчинг эмэгтэй нэр дэвшигчдэд санал болгох;
2. Жендэрийн тэгш байдлын зарчмыг үндэсний хууль тогтоомж батлах, яам дамнасан бодлого тодорхойлох, яам дамнасан үндэсний хөтөлбөр, бусад чухал журам батлахдаа оруулан тусгаж байх;
3. Нам, намын байгууллагуудад эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх;
4. Намын ерөнхий бодлого болон бүс нутгийн бодлогын тодорхойлохдоо жендэрийн тэгш байдлыг хангах, мөн тэг боломжийн зарчмыг хэрэгжүүлэх замаар нам дотор тэгш боломжид суурилсан, түүнийг хүлээн зөвшөөрдөг соёл бий болгох.

Арга

1. Намын дүрэмд заасны дагуу жендэрийн тэнцвэртэй төлөөлөлтэй болох
2. Үндэсний Ассамблей, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхийлөгчийн сонгуульд эмэгтэйчүүд нэр дэвшихийг нь дэмжих;
3. Намын байгууллагуудад эмэгтэйчүүд нэр дэвшихийг дэмжих;
4. Эмэгтэйчүүд бодлого боловсруулахад идэвхтэй оролцоход зориулан нэмэлт мэдлэг олгох үүднээс семинар зохион байгуулах, бичгээр холбогдох материал боловсруулж бэлтгэх (харилцааны талаар, олон нийтэд илтгэл тавих зэрэг чиглэлээр);
5. Нам дотроо бүсийн болон бусад чухал албан тушаалд эмэгтэйчүүд очиход зориулан эмэгтэйчүүдэд сургалт хийх;
6. Намын гишүүн эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулан дараахь сэдвээр сургалт хийх:
 - Бодлогод жендэрийн тэнцвэртэй төлөөллийг хангах;
 - Жендэрийн тэгш байдал ба ялгаа;
 - Бүсийн бодлогыг тодорхойлоход жендэрийн асуудлыг анхаарч тусгахын ач холбогдол;
 - Үндэсний баримт бичиг, чухал журмуудад жендэрийн асуудлыг анхаарч тусгахын ач холбогдол;
7. Намын хэвлэлд жендэрийн тэгш байдлын сэдэв, тэгш боломжийн талаарх сэдвийг оруулж байх;
8. Намын эмэгтэй гишүүдийн дунд хамтын ажиллагааны тогтмол харилцаа бий болгох.

СЛА Гүйцэтгэх зөвлөл, 2003 оны 11 дүгээр сарын 10

Словений Ардын нам

Словений эмэгтэйчүүдийн холбоо

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Словений Ардын намаас 2004-2008 онд хэрэгжүүлэх **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ

1. **Түс Үйл ажиллагааны төлөвлөгөөг** 2002 оны 7 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болсон Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хууль (Словений төрийн мэдээлэл, No. 59/2002), түүний 31 дүгээр зүйлд улс төрийн намууд дөрвөн жил тутамд үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, түүнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэнцвэртэй төлөөллийн асуудлаарх байр сууриал илэрхийлсэн, мөн үг байр суурийн дагуу намын байгууллагууд дотроо болон үндэсний парламентын сонгууль, орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалт, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэхдээ эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн илүү тэнцвэртэй төлөөллийг хангахын тулд баримтлах арга, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тусгасан ёстой гэж заасны дагуу батлав.

Улс төрийн намууд Словений Тэгш боломжийн газарт үг төлөвлөгөөгөө баталснаас хойш 3 сарын дотор хүргүүлэх ёстой. Гэвч тус хуулийн 41 дүгээр зүйлд улс төрийн намууд эхний төлөвлөгөөгөө нэг жилийн дотор, өөрөөр хэлбэл, тус хууль хүчин төгөлдөр болсноос хойшхи буюу 2003 оны 7 дугаар сарын 20-ноос хойшхи эхний их хурлаараа батлах ёстой гэж заасан. Тус хуулийн 35 дугаар зүйлд төлөвлөгөөгөө ийнхүү ирүүлээгүй бол тухайн улс төрийн намыг SIT 300,000-аар торгохоор заажээ.

2. Европын холбооноос Гишүүн орнуудад аль аль хүйсийн хүмүүст тэгш хандахыг үүрэг болгосон олон заавар гаргасан. Тухайлбал, Амстердамын гэрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын асуудлыг үндсэн зорилго болгон оруулснаас гадна бүх Гишүүн орнууд бүхий л үйл ажиллагаагаараа тэгш бус байдлыг арилгахыг зорих ёстой гэж дурдсан. Түүнчлэн 1996 онд Европын зөвлөл зөвлөмж гаргаж, ардчиллыг бодитой хангах шаардлагатай нөхцөл болох эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг шийдвэр гаргах үйл явцад илүү тэнцвэртэй оролцуулах санаачилгаа идэвхжүүлэхийг уриалсан.

3. Словений 1992, 1996, 2000 оны парламентын сонгуульд нийт 270 суудлаас дөнгөж 31-т нь ЭМЭГТЭЙ хүн сонгогдсон, түүнчлэн эмэгтэйчүүдийн парламентад эзлэх хамгийн өндөр хувь нь 13.3% байгаа юм. Харин Европын холбооны Гишүүн 15 орны парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь 31% байна. Словений 1998 оны орон нутгийн сонгуульд сонгогдогчдын дөнгөж 11,9% нь эмэгтэй, түүнээс дөнгөж 4.2 хувь нь хөдөөгийн орон нутагт сонгогдсон бөгөөд 2000 онд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1 хувиар л өсчээ.

4. Словений Ардын намын гишүүдийн 33% орчим нь эмэгтэй, орон нутгийн зөвлөлийн 6% нь эмэгтэй даргатай. Намын дүрмээр хоёр дэд ерөнхийлөгчтэй, үүнээс нэг нь эмэгтэй байхаар заасан; Гүйцэтгэх зөвлөлийн 10 сонгуульд гишүүнээс нэг нь эмэгтэй; Намын зөвлөлийн 25 сонгуульд гишүүний 6 нь эмэгтэй байна.

5. Үндэсний ассамблейд тус намаас гишүүн байхгүй, эмэгтэй зөвлөх, сайд байхгүй.

6. НАМД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Словений Ардын намын (САН) эмэгтэй гишүүдийн намын байгууллага, муж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагад ажиллаж буй байдлыг шинжлэн үзэхэд эмэгтэйчүүд намын байгууллагад дутуу төлөөлөлтэй байгаа нь харагдаж байна. Тэр ч байтугай намын гишүүн эмэгтэйчүүдийн тоотой хувь тэнцэж ч чадахгүй байна. Намын эмэгтэй гишүүд муж, орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх жингийн дунджид ч хүрч чадахгүй байгаа бөгөөд Европын орнуудын дундажтай харьцуулбал бүр доогуур байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Энэхүү Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталснаар тус Намаас эмэгтэй гишүүдийн тоог нэмэгдүүлэх, Намын байгууллагад мөн Европын парламент, Үндэсний Ассамблей, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхийлөгчийн сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалтанд эмэгтэйчүүдийн төлөөллийг өсгөх үүднээс тусгай арга хэмжээ авна. Ийнхүү тус Намаас орон нутгийн өөрөө удирдах байгууллага, муж, бусад байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэхэд хувь нэмэр оруулна. Улмаар Словенид эмэгтэйчүүдийн төлөөлөл Европын холбооны гишүүн улсуудтай харьцуулахад өсөн нэмэгдэхэд САН-аас шүүд хувь нэмэр оруулна.

АВАХ АРГА ХЭМЖЭЭ

1. Намын дүрэмд өөрчлөлт оруулах, зохих заалтыг шинээр боловсруулах, батлах

Намаас Словений эмэгтэйчүүдийн холбоотой хамтран намын дараагийн их хурал эсвэл Ерөнхий зөвлөлийн холбогдох хурал хийж Намын дүрэмд өөрчлөлт оруулах эсвэл шинэ дүрэм батлах хүртэлх хугацаанд Намын дүрэмд оруулах зохих өөрчлөлт эсвэл шинэ дүрэмд тусгагдах заалтуудыг бэлтгэнэ.

2. Намаас СЭХ-ны хөрөнгө нөөц, SLS доторх санхүүжилтийг бэхжүүлнэ

Ердийн хийгддэг ажлуудаас гадна SLS дэх СЭХ-нд тус Төлөвлөгөөнд батлагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд намын дэмжлэг шаардагдах тул намаасаа хөрөнгө нөөцийн шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ.

3. Намаас SLS-ийн эмэгтэй гишүүдэд зориулсан хөрөнгийн суурь бүрдүүлнэ

Намаас СЭХ, Шинэ үе ба Словений тариачдын холбоо, Тэтгэвэрт гарсан иргэдийн холбоо, бусад клуб, холбоо, хөдөлгөөний тусламжтайгаар эмэгтэй ажилтан, нэр дэвшигчдийн тусгай бүртгэл хөтөлнө.

4. Намаас эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдэд зориулсан сургалтын хүрээнд СЭХ, Шинэ үетэй хамтран эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан сургалты хөтөлбөр боловсруулахын зэрэгцээ тэгш, шударга төлөөллийн талаар мэдлэг ойлголтыг гишүүддээ олгоно.

5. Намаас Үндэсний ассамблей, Европын парламент, орон нутгийн сонгууль, түүнчлэн намын байгууллагуудад **эмэгтэй нэр дэвшигчдийг шат дараатай нэмэгдүүлэх арга хэмжээг** авна. Намаас эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн нэрийг сөөлжүүлэн бүртгэнэ. Ингэхдээ Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хуулийг даган мөрдөнө.

ЦАГ ХУГАЦАА

Намаас тус Төлөвлөгөөн дурдсан ажлыг 2004 онд эхлэх бөгөөд 2008 оны Үндэсний ассамблейн сонгууль хүртэл амлалтаа цаг тухайд нь хэрэгжүүлнэ. 3 дугаар ажлыг 2004 онд харин 4 дүгээр ажлыг нэр дэвшигчдийн сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ЯВЦЫН ХЯНАЛТ, ХЯНАЛТ ТАВИХ

SLS дэх Словений эмэгтэйчүүдийн холбоо нь жилд наад зах нь 3 удаа үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг Намын Удирдах зөвлөлд тайлагнана. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд Намын зөвлөл хяналт тавих бөгөөд улмаар жилийн тайлангаа Словений Тэгш боломжийн газарт хүргүүлнэ. Тус Үйл ажиллагааны төлөвлөгөөг Словений Ардын намын их хурлаар батлав. Rogaška Slatina, 2003 оны 11 сарын 15.

2005 оны 1 дүгээр сарын 21.

СОЦИАЛ ДЕМОКРАТУУДЫН НЭГДСЭН ЖАГСААЛТЫН (ZLSD) ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хууль (Словений төрийн мэдээлэл, No. 59/2002), түүний 31 дүгээр зүйлд улс төрийн намууд дөрвөн жил тутамд үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, түүнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэнцвэртэй төлөөллийн асуудлаарх байр сууриал илэрхийлсэн, мөн уг байр суурийн дагуу намын байгууллагууд дотроо болон үндэсний парламентын сонгууль, орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалт, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэхдээ эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн илүү тэнцвэртэй төлөөллийг хангахын тулд баримтлах арга, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тусгасан ёстой гэж заасны дагуу ZLSD-ийн удирдлага дараахь үнэлгээ, Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж байна.

ZLSD эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэнцвэртэй төлөөллийн асуудлаар дараахь байр суурийг баримтална:

ZLSD-ийн хувьд төрийн хэрэг, бүх шатны улс төрийн шийдвэр гаргах үйл явц дах жендэрийн тэнцвэртэй төлөөллийн асуудал нь ардчиллын суурь асуудлуудын нэг юм. Энэ бол ардчиллын агуулгын ч, хэлбэрийн ч асуудал юм: агуулгын гэж байгаагийн учир нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс бодлогод өөр өөр түүхэн болон хувийн түршлагаа оруулж ирдэг бөгөөд улс төрийн тэргүүлэх чиглэлийн хувьд, түүнийг хэрэгжүүлэх хэлбэр, цаг хугацааны хувьд ялгаатай байр суурьтай байдаг; хэлбэрийн гэж байгаагийн учир нь тэнцвэртэй төлөөлөлгүйгээр ардчилал бодитой орших боломжгүй юм. Иймээс ZLSD нь эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхагдсан цөөнх байх ёсгүй, тэнцвэртэй эрх мэдэлтэй байх эрх бүхий хүмүүс төрөлхтний тэн хагас гэж үзэж байгаа юм.

Эмэгтэйчүүд улс төрийн эрх мэдэлд хүрэх тэгш боломж эдлэхэд тулгарч буй бэрхшээл нь түүхэн, бүтэц зохион байгуулалтын шалтгаантай бөгөөд тэдгээрийг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эв санааны нэгдэл, хамтын үйл ажиллагааны үндсэн дээр, мөн ардчиллын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, улс төрийн янз бүрийн намуудын чадавхийг бэхжүүлэх замаар л арилгах боломжтой юм.

ZLSD байгуулагдсан цагаасаа хойш эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломжийг дотроо болон улс төр, төрийн хэргийн ерөнхий хүрээнд сайжруулахыг байнга чармайж ирсэн билээ. Байгуулагдсан цагаасаа хойш ZLSD нь эмэгтэйчүүдийн бүлгийг тогтмол ажиллуулж ирсэн бөгөөд намын бүхий л байгууллагын сонгуульд хүйсийн бүтэц нь боломжтой бол, аль нэг хүйс нь 30 хувийг бүрдүүлж байхаар, хожим 40 хувийг бүрдүүлж байхаар шийдвэр гаргаснаас гадна 1995 онд орон нутгийн болон үндэсний түвшинд нэр дэвшигчийг сонгох журамд дээрх харьцааг мөрдсөн байна.

ZLSD нь засгийн газар, захиргааны хамгийн хариуцлагатай албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог зориуд анхааран нэмэгдүүлж ирлээ. ZLSD жендэрийн тэгш байдал албан ёсоор, бүрэн дүүрэн тогттол уг хүчин чармайлтаа үргэлжлүүлэх болно.

Ийм зорилгоор ZLSD Үйл ажиллагааны дараахь төлөвлөгөөг баталж байна:

Намын дотоод ардчиллыг бэхжүүлэх талаар

1. Намаас жилийн төлөвлөгөө, санхүүгийн хөтөлбөртөө Эмэгтэйчүүдийн форумд зориулсан тусгай санг оруулж, тус байгууллагын ажил саадгүй явагдахад зориулсан санхүүжилтийг аажим нэмэгдүүлнэ.
2. Намаас эмэгтэй гишүүдийн мэдлэг, өөртөө итгэх итгэл, эв санааны нэгдэл, хэлхээ холбоог бэхжүүлэхэд зориулсан тусгай сургалтыг боловсронгуй болгож, хэрэгжүүлнэ.
3. Намаас эмэгтэй, эрэгтэй гишүүддээ зориулан явуулах жендэрийн тэгш байдлын талаарх сургалтыг боловсронгуй болгож, тогтмол зохион байгуулна.

4. Намаас сонгуульт хугацааны дотор жилд наад зах нь нэг удаа тэгш боломжийн талаар тусгай бага хурал хийж, ажлын үр дүн, цаашдын арга хэмжээг үнэлж, хэлэлцдэг байна.
5. Намаас жендэрийн тэгш байдлын талаар хамтран ажиллах боломжоор хангах үүднээс эмэгтэй, эрэгтэй идэвхтэн, эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигч, ажилтнууддаа сургалт хийнэ.
6. Намаас ирээдүйн эмэгтэй нэр дэвшигч, зөвлөх, тойргийн ажилтан, парламентын гишүүн, төрийн нарийн бичгийн дарга, сайд нарт зориулсан сургалтын тусгай хэлбэрийг нэвтрүүлнэ.
7. Намаас зохион байгуулах сургалтанд эмэгтэй, эрэгтэй гишүүдийг тэгш хамруулна.
8. Намаас сонгуулийн сурталчилгааны ажил зохион байгуулахдаа жендэрийн тэнцвэртэй төлөөллийн ач холбогдлыг онцлон тэмдэглэнэ.
9. Намаас хууль тогтоомжийн аливаа нэмэлт өөрчлөлтийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш боломж олгож байгаа эсэхээр нь хянан дүгнэж, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, гэр бүл, нийгмийн бодлогын хүрээнд тэгш боломж олгоход тусгайлан анхаарах замаар эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш нөхцөл байдал бий болгохыг дэмжинэ.

Хэвлэл мэдээлэл ба тэгш боломж

1. ZLSD нь эмэгтэйчүүдийг хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх, олон нийттэй уулзах зэргийг онцлон дэмжиж, хэвлэлийн бага хуралд оролцогчдын жендэрийн төлөөлөл тэнцвэртэй байхад анхаарч байна.
2. Намаас нийгэм, төрийн хэргийн янз бүрийн салбарт ажиллаж буй ирээдүйтэй эмэгтэйчүүдийн жагсаалт гарган, мэргэжлийн янз бүрийн сэдвээр олон нийтэд хандах ярих боломж гарах үед дэмжин сурталчилж байна.
3. Намаас жендэрийн тэгш төлөөллийн бодлогоо олон нийтэд идэвхтэй сурталчилна.

Тэгш боломж ба нэр дэвшигчийг сонгох журам

1. Дараагийн их хуралд намын удирдлагаас 51, 52 дугаар зүйлд өөрчлөлт оруулах саналыг дэвшүүлэх бөгөөд тэдгээрт хүн амын болон намын бодит бүтэц, мөн үндэсний болон орон нутгийн жагсаалтын бүтцийг авч үзсэн.
2. Намын дарга болох Ерөнхийлөгч нь эрэгтэй бол Дэд ерөнхийлөгч нь заавал эмэгтэй, эсвэл эсрэгээрээ байхаар заалт оруулна.
3. Намаас Европын холбооны сонгууль, Үндэсний ассамблейн сонгуульд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нэрийг сөөлжүүлэн байршуулах зарчмыг байнга баримтална.
4. Намаас орон нутгийн сонгуульд саналын наад зах нь 10 хувийг авсан үед мөн сөөлжих зарчмыг хэрэгжүүлнэ.

Словений бодлогод жендэрийн тэгш байдлыг хэрэгжүүлэхийн тулд ZLSD:

1. Сонгуулийн болон бусад хууль тогтоомжид эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломжийг тусгахын тулд бололцоотой бүхнээ хийнэ, мөн бусад намтай улс төрийн тохиролцоон хүрэхийг байнга эрмэлзэнэ.
2. Парламентын бүлэг, тус намын сайд нар жендэрийн тэгш төлөөллийг хангахад сөрөг нөлөө үзүүлж буй сонгуулийн тойрог байлгахгүйн тулд Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахыг байнга эрмэлзэнэ.

3. Парламент дахь бүлэг нь пропорционал тогтолцоотой бүхий л сонгуульд эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн нэрийн сөөлжүүлэн оруулах зарчмыг хатуу мөрддөг байх асуудлыг дэвшүүлнэ.
4. Намаас улс төрийн албан тушаал, өргөмжлөл, бусад ажил (орон нутаг, парламентын гишүүний үүрэг гэх мэт) төвлөрөхөөс хүний нөөцийн бүхий л журмаар сэргийлэх хүчин чармайлт гаргана.
5. Олон нийтийн байгууллагуудын Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн байхтай холбоотой хүний нөөцийн журамд нэр дэвшигчид адил чадавхтай байх тохиолдолд төлөөлөл нь цөөнх байгаа нэр дэвшигчийг намаас дэмжинэ.

ZLSD-ийн Эмэгтэйчүүдийн форум

1. Эмэгтэйчүүдийн форум сүлжээг бэхжүүлж, намын орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгийг сүлжээг нэмэгдүүлнэ.
2. Хэвлэлийн бага хурлын тогтмол хийж, нийгмийн нэн чухал асуудлаар, ялангуяа төрийн хэрэг дэх жендэрийн тэгш байдлын асуудлаарх байр сууриа олон нийтэд танилцуулж байна.
3. Эмэгтэйчүүдийн форум нь жендэрийн тэгш байдлын асуудлаарх нөхцөл болзлыг хангахын тулд эмэгтэйчүүд, залуучууд, мөн намын сүлжээнд сургалт явуулахад оролцоно.
4. Эмэгтэйчүүдийн форум нь эдийн засаг, нийгмийн янз бүрийн салбарт амжилттай ажиллаж буй, өсөх ирээдүйтэй эмэгтэйчүүдийн жагсаалт гаргана.
5. Эмэгтэйчүүдийн форум нь залуу, ирээдүйтэй идэвхтнүүд MF, Эмэгтэйчүүдийн форум, ZLSD-д шилжин ороход нь шууд дэмжлэг, сургалт, бүртгэл, хүний нөөцийн журмаараа дамжуулан туслалцаа үзүүлнэ.
6. Орон нутгийн түвшинд Эмэгтэйчүүдийн форум нь залуу эмэгтэй гишүүд орон нутгийн улс төрд ороход онцгой анхаарал хандуулж, тэднийг сонгогдох боломжтой газарт нэр дэвшигчийн жагсаалтанд оруулна.

Саналыг бэлтгэсэн: ZLSD Эмэгтэйчүүдийн зөвлөл, дарга: Alenka KOVŠCA

Хавсралт 4. Нэр дэвшигчийг сонгох үйл явцын дөрвөн гол бэрхшээл

Бэрхшээл 1. Нэр дэвшигчийг тодруулах үйл явц албан бус, зохицуулалтгүй байх

Нэр дэвшигчийн тодруулан сонгох үйл явц албан бус, зохицуулалтгүй бол уг үйл явц *ил тод биш* гэсэн үг. Намын гишүүн элсүүлэх журмыг намын дүрэмд тодорхой тусгаж, ялангуяа насны доод хязгаар, намын гишүүний тодорхойлолттой байх зэрэг шаардлага тавигддаг ч нэр дэвшигч сонгох үйл явц ихэнхдээ ил тод бус, зохицуулалтгүй, тодорхой бус байдаг. Намууд өөр хоорондоо бага зэрэг ялгаатай ч ихэнх тохиолдолд нэр дэвшигчийг сонгох бичгээр гаргаж, албажуулсан, ил тод үйл явц байхгүй байна³⁰³. Нэгэнт нэр дэвшигчид тавигдах шаардлага, үр чадвар, мэргэжил, мэдлэгийг албан ёсоор заагаагүй тул сонгох үйл явц албан бус, ил тод явагдах бүхий л боломж бий.

Уг үйл явц ил тод бус байхын үр дагавар нь намын удирдлагад ойр биш хүмүүс намын ямар байгууллага, хороо нэр дэвшигчийн сонгох талаар мэдэлгүй үлддэг. ЕАБХАБ-ын улс орнуудын зарим нам нэр дэвшигч сонгох хороо байгуулсан, эсвэл нэр дэвшигчийг намын их хурлаараа баталдаг журамтай байна. Гэвч уг хорооны бүрэлдэхүүн, бодит нөлөө, үйл ажиллагаандаа баримтлах зарчим нь бүдэг бадаг хэвээр байна. Тухайлбал, намын янз бүрийн түвшинд сонгон шалгаруулах хороо хэрхэн байгуулагддаг; намын гишүүд эдгээр хороонд хэрхэн нэр дэвшиж ордог; эдгээр хорооны хараат бус байдал бодил амьдралд хэр хэрэгждэг; эдгээр хорооны үйл ажиллагааг хэрхэн зохицуулж, хяналт тавьж, хэрэгжилтийг хангадаг талаар тодорхой журам байхгүй байна.

Тиймээс нэр дэвшигчийг сонгох хороодод эмэгтэйчүүд байхгүй тохиолдолд нэр дэвших үйл явц нь эмэгтэй нэр дэвшихийг горилогчдод хүртээмжгүй, ялгаварлан гадуурхалгүй, субъектив болоход тун амархан. Нэр дэвшигчийг сонгох, албан бус зохицуулалтгүй үйл явц нь нам доторх албан бус сүлжээний ач холбогдлыг өсгөх бөгөөд эрэгтэйчүүд давамгайлсан улс төрийн соёлд энэ нь эмэгтэйчүүдэд хохиролтой байдаг. Ардчилал харьцангуй шинэ байгаа хуучин социалист орнуудад эрэгтэй улс төрчид намын гишүүн эрэгтэйчүүдээ нэр дэвшүүлэх арга зам боловсруулж, холбоотон бий болгох практик аль хэдийн бий болоод байна. Энэ нь нэр дэвшигчийг сонгох шийдвэр нь хаалттай хаалганы цаана төдийгүй эмэгтэйчүүд очих боломжгүй байр саванд, цаг хугацаанд гарч байна гэсэн үг юм.

Бэрхшээл 2. Нэр дэвшигчийг сонгох тохиолдлын шинжтэй үйл явц

Нэр дэвшигчийг сонгох үйл явц тохиолдлын, албан бус байдлаар явагддаг бол энэ нь *улс төрийн намуудын ардчилсан арга замаар ажиллах явдлыг сулруулж, тэдний сонгогчдын өмнө хүлээх хариуцлага тайлагналыг бууруулж байгаа хэрэг юм*. ЕАБХАБ-ын зарим улс орнууд дахь улс төрийн намууд улс төрийн орчны өөрчлөлт, олон нийтийн санаа бодол, хэвлэл мэдээллийн түр зуурын нөлөө зэрэгт байнга хариу үйлдэл үзүүлж байдаг тул нэр дэвшүүлэх ажлыг ихэнхдээ тохиолдлын байдлаар, цагийг нь тулган хийж байна. Намын дотоод тодорхой журам, удирдамж байхгүй тул зориг орсон намын удирдлагууд аль нэг нэр дэвшигчийг нөгөөгөөр солих, эсвэл намын жагсаалт дахь байршил, тойрог солих зэргээр нэр дэвшигчийг сонгох үйл явцад шууд хөндлөнгөөс оролцох боломжтой байдаг. Тиймээс нэр дэвшигчийн жагсаалт сонгуулийн байгууллагад хүргүүлэх албан ёсны хугацаа дуусахын өмнөхөн л эцэслэгддэг.

Энэ бүхэн эмэгтэйчүүдэд нөлөөлдөг, учир нь хамгийн сүүлийн мөчид намын жагсаалт дахь байр өөрчлөгдөхөд ихэнхдээ эмэгтэйчүүдийг хойшоо оруулсан байдаг. Зарим үед

303 Sarah Childs, Joni Lovenduski and Rosie Campbell, "Women at the top: changing numbers, changing politics", Hansard Society, 2005, <www.hansardsociety.org.uk>

нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон эмэгтэй нэр дэвшигчийг намын удирдлагууд сонгуулийн байгууллагад өгсөн жагсаалт дээрээ хасаад хүргүүлсэн байдаг. Эсвэл намууд заримдаа сонгогчдыг татахын тулд намын жагсаалтдаа эмэгтэйчүүдийг оруулсан ч эмэгтэй нэр дэвшигчдийг сайн дураараа нэрээ татаж, намын өөр нэг гишүүнд суудлаа өгөхийг “урьдаг”. Энэ тохиолдолд Киргизстанд гарч байсан. Өөр бүр хэтэрсэн жишээ гэвэл бүр сонгуулийн өмнө “гэрээ” байгуулдаг явдал юм. Энэ тохиолдолд эмэгтэй нэр дэвшигчдийг гэр бүлийн үүрэг хариуцлага ихтэй, мэргэжлийн ажлын хүлээсэн үүрэг зэрэг шалтгааныг үндэслэл болгон тайлбарлахыг тулгадаг.

Тохиолдлын, цагийг нь тулгаж дуусгадаг нэр дэвшигчийг сонгох үйл явцын өөр нэг жишээ болгон Казахстаны зарим улс төрийн намын үйлдлийг дурдаж болох юм. Тэд нэр дэвшигчийн жагсаалтыг сонгуулийн хороонд өгөхдөө үсгийн дарааллаар өгдөг. Харин нэр дэвшигчдээс хэн нь ялах вэ гэдгийг тухайн нам парламентанд хэдэн суудал авах нь тодорхой болсны дараа шийдэгддэг. Өөрөөр хэлбэл, намын нэр дэвшигчдийн жагсаалтыг урьдчилан гаргадаггүй, нэр дэвшигчид өөрсдөө ч жагсаалтын аль хавьд бичигдсэнээ мэддэггүй. Энэ нь эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдэд аль алинд нь сөрөг нөлөөтэй ч ялангуяа нэр нь төдийлөн сайн танигдаагүй, санхүүгийн хөрөнгө нөөц, хандивлагчтай харилцах боломж нь эрэгтэйчүүдээс сүл эмэгтэй нэр дэвшигчдэд илүү хохиролтой юм.

Бэрхшээл 3. Нэр дэвшигчийг сонгох дээрээс доош чиглэсэн үйл явц

Дээрээ нэр дэвшигчийг сонгодог үйл явц нь намын дотоод ардчиллын зарчимд сөргөөр нөлөөлж, намын анхан шатны түвшин дэх дэмжлэгийг сулруулдаг. Улс төрийн нам доторх нэр дэвшигчийг сонгох ажлыг ихэвчлэн дээрээс хийдэг тохиолдолд намын нэрсийн жагсаалт бол үндсэндээ намын удирдлага, намын зөвлөхүүд гэсэн хаалттай хүрээнийхний хувь хүний сонголт болж хувирдаг. Шийдвэр гаргалтын энэхүү захиргаадлын хэлбэр нь улс төрийн намд үнэнч байр ойлголтыг бусниулж, нам, сонгогчдод үнэнч байх нь намын даргад үнэнч байх ойлголтоор солигдох талтай.

Зөвлөлдөөний бус үг үйл явц нь улс төрийн намын орон нутгийн болон бүсийн салбарын нэр дэвшигчийн сонголтод нөлөөлөх боломж бололцоог хязгаарлаж, орон нутагт буй намын гишүүдийн нэр дэвших шударга үйл явцад оролцох эрхийг хязгаарлана. Ялангуяа үндэсний түвшний намын удирдлагууд орон нутагт нэр дэвшигчийг тулган дэвшүүлснээр намын орон нутаг дахь салбарын удирдлагын байр суурь ганхана. Энэ нь эргээд орон нутгийн салбарын ач холбогдлыг бууруулахын хамт намын төлөөллийн чанарыг бууруулна. Богино хугацаанд ийм үйлдэл нь орон нутаг дахь намын дэмжлэгийг сулруулдаг бол урт хугацаанд орон нутаг дахь намын гишүүд, сонгогчид тухайн нам ардчиллыг хэрэгжүүлэх бодит эрмэлзэлтэй эсэхийг асууж, ерөнхийдөө ардчилсан тогтолцоонд үл итгэх байдал тархах талтай.

Бэрхшээл 4. Нэр дэвшүүлэх үйл явц нь хөрөнгөнд захирагдсан байх

Нэр дэвшүүлэх үйл явц нь хөрөнгө мөнгөний асуудалд захирагдан явагддаг бол энэ нь нэр дэвших боломжтой хүмүүсийн тоог цөөрүүлж, мерит буюу мэдлэг чадварт тулгуурлах шалгуурын ач холбогдлыг бууруулна. “Хөрөнгө мөнгө” гэдэгт энэ тохиолдолд санхүүжилт авах боломж, нэр нь танигдсан байдал багтах бөгөөд эдгээр нь мэргэжлийн үр чадвар, боловсрол, намд зүтгэсэн байдал гэх мэт мерит буюу мэдлэг чадварт тулгуурласан шалгуурыг үгүйсгэж байдаг. Сонгогчдод хүрч ажиллах, шинэ сонгогчдыг аль болох татах зорилгоор улс төрийн намууд гишүүдээсээ бус харин нэр хүнд бүхий хувь хүнийг элсүүлж, нэрийг нь дэвшүүлэх явдал гардаг. Тэрхүү шинэ хүмүүс нь өмнөх амжилт, нэр төр, нийгмийн амьдралын бусад салбар дахь сүлжээгээ

хамт авчирдаг тул сонгогчдын дунд “нэр нь танигдсан” байдаг. Улс төрийн намууд ийнхүү нэртэй хүмүүсийг өөртөө татсанаар нэмэлт санал авч чадах ч энэ практик нь нэр дэвшигчийг сонгох үйл явцын ил тод, шударга байдлыг сулруулж, намын ердийн, удаан зүтгэсэн гишүүдийн нэр дэвших боломжийг хязгаарладаг.

Дээрх чиг хандлага нь зарим талаар сонгуулийн сурталчилгааны ажлын зардал өндөр байгаатай холбоотой бөгөөд улс төрийн намууд гишүүд, хандивлагчдын санхүүгийн дэмжлэгт онцгой ач холбогдол өгөхөд хүргэдэг. Ингэснээр өөрийн гэсэн санхүүгийн дэмжлэгтэй, гэхдээ намын ажил, улс төрд ерөнхийдөө бараг оролцож байгаа нэр дэвшигч сонгогдохд хүрдэг. Улмаар мэргэжлийн үр чадвар, авъяас, зүтгэл, амжилт зэрэг сонгон шалгаруулан бусад шалгуур хойш тавигддаг.

Гэвч хачирхалтай нь, ийм хөрөнгө мөнгөнд захирагдсан нэр дэвших үйл явц төлөөлөл сул байгаа хүйсийн хүмүүст зориулан хуулиар квот тогтоосон газар илүү тархсан байдаг. Хуулийн шинэ заалтыг даган мөрдөхийн тулд тухайлбал, намууд өөрийн гэсэн сүлжээтэй, дээгүүр тушаалын хүмүүстэй харилцаатай, эсвэл хувийн санхүүгийн нөөц зэргийг авчирч чадах эмэгтэй нэр дэвшигчийг хайдаг. Энэ нь намын гишүүн эмэгтэйчүүд нэр дэвшигчийн жагсаалтанд орох боломжийг бууруулна гэсэн үг юм. Бүхэлд нь авч үзвэл, хөрөнгө мөнгөнд захирагдсан нэр дэвших үйл явц эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү хохиролтой, учир нь эмэгтэйчүүд ЕАБХАБ-ын бүс нутагт эдийн засгийн хувьд бүхэлдээ хохиролтой нөхцөлд байгаа бөгөөд тэдний улс төрийн сүлжээ, хандивлагчийн дэмжлэг авах боломж сул байна.

Энэ бол зүгээр нэг тооны асуудал биш бөгөөд ер нь намын жагсаалтанд эмэгтэйчүүдийн тоо цөөн байна гэдэг нь тэд сурталчилгааны ажилд бага оролцоно, мөн сурталчилгаанд сул дүр төрхтэй дүрслэгдсэнээр нийт эмэгтэй иргэдэд нөлөөлж, эмэгтэйчүүд сонгогдох магадлал багатай гэсэн ойлголтыг улам өөгшүүлэн, олонд сайн танигдаж чадаагүй байгаа эсвэл хөрөнгө нөөц муутай эмэгтэйчүүдийг сонгуульд өрсөлдөхөөс татгалзуулах талтай³⁰⁴. Энэ нь эмэгтэйчүүд цөөн байх, эсвэл ямар эмэгтэйг одоогийн тогтолцоо дэмжих гаргаж ирж байгаа нь эмэгтэйчүүд хэдий намын улс төрд авчрах өөрийн гэсэн мэдлэг чадвартай ч улс төрийн карьер хөөх итгэлийг бууруулж “сөрөг нөлөөтэй” гэдгийг харуулж байна.

Хавсралт 5. ЕАБХАБ-ын гишүүн орнуудын улс төрийн намуудаас сайн дурын үндсэн дээр баталсан жөндөрийн квот*

Улс орон	Нам	Квот (эмэгтэйчүүдийн эзлэх хувь)
Австри	Ногоон- Ногоон альтернатив	50
	Австрийн Ардын нам	33.3
	Австрийн социал демакрат нам	
Хорват	Социал демократ нам	40
Кипр	Социал демократуудын хөдөлгөөн	30
	Киприйн ардчилсан хөдөлгөөн	30
Чех	Социал демократууд	25
Герман	Социал демократ нам	40
	Зүүний нам	50
	Альянс 90/Ногоон	50
	Христийн ардчилсан холбоо	33.3
Унгар	Унгарын социалист нам	20
	Улс төрийг өөрөөр хийж болно	30
Исланд	Социал демократ альянс	40
	Зүүн-ногоон хөдөлгөөн	50
	Дэвшилтэт нам	40
Итали	Ардчилсан нам	50
Литва	Социал демократ нам	30
Люксембург	Христийн социал ардын нам	33
	Зүүний нам	50
	Ногоон нам	50
Мальт	Хөдөлмөрийн нам	20
Нидерланд	Хөдөлмөрийн нам	50
	Ногоон зүүний нам	50
Норвеги	Социалист нам	40
	Норвегийн хөдөлмөрийн нам	50
	Төв нам	40
	Христийн ардын нам	40
Румын	Ардчилсан нам	30
	Социал демократ нам	30
	Словакийн ардын нам	50
Швед	Социал демократ нам	50
	Зүүний нам	50
	Ногоон нам	50
Швейцар	Швейцарийн социал демократ нам	40
Их Британи	Хөдөлмөрийн нам	50 (ялах боломжтой суудалд)

*Үүнд хуулиар тогтоосон квотонд багтсан намын квотыг оруулаагүй болно.

Хавсралт 6. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын квот нэвтрүүлэх үе шатчилсан удирдамж

1. Өөрийгөө бэлтгэ

- Намын гишүүн эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь, танай намд саналаа өгдөг эмэгтэй сонгогчдын эзлэх хувь, удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүд хэдэн хувь эзэлж байгаа зэргийг мэдэж авах,
- Эдгээр эмэгтэйчүүдээс ашиглагдахгүй байгаа боломж, хөрөнгө нөөц, намд оруулж буй хувь нэмрийг үнэлж үзэх.
- Жендэрийн тэгш байдлын албан бус арга хэмжээ нэвтрүүлэхээс эхлэх: намын хэлэлцээрүүд, намын аливаа үйл явдал, сургалт, олон улсын болон бусад арга хэмжээ болон намын илтгэгчид, намын хууль боловсруулах санаачилгад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиныг оруулах, намын эмэгтэй гишүүд хэвлэл мэдээллээр нэвтэрч байх явдлыг хангах гэх мэт.
- Нам дотроо эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах байгууллагад оруулах, илтгэгчээр оруулж байх, эрэгтэй, эмэгтэй хоёр ерөнхийлөгчтэй байх журмыг нэвтрүүлэх гэх мэт.
- Эдгээр санаачилга хүлээж байснаас өөр болбол дахин үнэлэх. Нэр дэвшигчдийн жендэрийн тэнцвэртэй мэдээллийн санг бий болгох.
- Танай улс жендэрийн тэгш байдал зэрэг асуудлаар олон улсын өмнө ямар үүрэг хүлээснийг нягтлах.

2. Үндсэн багаа бүрдүүл

- Нам дотроо эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх талаарх санаагаа намын илтгэлтэй гишүүдтэй хэлэлцэх, тус арга хэмжээ нь намд ямар ач тустайг танилцуулах.
- Дараахь асуудлыг шийдэх. Үүнд:
 - ✓ ямар арга хэмжээг нэвтрүүлэхийг хүсч байна вэ;
 - ✓ уг арга хэмжээгээ та юу гэж нэрлэх вэ;
 - ✓ уг санаагаа нам дотроо сурталчлахын тулд та ямар үндэслэл ашиглах вэ;
 - ✓ танд зорилгодоо хүрэхэд хэн туслах вэ;
 - ✓ та уг санаачилгаа хэзээ хэрэгжүүлж эхлэхийг хүсч байна вэ. Цаг хугацаа бол чухал; тиймээс парламентын сонгууль болоод өнгөрсөн даруйд нам дотроо зөвшилцөл үүсгэх ажлаа эхлэх нь зүйтэй.

3. Нам дотроо дэмжлэг бий болго

- Намын нэр хүндтэй, хүмүүсийн хүндэлдэг эрэгтэй улс төрчдийг дэмжлэгийг ав.
- Ингэхийн тулд эхлээд намын гишүүн эмэгтэйчүүд, намын бүх шатны удирдлагын дэмжлэгийг авахаас эхэлж болно.
- Танай намд эмэгтэйчүүдийн бүлэг байдаг бол уг бүлэгтээ намын эмэгтэйчүүдийг дайчлан дэмжүүлэх даалгавар өгч болно. Эсвэл сайн дурын арга хэмжээ нэвтрүүлэх зорилгоор өөрөө эмэгтэйчүүдийн бүлэг байгуулж болно.
- Эмэгтэйчүүдийн бүлэг нь намын бүх шатны эмэгтэй удирдлагыг нам дотроо эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгод татн оруулах ёстой.
- Нам өөрийн сонинтой бол бусад орны улс төрийн намуудад эмэгтэйчүүд ямар үүрэг гүйцэтгэдэг талаар, мөн намынхаа эмэгтэй гишүүдийн амжилтын талаар бичих замаар уншигчдын дэмжлэгийг авах.
- Улс төрийн намууд дахь жендэрийн тэгш байдлын асуудлаар ажилладаг ТББ-уудад мэдэгдэж, тэдний дэмжлэг, зөвлөгөөг авах.

4. Зөвшилцөл бий болго

- Тухайн шинэ арга хэмжээ нь яг ямар хэлбэр маягтай, ямар түвшинд хэрэгжих талаар намын бүхий л түвшинд зөвшилцөл бий болсон байхад анхаарах.
- Тухайн улсдаа танай нам эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх сайн дурын арга хэмжээ авах гэж байгаа эхний нам бол түүнийг давуу тал болгон хувиргаж, өөрийн хүчин чармайлтыг сурталчлан, бусад намын энэ чиглэлээр дутагдлыг онцлон тэмдэглэх.
- Хэрэв улс төрийн бусад нам адил төстэй арга хэмжээг нэвтрүүлчихсэн байгаа бол тэднээс арай өндөр түвшинд хүрэх зорилго тавих ёстой.
- Та хэрэгжүүлэхээр шийдсэн арга хэмжээгээ жендэрийн төвийг сахисан үг хэллэгээр томъёолохыг танд зөвлөж байна!

5. Өөрчлөлтөө институтчилж үлдээ

- Нам дотроо эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх сайн дурын арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө бэлтгэх, түүнд хүрэх түвшингээ нарийн тодорхойлж, ахиц дэвшлээ үнэлэх шалгуураа тодорхой гаргах.
- Хүрэх түвшин нь тоон (намын жагсаалтанд орох эмэгтэйчүүдийн тоо гэх мэт) болон чанарын (үг өөрчлөлт, түүний үр нөлөөг намын гишүүд хэрхэн ойлгож байгаа гэх мэт). Эдгээр хүрэх түвшингийн шалгуур болон хэрхэн хэмжихээ урьдчилан тодорхойлсон байх ёстой.
- Намын их хурлын үеэр удирдлага эсвэл бусад шийдвэр гаргах байгууллагын (эмэгтэй төлөөлөгчдийг оролцуулан) хурал зарлаж, энэ шийдвэрийг батлах.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх сайн дурын арга хэмжээг намын дүрэмд суулгах.

6. Тодорхой хүрэх түвшин, цаг хугацаа тавь

- Сайн дурын арга хэмжээг орон нутаг, бүс, үндэсний түвшний сонгууль зэргийн хамгийн эхнийхэд шууд хэрэглэж эхлэх.
- Дараагийн сонгуульд уг сайн дурын арга хэмжээ нь хэр үр дүнтэй байсныг үнэлэхийн тулд эмэгтэйчүүд сонгогдох хамгийн бага тоо, нэр дэвшигчийн жагсаалт дахь тэдний байршил гэх мэтээр шалгуурыг тодорхой болгох. Сонгуулийн тогтолцоо нь тохиромжтой бол нэр дэвшигчийн жагсаалтанд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг сөөлжүүлэн байрлуулах асуудлыг дэвшүүлж болно.
- Нэр дэвшигчийг сонгох үйл явцыг албан ёсны болгох. Хөтөлбөрийнхөө ардчилсан шинж чанарыг улам бататгахын тулд дутуу төлөөлөлтэй байгаа хүйсийн хүмүүст төдийгүй бусад орхигддог бүлгүүдийн (тухайлбал, үндэстэн ястны цөөнх, шашны цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт) төлөөллийг нэмэгдүүлэхэд шат дараатай арга барилыг ашиглаж болно. Энэ нь шинэ сонгогч, дэмжигчдийг татах, мөн шинэ хандивлагчдыг татахад тусалж болох юм.
- Намын дотоод шийдвэр гаргах байгууллага, нэр дэвшигчийн жагсаалт, парламентад суларсан суудал, бусад сонгуульд байгууллагад эмэгтэй хүн ажиллаж байсан бол түүний суларсан орон тоонд эмэгтэй хүн нөхөн ордог дүрмийг нэвтрүүлэх.

7. Ахиц дэвшлээ хянах

- Төлөвлөгөөнийхөө хэрэгжилтийн байдлыг 3-6 сар тутамд тогтмол эргэн нягталж байх. Ингэхдээ дээр 5 дугаар зүйлд дурдсанчлан, хүрэх зорилтын тоон болон чанарын шалгуурыг харгалзах ёстой.
- Танай намаас тухайн хүрэх зорилтыг хангахад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, түүний цаана буй шалтгааныг үнэлэх, мөн түүнийг даван гарахад ямар алхам хийж болохыг тодорхойлох. Танай намд хэн, юу ахиц дэвшил гарахад саад хийж байна, мөн танай намаас үг зорилтод хүрэхэд хангалттай, зохистой хөрөнгө нөөцийг хуваарилсан эсэхийг тогтоох.
- Нам дотроо гарсан ахиц дэвшил нь ямар нөлөө үзүүлж байгаа талаар хүмүүсийн санаа бодлыг сонсох, мөн өөр ямар нэмэлт шалгуур нэмж оруулж болох талаар тогтмол хэлэлцүүлэг хийх.

8. Амжилтаа мэдээлж, танилцуулж, санал авах

- Намын гишүүддээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны сайн дурын арга хэмжээг нэвтрүүлснээр ямар амжилт, бэрхшээл гарч байгааг мэдээлж байх.
- Гарсан үр дүн, дүгнэлтийн талаар нам даяар хэлэлцүүлэг хийж, намын гишүүдийг саналаа өгөхийг уриалах.
- Амжилтандаа итгэлтэй байгаа бол авсан арга хэмжээнийхээ үр дүнг сонгогчдод цахим шуудан, нийгмийн сүлжээ, намын цахим хуудас, телевиз, ТББ зэргээр дамжуулан түгээн сурталчлах.
- Авсан арга хэмжээнийхээ үр дүнг гадаад дахь намынхаа түнш, мөн олон улсын байгууллага (ЕАБХАБ/АИХЭА гэх мэт), олон улсын судалгааны байгууллагуудад (Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн гэх мэт) хүргүүлэх. Энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх сайн дурын дурын арга хэмжээг нэвтрүүлэх таны туршлагаас бусад тал суралцахад тусална.

9. Дараагийн алхмуудаа бодож төлөвлөх

- Намын шинэ болон туршлагатай гишүүдэд мэдлэг ойлголт өгөх хөтөлбөр боловсруулах.
- Намын эмэгтэй, эрэгтэй гишүүд үлгэр болж, бусаддаа дэмжлэг үзүүлэхийг уриалах. “Хатан зөгий” гэжиг буюу нам доторх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны асуудлыг нэг эмэгтэй өмчилж бусадтайгаа туршлагаа хуваалцаж, амжилт гаргахад нь дэмжлэг үзүүлэхээс цааргалдаг үзэгдлийн талаар мэддэг байх.
- Квот бол улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэвшлүүлэх цорын ганц арга биш гэдгийг тодорхой илэрхийлэх.
- Намын бүхий л гишүүн нам дотроо жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах санал гаргахыг нь дэмждэг байх.
- Намд элсэн, сонгуульд нэр дэвших боломжтой эмэгтэйчүүдийг идэвхтэй эрэлхийлэх.
- Улс төрийн намуудад эмэгтэйчүүдийн оролцооны квотыг хуулиар тогтоогоогүй байгаа бол орон нутаг, бүс, үндэсний түвшинд тийм квот тогтоох санаачилга гаргах.
- Улс төрийн намуудад төрөөс санхүүжилт олгодог бол түүнийг гүйцэтгэх байгууллага, намын жагсаалт дахь эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй уяхыг оролдох. Тийм тогтолцоо байгаа бол танай нам уг санхүүжилтийг авахад шаардагдах эмэгтэйчүүдийн төлөөллийг хангасан байхад анхаарах.

Эх сурвалж: ODIHR-ын ажилтнуудаас дараахь болон бусад материалд түшиглэн боловсруулав. Үүнд: НҮБХХ, Үндэсний ардчиллын хүрээлэн, Улс төрийн хүчтэй намын төлөө эмэгтэйчүүдийн мэдэлжүүлэх нь. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх сайн практикийн удирдамж. НҮБХХ/ҮАХ. 2011; Сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш байдал: 6 алхамт үйл ажиллагааны төлөвлөгөө”, OSCE/ODIHR, 2011, <<http://www.osce.org/odihhr/78432>.

Хавсралт 7. Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх судалгааны зарим байгууллага

Жендэрийн тэгш байдлын Европын хүрээлэн (EIGE, <http://www.eige.europa.eu/>) Литвад байрладаг Европын холбооны байгууллага бөгөөд жендэрийн тэгш байдлыг сурталчилж, жендэрийн тэгш байдлын асуудлаар ойлголт мэдлэг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг. Тус байгууллагын одоо хэрэгжүүлж буй нэг санаачилга бол “Европод урам зориг өгч буй эмэгтэйчүүд” сан бөгөөд бусдад үлгэр болж, урам авах эх сурвалж болж байгаа Европын өнцөг булан бүрт буй эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийг агуулдаг. Уг сан нь тус хүрээлэнгийн Лавлах, баримтжуулалтын төвийн суурь болох зорилготой бөгөөд Европын эмэгтэйчүүдийн түршлагаас цуглуулж, тэдний амжилтыг тодруулан харуулдаг. Энэ санаачилгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараахь хаягаар орж авна уу: <http://www.eige.europa.eu/content/women-inspiring-europe>.

Ратгерс Их сургуулийн Америк эмэгтэйчүүд ба улс төр төв (<http://www.cawp.rutgers.edu/>) бол АНУ дахь Америкийн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх эрдэм шинжилгээний бүтээл, мэдээллийн хамгийн тэргүүлэх эх сурвалж гэж хүлээн зөвшөөрдөг. Нью Жерсийн их сургуулийн Ратжерс Улс төрийн Ийглтон хүрээлэнгийн нэг хэсэг болох тус төв нь улс төр, засгийн газар дахь эмэгтэйчүүдийн оролцооны талаар мэдлэг ойлголтыг түгээдэг бөгөөд төрийн хэрэгт эмэгтэйчүүдийн нөлөө, манлайллыг дээшлүүлэхийг зорьдог. Энэхүү гарын авлагыг бэлтгэж байх үед тус төвөөс боловсрол, сургалтын хоёр хөтөлбөр хэрэгжүүлж байв: “ШИНЭ манлайлал” хөтөлбөр, “Эмэгтэйчүүдэд зориулсан өрсөлдөхөд бэлэн” хөтөлбөр. 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн тус төвөөс Конгресс, мужийн хууль тогтоох байгууллагуудад буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх зорилготой үндэсний хэмжээний, нам бус “2012 төсөл” хэрэгжүүлсэн.

Газрын дундад тэнгисийн Жендэр судлалын хүрээлэн (MIGS, <http://www.medinstgenderstudies.org/>) бол Кипрт байрладаг, газрын дундад тэнгисийн бүс нутагт төвлөрөн жендэртэй холбоотой нийгэм, улс төр, эдийн засгийн судалгаа хийдэг төрийн бус байгууллага юм. Эрхэм зорилгынхоо дагуу, судалгаа, сурталчилгаа, нөлөөллийн ажил хийхээс гадна сургалт, бага хурал, бусад үйл ажиллагаа явуулдаг. Сургалт, манлайллын одоо хэрэгжүүлж буй нэг хөтөлбөр нь залуу эмэгтэйчүүдэд хандсан бөгөөд “Улс төрд залуу эмэгтэйчүүд тохирно!” гэдэг нэртэй.

Иелийн их сургуулийн Эмэгтэйчүүдийн сурталчилгааны ажлын сургууль (<http://www.wcsyale.org/>) бол АНУ болон дэлхий даяар сонгуульд болон томилогддог албан тушаалд эмэгтэйчүүдийн үүрэг, тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн жил бүр явагддаг зуны сургууль юм. Улс төрд буй эмэгтэйчүүдийн ялгаатай зүйл гэхээсээ түгээмэл хэрэгцээ, түршлагад үндэслэн 202 явагддаг тус хөтөлбөр нь улс төрд буй эмэгтэйчүүдэд тулгардаг соёлын бэрхшээлийг давахад нь дэмжлэг үзүүлдэг. Эрэгтэйчүүд ч элсч болдог тус сургуульд АНУ-ын улс төрийн хоёр тэргүүлэх намын аль алинаас нь дээд зэрэглэлийн мэргэжилтгүүд ирж сургалт явуулдаг.

Улс төрд эмэгтэйчүүдийн дэвшлийн төлөө төв Белфасны Күийн их сургууль дээр байрладаг ([http://](http://www.qub.ac.uk/cawp/aboutus.html)

www.qub.ac.uk/cawp/aboutus.html) бөгөөд улс төр, удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, нөлөөний талаар үүсэн бий болж буй асуудлуудыг судалдаг. Ялангуяа тус Төвөөс улс төр, төрийн хэрэгт оролцож буй эмэгтэйчүүдийн талаар олон нийтийн хандлага, хэвлэл мэдээллээр тэднийг дүрслэн үзүүлж буй байдал, мөн парламентад улс төрийн төлөөлөл ба эмэгтэйчүүдийн талаар жендэрийн холбогдолтой явагдаж буй хэлэлцүүлэг зэргийг судалдаг. Тус Төвөөс Их Британи, Хойд Ирланд дахь

эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар шүүмжлэлт, феминист байр суурийг тусгахыг зорьдог.

Улс төр, бизнест буй эмэгтэйчүүдийн Европын академи (EAF, <www.eaf-berlin.de>) бол Германы Берлинд байрладаг хараат бус, ашгийн төлөө бус байгууллага юм. Тус байгууллага нь эмэгтэйчүүдийг улс төрд орохыг уриалж, мэдэлжүүлж, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэхийг зорьдог. Сургалт, дагуулан сургах хөтөлбөрөөрөө дамжуулан эмэгтэй улс төрчдөд карьераа төлөвлөж, ахиулахад нь дэмжлэг үзүүлдэг. Үүний зэрэгцээ нэр дэвшигчдэд мэргэжлийн болон арга зүйн туслалцаа үзүүлдэг.

Мөн тус байгууллагаас холбооны яамд, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагуудад эмэгтэйчүүдийг элсүүлэх үйл явц, тавигдах шалгуур, тэгш боломжийн бодлого, мөн эмэгтэйчүүдэд мэргэжлийн болон гэр бүлийн амьдралаа тэнцвэртэй авч явахад нь байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох зэрэгт зөвлөгөө өгч ажилладаг. Мөн судалгаа хийж, улс төр, бизнесийн үйлчлүүлэгчиддээ зөвлөгөө өгч, мэргэжлийн түвшин дээшлүүлэх төслүүдийг хэрэгжүүлдэг.

LSE Жендэрийн хүрээлэн (<<http://www2.lse.ac.uk/genderInstitute/about/home.aspx>>) бол Европ дахь энэ тарлийн хамгийн том судалгаа, сургалтын нэгж бөгөөд онол, практикийг хослуулан, салбар дамнасан, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг. Жендэрийн асуудлаар Жендэр, хөгжил, даяаршил сэдэвт магистрын хөтөлбөр, Жендэр, бодлого, тэгш бус байдал сэдэвт магистрын хөтөлбөр гэх мэт хэд хэдэн төгсөлтийн дараахь хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Жендэрийн улс төр ба төр судалгааны сүлжээ (<<http://libarts.wsu.edu/pppa/rngs/index.html>>) бол судлаачдын сүлжээ бөгөөд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ба төрийн талаарх урт хугацааны судалгааны төсөл хэрэгжүүлж, цуврал ном гаргах, мэдээллийн сан ажиллуулж, хэд хэдэн практик төсөл хэрэгжүүлж, нийтлэлүүд гаргасан. Тус сүлжээ ажлаа 2012 онд дуусгасан. Цахим хуудас нь тус төслийн ажлыг агуулж байгаагаас гадна жендэрийн улс төр ба төрийн асуудлыг сонирхдог хүмүүст судалгааны эх сурвалж болж байдаг.

Эмэгтэйчүүдийн бодлогын талаарх хамтын бүтээл болох Харьцуулсан феминизм номыг гаргасан туршлага дээрээ үндэслэн тус сүлжээг Баруун Европ, Хойд Америкийн хэд хэдэн их сургуулийн хорин эрдэмтэн 1995 онд Нидерландын Лайдэн Их сургууль дээр болсон бага хурлын үеэр байгуулжээ. Уг сүлжээ улмаар 15 хөгжингүй орны 38 судлаач, 164 дэд судлаачтай болж өргөжсөн байна.

Тус сүлжээнээс гадна улс төр болон бусад холбогдох сэдвээр дагнасан эрдэм шинжилгээний олон сүлжээ ажиллаж, жендэрийн тэгш байдал, улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн талаар тайлан, бүтээл, тоо баримтыг тогтмол нийлж байна. Үүнд Улс төрийн судалгааны нийгэмлэгийн “Эмэгтэйчүүд ба улс төр бүлэг”³⁰⁵, Улс төрийн судалгааны Европын консорциумын “Жендэр ба улс төр байнгын бүлэг”³⁰⁶, Ирландын Улс төр судлалын нийгэмлэгийн “Жендэр ба улс төр дагнасан бүлэг”³⁰⁷, мөн Америкийн Улс төр судлалын нийгэмлэгийг “Эмэгтэйчүүд ба улс төр бүлэг”, мөн эмэгтэйчүүдийн бүлэг зэрэг байгтана. Их Британи судлаач Сара Чайлд зэрэг судлаачид гол гол сонгуулиас өмнө улс төрийн нам, сонгуулийн мөрийн хөтөлбөрт жендэрийн аудит хийхэд тогтмол оролцож байна.

304 Political Studies Association (PSA), <<http://www.psa.ac.uk/>>.

306 Standing Group on Gender and Politics, <<http://www.ecpr.eu/StandingGroups/StandingGroupHome.aspx?ID=8>>.

307 Gender and Politics Specialist Group, <<http://psai.ie/specialist/gender.asp>>.

НОМ ЗҮЙ

OSCE and International Documents

“15 förslag för en jämställd riksdag: Rapport från arbetsgruppen för en jämställd riksdag”, [15 Proposals for a Gender-equal Parliament], Riksdagstryckeriet, Stockholm, 2005, <http://www.riksdagen.se/sv/Dokument-Lagar/Ovriga-dokument/Ovrigt-dokument/15-forslag-for-en-jamstalld-ri_GSA5URF1/>.

OSCE, “Charter for European Security”, Istanbul, November 1999, <<http://www.osce.org/mc/17502>>.

OSCE/ODIHR and Council of Europe Venice Commission, Guidelines on Political Party Regulation (OSCE/ODIHR: Warsaw, 2010), <<http://www.osce.org/odihr/77812>>.

OSCE/ODIHR, Handbook for Monitoring Women’s Participation in Elections (Warsaw: OSCE/ODIHR, 2004),

<<http://www.osce.org/odihr/elections/13938>>.

The United Nations Fourth World Conference on Women, Beijing, September 1995,

<<http://www.un.org/womenwatch/daw/beijing/platform/decision.htm>>.

The Universal Declaration of Human Rights, 1948, <<http://www.un.org/en/documents/udhr/>>.

Selected Political Party Statutes

Liberal Party of Canada, “Rules of Procedure for the Liberal Party of Canada (Ontario) and its Constituent Bodies, 2012, <<https://ontario.liberal.ca/files/2010/06/Rules-of-Procedure-2011-ENGLISH.pdf>>. Norwegian Labour Party, <<http://arbeiderpartiet.no/>>.

Statutenbroschüredes CDU Deutschlands”, CDU Official website, 2007, <<http://www.cdu.de/doc/pdfc/080121-CDU-statut.pdf>>.

Statutul Partidului Liberal Democrat din Moldova”, PLDM Official website, <http://www.pldm.md/index.php?option=com_content&view=article&id=158&Itemid=50>.

Statutul Partidului Social Democrat”, PSD Official website, 2007, <http://psdm.md/?lang=md&menu_id=13>.

Texas Democratic Party, “The Rules of the Texas Democratic Party. State Democratic Executive Committee”, 2012,

<<http://www.txdemocrats.org/wp-content/uploads/2012/2010–2012-TDP-Rules.pdf>>.

The Constitution of the Swedish Social Democratic Party”, Swedish Social Democratic Party, 2001,

<http://www.socialdemokraterna.se/upload/Internationellt/Other%20Languages/SAPconstitution_eng.pdf>.

The Labour Party Rule Book 2010,” 2010, <<http://www.leftfutures.org/wp-content/uploads/2011/02/Labour-Party-Rule-Book-2010.pdf>>.

Selected Bibliography

Afkhami, M. and Eisenberg, A., Leading to Action: A Political Participation Handbook for Women, Women’s Learning Partnership for Rights, Development, and Peace (WLP), 2010.

Afkhami, M., Eisenberg, A. and Vaziri, H., Leading To Choices. A Leadership Training Handbook For Women,

Women’s Learning Partnership For Rights, Development, And Peace (WLP), 2001,

<<http://learningpartnership.org/docs/englctmanual.pdf>>.

Avdeyeva, O., “When do states comply with international treaties? Policies on violence against women

in post-communist countries”, International Studies Quarterly, Vol. 51. No. 4, 2007, pp. 877–900.

Bagratiya, T. and Badashvili, M., “Developing Intra-Party Democracy from a Gender Perspective”, in Intra-party

Democracy and local governance, Netherlands Institute for Multiparty Democracy (NIMD) Georgia, March 2012.

Ballington, J. and Binda, F., “The Implementation of Quotas: European Experiences”, Quota Report Series,

- International IDEA, 2005, <http://www.idea.int/publications/quotas_europe/index.cfm>.
- Bardall, G., “Breaking the Mold: Understanding Gender and Electoral Violence”, International Foundation for Electoral Systems (IFES), White Paper Series, December 2011, <<http://www.ifes.org/Content/Publications/Articles/2011/Breaking-the-Mold-Understanding-Gender-and-Electoral-Violence.aspx>>.
- Bock-Schappelwein, J., Eppel, R. and Mühlberger, U., “Sozialpolitik als Produktivkraft, Study for the Austrian Chancellery, 2009, <http://www.wifo.ac.at/www/jsp/index.jsp?fid=23923&id=35602&typeid=8&display_mode=2>.
- Booth, C. QC, “Seeking True Democracy: The Challenge and Promise of Full Equality for Women”, Chatham House, December 2011, <<http://www.chathamhouse.org/sites/default/files/public/Meetings/Meeting%20Transcripts/051211booth.pdf>>.
- Borovsky, G., Cherrabi El Alaoui, S. and Doherty, M., Confidence, Capacity, Connections. A Young Woman’s Guide to Leadership, National Democratic Institute, 2010.
- Childs, S., Lovenduski, J. and Campbell, R., Women at the Top 2005: Changing Numbers, Changing Politics? (London: Hansard Society, 2005).
- Cowley, P. and Childs, S., “To Spineless to Rebel? New Labour’s Women MPs”, British Journal of Political Science, Vol. 33, No. 3, 2003, pp. 345–365.
- Dahlerup, D. (ed.), Women, Quotas, and Politics (London: Routledge, 2006).
- Dahlerup, D. and Freidenvall, L. (eds.), Electoral Gender Quotas and Their Implementation in Europe (Brussels: European Parliament, 2011).
- Dahlerup, D. and Freidenvall, L., “Quotas as a ‘Fast Track’ to Equal Representation for Women: Why Scandinavia Is No Longer the Model”, International Feminist Journal of Politics, Vol. 7 No. 1, 2005, pp. 26–48.
- Dhembo, E., “Women in Politics and Decision-Making in Albania: A Qualitative Analysis”, Journal of International Social Research, Vol. 3, No. 13, 2010.
- Druciarek, M., Fuszara, M., Nizynska, A. and Zbieranek, J., Women on the Polish Political Scene (Warsaw: Institute of Public Affairs/ODIHR, 2012).
- EMILY’s List, Thinking of Running for office: A Guide for Democratic Women Candidates, 2003, <<http://emilyslist.org/>>.
- Fox, R. L. and Lawless, J. L., “If Only They’d Ask: Gender, Recruitment, and Political Ambition”, The Journal of Politics, Vol. 72, No. 02, April 2010, pp. 310–326.
- Freidenvall, L., “Women’s Political Representation and Gender Quotas – the Swedish Case”, Working Paper Series, Vol. 2, 2003.
- Glushkova, M. and Moldosheva A., Gender analysis of the Civil Service in the Kyrgyz Republic (Bishkek: UNDP/SIDA, 2008), <<http://www.awli-kg.org/en/images/eng/gender-analysis-civil-service-eng.pdf>>.
- Gonzalez, K. and Sample, K., “One Size Does Not Fit All: Lessons Learned From Legislative Gender Commissions And Caucuses”, NDI/ International IDEA, 2010.
- Hazan, R. Y. and Rahat, G., Democracy within Parties: Candidate Selection Methods and their Political Consequences (New York: Oxford University Press, 2010).
- Henneberger, M., “Why women don’t run for political office”, The Washington Post, 25 March 2012.
- Ilonszki, G. (ed.), Women in Decision-making: CEE Experiences (Budapest: Open Society Institute, 2004).

- International IDEA, *Women in Politics: Beyond Numbers* (International IDEA: Stockholm).
- Kam, C. and Zechmeister, E., "Name Recognition and Candidate Support", 2011, <<http://www.princeton.edu/csdp/events/Kam04282011/Kam04282011.pdf>>.
- Karam, A. and Ballington, J. (eds.), *Women in Parliament: Beyond Numbers*, 2nd edition (Stockholm, Sweden: IDEA Publishing, 2005).
- Krook, M. L., *Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide* (New York: Oxford University Press, 2009).
- LaFont, S., "One step forward, two steps back: women in the post-communist states", *Communist and Post-Communist Studies*, Vol. 34, No. 2, 2001, pp. 203–220.
- Lilliefeldt, E., "European Party Politics and Gender. Configuring Gender-Balanced Parliamentary Presence", Stockholm, 2011.
- Lovenduski, J. and Norris, P. (eds.), *Gender and Party Politics* (London: Sage, 1993).
- Matland, R. E. and Montgomery, K. (eds.), *Women's Access to Political Power in Post-Communist Europe* (Oxford: Oxford University Press, 2003).
- Matland, R., "Enhancing women's political participation: legislative recruitment and electoral systems", in Karam, A. and Ballington, J. (eds.), *Women in Parliament: Beyond Numbers*, 2nd edition (Stockholm, Sweden: IDEA Publishing, 2005).
- Meier, P., "The Mutual Contagion Effect of Legal and Party Quotas: A Belgian Perspective", *Party Politics*, Vol. 10, No.5, 2004, pp. 583–600.
- Murray, R., "The Power of Sex and Incumbency: A Longitudinal Study of Electoral Performance in France", *Party Politics*, Vol. 14, No. 5, 2008, pp. 539–554.
- Murray, R., *Parties, Gender Quotas, and Candidate Selection in France* (London: Palgrave, 2010).
- National Democratic Institute for International Affairs, *Assessing Women's Political Party Programs: Best Practices and Recommendations* (Washington: NDI, 2008), <<http://www.ndi.org/node/15121>>.
- National Democratic Institute for International Affairs, *Democracy and the Challenge of Change. A Guide to Increasing Women's Political Participation* (Washington: NDI, 2010), <http://www.ndi.org/Democracy_and_the_Challenge_of_Change>.
- Nazarkulova, E. and Akmatova, Ch., *Gender analysis of the political parties of the Kyrgyz Republic* (Bishkek, UNDP, 2008), <<http://www.awli-kg.org/en/images/eng/gender-analysis-political-parties-eng.pdf>>.
- Norris, P. and Krook, M. L., "Gender Equality in Elected Office: A Six Step Action Plan" (Warsaw: OSCE, 2011), <www.osce.org/odihr/78432>.
- Norris, P. and Lovenduski, J., *Political Recruitment: Gender, Race and Class in the British Parliament* (Cambridge: Cambridge University Press, 1995).
- Palmieri, S., "Gender-Sensitive Parliaments. A Global Review of Good Practice", Reports and Document No. 65, Inter Parliamentary Union, 2011, <<http://www.ipu.org/pdf/publications/gsp11-e.pdf>>.
- Partnership for Development (ProGen), *Equal opportunities in Elections* (Chisinau: Center "Partnership for development", 2008–2011), <www.alegeriprogen.md>.
- Political Parties Is Key Factor To Increase Women's Representation In Decision Making", *Database of Women: Georgia, Ukraine, Kazakhstan*, (Prague: International Gender Policy Network (IGPN), 2010), <www.igpn-womandatabase.net>.

- [Public perception of women's participation in elections in Albania, (Tirana: Albanian Centre for Economic Research (ACER), 2010).
- Ray, R., Gornick, J. C. and Schmitt, J., "Parental Leave Policies in 21 Countries. Assessing Generosity and Gender Equality", Center for Economic and Policy Research, September 2008 (Revised June 2009), <http://www.cepr.net/documents/publications/parental_2008_09.pdf>.
- Rekosz, E., Women and men in television electoral campaign. Parliamentary elections of 2011 (Warsaw: Institute of Public Affairs, 2011).
- Rising through the ranks: A Young Woman's Guide to Leadership and Political Party Engagement (National Democratic Institute for International Affairs (NDI), 2011).
- Rossister, M. W., "The Matthew Matilda effect in science", *Social Studies of Science*, 1993, Vol. 23, No. 2, p. 325–341.
- Rule, W., "Why women don't run: The critical contextual factors in women's legislative recruitment", *Western Political Quarterly*, Vol. 34, 1988, pp. 60-77.
- Saxonberg, S., "Women in East European parliaments", *Journal of Democracy*, Vol. 11, No. 2, 2000, pp. 145–158.
- Swedish Social Democratic Party "Power Booklet", S-Kvinnor Sveavägen.
- "The 100 women who run the world. The World's 100 most powerful women", *Forbes.com*, <<http://www.forbes.com/power-women/>>.
- The World Development Report 2012: Gender Equality and Development (Washington, DC: World Bank, 2012).
- Thomas, S., *How Women Legislate* (New York: Oxford University Press, 1995).
- UK Labour Party, *Winning for Women. A guide to what Labour has delivered for women*, 2010, <<http://www.labour.org.uk/uploads/746d1524-6792-d714-252f-e40e1e93b64d.pdf>>.
- UNDP and NDI, *Empowering Women for Stronger Political Parties. A Good Practices Guide to Promote Women's Political Participation*, UNDP/NDI, 2011, <<http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/womens-empowerment/empower-women-political-parties.html>>.
- UNDP, *Enhancing Women's Political Participation. A Policy Note for Europe and CIS*, 2010.
- van Biezen, I., "On the internal balance of party power: party organizations in new democracies", *Party Politics*, Vol. 6, 2000, pp. 395–418.
- Who Answers to Women? Progress of The World's Women 2008/2009, *Gender & Accountability*", UNIFEM, 2008, <<http://www.unifem.org/progress/2008/index-2.html?>>.
- Wolbrecht, C. and Campbell, D. E., "Leading by example: Female members of parliament as political role models", *American Journal of Political Science*, Vol. 51, No. 4, 2007, pp. 921–939.
- Women candidates participating in elections to the local government of Georgia (Tbilisi: Women's Information Center, 2010).
- Wood, J. T., "Gendered media: The Influence of Media on Views of Gender, <<http://www.udel.edu/comm245/readings/GenderedMedia.pdf>>.
- Воронова, Л., "Женщины-политики в СМИ: мифы и анти-мифы" (Voronova, L., "Women-politicians in Mass Media: myths and anti-myths"), *Mediascop*, Vol. 2, 2009, <<http://mediascope.ru/node/345>>.
- Омиралиев, М., "Женщина: и очаг, и дело" [Omiraliev, M., "Woman: home and career"], *Деловой Казахстан*, Vol. 307, No. 10, 3 March 2012, <<http://dknews.kz/zhenshhina-i-ochag-i-delo.htm>>.

Selected Organizations and Websites

ACE Electoral Knowledge Network, <<http://aceproject.org>>.

Association of Business Women of Kazakhstan, <http://www.businesswomen.kz/zhenskoe_poiticheskoe_iderstvo/>.

Association for Participatory Democracy (ADEPT), “Leadership School for Young Political Leaders”, <<http://www.e-democracy.md/en/liderismpolitic/>>.

Women’s Learning Partnership for Rights, Development, and Peace (WLP), <<http://www.learningpartnership.org/>>.

Center for American Women and Politics, Eagleton Institute of Politics, Rutgers University, <<http://www.cawp.rutgers.edu>>.

Center Partnership for Development PROGEN, <www.progen.md>.

Emerge America: Women leaders for a democratic future, <<http://www.emergeamerica.org/home>>.

European Forum for Democracy and Solidarity, <www.europenforum.net/gendernetwork>.

European Institute for Gender Equality (EIGE), <<http://www.eige.europa.eu/>>.

Feminist League, <www.empowering-women.kz>.

Friederich-Naumann-Stiftung, <<http://www.freiheit.org/>>.

Friedrich-Ebert-Stiftung, <<http://www.fes.de/>>.

Global Database of Quotas for Women, Quota Project, “Voluntary Political Party Quotas for Europe”. Accessed 25 October 2012, <<http://www.quotaproject.org/systemParty.cfm?region=50>>.

International IDEA, <<http://www.idea.int/publications/>>.

International Knowledge Network of Women in Politics (iKNOW Politics), <<http://www.iknowpolitics.org/>>.

International Republican Institute (IRI), <<http://www.iri.org/>>.

Inter-Parliamentary Union (IPU), <<http://www.ipu.org/gpr-e/about/index.htm>>.

Laboratoire de l’*égalité*, <<http://www.laboratoiredelegalite.org/>>.

League of Women Voters, <<http://www.lwv.org/>>.

Millennium Women’s Network (MWN), <www.albania-mwn.org>.

National Democratic Institute for International Affairs (NDI), <<http://www.ndi.org/>>.

National Federation for Republican Women (NFRW), <<http://www.nfrw.org/>>.

National Federation of Democratic Women (NFDW), <<http://www.nfdw.com/>>.

Political Parity, <<http://www.politicalparity.org>>.

Running Start: Bringing Young Women to Politics, <<http://www.runningstartonline.org/>>.

She should run, 2011, <<http://www.sheshouldrun.org/>>.

The “Susan B. Anthony List”, <<http://www.sba-list.org/>>.

The White House Project, 2012, <<http://thewhitehouseproject.org/>>.

The WISH List, <<http://www.thewishlist.org/>>.

Women’s Campaign Fund, 2011, <<http://www.wcfonline.org/>>.

Women’s Campaign School, Yale University, 2009–2011, <<http://www.wcsyale.org/>>.

Women’s Democracy Network (WDN), an initiative of the International Republican Institute website, <www.wdn.org>.

World Economic Forum, “The Global Gender Gap” (WEP), <<http://www.weforum.org/issues/global-gender-gap>>.

Women in the House of Commons, House of Commons Information Office, <<http://www.parliament.uk/documents/commons-information-office/m04.pdf>>.

Women’s Information Center in Georgia, (WIC), <www.wicge.org>.

Women moving millions, <<http://www.womenmovingmillions.org/how-we-do-it/facts>>.

